


Шинэ Гэрээ

О Ю У Т Н Ы



СУДЛАХ ГАРЫН АВЛАГА

Сүмийн Боловсролын Системээс
Бэлтгэн Гаргав

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргав,
Солт Лейк Хот, Юта

© 1999 by Intellectual Reserve, Inc.
Бүх эрх хамгаалагдсан.
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв
Англи эхийн зөвшөөрөл: 8/97
Орчуулгын зөвшөөрөл: 8/97

New Testament Student Study Guide–ын орчуулга
Mongolian

Энэ Гарын Авлагыг Хэрхэн Ашиглах вэ	1	Марк 15	Есүс Цовдлогдов	59
Судруудыг Судлах нь	2	Марк 16	“Тэр Энд Байхгүй”	60
Шинэ Гэрээг Унших Хуваарь	8			
Шинэ Гэрээнд Тавтай Морилно уу	9			
Гэгээнтэн Матайн Сайн Мэдээ	11	Гэгээнтэн Лукийн Сайн Мэдээ	62	
Матай 1 Есүс Христ Мэндлэв	12	Лук 1 Хоёр Гайхамшигт Төрөлт Угтан		
Матай 2 Мэргэн Хүмүүс Есүсийг Эрж, мөн Олов	12	Хэлэгдэв	62	
Матай 3 Иохан Баптист Есүст Баптисм		Лук 2 Аврагч Мэндлэв	63	
Хүртээв	14	Лук 3 Иохан Бурханы Хүүд Баптисм		
Матай 4 Уруу Таталтууд ба Есүсийн		Хүртээв	64	
Тохинуулал Эхэлсэн нь	15	Лук 4 Есүс Сатаныг Ялж, Өөрийн		
Матай 5 Уулан Дээрх Номлол, Хэсэг 1	16	Тохинууллыг Эхлэв	66	
Матай 6 Уулан Дээрх Номлол, Хэсэг 2	18	Лук 5 “Ирж, Намайг Дага”	67	
Матай 7 Уулан Дээрх Номлол, Хэсэг 3	19	Лук 6 Есүс Арванхоёр Төлөөлөгчийг		
Матай 8–9 Есүс Олон Гайхамшиг Үйлдэв	20	Томилж, Гэдэнд Заасан нь	68	
Матай 10 Арванхоёр Төлөөлөгчид Өгсөн		Лук 7–8 Итгэлийн Асуудлууд	69	
Зааврууд	22	Лук 9 Арванхоёр Төлөөлөгч Номлохоор		
Матай 11 “Надад Ирэгтүн”	23	Гадагш Илгээгдэв	71	
Матай 12 Фарисайчууд Есүсийг		Лук 10 Дал Номлохоор Илгээгдэв	71	
Эсэргүүцэв	24	Лук 11 Гэрлээр Дүүрэн Бай	72	
Матай 13 Сургаалт Зүйрлэлүүд	26	Лук 12 “Та нар Бурханы Хаант Улсыг Хай”	74	
Матай 14 “Бүү Ай”	27	Лук 13 Наманчил Эс Бөгөөс Мөхөгтүн	74	
Матай 15 Юу Цэвэр Ариун, Юу Бузар Вэ?	28	Лук 14 Шавилах Ёсны Үнэ Цэнэ	75	
Матай 16 “Та Бол Христ”	28	Лук 15 Сургаалт Зүйрлэлүүдийн Цаг	77	
Матай 17 Хувиралтын Уул	30	Лук 16 Бурханыг Угтахаар Бэлтгэх нь	78	
Матай 18 “Бүдрүүлэлт” ба Уучлал	31	Лук 17 Бурханы Хаант Улс Хэзээ Ирэх Вэ?	78	
Матай 19 Мөнх Амьдралтай Байхын		Лук 18 Тэнгэр дэх Эрдэнэс	79	
Тулд Би Юу Хийх Ёстой Вэ?	32	Лук 19 Есүс Иерусалимд Ирэв	80	
Матай 20 Агуу Ихийг Есүс Дахин		Лук 20 Тэд Түүнийг Хөнөөхөөр		
Тодорхойлов	33	Оролдож Байв	81	
Матай 21–22 Иерусалим дахь Сүүлчийн Гэрч	34	Лук 21 “Тэр Цаг Ойртож Байна”	82	
Матай 23 Есүс Хоёр Нүүртнүүдийг Зэмлэв	36	Лук 22 Ариун Ёслолын Бэлэгдэл	83	
Матай 24 Хоёр дахь Ирэлт	38	Лук 23 Цовдлолт	85	
Матай 25 Та Нар Бэлэн үү?	40	Лук 24 “Аврагч Минь Амьдардгийг		
Матай 26 “Миний Цаг Ойрхон Байна”	41	Би Мэднэ”	86	
Матай 27 Есүс Христийн Цовдлолт	43			
Матай 28 Тэр Босч Ирэв!	44	Гэгээнтэн Иоханы Сайн Мэдээ	87	
Гэгээнтэн Маркийн Сайн Мэдээ	46	Иохан 1 Есүс Бол Мөнх Бус Байдлын Өмнөх		
Марк 1 Есүсийн Тохинуулал Эхэлсэн нь	46	Христ бөгөөд Бүтээгч Мөн	88	
Марк 2 “Нүглүүд Чинь Чамд		Иохан 2 Есүс Өөрийн Ажлыг Эхлэв	89	
Өршөөгдсөн Болой”	47	Иохан 3 “Та Нар Дахин Төрөх Ёстой”	90	
Марк 3 Есүс Их Анхаарал Татав	48	Иохан 4 Худаг Дээрх Эмэгтэй	91	
Марк 4 Есүс Сургаалт Зүйрлэлүүдээр Заав	49	Иохан 5 “Би Эцэгийнхээ Нэрээр Ирсэн Юм”	92	
Марк 5 Илүү Олон Гайхамшгууд	50	Иохан 6 “Есүс Бол Амьдралын Талх”	93	
Марк 6 Есүс Гэх Энэ Хүн Хэн Бэ?	51	Иохан 7 Есүс Иерусалимд Гэрчилсэн нь	94	
Марк 7 Хүнийг Юу Бузарладаг Вэ?	52	Иохан 8 “Би Байдаг”	95	
Марк 8 “Та Нар Одоо ч Ухаарахгүй		Иохан 9 Есүс ба Төрөлхийн Хараагүй Хүн	96	
Байна уу?”	53	Иохан 10 Сайн Хоньчин	97	
Марк 9 “Итгэлгүй Байгаад Минь Туслаач”	53	Иохан 11 Лазар Үхэгсдээс Босч Ирэв	98	
Марк 10 Жинхэнэ Агуу Чанар	54	Иохан 12 Нийтийн Өмнөх Есүсийн Сүүлчийн		
Марк 11–12 Сүүлчийнхээ Долоо Хоногт Есүс		Гэрчлэл	99	
Юу Хийж, Юу Заасан бэ?	55	Иохан 13 “Бие Биенээ Хайрла”	100	
Марк 13 Хоёр Дахь Ирэлтийн Тэмдгүүд	57	Иохан 14 “Хэрэв Та Нар Намайг Хайрладаг		
Марк 14 Есүсийн Мөнх Бус Амьдралын		Бол, Зарлигуудыг Минь Сахь”	101	
Сүүлчийн Цагууд	58	Иохан 15 Есүс Бол Усан Үэмийн Жинхэнэ Мод	102	
		Иохан 16 Ариун Сүнсний Үүрэг	103	
		Иохан 17 “Энэ Бол Мөнхийн Амь”	104	
		Иохан 18 Есүсээс Урваж, Тэрээр Баривчлагдав	104	
		Иохан 19 Есүс Христ Амиа Өгөв	105	

Июхан 20	Есүс Христийн Амилуулалтанд Итгэхүй	106
Июхан 21	Их Эзэний Ажлыг Үргэлжлүүл	107
Төлөөлөгчдийн Үйлс 109		
Үйлс 1	Есүс Христ Тэнгэрт Дээшлэн Одов	109
Үйлс 2	Гэрчлэлийн Өдөр	110
Үйлс 3	Петр Наманчлалыг Зоригтойгоор Номлов	111
Үйлс 4	Петр, Иохан Хоёр Баривчлагдав	112
Үйлс 5	Шоронгоос Суллагдав	113
Үйлс 6–7	Стефений Үхэл	114
Үйлс 8–9	Саулын Хөрвүүлэг	115
Үйлс 10	Сайн Мэдээ Хүн Бүгдэд Зориулагдсан Юм	116
Үйлс 11–12	Христэд Итгэгч Байх нь	117
Үйлс 13–14	Паулын Анхны Номлол	118
Үйлс 15	Иерусалимын Чуулган	119
Үйлс 16	Паул Хоёр Дахь Номлолоо Эхэлсэн нь	120
Үйлс 17–18	“Бид Бурханы Үр Удам”	121
Үйлс 19–20	Санваарын Эрх Мэдэл болон Паулын Номлолын Гурав Дахь Аялал	122
Үйлс 21–23	Паул Иерусалимд Баривчлагдав	124
Үйлс 24–26	Паул Сайн Мэдээг Дэлгэрүүлэв	125
Үйлс 27–28	Паул Ром уруу Явсан Бүх Замынхаа Туршид Гэрчлэв	126
Ромчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Захидал 128		
Ром 1	“Христийн Сайн Мэдээнээс Би Ичдэггүй”	128
Ром 2	Бурхан Бидний Ажлуудын Дагуу Биднийг Нэгбүрчлэн Шагнах Болно	129
Ром 3	Христ Хүн Бүгдэд Хэрэгтэй	130
Ром 4–5	Есүс Христэд Итгэх Итгэл Бол Нүглийг Даван Туулах Түлхүүр Мөн	130
Ром 6	“Мөнх Бус Биенд чинь... Нүгэл Бүү Ноёрхог”	132
Ром 7	Есүс Христ Мосегийн Хуулийг Гүйцэлдүүлэв	132
Ром 8	“Христийн Хамтран Залгамжлагчид”	132
Ром 9–10	Христийн Хуулийн Дагуу Амьдрах нь	133
Ром 11	Сайн Мэдээ Бурханы Бүх Хүүхдүүдэд Зориулагдсан Юм	134
Ром 12–13	Гэгээнтнүүдэд Өгсөн Зөвлөгөө	135
Ром 14–16	Жинхэнэ Гэгээнтнүүд Бие Биентэйгээ Нөхөрлөдөг	136
Коринтчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Анхны Захидал 138		
1 Коринт 1–4	Сүнсээр Дамжсан Эв Нэгдэл	139
1 Коринт 5–7	Сүмд Өгсөн Зааврууд	140
1 Коринт 8–11	Шинэ Гишүүдэд Өгсөн Зөвлөгөө	141
1 Коринт 12–14	Сүнсний Бэлгүүд	143
1 Коринт 15–16	Амилуулалтын Сургаал	144

Коринтчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Хоёр Дахь Захидал 146		
2 Коринт 1–3	Сүнс Амь Өгдөг	146
2 Коринт 4–6	Итгэлээр Алхагтун	147
2 Коринт 7	Бурханлиг Харамсал	148
2 Коринт 8–10	Бэлгүүд ба Өглөг	149
2 Коринт 11	Сайн Мэдээний Төлөөх Паулын Золиослол	149
2 Коринт 12–13	Паул Гурав Дахь Тэнгэрт Дээш Аваачигдав	150
Галатчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Захидал 151		
Галат 1–2	Хуурамч Багш Нар Үнэн Сайн Мэдээг Гуйвуулав	152
Галат 3–6	Итгэлийн Сайн Мэдээ Мосегийн Хуулиас Өмнө Ирсэн Юм	152
Ефесчүүдэд Бичсэн Төлөөлөгч Паулын Захидал 155		
Ефес 1–3	Есүс Христийн Сүмийн Нэн Чухал Сургаалууд	155
Ефес 4–6	Шавийн Зан Төлөв	157
Филиппойчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Захидал 159		
Филиппой 1–4	Есүс Христэд Хүч Чадлыг Олох нь	159
Колосайчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Захидал ... 160		
Колосай 1–4	Хуурмаг Заалтуудын Эсрэг Сэрэмжлүүлэг	161
Тесалоникчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Анхны Захидал 162		
1 Тесалоник 1–5	Сайн Мэдээ Биднийг Есүс Христийн Хоёр Дахь Ирэлтэд Бэлтгэдэг	162
Тесалоникчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Хоёр Дахь Захидал 163		
2 Тесалоник 1–3	Сайныг Үйлдэхээс Бүү Зүрхшээ	164
Тимотод Бичсэн Төлөөлөгч Паулын Анхны Захидал ... 165		
1 Тимот 1–2	Сайн Мэдээний Дагуу Амьдрах нь	165
1 Тимот 3	Бишопууд болон Диконуудад Өгсөн Зөвлөгөө	166
1 Тимот 4–6	“Сайнтай Тэмцэх нь Итгэлийн Эсрэг Тэмцсэн Хэрэг”	167
Тимотод Бичсэн Төлөөлөгч Паулын Хоёр дахь Захидал 168		
2 Тимот 1–2	Зовлон Зүдгүүрийг Тэвч	168
2 Тимот 3–4	Урвалт	168
Титэд Бичсэн Паулын Захидал 169		
Тит 1–3	“Итгэл Дотроо Эрүүл Бай”	169
Филемонд Бичсэн Паулын Захидал 170		
Филемон 1	Сайн Мэдээн Дэх Ахыгаа Хүлээж Авагтун	170
Еврейчүүдэд Бичсэн Төлөөлөгч Паулын Захидал 171		
Еврей 1–2	Дорд Байснаар Илүү Агуу Болох нь	172
Еврей 3–4	Египетээс Гарсан нь-аас Авах Сургамжууд	173
Еврей 5	Есүс Христ, Агуу Дээд Санваартан	173

Еврей 6–10	Мосегийн Хууль Христийн Тухай Гэрчилдэг	174	Иудагийн Нийтлэг Захидал	189
Еврей 11	Есүс Христэд Итгэх Итгэлийн Хүч . .	175	Иуда 1	Өөрсдийнхөө Асуудлуудын Шийдлийг Судруудаас Ол
Еврей 12	Шийдвэр Төгс Байдал ба Залруулга . .	176		
Еврей 13	Зааврын Сүүлчийн Зүйлүүд	178	Бурханлиг Гэгээнтэн Иоханы Илчлэлт	190
Иаковын Нийтлэг Захидал		178	Илчлэлт 1	Есүс Христийн Илчлэлт
Иаков 1–2	“Үйлсгүй Итгэл Үхмэл Юм”	178	Илчлэлт 2–3	Сүмийн Долоон Салбарт Зориулсан Зөвлөгөө
Иаков 3	Хэлийг Номхруулах нь	180	Илчлэлт 4	“Үүний Дараа Тохиолдох Зүйлүүд” . .
Иаков 4–5	Өөрийнхөө Амьдрал Дахь Хилэнцийг Даван Туулах нь	180	Илчлэлт 5–7	Долоон Тамгатай Ном
			Илчлэлт 8–9	Долоо Дахь Лацан Дахь Долоон Тэнгэр Элч
Петрийн Анхны Нийтлэг Захидал		181	Илчлэлт 10	Иоханы Үүрэг Зорилго
1 Петр 1–2	Есүс Христ, Урьдчилан Томилогдсон Гэтэлгэгч	181	Илчлэлт 11	Хоёр Онцгой Гэрч
1 Петр 3–5	Нас Барагсдыг Гэтэлгэх нь	183	Илчлэлт 12	Сайн, Муугийн Хоорондох Агуу Тулалдаан
Петрийн Хоёр Дахь Нийтлэг Захидал		184	Илчлэлт 13	Мууг Төлөөлдөг Араатнууд
2 Петр 1–3	Бурханлиг Мөн Чанараас Хүртэхүй	184	Илчлэлт 14	Дэлхий Дээрх Ургац Хураах Цаг
			Илчлэлт 15	Сэлэстиэл Дэлхийн Тухай Үзэгдэл . .
Иоханы Анхны Нийтлэг Захидал		186	Илчлэлт 16	“Бурханы Шүүлтүүдийг Цутгах” Долоон Тэнгэр Элч
1 Иохан 1–2	“Гэрэлд Алх”	186	Илчлэлт 17–18	Янхан Вавилоны Устгал
1Иохан 3–5	“Бурханы Хайр”	186	Илчлэлт 19	Христийн Хоёр Дахь Ирэлт
Иоханы Хоёр Дахь Захидал		187	Илчлэлт 20	Мянган Жил
2 Иохан 1	Хуурамч Багш Нараас Болгоомжил . .	187	Илчлэлт 21–22	Газар Сэлэстиэл Дэлхий Боллох нь . . .
Иоханы Гурав Дахь Захидал		188		
3 Иохан 1	Бусдад Тусалж, Тэднийг Хайрла	188		

Энэ гарын авлага нь нэрнийхээ дагуу судруудыг судлахад та нарт гарын авлага болно. Гарын авлага нь та нараас уншсан зүйлээ ойлгох явдлыг дээшлүүлэхэд тань туслах хэд хэдэн хэсгээс бүрдэж байгаа болно.

Лук 12

“Та Нар Бурханы Хаант Улсыг Хай”

А **Ариачийг Өмнөхөд Туслах нь**

Ариачийг өмнөхөд туслах нь бид өөрсдийг өмнөхөд тусгахтай адилтгэнэ. Ариачийг өмнөхөд туслах нь бид өөрсдийг өмнөхөд тусгахтай адилтгэнэ. Ариачийг өмнөхөд туслах нь бид өөрсдийг өмнөхөд тусгахтай адилтгэнэ.

1. Бид үнэ 16-ийг өөрийн нь авчирсан үйлдүүдийн талаар юу гэж бодож байна? Жилийн өмнө үүнийг мэдэж улам хэрэглэсэн байна вэ?
2. Энэ нь түүний хандлагын талаар юу харуулж байна вэ?
3. Ариачийн сургаалт үгээрээ “шударга сайн” гэдгийг хэрхэн харуулж байна вэ?
4. Дэлхийн үнэ эргэлтийн талаар та нар энэ сургаалт үгээрээ юу мэдэж болох вэ?

Б **Судруудыг Ойлгох нь**

Лук 12

<ul style="list-style-type: none"> Гинигэчин (ил.1)–Гинигэч Моринго (ил.3)–Илгэж моринго Хүрэн зонхирох (ил.8)–Хүрэн зонхирох Заврагчид (ил.11)–Удирдагчид, толгойлогчид, зохионо зэрэг мэдэгдэгчид Шууд (ил.16)–Шуудайрагчид 	<ul style="list-style-type: none"> Хандлага байр суу (ил.17)–Гэгээ, дуулах Урсагдах (ил.25)–Өмдөрсгөх Нэг зөрөө (ил.25)–Өмдөрсгөх 18 нэг буюу 5 метр Ажиллах (ил.27)–Ажиллах Угас эрэг (ил.27)–Хуучин үг болон угас эрэг Хуучин (ил.27)–Хуучин үг болон угас эрэг
--	--

В **Судруудыг Судлах нь**

Лук 12-ийг судлахад дараах үйл ажиллагаануудыг (А-В) хэрхэн нь хий.

А **Дуртай Шүлгээ Сонго**

Лук 12-ийг уншихад өөрсөдөө хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн гурван нүгтийг сонгож олоод, дараа асуултуудад хариулах юмуу хий.

1. Эдгээр нүгэл бэрийг та нар агаад сонгож авсан вэ?
2. Эдгээр нүгэл тус бүрээр юу замаа мөнгөж байна гэж та нар бодож вэ?
3. Эдгээр нүгэлүүдэд нэгний нь нөхцөл, үүнийг гэр бүлийнхээ гинүүн, багш, эсвэл найздыг зориулж иш тат.

Б **Тоона Юу Вайдаг вэ?**

Лук 12:15-ийг уншаад, Егип цорны сэрэг сэрэмжлүүлснийг ойлго. Шүлг: 16–21-ийг уншиж, дараа асуултуудад хариул.

Лук 13

Наманчил Эс Бөгөөс Мохотгун

А Оршил

Гялгар цаасан дээрх зурган дээр хэвлэгдсэн доорх бүлгийн товч агуулга нь та нарт уншихаар даалгавар өгөгдсөн судруудын бүлгүүдийн оршлууд түүнчлэн уншихаар та нарт даалгавар өгөөгүй бүлгүүдийн талаарх тайлбар юм. Энэ хэсэг нь дараах төрлийн мэдээллийг агуулсан болно:

- Түүхийн хэсэг
- Судрын тухайн хэсэг нь өмнөх болон дараах бүлэгтэйгээ хэрхэн холбогддогийг ойлгосон тайлбар
- Уншихынхаа өмнө болон унших үеэрээ тухайн хэсгийн захиаст анхаарлаа төвлөрүүлэхэд тань туслах асуултууд хийгээд санаануудын талаар бодож үзэх.

Б Судруудыг Ойлгох нь

“Судруудыг Ойлгох нь” хэсэг нь судруудад агуулагддаг санаанууд хийгээд үзэл баримтлалуудыг ойлгоход тань та нарт туслах хэцүү үг хэллэг, өгүүлбэрүүд хийгээд тайлбарыг агуулдаг. Тайлбар нь Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн мэдэгдлийг өөртөө багтаасан байх нь олонтаа тохиолддог.

В Судруудыг Судлах нь

“Судруудыг Судлах нь” хэсэг нь нээж олох, тунгаан бодох хийгээд судруудад агуулагддаг сайн мэдээний зарчмуудыг хэрэглэхэд тань туслах асуултууд

хийгээд үйл ажиллагаануудыг агуулдаг. Гарын авлагад бичих зай байхгүй учраас эдгээр үйл ажиллагаануудыг та нар тэмдэглэлийн дэвтэртээ буюу цаасан дээр хийх хэрэгтэй.

Дараах алхмууд судруудыг судлахад тань та нарт туслах болно:

- Залбирлаар эхэл.
- Судлах бүлгийнхээ оршлыг уншиж, “Уншихын Өмнө” гэсэн судлах бусад ур чадваруудыг анхаарч үз (хуудас 1–4-ийг үз).
- Туслацдаа авахын тулд холбогдох “Судруудыг Ойлгох нь” хэсгийг дурдаж буй даалгасан бүлгийг унш. “Унших Үедээ” гэсэн судлах ур чадварыг ашигла (хуудас 4–6-г үз). Тэмдэглэл ба асуултуудыг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж ав. Түүнчлэн өөрсдийн тань хувьд ач холбогдолтой бодол санаа буюу сэтгэгдлүүдийн тухай бич.
- Өөрсдийн судалж байгаа бүлэгт зориулсан “Судруудыг Судлах нь” хэсэгт үйл ажиллагаануудыг хий. Зарим үед та нар дуусгах ямар үйл ажиллагааг сонгох шаардлагатай байх болно. Хэрэв та нар илүү ихийг мэдэхийг хүсвэл, бүү ажиллагааг дуусга.

Гэрээр Судлах Семинарын Хөтөлбөр

Хэрэв та нар гэрээр судлах семинарын хөтөлбөрөөр сурч байгаа бол, 8-р хуудсанд байгаа хүснэгтийг унших нь семинарын долоо хоног бүр та нарын юу унших ёстойг харуулна. Семинар бол шашны боловсролын өдөр тутмын хөтөлбөр мөн гэдгийг, судруудыг залбиралтайгаар унших нь өдөр тутмын дадал хэвшил байх ёстой гэдгийг, тэр ч байтугай та нар семинарт өдөр бүр оролцохгүй байлаа ч гэсэн семинарын даалгаврыг хийхийн тулд хичээлийн өдөр бүр ажиллаж байх ёстой гэдгийг санагтун. Хэрэв танай семинарын жил гучин зургаагаас цөөн долоо хоногтой бол, та нар долоо хоногт ямар бүлгүүдийг унших ёстойг, түүнчлэн ямар даалгавруудыг гүйцээх ёстойг багш тань та нарт хэлж өгөх болно. Судруудыг уншиж, энэхүү суралцах удирдамжийг ашиглах нь семинарын хичээлд суугаагүй өдөр бүрийн хувьд та нараас гучаас дөчин минут л авах болно.

Судруудын талаарх өөрсдийнхөө санаа бодлыг агуулсан тэмдэглэлийн дэвтрийнхээ хуудсуудыг, тэрчлэн тухайн долоо хоногт дуусгасан суралцах удирдамжийн үйл ажиллагааг та нар долоо хоног болгон багцдаа өгч байх ёстой. Багш тань эдгээр зүйлүүдийг уншиж, хариулт өгөөд тэмдэглэлийн дэвтрийг тань та нарт буцааж өгөх болно. Та нар хоёр тэмдэглэлийн дэвтэртэй байж, долоо хоногоор ээлжлэн хэрэглэж болно. Тэрчлэн та нар сугалж авч болдог хуудастай дэвтэрт бичиж тухайн долоо хоногтоо хийсэн ажаалаа хуудаснуудаар ээлжлэн бичиж өгч болно. Багш тань хуудаснуудыг эргүүлэн өгөх үед, тэдгээрийг тэмдэглэлийн дэвтэртээ буцааж хийгээрэй.

Семинарын Өдөр Тутмын Хөтөлбөр

Хэрэв танайд семинарын өдөр тутмын хөтөлбөр байдаг бол, та нар энэхүү судлах удирдамжийг багшийнхаа зааварласны дагуу ашиглах хэрэгтэй.

Судруудыг Судлах нь

Энэхүү судлах удирдамж нь судруудыг унших, судлах хийгээд ойлгоход тань та нарт туслахын тулд бэлтгэгдсэн болно. Та нар судлах ихэнх цаг тань судруудыг унших хийгээд тэдгээрийн талаар тунгаан бодоход зориулагдах учраас энэ хэсэг нь үүнийг илүү үр ашигтай болгоход та нарт туслах болно.

Тухайн үедээ Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан Ахлагч Ховард В.Хантер судар судлах талаар Сүмийн гишүүдэд үнэ цэнэтэй зөвлөгөө өгснийг доор товч томъёолон харуулав. Та нар түүний санаануудыг картан дээр бичиж, судар судалж байх үедээ үүнийг харагдах газарт тавьж болно.

- Судруудыг ойлгохын тулд анхааралтай унш.
- Өдөр бүр судал.
- Өдөр бүр судар судлах тогтмол цаг товл.
- Анхаарал сарниулах буюу тасалдал гарахааргүй, анхаарлаа төвлөрүүлэх боломжтой газарт судал.
- Тодорхой тооны бүлэг буюу хуудсыг уншихаас илүүгээр тодорхой цагт багтааж судал: жаран минут туйлын зохимжтой, гучин минут бол нэн сайн, түүнчлэн арван таван минут ч гэсэн боломжийн юм.
- Судлах төлөвлөгөөтэй бай. (Conference Report, 1979 оны Аравдугаар сар, х. 91–93; эсвэл *Ensign*, 1979 оны Арваннэгдүгээр сар, х. 64–65-ыг үз.)

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэн гаргасан судруудад байдаг судлахад туслах гарын авлагуудыг ашиглах нь түүнчлэн судлах сайн ур чадвар нь та нараас судруудыг өдөр тутам судлахад тань ашиг тустай байх болно.

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс Хэвлэн Гаргасан Судрууд дахь Судлахад Туслах Материалууд

Харьцуулах Ишлэлүүд

Харьцуулах ишлэл бол судалж байгаа сэдвүүдээр тань та нарт нэмэлт мэдээлэл хийгээд ойлгох чадвар уруу хөтөлдөг судрын ишлэл юм.

15 Neither do men light a candle, and put it under a bushel, but on a candlestick; and it giveth light unto all that are in the house.

16 Let your light so shine before men, that they may see your good works, and glorify your Father which is in heaven.

17 ¶ Think not that I am come to destroy the law, or the prophets: I am not come to destroy, but to fulfil.

18 For verily I say unto you, Till heaven and earth pass, one jot or one tittle shall in no wise pass from the law, till all be fulfilled.

19 Whosoever therefore shall break one of these least commandments, and shall teach men so, he shall be called the least in the kingdom of heaven: but whosoever shall do and teach them, the same shall be called great in the kingdom of heaven.

20 For I say unto you, That except your righteousness shall exceed the

12c TG Persecution.	b D&C 1: 3
13a See Lev. 2: 13 and Num. 18: 19, where salt is a token of the covenant and was part of sacrifice ritual.	19a TG Sin.
14a TG Mission of Early Saints.	b JST Matt. (Appendi
15a Luke 11: 33 (33–34).	c 2 Ne. 28:
16a 3 Ne. 18: 24; TG Children of Light; Example; Light.	d TG Missio
b 1 Pet. 2: 12. TG Good Works.	20a TG Right
c John 15: 8.	b TG Scribe
17a D&C 10: 52 (52, 54).	21a TG Comm
b TG Law of Moses.	God.
18a TG Law of Moses.	b TG Blood Murder.
	c GR subjec demnatic
	22a Prov. 29:
	3 Ne. 12:
	TG Anger
	b JST Matt.
	12: 22 on

Жишээ нь, Матай 5:14–16-г уншаад, зүүвэр тайлбар 16-г ажигла. Зүүвэр тайлбаруудад иш татсан судрыг харж, уншсанаар, “Та нарын гэрэл гэрэлтэй” (Матай 5: 16) гэсэн нь ямар утга учиртай тухайд та нар ямар нэмэлт ойлголтыг авч болох вэ?

Сэдэвчилсэн Удирдамж ба Библийн Толь Бичгийн Ишлэлүүд

Сэдэвчилсэн Удирдамж (СУ) нь Сүмийн нийт дөрвөн жишиг бүтээлүүд дэх судрын ишлэл бүхий хэдэн зуун үгс болон сэдвийн, цагаан толгойн дэс дарааллын жагсаалтаас бүрддэг. Библийн Толь Бичиг (БТБ) нь Библийн олон нэр болон сэдвүүдийн талаарх тодорхойлолтууд хийгээд тайлбаруудыг агуулдаг. Хэдийгээр зүүвэр тайлбаруудад иш татагдаагүй ч гэсэн, та нар нэмэлт ишлэлүүд олж үзэхийн тулд Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, түүнчлэн Агуу Үнэт Сувдад зориулсан товъёогт (индекс) үзэж болно.

25 And God made the beast of the earth after his kind, and cattle after their kind, and every thing that creepeth upon the earth after his kind: and God saw that it was good.
 26 ¶ And God said, Let us make man in our image, after our likeness: and let them have dominion over the fish of the sea, and over the fowl of the air, and over the cattle, and over all the earth, and over every creeping thing that creepeth upon the earth.
 27 So God created man in his own image, in the image of God created he him; male and female created he them.
 28 And God blessed them, and God said unto them, Be fruitful, and multiply, and replenish the earth, and subdue it: and have dominion over the fish of the sea, and over the fowl of the air, and over every living thing that moveth upon the earth.
 29 ¶ And God said, Behold, I have given you every herb bearing seed, which is upon the face of all the earth, and every tree, in the which is the fruit of a tree yielding seed; to you it shall be for meat.
 30 And to every beast of the earth, and to every fowl of the air, and to every thing that creepeth upon the earth, wherein there is life, I have

22a D&C 45:58; 132:63 (55-56, 63); Moses 2: 22; Abr. 4: 22.
 24a TG Order.
 26a Abr. 4: 27 (26-31); 5: 7. TG Godhead; Jesus Christ, Creator.
 b TG Creation.
 c TG Adam; Man, Physical Creation of.
 d Mosiah 7: 27; Ether 3: 15 (14-17); D&C 20: 18 (17-18); Moses 1: 6 (6, 13, 16); 2: 26 (26-29); 6: 9 (8-10); Abr. 4: 26 (26-31).
 e Gen. 5: 3.
 f Prov. 12: 10; D&C 49: 19 (18-21); 76: 111 (110-112); 121: 37 (34-46); Mos 28); Abr TG Man, Become Father.
 27a TG God, Christ, Creator.
 b TG Woman.
 28a TG Child b TG Birth Marriage
 c HEB ill: in v. 22.
 d TG Earth
 e Gen. 9: 2
 29a HEB food (29-30); (29-30).
 Word of

Жишээ нь, Эхлэл 1:26-г унш. Ингэхдээ, “Хүнийг өөрсдийнхөө дүр төрхөөр бид хийцгээе” гэсэн судрын ишлэл дэх бид гэдэг үгийн талаар та нар гайхаж болно. Бүтээлтэд Бурханд хэн тусалсан бэ? Сэдэвчилсэн Удирдамжид та нарт ишлэл зааж байгаа зүүвэр тайлбарыг ажигла. Есүс Христ бол Бүтээгч гэдгийг тод томруунаар хэлдэг судрын ишлэлийг ол. Христийг мэддэг өөр нэрсийн жагсаалтыг олохын тулд Библийн толь бичиг дэх “Христ” гэдэг үгийг хар (хуудас 633).

Иймээс Бошиглогч Иосеф Смит олон чухал үнэнийг сэргээж, зөв орчуулагдаагүй буюу эсвэл бүрэн биш байсан Библийн хэсгүүдэд олон чухал өөрчлөлт оруулсан юм (Итгэлийн Тунхаг 1:8-ыг үз). Сүнсээр өөрчлөгдсөн энэхүү хувилбарыг “Иосеф Смитийн Орчуулга” гэдэг. Уг орчуулга зүүвэр тайлбаруудад “ИСО” хэмээн товчлогддог. Иосеф Смитийн хийсэн зарим өөрчлөлт зүүвэр тайлбаруудад байдаг бол бусад нь “Иосеф Смитийн Орчуулга” нэртэй хавсралтуудад байдаг бөгөөд Библийн Хаан Жеймсийн Хувилбарын Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хэвлэлийн 797-р хуудаснаас эхэлдэг.

Матай 4:2-6-г унш. Иосеф Смитийн Орчуулга эдгээр шүлгүүдэд ямар чухал зүйлээр тусалсан бэ?

2 And when he had fasted forty days and forty nights, he was afterwards an hungred.
 3 And when the tempter came to him, he said, If thou be the Son of God, command that these stones be made bread.
 4 But he answered and said, It is written, Man shall not live by bread alone, but by every word that proceedeth out of the mouth of God.
 5 Then the devil taketh him up into the holy city, and setteth him on a pinnacle of the temple,
 6 And saith unto him, If thou be the Son of God, cast thyself down: for it is written, He shall give his angels charge concerning thee: and in their hands they shall bear thee up, lest at any time thou dash thy foot against a stone.
 7 Jesus said unto him, It is written again, Thou shalt not tempt the Lord thy God.
 8 Again, the devil taketh him up into an exceeding high mountain, and sheweth him all the kingdoms of the world, and the glory of them;
 9 And saith unto him, All these things will I give thee, if thou wilt fall down and worship me.
 10 Then saith Jesus unto him, Get thee hence, Satan: for it is written,

2a Mosiah 3: 7. TG Fasting.
 b Ex. 24: 18.
 2c JST Matt. 4: 2... and had communed with God, he was afterwards an hungred, and was left to be tempted of the devil.
 3a TG Devil.
 b TG Bread.
 4a Deut. 8: 3; D&C 84: 44 (43-44).
 b TG Mortality.
 c TG Bread.
 d TG Revelation.
 e TG God, Body of (Corporeal Nature).
 5a JST Matt. 4: 5 Then Jesus was taken up into the holy city, and the Spirit setteth him on the pinnacle of the temple.
 b Neh. 11: 1.
 6a JST Matt. 4: 6 Then the devil came unto him and said, If...
 b Matt. 27: 40; D&C 20: 22.
 7a D&C 10: (13-14), TG Christ, TG Test, Try.
 8a JST Matt. gain, Jesu Spirit, onc him...
 b D&C 10: Earthly.
 9a JST Matt. devil came again, and
 10a TG Devil.
 b TG Worship
 11a JST Matt. now Jesu John was prison, an angels, an they came tered unt

Үгс болон Өгүүлбэрүүдээр Тусал

Зарим үгс, өгүүлбэр буюу холбоо үгс нь дараах байдлаар товчлогдсон байгаа:

- ЕВР: Еврей хэлнээс хийсэн орчуулгын (орлуулах) хувилбар (Хуучин Гэрээний анхдагч эх хэл).
- ГР: Грек хэлнээс хийсэн орчуулгын хувилбар (Шинэ Гэрээний анхдагч эх хэл)
- ӨХТ: Өвөрмөц үг хэллэгүүдийн тайлбар болон хэлзүйн хүнд хэцүү бүтцүүд (судрууд бичигдсэн үед хэрэглэгдэж байсан хэдий ч өнөө үед нийтээр хэрэглэгдэггүй үг хэллэгүүд).
- ХҮ: Хуучирсан үг хэллэгийн утгын тодруулга.

22a 1 Pet. 2: 8 (4-8).
 23a TG Treasure.
 b TG Celestial Glory; God, Glory of.
 25a IE Hosea.
 b Hosea 2: 23; Zech. 13: 9.
 26a GR sons. TG Sons and Daughters of God.
 27a IE Isaiah.
 b Isa. 10: 22.
 c TG Israel, Blessing of.
 d TG Israel, Remnant of.

28a D&C 52: 11.
 29a HEB hosts.
 b GR posterity.
 30a TG Righteousness.
 31a TG Apostasy, of Israel.
 32a GR Why.
 b Isa. 8: 14 (13-15); Matt. 21: 44 (43-45); Luke 2: 34.
 33a TG Cornerstone; Jesus Christ, Prophecies about.

Ром 9:29 дэх “Сабаот” хэмээх еврей үгийн утгыг мэдэж авснаар та нар ямар ойлголт олж авав?

Библийн Иосеф Смитийн Орчуулга

Библийг судалж, Библийн илүү бүрэн, зөв орчуулгатай болох илчлэлт эрэлхийлэхийг Их Эзэн, Бошиглогч Иосеф Смитэд зарлигласан билээ (С ба Г 37:1; 73:3-4-ийг үз).

Библийн Газрын Зургууд ба Гэрэл Зургууд

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс нийтлүүлсэн Библийн хавсралтад байдаг Библийн газрын зургууд болон гэрэл зургууд нь судруудад иш татагддаг газруудыг олоход чухал хэрэгтэй юм.

Бүлгийн Товч Агуулга, Хэсгийн Товч Агуулга ба Шүлгийн Хураангуй

Бүлгийн болон хэсгийн товч агуулгууд түүнчлэн шүлгийн хураангуй нь уншиж байгаа зүйлээ ойлгоход тань та нарт туслах нэн чухал үндсэн мэдээллээр хангах буюу тайлбарладаг. Жишээ нь, Сургаал ба Гэрээний 89-р хэсгийн товч агуулгыг уншсанаар та нар ямар ашигтай мэдээлэл олж авдаг вэ?

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлүүлсэн судруудад байдаг судлах тусламжуудтай байх нь бүгд нэг дор та нарт олоход— ишлэлүүдийн номны бяцхан цуглуулгатай байхтай адил юм!

Судлах Ур Чадвар

Бид судрууд дээр “найрлах” ёстой гэж Нифай (2Нифай 32:3) хэлсэн байдаг, тийнхүү Их Эзэн “[тэдгээрийг] хичээнгүйлэн судлахыг” Нифайчуудад зарлиглажээ (3Нифай 23:1). Ийм байдлаар судлах нь судруудыг зүгээр л хурдан гүйлгэж уншихаас илүү зүйлийг хамруулдаг. Дараах санаанууд хийгээд ур чадварууд нь судалж байгаа үедээ илүү их зүйл олж мэдэхэд тань та нарт туслах болно. Эдгээр нь: уншихын өмнө, уншиж байх үед, уншсаны дараа гэсэн гурван төрөлд хуваагддаг.

Уншихын Өмнө

Залбирал

Судрууд бурханлиг нөлөөлөөр бичигдсэн юм. Ийм учраас, бид Сүнсний нөхөрлөлтэй байгаа үед тэдгээр нь хамгийн сайнаар ойлгогддог. Хуучин Гэрээнээс бид “Эзэний хуулийг эрэлхийлэхэд өөрийн зүрх сэтгэлийг бэлтгэсэн” санваартан Езрагийн тухай мэддэг (Езра 7:10). Судар унших болгондоо залбирснаар та нар тэдгээрийг уншихад зүрх сэтгэлээ бэлтгэгтүн.



Тулгуур Мэдээлэл Олж Авах нь


Судруудын түүхийн тулгуурыг ойлгох нь уншиж байх үедээ илүү чухал ойлголтыг олж авахад та нарт тусална. Библийн Толь Бичиг түүхийн тулгуур материал хийгээд ном бүрийн агуулга болон үндсэн гол сэдвүүдийн товч хураангуйллаар хангадаг. Сургаал ба Гэрээний хэсгийн товч агуулга нь илчлэлтүүдийн түүхэн тулгуурыг товч тайлбарладаг. Энэ гарын авлага нь судрууд дээрх олон бүлэгт тулгуур материалыг өгнө. Хэрэв та нарт цаг байвал, уншиж байгаа судрын тань талаар тулгуур материалыг агуулсан, Сүмээс эрхлэн хэвлүүлсэн ном, гарын авлагуудад тэрчлэн хандаж болно.

Асуултууд Асуу

Уншихын өмнө “Эдгээр шүлгүүдийг хэнд зориулж, хэн бичсэн бэ?”, “Энэ заасан зүйл яагаад судруудад орсон юм бол?”, “Өнөөдөр би уншихдаа юуг сурч мэдэхийг хүсч байна?”, “Эдгээр шүлгүүдээс юуг мэдэж авахыг Их Эзэн надаас хүсэх байсан бол?” гэхчлэнгийн асуултуудыг өөрсдөөсөө асуух нь ашигтай. Та нар судар уншиж байхдаа, асуултуудынхаа хариуг эрж бай. Түүнчлэн та нар Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс нийтлүүлсэн судруудын хэвлэлүүд дэх судлах тусламжуудыг бас ашиглаж болно, эсвэл Сүмийн гарын авлагууд хийгээд нийтлэлүүдэд хариуг эрж болно гэдгийг санагтун.

Бүлгүүдийн товч агуулгыг унш

Бүлгүүдийн товч агуулга бол тухайн бүлэг дэх гол санаануудын товч хураангуйлал юм. Бүлгийг уншиж эхлэхээс өмнө тухайн бүлгийн товч агуулгыг унших нь зөвхөн судлах сайн дадал хэвшил төдийгүй, мөн уншиж байх үедээ өөрсөдөө асуултууд тавих болон хариултуудыг эрж хайхад тань та нарт туслах болно.




Унших Үедээ

Зогсолт Хийхээс Бүү Ай

Ихэнх цул алт газрын гадаргуу дээрээс олддоггүй—алтыг олохын тулд та нар газрыг ухах ёстой. Судар судлах явцдаа удаашрах буюу, зогсолт хийж, дараах зарим үйл ажиллагааг хэрэгжүүлбэл судар судлах нь та нарын хувьд илүү их үр дүнтэй байх болно.

Ойлгохгүй Байгаа Үгсийнхээ Утгыг Хар (Толь Бичгээс)



Толь бичиг ашигла. Зарим үед үгээ хараад мэднэ гэж боддог үг тань тухайн тохиолдолд нэмэлт ойлголт өгч болно. Энэ гарын авлагын “Судруудыг Ойлгох нь” хэсгүүд нь олон хүнд үг, өгүүлбэрүүдийг ойлгоход тань та нарт туслах болно.

Зарим үед Их Эзэн Өөрийн бошиглогчдыг бичсэн зүйлүүддээ үг, өгүүлбэрүүдийн утгыг

бидэнд ойлгомжтой болгохын тулд тайлбарлахад сүнсээр нөлөөлсөн байдгийг анхаар. Жишээ нь, Мозая 3:19-ийг унш, тэгээд хүүхэдтэй адил бол гэж Хаан Бэнжамин хэлсэн нь ямар утгатайг мэдэж ав.

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс Хэвлүүлсэн Судрууд Дахь Судлах Тусламжуудыг Ашигла

“Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс Хэвлүүлсэн Судрууд Дахь Судлах Тусламжууд” хэсгийг үз, хуудас 2–3.

Судартай Адилтгах

Өөрсдийнхөө нэрийг судрын шүлэгт ашиглах нь судруудын заадаг зүйлүүдийг илүү хувь хүний шинжтэй болгоход тусалдаг. Жишээ нь, Мосе 1:39-д “хүмүүн” гэдэг үгийн оронд та нар өөрсдийнхөө нэрийг хэрэглэхэд ямар ялгаа гарах вэ?

Санаандаа Төсөөл



Болж байгаа үйл явдлыг санаандаа төсөөлөн дүрсэл. Жишээ нь, та нар эхлэл 37-г уншиж байхдаа, хэрэв та нар гэр бүлдээ эрэгтэй дүү нарын нэг нь байсан бол, тэгээд ах нар тань бүгдээрээ чамайг үзэн ядаж, чамд атаархаж байсан бол чамд ямар бодол төрөх байсныг төсөөлөн бод.

Зарим үед судрууд бидэнд төсөөлөн бодохыг сануулдаг. Алма 5:15–18-ыг уншаад Алмагийн санал болгосныг хийхийн тулд зогс. Эдгээр шүлгүүдийг санаандаа төсөөлөн бодох үед ямар бодол төрсөн тухайгаа бичихийн тулд хэсэг цаг гарга.

Холбогч Үгсийг Хай

Мөн, гэвч, харин, учраас, иймээс, иймийн тул, гэсэн хэдийг гэх мэт үгс бол холбогч үгс юм. Та нар эдгээр үгсийг уншихдаа, эдгээр нь хоёр буюу түүнээс дээш санаануудыг ойлгоход та нарт хэрхэн тусалдгийг ажигла. Заримдаа эдгээр нь хоёр буюу түүнээс илүү зүйлүүд хэрхэн хоорондоо төстэй буюу ялгаатайг харуулсан байдаг.

Жишээ нь, хэрэв та нар Мозая 26:2–3-т байгаа *учраас* гэдэг үг юу зааж байгааг бодож үзэх юм бол, судар судлах тухай чухал үнэнийг та нар мэдэж авч чадна.

2 They did not believe what had been said concerning the resurrection of the dead, neither did they believe concerning the coming of Christ.

3 And now because of their unbelief they could not understand the word of God; and their hearts were hardened.

Сургаал ба Гэрээ 45:30–32-ыг уншиж, *гэвч* гэдэг үг хожмын өдрүүд дэх ёс бусчуудын хийгээд зөв шударга хүмүүсийн нөхцөл байдлуудын хоорондох эсрэг тэсрэг байдлыг хэрхэн харуулж байгааг ажигла.

30 And in that generation shall the times of the Gentiles be fulfilled.

31 And there shall be men standing in that generation, that shall not pass until they shall see an overflowing scourge; for a desolating sickness shall cover the land.

32 But my disciples shall stand in holy places, and shall not be moved; but among the wicked, men shall lift up their voices and curse God and die.

Загваруудыг Хай

2 Нифай 31:2-т Нифай хэлэхдээ, Христийн сургаалын талаар хэдэн үг хэлэхийг тэрээр хүслээ гэсэн байдаг. Тийнхүү шүлэг 21-д тэрээр Христийн сургаалыг тайлбарласан өөрийн гэрчлэлийг хэлсэн байдаг. Шүлэг 2–21-ийн хооронд Нифай Христийн сургаалыг заасан байдгийг мэдсэнээр бид Христийн сургаал гэж юу вэ гэдгийг улам сайн мэдэхийн тулд Нифайн үгсийг судлахаар эдгээр шүлгийг эргэн харж болно.

Учраас гэдэг үг хүмүүсийн итгэлгүй байдал хийгээд судрууд болон бошиглогчдын үгсийг ойлгох тэдний чадварын хоорондын шалтгаан, үр дагаврын харьцааг харуулдаг.

Гэвч гэдэг үгийг онцгойлон анхаарах нь Хоёр дахь Ирэлтийн өмнө тохиох зарим устгалуудаас зөв шударга хүмүүс хамгаалагдан үлдэх болно гэдэг баттай итгэлийг бидэнд өгч чадна.



Загвар олохын өөр нэг жишээ бол шалтгаан ба үр дагаврын тухай бошиглогчийн тайлбарыг эрж хайхдаа тэрээр *хэрэв, тэгвэл (дараа нь)* гэсэн үгсийг хэрхэн хэрэглэснийг ажиглах явдал мөн. Левит 26-д, Израилын хүүхдүүдэд тохиох адислалууд хийгээд зүхлүүдийн тухай Мосе бошиггосон байдаг. Шүлэг 3–4, 18, 23–24, 27–28, түүнчлэн 40–42-ыг харж,

хэрэв Израилын хүүхдүүд Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагах буюу дуулгаваргүй байх юм бол, тэдэнд юу тохиох талаар *хэрэв-тэгвэл* загварыг ашигласныг ажигла.

Үг буюу санааг давтах нь загвар эрэх өөр нэг хэлбэр мөн. Жишээ нь, Эхлэл 39-д Их Эзэн Иосефтой хамт байсныг зохиогч хичнээн удаа дурдсаныг ажигла.

Судрууд дахь Жагсаалтуудыг Олж Үз

Жагсаалтууд нь Их Эзэн болон Түүний бошиглогчдын заадаг зүйлүүдийг илүү тодорхой ойлгоход тань та нарт туслах болно. Арван Зарлиг бол жагсаалт юм (Египетээс Гарсан нь 20-ийг үз). Матай 5-дахь Ерөөлүүдийг жагсаалт гэж амархан хэлж чадна. Өөр жагсаалтуудыг олох нь бага зэргийн хүч чармайлт шаардана. Жишээ нь, Сургаал ба Гэрээний 68:25–31-д эцэг эхчүүдээс хүүхдүүдээ заах шаардлагатай зүйлүүдийн талаар Их Эзэний хэлснийг жагсаалт болго.

Асуултууд Асуу

“Уншихын Өмнө” хэсэгт та нарт зааварласанчлан, асуултууд асуухаа үргэлжлүүл. Та нар уншихдаа, уншихаас өмнө асуусан асуултуудаа дахин асуух буюу эсвэл огт өөр асуултуудтай ирж болно. Асуултуудад хариу эрэх нь бид судар судлахдаа илүү сайн ойлголт олж авах хамгийн чухал арга замуудын нэг мөн. Асуух хамгийн чухал асуултуудын нэг бол “Үүнийг судруудад оруулахын тулд Их Эзэн яагаад зохиогчид бурханлигаар нөлөөлсөн байж болох вэ?” гэсэн асуулт юм. “Мөн ийн бид харьюу” гэдэгтэй адил зүйлийн тухай ярьж байхдаа зохиогчид илэрхий түлхүүр үгнүүдийг үлдээдгийг эрж ол.

Судруудад Өгөгдсөн Асуултуудад Хариул

Их Эзэн олон удаа асуулт тавьж, тэгээд асуултууддаа хариулсан байдаг. Тэрээр Нифай шавь нараасаа, “Та нар ямархуу маягийн хүмүүс байвал зохих билээ?” гэж асуугаад, Тэрээр, “Бүр миний адил буюу” гэж гэж хариулсан байдаг (3 Нифай 27:27).

Бусад тохиолдлуудад хариулт нь ерөнхийдөө өгөгдөөгүй асуултууд асуусан байдаг—учир нь гэвэл зохиогч хариулт нь тодорхой байгаа гэж боддог байж болно. Заримдаа зохиогч хариуг өгдөггүй. Учир нь гэвэл, асуусан асуулт нь тунгаан бодох шаардлагатай буюу эсвэл тэр даруйд хариулах хэрэггүй байж болно. Жишээ нь, Марк 4:35–41-ийг унш, тэгээд эдгээр шүлгүүд дэх дөрвөн асуултад хариул.

Загвар болон Бэлэгдлийн Утгуудыг Хай

Бошиглогчид өөрсдийн захиасуудыг илүү хүчтэйгээр дамжуулахын тулд бэлэгдлүүд хийгээд уран дүрслэл ашиглах нь олонтаа байдаг. Жишээ нь, сургаалт зүйрлэлүүд бол захиасыг энгийнээр, түүнчлэн гүнзгий утгаар нь таниулах арга хэлбэр мөн. Сургаалт зүйрлэл дэх түүх нь илүү амархан тогтоогдох утга учир бүхий сургамжийг заадаг.

Дараах зөвлөмжүүд нь судрууд дахь бэлэгдлүүдийг ойлгоход та нарт тусалж чадна:

1. Тайлбаруудыг судруудад эр. Жишээ нь, 1 Нифай 8-д Лихай үзэгдэл харсан байдаг. Хожим нь Нифай аавынхаа харсан тэрхүү үзэгдлийг, аавынхаа үзэгдэл дэх бэлэгдлүүдийн тайлбарын хамт харжээ (1 Нифай 11–14-ийг үз). Заримдаа тайлбар нь зүүвэр тайлбарууд дахь харьцуулах ишлэлийг ашиглах үед тааралдаж болно.
2. Бэлэгдлийн онцлог шинжийн тухай, түүнчлэн уг бэлэгдэл нь та нарт юуг сурган зааж байгаа тухай бод. Алма Лиахонаг хүүдээ тайлбарлах үед энэ ур чадварыг ашигласан байдаг (Алма 37:28–47-г үз).
3. Бэлэгдэл нь зарим үед Аврагчийн тухай ямар нэг зүйлийг та нарт зааж байгаа эсэхийг хар. “Бүх зүйлүүд [түүний] тухай гэрчилдгийг” (Мосе 6:63) Их Эзэн Адамд хэлсэн байдаг. Жишээ нь, Абрахам хүү Исаакаа золиослох гэсэн түүхэн дэх янз бүрийн элементүүд нь Есүс Христийн золиослолын тухай хэрхэн гэрчилдэг вэ?

Бич

Жагсаалт, өөрсдийн мэдэж авсан өвөрмөц ойлголтууд, эсвэл уншсан зүйлийнхээ талаарх өөрсдийн бодол санаа гэхчлэн өөрсдийн санаж авахыг хүссэн санаануудыг тэмдэглэхийн тулд хэсэг цаас буюу тэмдэглэлийн дэвтрээ биендээ авч яв. Дараагийн удаа өөрсдийн унших санаанууд хийгээд ойлголтуудыг санахад тань туслахын тулд, та нар эдгээр санаануудыг түүнчлэн судрынхаа зах дээр тэмдэглэж авч болно.



Олон хүн чухал үгс болон өгүүлбэрүүдийг судрууд дээрээ тэмдэглэх дуртай байдаг. Үүнийг хийхэд зөв эсвэл буруу гэсэн зам байхгүй. (Та нар бүр хийхийг хүсэхгүй ч байж болно.) Зарим хүмүүс шүлгийг өвөрмөц утгатай болгож байгаа үг, өгүүлбэрүүдийн доогуур зурах буюу өнгөөр ялган будсан байдаг.

Сударт тэмдэглэл хийх өөр нэг арга бол харьцуулах ишлэлийг өөр судрын зах

дээр бичиж тэмдэглэх явдал мөн. Үүнийг хэд хэдэн шүлэгт хийснээр, энэ нь танд тодорхой сэдвээр судруудын гинжин холбоог харуулдаг адилхан сэдвийг үзүүлнэ. Ингэснээр та тэрхүү гинжин холбоондоо судруудын аль нэгийг хайн олж болно. Судруудад тэмдэглээ хийх нь чухал шүлгүүдийг илүү хурдан олоход тань та нарт тусалж чадна.

Уншсаны Дараа

Тунгаан Бод

Тунгаан бодох гэдэг нь ямар нэг юмны талаар гүнзгийгээр бодох, асуултууд тавих, өөрсдийн мэддэг хийгээд сурсан зүйлүүддээ үнэлэлт дүгнэлт өгөх замаар тухайн зүйлийг оюун санаандаа цэгнэх явдал мөн. Судрууд заримдаа үүнийг “бясалгах” гэж нэрлэсэн байдаг (Иошуа 1:8-ыг үз). Чухал илчлэлтүүд тунгаан бодсоны, ялангуяа судруудыг тунгаан бодсоны үр дүнд ирсэн сайн жишээ судруудад нилээд хэд байдаг (С ба Г 76:15–20; 138:1–11-ийг үз).

Судруудыг Өөрсөдтэйгөө Адилтга

Судруудыг өөрсөдтэйгөө адилтгах гэдэг нь тэдгээрийг өөрсдийнхөө амьдралтай жишиж харьцуулах явдал мөн. Судруудыг өөрсөдтэйгөө адилтгахын тулд, “Миний сая уншсан судруудад сайн мэдээний ямар зарчмууд заагдаж байна вэ?”, “Эдгээр зарчмууд нь миний амьдралтай хэрхэн холбогдож байна вэ?” гэх мэт асуултуудыг та нар тавих хэрэгтэй. Судруудыг өөрсөдтэйгөө адилтгахын нэг чухал хэсэг бол “та нарыг бүх үнэн рүү хөтлөх болно” (Иохан 16:13) хэмээн Их Эзэний амласан Сүнсний өдөөлтүүдийг сонсох явдал мөн.



Жишээ нь, Нифай өөрийнх нь болон гэр бүлийнх нь тухайн нөхцөл байдалтай Исаиагийн заасан зарим зарчмуудыг холбон үзсэнээр судруудыг өөртэйгөө болон гэр бүлтэйгээ адилтгасан байна. Израилын хүүхдүүдийн нэгэн адил ах нар нь Бурханаас нүүр буруулсан байхад—Бурхан тэднээс нүүр буруулаагүйг тэрээр ах нартаа заажээ. Тэрчлэн хэрэв тэд наманчлах юм бол, Их Эзэн тэдэнд нигүүлсэнгүй байж, тэднийг өршөөх болно гэдгийг тэрээр тэдэнд заажээ (1 Нифай 19:24; 21:14–16-г үз). Исаиагийн үгсийг өөртэйгөө болон ах нартайгаа адилтгаснаар Есүс Христийг Гэтэлгэгч гэж итгэх тэдний итгэл дээшилсэн юм хэмээн Нифай хэлсэн байдаг (1 Нифай 19:23-ыг үз).

Дахин Унш

Бид анх удаа уншаад судрын аль нэг хэсгээс юу ч мэдэж авдаггүй. Үнэндээ бол, судруудыг жинхэнэ ёсоор ойлгохын тулд хүн тэдгээрийг насан туршдаа судлах хэрэгтэй. Бид хоёр юм уу гурав дахин уншсаны дараа л загваруудыг харж, оюун санаандаа илүү сайн төсөөлдөг болж, судруудыг илүү гүнзгий ойлгож эхлэх нь олонтаа байдаг. Та нар дахин унших үедээ шинэ сургаалуудыг хайх буюу өөр асуултууд асууж болно. Аль нэг түүх юм уу эсвэл нэг буюу хоёр шүлгийг өөрсдийн үгээр дахин бичихийг хичээх нь уншсан зүйлээ ойлгосон байна уу, үгүй юү гэдгийг мэдэхэд тань, мөн энэ нь судруудыг илүү сайн ойлгоход тань та нарт тусална.

Бич

Зарим хүмүүс уншсан зүйлийнхээ гол санааг тэмдэглэх буюу эсвэл уншсан зүйлийнхээ талаар ямар бодол санаатай байгаагаа, эсвэл уншсан зүйлээ амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх талаар бодож байгаа зүйлээ бичиж тэмдэглэх дэвтэр хөтөлдөг. Хэрэв та нар энэ гарын авлагыг гэрээр судлах семинарт ашиглаж байгаа бол, та нар кредит авахын тулд тэмдэглэлийн дэвтэр хөтлөх шаардлагатай. Энэ тэмдэглэлийн дэвтэр нь судрын тэмдэглэл шиг байх болно.




Түүнчлэн уншсан зүйлийнхээ талаар бусадтай ярилцах нь сайн байдаг. Өөрсдийнхөө ярихыг хүссэн зүйлийг эргэн санахын тулд эсвэл мэдэж авсан зүйлийнхээ талаар ярилцах нь уншсан зүйлээсээ илүү ихийг эргэн санах буюу илүү сайн ойлгоход тань туслах болно.

Хэрэглэх нь

Судруудаас та нарын олж авсан мэдлэгийн жинхэнэ үнэ цэнэ нь та нар сурсан зүйлийнхээ дагуу амьдрахад ирдэг. Их Эзэнд нэн ойр дөт байх, Түүний өгдөг амар амгаланг мэдрэх нь сайн мэдээний дагуу амьдардаг хүмүүст ирдэг адислалуудын ердөө л нэг хэсэг нь юм. Түүнээс гадна, судруудаас сурсан зүйлийнхээ дагуу амьдардаг хүмүүст илүү их зүйл өгөгддөг бол, сурсан зүйлүүдийнхээ дагуу амьдардаггүй хүмүүс өөрсөддөө байгаа мэдлэгийг ч алдах болно гэж Их Эзэн хэлсэн байдаг (Алма 12:9–11–г үз).

“Христийн үгэн дээр хуримла; учир нь болгоогтун, Христийн үгс та нарын хийвэл зохих зүйлийг та нарт хэлэх болно” (2 Нифай 32:3).



Шинэ Гэрээг Унших Хуваарь

Би Арван Минут Буюу Түүнээс Илүү Унших Өдрүүд

Н	Д	М	Л	П	Б	Бя	1-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	2-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	3-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	4-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	5-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	6-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	7-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	8-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	9-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	10-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	11-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	12-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	13-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	14-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	15-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	16-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	17-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	18-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	19-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	20-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	21-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	22-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	23-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	24-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	25-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	26-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	27-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	28-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	29-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	30-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	31-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	32-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	33-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	34-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	35-р Долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	Бя	36-р Долоо хоног

Энэ Долоо Хоногт Миний Уншихаар Товлосон Бүлгүүд

“Судруудыг Судлах нь”
Матай 1 2 3 4 5
Матай 5 (үргэлжлэл) 6 7 8 9 10
Матай 11 12 13 14 15 16
Матай 17 18 19 20 21 22 23
Матай 24 25 26
Матай 27 28 Марк 1 2 3
Марк 4 5 6 7 8 9 10
Марк 11 12 13 14 15 16
Лук 1 2 3 4 5 6
Лук 7 8 9
Лук 10 11 12 13 14 15
Лук 16 17 18 19 20 21
Лук 22 23 24
Иохан 1 2 3 4 5
Иохан 6 7 8
Иохан 9 10 11 12
Иохан 13 14 15 16 17
Иохан 18 19 20 21
Үйлс 1 2 3 4 5
Үйлс 6 7 8 9 10 11 12
Үйлс 13 14 15 16 17 18 19 20
Үйлс 21 22 23 24 25 26 27 28
Ром 1 2 3 4 5 6 7 8
Ром 9 10 11 12 13 14 15 16
1 Коринт 1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14
1 Коринт 15 2 Коринт 1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13
Галат 1 2 3 4 5 6 Ефес 1 2 3 4 5 6
Филиппой 1 2 3 4 Колосай 1 2 3 4 1 Тесалоник 1 2 3 4 5 2 Тесалоник 1 2 3
1 Тимот 1 2 3 4 5 6 2 Тимот 1 2 3 4 Тит 1 2 3 Филемон 1
Еврей 1 2 5 7:1–4 11 12 13
Иаков 1 2 3 4 5 1 Петр 1 2 3 4 5
2 Петр 1 2 3 1 Иохан 1 2 3 4 5 2 Иохан 1 3 Иохан 1 Иуда 1
Илчлэлт 1 2 3 4 5 6 7
Илчлэлт 10 11 12 14 15
Илчлэлт 17 18 19 20 21 22

Аврагчийн Мөнх Бус Байдал Дахь Тохинууллын Цэдэг

Шинэ Гэрээ бол Аврагчийн мөнх бус байдал дахь тохинууллын үеийн Түүний амьдрал хийгээд заасан зүйлүүдийн тухай цэдэг юм. Энэ нь түүнчлэн Түүнийг тэнгэрт дээшлэн одсоны дараах Түүний Төлөөлөгчдийн аялал хийгээд заасан зүйлүүдийн тухай цэдэг юм. *Testament* гэдэг үг нь “гэрээ” гэсэн утгатай учир үүнийг Шинэ Гэрээ гэж нэрлэдэг. Гэрээнүүд гэдэг нь Бурханаас Өөрийн хүүхдүүдэд өгсөн эрхэм ариун амлалтууд юм. Эдгээр амлалтууд нь эдгээр гэрээнүүдэд дуулгавартай байснаар дамжуулан энэ амьдралд агуу адислалуудыг, ирэх дэлхийд мөнх амьдралыг олж авах боломжийг Түүний хүүхдүүдэд олгодог.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Брус Р.МакКонки, “Сайн мэдээний утгаар нь хэрэглэх юм бол, “testament” гэдэг нь Бурханаас Өөрийн хүмүүстэй хийсэн гэрээ юм. Тийнхүү сайн мэдээний бүрэн байдал бол шинэ бөгөөд үүрдийн гэрээ (С ба Г 22:1-ийг үз) харин бэлтгэл сайн мэдээ буюу Мосегийн хууль нь бага гэрээ юм. Сайн мэдээ цаг хугацааны голчид Есүс болон түүний төлөөлөгчдөөр сэргээгдсэн үед, Мосегийн өдрүүдээс хойш хүчин төгөлдөр байсан хуучин гэрээтэй харьцуулан үүнийг шинэ гэрээ гэжээ” хэмээн тайлбарласан байдаг (*Doctrinal New Testament Commentary*, 3 боть. [1966–73], 1:63).

Есүсийг Төрөх Үе дэх Израилын Угсаа

Эртний бошиглогчид Абрахам, Исаак, түүнчлэн Иаковын (нэр нь Израил болж өөрчлөгдсөн) өдрүүдээс Их Эзэн тэдний үр удам—Израилын угсааг Өөрийн гэрээт хүмүүс байлгахад сонгож авчээ. Тэр үед Есүс Христ төрж, Израилын угсааны ихэнх нь дэлхий даяар тараагдаж, мөн өөрсдийн ёс бусын улмаас түүхэнд алга болсон ажээ. Үлдсэн Израилчууд нь ихэнхдээ Иудейчүүд байсан бөгөөд тэд үнэнээс хазайж, сүнсний харанхуйд оржээ. Хуучин Гэрээний үеийн сүүлчийн бошиглогч Малахи Есүсийг төрөхөөс дөрвөн зуу орчим жилийн өмнө нас баржээ.

Есүсийг төрөх үед, Иудейчүүд улс төрийн хувьд ч мөн адил харанхуйд байлаа. Тэд тусгаар улс үндэстэн байсангүй, харин Ромын Эзэнт Гүрний байлдан дагуулж, хянадаг байсан нутаг дэвсгэрүүдийн нэг хэсэг байлаа (Өөрсдийнхөө Библийн хавсралт дахь Библийн газрын зураг 8-ыг үз).

Шинэ Гэрээний Оршил Тойм—Агуулгын Товьёог

Өөрсдийнхөө Библийн өмнөх “Хуучин ба Шинэ Гэрээний бүх Номнуудын Нэрс болон Дараалал”-ыг хар. Шинэ Гэрээний Номнууд нь он дарааллаар бус, харин номын төрлөөр эхлэгдсэн байдаг. Шинэ Гэрээний өөр өөр төрлийн номнуудыг эргэн санахын тулд агуулгын товьёогтоо тэмдэглэ (Bible Dictionary, “Bible,” х.622–24-ийг үз).

1. *Сайн Мэдээнүүд*. Матай, Марк, Лук, Иохан нарын номнуудыг Сайн Мэдээнүүд гэдэг бөгөөд эдгээр ном тус бүр зохиогчийнхоо нэрээр нэрлэгддэг. Gospel гэдэг үг “сайн мэдээ” гэсэн утгатай. Сайн Мэдээнүүд бол Есүс Христийн амьдрал хийгээд үүрэг зорилгын тухай эдгээр зохиогчдын гэрчлэлүүд юм (Bible Dictionary, “Bible,” х. 682–83-ыг үз).
2. *Төлөөлөгчдийн Үйлс*. Төлөөлөгчдийн Үйлсийг Лук бичсэн бөгөөд энэ нь Төлөөлөгчдийн чиглүүллийн доорх Сүмийн өсөлтийн тухай түүний өгүүлсэн шастир юм (Bible Dictionary, “Acts of the Apostles,” х. 603–4-ийг үз).
3. *Паулын Захидлууд*. Еврейчүүдээр дамжуулсан Ромын номнууд бол Төлөөлөгч Паулын бичсэн захидлууд (захианууд) юм. Эдгээр нь уг захидал тэдэнд бичигдсэн Сүмийн Салбар буюу хувь хүн эсвэл бүлгийн нэрээр нэрлэгдсэн юм (Bible Dictionary, “Pauline Epistles,” х. 743–48-ыг үз).
4. *Нийтлэг Захидлууд*. Иудагаар дамжуулсан Иаковын номнууд бол мөн л захидлууд юм. Эдгээрийг нийтлэг захидлууд гэж нэрлэх нь олонтаа бөгөөд уг захидлуудыг бичсэн Сүмийн удирдагчдын нэрээр нэрлэгджээ.
5. *Илчлэлтийн ном*. Илчлэлтийн номыг (заримдаа Апокалипс гэдэг) түүнчлэн Сайн Мэдээ болон түүний нэрээр нэрлэгдсэн захидлуудыг Төлөөлөгч Иохан бичсэн юм. Илчлэлт бол Их Эзэнээс Иоханы хүлээн авсан илчлэлтийн шастир юм (Bible Dictionary, “Revelation of John,” х. 762–63-ыг үз).

Шинэ Гэрээг Судлах нь Надад Юу Өгөх Вэ?

“Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн” (Иохан 17:3) гэж Аврагч гэрчилсэн байдаг. Шинэ Гэрээн дэх Түүний мөнх бус байдлын тохинууллын цэдэгт өгүүлснээс илүүгээр Аврагчийн тухай мэдэх аливаа илүү дээр газар бий юү?

Ерөнхийлөгч Жеймс И.Фауст хэлэхдээ: “Шинэ Гэрээ бол илүү сайн гэрээ юм, учир нь гэвэл зүрх сэтгэл хийгээд оюун ухааны бодолд их зүйл үлдсэн байдаг. Бодгалийн энэхүү сайжруулалт нь хувь хүний гэрчлэлийн нэмэгдсэн хүч чадлын нэг хэсэг мөн. Хэрэв зүрх сэтгэл хийгээд оюун санаанд гэрч байхгүй аваас, тэнд гэрчлэл байх нь үгүй. Аврагчийн заасан дагахад хэцүү тэрхүү сургаалуудыг судалж, сурч, тэдгээрийн дагуу амьдарцгаая, ингэснээр Христийнх шиг зан байдал биднийг сүнсний илүү өндөр амжилтад хүргэх болно” (*Finding Light in a Dark World* [1995], 16).

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли судар унших талаар Сүмийн залуу эмэгтэйчүүдэд хандаж хэлсэн үгэндээ: “Та нарын хувьд энэ нь ажил үүргээс хамаагүй илүү маш дурламаар зүйл байх болно гэдэгт би итгэдэг; энэ нь чухамдаа Бурханы үгтэй ажиллах хайрын ажил хэрэг байх болно. Та нарыг унших үед зүрх сэтгэл тань гэгээрч, сүнс тань өргөгдөх болно гэдгийг би та нарт амлаж байна. Эхлээд




энэ нь залхуутай юм шиг санагдаж болно, гэвч энэ нь бурханлиг зүйлүүдийн тухай бодол санаа хийгээд үгсийн гайхамшигт туршлага болон өөрчлөгдөх болно” (“The Light within You,” *Ensign*, 1995 оны Тавдугаар сар, 99).

Та нар Шинэ Гэрээ судлах үедээ Есүс Христийн тухай та нарт илүү ихийг зааж чадах үнэнүүдийг хийгээд Түүний сайн мэдээг амьдралдаа хэрхэн хэрэглэхийг эрж хай.

Судлах ажлынхаа нэг хэсэг

болгож, ойлголтууд хийгээд даалгавруудыг тэмдэглэлийн дэвтэр хөтлөх хэрэгтэй. Аврагчийн тухай мэдэж авсан, онцгой сэтгэгдэл төрүүлсэн зүйлүүдийг тэмдэглэж авч байхад анхаар. Энэ нь Сүнсний шивнээг сонсож сурахад та нарт тусалж, Есүс Христийн тухай гэрчлэлээр зүрх сэтгэлийг тань дүүргэх болно

Гэгээнтэн Матайн Сайн Мэдээ



Матай Ромын засгийн газрын татвар хураадаг байв.

Матай Гэж Хэн Байв?

Матай төрийн ажилтан, буюу Ромын засгийн газрын татвар хураагч байв (Матай 9:9-ийг үз). Тэрээр Аврагчийг дагахын тулд мэргэжлээ орхиж, анхны Арванхоёр Төлөөлөгчийн нэг болжээ. Түүнийг бас Леви гэдэг байв (Марк 2:14-ийг үз). Матайн тухай дэлгэрэнгүй мэдээллийг “Matthew” in the Bible Dictionary (х. 729-өөс үз).

**Хуучин Гэрээний
Бошиглал**

**Матайн
Ном**

**Есүс Христийн
Амьдрал**



Матай Яагаад Энэ Номыг Бичсэн Бэ?

Хэрэв Хуучин Гэрээний бошиглолууд хийгээд Есүс Христийн амьдрал дахь үйл явдлуудыг тусдаа хоёр гинжин хэлхээ болгон харьцуулах юм бол, Матайн гэрчлэл энэ хоёрыг хамтад нь нэгтгэсэн холбоос болж харагдах болно. Матай Шинэ Гэрээний бусад аль ч зохиогчоос илүүгээр Хуучин Гэрээг иш татсан байдаг. Матайн эхний шүлгүүд нь Есүсийн ирэлтийг Хуучин Гэрээний түүхийн үргэлжлэл мэтээр харуулдаг. Матай Есүсийг Хуучин Гэрээний амлалтууд хийгээд бошиглолуудыг хэрэгжүүлсэн гэдэгт онцгой анхаарал хандуулсныг дараах схем харуулж байгааг та нар унших үедээ олж мэдэх болно.

Бошиглолуудын Тухай Матайн Гэрчлэл Есүс Христээр Гүйцэлдэв

Бошиглал	Гүйцэлдэлт
Тэр онгон бүсгүйгээс төрөх болно (Исаиа 7:14-ийг үз)	Матай 1:18–23

Тэр Бетлехемд төрөх болно (Мика 5:2-ыг үз).	Матай 2:1–6
Тэр Абрахамын удмынх байх бөгөөд Давидын хаан ширээг залгамжлах болно (Исаиа 9:6–7; Абрахам 2:11-ийг үз).	Матай 1:1–17
Бусад үндэстнүүдийн хаад Түүний төрөлтөөр Түүнд бэлгүүд авчрах болно (Дуулал 72:10-ыг үз).	Матай 2:1–11
Бурханы Хүү Египетээс гарч явах болно (Хосеа 11:1-ийг үз).	Матай 2:13–15
Мессиа Назарин хэмээн нэрлэгдэх болно (мэдэгдээгүй)	Матай 2:23
Замыг бэлтгэхээр нэг хүн Мессиагийн өмнө хүрч ирэх болно (Исаиа 40:3; Малахи 3:1-ийг үз).	Матай 3:1–3; 11:10
Мессиа Галилд цагийг өнгөрүүлэх болно (Исаиа 9:1–2-ыг үз).	Матай 4:12–23
Мессиа сургаалт зүйрлэлүүд хэрэглэх болно (Дуулал 78:2; Исаиа 6:9–11-ийг үз).	Матай 13:10–15, 34–35
Агуу гайхамшгууд үйлдэгдэх болно (Исаиа 35:5–6-г үз).	Матай 11:4–5
Мессиа ард түмний захирагчдаар ад үзэгдэх болно (Дуулал 118:22; Исаиа 8:14-ийг үз).	Матай 21:42
Гучин мөнгөн зоосны төлөө Мессиагаас урвах болно (Зехариа 11:12-ыг үз).	Матай 27:3
Мессиагийн хацрыг саваадаж (Мика 5:1-ийг үз), нулиман (Исаиа 50:6-г үз), тохуурхах болно (Дуулал 22:7–8-ыг үз).	Матай 27:30–31, 39–44
Мессиад уулгахаар цуу өгөх болно (Дуулал 69:21-ийг үз).	Матай 27:34
Мессиа Түүний үхэлд буруутнуудын дунд тоологдох бөгөөд баян хүмүүстэй хамт оршуулагдах болно (Исаиа 53:9, 12-ыг үз).	Матай 27:38, 57–60

Мессиагийн тухай Хуучин Гэрээний бошиглолуудыг Есүс хэрхэн гүйцэлдүүлснийг харуулснаар Хуучин Гэрээнд Иудейчүүдийн хэрэглэж байсан Мосегийн хуулиас илүү дээд хуулийг Есүс Хэрхэн өгснийг Матай заасан байдаг (Матай 5–7; ялангуяа Матай 5:21–22, 27–28, 31–32, 38–42-ыг үз). Тэр бол Мессиа байсан гэдгийг нотлох олон гэрчлэл байсныг Иудейчүүдийн удирдагчид хэрхэн үл хайхран, Есүсийг ад үзсэн талаар Марк, Лук, Иохан нараас илүү олон тооны түүхийг Матай ярьсан байдаг. Ийнхүү Хуучин Гэрээний хууль хийгээд бошиглолын гүйцэлдүүлэлт болсон Есүсийг онцгойлон анхаарсан нь Есүс бол тэдний Мессиа байсан юм гэдгийг Матай Иудейчүүдэд мэдүүлэхийг хүсч, тэдэнд зориулан бичсэнийг харуулах гэсэн бололтой.

Зөвхөн Матайд

Есүсийн заасан олон зүйлүүд хийгээд түүхүүд Сайн Мэдээнүүдийн нэгээс олонд нь байдаг ч гэсэн, дараах зүйлүүд нь зөвхөн Матайд л байдаг билээ:

- Иосефын зүүд, Маритай гэрлэхээр шийдсэн (Матай 1:18–20-ийг үз), мэргэн хүмүүс ирсэн (Матай 2:1–13-ыг үз),

тэрчлэн Херодоос зугтааж Египет рүү явсан болон хүүхдүүдийг алсан түүх (Матай 2:14–18-ыг үз) гэхчлэн Есүсийн төрөлттэй холбоотой зарим нарийн ширийн зүйл.

- Уулан дээрх төгс Номлол (Матай 5–7-г үз).
- Бусад Сайн Мэдээнүүдэд байдаггүй арван сургаалт зүйрлэл.
- Аврагчийн Амилуулалтын дараа Гэгээнтнүүд амилуулагдан, хүрч ирсэн (Матай 27:52–53-ыг үз).
- “Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, над руу ир. Би та нарт амралт өгье” (Матай 11:28) гэх зэрэг олон-таа иш татагддаг, Есүсийн зарим чухал хэллэгүүд.

Матай 1

Есүс Христ Мэндлэв



Есүс бол Абрахамын удмынх, мөн хаан Давидын удмынх гэдгийг харуулахын тулд Матай гэр бүлийн чухал түүхээр өөрийн гэрчлэлийг эхэлжээ. Абрахамын удмынхан бүх дэлхийд авралыг авчран адислах болно хэмээн Бурхан Абрахамд амласан учир Абрахамын үр удам байх нь чухал учир холбогдолтой байлаа (Эхлэл

12:2–3; Абрахам 2:9–11-ийг үз). Мессиа бол Давидын шууд удам байх ёстой гэдгийг Иудейчүүд мэдэж байсан учир Хаан Давидын удам байх нь чухал учир холбогдолтой байв (Исаиа 11:1–9).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Жеймс Е.Талмейж, хэрэв Иудей Давидын үеэс хаадаар үргэлжлүүлэн захирагдсаар байсан бол Маригийн нөхөр Иосеф “Иудейн үе залгамжилсан хаан байх байлаа; мөн хаан ширээг хууль ёсоор залгамжлагч нь Есүс байх учиртай байв” (Jesus the Christ, 3 дахь хэвлэл, [1916], 87).

Христийн мэндэлсэн тухай түүх бас Лук 2-т байдаг. Лук 1, 2-т Маригийн тухай түүхийг өгүүлдэг бол Матай 1-д Иосефын тухай болон Христийн мэндэлсний тухай өгүүлдэг. Та нар Матай 1:18–25-ыг судлахдаа, Иосефыг Есүсийн хувьд сайн асран хамгаалагч хийгээд сайн эцэг болгосон чанаруудыг эрж хай.

Матай 1-д Та Нарын Уншдаг Зүйлүүдийн Бусад Шастирууд

Матай 1:1–17—Лук 3:23–38

Матай 1:18–24—Лук 2:1–7

Судруудыг Ойлгох нь



Матай 1

Хүүхэд олох (ш.18)—

Жирэмслэх, хөл хүнд болох

Хүүхэдтэй болох (ш.23)—

Хүүхэдтэй болох, жирэмсэн

болох

Ариун Сүнсээр (ш.18)—Энэ

нь Ариун Сүнсний хүчээр

тохиов (гэвч Ариун Сүнс

Түүний эцэг биш)

Зөвт (ш.19)—Зөв шударга

Орчуулбал (ш.23)—

Орчуулах аваас, орчуулбал

Онгон хэвээр нь байлгах

(ш.25)—Түүнтэй бэлгийн

харилцаанд орсонгүй

Матай 1:18–19—“Сүй Тавив”

Сүй тавилт бол гэрлэх албан тохиролцоо юм. Уг тохиролцоо нь нэн чанд байсан бөгөөд хэрэв хүн сүй тавилтын үед итгэлтэй бус байсан бол үүнийг садар самуун явдал гэж үзэн, түүнийг үхлээр шийтгэх ёстой гэж үздэг байв (Дэд Хууль 22:23–24-ийг үз). Чухам энэ нь, Марийн жирэмсэлсэн талаар санаа нь их зовж, энэ талаар яах ёстойгоо Иосеф бодож байсны шалтгаан юм.

Судруудыг Судлах нь



Матай 1-ийг судлах үедээ үйл ажиллагаа А-г хий.

А Есүст Эцэг Бэлтгэсэн нь

1. Марийг хүүхэд төрүүлэх нь гэдгийг мэдсэн үедээ Иосеф юу хийхийг хүсч байсан бэ? (Матай 1:18–19-ийг үз).
2. Иосеф зүүдэнд нь тэнгэр элч айлчилсныг харсны дараа яахаар шийдсэн бэ? (Матай 1:20–25-ыг үз).
3. Хэдийгээр Иосеф Есүсийн төрүүлсэн эцэг нь биш боловч, мөнх бус байдалд Есүсийн эцэг нь байхаар Тэнгэрлэг Эцэгийн итгэмжлэл хүлээлгэсэн тэр хүн байх учиртай байжээ. Матай 1:18–25 дахь нөхцөл байдлуудад Иосеф хэрхэн хариу үйлдэл үзүүлснийг ажиглаж, та нар эцэг эх болохоор бэлтгэхийн тулд өөрсөддөө хөгжүүлж болох түүний батлан үзүүлсэн чанаруудаас хамгийн наад тал нь хоёрынх нь тухай бич.

Матай 2

Мэргэн Хүмүүс Есүсийг Эрж, мөн Олов

Есүсийг мэндэлсэн үед Иудейчүүд Ромын захиргаанд байсан бөгөөд Ромчууд Херодыг тэдний хаан байхаар томилсон байв. Херод бол Харь хүн, Иудейчүүдийн итгэлд хөрвүүлэгдсэн Идум хүн байжээ. Тэрээр Иудейчүүдийн ариун сүмийг асар их үнээр дахин барьж, тэдэнд тал олохыг хичээж байлаа. Тэрчлэн түүний хаанчлал түүний хүч хийгээд харгис үйлдлүүдэд нь заналхийлж болох хүн бүгдийн хувьд атаа хорслоороо нэрд гарсан байлаа.

Эдгээр харгис үйлдлүүдийн нэгнийх нь тухай Матай 2-т цэдэглэсэн байдаг (Энэ хаан болон түүний гэр бүлийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Bible Dictionary, х. 700–1, “Херод”-оос үз).



Мэргэн Хүмүүс Одоор Удирдагджээ

Матай 2-т, саяхан төрсөн “Иудейчүүдийн Хааныг” эрж “дорнын мэргэн хүмүүс” (зурхайчид) Иерусалимд байсан Херод уруу очсон тухай та нар мөн унших болно. Дорнын эдгээр мэргэн хүмүүсийн тухай олон түүх хийгээд домгууд яригддаг. Аврагчийн мэндэлсэн хийгээд түүний анхны жилүүдийн тухай Матай өөрийн гэрчлэлд яагаад тэдний тухай тусгайлан дурдсаныг тайлбарлахын тулд тэрээр юу хэлснийг эрж хай. Библийн Толь Бичигт “Маги” болон “Дорнын мэргэн хүмүүс”-ийг үзсэнээр Аврагчийн мэндэлсэн тухай эдгээр гэрчүүдийн тухай та нар илүү ихийг мэдэж чадна (Bible Dictionary, х. 727–28, 789).

Иосеф Смитийн Орчуулгаас (ИСО) энэ бүлэгт чухал нэмэлтүүд байдгийг анхаар.

Матай 2-т Та Нарын Унших Зүйлийн Талаарх Бусад Шаструуд

Матай 2:22–23—Лук 2:39

Судруудыг Ойлгох нь

Матай 2

Хуулийн багш нар (ш.4)—Иудейн хууль, дүрмийн багш нар

Нууцаар (ш.7)—Нууцаар, сэмхэн

Асуужээ (ш.7, 16)—Асуув, асуужээ

Гүгэл, мир (ш.11)—Үнэртэй ус болгон хэрэглэдэг, түүнчлэн шагааж утлагад хэрэглэдэг (хурц үнэрт) ургамлууд

Хөнөөлгөв (ш.16)—Алуулав

Гашуудал, уй гашуу (ш.18)—Гашуудаж, уйлан гунигтай байх

Тийшээ (ш.22)—Тэнд, тийшээ

Явав (ш.22)—Буцаж явав

Матай 2:2—“Бид Түүний Одыг Харсан”

Хэдийгээр Тооллогын номон дахь бошиглол Мессиаг “Иаковаас Гарсан Од” хэмээн нэрлэдэг ч гэсэн Хуучин Гэрээнд Мессиагийн мэндэлсний тэмдэг болох одны тухай тусгай бошиглол байдаггүй. Гэтэл Мормоны Номын Бошиглогч Самуел, Аврагчийн мэндэлсний тэмдэг болох нэгэн “шинэ одны” тухай бошиглосон байдаг (Хиламан 14:5–ыг үз).



Бяцхан хүү Есүс болон Түүний эцэг эхийн аялал

Судруудыг Судлах нь

Матай 2-ыг судлах үеэрээ дараах үйл ажиллагаануудаас хоёрыг нь (А–В) хий.

А Зөвхөн Баримтууд

“Дорнын мэргэн хүмүүсийн” тухай олон түүх хийгээд домгууд яригддаг, Матай 2:1–13 дахь мэдээллийг ашиглан, эдгээр нэрд гарсан хүмүүсийн тухай дараах асуултуудад хариул:

1. Тэд хэдүүлээ байсан бэ?
2. Есүсийг хаана хайхаа тэд яаж мэдсэн бэ?
3. Тэд яагаад тийшээ явсан бэ?
4. Тэд Есүсийг яг хаана олсон бэ?
5. Есүс дээр очоод тэд юу хийсэн бэ?
6. Есүс дээр ирсэнийхээ дараа тэд яасан бэ?

Б Давтагдсан Санааг Ажигла

Матай 2-т бичигдсэнээр Есүс яагаад Бетлехемд төрж, Египет рүү аваачигдан, дараа нь Назарт өссөн бэ? Сургаал ба Гэрээний 1:38–ын ишлэлийг яагаад эдгээр зүйлүүд тохиох шаардлагатай байсныг өгүүлдэг дараах гурван шүлгийн нэгтэй нь буюу эсвэл бүгдтэй нь та нар зэрэгцүүлэн бичиж болно.

В Есүсийн Тухай Би Юу Мэддэг вэ?

1. Доорхын адил хуваарийг тэмдэглэлийнхээ дэвтэрт хийж, Матай 2:1–10-т уншсан зүйл дээрээ тулгуурлан үүнийгээ бөглө.

ЯМАР ХҮМҮҮС?	ЕСҮСИЙН ТУХАЙ ТЭД ЮУ МЭДЭЖ БАЙСАН БЭ?	ТЭД МЭДЭЖ БАЙСАН ЗҮЙЛЭЭРЭЭ ЮУ ХИЙСЭН БЭ?
Мэргэн хүмүүс		
Херод		
Ахлах Тахилчид ба Хуулийн Багш нар		

2. Дараах асуултын хариуг бич: Есүсийн тухай би юу мэддэг вэ? Би мэддэг зүйлээрээ юу хийх вэ?

Матай 3

Иохан Баптист Есүст Баптисм Хүртээв

Иосеф Смитийн Орчуулга Есүсийн хүүхэд ахуй үе хийгээд Тэрээр насанд хүрсэн үеийн тухай товч мэдээллийг нэмсэн юм (ИСО, Матай 3:24–26-г үз) Матай 3 Есүсийг гуч орчим настай байх үеэс эхэлдэг. Есүс Христийн тухай гэрчилсэн Иохан Баптист хэмээн нэрлэгддэг байсан хүнтэй бид энэ бүлэгт танилцдаг. Есүсийг мэндлэхээс зургаан сарын өмнө тохиосон Иоханы төрөлтийн тухай түүхийг Лук 2:5–25-д өгүүлдэг. Тэндэх нутгийн хоёр болон түүнээс доош настай хүүхдүүдийг Херод алуулах үед (Матай 2:16–18-ыг үз), Иоханы ээж түүнийг аглаг буйдад нуусан бөгөөд Иоханыг хаана нуусныг хэлээгүйн улмаас Иоханы аав алагдсан ажээ (Teachings of the Prophet Joseph Smith, Joseph Fielding Smith-ийн түүвэр зохиолууд [1976], х. 261, түүнчлэн Матай 23:35-ыг үз).

Иохан Баптист Аароны Санваарын түлхүүрүүдийг атгадаг байсан (С ба Г 13-ыг үз) бөгөөд түүнийг төрөхөөс хэдэн зуун жилийн өмнө түүний нэн чухал үүрэг зорилгын талаар бошиглогчид угтан хэлж байжээ (Исаиа 40:3; Малахи 3:1; 1 Нифай 10:7–10-ыг үз). Матай 3-т, тэрээр Аароны Санваарын түлхүүрүүдийг тэрээр хэрхэн нэн чухал арга замаар хэрэглэж байсан тухай бид уншидаг.

Та нар Матай 3-ыг унших үеэрээ Иоханы заасан зүйлээс баптисмын ач холбогдлын тухай, Есүс юу хийсэн хийгээд Тэнгэрлэг Эцэг юу гэж хэлсэн талаар юу мэдэж авснаа эргэцүүлэн бод.

Матай 3-т Та Нарын Унших Зүйлийн Талаарх Бусад Шастирууд

Матай 3:1–12—Марк 1:2–8; Лук 3:1–20

Матай 3:13–17—Марк 1:9–11; Лук 3:21–22; түүнчлэн

Иохан 1:29–34 дэх Иоханы гэрчлэлийг үз.

Судруудыг Ойлгох нь



Матай 3

Дээл (ш.4)—Хувцас, өмсгөл

Суран бүс бүслэх (ш.4)—Бүсэлхийгээрээ суран бүс бүслэх

Хоол хүнс (ш.4)—Хоол, хүнс, идэх юм

Фарисайчууд ба Садукайчууд (ш.7)—

Иудейчүүдийн удирдагчдын хоёр өөр бүлэг (Bible Dictionary, “Pharisees” and “Sadducees,” х. 750, 767-г үз)

Хорт могойнууд (ш.7)—Хорт (наж) могойнууд (ёс бус явдлын бэлэгдэл байх нь олонтаа тохиолддог)

Уур хилэн (ш.7)—Уур, хилэгнэл

Үр жимс (ш.8)—Үр дүн, үйлдэл, үйл ажиллагаа

Моддын үндсэнд сүх хэдийнэ зоогджээ (ш.10)—Шүүлт ойрхон байгаа буюу

Түүний нутагт үр жимс өгдөггүй модыг Бурхан тас тавчин хаях гэж байгаа тухай бэлэгдлийн хэллэг

Авч явах (ш.11)—Үүрэх, хүлээх (өгүүлбэр нь бүхэлдээ, Аврагчийн үүрэг зорилго бол түүнийхээс хавьгүй агуу их гэдгийг Иохан

бэлэгдлийн хэлбэрээр хэлжээ; ИСО, Матай 3:38-ыг үз)

Шигшүүр (ш.12)—Улаан буудайн үрийг гадуурх хөнгөн хальснаас (үүнийг будааны хальс гэдэг бөгөөд иддэггүй) салгахад ашигладаг багаж



Тариа Шигших

Үтрэмээ цэвэрлэх (ш.12)—Ургацынхаа газрыг цэвэрлэх

Түүнийг болиулав (ш.14)—Хэрэггүй гэж түүнд хэлэв

Бидэнд зохицож байна (ш.15)—Бидний хийх зөв зүйл мөн үү

Бууж (ш.16)—Бууж ирэх

Гарч (ш.16)—Газар дээр гарч ирэх

Судруудыг Судлах нь



Матай 3-ыг судлах үеэрээ үйл ажиллагаа А-г, дараа нь Б, В хоёрыг хий.

А Аароны Санваарыг Ашиглах нь

1. 1829 онд Аароны Санваарыг Иохан Баптист дэлхий дээр сэргээх үедээ тэрээр юу гэж хэлснийг Сургаал ба Гэрээ 13-т өгүүлдэг. Тэрбээр Аароны Санваарын гурван түлхүүр: (1) тэнгэр элчүүдийн тохинууллын түлхүүрүүд, (2) нананчлалын сайн мэдээний түлхүүрүүд, (3) нүглүүдийн ангижралын төлөө усанд умбуулах баптисмын түлхүүрүүдийн тухай ярьжээ. Эдгээр гурван түлхүүр тус бүрээр, Иохан тухайн түлхүүрийг ашиглаж байсныг дүрсэлсэн шүлэг буюу (бүлэг шүлгийг) Матай 3-аас ол. (Тэнгэр элчүүдийн тохинууллын түлхүүрийг ойлгоход

туслалцаа авахын тулд Моронай 7:29–32–ыг уншиж болно. Энэхүү захиас нь Иохан хийж байсантай бүр ч тохирч байж болно.) Өөрсдийн сонгож авсан шүлэг бүрээр Иоханы үйл ажиллагаа тэрхүү санваарын түлхүүрийг хэрхэн батлан харуулдаг байсныг товч тайлбарла.

2. Аароны Санваарын мөнхүү эдгээр гурван түлхүүрийг өнөө үед Аароны Санваарыг атгагчид ашиглахад зөвшөөрөгддөг арга замуудыг дүрсэл.

Б Есүсийн Баптисм

Дараах асуултуудад хариул:



1. Ямар зорилгоор Иохан Иудейчүүдэд баптисм хүртээж байсан бэ? (Матай 3:11-ийг үз).
2. Ямар зорилгоор Есүс баптисм хүртсэн бэ? (Матай 3:13–15; 2 Нифай 31:5–9-ийг үз).
3. Яагаад Есүс баптисм хүртэхээр Иохан уруу очсон гэж та нар боддог вэ?
4. Усанд умбуулах нь яагаад баптисмын чухал бэлэгдэл байдаг вэ? Матай 3:13–17 дахь ямар

түлхүүрүүд Есүс усанд умбуулалтаар баптисм хүртсэнийг ойлгоход бидэнд тусалдаг вэ?

5. Тэнгэрлэг Эцэг баптисмыг баталсан гэдгийг Тэрбээр хэрхэн харуулсан бэ?

В Номлогч Байх нь

Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ болон Ариун Сүнс нь тус тусдаа гурван хүмүүн биет гэдгийг та нар Сүмийн гишүүн бус хүнд тайлбарлахын тулд Матай 3:13–17-г хэрхэн ашиглахаа бич.

Матай 4

Уруу Таталтууд ба Есүсийн Тохинуулал Эхэлсэн нь

Есүс зөвхөн нүгэлгүй байсан төдийгүй, харин Тэрбээр “нүгэлгүй атлаа, бүх талаар бидэн шиг соригдсон” (Еврей 4:15) гэдгийг мэдэх нь бидний хувьд чухал ач холбогдолтой юм. Тэрбээр үүнийг биеэрээ амсч, мөн эсэргүүцсэн учраас сорилтыг (уруу таталт) ойлгодог билээ. Матай 4:1–11-ийг уншихдаа, уруу таталтыг хэрхэн даван туулах талаар бидэнд үзүүлсэн Түүний төгс үлгэр жишээг ажигла. Түүнчлэн Тэрбээр Өөрийн сайн мэдээг нийтэд номлохоор бэлтгэж байх үед энэхүү сорилт ирснийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Аврагчийн сайн мэдээг өнөөдөр номлох хүмүүсийг ч Сатан уруу татахаар эрэл-

хийлдэг. Бид Есүс Христийн нэрээр зааж, тохинуулах өөрсдийн дуудлагуудыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд эдгээр уруу таталтуудыг даван туулахад суралцах ёстой.

Матай 4-ийн үлдсэн хэсэг нь Есүс Өөрийн хүмүүсийн дунд номлож, тохинуулж эхэлсэн үед Тэрбээр юу хийж, юу хэлсэн тухай бидэнд өгүүлдэг. Энэ бүлэгт зориулсан Иосеф Смитийн Орчуулгыг бүгдийг нь унш. Эхний арван нэгэн шүлэгт зарим нэн чухал өөрчлөлтүүд байдаг.

Матай 4-т Та Нарын Унших Зүйлийн Талаарх Бусад Шастирууд

Матай 4:1–11–Марк 1:12–13; Лук 4:1–13

Матай 4:12–17–Марк 1:14–15

Матай 4:18–22–Марк 1:16–20; Лук 5:1–11

Судруудыг Ойлгох нь



Матай 4

Соригч (ш.3)—Сатан, чөтгөр

Гарах (ш.4)—Гардаг, гарах

Ариун Хот (ш.5)—

Иерусалим

Орой дээр (ш.5)—Цамхаг

Үсрэх, хорих (ш.6, 12)—Хаях

(шпоронд хорих)

Чамд санаа тавих үүрэг

(ш.6)—Чамайг харж хандан

чамд туслах эрх мэдэл

буюу үүрэг

Эс тэгвэл (ш.6)—Ингэсэн

тохиолдолд

Цохих (ш.6)—Цохих, дэлсэх,

мөргөх

Зайл чи (ш.10)—Зайлах, холдох

Тэр даруй (ш.20)—Үтэр түргэн, нэн даруй

Тэндээсээ (ш.20)—Тэндээс

Синагогууд (ш.23)—

Шашны үйлчлэлийн тулд

Иудейн итгэл бүхий хүмүү-

сийн хамтдаа цугладаг

барилгууд

Бүхнийг (ш.24)—Өөр өөр, янз бүрийн

Зовж шаналсан (ш.24)—

Өвчин зовлонтой

Матай 4:1—Цөл

Иудейн цөл бол амьдрахад хэцүү бэрх газар юм. Энэ бол маш тачирхан ургамалтай, элсэрхэг, хад чулуутай хөрс бүхий нэн хуурай цөл юм. Зун энд Фаренгейтын 115 хэм (цельсийн 46 хэм) халуун болдог байна.

Матай 4:1–11—Уруу Таталтыг Хэрхэн Даван Туулах вэ

Түүнд уруу таталтууд (сорилтууд) ирэх үед Есүс ердөө л “анхаарахгүй” байсныг өгүүлснээрээ Сургаал ба Гэрээ 20:22 нь бидэнд нэмэлт ойлголт өгдөг. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Нил А.Максвелл, “Есүсийн адилаар уруу таталтуудыг анхаарахгүй байхын оронд, үүнийг анхаарсан олон хүмүүст бэрхшээл зовлон учирсан байдаг! Бидний оюун санаанд орж ирсэн муу муухай бодол санаанаас хол байх нь бидний хувьд боломжгүй байх нь олонтаа тохиолдох ч гэсэн, бид уруу таталтад сандал өгч, суухыг урих ёсгүй гэж манай номлолын ерөнхийлөгч хэлдэг байлаа” хэмээн хэлжээ (“I Will Arise and Go to My Father,” *Ensign*, 1993 оны 9-р сар, 67).

Судруудыг Судлах нь

Матай 4-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Уруу Таталтыг Эсэргүүцэх нь

1. Дараахтай адил хуваарь хийж Матай 4:1–10 дахь мэдээллүүдээр түүнчлэн өөрсдийн санаанууд хийгээд туршлагаар үүнийг бөглө.

	Анхны Сорилт (ш. 2–4)	Хоёр дахь Сорилт (ш. 5–7)	Гурав дахь Сорилт (ш. 8–10)
Сорилт гэж юу байсан бэ?			
Есүс үүнд хэрхэн хариулсан бэ?			
Өнөө үед Сатан иймэрхүү аргаар биднийг хэрхэн сорьдог вэ?			

2. Дээрх гурван сорилт тус бүрийг Есүс анхаарахгүй байсан аргуудтай юу төстэйг ажигла. Есүсийн хийсэн зүйл дээр тулгуурлан, сорилтуудыг эсэргүүцэх талаарх дараах зөвлөгөөг дуусга: Сорилтыг эсэргүүцэх надад байдаг хамгийн чухал арга хэрэгслүүдийн нэг бол. . .

Б Намайг Дага



“Ирж, намайг дага”

1. Есүс Өөрийгөө дагахыг тэднээс хүссэн Матай 4:18–22 дахь дөрвөн хүнийг нэрлэн жагсаа.
2. Тэдгээр хүмүүс Есүсийг дагахын тулд юугаа орхисон бэ, тэд яагаад ингэсэн гэж та нар боддог вэ?

3. Дараах хоёр нөхцөл байдлаас нэгийг нь сонго: Сүмд элсэхээр бодож байгаа хүн эсвэл номлолд үйлчлэх дуудлага хүлээн авах гэж байгаа хүн. Сонгосон нөхцөл байдлынхаа хувьд, тухайн нөхцөл байдал дахь хүн юугаа орхиж болохыг жагсаагаад дараа нь, яагаад энэ нь золиослолын хувьд үнэ цэнэтэй талаар тухайн хүнд юу гэж хэлэхээ бич.

Матай 5

Уулан Дээрх Номлол, Хэсэг 1

Хэрэв Христийн тухай нэн бага мэддэг хүнд Түүний заадаг зүйлүүдийг тоймлон ярихыг танаас хүсвэл та юу ярих вэ? Матай 5–7-д байдаг Уулан дээрх Номлолоос их зүйлийг та ярьж болно. Есүс Амилуулалтынхаа дараа Нифайчууд дээр очиж, бараг л үүнтэй адил номлолыг Тэрээр тэдэнд өгснийг бид мэдэхдээ энэхүү номлол хичнээн чухал ач холбогдолтойг ухааран ойлгодог. (3 Нифай 12–14-ийг үз) Уулан дээрх номлолын заадаг зүйлүүд, Христэд итгэгч байх гэдэг нь юу гэсэн үг болох хийгээд эдгээр заадаг зүйлүүдийн дагуу амьдрах нь Бурханы хаант улсад авралыг хүлээн авахад зайлшгүй чухал болохыг ойлгоход бидэнд тусалдаг (Матай 7:21, 24–27; 3 Нифай 15:1-ийг үз). Төлөөлөгч асан, Ахлагч Брус Р. МакКонки, “Энэхүү номлол бол . . . хүмүүн авралыг олохын тулд юу хийвэл зохих ёстой тэр зүйлийн товч хураангуйлал . . . ; мөн сонсогчид (түүнчлэн уншигчид) үүн дотроос өөрсдийн сүнсний чадварын хэмжээгээр олж авах мөнхийн үзэл баримтлалууд байгаа юм” гэж бичжээ (The Mortal Messiah: From Bethlehem to Calvary, 4 боть. [1979–81], 2:116).



Матай 5 нь Ерөөлүүд хэмээн нэрлэгддэг цуврал заалтуудаар эхэлдэг. Ерөөл гэдэг үг нь “аз жаргалтай, заяа хийморьтой буюу адислагдсан байх” гэсэн үгнээс гаралтай ажээ. Адислагдсан гэдэг үг шүлэг 1–12-т есөн удаа гардаг. Есүс Өөртөө ирсэн бүхэнд санал болгосон энэхүү жинхэнэ аз жаргалыг олж авах арга замыг Тэрээр тайлбарлахдаа энэ үгийг тухайн бүр хэрэглэсэн байдаг. Христийн заадаг эдгээр зүйлүүдийг өөрсдийнхөө амьдралд хэрхэн хэрэглэж болохыг анхааралтай авч үз.

Түүний хуулиуд хийгээд зарлигууд нь хэрхэн Мосегийн хуулиас илүү өндөр зөв шударга ёсны жишгийг шаардда-

гийг Есүс Матай 5-ын үлдсэн ихэнх хэсэгт заасан байдаг. Мосегийн хууль нь мөнх амьдралтай болгохын тулд хүмүүсийг Бурханы оршихуйд авчрах хүчгүй байдаг бол, энэхүү илүү өндөр хууль тэнгэрийн хаант улсад ороход нь тэдэнд тусалж, тэднийг Тэнгэр дэх Эцэгтэй адил “төгс” болгох болно гэж Есүс амлажээ.

Судруудыг Ойлгох нь



Матай 5

Дөлгөөн (ш.5)—Бардам бус, Их Эзэнд захирагдах хүсэлтэй

Энэрэнгүй (ш.7)—Нигүүлсэнгүй, өршөөнгүй, уучламтгай

Доромжлох (ш.11)—Хэл амаар дормжилж, муу зүйлүүд хэлэх

Сав (ш.15)—Сав, сагс

Үсэг, зураас (ш.18)—Өчүүхэн жижиг зүйлс (энд : Еврей хэлний бичгийн хамгийн жижиг тэмдгүүд)

Зөвлөлийн өмнө буруутай (ш.22)—Иудейн шашны удирдагчдын өмнө хариуцлага хүлээхээр дуудагдах

Ямар нэг юм (ш.23)—Ямар нэг зүйл, юм

Эвлэр (ш.24)—Хүнтэй эвлэрэх, асуудлыг шийдэх

Арцалдагч (ш.25)—Дайсан, дайсагнагч

Завхайрал (ш.27–28, 32)—Садар самуун, эхнэр буюу нөхрөөсөө өөр хүнтэй бэлгийн харилцаанд орох

Тачаадах (ш.28)—Хэн нэгний тухайд бэлгийн харилцааны тачаангуй хүсэлтэй байх

Дээр (ш.29–30)—Илүү дээр, дээр

Салах (ш.31–32)—Эхнэр буюу нөхрөөс салах

Өөр (ш.32)—Өөр, бусад

Садар самуун (ш.32)—Бэлгийн харилцааны нүгэл

Хуурамчаар тангараглах (ш.33)—Худал тангараг өргөх, амлалтаа зөрчих

Тангараглах (ш.34)—Бурханы нэрээр буюу ариун зүйлүүдээр амлалтууд өгөх

Хүчлэх (ш.41)—Алдаах, хүчлэх

Хоёр (ш.41)—Хоёр

Хавчдаг (ш.44)—Үзэн яддаг

Татвар хураагчид (ш.46)—Татвар хураагчид (Bible Dictionary, “publicans”-ийг үз, х. 755)

Матай 5:13—“Та Нар Бол Газрын Давс”

Давсыг зөвхөн хоолонд амт оруулахад ашигладаг байсан төдийгүй, бас үүнийг ямар нэг юмыг ялзарч муудахаас хамгаалахад хэрэглэдэг. Иймээс, давсыг гэрээ хийхийн бэлэгдэл болгон ашигладаг байв, учир нь гэвэл Бурхантай гэрээнүүд хийж, тэдгээрийг сахих нь биднийг сүнсний “ялзралаас” хамгаалдаг. Сургаал ба Гэрээ 101:39–40-д үүрдийн сайн мэдээ хийгээд гэрээг хүлээн авсан хүмүүс бол газрын давс мөн гэж Их Эзэн хэлсэн байдаг. Шороо мэтийн бусад элементүүдтэй холилдсон үедээ давс амт оруулах чанараа, мөн тэрчлэн цэвэр байдлаа алддаг. Ингэсэн тохиолдолд давс нь амт оруулах болон хамгаалахад ашиггүй болсон байдаг.

Матай 5:23–24—“Тахилын Ширээнд Өргөлөө Авчир”

Энэ шүлэгт хэрэглэгдсэн *тахилын ширээ* гэдэг үг нь Бурханд зориулж бидний хийж болох аливаа золиослолудыг бэлэгдэн харуулжээ. Есүсийн өгсөн зөвлөгөө нь аравны нэгээ төлөх, сүмийн цулаанууддаа оролцох, дуудлагуудад үйлчлэх зэрэг биднийг Бурханд ойртуулах бүх зүйлд хамаа-

тай байдаг. Матай 5:23–24 дэх зарлиг нь бид бусдыг гомдоосон үед гомдлыг эргэн барагдуулах арга замуудыг эрэлхийлэх нь Бурхантай харилцах бидний харилцааг дээшлүүлэхийг эрэлхийлэх нь чухал болохыг ойлгоход бидэнд тусалдаг. Чухамдаа бол, бид Бурхантай нэг байж үнэхээр чадахгүй, хэрэв бид түүнчлэн бусдыг хайрлахгүй юм бол, бид Түүнд хичнээн “өргөл” өргөсөн нь хамаагүй хэрэг билээ (1 Иохан 4:20–21; Алма 34: 26–29-ийг мөн үз).

Матай 5:29–30—Шийтгэл Болгож Бидний Биеийн Эрхтэнийг Тасдаж Хаяхыг Есүс Хөхүүлэн Дэмждэг Байсан уу?

Бидний биенээс нүглийг зайлуулахын ач холбогдолд онцгой анхаарал хандуулахын тулд энэ сургаалт зүйрлэлийг ярьдаг болохоос биш, бидний биеийн эрхтэнийг тасдаж хаях тухай хэлээгүй гэдгийг ойлгоход Иосеф Смитийн Орчуулга бидэнд тусалдаг. Бид нүглээс зайлсхийхийн тулд өөрсдийгөө хянах зоримог арга хэмжээ авах учиртай бөгөөд, бүхий л бурханлиг бус зүйлээс татгалзах ёстой (ИСО, Матай 5:34-г үз).

Матай 5:33–37—Тангараг ба Андгай

Есүсийн үед олон Иудейчүүд Их Эзэний нэрээр өргөсөн тангараг буюу амлалтыг зөрчих нь буруу гэдэгт итгэж, харин ариун сүм буюу хот, эсвэл өөр бусад ямар нэг зүйлийн нэрээр өргөсөн тангаргийг зөрчихийг төдийлөн ноцтой зүйл гэж үздэггүй байжээ. Есүс энэ номлолдоо, бид ямар нэг зүйлээр буюу хэн нэгнээр тангараг өргөх ёсгүй, гэхдээ бид тангараг өргөсөн байна уу, үгүй юү гэдгээс хамаарахгүйгээр хэлсэн үгэндээ хүрч байх ёстой гэж заажээ. Бид за гэж хэлсэн ч байна уу, үгүй гэж хэлсэн ч байна уу, ялгаагүй хэлсэндээ хүрэх ёстой.

Судруудыг Судлах нь



Матай 5-ыг судлах үеэрээ дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Ерөөлүүд: Аз Жаргалын Гарын Авлага

Матай 5:3–12-т Есүс ерөөлүүд буюу жинхэнэ аз жаргалд хүргэх зан төлөвүүдийн тухай ярьсан байдаг. Эдгээр шүлгүүдэд Түүний дурдсан ерөөл буюу зан төлөв бүрийг жагсааж, энэ нь ямар утгатайг хэл. Жагсаан бичсэн зан төрх буюу зан төлөв бүр нь та нарыг илүү агуу аз жаргалд хэрхэн хүргэнэ гэж бодож байгаагаа жишээгээр харуул. Жишээ гаргах үеэрээ, эдгээр зан төрх буюу зан төлөвтэй хүнд Есүсийн амласан адислалуудыг анхаарч үз. Чухал санаануудын утгыг илэрхийлэхэд зүүвэр тайлбарууд та нарт тусалж чадна.

Б Төгс Эзэмших Судар—Матай 5:14–16

- 3 Нифай 18:24-ийн дагуу, бид хэрхэн өөрсдийн гэрлийг бусдыг гэрэлтүүлэхээр болгох вэ?
- Та нар өөрсдөө болон та нарын насны өөр хэн нэгэн өөрийгөө хүмүүсээс илүү дээр гэж бусдад бодуулахгүйгээр “гэрэл” байж болох хоёр арга замын тухай бич.
- Матай 5:16-гийн дагуу, яагаад та нар бусад хүмүүс өөрсдийн тань сайн үйлүүдийг хараасай гэж хүсдэг вэ?

В Христийн Илүү Өндөр Хууль

Түүнийг дагалдагчдын зөв шударга байдал хуулийн багш нар хийгээд Фарисайчуудынхаас илүү агуу байх ёстой гэж Есүс Матай 5:20-д хэлснийг ажигла. Учир нь гэвэл хуулийн багш нар хийгээд Фарисайчууд хүмүүс харж болох хуулийн тэр хэсгүүдийг дуулгавартай чанд сахих талаараа нэрд гарсан байлаа. Нүдэнд эс харагдах хуулийн сүнслэг талд тэд анхаардаггүй байв. Шүлэг 21-ээс эхлэн Есүс Мосегийн хуулийн дагуух янз бүрийн хуулиуд хийгээд уламжлалуудын тухай ярьсан байдаг. Эдгээр шүлэг бүрт Тэрбээр Өөрийнхөө хаант улсын гишүүдээс шаардагдах илүү өндөр дээд зөв шударга ёсны тухай тайлбарлажээ.

Мосегийн “хуучин” хуулийг Христийн “шинэ” хуультай харьцуулсан, доорхтой адил харьцууллыг тэмдэглэлийн дэвтэртээ хий. “Шинэ Хууль буюу Шинэ Жишиг” баганад, бид тухайн зарлигийг сахих талаар баримтлах ёстой хэмээн Есүсийн хэлсэн арга замуудыг жагсаа.

Матай 5-ын Шүлгүүд	Хуучин Хууль буюу Хуучин Жишиг	Шинэ Хууль буюу Шинэ Жишиг
21–26	“Энэ нь эрт үеийн тэднээр хэлэгдсэн байсныг та нар сонссон шүү дээ...”	“Гэвч би та нарт хэлье...”
27–32		
33–37		
38–42		
43–47		

Матай 6

Уулан Дээрх Номлол, Хэсэг 2

Матай 6 бол Есүсийн уулан дээрх номлолын үргэлжлэл юм. Энэ бүлэгт бид өөрсдийгөө зөв шударга хүмүүс байна гэж бусдад бодогдуулахыг хүсдэгийн улмаас биш, харин бид Их Эзэнийг хайрладгийн улмаас Түүнийг бид амьдралдаа нэгдүгээрт тавьж, шүтэн биширснээр ирдэг адислалуудад онцгой анхаарал хандуулсан байдаг.

25-34-р шүлгүүд дээрх зөвлөгөө нь ялангуяа шинээр дуудагдсан Төлөөлөгчид зориулсан байсан ба хэдийгээр энэхүү тодорхой зөвлөгөө нь бид бүгдэд зориулаагүй ч, сүмийн гишүүн бүр тэдгээр шүлгүүдэд заасан тэрхүү зарчмуудыг хэрэгжүүлж болно.

Судруудыг Ойлгох нь



Матай 6

Харуулахын тулд (ш.1)—
... гэж бодох, анхаарах

Өглөг (ш.1–4)—Ядууст өгдөг тусламж

Синагогууд (ш.2, 5)—
Сүмүүд, шүтэн бишрэх, сурах газрууд

Хоосон давтах (ш.7)—Нэг л зүйлийг утга учиргүй дахин дахин давтах

Харь үндэстнүүд (ш.7)—
Үнэн хийгээд амьд Бурханд итгэдэггүй хүмүүс

Ариунаар (ш.9)—Ариунаар, эрхэм нандинаар

Өр (ш.12)—Нүгэл, алдаа дутагдал, гомдлууд

Алдаа (ш.14)—Нүглүүд
Байгаагаа (ш.16)—Байдал төрх (ялангуяа нүүрэн дээрх)

Царайгаа барайлгах (ш.16)—
Муухай царайлах

Сүйтгэдэг (ш.19)—Сүйрэх, эвдрэх

Үзэн ядах (ш.24)—Ихэд дургүй байх, үзэн ядах

Эд баялаг (ш.24)—Дэлхийн эд баялаг

Хувцас (ш.25)—Хувцас хунар

Тарих (ш.26)—Тариалах

Хураах (ш.26)—Үр жим буюу хүнсний ногоо зэрэг тарьсан зүйлээ боловсорсон үед хурааж авах

Өөрийнхөө өндрийг ганц тохойгоор нэмэх (ш.27)—
Өндрөө нэмэгдүүлэх

Ажил хийх (ш.28)—
Ажиллах

Ээрэх (ш.28)—Хувцас хийхэд зориулж утас ээрэх

Хувцасласан (ш.29)—
Хувцасласан (өөртөө анхаарал тавьсан гэсэн утгатай)

Хэрхэн (ш.31)—Яаж, хэрхэн

Өдөр бүрийн зовлон тухайн өдөртөө хангалттай (ш.34)— Өнөөдрийнхөө ажилд л санаа тавь, харин ирээдүйд тулгарах асуудал өнөөдрийн хийснээс тань бүү хөндийрүүлэг.

Судруудыг Судлах нь



Матай 6-г судлахдаа үйл ажиллагаа В-г, бас өөр нэг үйл ажиллагааг (А буюу Б) гүйцэтгэ.

А Загвар Ол

Залбирч (ш.5–15), мацаг барин (ш.16–18), өглөг өгөх тухай Есүсийн өгсөн зөвлөгөөнд юу нь адил төстэй байна вэ? Зөв шударга байдал хэмээн Есүсийн авч үзсэн энэхүү давтагдсан санаанаас та нар юу мэдэж авав?

Б Их Эзэний Залбирал

Матай 6:5–15 нь залбирлын талаар Есүсийн заадаг үндсэн гол зүйлийг агуулдаг. Шүлэг 9–13-ыг Их Эзэний Залбирал хэмээн нийтлэгээр нэрлэдэг. Залбирлын шүлэг бүрийг анхаарч үзэж, Есүсийн залбирлын жишээний тусгай хэсэг бүрээс бид юу сурах ёстой гэж боддоогоо тэмдэглэлийн дэвтэртээ бич. Илүү сайн ойлгохын тулд “амен”, “залбирал” гэдэг үгсийг Библийн Толь Бичигт (х.607, 752–53) харж болно.

В Төгс Эзэмших Судар—Матай 6:24

1. Матай 6:24-г Есүсийн хэлснийг анхаарч үзэхэд, эдгээр гурван жишээ болгонд хүн хэрхэн хоёр эзэнд нэг зэрэг үйлчлэхийг хичээсэн байна вэ? Эдгээр нөхцөл байдал тус бүрт эцэстээ юу тохиолдож болох вэ?

- а. Майкл (18 настай) Ням гараг болгонд ажиллах шаардлагатай ажил сонгож авснаар тэрээр номлолдоо зориулж мөнгө хурааж чадах уу?
- б. Донна (16 настай) Сүмийн гишүүн биш эрэгтэй найзтай байнга үерхэн, номлолын ажил хийж байгаа гэж ярьжээ.
- в. Смит Ах (35 настай) үйлчлүүлэгчидтэйгээ төгс үнэнч шударга биш байж бүтээгдэхүүнээ борлуулж олсон мөнгөөр аравны нэг болон мацгийн өргөлүүдийг илүү төлжээ.
2. Матай 6:19–23, 33 дахь Есүсийн зөвлөгөө нь шүлэг 24-т өгүүлсэн асуудлыг шийдэхэд хэрхэн тусалж чадсан бэ?
3. Өөрийг нь Эзэнээ болгон сонгож авсан хүмүүст Есүс юу амласан бэ?

Матай 7

Уулан Дээрх Номлол, Хэсэг 3



“Үр жимсээр нь та нар тэднийг таних болно”

Өлссөн хүн хоол хүнсний тухай бодож, хоол хүнсний тухай ярих буюу эсвээс хоол хүнсний зураг харж болох хэдий ч, хэрэв тэрээр хоол идэхгүй л юм бол, энэ нь тэр хүнд тус болж чадахгүй.

Уулан дээрх Номлолын энэхүү сүүлчийн бүлэгт Есүс зарим нэмэлт заалтуудыг өгч, тэгээд Түүний эдгээр заасан зүйлүүдийн адислалууд зөвхөн тэдгээрт итгэж, тэдгээрийг судлах буюу тэдгээрийн тухай ярьснаар бус, харин тэдгээрийн дагуу амьдарснаар ирдэг гэдэгт онцгой анхаарал хандуулжээ.

Нарийн (ш.13–14)—Давчуу, нарийхан
Хомхой (ш.15)—Улангассан, өлсгөлөн, ховдог
Хэлэх (ш.23)—Хэлэх, өгүүлэх, ярих, гэх
Ёс бусыг үйлдэх (ш.23)—Алдас үйлдэх, муу зүйлүүд хийх

Зүйрлэх (ш.24, 26)—Харьцуулах, жиших
Суурилагдсан (ш.25)—Баригдсан
Гайхан шагширч байв (ш.28)—Гайхаж байв

Судруудыг Судлах нь

Матай 7-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Д) гурвыг нь хий.

А Шүүх

- Матай 7:1–5-ыг уншсаны дараа, дараах өгүүлбэрүүдийг өөрсдийн үгээр бөглөн, Есүсийн заасан зүйлүүдийг тэмдэглэлийн дэвтэртээ тоймлон дүгнэ:
 - Та нар бусдыг шүүснээрээ Бурханыг . . .
 - Та нар бусдыг шүүмжлэхээсээ өмнө . . . ёстой.
- Матай 7:1-д бид юу хийх ёсгүйг бид тод томруунаар харж болно. Энэ шүлэгт зориулж, Иосеф Смитийн Орчуулгыг уншаад, бид юу хийх ёсгүйг бич. Үүнийг бид яаж хэрэгжүүлэх ёстойг тайлбарла (Матай 7:15–20 болон Моронай 7:12–19-ийг нэмэлт тусламж болгон үз).


Б Энэ нь Ямар Өөрчлөлт Гаргадаг вэ?

- Матай 7:7–11-д Есүсийн заасан зүйлүүдийг мэдэх нь та нарын залбирлуудад ямар өөрчлөлт гаргах ёстой вэ?
- Бурханаас адислалууд хүсэх талаар ямар нэмэлт мэдээлэл 3 Нифай 18:20; Сургаал ба Гэрээ 50:28–29; 88:64–65-д байдаг вэ?

В Зураг Зур

Матай 7:13–14-т байдаг санаануудыг дүрсэлсэн зураг зар. Зургийнхаа хэсгүүдэд нэр өг.

Г Чухал Дүгнэлт



Мэргэн хүн хадан дээр барьдаг.

- Моднуудын тухай, хаант улсад орох хийгээд байшин барих тухай Матай 7:16–27-д байдаг ярилцлагууд нь бүгдээрээ нэг гол санаа буюу сэдвийг агуулж байгаа. Энэ юу вэ?

Судруудыг Ойлгох нь

Матай 7

Анхааруулга: Энэ бүлэгт Иосеф Смитийн Орчуулгаас тусламж эр.

Та нар ямар хэмжүүрээр хэмжинэ (ш.2)—Юмсыг та нар яаж хэмжинэ (шүүнэ), түүгээр
Хэсэглэн тастах (ш.6)—Урах буюу тасалж хаях

Энэ бол Хууль болоод Эш Үзүүлэгчид (бошиглогчид) (ш.12)—Энэ бол судруудын заадаг зүйл мөн (үндсэндээ Хуучин Гэрээний)

2. Матай 7:24–27 дахь түүх Хиламан 5:12-т байгаа зүйлийн утгыг илүү сайн ойлгоход та нарт хэрхэн туслах вэ?
3. Байшин баригч мэргэн хийгээд тэнэг хоёр хүний тухай түүхэнд, шуурга хоёр байшинг хоёуланг нь “нүдсэн” боловч хожим нь зөвхөн нэг нь л нуруулгүй үлдсэн байдаг. Сайн мэдээний дагуу амьдрах нь амьдралын “шуурганд” та нарт хэрхэн тусалдаг тухай бич.

Д Энэ нь Миний Хувьд Ямар Учир Холбогдолтой вэ?

Уулан дээрх Номлолыг судалсан учраас та нар Есүс Христийг дагахаар хичээж, амьдралдаа дээшлүүлэхээр хүсч буй наад зах нь хоёр зүйлийн тухай бич.

Матай 8–9

Есүс Олон Гайхамшиг Үйлдэв

Есүс Уулан дээрх Өөрийн агуу Номлолыг заасны дараа Тэрбээр хүмүүсийн дунд орж, тэдэнд заан, мөн тэрчлэн олон гайхамшигуудыг үйлдсэн билээ. Тэрбээр Галилын Тэнгисийн ойролцоох нутагт байхдаа хэд хэдэн гайхамшиг үйлдсэн нь Матай 8–9-д цэдэглэгдсэн байдаг.



Эдгээр гайхамшигуудын ач холбогдол юу вэ? Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МакКонки, “Бидний Их Эзэн өөрийн тохинуулалд хаант улсын сайн мэдээг номлож; . . . энэ амьдралд амар амгаланг, ирэх дэлхийд мөнх амьдралыг олохын тулд бүх хүмүүн юу хийх ёстойг нэн олонтаа тунхаглаж байхдаа, Аврагч бас, “итгэл бишрэлтнүүд хийгээд итгэл бишрэлгүйчүүд аль алиных нь бүгдийн нүдэнд харагдах нотолгоо болгон” гайхамшигуудыг үйлдсэн нь мөнх бус хүчнээс илүү зүйл түүнд байсных. Эдгээр нь яг л хэлэгдсэнчлэн, нотолгоо мөн, ийнхүү түүний үгс үнэн юм” хэмээн заажээ. (Mortal Messiah, 2:42; түүнчлэн Матай 11:3–5-ыг үз). Түүнчлэн Ахлагч МакКонки, “гайхамшигууд нь өөрөө хүмүүсийг үнэнд

хөрвүүлдэггүй . . . Гэвч гайхамшигууд нь чин хүсэлтэй сонирхогчийг итгэл рүү хөтлөх алхмуудыг хийхэд хүргэн нөлөөлдөг” хэмээн бас сургажээ (Doctrinal New Testament Commentary, 2:81).

Матай 8–9-д Есүсийн үйлдсэн гайхамшигуудын тухай шастируудыг уншихдаа, тэдгээр нь Есүсийн тухай та нарт юу зааж байгааг, түүнчлэн гайхамшиг тус бүр нь та нарын итгэлийг бэхжүүлэх хийгээд Түүнд бүрэн итгэх итгэлээ дээшлүүлэхэд тань та нарыг урамшуулан дэмжих арга замуудыг анхааралтай авч үз.

Матай 8–9-д Та Нарын Уншдаг Зүйлийн Талаарх Бусад Шастирууд

Матай 8:1–4—Марк 1:40–45; Лук 5:12–16
 Матай 8:5–13—Лук 7:1–10
 Матай 8:14–15—Марк 1:29–31; Лук 4:38–39
 Матай 8:18–22—Лук 9:57–62
 Матай 8:23–27—Марк 4:35–41; Лук 8:22–25
 Матай 8:28–34—Марк 5:1–20; Лук 8:26–39
 Матай 9:1–17—Марк 2:1–22; Лук 5:17–39
 Матай 9:18–26—Марк 5:21–43; Лук 8:40–56
 Матай 9:35–38—Лук 10:2–3

Судруудыг Ойлгох нь



Матай 8

Уяман өвчтэй хүн, уяман өвчин (ш.2–3)—Уяман өвчин бол арьс, нэхдэс буюу мэдрэлийн янз бүрийн өвчнүүд юм. (мөн Bible Dictionary, “leper”, “leprosy” гэсэн үгсийг хар, х. 723–24).
Зуутын дарга (ш.5, 8, 13)—Ромын цэргийн зуун цэрэг хариуцсан дарга
Саа өвчин (ш.6)—Хүнийг тахир дутуу болгодог өвчин
Сүрхий өвдөн шаналж байна (ш.6)—Аймшигтай их өвдөх

Орой (ш.16)—Үдэш
Сул дорой байдал (ш.17)—Сул тал, сул дорой байдал
Үүрсэн (ш.17)—Үүрсэн
Сүйрэх, сүйрлээ (ш.25, 32)—Мөхөх, үхэх
Зэмлэжээ (ш.26)—Орхиоор зарлиглав
Тарчилгах (ш.29)—Шийтгэх
Сүрэг гахай (ш.30–32)—Гахайнууд
Гуйв (ш.31, 34)—Хүсэв
Болсон явдал (ш.33)—Тохиолдсон явдал

Матай 8:4—Яагаад Есүс Эдгээсэн Хүмүүстээ Сүнийг Хүнд Битгий Хэлээрэй Гэсэн Бэ?

Матай 16:20 дахь (х.29–33) “Судруудыг Ойлгох нь”-ыг үз.

Матай 8:21–22—Яагаад Есүс Тэр Хүнд Эцгээ Оршуулахыг нь Зөвшөөрөөгүй вэ?

Есүс тэр хүнд яагаад эцгийгээ оршуулахаар биш, харин Түүнийг дагахаар яв гэж хэлснийг ойлгоход: “Илчлэлтийн сүнсээр хүмүүс Бурханаас дуудагдахад, бүх зүйлийг мэддэг түүний гаргуун мэргэн ухаанд дуудагдахад, эдгээр дуудлагууд зөрчилдөгч бүх ашиг сонирхлуудыг даван тэргүүн зэргийн ач холбогдолтой болдог. Ийнхүү урагш илгээгдсэн номлогч нар хувь хүний болоод гэр бүлийн бүхий л үүргүүдээ орхидог. Хайртай хүмүүс маань талийгаач болж болно,

харин Бурханы хаант улсыг номлож, номлогч нар үүрэг буюу дуудлагуудаа биелүүлж үлддэг” гэсэн Ахлагч Брус Р.МакКонкийн нотолгоо бидэнд тусалдаг (*Doctrinal New Testament Commentary*, 1:304).

Ямар ч нөхцөл байдалд бид Есүсийг дагах ёстой гэдгийг санах нь чухал юм.

Матай 9

Өөрийн хотдоо (ш.1)—Капернаум (*Bible Dictionary*, “Capernaum”-ыг үз, х. 631)

Доромжлох (ш.3)—Гутаан доромжлох, гутаах

Хүний Хүү (ш.6)—Есүс Өөрийгөө Хүний Хүү хэмээн нэрлэсэн юм, учир нь гэвэл Тэр Бурхан Эцэгийн Хүү бөгөөд Тэнгэрлэг Эцэгийн нэг нэр нь “Ариун Хүн” юм (Моисе 6:57-г үз). Ийм учраас, Есүс бол “Ариун Хүний Хүү” билээ.

Тэндээс (ш.9, 27)—Тэнд, тэндээс

Татварын газар (ш.9)—Татвар хураадаг газар

Идэж байв (ш.10)—Хоол идэж байв

Татвар хураагчид (ш.10–11)—Татвар авагчид, татвар хураадаг хүмүүс

Олонтаа (ш.14)—Олон удаа

Шинэ хүргэний бараа болочид (ш.15)—Хуримын зочид

Хүргэн (ш.15)—Гэрлэх гэж байгаа эрэгтэй хүн (олон тохиолдолд Христийн бэлэгдэл, эмэгтэй хүн нь Сүм юм)

Дээл (ш.16, 20)—Хувцас

Урах (ш.16)—Урах, тасдах

Бишгүүрчид (ш.23)—

Хөгжим тоглодог хүмүүс

Гарцгаа (ш.24)—Гарах, зай болох

Шоолон инээлджээ (ш.24)—Хүндэтгэлгүйгээр шоолон инээх


Давидын Хүү (ш.27)—Хүмүүс Түүнийг өөрсдийн хаан байх учиртай Давид Хааны үр удам, эсвээс Мессиа буюу Христ гэдэгт итгэж байсныг харуулсан өвөрмөц нэр

Хэлгүй (ш.32–33)—Ярьж чаддаггүй

Өрөвдөх (ш.36)—Нинжин буюу хайрлах, өрөвдөх сэтгэл төрөх

Туйлдсан (ш.36)—Ядарсан

Арвин (ш.37)—Олон, их



2. Матай 8:5–9-д уншсан зүйлээсээ зуутын дарга гайхмаар итгэл харуулсан байдлаас дор хаяад хоёрыг тайлбарла.

3. Матай 9:20–22 дахь эмэгтэй, тэрчлэн Матай 9:27–29 дахь эрэгтэйчүүд итгэлээ харуулахын тулд юу хийсэн бэ?

4. Илүү итгэлтэй байхыг хүсдэг амьдралынхаа аль нэг тал буюу эсвэл сайн мэдээний аль нэг заадаг зүйлийг сонгож ав. Зуутын даргын, сайхь эмэгтэйн, эсвээс хоёр эрэгтэйн жишээ нь тэр талд итгэлээ нэмэгдүүлэхэд тань та нарт хэрхэн тусалсан бэ?

Б “Хамгийн Агуу Гайхамшиг Байх”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Жон Видцо: “Есүс Христийн сайн мэдээн дэх хамгийн агуу гайхамшиг нь сайн мэдээний үнэнийг итгэлтэйгээр хүлээн авч, тэгээд өөрсдийнхөө амьдралд үүний дагуу амьдардаг эрэгтэй, эсвэл эмэгтэй хүнд ирдэг тэрхүү өөрчлөлт байх. . . . Шинэ болоод илүү агуу үнэнүүд ирэх үед, тэдгээрийн тухай ойлголт бидний дотор хөгжих үед, хэрэв бид тэдгээрийг хүлээн авч, тэдгээрийн дагуу амьдрах юм бол, бид ердийн хүмүүсээс шинэ хүчнүүд хийгээд шинэ боломжуудад хувиран өөрчлөгддөг” гэж хэлжээ (in Conference Report, 1952 оны Дөрөвдүгээр сар, 34).

Матай 9 дэх бүх түүхүүдийн дундаас аль нь Ахлагч Видцогийн өгүүлсэн гайхамшигийн хамгийн сайн жишээ байж болно гэж та нар бодож байна?

В Эмчид Сзүүлэхдээ

1. Матай 9:10–12-ын дагуу, хэнд эмч хэрэгтэй байгаа вэ?
2. Сүнслэг байдлын хувьд өсч хөгжихөд тань эдгээр шүлгүүд та нарт хэрхэн тусалсан бэ?
3. Сүмд нэгдэх өөр хүнд туслахыг хичээх буюу эсвэл үйл ажиллагаанд эргэн ирэхэд эдгээр шүлгүүд та нарт хэрхэн тусалсан бэ?

Г Ажилчид Хэрэгтэй Байна

1. Матай 9:36–38-ын дагуу, Есүс хэрхэн бодсон бэ? Тэр яагаад ингэж бодох болсон бэ?
2. Матай 9:36–38-д өгүүлсэн энэ “ажилд” хүмүүсийн анхаарлыг хандуулахын тулд сонинд зориулсан зарлал (жинхэнэ биш) бич. Есүс Өөртөө үйлчлүүлэх хүмүүсээс хүсэх байсан гэж өөрсдийн боддог чанаруудыг зарлалд оруул.

Судруудыг Судлах нь

Матай 8–9-ийг судлахдаа доорх үйл ажиллагаануудаас (А–Г) гурвыг нь хий.

А Итгэлийн Агуу Жишээнүүд

1. Матай 8:5–13 нь Аврагчаас тусламж эрсэн Ромын цэргийн дарга—Израил биш, Харь хүний тухай түүхийг өгүүлдэг. Шүлэг 10-т зуутын даргын итгэлийг тухайн үеийн Израилчуудын итгэлтэй харьцуулан Аврагч юу гэж хэлсэн бэ?

Матай 10

Арванхоёр Төлөөлөгчид Өгсөн Зааврууд

Матай 9-ийн эцэст Есүс Өөрийнхөө хийхээр ирсэн тэрхүү агуу ажлыг гүйцэлдүүлэхэд Түүнд туслацгаа хэрэгтэй байна хэмээн мэдэгдсэн байдаг.

Ийм учраас, Тэрбээр арванхоёр хүнийг Төлөөлөгчөөр дуудсан бөгөөд энэ нэр нь “урагш илгээгдсэн хүн” гэсэн утгатай юм. Номлолд буюу Сүмийн бусад дуудлагуудад үйлчлэхээр илгээгдсэн бусад шавь нараас ялгаатай нь гэвэл, Есүс эдгээр эрэгтэйчүүдийг тусгай төлөөлөгчид буюу Түүний тусгай гэрчүүд хэмээн нэрлэж, тэгээд Тэрбээр Өөрийнхөө нэрээр үйлдэх буюу ярих тусгай түлхүүрүүд хийгээд хүчийг тэдэнд өгсөн билээ. (Дэлгэрэнгүй мэдээллийг Bible Dictionary, “Apostle,” х. 612-оос үз.) Тэрбээр түүнчлэн тэдэнд тусгай үүрэгт ажил буюу зааврууд өгснийг бид Матай 10-т уншдаг. Хэдийгээр энэ захиас уг анх Арванхоёр Төлөөлөгчид өгөгдсөн ч гэсэн, Түүний сайн мэдээг заах Их Эзэний төлөөлөгч болж дуудагдсан хэн ч гэсэн энэ бүлэгт агуулагдсан зарчмуудаас сурацгааж болно.



Матай 10-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 10:1–4—Марк 3:13–19; Лук 6:12–16

Судруудыг Ойлгох нь



Матай 10

Нэрс (ш.2)—Гэр бүлийн нэр, өгсөн нэр

Урвасан (ш.4)—Эсрэг эргэсэн

Израилын гэр (ш.6)—Израилын (Иаковын) угсаа, үр удам

Авч явж болохгүй (ш.9)—Бүү авч яв, битгий авч яв

Бүс (ш.9)—Мөнгө хадгалах халаастай даавуун бүс

Таяг (ш.10)—Явахад хэрэглэдэг таяг

Зохистой (ш.11, 13)—Зохимжтой, эрхэмлүүштэй

Бай (ш.11)—Байх, үлдэх

Мэндийг нь мэд (ш.12)—Мэндэл

Илүү тэвчмээр байх болно (ш.15)—Шийтгэл нь бага байх болно

Ташуурдах (ш.17)—Зодох, ташуураар зодох


Тэсэх (ш.22)—Бууж өгөхгүй байх

Беелзебул (ш.25)—Чөтгөр

Задгай зоос (ш.29)—Маш бага мөнгө

Эсрэг (ш.35)—

Зөвшөөрөхгүй байх



Матай 10:38—“Загалмайгаа Сүрээд Миний Хойноос Дагахгүй Хүн Миний Хувьд Зохистой Нэгэн Биш”

Хэдийгээр энэ шүлэг болон яг үүний өмнөх болон дараах шүлгүүд Есүсийг дагах хүмүүсийн хувьд нэн хатуу хийгээд ихийг шаардсан шинжтэй боловч, тэдгээр нь Сүмд хөрвөгчдийн заримынх нь хувьд нэн бодитой юм. Ийм нэгэн хөрвөгчийн тухай Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли өгүүлсэн байдаг. Тэр бол Христийн биш шүтлэгтэй нэг улсаас Нэгдсэн Улсад мэргэжлийн сургалт хийхээр ирсэн, тэнгисийн цэргийн офицер байлаа. Нэгдсэн Улсад байхдаа тэрээр Сүмтэй танилцаж, улмаар баптисм хүртгэхээр шийджээ. Гэр лүүгээ буцахын өмнө тэрээр түүнтэй уулзаж ярилцсан тухай Ерөнхийлөгч Хинкли өгүүлэхдээ:

“Танай хүмүүс Христэд итгэгчид биш юм байна. Та Христэд итгэгч, бүр тодруулбал Христэд итгэгч Мормон хүн болоод гэртээ эргэж очиход тань юу болох бол?” гэж би хэллээ.

“Түүний нүүр барайж, ‘Манай гэрийнхэн сэтгэл гонсгор байх болно. Тэд намайг гэрээсээ гаргаж хаяад, намайг үхсэнд тооцох болно. Ирээдүйн ажил мэргэжил хийгээд бүх боломж минь бүр миний эсрэг эргэж ч болно’ гэж тэр хариуллаа.

“‘Сайн мэдээний төлөө та өдий их төлөөс төлөх хүсэлтэй байна уу? гэж би асуув.

“Түүний хар нүдэнд нулимс цийлэгнэж, ‘Сайн мэдээ үнэн биз дээ, тийм үү?’ гэж тэрээр хариулах үед, сайхан бор царай нь гэрэлтэж байлаа.

“Ийм асуулт асуусандаа би ичиж, ‘Тийм ээ, сайн мэдээ үнэн’ гэж би хариуллаа.

“Үүнд тэр хариулахдаа, ‘Тэгвэл өөр ямар асуудал байх билээ?’ гэв” (“It’s True, Isn’t It?” *Ensign*, 1993 оны 7-р сар, 2).

Судруудыг Судлах нь

Матай 10-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Арванхоёр Төлөөлөгч

Матай 10:2–4-т дурдагддаг Арванхоёр Төлөөлөгчийн нэрсийг жагсаа. Дараа нь Библийн Толь Бичигт нэр болгоныг харж, тэгээд тэнд бичигдсэн зүйлээс тухайн Төлөөлөгчийн талаар мэддэг зүйлээсээ наад тал нь хоёрыг бич.

Б Номлогч Нарт Тохиолддог Бэрхшээлүүд хийгээд Амлалтууд

1. Матай 10:17–18, 22–25-ыг нэгтгэн дүгнээд, Түүний Төлөөлөгчид сайн мэдээг номлохоор явахад тэдэнд тохиолдох болно гэж Есүсийн хэлсэн хэцүү нөхцөл байдлуудаас дор хаяж гурвыг жагсаан нэрлэ.
2. Номлолд байсан хэн нэгнээс түүнийг номлолд үйлчилж байхад нь өөрсдийн тань жагсаан бичсэн нөхцөл байдлуудаас зарим нь тохиолдож байсан уу гэдгийг асуу. Тэр хүнд тохиолдож байсан хэцүү нөхцөл байдлын хажууд “Х” гэж тэмдэглэ. Тэдгээр туршлагауудынх нь нэгний тухай, түүнчлэн тэр талаар тэр юу гэж бодож байсныг нь уг хүнээр яриул. Мэдэж авсан зүйлийнхээ талаар бага сага зүйлийг тэмдэглэлийнхээ дэвтэрт бич.
3. Та нарын дээр жагсаасан бэрхшээлүүдийг хялбараар тэсэн гарахад тусалж болох ямар зүйлийг Есүс Матай 10:19–20, 26–33-т амласан бэ?

В Яагаад Ийм Байдаг Билээ?


Хэвийн байдлаар бид зөв гэж боддог зүйлийн эсрэгээр байж болох гурван өөр нотолгоог Есүс Матай 10:34–39-д хийсэн байдаг. Тэрээр энх тайвныг бус, харин илд авчрахаар (ш.34-ийг үз), гэр бүлүүдийг бие биенийх нь эсрэг босгохоор ирсэн (ш.35–37-г үз), тэрчлэн бид амьдралаа олж авах цорын ганц зам бол үүнийгээ алдах явдал мөн (ш.39-ийг үз) гэсэн байдаг.

1. Есүс Христийн сайн мэдээ нь үүний дагуу амьдардаг хүмүүст амар амгаланг авчирдгийг бид мэднэ (Иохан 14:27-г үз). Түүнчлэн Матай 10:16–17; 24:6–10; Үйлс 12:1–2; мөн Сургаал ба Гэрээ 76:28–29-ийг уншиж, тийнхүү Матай 10:34 дэх Есүсийн нотолгоо бас үнэн байх үеүдийн тухай ярь.
2. Сайн мэдээний нэг зорилго бол гэр бүлүүдийг үүрд мөнхөд хамтад нь лацдан холбох явдал мөн гэдгийг бид мэднэ. Ямар нөхцөлд Матай 10:34 дэх Есүсийн нотолгоо үнэн бэ?
3. Хүн үүнийг алдсанаар өөрсдийн амьдралаа хэрхэн олж авч болох вэ?

Матай 11

“Надад Ирэгтүн”

Есүс Христэд зориулж замыг нь бэлтгэх чухал үүрэг зорилгыг Иохан Баптист хүлээжээ. Тэрээр энэхүү үүрэг зорилгоо: (1) үнэн сүнс хийгээд Мосегийн хуулийг номлосноор; (2) наманчлах, баптисм хүртэхийг, түүнчлэн цаашидын үнэн хийгээд Мессиагийн ирэлтийн адислалуудыг хүлээн авахад нь бэлтгэхийг хүмүүст зааснаар; (3) Есүс Христ бол тэрхүү амлагдсан Мессиа мөн гэдгийг гэрчилснээр гүйцэлдүүлсэн билээ. Хараажаар түүнд үнэнч байсан Иоханы зарим дагалдагчид Есүс үнэхээр Мессая байсан эсэхд итгэлтэй бус байсаар л байсан юм. Үнэн бошиглогчид биднийг ямагт Христ өөд зааж, Түүнд очиход биднийг урамшуулан дэмждэг. Есүсийг дагалдагчид Түүнийг олж, мөн Түүнийг дагахад нь туслахын тулд Иохан юу хийснийг хай.



Иохан Баптист—бошиглогчоос илүү

Матай 11 Аврагч Өөрөө Түүн рүү ирэхийг урьсан агуу урилгуудыг нэгийг бас агуулдаг.

Матай 11-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 11:2–19—Лук 7:18–35

Матай 11:20–24—Лук 10:12–15

Матай 11:25–27—Лук 10:21–22

Судруудыг Ойлгох нь



Матай 11

Үзэх (ш.4)—Харах

Надаас болж бүдрэх (ш.6)—
Миний хийсэн буюу хэлсэн
зүйлээс ичих

Тэнгэрийн хаанчлалын
хамгийн бага нэгэн ч түү-
нээс агуу билээ (ш.11)—
Та нарын (шашны удирдаг-
чид) хамгийн бага ач холбог-
долтой гэж үздэг Тэр; Есүс
Өөрийгөө хэлжээ.

Хүчинд автагдах (ш.12)—
Хавчлага, мөрдлөгтэй
тулгарач

Елиа (ш.14)—Елиа (Еврей
нэрний грек хэлбэр; Bible
Dictionary, "Elias," х. (00)
663-ыг үз)

Зүйрлүүлэх (ш.16)—
Харьцуулах, жиших

Гашуудсан (ш.17)—
Харамссан

Ховдог (ш.19)—Их идэж
уудаг хүн

Архичин (ш.19)—Хэтэрхий
их дарс уудаг хүн

Үйлсээрээ зөвтгөгддөг
(ш.19)—Ажил үйлсээрээ
зөвтгөгдөх

Зэмлэх (ш.20)—шүүмжлэх,
загнах

Матай 11:7–11—“Эмэгтэй Хүнээс Төрсөн Хүмүүсийн Дунд Баптисм Хүртээгч Иоханаас Илүү Агуу нь Байгаагүй”

Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ:

“Иоханыг хамгийн агуу их бошиглогчдын нэг гэж үздэгийн
учир юун билээ? Түүний гайхамшгууд түүний агуу чанарыг
бүрдүүлж чадаагүй юм.

“Нэгдүгээрт. Их Эзэний өмнө замыг бэлтгэх бурханлиг
үүрэг зорилгыг түүнд итгэмжлэн даатгасан байлаа. Үүнээс
өмнө буюу хожим нь ийм итгэмжлэл хүлээлгэн даатгасан
хэн байдаг билээ? Нэг ч хүн байхгүй.

“Хоёрдугаарт. Чухал үүрэг зорилгыг түүнд итгэмжлэн даат-
гасан бөгөөд Хүний Хүүд баптисм хүртээх нь түүний гараас
шаардагдсан юм. Үүнийг хийх эрхэм хүндэт үүрэг хэнд
ноогдсон билээ? Алдар суугийн ийм агуу онцгой боломж
хэнд олдсон билээ? Бурханы Хүүг баптисмын ус уруу хэн
хөтөлж, энэхүү адислалын гэрч болон Ариун сүнс тагтаа
хэлбэрээр, эсвээс тагтааны тэмдгээр бууж ирэхийг харах
онцгой боломж хэнд олдсон байдаг билээ? . . .

Золгүй (ш.21)—
Сэрэмжлүүлэх

Үнсэн дээр таар нөмрөх
(ш.21)—Иудей хүмүүс
гашуудаж байгаа, эсвэл
наманчилж байгаагийн тэм-
дэг болгон тэмээний ноос
буюу ямааны хялгасаар нэх-
сэн бүдүүн утсаар хийсэн
хувцас өмсөн, толгой дээрээ
үнс асгадаг байжээ.


Хүлцмээр (ш.22, 24)—Гайгүй
(шийтгэл бага ирэхээр)

Тэнгэрт тултал өргөмжлөг-
дөх (ш.23)—Бардамналаар
дүүрэх

Эцэж туйлдах (ш.28)—Маш
их ажиллах

Хүнд дарамт үүрсэн
(ш.28)— Хүнд ачаа үүрсэн

Буулга (ш.29–30)—Ачаа тээж
явахад хялбар болгон малын
хүзүүнд угладаг дугариг мод



Үхрийн буулга

Ачаа (ш.30)—Хүн үүрч явдаг
юм; ажил үүрэг

“Туравдугаарт. Тэр үед Иохан бол дэлхий дээр тэгэхэд бай-
сан хаант улсын хэрэг явдалд цорын ганц хууль ёсны гүй-
цэтгэгч нь байсан бөгөөд эрх мэдлийн түлхүүрүүдийг
атгаж байсан юм. . . . Эдгээр гурван шалтгаан түүнийг
эмэгтэй хүнээс төрсөн хамгийн агуу бошиглогч болгодог”
(Teachings of the Prophet Joseph Smith, 275–76).

Судруудыг Судлах нь



Матай 11-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Эргэж Илтгэ

Матай 11:1–19-д Иохан Баптисмын хоёр шавь Есүсийг юу
хийж, юу зааж байгааг харахаар ирсэн тухай өгүүлдэг.
Иохан уруу эргэж очоод харсан, сонссоноо түүнд ярь гэж
Есүс тэдэнд хэлжээ. Эдгээр арван есөн шүлэгт уншсан
зүйл дээрээ тулгуурлан, хэрэв та нар эдгээр хоёр хүн бай-
сан бол буцаж очоод Иоханд ярих байсан зүйлээсээ гурвыг
бич. Өөрсдийн харж болох байсан гайхамшгууд хийгээд
Есүсийн зааж байсныг нь сонссон үнэнүүдийг оруул.

Б “Над Уруу Ир”

1. Түүний ад үзсэн ёс бусчууд дээр ирэх шийтгэлүүдийн
тухай (Матай 11:20–24-ийг үз) ярьсны дараа, Түүний тухай
мэдэж, Түүнийг дуулгавартай дагадаг хүмүүст Есүс Матай
11:28–30-д юу амласан бэ?
2. Матай 11:28-д ямар төрлийн хөдөлмөр хийгээд хүнд ачаа-
ны тухай өгүүлсэн гэж та нар боддог вэ?
3. Есүсийн биднээс хүсдэг зүйл бол ачаа юм гэж зарим
хүмүүс боддог. Доорх жагсаалтаас, зарим хүмүүсийн хүнд
ачаа гэж үздэг зүйлүүдээс гурвыг нь сонгож, эдгээр нь
Христийг дагадаг хүмүүсийн хувьд яагаад хөнгөн ачаа
гэж бодлогоо тайлбарла.

- Аравны нэгээ төлөх
- Долоо хоног бүр Сүмд гурван цагаар очих
- Семинарт явах
- Мацаг барих
- Номлолд үйлчлэх
- Ёс суртахууны хувьд цэвэр ариун байх

Матай 12

Фарисайчууд Есүсийг Эсэргүүцэв

Матай 12-ыг уншихын өмнө Есүсийн үед Иудейн удирдаг-
чид ахлах тахилчдын уламжлалууд хэмээн нэрлэгддэг
нарийн ээдрээтэй дүрмийг Мосегийн хууль дээр нэмсэн
байжээ (Марк 7:5–9-ийг үз). Эдгээр хуулиуд Их Эзэнээс
ирээгүй бөгөөд олон нь тухайлбал Хүндэтгэлийн өдөр

эдгээх нь “ажил” байсан учир хориглосон байсан гэхчлэн инээдтэй зүйл байлаа. Есүсийн үе дэх шашны хамгийн хүчирхэг бүлэг Фарисайчууд эдгээр уламжлалуудыг дуулгавартай дагах талаараа нэн чанд хатуу байсан бөгөөд эдгээр уламжлалуудыг бошиглогчдын үгсээс илүү ач холбогдолтой гэж үздэг байжээ. Матай 12-ыг уншихдаа, Есүсийн заадаг зүйлүүд эдгээр уламжлалудтай харшилдахад юу болдог байсныг эрж хай.



Матай 12-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 12:1–8—Марк 2:23–28; Лук 6:1–5
 Матай 12:9–14—Марк 3:1–6; Лук 6:6–11
 Матай 12:24–32—Марк 3:22–29
 Матай 12:38–42—Лук 11:29–32
 Матай 12:43–45—Лук 11:24–26
 Матай 12:46–50—Марк 3:31–35; Лук 8:19–21

Судруудыг Ойлгох нь



Матай 12

Гэмгүй хүнийг буруутгах (ш.7)—Түүнд уг хууль байхгүй байхад Есүс үүнийг зөрчсөн тухай өгүүлжээ

Тэндээс явав (ш.9)—Тэр газраас явав

Хатингар (ш.10)—Хатсан, хатингар болсон, ашиглах аргагүй

Зүгээр болов (ш.13)—Эдгэрэв

Сануулав (ш.16)—Тушаав, зарлиглав

Давидын хүү (ш.23)—Мессиа

Булаах (ш.29)—Хулгайлах

Доромжлол (ш.31)—Муу муухай зүйл ярих буюу ариун зүйлсээр тохуурхах

Муу (ш.33)—Ялзарсан, идэж болохгүй

Хорт могойн удам (ш.34)—Ёс бус хүмүүс (наж могой бол хорт могой)

Бодлогогүй хэлсэн үг бүр (ш.36)—Хүний хэлсэн хөнгөн хуудамгай зүйлүүд

Тайлагнах (ш.36)—Хариуцах, тайлагнах


Зөвтгөгдөх (ш.37)—Сайнаар шүүгдэх

Яллагдах (ш.37)—Муугаар шүүгдэх

Цэгцтэй болсон (ш.44)—Эмх цэгцэд оруулах

Матай 12:3–6—Хүндэтгэлийн Өдөр Юу Зөв Эсвэл Юу Буруу Болох Тухай Тайлбарууд

Есүсийн шавь нар Есүстэй хамт явж байгаад хэсэг үр тариа хурааж, үүнийгээ идсэнийг Фарисайчууд тэднийг Хүндэтгэлийн өдөр ажиллалаа гэж буруутгажээ. Фарисайчуудын илүү чухал гэж боддог байсан уламжлалуудыг тэд зөрчсөн хэдий ч, Түүний шавь нар Мосегийн хуулийг сахьсан гэдгийг харуулахын тулд Есүс дараах хоёр жишээг ашиглажээ (Матай 12-ын дээрх оршлыг үз):



• Давид болон түүний хүмүүс ариун сүмийн талхыг идсэн хэдий ч, тэд Их Эзэний ажлыг хийж байсан учир тэд гэм буруугүй байлаа (Самуел 21:1–6-г үз).

• Ариун сүмийн ахлах тахилчид Хүндэтгэлийн өдөр ариун сүмд олон зүйлийг хийх ёстой байдаг нь өөр аль нэг газарт бол хууль бус байх байсан.

Матай 12:18–20— Исаиагийн Нэг Бошиглол

Энэхүү бошиглол нь Мессиа Өөрийн ажлыг дуусгах хүртэл Түүний эсрэг байсан хүмүүсийн эсрэг шүүлтэнд Тэрбээр хариулахгүй гэсэн утгатай юм. Шүүлэг 20 дахь бэлгдлүүд нь хэн ч гэсэн хялбархан хийж чадах зүйлүүд (аль хэдийнэ гэмтсэн ургамлыг хугалж хаях буюу унтрах шахсан галыг унтраах) боловч, Мессиа Өөрийн ажлыг дуусах хүртэл, Тэрээр бүр хялбархан хийж чадах юмаа ч (Дайснуудаа шийтгэх) хийх нь үгүй билээ.

Матай 12:31–32—“Ариун Сүнсний Эсрэг Доромжлол Гэж Юу Вэ”?

“Ариун Сүнсний эсрэг нүглээс бусад бүх нүглүүдийг уучлах ёстой; учир нь Есүс мөхлийн хүүхдүүдээс бусдыг бүгдийг нь аврах болно. Хүн юу хийснээр энэхүү уучилшгүй нүглийг үйлддэг вэ? Тэр Ариун Сүнсийг хүлээн авч, тэнгэр түүнд нээгдэхэд Бурханыг мэддэг болсон атлаа Түүний эсрэг нүгэл үйлдсэнээр. Хүн Ариун Сүнсний эсрэг нүгэл үйлдсэний дараа, түүний хувьд наманчлал байдаггүй. Нарыг харж байгаа атлаа түүнийг гэрэлтэхгүй байна гэж хэлдэг; тэнгэр түүнд нээгдсэн байхад тэрээр Есүс Христийг үгүйсгэдэг, мөн нүд нь авралын төлөвлөгөөний үнэнд нээгдсэн байхад тэрээр үүнийг үгүйсгэдэг; тэгээд энэ цагаас эхлэн тэрээр дайсан болж эхэлдэг. Энэ бол Есүс Христийн Хожмын Уеийн Гэгээнтнүүдийн Сүмээс урвасан олон урвагчдад тохиосон зүйл” хэмээн Бошиглогч Иосеф Смит тайлбарлажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 358).

Судруудыг Судлах нь

Матай 12-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Хүндэтгэлийн Өдөр

Матай 12-ын шүүлэг 1–9, 10–14 нь Есүс болон Түүний шавь нарыг Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахьсангүй хэмээн Фарисайчууд буруутгасан хоёр тохиолдлын тухай өгүүлдэг. Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихад та нарт тусалж

чадах тус бүр нэг санааг шастир бүрээс бич. Бичсэн зүйлийнхээ нэг хэсэг болгон, эдгээр санаанаас өөрөөр буюу илүү сайнаар юу хийхийгээ тайлбарла.

Б Та Нар Сүнийг Хэрхэн Харахаас Хамаарна

1. Матай 12:22 дахь гайхамшгийг Есүс үйлдсэний дараа, үлдсэн хүмүүсийн хариу үйлдлээс өөр байдлаар Фарисайчууд хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ? (ш.23–24-ийг үз).
2. Адилхан үйл явдлыг харсан хоёр хэсэг хүмүүс яагаад санал зөрсөн гэж та нар бодож байна? (ш.14-ийг үз).
3. Шүлэг 24-т Түүний талаар Фарисайчуудын хэлсэн зүйлд Есүс хэрхэн хариулсан бэ? (ш.25–29-ийг үз).

В Есүсийн Жишээг Дага

Матай 12 нь ихэвчлэн, Есүс Өөрийг нь эсэргүүцдэг хүмүүст хэрхэн хандаж харьцаж байсан тухай цэдэглэдэг учраас Сүмийг эсэргүүцдэг хүмүүст хандаж харьцахдаа өөрсдийн ашиглаж болох, Есүсийн хийж байсан буюу хэлж байсан нэг зүйлийг энэ бүлгээс сонгон авч, үүнийг хэрхэн ашиглахаа тайлбарла.

Матай 13

Сургаалт Зүйрлэлүүд

Матай 13-т Есүс сургаалт зүйрлэлүүд хэмээн нэрлэгддэг богинохон түүхүүдээр дамжуулан хүмүүст заасан байдаг. Сургаалт зүйрлэлүүдээр дамжуулан заах нь сүнслэг байдлын хувьд зохимжтой хүмүүст агуу үнэ-нүүдийг илчлэх боломж олгодог байсны хамт эдгээр үнэ-нүүдийг хүлээн авахад бэлэн биш хүмүүсээс тэдгээрийг далдлах буюу нуудаг байжээ. Сүнслэг байдлын хувьд бэлэн хүмүүс ч гэсэн Аврагчийн сургаалт зүйрлэлүүдийг бүрэн ойлгохын тулд тунгаан бодож, залбирах ёстой. Сүнсээр дамжуулан бид хариу авах үед бид эдгээр сургаалт зүйрлэлүүдийг илүү сайн хийгээд удаан хугацаанд санадаг учраас энэ нь үнэн хэрэгтээ нэг төрлийн адислал юм.

Сургаалт зүйрлэлүүдийн утгыг ойлгохыг хичээхдээ, дараах гурван үе шат бүхий үйл явцыг анхаар:

1. **Уг сургаалт зүйрлэлийг зураглан дүрсэл.** Энд гарч байгаа юмс буюу хүмүүсийг, түүнчлэн ямар үйл явдал болсон, эдгээр үйл явдлын үр дүн нь юу болохыг жагсаан тооч.
2. **Тайлбарлах түлхүүрийг эр.** Түлхүүрүүд нь Есүсийн хэлсэн “үүн шиг” гэсэн үгс, та нарын судрууд дахь харьцуулах ишлэлүүд, сургаалт зүйрлэлийг өдөөсөн нөхцөл байдал буюу асуулт, тэрчлэн тухайн сургаалт зүйрлэлийг хуваалцсан хүмүүсийн тухай та нар юу мэддэг зэрэг нь байж болно.

3. **Харьцуулалт хий.** Тухайн сургаалт зүйрлэлийн тайлбарын талаар бодохдоо мэдэж авсан зүйлээ тэмдэглэх нь тустай. Сургаалт зүйрлэл дэх хүмүүс хийгээд эд юмсын харилцан халмаарлын талаар асуултууд тавьж, дараа нь эдгээр асуултуудынхаа хариуг бичиж болно.

Матай 13-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 13:1–23—Марк 4:1–20; Лук 8:4–15

Матай 13:31–32—Марк 4:30–32

Матай 13:54–58—Марк 6:1–6

Судруудыг Ойлгох нь



Матай 13

Суулгах, Тарих (ш.3, 27)—
Тарих, үр суулгах

Хавиар (ш.4, 19)—Явж
өнгөрсөн хатуу газар (Зөрөг
буюу зам зэрэг)

Идчихсэн (ш.4)—Идсэн

Хорчийн хатжээ (ш.6)—
Үхжээ

Ойлгох (ш.14)—Ухаарах,
мэдэх, анхааралтай байх

Хатуурч (ш.15)—Хатуу, мэд-
рэмжгүй болох

Баяртайгаар (ш.20)—Чин
сэтгэлээсээ

Тохиолдох (ш.21)—
Үргэлжлэх

Зовлон (ш.21)—Бэрхшээл,
зовлон зүдгүүр

Хуурамч байдал (ш.22)—
Хуурамч амлалтууд

Зэрлэг өвс (ш.25–30)—
Хогийн ургамлууд

Хэлэв (ш.35)—Ярьсан

Ёс бусыг (ш.41)—Нүглийг

Уйлна (ш.42, 50)—Гашуудан
уйлах

Сав (ш.48)—Сав суулга
(юм хадгалах)

Хуулийн багш (ш.52)—
Судруудыг хичээнгүйлэн
судалдаг хүн

Өөр (ш.57)—Бусад, өөр

Судруудыг Судлах нь



Матай 13-ыг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Sp Суулгагчийн Тухай Сургаалт Зүйрлэл

1. Матай 13:3–8 дахь сургаалт зүйрлэл нь үр суулгагчийн тухай сургаалт зүйрлэл гэж олонтаа нэрлэгддэг хэдий ч, эдгээр нь бас хөрсний тухай сургаалт зүйрлэл хэмээн нэрлэгдэж болох вэ?
2. Матай 13:3–8, 18–23-т өгөгдсөн мэдээллээс, хөрсний төрөл бүр дэх үрүүдэд юу тохиолдохыг харуулсан дөрвөн зургийг тэмдэглэлийн дэвтэртээ зур. Зураг бүрийн хажууд юу зурснаа хийгээд энэ нь юуг бэлэгдэж байгааг тайлбарла.
3. Сургаалт зүйрлэл дэх хөрснүүдийн аль нь ч байсан тэр нөхцөлдөө үлдэж чадахгүй. Хөрсний төрөл бүрийг, эрүүл, үр жимсээ сайн өгдөг ургамлууд үүн дээр ургадаг байлгахын тулд юу хийх хэрэгтэйг дүрсэл. Хөрсийг сайжруулах энэхүү төсөл нь та нарыг сүнслэг байдлын хувьд өсөхөд тань та нарын амьдралд юуг бэлэгдэж болохыг мөн дүрсэл.

Б Өөр Сургаалт Зүйрлэлийг Тайлбарла

Дараах сургаалт зүйрлэлүүд буюу бүлэг сургаалт зүйрлэлээс нэгийг нь сонго:

- Зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэл (Матай 13:24–30)
- Гичийн үр болон эсгэх хөрөнгийн тухай сургаалт зүйрлэл (Матай 13:31–33)
- Эрдэнэ хийгээд их үнэт сувдны тухай сургаалт зүйрлэлүүд (Матай 13:44–46)
- Сайн мэдээний торны тухай сургаалт зүйрлэл (Матай 13:47–50)

Сургаалт зүйрлэл буюу сургаалт зүйрлэлүүдийг анхааралтай унш, энэ бүлгийн оршил дахь сургаалт зүйрлэлүүдийг тайлбарлах зөвлөмжүүдийг ашигла, тэгээд дараа нь Их Эзэн Өөрийн хаант улсын тухай юу зааж байсан гэж бодож байгаагаа бич.

Матай 14 “Бүү Ай”

Бүү ай, харин Түүнд хийгээд Түүний зорилгуудад итгэлтэй бай хэмээн Их Эзэн судруудад бидэнд хандан олон удаа хэлсэн байдаг (жишээ нь, Исаиа 41:13; Марк 5:36; С ба Г 6:34–36-г үз). Бид юмыг айж хийсэн үед алдаа гаргах нь олонтаа байдаг, харин бид итгэлтэйгээр үйлдэх үед өөрсдийнхөө хийж чадахаас хавигүй илүү ихийг хийх хүч чадал бидэнд байдаг. Матай 14 дэх түүхүүдэд айдас буюу итгэлийг хэрхэн харуулсныг, мөн айдас буюу итгэл нь хүмүүст яаж нөлөөлдгийг эрж хай.

Матай 14-г Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 14:1–12—Марк 6:14–29

Матай 14:13–33—Марк 6:30–52; Лук 9:10–17; Иохан 6:1–21

Матай 14:34–36—Марк 6:53–56

Судруудыг Ойлгох нь



Матай 14

Өрөвдөн (ш.14)—Хайр болон халамжийн мэдрэмж

Өвдөл цөвдөл (ш.20)—Хүмүүсийн идээгүй зүйл

Даруй (ш.22, 27)—Тэр даруй, түргэн

Албадан (ш.22)—Хэлж, шавдуулан

Өөдөөс нь (ш.24)—Эсрэг

Хүчтэй (ш.30)—Хүчтэй, ширүүн

Гуйж байв (ш.36)—Гуйв, хүсэв

Матай 14:3–4 “Та Түүнийг Авсан нь Хууль Бус Байна”

Марк 6:17–19 (х.51)-гийн “Судруудыг Судлах нь”-ыг үз.



Матай 14:22–33—Петр Усан Дээгүүр Явав

Ерөнхийлөгч Ховард В.Хантер Матай 14:22–33 дахь түүхийг яриад дараа нь:

“Бид хувь хүмүүс, гэр бүлүүд, хамт олноуд хийгээд улс үндэстний хувьд Петр лугаа адил, хараагаа Есүс дээр тогтоон, бид ч бас итгэлгүй байдлын улам ихэсч байгаа давалгаан дээр ялгууснаар алхан, эргэлзээний хуй салхин дунд айдас хүйдэсгүйгээр үлдэж чадна гэдэг нь миний бат бөх итгэл билээ. Гэвч, хэрэв бид итгэх ёстой хүнээс хараагаа холдуулах аваас, ингэх нь тун амархан бөгөөд дэлхийд уруу татах зүйл зөндөө буй, хэрэв бид өөрсдөд маань тусалж, биднийг аварч чадах түүн рүү биш, харин бидний эргэн тойронд байдаг аюулшигт хийгээд сүйтгэгч элементүүдийн хүч болоод хилэгнэл рүү харах аваас, бид зөрчлийн, уй гашуугийн хийгээд цөхрөлийн далайд зайлшгүй живэх болно.

“Үер үйж үхэх аюулаар бидэнд заналхийлэн, гүн нь бидний итгэлийн шидэгдсэн торхыг залгичихаар байгааг мэдэрсэн ийм үед: ‘Зоригтой бай; Би байна; бүү ай’ (Матай 14:27) гэсэн Аврагчийн үгийг бид, шуурга хийгээд харанхуйн дунд ямагт сонсож байх болтугай хэмээн би залбирдаг” гэж хэлжээ (in Conference Report, 1992 оны 10-р сар, 24; Ensign, 1992 оны 11-р сар, 19).

Судруудыг Судлах нь

Матай 14-ийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Усан Дээгүүр Явсан нь

Матай 14:22–33-ын тухай дараах асуултуудад хариул

1. Шавь нараа завин дээр байх үед Есүс яасан бэ?
2. Есүс тэднийг чиглэн усан дээгүүр явж байхад шавь нар нь эхлээд яаж хариу үйлдэл үзүүлсэн бэ?
3. Петр түүний талаар юу гэж хариулсан бэ?
4. Матай яагаад Петрийг живнэ гэж хэлсэн бэ?
5. Живж эхлэхдээ Петр яасан бэ?
6. Христэд ирэх та нарын чармайлтад Петрийн туршлага эрхэн бэлэгдлийн шинжтэй байж болох вэ?

Матай 15

Юу Цэвэр Ариун, Юу Бузар Вэ?

Өмнө нь энэ тухай авч үзсэн өвөг дээдсийн уламжлалууд нь Иудейчүүдийн удирдагчдаас олон жилийн туршид хөгжүүлж ирсэн, Мосегийн хуулинд оруулсан нарийн төвөгтэй нэмэлтүүдийн тогтолцоо байв. Удирдагчдын бодол нь сайн хэдий ч, эдгээр нэмэлтүүд нь эцэстээ Иудейчүүдийн хувьд уг хуулиас өөрөөс нь— тодруулан хэлбэл уг хуулийн амин сүнснээс илүү чухал болсон байлаа. Уг хуулинд оруулсан нэмэлтүүдийн нэг нь хоол идэхийн өмнөх ёслолын угаалгууд байв. Энэ бол эрүүл мэндийн шалтгааны улмаас хийдэг ердийн угаалга байсангүй, харин Иудейчүүдийн удирдагчдаас тогтоосон угаалгын өвөрмөц арга байв. Өвөг дээдсийнх нь энэ уламжлалыг зөрчлөө гэж Есүсийн шавь нарыг буруутгахад, Есүс үүнийг заах боломж болгон ашигласан байдаг. Та нар унших үедээ, Иудейчүүд өөрсдийн ёс заншил дээр анхаарал төвлөрүүлснээр тэд ямар чухал үнэн зарчмуудыг орхигдуулсан тухай Есүс юу гэж хэлснийг эрж хай. Матай 15-ыг уншихдаа Есүс үйлдсэн бусад гайхамигуудыг ол.

Матай 15-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 15:1–31—Марк 7:1–37

Матай 15:32–39—Марк 8:1–10

Судруудыг Ойлгох нь



Матай 15

Та нар тусалж магадгүй байсан өөрийн ямар ч зүйлээ (ш.5)—Та нарт өөрийн өгч болох ямар ч юмыг

Зальхай хүмүүс (ш.7)—Зөв шударга хүсэл бодолгүй хэрнээ бусдад зөв шударга болж харагдахыг хүсдэг хүмүүс

Хүндэлдэг (ш.8)—Ойр байдаг

Дэмий хоосноор (ш.9)—Ямар ч зорилгогүйгээр

Зааврыг (ш.9)—Сүнслэг үнэнүүдийг

Бузарладаг (ш.11, 18, 20)—Нүгэлтэй буюу бузар болгох

Арилдаг (ш.17)—Алга болох

Хэрцгийгээр эзэмдэх (ш.22)—Их зовоох

Гуйв (ш.23)—Хүсэв

Тахир дутуу (ш.30–31)—Гар хөл нь хөдлөх чадваргүй болсон хүмүүс

Матай 15:4–6—“Энэ бол Бэлэг”

Матай 7:9–12-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг үз (х.52)

Матай 15:22–28—Есүс Яагаад Канаан Эмэгтэйг Нохой Гэж Хэлсэн Бэ?

Энд “ноход” гэж орчуулагдсан грек үгийг, гэрийн нохойнууд, эсвээс эздийнх нь хайртай гэрийн тэжээмэл амьтдад хамаарах “жигжигхэн нохойнууд” гэж орчуулах нь дээр юм. Есүс Өөрийн тохинууллын үед гэрийн хүүхдүүд буюу— Израилчууд дээр анхаарлаа төвлөрүүлэхээр ирсэн болохоор ийнхүү Харь эмэгтэйг гэрийн амьтантай зүйрлэжээ. Тэр эмэгтэй Их Эзэнд итгэх итгэлээ ашиглан, гэрийн амьтан нь гэрийн хүүхдүүдэд өгсөн хоолноос унасан “өвдөл цөвдлийг идэх нь” гагцхүү зөв байх болно гэж хэлснээр Есүсийн бэлэгдлийн үгэн дээр барьсан хэрэг.

Судруудыг Судлах нь



Матай 15-ыг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Түлхүүр Сгс болон Холбоо Сгнүүдийг Тайлбарла

Дараах үгс буюу холбоо үг тус бүр нь Матай 15 дахь үйл явдлуудтай ямар холбоотойг тайлбарла.

1. “Ахмадын ёс заншил” (ш.2–9-ийг үз)
2. Бузарлах буюу бузарладаг (ш.7–11, 17–20-ийг үз)
3. Уруул, зүрх, ам (ш.7–11, 17–20)
4. Ноход (ш.22–28-ыг үз)
5. Өрөвдөх (ш.32–39-ийг үз)
6. Талх, загаснууд (ш.32–39)

Матай 16

“Та Бол Христ”

Матай 16-д дүрсэлсэн үйл явдлуудын үеэр Аврагчийн гайхамшигт хүчийг олон хүн гэрчилсэн билээ. Түүнд жинхэнээр итгэдэг байсан хүмүүс тооны хувьд цөөхөн хэвээр байлаа. Яагаад илүү олон хүмүүс хөрвүүлэгдээгүй вэ? Түүний гайхамигууд Тэр бол Христ, амлагдсан Мессиа байсан гэдгийн хангалттай нотолгоо болж чадаагүй юу? Матай 16-г уншихдаа Фарисайчууд болон Садукайчууд Есүсийн өгөхөөс татгалзсан юуг хүсч байсныг эрж хай. Түүнчлэн үнэхээр гэрчлэлийг авчирч, хүмүүсийг хөрвүүлдэг юуг Есүс шавь нартаа зааж байсныг эрж ол.

Матай 16-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 16:1–12—Марк 8:11–21

Матай 16:13–28—Марк 8:27–9:1; Лук 9:18–27

Судруудыг Ойлгох нь



Матай 16

Ялган мэдэх (ш.3)—Мэдэх, шийдэх

Хөрөнгө (ш.6, 11)—Эсгэх хөрөнгө

Ярилцах (ш.8)—Хэлэлцэх
Дийлэх (ш.18)—Даван туулах, ялах

Холбох (ш.19)—Хамтад нь холбох буюу хамтад нь лацдах

Зэмлэх (ш.22)—Хүнээр ямар нэг юм хийхийг нь болиулах, залруулах

Боддог (ш.23)—Хүсдэг

Өөрийгөө үгүйсгэх (ш.24)—Өөрийгөө болон өөрийн ашиг сонирхлыг умартах

Матай 16:18—Есүс Петрт Ямар “Хадны” Тухай Ярьсан Бэ?



“Есүс Өөрийн заадаг зүйлүүдэд хэлэхдээ, “Энэ хадан дээр би Өөрийн Сүмийг барих болно, тийнхүү тамын үүд үүнийг дийлэх нь үгүй” хэмээн хэлсэн билээ. Ямар хад вэ? Илчлэлт гэж Бошиглогч Иосеф Смит хэлсэн байдаг” (Teachings of the Prophet Joseph Smith, 274).

“Үүгээр [Матай 16:18] Тэрбээр Симоны нэр ‘Петрийг’ хад хэмээн

хэлжээ, тийм болохоор илчлэлтээр ирдэг энэхүү гэрчлэл нь Христийн Сүм дээр нь баригдах тэрхүү хад байх болно” гэж Ерөнхийлөгч Давид О.Маккей бичжээ (Ancient Apostles [1964], 34; түүнчлэн Матай 16:18, зүүвэр тайлбар а-г үз).

Сүмийн хүч чадал нь Ариун Сүнсний хүчээр дамжин хувь гишүүдэд илчлэлтээр ирдэг, Есүс бол Христ мөн хэмээх гэрчлэл гэдгийг Есүс Петрт заасан бөгөөд үүнийг Петр болон бусад бүх бошиглогчид хийгээд төлөөлөгчид тэр цагаас хойш заасаар ирсэн билээ.

Матай 16:19—“Хаант Улсын Түлхүүрүүд”

Их Эзэний үхэл хийгээд амилуулалтын дараа дэлхий дээр Сүмийг чиглүүлж байх боломжийг түүнд болон бусад Төлөөлөгчдөд олгох санваарын түлхүүрүүд, түүний дотор өргөмжлөлийн тулд шаардлагатай бүх ёслолуудыг хууль ёсоор гүйцэтгэх эрх Петрт амлагдсан байлаа. Дэлхий дээр түүний гүйцэтгэсэн ёслолууд мөн түүнчлэн тэнгэрт ч гэсэн хүчинтэй байх болно гэдэг нь Петрт амлагдсан байсныг тусгайлан анхаарч ажигла. Тийнхүү, тэрээр бусад зүйлүүдийн дотор, эхнэр, нөхрүүд хийгээд хүүхдүүдийг үүрд хамтад нь лацдан холбох хүчийг зайлшгүй хүлээн авсан ажээ. Тэрээр эдгээр түлхүүрүүдийг хэрхэн хүлээж авсныг бид Матай 17-д уншдаг.

Матай 16:20—Яагаад Есүс Шавь нар нь Түүнийг Христ Байсан Гэдгийг Хэнд ч Хэлэхийг Хүсээгүй Вэ?

Есүс Өөрийн гурван жилийн тохинууллын төгсгөл хавьд Тэр бол Христ—Иудейчүүдийн Мессиа мөн гэдгийг илүү ил тодоор зааж байлаа. Энэ нь Иудейчүүдийн удирдагчдыг уурлуулж, Түүний Цовдлолт уруу шууд хөтөлсөн билээ. Тэр үед энэ сургаалыг ил тодоор заахгүй байхыг Өөрийн шавь нараас хүссэн нь сайн мэдээний захиасыг заахаа үргэлжлүүлэх, түүнчлэн шүүгдэж, цовдлуулах Түүний цаг болохоос өмнө Иудейчүүдийг уурлуулахгүй байх боломжийг Түүнд олгосон ажээ.

Судруудыг Судлах нь

Матай 16-г судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Төгс Эзэмших Судар—Матай 16:15–19

1. Матай 16:15-д Есүс нэг асуулт асуусан байдаг. Петрийг хариулсны дараа, Есүс уг хариултын талаар түүнд юу гэж заасан бэ?
2. Петрт Есүсийн хэлсний дагуу, энэ арга замаар Сүмийн гишүүд гэрчлэлтэй болох нь ямар ач холбогдолтой вэ? (түүнчлэн дээрх “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз).
3. Петрт байсан тэрхүү гэрчлэлийн хариуд Фарисайчууд болон Садукайчууд юу хийхийг хүсч байсан бэ? Тэдний хүсч байсан зүйлийн талаар Есүс юу гэж хэлсэн бэ? (Матай 16:1–4-ийг мөн үз).
4. Яагаад Петрийн хүлээн авсан гэрчлэл Фарисайчууд хийгээд Садукайчуудын түүнээс хүссэн “гэрчлэлээс” илүү хүчирхэг хийгээд хөрвүүлэгч шинжтэй байсан бэ?

Б Есүсийг Дагах нь

Түүнийг дагана гэдэг ямар утга учиртай талаар Есүс шавь нартаа зааж байсныг бид Матай 16:24–28-д уншдаг. Дараах нөхцөл байдал тус бүрт эдгээр нөхцөл байдлуудад хариу үйлдэл үзүүлэхдээ өөрсдийн ашиглаж болох өгүүлбэр буюу шүлгүүдийг хэл (Иосеф Смитийн Орчуулгыг ашиглахаа бүү мартаарай).

1. Таныг спортын багт тоглуулахын тулд их сургуулийн тэтгэлгийг танд санал болгожээ. Цорын ганцхан болзол нь, та номлолд үйлчлэхийг зөвшөөрөх ёсгүй, учир нь энэ нь таныг тамирчин болж хөгжихөд хортой гэж дасгалжуулагч бодож байгаа болно.
2. Мацаг барих нь таны толгойг өвтгөж, энэ нь танд туслахгүй гэж та боддог болжээ. Гэрт тань таныг хоол идэхээр гал тогоо уруу ухасхийхэд, хэн ч зогсоож чадахгүй.
3. Их цалинтай боловч таныг Ням гараг бүр Сүмээс хөндийрүүлж, бас их хугацааг гэр бүлээсээ хол өнгөрүүлэх ажлыг танд санал болгожээ. Уг ажлыг танд санал болгож байгаа хүн, ийм байдал 10–12 жил үргэлжлэх болно гээд, “хэрэв та энэ ажилд өөрийгөө зориулах юм бол, та өөртөө асар их баялагтай болно, тэгээд дараа нь үүнийгээ дуртай зүйлдээ, гэр бүлдээ ч юмуу эсвэл Сүмдээ зориулан ашиглаж болно” гэж хэлжээ.

4. Сургуулийн нэг ангийн гишүүн ойртож байгаа маш чухал шалгалтын асуултын (хариутайгаа хамт) хувийг олж авчээ. Ангийн хэсэг гишүүд үүнийг хамтдаа судлахаар цуглав. Тэд чамайг урьжээ.

Матай 17

Хувиралтын Уул

Матай 16 нь Есүс тэнгэрийн хаант улсын түлхүүрүүдийг Петрт амласан тухай өгүүлдэг. Матай 17-д Петр, Иаков, Иохан нар тэдгээрийг хүлээн авсан цаг үеийн тухай өгүүлдэг. Эдгээр түлхүүрүүд нь авралын ёслолуудыг Бурхан хүлээн авч болохуйц байдлаар гүйцэтгэх, тэрчлэн дэлхий дээр Есүс Христийн Сүмийг удирдах хүчийг өөртөө багтаадаг. Матай дахь энэ үйл явдалтай төстэй нэг үйл явдал Бошиглогч Иосеф Смит 1836 онд Көртландын Ариун Сүмд энэ эрин үед зориулсан хаант улсын түлхүүрүүдийг хүлээн авах үед тохиосон билээ (С ба Г 110-ыг үз). Тэр үеэс хойш уг түлхүүрүүд Сүмийн Ерөнхийлөгч бүрт томилолтоор өгөгдсөөр иржээ.

Энэ бүлэг дэх үйл явлын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Библийн Толь Бичиг, х.786, "Transfiguration, Mount of" оос үз.

Матай 17-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 17:1–23—Марк 9:2–32; Лук 9:28–45

Судруудыг Ойлгох нь



Матай 17

Гарах (ш.1)—Хүнээс зайдуу, хол

Хувирч өөрчлөгдөв (ш.2)—Хүний бие түр хугацаагаар хувирч, тэнгэрлэг биетүүдийн оршихуйд алдар сууг олж, үхэхгүй болдог байдал

Хувцас (ш.2)—Өмсгөл

Елиа (ш.3)—Елиа (Еврей нэрний грек хэлбэр)

Өөр (ш.8)—Өөр, бусад

Солиотой (ш.15)—Хүн биеэ бүрэн хянаж чадахгүй болж, салганан чичирдэг сэтгэцийн өвчин

Их өвчтэй (ш.15)—Хүндээр өвчилсөн

Тэрслүү (ш.17)—Гэм зэмгүй

Зэмлэв (ш.17)—Хүнээр

ямар нэг юм хийхийг нь болиулахыг, залруулах

Татвар (ш.24–25)—Алба гувчуур, татвар

Матай 17:1—Яагаад Зөвхөн Петр, Иаков, Иохан Нар Энэ Туршлагад Уригдсан Бэ?

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит тайлбарлахдаа: "Петр, Иаков, Иохан нар тэр үед Сүмийн Тэргүүн Зөвлөл

болж ажиллаж байсан юм (*Doctrines of Salvation*, Bruce R. McConkie, 3 боть зохиолын эмхтгэл, [1954–56], 3:152) гэжээ". Ийм учраас тэд дуудагдсан ажлаа гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай түлхүүрүүдийг хүлээн авахын тулд Хувиралтын Уулан дээр гарчээ.



Матай 17:10—Шавь Нар Елиагийн Тухай Юу Мэдсэн Бэ?

Петр, Иаков, Иохан нар Есүстэй хамт уулан дээр гарч Мосе, Елиа хоёрыг харсан бөгөөд Мессиагийн өмнө Елиа ирэх болно гэсэн бошиглолыг тэдэнд сануулжээ (Матай 17:10-ыг үз). Есүс бол Мессиа байсан гэдгийг тэд гэрчлэхийн хамт, харин Тэрээр уулан дээр Елиаг хүрч ирсэний дараа биш, өмнө нь иржээ гэж будилсан ажээ. Иосеф Смитийн Орчуулгад цэдэглэгдсэнээр, Есүсийн хариулт нь, Елиа бол нэгээс илүү хүнд хамаатай ерөнхий нэр юм. Иохан Баптист бол Аврагчийн анхны ирэлтийн "замыг бэлтгэх" урьд нь ирэгч болж "аль хэдийнэ ирсэн" Елиа байлаа. Өөр нэгэн Елиа "бүх зүйлийг сэргээхийн тулд" сүүлчийн өдрүүдэд ирэх болно (ИСО, Матай 17:10–14-ийг үз). "Иосеф Смит бол Елиа байлаа, учир нь тэрээр бидний Аврагчийн хоёр дахь ирэлтийн замыг бэлтгэхээр илгээгдсэн юм" хэмээн Бошиглогч Жозеф Фийлдинг Смит сургажээ. (*Answers to Gospel Questions*, Joseph Fielding Smith Jr., 5 боть зохиолын эмхтгэл. [1957–66], 4:194).

Судруудыг Судлах нь



Матай 17-г судлахдаа үйл ажиллагаануудын (А болон Б, В) аль нэгийг хий.

А Тэд Юу Сурч Авсан Бэ?

Петр, Иаков, Иохан нар Есүсийн тухай уулан дээр юу сурч авсан бэ? (Матай 17:1–9; Петр хожим нь энэ үйл явдлын тухай 2 Петр 1:16–19-д тэрчилжээ).

Б Юуг Өөрчилсөн Бэ?

Матай 17:14–21 нь Есүс өвчтэй нэг залууг эдгээсэн тухай өгүүлдэг. Есүсийн өгсөн санваар өөрсдөд нь байсан агал тэд яагаад тэр хүнийг эдгээж чадахгүй байсандаа шавь нар нь гайхжээ.

1. Тэр хүнийг эдгээхэд шавь нартаа тусалж чадах байсан, Есүсийн хэлсэн гурван зүйлийг жагсаа. Тэдгээр зүйлүүд юуны учир хэрхэн шаардлагатай болохыг тайлбарла.
2. Эдгээр гурван зарчмын нэгийг амьдралд хэрэглэсэн хүнд буюу тэрч байтугай боломжгүй мэт санагдаж байсан ямар нэг зүйлийг хийхэд та нарт тусалсан цаг үеийн тухай бич. Хэрэв үүнтэй төстэй туршлага танд байхгүй бол, ийм туршлага байж магадгүй гэж бодсон хэн нэгэнтэй ярилц. Энэ тухай тэр хүнээс асууж, мэдэж авсан зүйлийнхээ талаар товч бич.

В Захиас нь Юу Вэ?

Матай 17:24–27-д Есүсийн хэлсэн буюу хийснээс бид сурч болно гэж боддог зүйлүүдээс наад зах нь хоёр сургамжийг бичиж, яагаад эдгээр сургамжууд танд чухал болохыг хэл.

Матай 18

“Бүдрүүлэлт” ба Уучлал

Ерөнхийдөө, хатуу хахир, түрэмгий байж шудрага бус замаар харьцахыг татгалздаг хүмүүсийг дэлхий шагнаж, хүндэтгэдэг. Алдаа гаргах явдлыг сул доройн тэмдэг гэж дэлхий үзэх нь олонтаа байдаг. Амьдралын энэхүү хэв маягийг Матай 18-д Есүс Өөрийн шавь нарт заасан зүйлүүдтэй хэрхэн харьцуулж болох вэ?

Матай 18-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 18:1–5—Марк 9:33–37; Лук 9:46–48

Матай 18:6–9—Марк 9:42–48; Лук 17:1–2

Матай 18:10–14—Лук 15:3–7

Судруудыг Ойлгох нь



Матай 18



Тээрмийн чулуу

Тээрмийн чулуу (ш.7)—Тариа тээрэмдэхэд ашигладаг хүнд чулуу; энэ чулууг илжиг эргүүлж байх ёстой тул тийм хүнд байжээ

Бүдрүүлэх сааднууд (ш.7)—Сул дорой буюу хөнгөн хуумгай хүмүүсийг нүгэл үйлдэх буюу алдаа гаргахад хүргэж болох үйл ажиллагаанууд

Хөлгүйгээр (ш.8)—Доголох, хазганах

Гаргүй, хөлгүйгээр (ш.8)—Гар буюу хөлөө бүрэн ашиглах боломжгүй

Басамжлах (ш.10)—Дорд үзэх

Эрсдэх (ш.14)—Мөхөх (эсвэл сүнслэг байдлаар устгагдах)

Нүгэл үйлдэх (ш.15)—Гэм нүгэл, алдас хийх

Татгалзах (ш.17)—Үгүй гэх

Харь үндэстэн (ш.17)—

Бурханд итгэдэггүй хүн

Талаар (ш.19)—Тухай

Боолуудтайгаа тооцоо хийх (ш.23)—Үйлчлэгч бүрийнхээ өртэй мөнгийг авах

Тооцоо хийх (ш.24)—Тоолох, юмсын тоон дүнг гаргах

Арван мянган талант (ш.24)—Сая сая ажлын өдөртэй тэнцэх урд хожид үзэгдээгүй их мөнгө; эргүүлж төлөх боломжгүй их мөнгө

Гуйв (ш.29)—Ихэд хүсэмжлэн гуйв

Хилэгнэн уурлах (ш.34)—Их уурлах

Зандалчин (ш.34)—Шоронгийн харгалзагч, хүн зовж, шаналан тарчилдаг газар



Есүс ба Билал Хүүдэр Карл Хейррих Блок, Хиллерданы Фредриксбург дахь Угдасий Туурайн Музей

Матай 18:6—“Хэн Эдгээр Багачуудаас Нэгийг нь Бүдрүүлнэ”

Матай 18:3–6-д Есүс Түүний хаант улсад орохын тулд зөвхөн бяцхан хүүхдүүд мэт болох төдийгүй, бяцхан хүүхдүүдэд анхаарал халамж тавихад анхаарч байхыг бидэнд зарлигласан байдаг. Энэ нь зөвхөн насаар бага балчир хүүхдүүдийг төдийгүй, бас хаант улсад орохын тулд саяхан өөрсдийгөө бяцхан хүүхдүүдтэй адил болгосон, сайн мэдээнд нас залуу хүмүүсийг багтааж болно.

Хүүхэдтэй зүй бус харьцдаг хүмүүст хандаж, Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлэхдээ: “Үүнийг зогсоож, үүнээс зайлсхийж, гомдоосон тэдэнд тусалж, тэднээс уучлал гуйхын тулд, тэдэнтэй харилцах харилцаагаа өөрчлөн сайжруулахын тулд Их Эзэнд хандан гуйхыг бибээр өөртөө байгаа бүхий л хүч боломжоор та бүгдээс шаргуу хүсч байна” хэмээн хэлжээ (in Conference Report, 1994 оны Аравдугаар сар, 74; Ensign, 1994 оны 11-р сар, 54).

Матай 18:8–9—Гар, Хөл, Нүдээ Авч Хаях нь

Матай 18:9-ийн Иосеф Смитийн Орчуулгыг үз. Түүнчлэн Матай 5:29–30-ийн “Судруудыг Ойлгох нь”-ыг үз х.17.

Судруудыг Ойлгох нь

Матай 18-ыг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Бяцхан Хүүхдүүд

1. Матай 18:3–4-ийн дагуу, бяцхан хүүхдүүд хийгээд тэнгэрийн хаант улс болох бидний хоорондын холбоо ямар хоёр хэлбэрээр оршдог вэ?
2. Мозая 3:19-ийг уншиж, бид бяцхан хүүхдүүдтэй адилхан болох арга замуудыг жагсаа. Та нар судрынхаа зах дээр Матай 18:3–4-ийн хажууд Мозая 3:19-ийг бичиж болно.
3. Матай 18:5–14-т Есүсийн хэлсэн зүйлээс хүүхдүүдтэй зохих ёсоор харьцах явдлыг урамшуулан дэмжсэн гурван нотолгоог өөрсдийн үгээр бич.

Б Бусадтай Хамтран Асуудлуудыг Шийдвэрлэх нь

Матай 18:15–35 дахь Есүсийн заасан зүйлүүд нь, бусад хүмүүс биднийг гомдоосон үед асуудлыг шийдвэрлэх зарим арга замыг ойлгоход бидэнд тусалж чадна.

1. Матай 18:15–17-гийн дагуу, хэн нэгэн хүн биднийг гомдоосон үед бидний хийх ёстой эхний гурван алхам юу вэ?
2. Шүлэг 21–35 нь хүн биднийг гомдоосон үед бид юу хийх ёстойг заадаг. Шүлэг 23–34 дэх сургаалт зүйрлэлүүдийг уншихдаа “арван мянган талантын” болон дээрх “Судруудыг Ойлгох нь” хэсэг дэх “зандалчин” гэдэг үгийн тайлбарыг анхааралтай авч үз. Сургаалт зүйрлэлүүдэд дараах зүйлүүдийг: таныг, Аврагчийг, Цагаатгалаас таны хүлээн авдаг ашиг тусыг, таныг гомдоох ямар нэг зүйл хийсэн хүнийг, уучилж боломгүй нүглийн төлөөх зовлонг хэн буюу юу төлөөлж байгааг бич.
3. Энэрэнгүй биш зарцын (үйлчлэгч) тухай энэ сургаалт зүйрлэлээс бид юуг сурах ёстойг Есүс юу гэж хэлснийг бич.
4. Уучлалын зарчмын тухай цаашдын ямар ойлголтыг Их Эзэн Сургаал ба Гэрээ 64:8–10-т өгсөн бэ?

Матай 19

Мөнх Амьдралтай Байхын Тулд Би Юу Хийх Ёстой Вэ?

Есүсийн үеийн Иудейчүүд урвалтын байдалд байжээ. Тэд хэсэг бүлгийн хувьд Бурханаар Мосед илчлэгдсэн өөрсдийн шашныг жинхэнэ ёсоор хэрэгжүүлэх явдлаас урвасан байлаа. Мари, Иосеф, Иохан Баптист зэрэг, хэрхэн зөв шударга амьдрахыг мэддэгийнхээ дагуу зөв шударгаар амьдардаг хүмүүс ч олон байв. Хуулийн багш нар, Фарисайчууд хийгээд Садукайчууд зэрэг Иудейчүүдийн итгэлд эрх мэдэл хийгээд удирдах

албан тушаалуудад байсан хүмүүс үнэнээс урвасан нь бүр ч тодорхой байлаа. Тэд жинхэнэ зөв шударга ёсноос илүүгээр удирдах албан тушаалуудаа хадгалж үлдэхэд илүү их анхаардаг байв. Есүс тэдний бардамнал хийгээд хоёр нүүрт байдлыг зэмлэн буруушаахад Түүний үгс тэдний зүрх сэтгэлийг шархлуулсан ажээ.

Матай 19 болон дараачийн хэдэн бүлгийг уншихдаа, жинхэнэ шударга ёс гэж юу болохыг тодорхойлсноор Есүс тэдэнд асуудал төвөг удаж байсан тэр үед Иудейчүүдийн удирдагчид Есүс рүү хэрхэн дайрч, түүнийг ичээхийг улайран зүтгэхээ үргэлжлүүлсээр байсныг ажигла.

Матай 19-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 19:1–9—Марк 10:1–12

Матай 19:13–30—Марк 10:13–31; Лук 18:15–30

Судруудыг Ойлгох нь

Матай 19

Нийлэх (ш.5)—Хамтрах, нэгдэх

Тайган хүн (ш.12)—Агталсан буюу зассан эр хүн. Ийм хүн гэрлэж, хүүхдийн эцэг болох боломжгүй.

Орхисон (ш.27, 29)—Орхисон, хаясан

Дахин төрөлт (ш.27)—Амилуулалт



“Тиймээс эр хүн эцэг эхээ орхин эхнэртэйгээ нийлж, хоёулаа нэг бие махбодь болдог.”

Матай 19:3–12—Гэрлэлт ба Салалтын тухай Есүсийн Зовлогоо

Есүсээс Фарисайчуудын асуусан асуулт бол Иудейн итгэлийн янз бүрийн бүлгүүдийн дунд маргаантай асуудал

байжээ. Мосегийн хуулин дахь салалтыг Их Эзэн зөвшөөрдөг байсныг зарим хүмүүс, эр хүн бараг л шалтгаан болгоноор эхнэрээсээ салж болох юм шигээр тайлбарладаг байв. Салах тухай хуулийн энэ тайлбарыг зүрх сэтгэл нь цэвэр ариун биш хүмүүс ашиглаж, тачаангуй хүслээ гүйцэлдүүлэхийн тулд олон дахин гэрлэдэг байжээ. Есүс энэхүү дадал зуршлыг ээмлэн буруушааж, үүнийг садар самуун хэмээн нэрлэсэн байна (Матай 5:31–32; 19:9-ийг үз).

“Салалт бол сайн мэдээний төлөвлөгөөний хэсэг биш. . . . Хамгийн төгс нөхцөлүүдэд, бэлгийн харилцааны нүгэл үйлдээгүй л бол салалт байх ёсгүй. Өнөө үед . . . илүү өндөр тогтолцоон дор [Есүсийн заасан] салсан хүмүүс, энэ үйлдээ ёс суртахуунгүй байдлын толбогүйгээр дахин гэрлэхийг Сүм зөвшөөрдөг” (Doctrinal New Testament Commentary, 1:547).

Салалтын эсрэг Есүс ийнхүү хатуугаар хэлсэн учраас зарим шавь нар нь ерөөсөө гэрлэхгүй байх нь дээр юм биш үү гэж илт боддог байжээ. Хариуд нь, зарим хүмүүст ийм боломж байхгүй байх болно гэдгийг Есүс хүлээн зөвшөөрөөд, гэвч энэ нь Бурхан яагаад ч болов анхааралдаа авах зүйл байх болно гэдгийг тэмдэглэжээ (Матай 19:10–12-ыг үз). “Тэрлэлт Бурханаар томилогддог” гэдгийг Их Эзэн өнөө үед илчилсэн билээ (С ба Г 49:15; тэрчлэн “Тэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг,” *Ensign*, 1995 оны 11-р сар, х. 102-ыг үз).

Судруудыг Судлах нь

Матай 19-ийг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Салалт



Эр хүн аль ч шалтгаанаар эхнэрээсээ салах нь зөв үү гэж Фарисайчууд Түүнээс асуухад Есүс хэрхэн хариулсныг бид Матай 19:3–9-д уншдаг. Эдүгээ улам өсөн нэмэгдэж байгаа салалттай холбон авч үзвэл, уг асуулт өнөөдөр ч гэсэн чухал учир холбогдолтой юм.

Есүсийн өгсөн хариулт хийгээд дээрх “Судруудыг

Ойлгох нь” хэсэг дэх тайлбар дээр тулгуурлан, салах гэж байгаа хүн уншиж, тунгаан бодвол зохино гэж өөрсдийнхөө үзсэн, салалтын талаарх Есүсийн үзэл бодлыг тайлбарласан товч дүгнэлт бич.

Б Баян Залуу

1. Матай 19:16–22-т гардаг залуу хүн яагаад Есүсийг дагахгүй байхаар шийдсэн бэ?
2. Түүний дагахаар золиослол хийсэн хүмүүст Есүс ямар адислалуудыг амласан бэ? (ш. 23–30-ийг үз).
3. Залуу эрийг явсны дараа Есүс болон Түүний шавь нар юу гэж хэлсэн дээр тулгуурлан (23–30-ийг үз), өөрсдөө энэ залуу хүнд хандан, тэрээр энэ шийдвэрээ эргэн харах хэрэгтэйгээ ойлгоход нь түүнд туслахыг хичээж, түүнд захидал бич.

Матай 20

Агуу Ихийг Есүс Дахин Тодорхойлов

Та нар өөрсдийгөө чухал хүн гэж бодох дуртай юу? Өөрсдийгөө чухал хүн гэж бодоход тань юу тусалдаг вэ? Нэрд гарч хүлээн зөвшөөрөгдсөн байдал уу? Удирдах албан тушаал уу? Мөнгө үү? Амжилт уу? Есүсийн үеийн Фарисайчууд өөрсдийгөө нэн чухал хүмүүс гэж үздэг байжээ. Тэдний ингэж боддог байсан шалтгаан нь өнөө үед агуу их байдлыг, түүнчлэн хэн, эсвэл юу чухал болох тухай хүмүүсийн тодорхойлдогтой адил төстэй юм. Гэвч Матай 20-ийг уншихдаа, Түүний хаант улсад юу чухал хийгээд юу агуу болохыг ойлгох талаар Есүс юу хийсэн буюу юу хэлснийг сайтар бод. Түүнчлэн сүүлийн сард, бүр тэр ч байтугай, Есүсийг цовдлогдохоос хоёр долоо хоногийн өмнө Матай 20-д юу хэлэгдэж, юу хийгдсэнийг мэдэх нь ашиг тустай юм.

Матай 20-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 20:17–34—Марк 10:32–52; Лук 18:31–43

Судруудыг Ойлгох нь

Матай 20

Газрын эзэн (ш.1)—Гэрийн эзэн

Ажилгүй (ш.3, 6)—Ажил хийгээгүй, хийх юмгүй

Орой болоход (ш.8)—Нар жаргах, үдэш болох

Даамал (ш.8)—Өөр хүний юмыг хариуцдаг хүн


Дургүйцэж гомдоллов (ш.11)—Гомдол гаргах, дургүйцэх

Ажилласан (ш.12)—Ажил хийсэн

Өөрийнхөө хөлсийг ав (ш.14)—Өөртөө хамаарах зүйлийг—өөрт ноогдохоо ав

Ташуурдуулж (ш.19)—Үзүүр хэсэгтээ хурц яс болон чулуутай ташуураар зодуулах

Зебедеен хөвгүүд (ш.20)—Төлөөлөгч Иаков, Иохан хоёр



Ташуурдахад Хэрэглэсэн Ташуур

Зэвүүцэл (ш.24)—Ихэд дургүйцэх

Ноёрхох (ш.25)—Эзэн нь байх

Зарц, үйлчлэгч (ш.26, 28)—Өөр хүний хэрэгцээнд үйлчилдэг хүн


Золиос (ш.28)—Төлөөс (хоригдсон болон чөлөөлөгдөхөд хэрэгцээтэй тэдгээр хүмүүст)

Зандрах (ш.31)—

Болиулахаар хүчтэй хүсэх

Судруудыг Судлах нь

Матай 20-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий



А Хөдөлмөрлөгчдийн Тухай Сургаалт Зүйрлэл

Матай 20:1–16 дахь сургаалт зүйрлэл нь Матай 19-ийн төгсгөлд Петртэй Есүсийн ярилцсан ярианы хариулт бололтой. Хаант улсад үйлчлэхэд түүний хийсэн гэж бодож байсан золиослолын төлөөх түүний шагнал юу байх тухай Петр асуужээ. Уг сургаалт зүйрлэл Матай 19-ийн төгсдөгтэй нэн адилаар төгсч байгааг ажигла.

1. Доорхтой төстэй бүдүүвчийг тэмдэглэлийн дэвтэртээ хий. Матай 20:1–16-д сурсан зүйлээрээ үүнийг бөглө.

Ажиллагсдыг Хөлсөлсөн Цаг	Тэр хүн тэдэнд хэдийг төлөхөөр тохиролцсон бэ	Ажилласан цагууд	Тэдэнд яг хэдийг төлсөн бэ

2. Их Эзэний хаант улсад үйлчлэх талаар энэ сургаалт зүйрлэлээс бид юу мэдэж болох вэ?
3. Сүмд хөрвөгчдийн хувьд тайтгарлын ямар захиас үгийг энэ сургаалт зүйрлэл агуулдаг вэ?

Б Та Яаж Агуу Болж Чадах вэ?

Хөвгүүд нь Бурханы хаант улсад чухал суудал эзэлж чадах болов уу гэж Иаков, Иохан хоёрын ээж Түүнээс асуусны дараа Есүсийн хэлсэн зүйлийг бид Матай 20:20–28-аас уншдаг.

1. Тэр эмэгтэйн хүсэлтэд өгсөн Есүсийн хариултан доторх хамгийн чухал гэж өөрсдийн бодсон гурван үг буюу холбоо үгийг сонгон авч, яагаад эдгээр үг буюу холбоо үгийг сонгож авснаа тус бүрт нь тайлбарла.
2. Аврагч Өөрийнхөө ярьсан агуу байдлыг хэрхэн харуулдаг байсан тухай Матай 20:17–19, 28–34 жишээнүүдийг жагсаа.

Матай 21–22

Иерусалим дахь Сүүлчийн Гэрч



Мөнх бус байдал дахь Түүний номлолын төгсгөл ойртож байгааг Есүс мэдэж байв (Матай 20:17–19-ийг үз).

Гэсэн хэдий ч, Тэр бол эхлэлээс ариун бошиглогчдоор амлагдсан Мессиа үнэхээр мөн байсныг гэрчлэх нэмэлт гэрчлэлүүдээр тэр үеийн Иудейн удирдагчдыг Тэрээр наснаас халихаасаа өмнө хангасан юм. Матай 21–22-ыг уншихдаа, Иудейн удирдагчдад Есүсийн өгсөн олон янзын гэрчлэлүүдийг эрж хай. Эдгээрт бошиглолын биелэлт, Түүний Өөрийнх нь заадаг байсан зүйлүүд хийгээд гэрчлэл, түүнчлэн бусад олон хүний, түүний дотор Түүнийг Иерусалимд орж ирэхэд Хаандаа хандан, “Хосанна!” хэмээн хашгирч байсан хүмүүсийн гэрчлэл багтана.

Матай 21 нь Аврагчийн мөнх бус амьдралын сүүлчийн долоо хоногээр эхэлдэг.

Матай 21–22-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 21:1–11—Марк 11:1–11; Лук 19:29–44; Иохан 12:12–19
 Матай 21:12–17—Марк 11:15–19; Лук 19:45–48;
 Матай 21:18–22—Марк 11:12–14; 20–24
 Матай 21:23–27—Марк 11:27–33; Лук 20:1–8
 Матай 21:33–46—Марк 12:1–12; Лук 20:9–19
 Матай 22:15–46—Марк 12:13–37; Лук 20:20–44



Матай 21

Ойртон ирж (ш.1)—
Ойрхон ирж
Юм (ш.3)—Ямар нэг юм
Хосанна (ш.9, 15)—Одоо авар!
(Энэ нь Есүс бол Мессиа байсан бөгөөд тэднийг авраач хэмээн хүмүүсийн хашгирдаг байсан уриа байжээ)
Нялх хөхүүд хүүхдүүд (ш.16)—Нярай, хөхүүд хүүхдүүд
Хувхайрчээ (ш.19–20)—Хатаж эхэлжээ
Тэр хоёрын аль нь (ш.31)—Тэр хоёрын аль нь

Тойруулан хашаа барьж (ш.33)—Тойруулж хашаа бариад
Түрээслэв (ш.33)—Түрээсэлсэн
Тариаланчдад (ш.33–35, 38, 40–41)—Фермийн эзэн
Өвийг нь булаацгаая (ш.38)—Өмчлөгчийн буюу эцгийнх юмыг авах, эзэмших
Тушааж өгөх (ш.41)—Өгөх, хангах
Ойлгов (ш.45)—Ухаарав, ойлгов

Матай 21:1–11—Есүс Илжиг Унан Иерусалимд Ирсэний Ач Холбогдол Юу вэ?

Өөрсдийнхөө Мессиаг илжиг унаж Иерусалимд ирэхэд нь Иудейчүүд таних болно гэж бошиглогч Зехариа заасан байдаг (Зехариа 9:9; Матай 21:4–5-ыг үз). Израилын хаад илжиг унадаг уламжлалтай байжээ (Шүүгчид 5:10; 10:4; 12:14; 2 Самуел 16:1–2; Хаадын Дээд 1:33-ыг үз). Тийнхүү Есүс дуран унаж, бошиглолын биелэлт болж, Израилын хаан, Мессиа болон Иерусалимд орж иржээ.

Матай 21:12–13—Яагаад Хүмүүс Ариун Сүмд Наймаа Хийж, Мөнгө Сольж Байсан Бэ?

Матай 21-ийн үйл явдлууд Дээгүүр Өнгөрсний Баярын долоо хоногийн үеэр болжээ. Тэр долоо хоногт Иудейчүүд шүтэн бишрэх хийгээд тахил өргөхийн тулд олон улс үндэстнүүдээс ирдэг байв. Тэр үед тахил өргөхийн тулд хэрэглэх малыг худалдан авч, аялагчдыг хөнгөвчлөхийн тулд гадаадын мөнгийг сольдог байжээ. Аврагч хоёр шалтгааны улмаас энэ бизнесийг эсэргүүцжээ: Энэ нь Их Эзэний өргөөнд хийгдэж байлаа, тэгснээр үүнийг дээрэмчдийн үүр болгож байлаа.



Матай 21:19–20—Зүхэгдсэн Инжрийн Мод

Марк 11:12–14, 20–21-ийн х.66 “Судруудыг Ойлгох нь”-ыг үз.

Матай 22

Уригдсан (ш.3–4, 8)—
Урилгатай, уригдсан
Бордсон малаа (ш.4)—
Тахил өргөх мал
Бусад нь (ш.6)—Үлдэгсэд нь
Тэднийг доромжлон гутаагаад алжээ (ш.6)—Тэдэнтэй зүй бус харьцаж, алжээ
Хэлсэн үгэнд нь унагаах (ш.15)—Буруу юм хэлүүлж түүн дээр унагах

Хуульд нийцэх (ш.17)—
Зөв эсэх
Татвар (ш.17, 19)—Алба гувчуур, татвар
Дүрс (ш.20)—Зураг буюу төстэй байдал
Бичээс (ш.20)—Зоосон дээр бичсэн үгс
Өг (ш.21)—Өг
Үр удмыг залгуулах (ш.24)—Хүүхэдтэй болох
Үр удам (ш.25)—Хүүхдүүд

Матай 22:11–14—“Хуримын Хувцас” Өмсөөгүй Хүн

Есүсийн үеийн нэг ёс заншлыг ойлгох нь яагаад хуримын хувцас өмсөөгүй хүнд түүнд нь тохируулан ханддаг байсныг ойлгоход бидэнд тусална. “Хааны өмнө ирэхдээ хүн зохих ёсоор хувцасласан байх ёстойг нийтээр мэддэг байлаа. Зочны гадаад байдал нь эзэнд хүндэтгэл үзүүлсэний илрэл байдаг билээ. Түүнчлэн ийм үйл явдлыг тохиолдуулан өмсөх ёстой хувцас нь цагаан орхимж байх учиртайг нийтээр ойлгодог байв. Өндөрлөг газруудаас уригдсан хүмүүст хуримын зохих хувцас хийх хугацаа ч, бэл бэнчин ч байдаггүй байсан нь харваас илт байсан болохоор хаан зочдоо өөрийн хувцасны сангаас хангадаг нийтээр дагаж мөрддөг заншил байжээ. Тийнхүү бүх хүмүүсийг хааны хувцасны санд өөрсдийгөө хувцасла хэмээн урьдаг байв” хааны өгсөн хувцаснаас илүүтэйгээр өөрийн хувцасандаа итгэл тавьж сонгосон тэр хүн зайлуулагдана. (Joseph F. McConkie, “Triumphal Entry and a Day of Debate,” in *Studies in Scripture: Volume 5, The Gospels*, ed. Kent P. Jackson and Robert L. Millet [1986], 381). Энэ сургаалт зүйрлэл дэх зохисгүй байдлаар хувцасласан хүн нь, Бурханы шаарддаг зөв шударга ёсны орхимжийг өмсөлгүйгээр Бурханы хаант улсад орж болно гэж боддог байсан Иудейчүүдийн удирдагчдад зориулсан бэлэгдэл байв (Илчлэлт 19:7–8).

Матай 22:23–32—Амилуулалт дахь Гэрлэлт

Лук 20:27–38-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг (х.81–82) үз.

Матай 22:36–38—“Анхны Бөгөөд Агуу Зарлиг”



Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон бид амьдралдаа Их Эзэнийг нэгдүгээрт тавихын ач холбогдлын талаар ярьсан байдаг. “Бид Бурханыг нэгдүгээрт тавихад бусад бүх зүйлүүд өөрсдийн зохих байрандаа орох буюу эсвэл бидний амьдралаас гээгддэг. Их Эзэнийг хайрлах бидний хайр нь, биднээс цаг хугацаа, бидний мөрддөг ашиг сонирхол хийгээд бидний эн тэргүүнд баримтлах ёстой зүйлүүдийн дэс дарааллыг шаарддаг” хэмээн тэрээр зөвлөжээ (Conference Report, 1988 оны 4-р сар, 3; *Ensign*, 1988оны 4-р сар, 4).

Судруудыг Судлах нь

Матай 21–22-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг нь хий.

А Харьцуулалт Хий

Матай 21–22 дахь түүхүүд хийгээд сургаалт зүйрлэлүүдийн ихэнх нь Дээгүүр Өнгөрөх Баяраар цугласан бүх хүмүүст Есүсийг муугаар, харин өөрсдийгөө сайнаар харагдуулахыг хичээж байсан Иерусалим дахь Иудейчүүдийн удирдагчдад чиглэсэн байлаа. Есүсийн хариу үйлдэл нь байдлыг эсрэгээр эргүүлжээ. Шинэ Гэрээнээс та нарын мэдсэн зүйлүүд хийгээд дээрх “Судруудыг Ойлгох нь” хэсгээс харахад, Иудейчүүдийн удирдагчид ямар байдалтай байв:

1. Матай 21:17–20 дахь инжирийн мод?
2. Матай 21:28–32 дахь хоёр дахь хүү?
3. Матай 21:33–41 дэх тариаланчдад?
4. Матай 22:1–14 дэх хуримын зочид хийгээд хуримын хувцасгүй хүн?

Б Олон Гэрчүүд Хийгээд Олон Нотолгоо

Матай 21–22 дахь үйл явдлын үеэр та нар өөрсдийгөө Христэд итгэгч байсан гэж төсөөлөн бод. Нэгэн Фарисай найз танд байжээ. Матай 21–22-т өгөгдсөн гэрчлэлүүд хийгээд нотолгоог ашиглан, Есүс бол мөнөөх амлагдсан Мессиа, Христ үнэхээр мөн гэдгийг тэрээр ойлгоход нь түүнд туслахыг хичээн түүнд захидал бич. Захидлынхаа нэг хэсэг болгон, эдгээр бүлгүүдэд гардаг үйл явдлуудаас наад зах нь гурвыг оруулах хэрэгтэй. Үүнд хэрэгтэй зарим хэсгүүд Матай 21:1–11, 12–16, 23–27 болон 22:15–33, 41–46-д байгаа.

В Татвар Төлөлт

Есүсийг муугаар харагдуулах нэг арга бол Иудейчүүд Ромчуудад татвар төлөх ёстой юу гэдгийг Түүнээс асуух явдал мөн гэж Фарисайчууд бодож байжээ. Энэхүү шастир

Матай 22:15–22-т цэдэглэгдсэн байдаг. Хэрэв Есүс татвар төлөх нь зөв гэж хэлбэл, Түүнийг Иудейчүүдийн үзэн яддаг Ромыг дэмжигч гэж үзэн буруутгаж болох байв. Хэрэв Есүс Иудейчүүд Ромд татвар төлөх ёсгүй гэж хэлбэл, Фарисайчууд Есүсийг засгийн газрын эсрэг үймээн дэгдээгч хэмээн Ромын эрх баригчдад мэдэгдэж болох байв.

1. Есүс тэдний асуултад хэрхэн хариулсан бэ?
2. Мөнгө дээрээ Цейзарийн дүрстэй байв. Үүн дээрх юу Бурханы дүрстэй вэ, түүнчлэн бид юуг Бурханд “өргөх” (өгөх) ёстой вэ?



ТИБЕРИЙН ДЕНАР (зоос)

Г Агуу Хоёр Зарлиг

1. Матай 22:35–40-ийн дагуу, Есүсийн өгүүлсэн хоёр агуу зарлиг юу вэ?
2. Сайн мэдээний заадаг таван чухал зүйлийг жагсааж, эдгээрээс тус бүр нь энэ хоёр зарлигийн аль нэгэнд буюу хоёуланд нь хэрхэн хамаарахыг хэлэх буюу эсвэл, хэрэв та нар энэ хоёр “агуу зарлигийг сахьсан” тохиолдолд аяндаа сахигдах өөр таван зарлигийг жагсаан, яагаад гэдгийг тайлбарла.
3. Дараах асуултуудын нэгэнд нь сайтар бодож хариул:
 - Та нар Бурханыг бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа хэрхэн өдөр бүр хайрлаж чадах вэ?
 - Яагаад нэгдэх агуу зарлиг хоёр дахийнхаа өмнө нь байх ёстой гэж та нар боддог вэ? Хэрэв хоёр дахь зарлиг нэгдүгээрт орвол юу буруу болно гэж та нар боддог вэ?
 - Хөршийгөө өөр шигээ хайрлана гэдэг нь юу гэсэн утгатай вэ?

Матай 23

Есүс Хоёр Нүүртнүүдийг Зэмлэв

Нурocrite буюу хоёр нүүртэн гэдэг үг “жүжиг тоглогч” гэдэг утгатай грек үгнээс гаралтай. Хоёр нүүртэн нь, нэр хүнд буюу ашиг олохын тулд ямар нэг юмыг байгаа байдлаас нь өөрөөр харуулахыг хичээдэг хүн юм. Хоёр нүүр гаргах нь бардамналын үр дагавар мөн. Бурханыг даруухнаар дагагчид нэр хүнд олж, үүнийхээ төлөө хүндлүүлэхийн тулд бус, харин Бурхан болоод бусад хүмүүсийг хайрлагдийн улмаас Түүний хуулиудын дагуу амьдрахаар эрэлхийлдэг билээ. Бурханыг даруухнаар дагагч буруу юм хийсэн нь мэдэгдсэн үед тэрээр зөвийг хийхийн тулд тэр даруй ажиллаж эхэлдэг. Хоёр нүүртэн нь нүглүүдээ нуухыг эрэлхийлж, тэдгээрийн төлөө шалтаг заадаг.

Матайн номыг судлах бүхий л үеийнхээ туршид та нар Есүсийн үеийн Иудейн удирдагчдын хоёр нүүр гаргах явдлын тухай, түүнчлэн Есүс Өөрт нь итгэгчиддээ хоёр нүүр гаргалгүйгээр сайн мэдээний дагуу амьдрахыг зааж байсан талаар уншсан байгаа. Матай 23 нь үнэн сайн мэдээ болоод мөнхийн аз жаргалын төлөвлөгөөний тухай Түүний заадаг зүйлүүд болон гэрчлэлүүдээс татгалздаг хүмүүсийн эсрэг Есүсийн сүүлчийн гэрчлэл хийгээд зэмлэлүүдийг агууладаг.

Та нар уншихдаа, хэрэв та Фарисай хүн байгаад үүнийг хүнээс сонссон бол энэ үгийн талаар юу гэж бодох байснаа анхаарч үз. Хэрэв та тэр үед Фарисайчуудыг дагахаа

үргэлжлүүлэх үү, эсвэл Есүсийг дагах уу гэдгийг шийдэхээр хичээж байсан хүн байсан бол, та хэрхэн шийдэх байсан бэ?

Матай 23-г Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 23—Марк 12:38–40; Лук 20:45–47

Судруудыг Ойлгох нь

Матай 23

Сахь (ш.3)—Та нарыг дуулгавартай дагахаар урихад

Хүнд ачаанууд (ш.4)—Биелүүлэхэд хүнд ажлууд

Өөрийгөө өргөмжлөх (ш.12)—Өөрийгөө бусдаас дээгүүрт тавих

Дорд болгогдох (ш.12)—Доогуурт тавигдах

Оруулдаггүй (ш.13)—Оруулахыг зөвшөөрдөггүй, орох боломж олгодоггүй

Бэлэвсэн эмэгтэйчүүдийн гэрийг цөлмөдөг (ш.14)—Бэлэвсэн эмэгтэйчүүдийн гэрийг аваад явчихдаг

Дүр үзүүлдэг (ш.14)—Дүр эсгэх, гадна талаараа харуулах

Хөндлөн гулд явдаг (ш.15)—Аялдаг

Сүсэгтнээ болгох (ш.15)—Хөрвүүлэх, шашиндаа татах

Хоёр дахин (ш.15)—Хоёр дахин илүү

Ариусгадаг (ш.17)—Ариун болгодог

Гаа, гоньд, зираа (ш.23)—Хоол амтлагчид

Чимдэг (ш.29)—Гоёх, чимэх, чимэглэх

Та нар өвөг эцгүүдийнхээ гэмийн хэмжээг дүүргэ (ш.32)—Өвөг дээдсийнхээ эхэлсэн ажлуудыг дуусга

Хоосон (ш.38)—Эзгүй, хоосон, эзэнгүй

Үүнээс хойш (ш.39)—Дахиад, үүнээс хойш

Матай 23:5—“Магнайн ба Гарын Сахиус” Гэж Юу Болох, “Унжлагаа Уртасгах” Гэсэн нь Ямар Утгатай Вэ?



унжлага хийдэг ёс заншлыг хэлж буй ажээ (Тооллого 15:38–40-ийг үз). Бүр онцгой зөв шударга гэж харагдахыг хүсдэг хүмүүс хувцасныхаа унжлага бүхий хэсгийг “өргөгсөдөг” байсан нь тэд нэн содон

Сахиус бол судруудын бичмэл шүлгүүдийг агуулдаг жижигхэн хайрцаг бөгөөд зарим Иудейчүүд үүнийг гар, духандаа зүүдэг байжээ. Энэхүү ёс заншил нь Дэд Хуулийн 6:6–8-д Мосед өгөгдсөн зөвлөгөөн дээр тулгуурлагдсан ажээ. Тэдний хувцасны “зах” гэдэг нь Бурханы хуулиудыг дурсан санахын тулд хувцасны зах буюу хөвөөн дээр

харагддаг байсан буюу тэд нэн тод харагдахуйц сахиусууд зүүдэг байжээ.

Матай 23:24—“Шумуулыг Шүүгээд Тэмээг Залгих”




image © 1998 PhotoDisc, Inc.

Мосегийн хуулийн дагуу, шумуул, тэмээ хоёрыг хоол хүнс болгохыг хоёуланг нь хориглодог байжээ.

Тохиолдлоор шумуул залгихаас сэрэмжлэхийн тулд зарим Фарисайчууд бүх төрлийн шингэнийг уухаасаа өмнө шүүдэг байв. Фарисайчууд ялихгүй жижиг сажиг зүйлүүдийн талаар нэн их анхааралтай байдаг хэрнээ илүү том хийгээд илүү чухал зүйлүүдийг эс хайхардгийг (ач ивээл, итгэл хийгээд хуулийн амин сүнс зэрэг) хэлэхийн тулд Есүс тэмээ залгих тухай хэтрүүлгийг ашиглажээ.

Судруудыг Судлах нь

Матай 23-ыг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Харьцуулалт Хий

Тэмдэглэлийн дэвтрийнхээ хуудсыг дундуур нь хуваа. Матай 23:1–12-т уншсан зүйлээсээ, Фарисайчууд агуу хэмээн бодоход өөрсдийгөө түлхэж байсан зүйлүүдийг хуудасны нэг тал дээр жагсаан бич. Хуудасны нөгөө тал дээр хүнийг юу агуу болгодог талаар Есүсийн хэлснийг жагсаа.

Б Золгүй Явдлын Чулуунуудыг Гишгэх нь

Золгүй явдал гэдэг үг нь эмгэнэл хийгээд зовлон зүдүүрийг заадаг. Хуулийн багш нар, Фарисайчууд хийгээд хоёр нүүртнүүдэд золгүй явдал тохиох болно гэдгийг Матай 23:13–16, 23–32-т Есүс найман удаа хэлсэн байдаг. Тэдэнд яагаад энэхүү золгүй явдал тохиолдохыг Тэрбээр тухай бүр дүрсэлжээ.

1. Дагалдах зураг чимэглэлд байгаагийн адилаар тэмдэглэлийн дэвтэртээ хоёр “зам” гарга. Нэг зам нь уйтгар гуниг хийгээд тамын шийтгэл (ш.33-ыг үз) рүү хөтөлнө, нөгөөх нь аз жаргал хийгээд алдар суу уруу хөтөлнө. Эхлээд, хуулийн багш нар, Фарисайчууд хийгээд хоёр нүүртнүүдийн хийдэг байсан зүйлийн талаар Есүсийн хэлсэн найман зүйлийг өөрсдийн үгээр дүрслэн золгүй

явдлын замыг бөглө. (Нэг дэх нь схем дээр аль хэдийнэ бичигдсэн байгаа.) Дараа нь Христийг дагадаг хүн үүний оронд юу хийх байсныг бичин, “Аз Жаргалд Хүрэх Замыг” бөглө.

2. Хэдийгээр Есүс Фарисайчуудыг шүүмжилдэг байсан ч, Өөрийг нь сонсох олон боломжийг Тэрээр тэдэнд олгосон бөгөөд Түүний сайн мэдээнд итгэхэд нь тэдэнд туслахын тулд олон гэрчүүд өгөгдсөн байлаа. Матай 23:37-г уншиж, Иудейчүүдийн эдгээр удирдагчдад зориулж Тэрбээр юу хийж чадна гэж Есүс найдаж байсныг тайлбарла.

**Аз Жаргал ба
Мөнх Амьдрал**

Шүлэг
29–32

Шүлэг
27–28

Шүлэг
25–26

Шүлэг
23–24

**Аз Жаргалд
Хүрэх Зам**

Шүлэг 16

Шүлэг 15

Шүлэг 14

Матай 23:13—Бид сайн мэдээний дагуу амьдарч, үнэнийг мэдэж, түүний дагуу амьдрахад нь бусдад туслах ёстой.

Матай 23:13—Тэд хуурамч сургаал зааж, тэгснээр өөрсдийгөө болон бусдыг тэнгэрт орохоос саатуулан барьж байв.

Шүлэг 14

Шүлэг 15

**Золгүй Явдлын
Чулууг Гишгэх нь**

Шүлэг 16

Шүлэг
23–24

Шүлэг
25–26

Шүлэг
27–28

Шүлэг
29–32

**Уйтгар Гуниг ба
Тамын Шийтгэл**

Матай 24

Хоёр дахь Ирэлт

Өөрийг нь ад үзэж байсан Иудейн удирдагчдын эсрэг гэрчилсний дараа Есүс, Тэрбээр бошиглогдсоны дагуу сүр жавхлантайгаар ирэх хүртэл тэд Өөрийг нь дахин харахгүй гэж хэлсэн байдаг (Матай 23:39; Иосеф Смит—Матай 1:1: мөн Есүсийн хэсэгчлэн иш татсан Дуулал 118:26-г үз). Есүс болон Түүний шавь нар, дээрээс нь Иерусалим хотыг—ялангуяа ариун сүмийг харж болох Чидун Уул уруу явжээ. Тэнд тэрбээр хотод хийгээд ариун сүмд тохиох агуу устгалуудын тухай ярьжээ. Есүсийн ярьсан зүйлийн улмаас, Түүний шавь нар, ариун сүм хэзээ устгагдахыг, Түүний Хоёр дахь Ирэлтийн тэмдгүүд юу байх, мөн дэлхийн төгсгөл хэзээ тохиохыг (Матай 24:3; Иосеф Смит—Матай 1:4-ийг үз) Түүнээс асууж, эдгээр гурван үйл явдлын хооронд ямар нэг холбоо бий эсэхэд илт гайхширчээ. Матай 24-ийн үлдсэн хэсэг нь тэдний асуултуудад Есүсийн өгсөн хариу, туудыг агуулдаг.



Матай 24-ийн Иосеф Смитийн Орчуулга нь Агуу Үнэт Сувдад байдаг бөгөөд, мөн Иосеф Смит—Матай хэмээн нэрлэгддэг. Бошиглогчийн бурханлигаар нөлөөлөгдсөн нэмэлтүүд хийгээд залруулгууд бидэнд байдаг болохоор, доорх “Судруудыг Ойлгох нь”, “Судруудыг Судлах нь” хэсгүүд нь Матай 24 дээр биш, харин Иосеф Смит—Матай дээр тулгуурласан юм.

Матай 24-т (мөн Иосеф Смит—Матай) Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 24 (Иосеф Смит—Матай 1)—Марк 13; Лук 21:5–36

Судруудыг Ойлгох нь



Иосеф Смит—Матай 1

Эзгүйрэх (ш.2)—

Эзэнгүйрэх, устгагдах

Зовлон зүдгүүрт унагах

(ш.7)—Зовлон учруулах эсвэл өвтгөхөд хүргэх

Хүүхдээ хөхүүлэх тэдэнд

(ш.16)—Хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдэд

Гай зовлон (ш.18, 21, 33,

36)—Хэцүү зовлон, хүнд гамшиг зовлон

Тохиосон (ш.19)—

Тохиолдсон

Махан бодь (ш.20)—Хүмүүн

төрөлтөн, хүмүүс

Сонгогдсон хүмүүсийн

төлөө (ш.20, 23, 29)—

Онцгой боломжууд хийгээд

хариуцлагуудын төлөө Их

Эзэнээр сонгогдсон хүмүү-

сийн ашиг тусын төлөө

Хүүр (ш.27)—Сэг, хүүр (үхсэн амьтан)

Өвчин тахал (ш.29)—Ургац болон хүмүүст аль алинд нь нөлөөлдөг өвчин, гай гамшигууд

Янз бүрийн (ш.29)—Өөр өөр, олон өөр, олон янзын

Үе (ш.34)—Тодорхой хугацаа

Овог аймгууд (ш.36)—Бүлэг хүмүүс

Нөөцлөх (ш.37)—Их үнэ

цэнэтэй зүйл мэт үзэж, хадгалах

Зохих (ш.49)—Зөв, таарах, зохих

Тасар цавчин (ш.54)—

Дундуур нь

Хувийг нь (ш.54)—Ноогдох

хэсгийг



Үгийг нөөцөл тэгснээр чи мэхлэгдэхгүй байх болно.

Матай 24:15—“Бошиглогч Даниелын Хэлсэн Хоосролын Жигшүүртэй Хэрэг”



Есүс Христ Иерусалимын устгалыг бошиглов.

Матай 24:15-д Иерусалим дахь устгал уруу хөтлөх ёс бус явдлыг угтан харсан Хуучин Гэрээний Бошиглогч Даниелын хийсэн бошиглолуудын тухай өгүүлдэг. Зөвхөн хангалттай муухай устгал тохиох төдийгүй, мөн энэ нь туйлын жигшүүртэй, бүр тэр ч байтугай, ад шоо үзэгддэг тэдний гар дахь устгал байх болно гэдгийг тэрбээр хэлснээрээ, уг устгал нь “жигшүүртэй” байдлаар тохиох болно гэдгийг харуулсан бололтой. “Хоосролын энэхүү жигшүүрт хэргийн” наад зах нь л хоёр тусдаа гүйцэлдэлт байдаг. Нэг нь МЭ 70 оны орчимд Ромчууд Иерусалим болон ариун сүмийг устгасан бөгөөд нөгөөх нь Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнө сүүлчийн өдрүүдэд тохиох болно.

Судруудыг Судлах нь



Матай 24-ийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Тэмдгүүд ба Амлалтууд

Иосеф Смит—Матай 1:4 нь Есүсийн шавь нарын Түүнээс асуусан асуултуудыг агуулдаг. Шүлэг 5–20 нь ариун сүмийн устгалын талаарх тэдний эхний асуултад Есүсийн өгсөн хариуг, харин шүлэг 21–55 нь Түүний Хоёр дахь Ирэлт болон ёс бусчуудын устгалын талаарх тэдний бусад асуултуудад түүний өгсөн хариуг агуулдаг.

1. Доорхтой адил хуваарийг тэмдэглэлийн дэвтэртээ хий. Иосеф Смит—Матайд олж мэдсэн мэдээллээр үүнийг бөглө. Бүх зүйлийг жагсаасны дараа, уг зүйлийг олсон шүлгийн дугаарыг бич.

Үйл Явдал	Иерусалим дахь Ариун Сүмийн Устгал (ш.5–20)	Есүс Христийн Хоёр дахь Ирэлт (ш.21–55)
Тэмдгүүд		
Зөв Шударга Хүмүүст Өгсөн Амлалтууд		

Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд зарим хүмүүс тэвдэн сандарч, тэр ч байтугай айдаг. Иосеф Смит—Матайд уншсан зүйл дээрээ тулгуурлан, ийм байдалтай байгаа хүнд найдвар төрүүлэхийн тулд та нар юу хэлэх вэ? Бичсэн зүйлдээ зарим шүлгүүдийг онцгойлон заа.

Матай 25

Та Нар Бэлэн үү?

Матай 25-д Түүний Хоёр дахь Ирэлтийн талаарх Есүсийн өгүүлэмж үргэлжилдэг. Үүндээ Тэрээр гурван сургаалт зүйрлэл өгчээ. Эдгээр сургаалт зүйрлэлүүд нь Түүнийг угтахад бэлэн байхын тулд, түүнчлэн уг уулзалтыг баяртай, алдар суутай туршилага байлгахын тулд бид юу хийх ёстойг ойлгоход бидэнд тусалж чадна.

Судруудыг Ойлгох нь



Матай 25

Ирсэнгүй (ш.5)—Ирээгүй, ирэхгүй

Үүрэглэж, унтаж эхлэв (ш.5)—Улам ядарч, унтаад өгөв

Дэнлүүгээ бэлдэв (ш.7)—Зулын шатсан голыг тайрч, дэнлүүндээ тос нэмж хийгээд бэлэн болгов



Дэнлүү

Эзэмшлээ тэдэнд даатгав (ш.14)—Эд хөрөнгөндөө анхаарал тавьж байхыг тэднээс хүсэв

Матай 25:1–13—Арван Онгон Бүсгүйн Тухай Сургаалт Зүйрлэл дэх Хуримын Зан Сйлүүд

Сүйт хархүү болон түүний найз нар сүйт бүсгүйг түүний гэр хүртэл түүний найз нар, бараа бологсдын хамт дагалдан явдаг ёс заншил Есүсийн үед байжээ. Энэ бол олон хүн оролцдог маш том баяр байв. Энэ нь ихэвчлэн шөнө болдог

Талант (ш.15–28)—Мөнгөний тоо

Чадварынх нь дагуу (ш.15)—Түүний чадах хэмжээгээр

Худалдаа хийгээд (ш.16)—Мөнгийг бизнесийн үйл ажиллагаанд оруулаад

Тэдэнтэй тооцоо бодов (ш.19)—Юу хийснээ илтгэхийг тэднээс хүсэв

Үр суулгаагүй газраас хадаж авдаг (ш.24)—Тариалаагүй газраас ургац хурааж авдаг

Залхуу (ш.26)—Лазан, ажилд дургүй

Цацах (ш.26)—Үр цацах

Мөнгө хүүлэгчид (ш.27)—Банкны ажилтнууд

Хүү (ш.27)—Мөнгөний хүү

Зохисгүй (ш.30)—Хэрэггүй, нэмэргүй, муу

байсан бөгөөд хүмүүс бүжиглэж, дуулах болон шинэ хостой хамт хөгжилдөхөд, чийдэн, дэнлүү хэрэглэдэг байжээ.

Матай 25:1–13—Иосеф Смитийн Орчуулгаас Авах Нэмэлт Тусламж

Шүлэг 12 дахь “Би та нарыг танихгүй” гэсэн өгүүлбэрийг Иосеф Смит “та нар намайг танихгүй” гэж өөрчилжээ (ИСО, Матай 25:11). Шүүлтгийн энэ цаг Мозая 26:25–27-д дүрслэгдсэн байна.

Судруудыг Судлах нь



Матай 25-ыг судлахдаа үйл ажиллагаа В-г, дараа нь бусад гурван үйл ажиллагааг (А, Б, Г) хий.



А Арван Онгон Бүсгүйн Тухай Сургаалт Зүйрлэл

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Харольд Б.Ли, онгон бүсгүйчүүд нь “Христэд итгэгчид хэмээгддэг байсан хүмүүсийг” бэлэгддэг гэж хэлжээ (in Conference Report, 1951 оны 10-р сар, 26).

1. Матай 25:1–13 дахь арван онгон бүсгүйн тухай сургаалт зүйрлэлийг уншсаны дараа, Сургаал ба Гэрээ 45:56–57-г уншиж, уг сургаалт зүйрлэл дэх тос юуг төлөөлж байгааг тайлбарла.

“Бидний амьдралд бэлтгэлтэй байхын тос нь зөв шударга амьдралд дусал дулаар хуримтлагддаг. Ариун ёслолын цуглаануудад оролцох нь олон жилийн туршид дусал дулаар бидний дэнлүүнд нэмдэг. Мацаг, гэр бүлийн залбирал, гэрийн багшлалт, бие махбодийн дур хүслээ хянах, сайн мэдээг номлох, судруудыг судлах—өөрсдийгөө зориулах хийгээд дуулгавартай байдлын үйлдэл бүр нь бидний агуулахад нэмэгдсэн дусал мөн” гэж хэлсэн байдаг (*Faith Precedes the Miracle* [1972], 256).

2. Тосны бэлэгдлийн утга хийгээд бид үүнийг хэрхэн олж авдгийг та нар одоо мэдсэн болохоор, тостой байсан тэр тав яагаад үүнийгээ тосгүй байсан хүмүүстэй хуваалцаж чадаагүйг тайлбарла.

Б Талантын Тухай Сургаалт Зүйрлэл

Есүсийн үед талант нь мөнгөний тоо байсан боловч, энэ нь бидэнд Их Эзэний өгсөн бүх зүйлийг төлөөлж чадна.

Матай 25:14–30-ыг уншихдаа, талантын тухай сургаалт зүйрлэлд гурван хүн тус бүрийн хүлээж авсан шагналуудыг жагсааж, яагаад хүн бүр тэр шагналыг авсныг тайлбарла.

2. Гурав дахь хүн талантаараа нөгөө хоёрынхоо хийснийг яагаад хийгээгүйг тайлбарлахын тулд ямар ганцхан үгийг та нар ашиглах вэ? Topical Guide (Сэдэвчилсэн Удирдамж)-ыг ашиглаж, үүнтэй адил асуудал байгаагийн улмаас өнөө үед адислалуудаа алдаж болох хүмүүсийг урамшуулан дэмжих нэг судар ол. Уг судрыг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, яагаад энэ нь тусалж чадна гэж бодож байгаагаа тайлбарла.

В Төгс Эзэмших Судар—Матай 25:40

1. Хонь ба ямаануудын тухай сургаалт зүйрлэл Матай 25:31–46-д цэдэглэгдсэн байдаг. Үүний хамгийн чухал санааг шүлэг 40-д гаргасан бололтой. Үлдсэн шүлгүүдээс мэдэж авсан зүйлээ, түүнчлэн сайн мэдээний тухай өмнө нь мэддэг байсан зүйлээ ашиглан шүлэг 40 дэх дараах зүйлүүд юуг зааж байгааг тайлбарла. Хариултаа аль болохоор бүрэн гүйцэд гарга.
 - “Хаан”
 - “Тэдэнд” (хааны гэдэнд хандан ярьж байгаа хүмүүс)
 - “Энэ нь” (“та нарын хийсэн зүйл” гэсэн утгатай)
 - “Эдгээр ах дүүсийн маань нэгэнд нь”
2. Түүний баруун гар тал дахь шагналуудыг хүлээн авах боломжийг тэдэнд олгосон ямар зүйлийг хонинууд хийлээ гэж Есүсийн хэлсэн зургаан зүйлийг жагсаа. Бие махбодийн хэрэгцээнд нь бусдад туслах эдгээр зургаан арга зам тус бүрт, эдгээрээс тус бүр нь сүнсний хэрэгцээг хэрхэн төлөөлж болох тухай, түүнчлэн сүнсний энэхүү хэрэгцээнд туслахад та нар юу хийж болох тухай саналаа хэл.

Г Сүнийг Хамтад нь Тавь

Матай 25 дахь гурван сургаалт зүйрлэлд уншсан зүйл дээрээ тулгуурлан, хэрэв та Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх талаар Ариун Ёслолын цуглаан дээр үг хэлэх үүрэг хүлээсэн бол, таны ярих гурван гол санаа юу байх вэ? Санаа тус бүрийн талаар Матай 25-аас судрын ишлэл тат.

Матай 26

“Миний Цаг Ойрхон Байна”

Матай 26, Есүсийн мөнх бус байдал дахь тохинуулал бараг дуусч байх үеэс эхэлдэг. Есүс гурван жилийн турш Өөрийн сайн мэдээг заан, Өөрийн үүрэг зорилгыг үг хийгээд үйл хэргийн аль алинаар нь гэрчилж, мөн

газар дээр Өөрийн Сүмийг байгуулан Иудейчүүдийн дунд аялсан билээ. Гэвч Матай 26–28-д цэдэглэгдсэнчлэн, хэрэв Тэрээр хийхээр Өөрийгөө бэлтгэсэн тэр зүйлийг дуусгаагүй бол, тэр үеийг хүртэл Түүний хийсэн бүхэн талаар болох байлаа.

Их Эзэн тэдний амь, амьдралыг аварч, тэднийг Египет дахь боолчлолоос чөлөөлснийг Израилчууд тусгай ёслол болон Дээгүүр Өнгөрсний Баярын зоог буюу эсгээгүй талхны найр хийж, мянга гаруй жилийн туршид дурсан тэмдэглэсээр ирсэн байлаа (Египетээс Гарсан нь 12–13-ыг үз). Дээгүүр Өнгөрсний Баярын зоогийн гол бүрдүүлбэр хэсэг нь, бага насны, өө сэвгүй, эр хурга байдаг байв. Зарлиглагдсаны дагуу, Анхны Дээгүүр Өнгөрөх Баяраар гэрийнхээ хаалганы хатавчинд хурганы цус түрхсэн хүмүүс, Египетийн бүх нутагт ууган төрөгсдийг алсан устгагч тэнгэр элчээс аврагдсан ажээ.



Энэхүү хурга нь Есүс Христийг хийгээд нүгэл болон үхлийн боолчлолоос биднийг аварсан Түүний үйлсийг бэлэгддэг байв. Үүнийг мэдсэний дараа, энэ нь Матай 26-д дүрслэгдсэн Есүс болон Түүний шавь нар Дээгүүр Өнгөрсний Баярын зоогийг хуваалцаж байсантай хэрхэн адил болохыг авч үз. Үүний дараа удалгүй, Есүс Өөрөө Дээгүүр Өнгөрсний Баяр болгоны бэлэгдэл байсан тэр Хурга болох байв. Их Эзэний цагаатгагч золиослол уруу урагш харах биш, харин арагш харсан өөр ёс жаяг хийгээд ёслолоор Дээгүүр Өнгөрсний Баярыг солихын тулд Есүс юу хийснийг ажигла. Бурханы Хурганы Цовдлолт уруу хөтөлсөн үйл явдлуудын талаарх Матайн гэрчлэлийг та нар анхааралтай унших юм бол Аврагчийн тухай өөр олон зүйлийг ажиглаж, мэдрэх болно.

Матай 26-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 26:1–5—Марк 14:1–2; Лук 22:1–2
Матай 26:6–13—Марк 14:3–9; Иохан 12:1–82
Матай 26:14–30—Марк 14:10–26; Лук 22:3–23
Матай 26:31–35—Марк 14:27–31; Лук 22:31–34
Матай 26:36–46—Марк 14:32–42; Лук 22:39–46
Матай 26:47–75—Марк 14:43–72; Лук 22:47–71; Иохан 18:1–27

Судруудыг Ойлгох нь



Матай 26

Зальжин аргаар (ш.4)—
Шударга биш, нууцлаг
аргаар

Гөлтгөнө (ш.7)—Гэрэлтсэн
өнгөтэй, гоёмсог үнэт чулуу

Үнэтэй тос (ш.7)—Их үнэ-
тэй, анхилуун үнэртэй тос

Уурлаж (ш.8)—Дургүйцэж,
жигшиж (шүүмжлэх өнгө
аястай уур)

Сайныг үйлдэв (ш.10)—
Сайн юм хийлээ

Гэрээний (ш.28)—Гэрээний
дагуух

Тэнд (ш.36)—Өөр газарт

Шийдэмтэй (ш.47, 55)—
Илд шийдэм (цохиур)
барьсан

Хөнөөгдөх (ш.52)—Алагдах

Одоохон (ш.53)—Бэлэн
(илгээх буюу явуулахад)

Легион (ш.53)—Их олон
хүнтэй бүлэг (Ромын легион
зургаан мянга орчим хүнтэй
байв)

Намайг бариагүй (ш.55)—
Намайг баривчлаагүй

Орхин зугтав (ш.56)—Хаяад
явав

Хүү татан (ш.65)—Урж
(ихэд баяр хөөргүй байсны
тэмдэг)

Доромжлов (ш.65)—Ариун
зүйлүүдээр тохуурхах

Нударгалан (ш.67)—Хүчлэн
цохьж

Цохих (ш.67–68)—Дэлсэх,
цохих, алгадах

Гадаа (ш.69)—Гадна талд

Гашуунаар (ш.75)—

Гашуудалтайгаар

Матай 26:23—“Миний Хамт Тавганд Гараа Дүрэгч нь”
Иохан 13:25-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг үз (х.100).

Матай 26:36—46—Гетсемани гэж Юу вэ?
Гетсемани



Матай 26:36—46—Гетсеман гэж Юу вэ?

Гетсеман бол Чидун уулын бэл дэх чидуны модтой цэцэр-
лэг (Лук 22:39-ийг үз). Энэ нэр нь үгчилбэл “тос шахах”
буюу гашуун байдаг түүхий чидунээс тос шахан гаргаж
авдаг газар гэсэн утгатай юм. Есүс “сүв бүрээс нь цус
шүүрч”, (С ба Г 19:18) Түүнийг тарчлан зовоход хүргэсэн
энэ газрыг хүн төрөлхтний нүглүүдийг Өөр дээрээ үүрэх
газар болгон сонгож авсан баримт нь агуу бэлэгдэл бөгөөд,

тийнхүү энэ нь нүглийн уучлалыг, тэрчлэн бүр мөнх амьд-
ралыг боломжтой болгосон юм.

Матай 26:59–60—Худал Гэрчлэлүүд

Цаазаар авах хүний өмнө хоёр буюу гурван гэрч байхыг
хууль шаарддаг байжээ (Дэд Хууль 17:6-г үз). Гэвч ахлах
тахилчдын хамтран цуглуулсан хуурамч гэрчүүдийн худал
гэрчлэлүүд хоорондоо таарахгүй байв (Марк 14:55–59-ийг
үз). Есүсийг цовдлохыг хүсч байсан Иудейчүүд гэрчүүдийн
тухай өөрсдийн хуулийг дагахыг маш их хичээсэн боловч,
худал гэрчлэл мэдүүлж болохгүй гэсэн хуулийнхаа талаар
санаа зовоогүй нь илт харагддаг нь егөөдөлтэй юм
(Египетээс Гарсан нь 20:16-г үз).

Матай 26:69–75—Петр Есүсийг Сгүйсгэв

Лук 22:31–34, 54–62-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг үз (х.83).

Судруудыг Судлах нь



Матай 26-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В)
хоёрыг нь хий.

А Сүүлчийн Оройн Зоог ба Ариун Ёслол

Энэ бүлгийн оршилд дурдсанчлан, Есүс болон Түүний
шавь нар, бас энэ нь Тэрбээр Мосегийн хуулийг өгөх үед
мөнх бус байдлын өмнөх Христийн тэднийг оролцохыг зар-
лигласан ёс жаяг буюу ёслол байсан Дээгүүр Өнгөрсний
Баярын зоогт хамт оролцож байсан билээ. Энэ зоогийн
дунд үед мөнх бус байдал дахь Христ бидний эдүгээ ариун
ёслол хэмээн нэрлэдэг дурсамж хийгээд шүтлэг бишрээ-
лийн шинэ ёслолыг танилцуулжээ (ш.26–29-ийг үз).

1. Матайн 26:28-ын Иосеф Смитийн Орчуулга дахь нэмэл-
түүд хийгээд залруулгуудыг анхааралтай үз (ИСО, Матай
26:24–25-ыг үз). Иосеф Смитийн орчуулгаас ямар чухал
үнэнүүдийг бид олж мэддэг вэ?
2. Өөрсдийн хэсэг буюу салбарт Хүүхдийн Хэсэгт зориулж
ариун ёслолын тухай танилцуулга хийж өгөхийг танаас
хүсчээ гэж бод. Матай 26:26–29-д Есүсийн танилцуулсан
ариун ёслолыг тайлбарлахад өөрсдөд тань туслах
бүдүүвч буюу зургуудыг зур.

Б Хөгжмийн Ач Холбогдол

1. Матай 26:30-д өгүүлсний дагуу, тэднийг Есүс Гетсеманийн
Цэцэрлэг рүү дагуулж явахын өмнө Есүс болон түүний
шавь нар юу хийсэн бэ?
2. Үүнийг хийсний үнэ цэнэ юу байж болох вэ?
3. Өөрсдийн тань бодол санаанд тусалдаг, мөн Есүс болон
Түүний шавь нарын бодол санаанд туслах байсан гэж
өөрсдийн боддог нэг дууллыг нэрлэ. Энэ дууллын юу
нь өөрсдөд тань чухал байдгийг тайлбарла.

В “Миний Хүслээр” Биш “Таны Хүслээр”



1. Матай 26:36–46-д, Гетсеманийн цэцэрлэгт гурван өөр үед Есүсийн залбирсан зүйлийн хэсэг болгон Матай дор хаяж цэдэглэсэн ажээ. Эдгээр залбирал тус бүрийн адил хийгээд ялгаатай тал нь юу вэ?
2. Есүсийг залбирч байхад шавь нар нь юу хийж байсан бэ? Матай 26:41-д тэдэнд Түүний хэлсэн зүйл, юу хийх нь Түүнд хэрэгтэй байсан талаар Тэрээр бодож, залбирч,

Тэрээр бас Өөртэйгөө тэмцэлдэж байсны бэлэгдэл хэрхэн болох вэ?

3. Мозая 15:7; 3 Нифай 11:11; мөн Сургаал ба Гэрээ 19:19-ийг унш. Гетсеманид түүний амссан зовлонгийн “гашуун аяганаас уухад” Есүсийг юу түлхэнийг дүрсэлсэн шүлгүүдээс холбоо үгсийг тэмдэглэлийн дэвтэртээ бич.
4. Гетсемани дахь Есүсийн үлгэр жишээнээс бид амьдралдаа хэрэгжүүлж болно гэж өөрсдийнхөө боддог нэг сургамжийн тухай товч бич. Үүнийг хийхдээ, өөрсдийн тань насны хүн Есүсийн үлгэр жишээг хэрэгжүүлэх хэрэгтэй тийм нэг нөхцөл байдлын тухай ярь.

Матай 27

Есүс Христийн Цовдлолт

Өөрийгөө Бурханы Хүү гэж Түүнийг хэлсний төлөө Иудейчүүдийн удирдагчид Бурханыг доромжиллоо хэмээн Есүсийг буруутгасныг Матай 26-д цэдэглэжээ. Мосегийн хуулиар бол, Бурханыг доромжилсоны төлөөх шийтгэл нь үхэл байлаа. Гэвч Иудейчүүд Ромын захиргаан дор амьдарч байсан бөгөөд хэнийг ч цаазаар авахыг Ромын зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэж чадахгүй байв. Түүнээс гадна, Бурханыг доромжлох нь Ромын хуулиар бол цаазаар авах ял биш байв. Иудейчүүд Есүсийг Пилатын өмнө авчирсан үед тэд буруутгалаа хэрхэн өөрчилснийг Матай 27-д цэдэглэжээ. Тэд Есүсийг

Иудейчүүдийн хаан болохоор санаархсан хэмээн буруутгасан нь цаазаар авахуулах, Ромын засгийн газрын эсрэг онц аюултай ноцтой хэрэг байлаа.



Есүсийн Амилуулалт Тэр бол Христ байсан гэдгийн агуу их ач холбогдол бүхий гэрчлэл байсан бөгөөд тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Гордон Б.Хинкли “бүх хүмүүс амьдрахын тулд амь насаа өргөж бидний Гэтэлгэгчийн төлсөн тэрхүү аймшигт төлөөс—Гетсеманид зовж тарчилсан, түү-

нийг гашуунаар шүүсэн тохуурхал, түүний махыг урж тасчиж буй жигшүүрт өргөст титэм, Пилатын өмнө цугласан олны цусанд улайрсан хашигираан, Калварийн замаарх түүний ганцаардлын хүнд алхаа, түүний гар, хөлийг цоо хатгасан том хадааснуудаас үүдсэн аймшигт өвдөлт, тэрхүү эмгэнэлт өдөр биеэрээ амссан түүний аймшигт гэсгээлтийг энэ Сүмийн ямар ч гишүүн үүрд мартаж ёсгүй” . . .

“ . . . Бид үүнийг хэзээ ч мартаж ёсгүй, учир нь энд бидний Аврагч, бидний Гэтэлгэгч, Бурханы Хүү, бидний хүн бүгдийн төлөө бидний өмнөөс Өөрийгөө золиослолд өргөсөн юм” гэж бидэнд сануулжээ (in Conference Report, 1975 оны 4-р сар, х, 137; Ensign, 1975 оны 5-р сар, 93).

Матай 27-г уншихдаа, та нар өөрсдийн тогтоохыг үргэлж хүсдэг хэсгүүдийг өнгө ялган тэмдэглэж болно.

Матай 27-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 27:1—Лук 23:1; Иохан 18:28

Матай 27:11–14—Лук 23:2–5; Иохан 18:29–38

Матай 27:15–26—Марк 15:6–15; Лук 23:13–15; Иохан 18:39–40

Матай 27:27–31—Марк 15:16–20; Иохан 19:1–16

Матай 27:32–61—Марк 15:21–47; Лук 23:26–56; Иохан 19:17–42

Судруудыг Ойлгох нь



Матай 27

Зөвлөлдөв (ш.1, 7)—

Шийдвэр гаргахаар цуглав

Ваарчны талбай (ш.7, 10)—

Шавраар ваар сав хийдэг газар

Иеремиа (ш.9)—Иеремиа

Нэг ч үг (ш.14)—Ганц ч үг

Явч нэмэргүй (ш.14)—

Хүмүүсийн сонголтыг юу ч өөрчилж чадахгүй

Ташуурдав (ш.26)—
Ташуураар зодов; тэр үед
ташуур нь махан биеийг
урж тасчихын тулд үзүүртээ
ихэвчлэн яс, шил буюу
төмөртэй байжээ

Хувцас (ш.31)—Хувцас

Албадаж (ш.32)—Хүч тул-
ган, хүчээр

Цөстэй хольсон дарс . . .
(ш.34)—Өвчнийг намдаан
мэдээгүй болгодог холимог
шингэн

Хувцсыг (ш.35)—Өмссөн
хувцсыг нь

Хоорондоо шодох (ш.35)—
Ялагчийг тогтоох тоглоо-
мын арга

Доромжилж (ш.39)—
Тохуурхсан үг хэлж,
доромжлох

Сэгсрэн (ш.39)—Толгой
сэгсрэх

Есүст үйлчилж (ш.55)—
Түүний хэрэгцээг анхаарч

Хаданд ухаж хийсэн
(ш.60)—Хаданд нүх гарган
ухаж хийсэн



“Булиш”

Булиш (ш. 60, 64, 66)—Бунхан,
нас барсан хүнийг оршуу-
лах агуй

Харуул (ш.66)—Харуул, хам-
гаалалт

Матай 27:11—Есүс Пилатад Юу гэж Хэлсэн Бэ?

“Та Иудейчүүдийн Хаан мөн юм уу?” Пилат Есүсээс асуухад, Есүс “Та ч хэлж байна” гэж Есүс хариулжээ. “Үүнийг та ч бас хэлж байна” гэвэл энэ өгүүлбэрийн илүү сайн орчуулга болно. Өөрөөр хэлбэл, Тэр үнэхээр хаан байсан гэж Есүс хэлжээ. Есүс, Пилат хоёрын хооронд болсон энэ ярианы талаар дэлгэрэнгүй мэдээллийг Иохан 18:33–38-аас үз.

Судруудыг Судлах нь

Матай 27-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг нь хий.

А Сонголт, Нүгэл ба Гэмшил

Есүс үхэх нь зайлшгүй шаардлагатай байсан хэдий ч, энэ нь Иудас Аврагчаас *урвахаас аргагүй* байсан гэсэн хэрэг биш юм. Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан Ерөнхийлөгч Жорж К.Каннон хэлэхдээ, “Иудас чөтгөр болох учиртай нь урьдчилан томилогдоогүй юм. Тэрээр энэхүү хувь тавиланг сонгох эрх чөлөөгөө эдлэн өөртөө сонгосон юм” гэжээ (in Brian H. Stuy, *Collected Discourses*, 5 боть зохиолын эмхэтгэл. [1987–92], 1:236).

1. Матай 26:14–16, 20–25, 45–56-г үзэж, Аврагчаас урвахгүй байх боломж Иудааст байсан хэдий ч, түүнийг уруу татсан чөтгөрт үйлчлэхээ үргэлжлүүлэхийг сонгосон гэж бодож байх үеүдээ дүрсэл.
2. Алма 30:60-ыг уншиж, энэ нь Матай 27:3–5-тай хэрхэн холбогдохыг хэл.
3. Иудааст тохиолдсон явдлын ойлголтоос ямар ашиг тусыг бид олж болох вэ?

Б Назарын Есүс Цаазаар Авахуулахаар Яллагдав

Та мэдээний сурвалжлагч байгаад Матай 27:11–66 дахь үйл явдлуудыг дагах боломж танд олджээ гэж бод. Эдгээр үйл

явдлуудын тухай мэдээний сурвалжлага бич. Дараах үйл явдлуудын талаар уншигчид тань мэдэхийг хүссэн нарийн ширийн зүйлүүдийг оруулахад анхаар:

- Есүс Пилат хоёр бие биендээ юу гэж хэлсэн бэ?
- Есүсийн тухай Пилат юу гэж бодсон бэ?
- Бараб гэж хэн байсан бэ, Есүсийн шүүлтгийн хувьд тэр юу хийх ёстой байв?
- Цовдлолтын өмнө болон цовдлолтын үеэр юу болсон бэ?
- Есүсийг үхсэний дараа юу болсон бэ?

В Бошиглолын Биелэлт

Матай дахь сэдвүүдийн нэг нь Хуучин Гэрээний бошиглолыг Есүс гүйцэлдүүлсэн явдал байв. Дараах судрууд бүрийг гүйцэлдүүлсэн, Матай 27-гийн шүлгүүдийг тогтоож, тайлбарла.

1. Дуулал 22:1
2. Дуулал 22:6–8
3. Дуулал 22:18
4. Дуулал 69:21
5. Дуулал 109:25
6. Исаиа 50:6
7. Исаиа 53:4–9
8. Амос 8:9

Г Яагаад Есүс Сүнийг Хийсэн Бэ?

Матай 26–27-д Есүсийн туулсан бүхнийг хэн нэгэн хүн туулж өнгөрүүлснийг төсөөлөхөд хэцүү юм.

1. Нифай 19:9-ийг унш. Есүс яагаад Өөрийн хийснийг тэвчин өнгөрүүлэх чадвартай байсан талаар Нифайн хэлснийг тайлбарла.
2. Есүс эдгээр бүх зүйлүүдийг таны төлөө биеэрээ амсч, тэвчин өнгөрүүлснийг мэдэхэд танд ямар санагдсан тухайгаа бич. Эсвэл Аврагчийн тухай таны бодол санаа хийгээд Матай 26–27-д Түүний туулж өнгөрүүлсэн зүйлийн талаар таны бодол санааг илэрхийлдэг дууллиудаас наад тал нь долоон өгүүлбэр бич.

Матай 28

Тэр Босч Ирэв!


“Түүхийн хамгийн агуу их үйл явдлууд нь хамгийн урт удаан хугацаанд хамгийн олон хүмүүст нөлөөлсөн үйл явдлууд байдаг. Энэ жишгээр бол, хувь хүмүүс хийгээд улс үндэстнүүдийн хувьд Эзэний Амилуулалтаас илүү чухал үйл явдал байж чадахгүй. Газар дээр амьдарч байсан тэгээд нас нөхцсөн бодгаль бүрийн амилуулалт нь судрын тодорхой үнэн мөн”



гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (The Teachings of Ezra Taft Benson [1988], 15; мөн түүнчлэн 1 Corinthians 15:22–23-ыг үз).

Христийн зовлон хийгээд Христийн үхэл-гүйгээр бид аврагдаж чадахгүй байсан нь үнэн юм бол, Амилуулалт гүйцэлдэх хүртэл

Цагаатгал бүрэн төгс байж чадахгүй байсан билээ. Цаашилбал, Амилуулалтын бодит байдал нь Есүс бол Христ, бидний Аврагч хийгээд Гэтэлгэгч мөн гэдгийн нотолгоо юм. Энэ нь үнэн учраас, Матай 28-ын захиас хэр зэрэг ач холбогдолтой вэ?



Матай 28-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Матай 28:1–8—Марк 16:1–8; Лук 24:1–12; Иохан 20:1–10
Матай 28:16–20—Марк 16:14–18

Дүр (ш.3)—Гадаад байдал, ялангуяа нүүрэн дээрх илэрхийлэл, төрх
Амар байна уу (ш.9)—Мэндчилгээ


Ятгах (ш.14)—Ухуулах, итгүүлэхээр оролдох
Сахин биелүүлэх (ш.20)—Биелүүлэх, хийх

Матай 28:17—“Харин Зарим нь Эргэлзэж Байлаа”
Эргэлзэж байсан хүмүүсийн жишээг Иохан 20:19–29-өөс үз.

Судруудыг Судлах нь

Матай 28-ыг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Гэрчүүд



1. Матай 28 дахь Есүсийн Амилуулалтын бүх гэрчүүдийг жагсаа. Гэрч бүрийн тухайд, тэдний түүхийг өгүүлдэг шүлэг буюу шүлгүүдийг бичиж, Амилуулалтын бодит үнэнийг тэд хэрхэн мэдсэнийг хэл.
2. Матай 28:7-д тэнгэр элчүүд эмэгтэйчүүдээс хийхийг хүссэн зүйл нь шүлэг 10-т Есүс шавь нараасаа хийхийг хүссэн зүйлтэй юугаараа адил байна вэ, мөн шүлэг 18–20-д Тэрээр тэдэнд юу гэж хэлсэн бэ?
3. Есүс амилсаныг та нар яаж мэддэг вэ? (С ба Г 46:13–14; 76:22–23-ыг үз). Мэдлэгээрээ юу хийхийг Их Эзэн та нараас хүсэн хүлээдэг гэж та нар боддог вэ?

Судруудыг Ойлгох нь

Матай 28

Амралтын өдөр (ш.1)— (Хүндэтгэлийн өдрийг Бямба гараг, Иудейн хүндэтгэлийн өдөр, долоо хоногийн долоо дахь өдөр) Амилуулалтын дурсгалд зориулж Ням гараг болгон өөрчилжээ)

Марк Гэж Хэн Байсан Бэ?

Маркийн бүтэн нэр нь Иохан Марк байсныг бид Үйлс 12:12-оос мэддэг. Хэдийгээр Марк Төлөөлөгч байгаагүй ч, тэрбээр Паулын хамтран номлогчоор үйлчилж байв (Үйлс 12:25-ыг үз) Тэрээр бас Төлөөлөгч Петртэй Ромд үйлчилж байсан бололтой (1 Петр 5:13-ыг үз). Марк өөрийн сайн мэдээнд бичсэн мэдээллийг их төлөв Петрээс мэдэж авсан байдаг. (Bible Dictionary, "Mark," х. 728-ыг үз).

Марк Хэнд Хандаж Бичсэн Бэ?

Матайтай адилгүйгээр, Марк нь Хуучин Гэрээний санаанууд хийгээд судруудыг нэн багаар иш татсан байдаг. Тэрчлэн тэрбээр иудей хэл болон ёс заншлуудыг тайлбарлахад илүү болгоомжтой хандсан байдаг (Марк 5:41; 7:2-4, 34-ийг үз). Эдгээр шалтгааны улмаас, тэрхүү Маркийн номлолын аяллууд олон Харийнхан буюу иудей биш хүмүүстэй хэлхээ холбоотой байхад хүргэсэн учраас түүний сайн мэдээ ихэнхдээ Харийнханд зориулагдсан бололтой.

Түргэн Өрнөлтэй Сайн Мэдээ

"Гэгээнтэн Маркийн Гэрчлэл" нь Есүсийн эцэг эх хийгээд түүний төрөлтийн талаар юу ч хэлэлгүйгээр Түүнийг ойролцоогоор гучин настай байхад болсон Есүсийн баптисмаас эхэлжээ. Түүнчлэн тэрхүү эхний бүлэгт бас Иохан Баптистын тохинууллын тухай, Есүсийг Сатан сорьсон хийгээд зарим Төлөөлөгчдийг дуудсан, гурван онцгой гайхамшиг, түүнчлэн бусад, агуу гайхамшгуудын тухай бид уншдаг.

Энэхүү түргэн өрнөл нь дөрвөн Сайн Мэдээнээс хамгийн богинохон нь болох үүнд тэр чигээрээ үргэлжилсэн байдаг. Тэр даруй, нэн даруй гэсэн үгс Маркийн 16 бүлэгт дөчин удаа давтагдаж, өрнөл хийгээд үйл явдал дээр нэмэгдсэн байдаг. Маркийн Сайн Мэдээ нь Есүсийг үйл ажиллагаа болон хүч бүхий хүн гэдгийг харуулж, бусад аль ч Сайн Мэдээнээс илүүгээр гайхамшгуудын шастирыг агуулсан байдаг. Гэвч энэ Сайн Мэдээ Есүсийн бурханлиг хийгээд хүч бүхий талаас нь үзүүлэхээс гадна Есүсийн хүмүүнлэг талыг харуулдаг. Есүс ганцаар байж, амрах цаг өөртөө гаргадаг байсныг Марк Сайн Мэдээний бусад зохиогчдоос илүү олон удаа дурджээ (Марк 4:38; 6:31; 8:13).

Зөвхөн Маркд

Маркийн шүлгүүдийн ерэн хувь орчим нь бусад сайн мэдээний аль нэгэнд нь буюу нэгээс илүүд нь гардаг. Гэсэн хэдий ч, зөвхөн Маркд гардаг цөөн хэдэн зүйл бий. Эдгээрийг дор харуулбал:

- Үр суулгалт ба хадалтын тухай сургаалт зүйрлэл (Марк 4:26–29-ийг үз)
- Есүсийг мужаан болохыг нь иш татсан ишлэл (Марк 6:3-ыг үз)
- Нэг хүнийг хоёр үе шаттайгаар эдгээсэн нь (Марк 8:22–26-г үз)
- Есүсийг баривчлагдах үед цэргүүдээс зугтсан нэг залуу шавь (Марк 14:50–52-ыг үз; тэр залуу хүн нь Марк өөрөө байсан бололтой)

Аврагчийн тухай Маркийн гэрчлэлийг унших үед Түүний тухай өөрсөддөө төрсөн шинэ сэтгэгдлүүдийг тэмдэглэх зайг тэмдэглэлийн дэвтэртээ гаргаж болно.



Марк 1

Есүсийн Тохинуулал Эхэлсэн нь

Есүсийн хэлсэн үгнээс Матай олныг нь цэдэглэсэн байхад, Марк Аврагчийн амьдралын үйл явдлуудад их анхаарал тавьжээ. Тэр нэн бага түүхийн тулгуурын талаар үзүүлсэн нь Марк Есүсийн тохинууллын тухай бичихийг ихэд хүссэн юм шиг санагдаж байна, тийнхүү нэгдүгээр бүлэгт тэрээр хүмүүсийн дунд хийж байсан Есүсийн ажлаас эхэлжээ. Бүлэг 2-т хурдан шилжихээсээ өмнө бүлэг 1 дэх түүхүүдээс бид Есүсийн талаар мэдэж авсан зүйлээ тунгаан бодоход цаг гарга.



Марк 1-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 1:1–11—Матай 3; Лук 3:1–22; Иохан 1:19–34
Марк 1:12–15—Матай 4:1–17; Лук 4:1–15
Марк 1:16–20—Матай 4:18–22; Лук 5:1–11
Марк 1:21–28—Лук 4:31–37
Марк 1:29–34—Матай 8:14–17; Лук 4:38–41
Марк 1:35–39—Матай 4:23–25; Лук 4:42–44
Марк 1:40–45—Матай 8: 1–4; Лук 5:12–16

Судруудыг Ойлгох нь



Марк 1

Нүглийн уучлал (ш.4)—
Нүглийг өршөөн хэлтрүүлэх, өршөөх

Бүс . . . бүслэх (ш.6)—
Бүсэлхийгээрээ бүсэлдэг суран бүс

Тэр даруй (ш.10, 18, 20–21)—Нэн даруй, үтэр түргэн

Синагог (ш.21, 23, 29, 39)—
Иудейчүүдийн шүтлэгийн газар

Гайхаж байлаа (ш.22)—
Гайхан биширч байв

Буруушааж (ш.25)—Хүнээр ямар нэг юм хийхийг болиулахыг шаардах, залруулах

Дуугүй бай (ш.25)—
Чимээгүй бай

Татвалзуулаад (ш.26)—
Чичрүүлээд

Төрөл бүрийн (ш.34)—Янз бүрийн

Зэлүүд газар (ш.35)—
Ганцаар байх газар (цөл)

Учир нь би үүний төлөө ирсэн билээ (ш.38)—Энэ бол миний ирсэн шалтгаан

Уяман өвчтэй хүн (ш.40)—
Арьсны өвчтэй хүн (Bible Dictionary, "leprosy," х. 724-ийг үз)

Гуйсанд (ш.40)—Хүссэнд

Зүг бүрээс (ш.45)—Олон газраас

Марк 1:1—"Есүс Христийн Сайн Мэдээний Эхлэл"

Есүс Христ Өөрийн мөнх бус байдал дахь тохинууллын үед Өөрийн Сүмийг эхлүүлсэн нь үнэн байдаг ч сайн мэдээний төлөвлөгөөг дэлхий дээрх хүмүүст мэдүүлсэн анхны цаг үе байгаагүй юм. Сайн мэдээ нь чухамдаа энэ дэлхий дээрх анхны гэр бүл Адам, Ева хоёрын үеэс, бүр тэр ч байтугай дэлхийн эхлэлээс өмнө номлогдож байжээ.

Марк 1:2–11—Иохан Баптист

Иоханы тухай дэлгэрэнгүй мэдээллийг Матай 3-ын оршлоос үз (х.14–15).

Марк 1:44—Яагаад Есүс Өөрийн Хийсэн Зүйлийн Талаар Бусдад Битгий Хэлээрэй гэж Өөрийн Эдгээсэн Хүмүүсээс Хүссэн Бэ?

Матай 16:20-ийн "Судруудыг Ойлгох нь"-ыг үз (х.29).

уншдаг. Марк 1:38-д, хүмүүсийн дундах Өөрийнх нь тохинууллын гол зорилго бол сайн мэдээг номлох явдал байлаа гэж Есүс хэлжээ. Энэхүү хам сэдэвт, Түүний үйлдсэн гайхамшиг тус бүрээс юу мэдэж авдаг тухайгаа бод. Жишээ нь, Марк 1:40–44-т дүрсэлсэн гайхамшигийг судлахдаа дараах асуултуудад хариул:

1. Есүс Христэд хэрхэн ирэх хийгээд Түүнээс адислалуудыг хүлээн авах талаар уяман өвчтэй хүнээс та нар юуг мэдэж авч болох вэ?
2. Уяман өвчтэй хүнд хариулсан байдлаас нь Аврагчаас та нар юуг мэдэж авч болох вэ?
3. Мосегийн хуулиар бол, уяман өвчтэй байх нь "бузар" гэж тооцогддог байжээ. Уяман өвчтэй хүн гэдэг үгийг нүгэлтэн гэдэг үгээр сольж, Марк 1:40–44-ийг дахин унш. Биднийг нүгэл үйлдсэн үед энэ нь бидэнд юун талаар зааж болох вэ?

Марк 2

"Нүглүүд Чинь Чамд Өршөөгдсөн Болой"

Марк 1:38-д дурдсанчлан, Есүс гайхамшигуудыг үйлдэхээр ирсэн гэхээс илүүгээр сайн мэдээг номлох гэж ирсэн билээ. Түүний үйлдсэн гайхамшигууд бол Тэрбээр бидний төлөө сүнсээр юу хийж чадахыг харуулсан гадна талын бодит бэлэгдлүүд юм. Марк 2-т бид Есүс энэ зарчмыг заасан цаг үеийн тухай унидаг.



Матай 2-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 2:1–22–Матай 9:2–17; Лук 5: 17–30
Марк 2:23–27–Матай 12:1–8; Лук 6:1–5

Судруудыг Судлах нь



Марк 1-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг нь (А буюу Б) хий.

А Замыг Бэлтгэх нь

Марк өөрийн гэрчлэлийг Есүс Христийн тохинууллын төлөө замыг бэлтгэсэн үйл явдлуудыг дүрсэлснээр эхэлсэн байдаг. Доорх дөрвөн бүлэг шүлгээс тус бүр нь Марк ямар үйл явдлыг дүрсэлсэн хийгээд Есүсийн мөнх бус байдал дахь тохинуулалд баримтлах ямар зүйлд замыг бэлтгэхэд энэ нь тусалсан гэж бодож байгаагаа товч ярь: Марк 1:2–8, 9–11, 12–13, 16–20.

Б Гайхамшгаас Та Нар Юу Мэдэж Болох Вэ?

Есүсийн үйлдсэн гурван өөр гайхамшиг хийгээд Тэрбээр "олныг" эдгээсэн тухай тэмдэглэлийн талаар бид Марк 1-д

Судруудыг Ойлгох нь



Марк 2

Дуулджээ (ш.1)—Үг таржээ
Саа өвчтөн (ш.3–5, 9–10)—
Татдаг өвчтэй, тахир дутуу
Цугласан олноос болж
түүнд хүрэх (ш.4)—
Цугласан олноос болж
түүнд хүрэх
Бодоход (ш.6, 8)—Тунгаан
бодох
Доромжилж (ш.7)—Ариун
зүйлүүдээр тохуурхах буюу
бурханлиг хүчний талаар
худал хэлэх

Үүнтэй адил (ш.12)—Үүн
шиг
Явав (ш.13)—Алхах, явах
Татвар хураагчид
(ш.15–16)—Татвар хурааж
авдаг хүмүүс
Эрүүл (ш.17)—Өвчингүй,
эрүүл чийрэг
Урна (ш.21)—Урах болно
Үгүй хоцорно (ш.22)—Үгүй
болгоно

Марк 2:23–28—Хүндэтгэлийн Өдрийн Журал

Энэ гарын авлага дахь Матайн оршлыг үз (х.11).

Судруудыг Судлах нь



Марк 2-ыг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Жинхэнэ Захиасыг Олж Мэдэх нь

Марк 2:1—12-ыг судлахдаа дараах асуултуудад хариул:

1. Саа өвчтэй хүнд эхлээд Есүсийн хэлсэн үг яагаад хачирхалтай мэт санагдаж болох вэ?
2. Матай 2:9-д цэдэглэгдсэн асуултанд та нар хэрхэн хариулах вэ? Тэрээр энэ асуултаараа юу хэлэхийг хүссэн гэж та нар бодож байна вэ?
3. Нүгэл нь бүх өвчний шалтгаан байдаггүй ч гэсэн, илүү их сүйтгэл авчирдаг. Харамсалтай нь, бие бодитой өвчний үр дагаврууд хийгээд шинж тэмдгүүдийг нүдээр харж болдог бол, нүгэл болон уучлалыг нүдээр харах нь хэцүү байдаг. Хүнийг нүглүүдээс нь уучлах хийгээд мөн түүний саа өвчнийг эдгээх аль аль талаас нь авч үзсэнээр Есүс хүмүүст ямар сургамж заахаар хичээж байсан гэж та нар боддог вэ?

Марк 3

Есүс Их Анхаарал Татав

Есүсийг амьд сэрүүн байхад хичнээн хүмүүс хөрвүүлэгдэж, Сүмийн гишүүн болсныг бид мэддэггүй. Энэ тоо

нилээд цөөхөн байсан байж болох юм, гэвч илүү олон тооны хүмүүс, ялангуяа Түүний гайхамигуудыг харсан буюу сонссон үедээ Есүсийг сонирхдог байсныг Марк цэдэгтээ тэмдэглэсэн байдаг. Марк 3 бол Есүсийг сонирхох сонирхол өсч байсан тухай цэдэг бөгөөд, Түүнийг нэрд улам гарахын хэрээр, эрх мэдэл, удирдлагад байсан хүмүүс Түүнийг хэрхэн эсэргүүцэж, Түүнийг хүмүүсийн нүдэн дээр гутаах арга замуудыг эрж хайж эхэлснийг харуулдаг.



Марк 3-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 3:1–6—Матай 12:9–14; Лук 6:6–11

Марк 3:7–12—Матай 12:15–16

Марк 3:13–19—Матай 10:2–4; Лук 6:12–14

Марк 3:20–30—Матай 12:22–27

Марк 3:31–35—Матай 12:46–50; Лук 8:19–21

Судруудыг Ойлгох нь



Марк 3

Хатангир (ш.1)—
Хатангиршсан, хатсан

Харамсаж (ш.5)—
Уйтгартайгаар

Херодынхонтой (ш.6)—
Ромыг дэмждэг Иудейчүүд,
түүнчлэн орон нутгийн
захирагч Херод

Бэлэн байлгахыг (ш.9)—
Түүнд зориулж бэлэн байл-
гахыг

Хурсан олон (ш.9)—
Цугласан олон хүн

Өвчин (ш.10)—Өвчин
зовлон

Хатуу санууллаа (ш.12)—
Хатуухан хэлэв

Түүнийг (Есүсийг) авчра-
хаар явав (ш.21)—Түүний
харгалзан, авчрах

Беелзебул (ш.22)—Сатан,
Дээрэмдэх (ш.27)—
Хулгайлах

Ариун Сүнснийг доромж-
лох (ш.29)—Христийг санаа-
тайгаар үгүйсгэх

Марк 3:8—Идум, Тир болон Сидон

Дагалдах газрын зургийг үз.



ажээ. Хүмүүсийн нэн сайн мэддэг юмсыг сүнслэг үнэнтэй жишиж харьцуулсан сургаалт зүйрлэлүүд буюу түүхүүдийг Есүс ярьдаг байлаа. Матай 13-ын оршил нь (х.26). Есүс яагаад сургаалт зүйрлэлүүдийг ашигладаг байсныг тайлбарлаж, тэдгээрийн утгыг гаргах зарим санаануудыг өгсөн байдаг.

Марк 4-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 4:1–25—Матай 13:1–23: Лук 8:4–18

Марк 4:30–34—Матай 13:31–35

Марк 4:35–41—Матай 8:18–27: Лук 8:22–25

Судруудыг Судлах нь

Марк 3-ыг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Бидний Эрмэлзлийн Ач Холбогдол

Марк 3: 1–6-д өгүүлсэн түүх нь Фарисайчуудын оюун ухаанд нэвтрэх сонирхолтой ойлголтыг бидэнд өгдөг. Эдгээр шүлгүүдийг судлахдаа дараах асуултуудад хариул:

1. Фарисайчууд Есүсийг хянаж байхдаа, тэд юу эрж байсан бэ? (Мөн энэхүү судлах удирдамж дахь Матай 12-ын оршлыг үз (х.24–25).
2. Эдгээх хүч хэнээс ирдэг вэ?
3. Есүст юу чухал байсан хийгээд Фарисайчуудад юу чухал байсан талаар энэ үйл явдал бидэнд юу өгүүлж байна вэ?
4. Өнөө үед Бурханы сүнслэг нөлөөллөөс илүүгээр хүмүүний ёс заншлуудыг баримталдаг хүмүүсийн Хүндэтгэлийн өдөр хийдэг зүйлүүдийн зарим жишээ юу вэ?

Б Христийн Гэр бүл

Марк 3:31–35-д Түүний ээж болон гэр бүл нь ач холбогдолгүй гэж хэлээгүй юм. Тэрбээр дэлхийд ирсэн Өөрийн хамгийн чухал учир шалтгаануудад дахин анхаарал төвлөрүүлсэн байлаа.

1. Марк 3:31–35-ын дагуу, Христийн гэр бүлийн гишүүн байхын тулд хүнд ямар чанарууд хэрэгтэй вэ?
2. Энэхүү сургаал Мормоны Номонд улам тодосгогджээ. Бид хэрхэн Христийн гэр бүлийн хэсэг байж болох талаар Мозая 5:5–9-д өгүүлсэн зүйлийг өөрсдийн үгээр тайлбарла.

Марк 4

Есүс Сургаалт Зүйрлэлүүдээр Заав

Сургаалт зүйрлэл гэдэг үг нь, “дэргэд нь тавих” буюу, өөрөөр хэлбэл, жишиж харьцуулахын тулд нэг зүйлийг нөгөөгийнх нь хажууд тавих гэсэн грек үгнээс үүсэлтэй

Судруудыг Ойлгох нь

Марк 4

Тариачин (ш.3, 14)—Үр суулгагч



Тариачин

Зам хавиар (ш.4)—Дээгүүр нь явдаг хатуу газар

Шувууд (ш.4, 32)—Шувуунууд

Хуурамч байдал (ш.19)—Хуурмаг байдал

Хүсэл (ш.19)—Шунал буюу хилэнцэт хүсэл

Сав (ш.21)—Том сав

Илрүүлэгдэх (ш.22)—Мэдэгдэх, ил гаргагдах

Өөрсдийнхөө хэмжүүрийн жишгээр (ш.24)—

Өөрсдийнхөө хэмжүүрээр хэмжих буюу шүүх, танд өгөгдсөн зүйлүүд

Хэмжигдэх (ш.24)—Өгөгдөх

Хадуур (ш.29)—Тариан гүрүү хаддаг махир хутга (багаж)

Тайлбарлан өгөх (ш.34)—Утгыг тайлбарлах

Хитэгт (ш.38)—Ар талд

Буруушааж (ш.39)—Зэмлэж, зогсохыг зарлигласан

Судруудыг Судлах нь

Марк 4-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б хоёрыг хоёуланг нь хий.

А Хэвлэлийнхэнтэй Уулзах

1. Сонины хэсэг сурвалжлагчидтай та Сүмийн тухай ярих даалгавар авчээ гэж бод. Дараах асуулт тус бүрт хариулахын тулд Марк 4-ийн сургаалт зүйрлэлүүдээс алийг нь ашиглаж болохыг хэл:

- Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн ирээдүй ямар байх вэ?
- Сүм яагаад ийм олон номлогч нарыг гадагш илгээдэг юм бэ?
- Энэ сүмийг дэлхийн олонхи шашнуудтай харьцуулахад нилээд шинэ бөгөөд Нэгдсэн Улсад их жижигхэн эхэлсэн атал Сүмийн гайхалтай өсөлтийг хэрхэн тайлбарлах вэ?

2. “Сүм гайхалтай бас гайхамшигтай байдлаар өсч байна . . . Сүм Дэлхий даяар гайхамшигтай байдлаар тархан дэлгэрч байна” гэсэн Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн үгст тохирох сургаалт зүйрлэлийг хэл (Steve Fidel, “Members Living Abroad Outnumber LDS in U.S.,” *Deseret News*, 26–27 1996 оны 2-р сар, А2-ыг үз).

Б Чухал Асуултуудын Хариулт

Марк 4:35–41-д дөрвөн асуулт асуусан байдаг. Шавь нар нь эхний болон дөрөв дэх асуултыг; Есүс хоёр дахь, гурав дахийг асуужээ. Асуултуудын алинд нь ч хариулаагүй боловч, түүхийг анхааралтай уншиж, Есүс хийгээд шавь нарынх нь тухай мэддэг зүйлдээ дүн шинжилгээ хийснээр бид зарим боломжит хариултуудын талаар бодож болно.

1. Эхний асуултыг, мөн Есүсийн өгөх байсан гэж боддог хариултыг бич.
2. Хоёр дахь, гурав дахь асуултуудыг бичиж, та нар өөрсдөө шавь нар нь байсан бол өгөх байсан хариултыг хэл.
3. Дөрөв дэх асуултад өөрсдийнхөө хариултыг өг.
4. Энэ туршлага өнөөдөр хэн нэгэнд ямар захиас үг болж чадах вэ?



Марк 5

Илүү Олон Гайхамшгууд

Хүмүүсийн амьдралыг адисалж, чухал зарчмуудыг заахын тулд Есүс гайхамшигуудыг үйлддэг байв. Гайхамшигууд нь Есүсийн бурханлиг хүч хийгээд

манай дэлхийг зохицуулдаг илүү өндөр түвшиний хуулиудыг ойлгох Түүний ойлголтыг харуулдаг байв. Гайхамшигуудыг үйлдэх энэхүү хүч нь үүнд оролцогчдын итгэлийг шаарддаг билээ. Марк 5 дахь гайхамшигуудын тухай шастируудыг уншихдаа, оролцсон хүмүүс өөрсдийн итгэлийг хэрхэн харуулж байсныг эрж ол. Гайхамшиг бүрээр, түүнчлэн үүнийг тэрээр үйлдсэн арга замаар Есүс ямар чухал зарчмуудыг заасныг анхаар.

Та нар энэ бүлгийг судлахдаа Матай 8–9 дэх мэдээллийг үзэж болно.

Матай 5-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 5:1–20—Матай 8: 28–34; Лук 8: 26–39

Марк 5:22–43—Матай 9:18–26; Лук 8:41–56

Судруудыг Ойлгох нь



Марк 5

Бузар сүнс (ш.2)—Бузар сүнс буюу чөтгөр

Гав (ш.4)—Гав гинж

Гуйя (ш.7)—Хүсье

Легион (ш.9, 15)—Олуулаа

Хүсэмжлэн гуйж (ш.10, 12, 23)—Ихэд хүсэн гуйв

Гахай (ш.11–12, 16)—Гахайнууд

Тэдэнд зөвшөөрөв (ш.13)—Тэд яваг (одог)

Тохиолдсоныг (ш.16)—Тохиох, болох

Нутгаасаа (ш.17)—Нутаг, зах хязгаар

Есүс зөвшөөрсөнгүй (ш.19)—Гэвч Есүс зөвшөөрсөнгүй

Зарлаж (ш.20)—Зарлан мэдэгдэж

Бүчин шахалдаж (ш.24)—Шахцалдан түлхэж

Цус алддаг (ш.25)—Цус гоождог

Хүч (ш.30)—Эрчим хүч

Уймарсан (ш.38)—Уймж шуугилдсан, санаагаар унасан

Марк 5: 8–13—Бузар Сүнснүүд Гахайнуудад Оров

Энэхүү эмгэнэлт түүх нь Сатаныг дагасан сүнснүүд ямар ч хамаагүй бие мах бодитой болох гэсэн агуу хүсэлтэй байдгийг ойлгоход бидэнд тусалдаг. Есүс яагаад эдгээр бузар сүнснүүдийг гахайн биенд оруулсныг буюу эсвэл яагаад гахайнууд тэр даруй Галилын Тэнгис рүү харайж орсныг бидэнд өгүүлдэггүй. Тиймээс Иудейчүүд гахай өсгөж байсан нь, тэд тушаалуудыг зөрчиж байжээ. Мосегийн хуулиар гахайг бузар амьтан гэж үздэг байв. Энэ нь хүнээс гарч улмаар бузар хэмээгддэг байсан амьтны биенд орохыг тушаалгуулсан бузар сүнснүүдийг харж, сонссон хүмүүст хүчтэй сургамж болсон ажээ. Энэ нь чөтгөрт үйлчилдэг хүн бүрийн хувьд сүнсний устгал зайлшгүйг бэлэгдэн харуулдаг.

Марк 5:23—“Та Очиж Түүн Дээр Мутраа Тавиач . . . Тэгвэл Тэр Эдгэж Амьдрах Байх”

Тухайн үедээ Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Ховард В.Хантер энэ шүлгийн тухай хэлэхдээ, “Эдгээр нь зөвхөн уй гашуунд цөхөрсөн нэг эцгийн итгэлийн тухай үгс төдийгүй, харин Есүс мутраа юун дээр ч тавилаа гэсэн, тэр нь амьдардгийг бас бидэнд сануулагч

болдог. Хэрэв Есүс гэрлэлт дээр мутраа тавилаа гэхэд энэ нь амьдардаг. Хэрэв Тэрбээр мутраа гэр бүл дээр тавилаа гэхэд энэ нь амьдардаг” гэжээ (in Conference Report, 1979 оны 10-р сар, 93; *Ensign*, 1979 оны 11-р сар, 65).

Судруудыг Судлах нь

Марк 5-ыг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-гийн аль нэгийг хий

А Бэлэгдлийн Утгыг Хай

Марк 5:1–20-д дүрслэгдсэн үйл явдал яг болсон ч гэсэн, бид энэхүү гайхамшгийн бэлэгдлээс мөн л сурч болно. Дараах асуултуудад хариулах нь энэ түүхийг өнөөдөр өөрсөддөө хийгээд бусдад хэрэглэхэд та нарт тусална.

1. Бузар сүнсстэй хүн “булшнуудын” (ш.2, 5) дунд амьдардаг байлаа гэсэн нь бэлэгдлийн ямар утгатай вэ?
2. “Гав гинжээр хүлэгдсэн” яг тэр хүн шиг, бүр асуудлыг хяналтандаа авахын тулд хүчин чармайлт хийгдсэний дараа ч үргэлжилж “номхруулахад” хэцүү байдаг ямар асуудлууд өнөө үед байдаг вэ?
3. Тэр хүний хувьд Есүсийн хийсэн зүйлээс, бидний хэцүү асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Түүний хийж чадах зүйлийн талаар бид юу мэдэж авч болох вэ?

Б Тэд Юу Хийсэн Бэ?

1. Марк 5:22-43-т тусламж болон адислалуудын төлөө Аврагчийг эрэлхийлж байсан хоёр хүний тухай өгүүлдэг. Эдгээр шүлгүүдийг анхааралтай уншаад, мөн түүнчлэн бид Аврагчаас адислалуудыг эрэлхийлэхийн тулд бидний хийж болох зүйлүүдийг эдгээр шүлэг тус бүрээр жагсаа.
2. Эдгээр түүхүүдээс та нар Есүсийн тухай юу мэдэж авав?

Марк 6

Есүс Гэх Энэ Хүн Хэн Бэ?

Есүсийн үйлдсэн гайхамшгууд үнэнхүү гайхмаар байлаа, гэвч хүмүүсийн олонх нь Есүс чухам хэн байсныг ойлгоогүй юм. Марк 6-д Түүний төрөлх хотын хүмүүс; захирагч Херод; мөн Түүнийг буруугаар ойлгосон хэвээр байсан Түүний шавь нар Түүнийг хэн гэж боддог байсан тухай бид уншидаг. Энэ бүлгийг уншихдаа Есүсийн тухай өөрсдийн гэрчлэлийн талаар бодож, хэрэв та нар Марк 6-д болж байгаа үйл явдлуудын үеэр тэнд байсан бол Есүсийг ойлгоход нь хүмүүст туслахын тулд хэрхэн чармайх байснаа төсөөлөн бод.

Матай 6-д Та нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 6:1–6—Матай 13:54–58

Марк 6:7–13—Матай 10; Лук 9:1–6

Марк 6:14–15—Матай 14:1–2; Лук 9:7–9

Марк 6:17–29—Матай 14:3–12; Лук 3:19–20

Марк 6:30–56—Матай 13–36; Лук 9:10–17; Иохан 6:1–21

Судруудыг Ойлгох нь

Марк 6



Энэ хүн үүнийг хаанаас авав? (ш.2)—Эдгээр зүйлүүдийг тэр хаанаас сурав?

Гэр, төрөл садныхан (ш.4)—Гэр бүл, төрөл төрөгсөд

Таягаас өөр (ш.8)—Тулах таягнаас өөр

Уут хүүдий (ш.8)—Хүнс буюу хувцас хийх цүнх

Шинэ Гэрээний орчуулгад сүүлчийн өгүүлбэр тэр чигээрээ орхигдсон—Энэ нь илүү тэвчмээр байх болно
Монгол Библид байхгүй (ш.14)—Газар сайгүй, олон газарт

Алуурчин (ш.27)—Хүн цаазаар авдаг (алах ялыг гүйцэтгэдэг) хүн

Цаг (ш.31)—Чөлөөт цаг, амрах цаг

Гүйсээр (ш.33)—Тийшээ явган явав

Хэсэг хэсгээр нь, хэсэг (ш.39–40)—Хэсэг (бүлэг) хүмүүс

Хэлтэрхий, үлдэгдэл (ш.43)—Үлдсэн юмс, үлдэгдэл

Суулгаж (ш.45)—Суухыг тушааж

Орой (ш.47)—Үдэш, орой

Сөрөн (ш.48)—Эсрэг

Шөнийн дөрөв дэх манааны үед (ш.48)—Нар мандахын өмнөхөн

Марк 6:17–19—“Дүүгийнхээ Эхнэрийг Авах нь Таны Хувьд Хууль Бус”

Түүхийн энэ цаг үед Херодын эхнэр Херодия эцэг буюу эх нэгтэй дүү Филиппийнх нь эхнэр байжээ. Тэрээр Херодтай суухын тулд түүнээс салж, мөн Херод анхны эхнэрээсээ салж, Херодиятай гэрлэжээ. Хүн, ах буюу дүүгийнхээ эхнэртэй түүнийг амьд байхад нь гэрлэхийг Мосегийн хуулиар хориглодог байв (Левит 20:21-ийг үз). Өөр хэн нэгэнд сонирхлын үүднээс эхнэр буюу нөхрөөсөө салах нь бас буруу байжээ. (Матай 5:31–32-ийг үз). Херодия гэм буруутай гэдгийг

мэдэрч, наманчлахын оронд гэмт үйлдлийг нь түүнд сануулсан хүн—Иохан Баптисаас хагацахын түүс болсныг түүний үйлдлүүд харуулдаг.

Судруудыг Судлах нь

Марк 6-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А **Есүс Төрөлх Хотдоо Эргэж Ирэв**

1. Марк 1–6-гийн дагуу, Есүс “Өөрийн орон нутаг” болох Түүний төрсөн хот Назарт эргэж ирэхэд Түүнийг хэрхэн хүлээн авсан бэ?
2. Тэдгээр хүмүүсийн харьцаа хандлагын улмаас ямар адислалууд нь тэднээс авагдсан бэ?
3. Энэхүү болсон явдал нь өнөө үед Сүмийн ерөнхий болон орон нутгийн удирдагчтай харьцах бидний харьцаанд хэрхэн тусгалаа олж болох вэ?

Б **Гэм Бурууд Хариу Сйлдэл Сзүүлэх нь**

1. Марк 6:14–28-д, Херод ямар нэг зүйлд гэм буруутайгаа мэдэрч байснаа харуулж болох юу хийсэн бэ?
2. Херодия өөрийнхөө гэм бурууд хэрхэн хариулсан бэ?
3. Бид нүглүүдийнхээ төлөө гэм буруутайгаа мэдэрсэн үед юу хийх ёстой вэ?
4. Бид өөрсдийн гэм буруу хийгээд нүглүүдийг нуухийг хичээх үед (С ба Г 121:37-г үз) тохиолддог зүйлийг бид өөрсдийгөө даруусгаж, наманчилсан үед тохиолддог зүйлтэй харьцуул (Инос 1:4–8; Мозая 4:2–3-ыг үз).

В **Аврагчийн Тухай Мэдэх нь**

Марк 6:31–44 дэх түүхээс Есүсийн зан чанар, төрөлх байдал буюу хүчний талаар мэдэж авсан зүйлээсээ хоёрыг нэрлэ.

Марк 7

Хүнийг Юу Бузарладаг Вэ?

Ёс заншил нь гэр бүлүүд хийгээд бусад хэсэг бүлгүүд дэх нэгтгэгч чухал нөлөө байж болно. Гэвч ёс заншил нь сайн мэдээний зарчмуудаас илүү чухал болох буюу тэдгээрийг орлох, эсвэл тэдгээртэй нийцэхгүй байвал, тэдгээр ёс заншил нь Их Эзэний аз жаргалын төлөвлөгөөний эсрэг үйлчилдэг. Шинэ Гэрээний үед Иудейчүүдийн зарим ёс заншлууд тэдний шашинд тэдгээрийг үндэслэсэн Бурханы хуулиудаас дээгүүрт тавигдсан байлаа. Марк 7-гийн ихэнх нь ахмадуудын эдгээр ёс заншлуудын талаар Есүсийн хэлсэн болоод

хийснийг өгүүлдэг. Марк 7-г уншихын өмнө судлах энэ удирдамж дахь Матай 12, 15-ын оршлуудыг (х.24–25 болон 28) дахин уншиж болно.

Матай 7-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 7—Матай 15:1–31

Судруудыг Ойлгох нь

Марк 7

Харин (ш.7)—Гэвч, гэсэн хэдий ч

Дэмий хоосон (ш.7)—Хоосон, ямар ч хэрэггүй

Зөвшөөрөх (ш.12)—Боломж олгох

Юу ч (ш.12)—Ямар нэг юм, юу ч

Гадна (ш.15, 18)—Гадна талд

Бузарлах (ш.15, 18, 23)—Хүний сүнсний хувьд цэвэр ариун биш болгох

Ойлгох (ш.18)—Ухаарах, ухаж ойлгох

Ходоодонд ороод хаягдана (ш.19)—Идсэн зүйл биед орж, дараа нь хаягдана

Шунахайрал (ш.22)—Шунахай, сувдаг сэтгэл

Тачаангуй байдал (ш.22)—Хяналтгүй тачаангуй байдал

Зохистой (ш.27)—Зөв буюу зохимжтой

Талгираа хэлтэй (ш.32)—Тод ярьж чаддаггүй

Марк 7:9–12—“Энэ бол Корбан”

Корбан гэдэг нь “Бурханд өгөгдсөн” гэсэн утгатай нэр томъёо юм. Мосегийн хууль нас өндөр болсон эцэг эхдээ хүүхдүүд нь халамж тавихыг шаарддаг, гэвч ахмадуудын уламжлал нь, хэрэв Бурханд буюу ариун сүмд (корбан) өргөхөөр төлөвлөсөн мөнгө буюу бусад нөөц танд байгаа бол, эдгээрийг эцэг эхээ тэтгэхэд хэрэглэж болохгүй гэж үздэг байв. Зөв шударга бус санаа бодолтой хүмүүс корбаны энэ ёс заншлыг Бурханыг бусад бүх зүйлээс— тэр ч байтугай гэр бүлээсээ илүү хайрладаг мэт харагдахад ашигладаг байжээ. Гэвч үнэндээ тэд эд баялгаа насан өтөл болсон эцэг эхээ асрахад ашиглахаас хол хөндий байлгадаг байлаа.

Марк 7:26–29—Яагаад Есүс Грек Эмэгтэйг Нохой Гэсэн бэ?

Матай 15:22–28-ын (х.28) “Судруудыг Ойлгох нь”-ыг үз.

Судруудыг Судлах нь

Марк 7-г судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А **Харьцуулалт Хий**

1. Марк 7:1–23-г уншсан зүйлээ ашиглан, Фарисайчуудын бузар гэж үздэг байсан зүйл, Есүсийн бузар гэж үздэг байсан зүйлийн хоорондох ялгааг тайлбарла.
2. 3 Нифай 27:19–20-ийг уншиж, цэвэр ариун буюу бузар байх талаар Есүсийн хэлснийг ойлгох нь яагаад чухал болохыг, түүнчлэн хэрэв бид цэвэр ариун биш байгаа тохиолдолд бид юу хийх ёстойг тайлбарла.

Марк 8

“Та Нар Одоо ч Ухаарахгүй Байна уу?”

Хүний хэлсэн зүйлийн утгыг буруу ойлгоод дараа нь үүнийг танд тайлбарлахад энэ нь тодорхой болсон үед, тэнэг юм шиг санагдсан явдал танд тохиолдож байсан уу? Марк 8-д Есүсийн шавь нарт үүнтэй адил явдал тохиолдсон ажээ. Шавь нар нь Есүсийг үргэлж ойлгохгүй байж болох байсан хэдий ч, тэд Түүнд итгэлтэй байжээ. Энэ бол, энэ бүлэг дэх нэг чухал санаа юм. Өөрсдийн ойлгоогүй зүйлүүдийг нотлох тэмдгийг шаарддаг байсан Фарисайчуудтай адилгүй нь гэвэл шавь нар итгэлтэй байсан бөгөөд Ариун Сүнсний нөлөөг хүлээн авдаг байв. Есүс Христийн тухай өөрсдийн ойлголт хийгээд гэрчлэлийг бэхжүүлэхэд Марк 8-аас юу сурч болохыг анхаар.

Марк 8-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 8:1–10—Матай 15:32–39

Марк 8:11–21—Матай 16:1–12

Марк 8:27–38—Матай 16:13–27; Лук 9:9:18–26

Судруудыг Ойлгох нь



Марк 8

Өрөвдөх (ш.2)—Өрөвч сэтгэл, өрөвдөх

Хэлтэрхийнүүд (ш.8)—Хоол хүнс

Үеийнхэн (ш.12, 38)—Энэ үеийн хүмүүс

Зааварлах (ш.15, 30)—Зааварлав; зарлиглав

Ойлгох (ш.17)—Ухаарах, ойлгох

Илүүдэл (ш.19–20)—Хэсгүүд

Зэмлэх (ш.32–33)—Хэлснийг нь буруутгах

Боддог (ш.33)—Таашаадаг

Марк 8:15—Хөрөнгө Гэж Юу Вэ?

Хөрөнгө (эсгэх) бол мөөгөнцөр юм. Багахан эсгэх хөрөнгийг талхны зуурмагтай холиход талхны зуурмагт түргэн нөлөөлж, цэврүүнүүд үүсгэн, талх болж өсдөг. Хөрөнгөөр эсгэсэн талх хөрөнгөөр эсгээгүй талхнаас илүү хөнгөхөн болдог, гэвч илүү хурдан мууддаг. Энэ шалтгааны учир эсгэх хөрөнгө нь сударт, заримдаа ялзралын бэлэгдэл болдог. “Фарисайчуудын болон Херодын хөрөнгөнөөс болгоомжил” гэж чухам Есүс үүнийг л хэлсэн хэрэг. Эсгэх хөрөнгийг бусад үед сайн буюу муу ямар нэг зүйлийг олон тоотой болоход нөлөөлж болох ямар нэг багахан буюу цөөн тоотой юмыг заасан байдаг.

Марк 8:29–30—Яагаад Есүс Өөрийнхөө Хэн Болохыг Хэнд ч Бүү Хэлээрэй Гэж Шавь Нарасаа Хүссэн бэ?

Матай 16:20-ийн (х.29) “Судруудыг Ойлгох нь”-ыг үз.

“Судруудыг Судлах нь”



Марк 8-ыг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Адил ба Ялгаатай нь

1. Марк 8:22–26-д дүрслэгдсэн гайхамшиг нь Шинэ Гэрээнд (жишээ нь, Матай 20:30–34-тэй харьцуул) та нарын уншсан бусад гайхамшигуудтай адил буюу ялгаатай байдлыг нь жагсаа.

2. Марк 8:22–26-д цэдэглэгдсэн гайхамшигаас сүнсний ямар захиасыг та нар сурч болох вэ?

Марк 9

“Итгэлгүй Байгаад Минь Туслаач”



Есүс болон Түүний шавь нар Цейзарийн Филиппд байх үеэр, Тэрбээр тэдэнд, ялангуяа Петрт “тэнгэрийн хаант улсын түлхүүрүүдийг” амласныг Матай 16-гаас бид мэдсэн билээ (Матай 16:19). Хувиралтын Уулан дээр энэхүү амлалт гүйцэлдсэн тухай Матай 17-д бид уншдаг. Түүнчлэн Матай 9:1–13 нь уг туршилагын тухай шастирыг агуулдаг. Энэхүү ариун туршилагын дараа Петр, Иаков, Иохан нар Эзэнээс мөн л олон зүйлийг мэдэж авах хэрэгтэй байлаа. Марк 9-ийг уншихдаа, Тэрбээр тэдэнд зааж, бас тэдний итгэлийг, мөн тэрчлэн бусдын итгэл болон ойлголтыг нэмэг-

дүүлэхэд тусалж байсан Түүний арга замуудыг эрж хай. Марк 9:24 дэх “итгэлгүй байгаад минь туслаач” гэсэн гуйлт нь хүүдээ тусламж хүссэн нэг эцгийнх байсан хэдий ч, энэ нь Аврагчид итгэдэг боловч, илүү итгэл, мэдлэг хэрэгтэй байгаагаа мэдсэн хэн нэгний гуйлт байхад яггүй сайн тохирно.

Марк 9-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 9:2–32—Матай 17:1–23; Лук 9:28–45

Марк 9:33–50—Матай 18:1–9; Лук 9:46–50

Судруудыг Ойлгох нь



Марк 9

Хувирч өөрчлөгдөх (ш.2)— Хүний бие түр зуур өөрчлөгдөж, уг хүн тэнгэрлэг биетүүдийн оршихуй хийгээд алдар сууг олох

Цайруулагч (ш.3)—Хувцас цэвэрлэж, цагаан өнгөтэй болгодог хүн

Цацар (ш.5)—Асар, майхан, түр зуур ашиглах шүтээний байр, табернекл



Табернекл барих нь

Мэдэх (ш.6)—Мэдэх

Өөр (ш.8)—Бусад

Хуулийн багш нар (ш.11, 14, 16)—Мосегийн хуулийн утгыг хүмүүст заадаг хүмүүс

Басамжлагдах (ш.12)—Үнэ хүндгүй гэж тооцогдох буюу шоовдорлогдох

Мэндлэх (ш.15)—Мэндлэх, мэнд усаа мэдэх

Сүнс шүгэлсэн (ш.17)—Ярьж чаддаггүй болгосон

Бие нь хөшчихдөг (ш.18)—Бие нь сул болчихдог

Сүнс түүнийг хүчтэй татвалзуулж (ш.20)—Тэр татвалзаж байлаа

Хөлбөрөн өнхөрч гарав (ш.20)—Унаж өнхрөв

Хүчтэй татвалзуулав (ш.26)—Тэр хүчтэй татганав

Тахир дутуу (ш.43)—Эрхтэн дутуу

Унтрах (ш. 43–46, 48)—Бөхөх, унтрах

Марк 9:43–48—Гар буюу Хөлөө Тасдаж Хая, Эсвээс Нүдээ Ухаж Хая

Матай 5:29–30-ын (х.17) “Судруудыг Ойлгох нь”-ыг үз. Марк 9:40–48-ын Иосеф Смитийн Орчуулга бас эдгээр шүлгүүдэд Есүс юу гэж хэлсэн талаар чухал ойлголт өгдөг.

Марк 9:49–50—Давс ба Гал

Мосегийн хуулиар тахилыг Их Эзэн хийгээд Түүний хүмүүсийн хоорондох үүрдийн гэрээний бэлэгдэл гэж үзэн давсалдаг байжээ. Энэ нь, уг тахилыг Их Эзэнд “сайн” болгодог байв. Христийг дагалдагчид өөрсдийгөө Түүнд амьд өргөл болгон барьдаг байсан бөгөөд (Омнай 1:26-г үз) уг өргөл нь Ариун Сүнсний хүчний цэвэршүүлэлтийг (эсвэл галын баптисмыг) авчирдаг.

Судруудыг Судлах нь



Марк 9-ийг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий

А Итгэлээ Нэмэгдүүлэх нь

1. Марк 9:14–29 дэх түүхэн дэх асуудал юу вэ?
2. Уг асуудлын талаар Есүс юу гэж хэлсэн бэ? (ш.19, 23, 29-ийг үз)
3. Тэр эцэг шүлэг 24-т Есүст хэлсэн зүйлээрээ юуг илэрхийлсэн гэж та нар боддог вэ?
4. Итгэлээ нэмэгдүүлэхэд тань энэ түүх та нарт хэрхэн туслах вэ, эсвэл итгэлээ нэмэгдүүлэхийг та нарт хэрхэн заах вэ?

Б Иосеф Смитийн Орчуулгаас Мэдэж Ав

1. Марк 9:40–48-ын Иосеф Смитийн Орчуулгыг анхааралтай унш. “Гар чинь”, “хөл чинь”, “нүд чинь” гэсэн нь хэнийг бэлэгддэг хэмээн бидэнд хэлдэг вэ?
2. Иосеф Смитийн Орчуулгын тайлбарыг санаандаа тогтоож, энэ зөвлөгөөг та нарын насны хүмүүст өнөөдөр хэрхэн хамааруулан ойлгож болно гэж та нар боддог вэ?

Марк 10

Жинхэнэ Агуу Чанар

Олон Иудейчүүд Мессиагийн анхны ирэлтийн тухай Хуучин Гэрээний бошиглолуудыг Түүний хоёр дахь Ирэлтийн тухай бошиглолуудтай самуурдаг байжээ. Тэд Мессиаг агуу их хүч хийгээд сүр жавхлантай байлдан дагуулагч хаан болж дайснуудыг нь устгахаар ирнэ гэж бодон хүлээж байлаа. Христ тэдний хамгийн хөнөөлтэй дайсан—нүгэл, үхэл хоёрыг устгахаар ирсэн бөгөөд—харин Өөрийн зовлон шаналал, үхлээр эдгээр дайснуудыг байлдан дагуулсан нь ихэнх хүмүүсийн хувьд ойлгоход хэцүү байжээ. Энэ нь Исаиа 53-т угтан хэлэгдсэн юм. Эдгээр зарчмуудыг Марк 10-т заахаар хичээсэн Есүсийн арга замуудыг эрж хай.

Марк 10-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 10:1–31—Матай 19; Лук 18:15–30

Марк 10:32–52—Матай 20:17–34; Лук 18:31–43

Судруудыг Ойлгох нь



Марк 10

Нутаг (ш.1)—Хязгаар, хил
 Хууль (ш.5)—Зарлиг
 Нэгдэх (ш.7)—Нийлэх
 Хоёул (ш.8)—Хоёр, хосоороо
 Салгах (ш.9)—Салгах, хуваах, хоёр хэсэг болгох
 Завхайрах (ш.11)—Өөрийн гэрлээгүй хүнтэй эр эмийн харьцаанд орох
 Мэхлэх (ш.19)—Хуурах, залилах

Гунигтай (ш.22)—Их гунигтай
 Ташуурдах (ш.34)—Ташуураар зодох
 Ноёрхох (ш.42)—Захирах, бусдыг өөртөө үйлчлүүлж, өөрийгөө дэмжүүлэх
 Зарц (ш.43)—Үйлчлэгч
 Золиос болгох (ш.45)—Хүнийг боолчлолоос чөлөөлөх төлбөр, төлөөс

Марк 10:2-12—Гэрлэлт ба Салалтын Талаар Есүсийн Заадаг Зүйлүүд

Матай 19:3-12-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг үз (х.32).

Судруудыг Судлах нь



Марк 10-ыг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Хаант Улсад Агуу Болох нь

Марк 10:17-22 дахь түүхэнд нэг баян залуу хүн мөнх амьдралыг өвлөхийн тулд тэрээр юу хийвэл зохихыг мэдэхийг хүссэн тухай, мөн шүлэг 35-45-д Аврагчийн дэргэд үүрд мөнхөд хүндэтгэлийн суудалд суухыг хүссэн Иаков, Иохан нарын тухай бид уншдаг.

1. Дараах схемийг тэмдэглэлийн дэвтэртээ хийж, Марк 10 дахь мэдээллээр үүнийг бөглөн, хаант улсад агуу байдлыг хүссэн хүмүүсийн тухай энэ хоёр түүхийг харьцуул.

Хэн Бэ?	Тэд юуг ойлгоогүй вэ	Есүс тэдэнд юу заасан бэ
Баян залуу (Марк 10:17-22)		
Иаков, Иохан хоёр (Марк 10:35-45)		


2. Агуу байх гэдэг нь ямар утга учиртай талаар Есүс Марк 9:33-37-д юу заасан бэ?
3. Марк 10:28-30-д өгүүлснээр, дэлхийн агуу байдлыг мөнх амьдралд тэнцэх хүмүүст Есүсийн санал болгосон зүйлтэй хэрхэн харьцуулж болох вэ?
4. Марк 10:32-34 нь Аврагчийн агуу байдлын талаар бидэнд юу заадаг вэ?
5. Бурханы мэлмийд агуу болохын тулд та нар амьдралдаа юу хийж болох вэ?

Б Харалган Байдлаас Эдгээгдэв

1. Марк 10:46-52 дахь хүн харалган байдлаас эдгээгдэхийн тулд юу хийснийг жагсаа.
2. Энэ түүх Аврагчийн тухай бидэнд юу заадаг болон Тэрээр бидний төлөө юу хийж чадах вэ?

Марк 11-12


Сүүлчийнхээ Долоо Хоногт Есүс Юу Хийж, Юу Заасан Бэ?



Марк 11 нь Есүсийн баптисмаас гурав орчим жилийн дараагаас эхэлдэг. Нэг долоо хоногийн дотор Тэрээр цовдлогдох учиртай байв. Марк 11-16 дахь үйл явдлууд Дээгүүр Өнгөрсний Баярын долоо хоногт буюу – бүх газрын Иудейчүүд ариун сүмд өргөл өргөхийн тулд Иерусалимд цугладаг үед болж өнгөрсөн байна. Энэ үе бол Есүсийн хувьд Тэрбээр бүх хүн төрөлхтний гэтэлгэлийн тулд Өөрийгөө Бурханы Хурга болгон өргөхөөр бэлтгэгдэж байсан тухай Өөрийн сүүлчийн гэрчлэлийг үй олон хүмүүст хүргэх боломж байлаа.

Марк 11-12-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 11—Матай 21:1–27; Лук 19:29–48; 20:1–8; Иохан 12:14–19
 Марк 12:1–12—Матай 21:33–46; Лук 20:9–19
 Марк 12:13–44—Матай 22:15–46; Лук 20:20–47; 21:1–4



Байрзүйн зураг

Судруудыг Ойлгох нь



Марк 11

Эсрэг талд чинь (ш.2)—
 Өмнө чинь
 Хувцас (ш.7–8)—Хувцас
 хунар
 Дэвсэх (ш.8)—Дэлгэх, дэл-
 гэж тавих
 Орой болох (ш.11)—Орой
 болох

Магад (ш.13)—Магадгүй
 Хатчихаж (ш.21)—Үхчихэж
 Хэн нэгний эсрэг ямар нэг
 юм (ш.25)—Хүний талаарх
 ямар нэг муу бодол

Марк 11:1–10—Есүс Илжиг Унаж Хот Уруу Орсны Ач Холбогдол Юу вэ?

Матай 21:1–11-ийн “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз (х.35).

Марк 11:15–18—Мөнгө Солигчид болон Хүмүүс Яагаад Ариун Сүмд Наймаа Хийж Байсан бэ?

Матай 21:12–13-ын “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз (х.35).

Марк 11:12–14, 20–21—Зүхэгдсэн Инжирийн Мод



Инжир жимстэй
 инжирийн мөчир

хожуу гарч ирдэг. Хэрэв инжирийн мод жимсээ эрт өгөхгүй бол, жилийн турш жимсээ өгдөггүй ажээ. Навчтай

Инжирийн модыг Тэрээр яагаад зүхсэнийг Есүс тайлбарлаагүй ч гэсэн, судруудад дүрсэлсэн нөхцөл байдалтай холбоотой, инжирийн моддын тухай багаахан мэдлэг нь Есүсийн хийсэн зүйлийн бэлэгдлийг ойлгоход бидэнд тусалдаг билээ. Марк 11-д дурдсан тэр төрлийн инжирийн модны жимс эрт, тэр ч байтугай, навчаар дүүрэхээсээ өмнө ургадаг аж. Инжир жимсний үндсэн ургац нь

модод (Марк, Матай аль алинд нь дүрслэгдсэнчлэн) мөн жимс өгөх ёстой ч уг мод жимсгүй, хувхайрсан байв. Тэр мод гаднах байдлаараа жимстэй мэт боловч, хэрэг дээрээ жимсгүй байжээ гэдгийг бид хэлж чадна. Энэ бол Есүсийн үе дэх Иудейчүүдийн удирдагчидтай адилхан юм. Тэд гаднах байдлаараа зөв шударга мэт харагдавч хоёр нүүр гаргадаг, зальхай, зөв шударга ёс нь хоосон зүйл байлаа. Үүний улмаас, Бурханы гэрээт хүмүүсийн удирдагчдын байдлыг бэлэгдсэн хоёр нүүртийн мод гэж зүхсэн ажээ.

Цаг нь болоогүй учраас уг модонд жимс байгаагүй гэж Маркийн шастирт өгүүлжээ; хэдий тийм ч, Иосеф Смитийн Орчуулга энэ өгүүлбэрийг авч, навч нь гарсан учраас энэ модонд жимс байх ёстой гэдгийг харуулжээ.

Марк 11:30–32; 12:12—Ахлах Тахилчид, Хуулийн Багш Нар хийгээд Ахмадууд “Хүмүүсээс Айв”



Иудейчүүдийн эдгээр удирдагчдыг тэдний хоёр нүүрт байдлын учир (жишээ нь, Марк 12:38–40-ийг үз) Есүс ээмлэн буруутгахаа үргэлжлүүлсээр байв. Марк 11–12 тэдний хоёр нүүрт байдлын эх сурвалж нь бардамнал гэдгийг өгүүлдэг. “Уг бардамнал нь Бурханы шүүлтээс илүүгээр хүмүүний шүүлтээс эмээх явдалд оршиж байв (D&C 3:6–7;

30:1–2; 60:2-ыг үз). “Миний тухай хүмүүс юу гэж бодож байна гэдэг нь, миний тухай Бурхан юу гэж бодох бол?” гэдгээс илүү жинтэй байлаа” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон заажээ (in Conference Report, 1989 оны 4-р сар, 4; Ensign, 1989 оны 5-р сар, 5).

Марк 12

Хашаа (ш.1)—Хайс, явган хашаа
 Усан үзэм шахах сав (ш.1)—Усан үзмийн модноос жимсний шүүс шахаж авах сав
 Түрээслээд (ш.1)—Түрээсээр өгөөд
 Тариаланчид (ш.1–2)—Ургацыг тордож анхаарал тавьдаг хүмүүс
 Өв залгамжлагч (ш.7)—Өв хөрөнгө хүлээн авах эрхтэй хүн
 Урхидаж барих (ш.13)—Мэхлэх
 Хэнд ч тал засдаггүй (ш.14)—Хүн болгонд тэгш хандах
 Албан татвар (ш.14)—Татвар

Хоёр нүүр гаргах (ш.15)—Зөв шударга биш атлаа зөв шударга дүр эсгэх
 Дүрс, бичээс (ш.16)—Зоосон дээр бичсэн үгс
 Үр удам (ш.20–22)—Хүүхдүүд
 Ухаалгаар (ш.34)—Ухаантайгаар, цэцнээр
 Зүрхлэх (ш.34)—Зориглох
 Мэндлүүлэх (ш.38)—Хүндэтгэн мэндлэх
 Цөлмөх (ш.40)—Эмэгтэйн эзэмшдэг юмыг дээрэмдэх
 Дүр үзүүлэх (ш.40)—Дүр эсгэх, дүр үзүүлэх
 Хоёр жижиг ээс зоос (ш.42)—Өчүүхэн бага мөнгө

Марк 12:18–27—Амилуулалт дахь Гэрлэлт
Лук 20:27–38-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг үз (х.33).

Марк 12:28–34—“Эдгээрээс Илүү Агуу Зарлиг Сгүй”
Матай 22:36–38-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг үз (х.35).

Судруудыг Судлах нь

Марк 11–12-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг нь хий.

А Тэд Хэрхэн Хариулж Болох Байсан бэ?

Марк 11:1–11-ийн түүхэн дэх хүмүүстэй та нар ярих боломжтой байжээ гэж бод. Тэдэнд хандаж тавьсан дараах жагсаалт дахь асуултуудад тэд хэрхэн хариулах байсан гэж та нар бодож байна.

1. Хоёр шавьд: Дудранг хэрхэн олж авах талаар Есүс яагаад тусгай заавар өгсөн бэ? Дудранг олж авсан арга замынхаа талаар та нар юу бодсон бэ?



2. Дудрангийн эзэнд: Есүсийн хоёр шавьд дудранг авахыг та яагаад зөвшөөрсөн бэ?
3. Зам дээр хувцсаа дэвсэж, Хосанна гэж хашигирсан хүмүүсийн нэгэнд: Есүсийг та хэн гэж боддог вэ? Та яагаад Түүнийг хүндэтгэдэг вэ?

Б Бэлэгдлийг Тайлбарла

Марк 11:12–14, 20–23 дахь инжирийн модны тухай түүхийг, тэрчлэн Марк 11-ийн “Судруудыг Ойлгох нь” хэсгийн тайлбарыг анхааралтай үз. Есүсийн зүхсэн инжирийн мод нь өнөө үед ямар хүнийг төлөөлж чадна гэж та нар боддог вэ? Тийм хүн хэрхэн үйлдэж, хэрхэн ярьж болохыг тайлбарла.

В Юуг Хийх Ёсгүй Вэ?

Марк 11:27, 12:40 дэх түүхүүд хийгээд заасан зүйлүүдэд Есүсийг эсэргүүцсэн буюу түүнээс асуултууд асуусан Иудейчүүдийн удирдагчдын нотолсон гурван үйлдэл буюу хандлагыг сонгож ав. Эдгээр үйлдлүүд буюу хандлагууд сүнсний хувьд өсч хөгжихөөс хүнийг хэрхэн саатуулж болохыг тайлбарла.

Г Захиас нь Юу Вэ?

Марк 11–12-ын их хэсэг нь Иудейчүүдийн удирдагчид Есүсийг хэрхэн эсэргүүцсэн тухай өгүүлдэг. Тэдэнтэй огт адилгүй нэг эмэгтэйн тухай бид Марк 12:41–44-т уншдаг.

1. Тэр бэлэвсэн эмэгтэй Марк 12:29–34 -т Есүсийн заасан зүйлийн үлгэр жишээ хэрхэн болох вэ?



2. Марк 12:44-ийн захиасыг өөрийнхөө үгээр бичиж, Есүс Христ юу зааж байсан гэж боддогоо тайлбарла.
3. Золиослол хийгээд дуулгавартай байдлын талаарх энэ бэлэвсэн эмэгтэйн үлгэр жишээг дагахын тулд амьдралдаа өөрчлөлт гаргаж чадсан ямар нэг зүйлийн тухай бич. (Энэ нь зөвхөн мөнгөнд хамаатай биш.)

Марк 13

Хоёр Дахь Ирэлтийн Тэмдгүүд

Аврагч цовдлолтоосоо долоо хоног хүрэхгүйн өмнө Өөрийн Хоёр дахь Ирэлтийн тухай өгүүлсэн байдаг. Зарим Иудейчүүд Есүсийг Түүний мөнх бус байдал дахь тохинууллын үед эсэргүүцэж байв, учир нь Мессиагийн ирэлтийн талаарх Хуучин Гэрээний бошиглолуудыг Тэрээр гүйцэлдүүлсэнд тэд, ялангуяа Түүнийг сүр жавхлан хийгээд шүүлтээр ирнэ гэж ярьдаг байсан хүмүүс итгэхгүй байжээ. Гэсэн хэдий ч, Христийн тухай Хуучин Гэрээний Бошиглолууд Түүний анхны болон хоёр дахь ирэлтийн аль алиных нь тэмдгүүдийг агуулсан байдаг. Тэрээр олон бошиглолыг гүйцэлдүүлсэн хэдий ч, Тэрээр дахин ирж Мессиагийн талаар бошилогчдын хэлсэн бүх зүйлүүдийг гүйцэлдүүлэх болно гэдгийг мэдэх нь Түүний шавь нарыг тайтгаруулах учиртай байв. Марк 13-т Есүс эцсийн өдрүүдийн тухай ихийг өгүүлсэн учраас эцсийн өдрүүдэд амьдарч байгаа бид эдгээр судруудыг онцгойлон сонирхох ёстой.

Марк 13-ын Иосеф Смитийн Орчуулга нь Иосеф Смит—Матай буюу Матай 24-ын Иосеф Смитийн Орчуулгатай адил юм.

Марк 13-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 13—Матай 24; Лук 21:5–36; Иосеф Смит—Матай 1

Судруудыг Ойлгох нь



Марк 13

Эсрэг талд (ш.3)—Өмнө нь, нөгөө талд

Болгоомжтой бай (ш.5, 9, 23, 33)—Сэрэмжтэй бай, анхааралтай бай

Тунхаглагдсан (ш.10)—Заагдсан, номлогдсон

Урьдаас бүү санаа зов (ш.11)—Урьд нь бүү шийд

Тушаах (ш.12)—Урвах, нүүр буруулах, эргэх

Хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүд (ш.17)—Хүүхдээ хөхүүлдэг эхчүүд

Сонгосон хүмүүс (ш.20, 27)—Гэрээт хүмүүс

Төөрөгдүүлэх (ш.22)—Буруу замаар хөтлөх, төөрөгдүүлэх

Гай гамшиг (ш.24)—Гай зовлон

Хаалгач (ш.34)—Үйлчлэгч, хаалгач

Марк 13:14 “Жигшүүрт Бузар Юм”

Матай 24:15-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг үз (х.39).

Судруудыг Судлах нь



Марк 13-ыг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Болгоомжил!

Марк 13-т (шүлэг 5, 9, 23, 33, 35, 37-г үз) цэдэглэгдсэн номлолд Есүс Өөрийг нь дагадаг хүмүүст “болгоомжил”, “сэрэмжил” гэдэг үгийг зургаан удаа давтан хэлсэн байдаг. Их Эзэнийг угтахын тулд итгэгчид юунаас болгоомжлох талаар энэ бүлгээс наад зах нь гурван зүйлийг жагсаа.



Марк 14

Есүсийн Мөнх Бус Амьдралын Сүүлчийн Цагууд

Ахлах тахилчид, хуулийн багш нар, тэрчлэн Иудейчүүдийн ахмадууд Дээгүүр Өнгөрсний Баяраар Иерусалимд цугласан хүмүүсийн өмнө Есүсийг ичээж, эсвэл Түүгээр Өөрөөр нь алдаа гаргуулж чадсангүй. Хэрэг дээрээ, Иудейчүүдийн удирдагчид өөрсдийгөө ичгүүрт тавьсан юм. Тэдгээр ялзарсан удирдагчдын

зарим нь, өөрсдийнх нь албан тушаал болон эрх мэдэлд илүү аюул занал учруулахаас Есүсийг хол байлгах цорын ганц арга бол Түүнийг алах явдал гэж үзэж байлаа. Есүс тэдний хүслийг мэдэж байсан бөгөөд Өөрийн амийг өгөхөөр бэлтгэж байжээ. Түүхэн дэх зарим хамгийн чухал үйл явдлууд Марк 14–16-д цэдэглэгдсэн билээ. Маркийн эдгээр сүүлчийн бүлгүүд дэх эрхэм ариун үйл явдлуудыг уншихдаа тунгаан бодох цаг гарга.



Марк 14-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 14:1–2—Матай 26:1–5; Лук 22:1–2

Марк 14:3–9—Матай 26:6–13; Иохан 12:1–8

Марк 14:10–16—Матай 26:14–19; Лук 22:3–13

Марк 14:17–31—Матай 26:20–35; Лук 22:14–39, Иохан 13

Марк 14:32–42—Матай 26:36–46; Лук 22:40–46

Марк 14:43–72—Матай 26:47–75; Лук 22:47–62; Иохан 18:1–27

Судруудыг Ойлгох нь



Марк 14

Эсгээгүй талх (ш.1, 12)—Дээгүүр Өнгөрсний Баярын зоогийн нэг хэсэг, хөрөнгөөр эсгээгүй талх

Далдуур (ш.1)—Шударга бусаар

Гөлтгөнө (ш.3)—Үнэтэй бодис

Цэвэр нардын их үнэтэй үнэрт тос (ш.3)—Анхилуун үнэртэй үнэт тос

Дургүйцэх (ш.4)—Ямар нэг зүйлийг зөв биш гэж үзэн дургүйцэх, уурлах

Гурван зуун динар (ш.5)—Ердийн нэг ажилчны жилийн цалин

Барьж өгөх (ш.10, 18)—Хүний эсрэг эргэж, дайсанд нь барьж өгөх

Гэрээ (ш.24)—Гэрээ

Бүр их хүчлэн (ш.31)—Ихэд хүчлэн

Үлдээд . . . бай (ш.34)—Үлдээд хүлээж бай

Аав аа (ш.36)—“Эцэг” гэсэн утгатай үг

Мэдсэн (ш.40)—Мэдэв

Тэр нь мөн (ш.14)—Тэмдэг

Хүү татаад (ш.63)—Ураад (санаагаар унасны тэмдэг болгон)

Нударгалан жанчих (ш.65)—Зодох, цохих

Чи бас Галилын хүн байна (ш.71)—Чи тэндээс ирсэн юм шиг аялгатай байна

Тангараглаж (ш.71)—Андгайлж буюу амлаж

Марк 14:3–9—Есүсийг Нэг Эмэгтэй, Тосоор Тослов



Мария Христийн Хөндий, Тосоож Байсан нь, Роберт Т. Барретт, © Robert T. Barrett

Энэ эмэгтэй бол Мартагийн болон үхэгсдээс Есүсийн босгосон Лазарын эгч Мариа байсныг Иохан 12:3 бидэнд өгүүлдэг (Иохан 11-ийг үз). Маш их үнэртэй тосоор тосолсон үйлдэл нь Есүсийг гүнээ хүндэтгэсэн, бас шүтлэг бишрэллийн үйлдэл байлаа. Түүнчлэн цогцсыг оршуулахын өмнө тосолдог заншил байв. Энэ тохиолдлыг Тэрбээр амиа

өргөхөд бэлтгэж байсныг шавь нарынх нь олонх нь ойлгохгүй байсан, эсвэл итгэхийг хүсэхгүй байсан тэрхүү үнэнийг шавь нартаа дахин хэлэх боломж болгон ашигласан байна.

Марк 14:20—“Надтай Хамт Нэг Тавганд Гар Дүрж Байгаа нь”

Иохан 13:25-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг үз (х.100).

Марк 14:32–42—Гетсемани

Матай 26:36–46-гийн “Судруудыг Ойлгох нь”-ыг үз (х.42).

Марк 14:33—Яагаад Есүс “Ихэд Зовж” мөн “Ихэд Шаналж Байсан Бэ”?


Цагаатгалын шаналал Гетсеманид эхэлсэн билээ. Ерөнхийлөгч Иосеф Фийлдинг Смит, “Ямар нэг буруу зүйл хийгээд дараа нь харуусдаггүй, бидэнд байдаггүй ч болоосой гэж хүсдэг . . . бидний нэг ч байдаггүй. Бидний ухамсар биднийг доргиож, бид нэн харуусалтай, нэн өрөвдмөөр хөөрхийлөлтэй болдог. . . Гэвч тэнд [Гетсеманид] миний гэм буруугийн, таны гэм буруугийн, бас Есүс Христийн сайн мэдээг хүлээн авдаг бодгаль бүрийн гэм буруугийн ачааг үүрсэн Бурханы Хүү бидэнд байсан. . . Тэрбээр ачааг—бидний ачааг үүрсэн юм. Би үүн дээр ямар нэг зүйл нэмсэн; та нар ч бас тэгсэн. Бусад нь ч бас бүгдээрээ тэгсэн. Би үүнээс зугтааж болох байсан, та нар ч зугтааж болох байсан тэрхүү төлөөс—бид түүний сайн мэдээг хүлээн авч үүнд үнэнч итгэлтэй байх нөхцлийн шийтгэлийг Тэрбээр Өөр дээрээ үүрсэн билээ” гэж тайлбарлажээ (*Fall—Atonement—Resurrection—Sacrament* [Солт Лейк дахь Шашны Институт дээр хэлсэн үг, 1961 оны 1-р сарын 14], 8).

Марк 14:54–59—Худал Гэрчүүд

Матай 26:59–60-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг үз (х.42).

Марк 14:66–72—Петр Есүсийг Сгүйсгэв

Лук 22:31–34, 54–62-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг үз (х.83).



Судруудыг Судлах нь

Марк 14-ийг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Та Аврагчийг Хэр Зэрэг Ихээр Снэлдэг Вэ?

Аврагчийг хэр их үнэлдэг болохоо харуулсан хоёр хүний тухай бид Марк 14:3–11-д уншдаг.

1. Тэр эмэгтэй Аврагчийг мөнгөнөөсөө илүү их хайрладаг байсныг түүний үйлдэл хэрхэн харуулсан бэ?
2. Тэрээр Аврагчаас илүүгээр мөнгийг үнэлдэг гэдгийг Иудасын үйлдэл хэрхэн харуулсан бэ?
3. Та нар дэлхийн зүйлүүдээсээ илүүгээр Аврагчийг хайрладаг гэдгээ харуулах ямар арга замууд байна вэ?

Б “Би Гайхширна”


“Би Гайхширна” дуулалд, Өөрийн Цагаатгалаар дамжуулан Есүсийн бидэнд илэрхийлсэн хайрыг бид хичнээн гайхан биширдэг тухай бид дуулдаг (Дуулал 84-ийг үз). Марк 14-өөс, таныг “гайхан бишрүүлж”, мөн Түүнийг илүү ихээр үнэлэн хүндэтгэхэд тань та нарт тусалсан хоёр зүйлийг сонго. Энэ хоёр зүйлийн тухай бичиж, эдгээр яагаад таныг гайхан бишрэхэд хүргэж, Аврагчийг гүнээ хайрлан хүндэтгэж, өндрөөр үнэлэх болгосныг ярь.

Марк 15

Есүс Цовдлогдов

Цагаатгал Гетсеманид эхэлсэн бөгөөд Голготад загалмай дээр төгссөнийг Марк 15-д цэдэглэсэн байдаг.

“Цовдлолтоорх үхэл нь цаазаар аваачих бүх хэлбэрүүдээс хамгийн удаан тарчилган зовоодог, хамгийн их өвтгөдөг нь яах аргагүй мөн байлаа. Хохирогч их тарчлан зоволтод ерөнхийдөө олон цаг, заримдаа олон хоног байдаг байжээ. . . . Намдаагдацгүй хүчтэй өвдөлтөөр бий болсон туйлдалтаар дамжин үхлийн таатай тайвшрал ирдэг” хэмээн Арванхоёр Төлөвлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Жеймс Е.Талмейж бичжээ (Jesus the Christ, 655). Сургаал ба Гэрээ 19:16–19-д, Гетсеманид Түүний үзсэн өвдөлт, загалмай дээр Түүний туулж өнгөрүүлсэн шаналал зовлонгоос илүү их байсан тухай Есүс хэлсэн байдаг. Манай нэгэн дуулал: “Ямар зовлонг тэр үүрснийг бид мэдэхгүй байж магад, бид хэлж чадахгүй, харин бидний төлөө тэр дүүжлэгдэж, тэнд зовсонд бид итгэдэг” хэмээн өгүүлдэг билээ (“Алс Тэртээх Ногоон Толгод”, Дууллууд 194). Энэ бүлгийг уншихдаа “[таны] төлөө тэрээр тэнд дүүжлэгдэж, зовсон юм” гэснийг оюун ухаандаа санан хадгалагтун.



Марк 15-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 15:1–19—Матай 27:2, 11–30; Лук 23:1–25; Иохан 18:28–19:16

Марк 15:20–41—Матай 27:31–56; Лук 23:26–49; Иохан 19:16–37
Марк 15:42–47—Матай 27:57–61; Лук 23:50–56; Иохан 19:38–42

Судруудыг Ойлгох нь



Марк 15

Пилат (ш.1–15)—Иерусалим дахь Ромын захирагч	Хурсан олонд нийцүүлэх (ш.15)—Хүмүүсийг сэтгэл ханамжтай байлгах
Гайхав (ш.5, 44)—Гайхав	Сүлжээд (ш.17)—Томох, сүлжих
Баяраар (ш.6)—Дээгүүр Өнгөрсний Баяраар	Албадах (ш.21)—Хүчээр тулгах
Бослого (ш.7)—Засгийн газрын эсрэг бослого	

Мирртэй дарс (ш.23)—Өвдөлтийг мэрүүлдэггүй холимог

Хувцсыг нь хоорондоо хуваав (ш.24)—Хувцсыг нь хувааж авав

Хэн авахаа үзэхээр шодож (ш.24)—Хувцсыг нь хэн авахаа шодолтоор үзэх

Ялынх нь пайз (ш.26)—Түүнийг гэмт хэрэгт яллахаар бичсэн зүйл

Басамжлан (ш.29)—Шоолон

Доромжилж (ш.32)—Дорд үзэх

Орой (ш.42)—Үдэш

Булш (ш.46)—Булш, бунхан, нас барагсдыг оршуулдаг газар

Ухаж янзалсан (ш.46)—Ухаж гаргасан

Марк 15:34—“Миний Бурхан, Миний Бурхан, Юунд Та Намайг Орхив?”

Эдгээр үгс түүнчлэн Дууллын 22:1 дэх Мессиагийн тухай бошиглолд байдаг. Өөрийн Хүүгээр бүрэн хийгээд төгс цагаатгалыг гүйцэлдүүлэх нь Эцэгийн хувьд зайлшгүй чухал байсан ажээ. Есүс үнэхээр “бүх зүйлийн дор бууж ирсэн билээ” (С ба Г 88:6).

Судруудыг Судлах нь



Марк 15-ыг судлахдаа үйл ажиллагаа А-г хий

А Тэр Мэддэг мөн Ойлгодог

Аврагч бүхий л төрлийн зовлон шаналлуудтай хүмүүст туслах болно гэдгээ тэрээр мэдэж байсан болохоор Тэрээр тийнхүү үйлдсэнийг бид Алма 7:11–13-т уншдаг. Марк 15-д болсон үйл явдлаас, өнөөгийн хүмүүст тулгарч байгаа, Есүсийн туулж өнгөрүүлсэн туршлагаудтай адил төстэй, хүнд бэрх туршлагаудаас наад зах нь гурвыг жагсаа. Жагсаасан туршлага бүртээ, Есүст бас тохиолдож байсан судрын ишлэлийг нэрлэ.

Марк 16

“Тэр Энд Байхгүй”

Есүст бүхнээ зориулсан дагалдагчид нь байсан хэсэг эмэгтэйчүүдийн тухай Марк 15:40–41-д өгүүлдэг. Хүндэтгэл хийгээд тийм их зовлон шаналлыг амссан хүнийг харах нь тэдний хувьд, ялангуяа Амилуулалтын талаар тэд ямар хэмжээгээр ойлгож байсныг нь бид мэдэхгүй болохоор, тэдэнд их хэцүү байжээ. Амилуулалтын талаар Есүс Өөрийнхөө дагалдагчдад ярьсан хэдий ч, тэд ойлгоогүй бололтой (Марк 9:31–32-ыг үз). Тэдний өөрсдийгөө зориулсан байдлын улмаас эдгээр эмэгтэйчүүд Есүсийг нүд анхтал загалмайн дэргэд байж, Түүнийг хаана оршуулсныг

харахаар дагалдан явсан билээ (Марк 15:47-г үз). Тэд Хүндэтгэлийн Өдрөөр Аврагчийн бие махбод болоод Түүний Булины талаар юу ч хийж болохгүй байсан хэдий ч, Хүндэтгэлийн Өдрийн маргааши нь хамгийн эрт тэнд очжээ. Марк 16-г уншихдаа, тэдэнд юу бодогдож, юу санагдаж байсан байж болохыг төсөөлөн бодохыг хичээ.



Марк 16-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Марк 16:1–8—Матай 28:1–8; Лук 24:1–12; Иохан 20:1–10

Марк 16:9–11—Матай 28:9–10; Иохан 20:11–18

Марк 16:12–13—Лук 24:13–35

Марк 16:14–18—Матай 28:16–20; Лук 24:44–49

Марк 16:19–20—Лук 24:50–53

Судруудыг Судлах нь

Марк 16-г судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Та нар Юу Хэлэх Байсан Бэ?

Марк 15:40–41, 47; 16:1–11-д эдгээр итгэлт эмэгтэйчүүдийн үзэж, хийсэн зүйлийг та нар харж, бас хийсэн гэж төсөөлөн бод. Есүс Христийн Амилуулалтын талаар эргэлзэж байсан найздаа юу гэж хэлэх байснаа бич. Тэр гурван өдөр өөртөө төрөх байсан бодол хийгээд яагаад тийнхүү үйлдсэнээ энэ найздаа тайлбарла.

Б Слгэр Жишээ Сзүүл

1. Марк 16:14–18-ыг унш. Есүс шавь нар дээрээ хүрч ирээд, юу хийхийг тэдэнд хэлсэн бэ? Тэрээр тэдэнд юу амласан бэ?



2. Өнөө үед гүйцэлдэж байгаа, Есүсийн амласан тэмдгүүдээс наад тал нь нэг жишээ гаргаж, үүний тухай бич. Хэрэв та ямар ч жишээ мэдэхгүй бол, эцэг эхтэйгээ, Сүмийн орон нутгийн удирдагчидтай, эсвэл эргэж ирсэн номлогчтой ярилц.



Судруудыг Ойлгох нь

Марк 16

Бусаддаа (ш.13)—
Үлдсэндээ, бусаддаа

Тухлан сууж (ш.14)—
Хооллож

Зэмлэв (ш.14)—Загнав
Яллагдах (ш.16)—Өсөлт
хөгжилт нь зогсох

Гэгээнтэн Лукийн Сайн Мэдээ

Лук Гэж Хэн Байсан бэ?

Лук бол энэ сайн мэдээ болон Үйлсийн номыг бичсэн грек эмч хүн байлаа. Лук иудей хүн байгаагүй ч гэсэн грекийн соёлд сайн боловсорсон байжээ. Тэрбээр газар дээрх Аврагчийн тохинууллыг нүдээр харсан гэрч байгаагүй бололтой, гэвч Есүсийн тухай Төлөөлөгч Паул болон бусад номлогч нараас мэдэж авчээ. Тэрээр Паултай хамт номлолын олон аялалд явж, Сүмийн өсөлтийн тухай Харийнханы дунд гэрчилсэн билээ (Үйлс 16:10; 2 Тимот 4:11-ийг үз).

Энэ Ном Яагаад Бичигдсэн бэ?



Лук энэ гэрчлэлийг өөрийн найз, мөн грек хөрвөгч байсан бололтой Теофилд, түүнийг Есүс Христийн тухай үнэнийг мэдээсэй хэмээн бичжээ. Энд Есүсийн хэлж, хийж байсан зүйлүүдийн талаар өөр олон шастир орсноос зарим нь үнэн, зарим нь үнэн биш байв. Тэрээр олон еврей үгийн утгыг тайлбарлаж, бас иудей биш хүмүүстэй Есүсийн харьцсан нилээд хэдэн түүхийг өгүүлсэн болохоор Лукийн оюун санаанд иудей биш уншигчид байсан бололтой.

Энэ Ном Матай болон Маркаас Юугаараа Ялгаатай Вэ?

Матайн сайн мэдээ нь амлагдсан Мессиагийн тухай Хуучин Гэрээний бошиглалуудыг Есүс гүйцэлдүүлсэн гэдгийг иудейчүүдэд харуулахын тулд бичигджээ (хуудас 10 дахь Матайн номны оршлыг үз). Есүс бол олон гайхамшгийг үйлдсэн Бурханы хүч бүхий Хүү нь, Цагаатгалын хамгийн агуу хүмүүн биет байсныг харуулжээ. Харийн хүний хувьд Лук Есүс Христийн сайн мэдээний талаар онцгой хэтийн төлөвтэй байжээ. Лукийн гэрчлэл бол Сайн Мэдээнүүдээс хамгийн урт нь юм. Энэ нь сайн мэдээний бусад зохиогчдын дурдаагүй олон мэдээллийг агуулсан байдаг. Сайн мэдээ бол зөвхөн иудейчүүдэд төдийгүй, харин бүх хүмүүст зориулагдсан юм гэдгийг тэр ойлгож, тиймээс Есүс Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүдийн төлөө зовон тарчилж, амиа өргөсөн гэдэгт онцгой анхаарал тавьжээ.

Зөвхөн Лукд

Зөвхөн Лукд байдаг зарим заасан зүйлүүдийг дор жагсаав:

- Захариа, Мари хоёр дээр Габриел хүрч ирсэн нь (Лук 1:5–20, 26–38)
- Бетлехемд Есүс Христийн мэндэлсэн тухай нарийн тодорхой зүйлүүд (Лук 2:1–20-ийг үз).
- Симеон, Анна хоёрын гэрчлэлүүд (Лук 2:21–38-ыг үз)
- Арван хоёр настай Есүс ариун сүмд (Лук 2:40–52-ыг үз)
- Лук 10–19-д байдаг сургаалт зүйрлэлүүд
- Далыг дуудсан нь (Лук 10:1–16-г үз)

- Гетсеманид сүв бүрээс нь цус урсч байсан Христ (Лук 22:44-ийг үз).
- Загалмай дээрх хулгайчид, тэрээр Түүнтэй хамт диваажинд байх болно хэмээн хэлж буй Есүс (Лук 23:39–43-ыг үз)

Лук 1

Хоёр Гайхамшигт Төрөлт Угтан Хэлэгдэв



Хэвийн байдалд хүүхэдгүй байж болох хоёр эмэгтэй Бурханы гайхамшигаар дамжуулан хоёр хүүхэдтэй болсон тухай Лук 1-д өгүүлдэг. Энэ хоёр эмэгтэйн нэг нь хүүхэдтэй болоход нас хэтэрхий өндөр болсонд тооцогдож байхад, нөгөөх нь гэрлэж байгаагүй онгон залуу бүсгүй байлаа. Энэ бүлгийг уншихдаа энэ хоёр эмэгтэй хэн байсан, тэдний хүүхдүүд хэн байсан, түүнчлэн яагаад эдгээр төрөлтүүдийн талаар тусгай тэмдэглэл хийгдсэнийг үз.

Судруудыг Ойлгох нь



Лук 1

Бүлэг (ш.5, 8)—Гэр бүлийн доторх хувь хүний үр удам
Хүүсэр (ш.7)—Хүүхэд төрүүлэх боломжгүй
Өтөлсөн (ш.7, 18)—Өндөр настай болсон
Гүйцэтгэж байсан (ш.8)—Гүйцэтгэж, хийж байв
Үүрэг (ш.9)— Ажил, үүрэг
Дохиж зангав (ш.22)—Хөдөлгөөн хийв, эсвэл гардаллав

Алба гүйцэтгэх өдрүүд дуусав (ш.23)—Үйлчлэх хугацаа дуусав
Жирэмслэв (ш.24, 36)—Жирэмсэн болов
Шившиг (ш.25)—Гутамшиг (Элизабет болон гэрлэсэн боловч хүүхэдгүй бусад эмэгтэйчүүд, хүүхэдгүйн улмаас бусад хүмүүс тэднийг дорд үздэг гэж боддог байв)

Сүй тавьсан (ш.27)—Сүй тавив (мөн Матай 1:18–19-ийн “Судруудыг Ойлгох нь”-ыг үз, (х.12).

Бодож цэгнэв (ш.29)—Бодов Мэндчилгээ (ш.29, 41, 44)—Мэндчилгээ

Хэвлий дэх үр чинь (ш.42)—Хүүхэд чинь

Даруу байдал (ш.48)—Энгийн даруу байдал

Хөвч хөндөх (ш.59)—Эрэгтэй хүүхдийг төрөөд найм хоносны дараа хөвчийг нь хөндөх ёслол үйлдэх

Авралын эвэр (ш.69)—Бурханы аврах хүчийг бэлэгдэн харуулахын тулд булан бүрийг нь бухын эврээр чимэглэсэн ариун сүм дэх тахилын ширээ

Мандах нар (ш.78)—Нар мандах үе

Лук 1:3—Теофил Гэж Хэн Байсан Бэ?

Теофил бол Лук түүнд зориулж энэ Сайн Мэдээг бичсэн найз нь байлаа. Тэр нэг бол Сүмийн гишүүн болсон, эсвэл үүний тухай судалж байсан Харь хүн байсан бололтой, тэгээд Лук түүнийг үнэнийг мэдээсэй хэмээн хүсч байжээ (Лук 1:3–4-ийг үз).

Лук 1:17—“Елиагийн Хүч Болоод Сүнс”

Елиа бол Хуучин Гэрээний бошиглогч байв. “Елиагийн сүнс бол Аароны томилогдсон Санваар болох . . . Бурханы агуу илчлэлтэд замыг бэлтгэх явдал мөн” гэж Бошиглогч Иосеф Смит тайлбарлажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 335). Иохан Баптист энэ үүргийг бүхий л арга замаар биелүүлж байв. Тэрээр Аароны санваарыг агтаж байсан бөгөөд Есүс Христээс ирэх илүү агуу сургаалууд хийгээд ёслолуудын төлөө замыг бэлтгэж байлаа.

Лук 1:19—Габриел Гэж Хэн Байв?

Бошиглогч Иосеф Смит Габриел бол Хуучин Гэрээний бошиглогч Ноа юм гэдгийг үзүүлсэн.

Лук 1:31—“Түүнийг Есүс Гэж Нэрлэ”

Есүс бол Иошуа буюу Жешуа гэдэг еврей нэрийн грек хэлбэр юм. Энэ нь “Бурхан бол тусламж” буюу “Аврагч” гэсэн утгатай.

ХОЁР ГАЙХАМШИГТ ТӨРӨЛТ

Уг түүхийн талаарх судрын ишлэл	Лук 1:1–25	Лук 1:26–38
Эцэг эхийнх нь нэр хэн байсан бэ?		
Тэд хүүхэдтэй болох гэж байгаагаар хэрхэн мэдсэн бэ?		
Өөрсдөд нь өгөгдсөн мэдээнд тэд хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ?		
Яагаад төрөлтийг гайхамшиг гэж үзсэн бэ?		
Тэд хүүхдэд ямар нэр өгсөн бэ?		
Тэд нэрийг хаанаас авсан бэ?		
Өсөх үед нь энэ хүүхдийн тусгай үүрэг зорилго юу байсан бэ?		

Лук 2

Аврагч Мэндлэв

Судруудыг Судлах нь

Лук 1-ийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Хоёр Гайхамшигт Төрөлт

1. Дараах схемийг тэмдэглэлийнхээ дэвтэрт хийж, Лук 1 дэх мэдээллүүдээр бөглө.



Лук бол Есүс Христийн төрөлтийн талаарх олон нарийн тодорхой зүйлийн тухай бидэнд өгүүлдэг, сайн мэдээний цорын ганцхан зохиогч юм. Эдгээр нь Цезарын хүн амын тооллого, Мариа, Иосеф хоёр Бетлехем уруу аялсан нь, тэжээлийн тэвшинд хүүхэд төрсөн нь, хоньчид хий-

гээд тэнгэр элчүүд, Симеон, Анна нар, тэрчлэн Есүсийн ариун сүмд заасныг багтаадаг. Яагаад Лук өөрийн харийн найз Теофил эдгээр зүйлүүдийг мэдээсэй гэж хүсч байсан гэж та нар боддог вэ?

Лук 2-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 2:1-39—Матай 1:18-25

Судруудыг Ойлгох нь



Лук 2

Нярайлах (ш.6)—Хүүхдээ төрүүлэх

Даавуунд ороож, даавуунд өлгийдөх (ш.7, 12)—Хүүхдийг даавуугаар ороож, өлгийдөх

Тэжээлийн тэвш (ш.7, 12)—Мал тэжээдэг сав

Баярлуулах сайн мэдээ (ш.10)—Сайн мэдээ

Яаран (ш.16)—Түргэн

Израилын Тайтгарал (ш.25)—Мессиа гэсэн утгатай Израилын тайтгарал буюу хөнгөвчлөл

Гэрлэснийхээ дараа (ш.36)—Гэрлээд дараа нь

Наян дөрвөн жил (ш.37)—Наян дөрвөн жил

Золилт (ш.38)—Гэтэлгэл; чөлөөлөлт; нүглийн үр дагавруудаас аврагдах

Хоногуудын тоог гүйцээх (ш.43)—Баяр тэмдэглэхийг дуустал хүлээв

Төрөл садан болон танилууд (ш.44)—Гэр бүл болон найз нөхөд

Дуулгавартай (ш.51)—Дуулгавартай; зөвлөмж хийгээд зөвлөгөөг дагав

Бие (ш.52)—Биеийн хэмжээ, гадаад төрх

Лук 2:21—“Найман Одор Дуусахад”

Абрахам болон түүний үр удамтай Их Эзэний хийсэн гэрээний тэмдэг болгон, Израилын угсааны бүх эрэгтэй хүүхдүүдийг төрөөд найм хоносных нь дараа хөвчийг нь хөнддөг байжээ (Эхлэл 17:12-ыг үз).

Лук 2:22—“Түүний Цэвэрших Одрүүд”

Шинээр төрсөн хүүгийн эхийг дөчин өдрийн дотор цэвэр биш гэж үздэг байв (тэрээр Мосегийн хуулийн ёслолуудад оролцох боломжгүй байдгийн улмаас). Дөч хоносны дараа тэр ариун сүмд очиж цэвэршилтийнхээ төлөө өргөл барьж болдог байжээ.

Лук 2:46-47—Есүс Ариун Сүмд Заав

Есүс биш, харин багш нар асуултуудыг асуусныг Иосеф Смитийн Орчуулга бидэнд өгүүлдэг (ИСО, Лук 2:46-г үз). “Түүний ойлголтууд хийгээд асуултуудад” тэдгээр багш нар гайхаж байжээ (Лук 2:47).



Лук 2:52—Есүсийн Залуу Сейин Хөгжилт

“Залуучуудын төгс эрүүл саруул байдлын хамгийн амжилттай, хүмүүнд мэдэгдсэн хөтөлбөр арван дөрвөн үгээр дүрслэгджээ. . . . Бурханы хийгээд хүмүүний тааллыг олохын тулд манай залуучууд мэргэн ухаан хийгээд бие бялдраар өсөхөд нь туслах залуучуудын төгс эрүүл саруул байдлын хөтөлбөр буй. Энэ нь юм бүхнийг—бие бялдын эрүүл мэнд, оюун санааны эрүүл саруул байдал, нийгмийн эрүүл саруул байдал, сэтгэл хөдлөлийн эрүүл саруул байдал, түүнчлэн сүнсний эрүүл саруул байдлыг багтаадаг” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон, Лук 2:52-ын талаар өгүүлэн заасан байдаг (*The Teachings of Ezra Taft Benson*, 555-56).

Судруудыг Судлах нь



Лук 2-ыг судлахдаа үйл ажиллагаа А, В буюу эсвэл зөвхөн Б-г хий.

А Христийн Мэндэлсний Түүх

Лук 2 нь Библи дэх хамгийн сайхан, хамгийн нэрд гарсан шастируудын нэгийг агуулдаг. Лук 2:1-16-г анхааралтай уншсаны дараа доорх зүйлийг хий:

1. Есүсийн төрөлтийн талаарх хамгийн чухал гэж өөрсдийн боддог наад тал нь зургаан асуултаар асуулт хариултын тэмцээн зохио. Асуулт бүрийн дараа, зөв хариулт болон хариу нь байгаа шүлгийг хаалтанд бич.
2. Христийн мэндэлсний баяраар Есүсийн тухай ярилцахад тохиромжтой гэж өөрсдийнхөө бодсон таван өгүүлбэрийг Лук 2:1-16-гаас жагсаа.

Б Христ Хүүхдийн Гэрчүүд

Лук 2-ыг уншиж, Есүсийг харсан хэмээн энэ бүлэгт дурдагдсан хүн бүрийг жагсаа. Нэр бүрийн дэргэд тэд Есүсийн тухай хэрхэн мэдснийг нь жагсаа.

В Хувь Хүний Өсөлтийн Загвар

Лук 2:40, 49-52-ыг уншсаны дараа Есүсийн өсч, хөгжиж байсан янз бүрийн салбаруудыг нэрлэ. Эдгээр салбаруудад та нар хэрхэн “өсч, хөгжиж” чадсан бэ?

Лук 3

Иохан Бурханы Хүүд Баптисм Хүртээв

Иохан Баптист Есүс хоёр үеэлүүд (Лук 1:36-г үз) бөгөөд Иохан Есүсээс ердөө л зургаан сар ах байжээ. Тэрбээр Есүс Христийн үүрэг зорилгын төлөө замыг нь бэлтгэхийн тулд илгээгдсэн байлаа. Та нар Лук 3-ыг судлахдаа Иохан хүмүүст юу зааж байсныг,

түүнчлэн Аврагчийг сонсоход бэлэн байхад нь тэдэнд тусалсан арга замуудыг олж хар.

Лук 3-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 3:1–22—Матай 3; Марк 1:2–1

Лук 3:23–38—Матай 1:1–17

Судруудыг Ойлгох нь

Лук 3

Захирагч (ш.1)—Засаглагч, засгийн тэргүүн

Уучлал (ш.3)—Уучлал, өршөөл

Ирэх уур хилэн (ш.7)—Бурханаас ирэх шүүлтүүд

Гэмшилд зохистой үр жимс (ш.8)—Үнэн наманчлалыг харуулах үйлдлүүд

Моддын үндсэнд сүх аль хэдийнэ зоогджээ (ш.9)—Матай 3:10-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг үз (х.14).

Цавчигдан (ш.9)—Тас цавчуулж

Татвар хураагчид (ш.12)—Татвар хураадаг хүмүүс

Авагтун (ш.13)—Хураа, ав

Сэтгэл хангалуун (ш.14)—Сэтгэл ханамжтай

Бодож байлаа (ш.15)—Тэр тухай бодож байв

Сур (ш.16)—Уяа, үдээс, оосор

Шигшигч сэрээ (ш.17)—Улаан буудайг гадуурх хөнгөн хальснаас нь салган цэвэрлэхэд ашигладаг багаж



Улаан буудайг хальснаас салган цэвэрлэж байгаа нь

Үтрэмээ гүйцэд цэвэрлэн (ш.17)—Үр тариа хурааж авдаг газраа цэвэрлэх

Сэнхрүүлэл (ш.18)—Урам оруулж итгүүлэх яриа

Зэмлэл хүртжээ (ш.19)—Загнаж, зэмлэжээ

Лук 3:8–9—“Бидэнд Абрахам Эцэг Маань Байна”

Абрахамын итгэлтэй байдлын улмаас Их Эзэн түүнд агуу амлалтуудыг өгчээ (Эхлэл 13:14–17; Абрахам 2:8–11-ийг үз). Олон иудей хүмүүс, тэд Абрахамын үр удам учраас зүгээр л аяндаа аврагдах болно гэдэгт итгэдэг байлаа. Хэрэв тэд наманчлахгүй бол хэрэггүй модод лугаа адил тас цавчигдах болно гэдгийг Иохан Баптист тэдэнд хэлжээ. Энэ заасан зүйл нь, бид ажил үйлсээрээ шүүгдэх болно, түүнчлэн зөвхөн зөв шударга хүмүүс мөнх амьдрал хүлээн авна гэдгийг онцлон үздэг билээ.

Лук 3:19–20—Херод Ямар Буруу Юм Хийсэн Бэ?

Лук 3:19–20-д захирагч Херод Антипын тухай өгүүлдэг. Тэр бол Матай 2-т та нарын уншдаг Агуу Херодын хүү байв. Херод Антипа өөрийнх нь дүү Филиптэй гэрлэсэн өөрийнх зээ хүүхэн Херодиатай гэрлэхийн тулд авааль гэргийгээ хаяжээ. Ийм гэрлэлт Мосегийн хуулийн эсрэг байлаа. Иохан Баптист Херодыг наманчлахыг уриалахад Херод Иоханыг шоронд хорьжээ.

Судруудыг Судлах нь

Лук 3-ыг судлахдаа дараах гурван үйл ажиллагааг хий (А–В).

А Иохан Замыг Бэлтгэв

1. Лук 3:7–14-ийг нэгтгэн дүгнэж, “урагш авчрахыг нь” Иохан хүмүүст ярьсан “наманчлалын зохистой үр жимсүүдийг” жагсаа (ш.8).
2. Эдгээр үр жимс тус бүр нь Аврагчийг угтахад бэлтгэхэд бидэнд хэрхэн туслах тухай бич.

Б Бид Юу Хийх Ёстой Вэ?

Сайн жимс ургуулдаггүй мод бүхэн цас цавчигдаж “галд хаягдах болно” гэдгийг (Лук 3:9) Иохан Баптист хүмүүст заасны дараа, “Тэгвэл бид юу хийх ёстой вэ?” гэж хүмүүс асуужээ (ш.10). Тэгэхэд Иохан сайн жимс авчрах гэдэг нь ямар учиртайг тайлбарлаж, зарим жишээ татжээ.

1. Иоханы санал болгосон зүйлүүдийг жагсаа:
 - а. Хоол хүнс хувцас хунартай хүмүүст
 - б. Татвар хураагчдад
 - в. Цэргүүдэд
2. Иоханы заасан зүйл дээр тулгуурлан өнөөдөр тэрээр юу санал болгох байсан гэж боддогоо бич:
 - а. Сургуулийн өсвөр насны сурагчдад
 - б. Эцэг эхтэйгээ хамт амьдардаг хүүхдүүдэд
 - в. Эцэг эхчүүдэд



В Бэлэгдлийг Сонго

1. Лук 3:7–18 дахь дараах үг тус бүр нь Иохан Баптистын захиас үг хийгээд үүрэг зорилгод юуг бэлэгдэж болохыг тайлбарла: *хорт могой, чулуу, үр жимс, үндэс, гутал, улаан буудай*.
2. Өөрсдийн тань таньдаг хүмүүсээс *хамгийн багаар ч гэсэн* дээрх бэлэгдлүүдэд хамааруулж болох нэг бэлэгдлийг сонго. Та нарын байгаа газрын тань хүмүүс илүү сайн ойлгож болох өөр бэлэгдлийн тухай бод. Иоханы зааж байсан зарчмыг заахын тулд үүнийг хэрхэн хэрэглэхээ бод.

Лук 4

Есүс Сатаныг Ялж, Өөрийн Тохинууллыг Эхлэв

Есүс Өөрийн тохинууллын эхэнд дөчин өдөр мацаг барьж, залбирав. Энэ үеийн дараа Сатан Түүнийг сорихоор иржээ. Яагаад? Чөтгөр юу олно гэж найдсан бэ? Тэнгэрлэг Эцэг Өөрийн бүх хүүхдүүдийг “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг” хүртээсэй хэмээн хүсдэг билээ (Моисе 1:39). Сатан бүх хүмүүнийг өөр шигээ зовлонт байгаасай гэж хүсдэг (2 Нифай 2:27; мөн шүлэг 18-ыг үз). Бидний авралын төлөөх Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд, нүгэл хилэнцгүй Аврагч бидний нүглүүдийн төлөө төлөөс төлөх нь зайлшгүй шаардлагатай юм. Түүнийг нүгэл үйлдүүлэхээр сорьсон Сатаны оролдлого амжилтгүй болсон билээ.

Түүнчлэн Сатан Бурханы үйлчлэгчдийг эсэргүүцдэг. Жишээ нь, тэр Моисе уруу татах гэж оролдож (Моисе 1:12–22-ыг үз), мөн тэр Бошиглогч Иосеф Смитийг дайрч байлаа (Иосеф Смит—Түүх 1:15–17-г үз). Бошиглогч Иосеф Смит өөрийн туршлагын талаар өгүүлж, “Амьдралын маань бүр эхэн үед намайг түүний хаант улсыг эсэргүүцэгч мөн өдөгч байх тавилантайг дайсан мэддэг байсан бололтой; тийм бус аваас харанхуйн хүчнүүд яагаад миний эсрэг нэгдэх учиртай билээ?” гэж бичжээ (Joseph Smith—History 1:20).

Лук 4-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд


Лук 4: 1–13—Матай 4:1–11; Марк 1:12–13

Лук 4:31–37—Марк 1:21–28

Лук 4:38–43—Матай 8:14–17; Марк 1:29–38

Гайхан шагшиж (ш.32)—
Гайхаж, гайхан биширч
Гуйв (ш.38)—Хүсэв, гуйлаа
Халууныг зэмлэхэд (ш.39)
— Халууныг буу гэж
тушаав

Тэдэнд зөвшөөрөхгүй байлаа (ш.41)—Тэдэнд зөвшөөрсөнгүй



Лук 4:16–30—Яагаад Есүсийн Төрсөн Хотынх нь Хүмүүс Түүнийг Алахыг Хичээж Байсан Бэ?

Есүс Өөрийгөө Мессиа байсан гэж Тэрээр хэлснээрээ Исаиагийн бошиглолуудыг гүйцэлдүүлээ хэмээн Тэрээр хэлсэн гэж Назарын синагог дахь иудейчүүд ойлгосон байлаа. Гэвч эдгээр хүмүүс Есүсийг өсөх үеэс нь мэддэг байв. Мессиа ямар байх ёстой талаарх тэдний хуурмаг төсөөлөл, түүнчлэн өөрсдийнх нь таньдаг хүн Мессиа байсан гэдэгт итгэх нь тэдний хувьд үнэхээр хэцүү байжээ. Түүнээс гадна, та өөрийгөө Мессиа гэж нэрлэвэл, Моисегийн хуулиар бол, цаазаар авахуулах ялаар шийтгүүлэх ёстой, Бурханыг доромжилсон хэрэг байлаа. Есүс Бурханыг доромжилсон гэж Назарын хүмүүс боддог байжээ, иймээс түүнийг цаазлах нь зөв гэж тэд боддог байлаа.

Судруудыг Ойлгох нь



Лук 4

Орой (ш.9)—Хамгийн дээд цэг

Цохих (ш.11)—Дэлсэх, цохих

Заншсан ёсоороо (ш.16)—
Заншсанаараа, ердийнхөөрөө

Тосолсон (ш.18)—
Сонгогдсон

Түүний тухай сайнаар ярьж (ш.22)—Түүний хэлснийг сонсож

Тэнгэр хаагдсан (ш.25)—
Бороо оруулахгүйн тулд тэнгэр лацдагдсан

Өлсгөлөн (ш.25)—Хүнс дутагдах

Елиа (ш.26)—Елиа (Элайжа)

Уяман өвчтөнүүд (ш.27)—
Арьсны аймшигт өвчнөөр шаналан зовсон хүмүүс

Елиша (ш.27)—Елиша

Уур хилэн (ш.28)—

Хилэглэнэл

Судруудыг Судлах нь



Лук 4-ийг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Ямар Уруу Таталтууд Снэхээр Бидэнд Тохiolддог вэ?

Сатан Есүсийг хэрхэн сорьсныг та нар Матай 4:1–10-г судалж, тэрээр өнөө үед биднийг мөн тийм байдлаар хэрхэн сорьдгийг таньж мэдсэн билээ. Энэхүү үйл явдлын талаар, тухайн үедээ Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Давид О.МакКей, “Та нарт бас надад ирдэг бараг уруу таталт бүр нь, доорх хэлбэрүүдийн аль нэгнээр ирдэг. Тэдгээрийг ангилах юм бол, та нарыг бас намайг толботуулдаг эдгээр гурван уруу таталт бүрийн аль нэгнийх нь эрхшээлд бид, бүр ялихгүй багаар ч гэсэн байдаг нь, (1) хоол идэх уруу таталт, (2) бардамнал хийгээд загвар маягт, тэрчлэн Бурханы зүйлүүдээс холдуулах хоосон зүйлүүдэд автах, эсвээс (3) дэлхийн баялгуудын төлөөх,

эсвээс хүмүүний дунд хүчийг олохын төлөөх хүсэл мөн” гэж хэлжээ (in Conference Report, 1911оны 10-р сар, 59).

1. “Ганцхан талхаар амьдардаггүй, харин Бурханы үг бүрээр амьдардаг” (Лук 4:4) гэсэн нь ямар утгатай гэж та нар боддог вэ? Бид амьдрахын тулд идэх ёстой, гэвч хоол идэх дур хүслийн уруу таталтанд амьдралаа зориулдаг хүмүүсийн амьдралыг Есүсийн зөвлөсний дагуу байсан хэн нэгийг амьдралтай харьцуул.
2. Хэрэв Есүс түүнийг шүтэн бишрэх юм бол, Сатан Түүнд юу амласан бэ? (Лук 4:5–8-ыг үз). Үүнийг Бурханы амласан зүйлтэй харьцуул (С ба Г 76:50, 54–59; 84:37–38-ыг үз).
3. Сатан Есүсийг сорихдоо, Түүнийг аюул осолд тавьж, Тэрээр ид шидийн замаар аврагдах нь уу гэдгийг харснаар Тэрээр хэн байсныг нотлохын тулд Түүнийг сорьсон ажээ. Хэрэв Есүс үүнийг хийсэн бол, Тэрээр Бурханыг хэрхэн сорих байсан бэ? (Лук 4:12-ыг үз). Есүс бол Бурханы Хүү гэдгийг Сатан мэдэж байв. Яагаад Сатан өөрийнхөө аль хэдийнэ мэддэг байсан зүйлийг нотлохын тулд Есүсийг сорьсон гэж та нар боддог вэ?
4. Уруу таталттай тэмцэж байгаа найз буюу эсвэл гэр бүлийн гишүүн танд байдаг гэж бодъё. Есүст ирсэн сорилтуудаас мэдэж авсан зүйлээ ашиглан, Сатаны уруу таталтууд нь дуулгавартай хүмүүст өгсөн бидний Тэнгэрлэг Эцэгийн амлалтуудын адил хэзээ ч тийм шагнан урамшуулагч шинжтэй байхгүйг цөөн өгүүлбэрээр бич.

Б Есүсийн Сүрэг Зорилгыг Тодорхойл

1. Мессиа Өөрийн тохинууллын нэг хэсэг болгон, юу хийхийг Исаиа бошиглосныг Исаиа 61:1–2-оос Есүс иш татсан байдаг. Лук 4:18–19-өөс, Есүс хийх болно хэмээн Исаиагийн бошиглосон зургаан зүйлийг жагсаа.
2. Өнөөдөр хувь хүмүүсийн амьдралд энэ үүрэг зорилгыг Есүс хэрхэн үргэлжлүүлж байгаа тухай наад зах нь хоёр жишээг гарга.

Лук 5

“Ирж, Намайг Дага”

Аврагчийн үүрэг зорилгын нэг чухал хэсэг нь газар дээр Бурханы хаант улсыг байгуулах явдал байв. Есүс Христ Өөрийн амилуулалтууд хийгээд тэнгэрт дээшлэн одсоны дараа Сүмийг удирдахаар Өөрийн итгэл хүлээлгэсэн хүмүүсийг дуудсан билээ. Эдгээр хүмүүс бол Арванхоёр Төлөөлөгч байв. Өөрийн Төлөөлөгчдийг чухал үүргээ гүйцэтгэхэд нь бэлтгэн зааварлахад Есүс их цаг зарцуулжээ. Лук 5 эдгээр хүмүүсээс зарим нь Есүсийг дагахаар хэрхэн дуудагдсаныг өгүүлдэг.

Лук 5-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 5:1–11—Матай 4:18–22; Марк 1:16–20
Лук 5:12–16—Матай 8:2–4; Марк 1:40–45
Лук 5:17–39—Матай 9:2–17; Марк 2:1–22

Судруудыг Ойлгох нь



Лук 5

Геннесаретын нуур (ш.1)—Галилын Тэнгис

Тойрон бүчиж (ш.1)—Эргэн тойронд шавж

Барьсан (ш.4, 9)—Барих

Зүдрэн (ш.5)—Ядартлаа ажиллаад

Саа өвчтэй (ш.18)—Саа өвчин хүрсэн

Бурханыг доромжлон (ш.21)—Ариун нандин зүйлсийн талаар хилэнцэтийг ярих

Леви (ш.27)—Матайн өөр нэг нэр


Татварын газар (ш.27)—Хүмүүс татвар төлдөг ширээ

Хүргэн (ш.34)—Гэрлэх гэж байгаа эрэгтэй хүн; энэ нь бас Есүс Христийн нэр болно.

Урж аваад (ш.36)—Ураад

Лук 5:36–39—Хуучин Хувцсыг Яагаад Шинэ Материалаар Нөхдөггүй Буюу Эсвээс Шинэ Дарсыг Яагаад Хуучин Тулманд Хийдэггүй Вэ?

Хувцсыг угаах, мөн өмсөх нь түүнийг агшихад хүргэдэг. Хуучин хувцсыг шинэ материалаар нөхөх нь үүнийг агшдаггүй ч гэсэн, нөхсөн материал агшсанаар хувцсыг урагдахад хүргэдэг.



Шинэ Гэрээний үед дарсыг мал амьтны арьсаар хийсэн тулманд хадгалдаг байв. Эдгээр ширэн савуудыг ихэвчлэн дарсны тулам хэмээн нэрлэдэг байв. Цаг хугацаа өнгөрөх тутам эдгээр туламнууд хатаж, хэврэгшин, улмаар амархан урагдаж, цуурдаг байв. Шинэ дарс исэх

явцад, шингэн өсч нэмэгддэг. Хэрэв хуучин тулманд шинэ дарс хийвэл, исэлт нь хуучин тулмыг тэлж, зад үсрэхэд хүргэж болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МакКонкийн дараах асуултууд энэ хоёр сургаалт зүйрлэлийг тайлбарлахад тусалдаг: “Хуучин сүм дэх багтисм, мөхөж байгаа хаант улс дахь шинэ илчлэлт, урвагч байгууллага дахь шинэ сургаал гэгч юу байх вэ! Тэдгээрийн сүнс хийгээд хүчтэйгээр, Мосегийн жаягийн үхширмэл хэлбэрдэлт хийгээд ёслол дээр Христийн шашинтны ёслолуудыг Есүс нэмж чадах байсан гэж үү?” (Doctrinal New Testament Commentary, 1:186).

Судруудыг Судлах нь



Лук 5-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А буюу В) нэгийг нь хий.

А Зөвлөгөө Өг

Та нар өөрсдийгөө Лук 5:11 дэх түүхэн дэх Петрийн завинд байсан хүмүүсийн нэг гэж бод. Цөөн хэдэн жилийн дараа нэг найз тань Сүмд идэвхтэй болоход нь туслахаар түүний хичээж байгаа нэг хүн бараг жил болоход Сүмийн ямар ч цуглаанд ирэхгүй хэвээр байгаа учраас урам нь хугарсан байдалтайгаар чам дээр иржээ. Лук 5:1–11 дэх түүхийг

дахин ярьснаар, үүнээс өөрсдийн мэдэж авсан зүйлийг, түүнчлэн үүнийг түүний нөхцөл байдалд хэрхэн хэрэглэхийг тайлбарласнаар найзыгаа хэрхэн урамшуулан дэмжиж болох тухай бич.

Б Хэрэв Та Нар Тэнд Байсан Бол

Лук 5:18–26 дахь түүхэн дэх хүнийг эдгээснийг та нар гэрчилж, тэгээд дараа нь шүлэг 27–32-т дүрсэлсэн найрт өөрсдийгөө оролцсон гэж төсөөлөн бод. Эдгээр үйл явдлуудын талаар найздаа юу гэж бичих байснаа бич. Есүс болон Түүний тохинууллаас юу мэдсэнээ, түүнчлэн тохиолдсон явдлуудаас тань шалтгаалж амьдрал тань хэрхэн өөрчлөгдөж болохыг оруул.

Лук 6

Есүс Арванхоёр Төлөөлөгчийг Томилж, Тэдэнд Заасан нь

Есүс урьд нь Өөрийгөө дагах хүмүүсийг дуудаж байсан. Лук 6 нь Арванхоёр Төлөөлөгчийг албан ёсоор дуудсан тухай цэдэглэсэн байдаг. Тэрчлэн тэднийг Түүний нэрээр номлохоор гадагш явах үед тэдэнд Түүний заасан зарим зүйлийг бид уншдаг. Тэдэнд өгсөн Түүний зөвлөгөө нь Матай 5-7 дахь Уулан дээрх Номлолд та нарын уншсан зүйлтэй төстэй юм. Лук 6:20–49-ийг зарим хүмүүс Тал дахь Номлол гэж нэрлэдэг.

Лук 6-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 6:1–11—Матай 12:1–21; Марк 2:23–3:12

Лук 6:12–16—Матай 10:2–4; Марк 3:13–19

Лук 6:17–49—Матай 5:1–7:29

Судруудыг Ойлгох нь

Лук 6

Ариусгасан талх (ш.4)—
Табэрнэклд тавьсан талх;
энэ нь Есүс Христийг
төлөөлдөг байв

Буруутгах шалтаг (ш.7)—
Яллах, буруутгах зүйл

Зүгээр болсон байв (ш.10)—
Эдгэрсэн байв

Ярилцацгаав (ш.11)—
Төлөвлөсөн буюу хуйвалдав
Зовоогдсон (ш.18)—Зовж
шаналсан

Доромжилж (ш.22)—

Зэмлэх, буруутгах

Тайвшрал (ш.24)—

Тайтгарал

Үртэс (ш.41)—Сүрэлний
жижигхэн хэсэг

Дүнз (ш.41)—Засмал мод;
үртэсээс хамаагүй том гэсэн
утга илэрхийлжээ

Муу (ш.43)—Жимс ургуул-
даггүй мод

Дайрахад (ш.49)—Хэт их
хүчтэйгээр ирэхэд

Лук 6:12–16—Төлөөлөгчдийг Дуудсан нь

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Давид Б.Хейт хэлэхдээ, “Бурханы хаант улсын бүх түлхүүрүүдийг атгадаг Сүмийн Ерөнхийлөгчийн удирдлага дор Төлөөлөгч бүр томилогддог. Тэрбээр Сүмд Өөрийнхөө хаших албан тушаал бүрт шаардлагатай санваарын эрх мэдлийг шинэ Төлөөлөгч болгонд өгдөг. Бурханы нэрээр үйлдэх тэрхүү эрх мэдэл нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд өнөөдөр үйлчилсээр байгааг бид мэдэгдэж байна. Эртний эрин үеүдэд энэ хүч буюу итгэмжлэлийг атгаж байсан хүмүүсийн гар доорх томилолтоор Сүмийн анхны ажилтнуудад олгосныг бид гэрчилж байна. Шинэ Гэрээний үед төлөөллийн энэхүү эрх мэдлийг атгаж байсан Петр, Иаков, Иоханаас төлөөллийн түлхүүрүүдийг Иосеф Смит хүлээж авсан билээ. Энэ эрх мэдэл Бошиглогч Иосеф Смитээс доош дамжин [өнөөгийн бошиглогчид] ирсэн юм” гэжээ (in Conference Report, 1994 оны 10-р сар, 17–18; *Ensign*, 1994 оны 11-р сар, 15; түүнчлэн Итгэлийн Тунхаг 1:5-ыг үз).

Судруудыг Судлах нь

Лук 6-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) гурвыг нь хий.

А Арванхоёр Төлөөлөгчийг Сонгосон нь

Лук 5:1–6:16-д уншсан зүйлээ анхааралтай авч үзэн, Арванхоёр Төлөөлөгчийн дуудлагын тухай дараах зүйлд хариул:

1. Төлөөлөгч болгон Өөрийнхөө дуудсан зарим хүмүүсийг Есүс ямар аргаар шалгасан бэ?

Тухайн үедээ Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Харольд Б.Ли үнэнч итгэлтэй байдлын ийм шалгуурын тухай ярихдаа: “Энэ Сүмд өндөр албан тушаалд дуудагдах хүн болгон, хүмүүний гараар бус хэрэгждэг энэхүү шалгуурыг туулах болно гэдэг нь миний итгэл үнэмшил бөгөөд үүгээр бидний Эцэг, Амьд Бурханы бошиглогчдыг дагахад бэлэн байгаа, түүнчлэн үнэнч итгэлтэй байж, өөрсдийн заадаг үнэнүүдийн гэрчүүд хийгээд үлгэр загвар байж чадах удирдагчдын нэгдсэн бүлэгт тэднийг тоолдог билээ” гэжээ (in Conference Report, 1950 оны 4-р сар, 101).

2. Эдгээр хүмүүс дуудагдахаасаа өмнө Есүсийн тухай юу мэдэх хэрэгтэй байсан бэ?

3. Лук 6:12 дахь үйл явдал шүлэг 13–16-гийн өмнө болж байгаагийн ач холбогдол юу байж болох вэ?

Б Арванхоёр Төлөөлөгч Хэн Бэ?

Одоо Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад үйлчилж байгаа хүмүүсийн нэрсийг тэмдэглэлийн дэвтэртээ жагсаан бич.

В Гол Санаануудыг Жагсаан Бич

Лук 6:17–26-д адислалууд хийгээд зүхлүүдийн (золгүй явдлууд) тухай Есүс шавь нартаа заадаг. Тэмдэглэлийн дэвтэртээ доорхтой төстэй схем хийж, адислалууд хийгээд золгүй явдлуудыг жагсаан бич. Жагсаалтаа дуусгаад үүнээс нэг зүйлийг сонгон авч, өнөөдөр үүнийг хэрхэн хэрэглэдгийг тайлбарла.

АДИСЛАЛУУД	ЗОЛГҮЙ ЯВДЛУУД
(Жагсаалт)	(Жагсаалт)

Г Та Нар Юу Тарина, Түүнийгээ Хурааж Авдаг

Лук 6:43–49 нь та нар юу тарина, түүнийгээ хурааж авдаг гэсэн зарчмыг заахад хоёр жишээг ашигладаг. Өөрөөр хэлбэл, та нар вандуй тариад эрдэнэ шиш хурааж авдаггүй. Лук 6:43–47 буюу 48–49-ийн аль нэгнээс Аврагчийн үлгэр жишээнүүдийн нэгний тухай зураг зур. Энэ үлгэр жишээ яагаад үр ашигтай байгааг тайлбарла.

Лук 6:27–42-ыг уншаад, үүнээс бид юу тарих (амьдралдаа хэрэгжүүлэх) ёстой хийгээд, тарьсан зүйл бүрийн төлөө ямар үр жимс (адислалууд) амлагддаг тухай Аврагчийн заасан зарчмуудаас гурвыг жагсаан бич.

Лук 7–8

Итгэлийн Асуудлууд

Сүмийн гишүүн бус хүмүүс Есүс Христэд итгэх итгэлтэй байж чадах уу? Түүнчлэн тэд залбирч, адислалуудыг, тэр ч байтугай, гайхамигуудыг Бурханаас хүлээн авч чадах уу? Лук 7–8-ыг уншихдаа хэн адислалууд хүлээн авсан, мөн хэн хүлээж аваагүйг тогтоож, Бурханаас адислалууд хүлээн авах тухайд энэ нь бидэнд юу заадгийг тунгаан бод.

Лук 7–8-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 7:1–10—Матай 8:1–13

Лук 7:18–35—Матай 11:2–19

Лук 8:4–18—Матай 13:1–23; Марк 4:1–25

Лук 8:19–21—Матай 12:46–50; Марк 4:1–35

Лук 8:22–56—Матай 8:18–34; 9:18–26; Марк 4:35–5:43

Судруудыг Ойлгох нь



Лук 7

Зуутын дарга (ш.2)—Ромын цэргийн дарга

Гуйлгах (ш.3–4)—Гуйх, хүсэх

Эрүүл болсон (ш.10)—Эдгэрсэн

Авс (ш.14)—Нас барсан хүний цогцсыг хийж оршуулах газар аваачдаг хайрцаг

Бурханы хаанчлалын хамгийн бага нэгэн (ш.28)—Хэнийг чи хамгийн бага нэгэн гэж бодох чинь чухал; Есүс Өөрийнхөө тухай ярьж байжээ.

Гөлтгөнөн савтай үнэт тос (ш.37)—Гөлтгөнө чулуугаар хийж, анхилуун үнэртэй үнэт тосоор дүүргэсэн сав

Мөнгө Зээлдүүлэгч (ш.41)—Бусдад мөнгө зээлдүүлдэг хүн
Өртөн (ш.41)—Зээлдүүлэгчид мөнгөний өртэй хүн

Динар (ш.41)—Ердийн ажилчны нэг өдрийн хөлс болох мөнгөн зоос



Лук 7:18–23—Есүс Христийн Бурханлиг Байдалд Иохан Эргэлзэж Байсан уу?

Ахлагч Брус Р.МакКонки өгүүлэхдээ:

“Эзэний үүрэг зорилгыг мэдэхэд Баптист оюун бодолдоо тодорхой бус байсан буюу эргэлзэж байсан гэх аливаа дүгнэлт огт баталгаагүй юм. Бодит байдалд, шоронд хоригдсон мөн бидний Их Эзэний өмнө ирэгч [Иохан], өөрсдийгөө орхиж, Есүсийг дагахыг шавь нартаа ятган ойлгуулахын тулд энэ арга хэрэгслийг ашиглажээ.

“Есүс хэн байсныг Иохан мэдэж байв. Баптистын оюун санаанд найгах зэгс ч байсангүй. . . Шавь нараа Есүс рүү илгээсэн энэ үйлдэл нь үр дүнгээ өгч, Есүс Бурханы Хурга байсан гэдгийн тухайд Иоханы үүрэг дэх сүүлчийн агуу гэрчлэл байв, учир нь түүний шавь нар Эзэнийг биечлэн харж, түүний заасан зүйлүүдийг сонссоноор тэрхүү агуу гэрлийг дагахаас аргагүйд хүрнэ гэдгийг Баптист мэдэж байжээ” гэсэн байдаг. (*Doctrinal New Testament Commentary*, 1:261–62).

Лук 7:31–35—Аврагчийн Сеийн Хүмүүс Хэнтэй Адил Байсан бэ?

Ахлагч Брус Р.МакКонки Аврагчийн захиас үгийг ийм байдлаар илэрхийлжээ: “Итгэлгүй иудейчүүд та нарын хичнээн хорон санаатай, уур уцаартай, хуурмагийг харуулахын тулд би ямар зураглал сонгож чадах вэ? Та нарыг хуурамч хурим хийхэд хамтран тоглогч тань бүжиглэхээс татгалздаг, та нар тоглоомоо оршуулгын цуваа болгон өөрчлөхөд хамтран тоглогч тань гашуудахаас татгалздаг тийм тоглоом тоглож байгаа хуйсгануур хүүхдүүдтэй адилхан юм. Ийм байдлаар та нар гагцхүү шашнаар тоглодог. Ууртай, бааштай [дэггүй] хүүхдүүд лугаа адил та нар Иоханыг эсэргүүцдэг, учир юун гэвэл тэрээр *Назарчуудын* чанд хатуу байдалтайгаар ирсэн юм, мөн би аятай сайхан олон нийтийн [нийгэмлэгийг] бий болгосон хүмүүнлэг дулаан зан байдлыг би харуулсан учраас та нар намайг эсэргүүцдэг бөлгөө” (*Doctrinal New Testament Commentary*, 1:263).

Лук 8

Нярав (ш.3)—Үйлчлэгч

Үр суулгах (ш.5)—Тарих

Маш олон хүн байсан учраас (ш.19)—Олон хүн цугласан учраас

Аюул (ш.23)—Осол, аюул

Өмсөх (ш.27)—Хувцас өмсөх

Дөнгө (ш.29)—

Хоригдлуудын гарыг гинжлэх, хөлийг дөнгөлөхөд ашигладаг гинж

Бүчин шахаж (ш.29)—

Тойрон цугларч

Цус алдах (ш.44)—Цус нь гоожиж байгаа эдгээгүй шарх буюу яр

Зогсов (ш.44)—Болив, эдгэв

Гашуудан (ш.44)—Уй гашуу болж

Тохуурхан инээлдэж (ш.44)—Шоолон инээлдэж

Лук 8:2—Магдалын Мариа гэж Хэн Байсан бэ?



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, ахлагч Жеймс Е.Талмейж: “Магдалын Мариа бол эмэгтэйчүүдийн дотроос Христийн хамгийн дотнын найз нарын нэг байлаа; энэ эмэгтэй Түүнийг өөрийгөө Эдгээгчийн хувьд, мөн Христ хэмээн тэрээр бишрэн дээдэлдэг Нэгэний хувьд тэр Түүнд бүхнээ зориулдаг байсан нь гуйвшгүй байлаа; бусад эмэгтэйчүүд Түүний мөнх бус амьдрал дахь зовлон шаналлын үед хол зайд хүлээж байсан бол, энэ эмэгтэй загалмайн дэргэд зогсож байлаа; амилуулалтын өглөө булшны дэргэд эхлэн очигчдын дунд тэр байлаа; сүнснийхээ бүхий л

оргилуун бишрэл, хайраар өөрийнхөө хайрладаг асан, амиллагдсан Хүмүүн биет—Их Эзэнийг харж, таньсан анхны мөнх бус хүмүүн нь мөн л тэр эмэгтэй байлаа” гэж бичжээ (*Jesus the Christ*, 264–65).

Судруудыг Судлах нь



Лук 7–8-ыг судлахдаа үйл ажиллагаа Б-г, түүнчлэн бусдаас (А, В буюу Г) нь хоёрыг хий.

А Түүний Зан Төлвийг Дүрсэл

Лук 7:1–10-ыг уншиж, зуутын даргын хамгийн их сэтгэгдэл төрүүлэм таван хандлага буюу зан төлвийн шинж юу байсан гэж бодлогоо жагсаан бич. Таван зүйл бүрийн дэргэд түүнд байсан хандлага буюу зан төлвийн шинжүүдийг харуулсан судруудаас нэг өгүүлбэр бич.

Б Аврагчийн Слгэр Жишээг Дага

Лук 7:11–17 дахь Найны бэлэвсэн эмэгтэйн тухай түүхийг унш.

1. Шүлэг 13-ыг тэмдэглэж, хэн нэгнийг өрөвдөн хайрлах нь ямар утга учиртайг тунгаан бод.
2. Хэрэв та нар түүнд өрөвч сэтгэл гаргах юм бол адислагдаж болох, өөрсдийн хэсэг буюу салбарын хэн нэгэн хүний тухай бод (бэлэвсэн эмэгтэй буюу бэлэвсэн эрэгтэй байж болно).
3. Тэр хүнд зориулан өөрсдийнхөө хийж болох үйлчлэлийн нэг хэлбэрийг бодож олоод, үүнийг энэ долоо хоногт хэрэгжүүл.
4. Тэмдэглэлийнхээ дэвтэрт өөрсдийнхөө үйлчлэлийн талаар, энэ тухай ямар бодол төрснөө нарийн тодорхой бич.

В Товч Дүгнэлт Бич

Лук 7:36–50 дахь түүхийг анхааралтай уншсаны дараа:

1. Эдгээр шүлгүүдийг нэгтгэн дүгнэсэн хоёр догол мөр бүхий түүх бич. Уг түүхийг хүүхдийн хэсгийн хичээл дээр уншиж өгөхөд үүнийг илүү сайн ойлгоход нь хүүхдүүдэд туслах тийм байдлаар бич.
2. Судрын энэ хэсгийн гол санааг дүрсэлсэн нэг өгүүлбэрийг бодож ол. Уг өгүүлбэрийг өөрсдийнхөө бичих түүхийн нэр болгож ашигла.

Г Өнөөгийн Нөхцөлд Авч Сэ

Дараах дүрслэлүүдийг (а–г) дор өгөгдсөн дөрвөн нөхцлүүдэд (1–4) тохируулан тавь. Зөв хариултуудыг олохын тулд Лук 8:5–15-ыг анхааралтай унших хэрэгтэй. Тэмдэглэлийнхээ дэвтэрт үсэг бүрийн ард тохирох тоог бич.

Дүрслэлүүд:

- а. Шувууд идсэн үрүүд
- б. Чулуурхаг хөрсөн дээрх үрүүд
- в. Хогийн ургамлуудаар сүйтгэгдсэн үрүүд
- г. Сайн хөрсөн дэх үрүүд

Нөхцөлүүд:

1. Унадаг дугуйных нь хий гарчихсан байхад Сара номлогч нартай тааралджээ. Тэд дугуйг нь засахад тусалж, номлолынхоо талаар түүнд яриу. Тэр коллежийн оюутан, завгүй байсан хэдий ч, тэдний үгсийг сонсож, Сүмд элсэн, идэвхтэй гишүүн болжээ. Нэг өрөөнд хамт амьдрагчид нь түүнийг шоолж эхлэн, бас найз залуу нь түүнээс харилцаагаа таслав. Тэр ганцаардаж, найз нартайгаа хамт байхын тулд сумд явахаа болиу.
2. Номлогч нар хаалгыг нь тогшиход Том тэднийг тохуурхан шоолсон хэдий ч, тэд хариу үг өдөж маргасангүй. Тэд бусдаас өөр байсан учир Томын сониуч зан хөдлөв. Тэр тэдний заасан зүйлийг сонсож, тэдэнтэй найзууд болов. Тэд түүнд таалагдсан учраас тэр сүмд элсчээ. Номлогч нарыг өөр хамт олон уруу шилжих хүртэл тэр сүмд явж байв, тэгээд дараа нь сонирхолгүй болж, ирэхээ болиу.
3. Анн Сүмд өсчээ. Тэр Брайнтай танилцах хүртлээ үргэлж идэвхтэй байлаа. Тэр түүнд хайртай байсан бөгөөд Брайн өөр сүмийн гишүүн байсныг тоодоггүй байв. Дахин сэргээгдсэн сайн мэдээний заадаг зүйлүүдийг тэр сонирхдоггүй байсан бөгөөд Анн өөрийн итгэлдээ бага зэрэг

тэнэг юм шиг түүнд санагддаг байв. Түүнийг зөвхөн Сүмдээ явахыг больсон цагт л тэд хамт байж болно гэж Брайн түүнд хэлжээ. Аннид гунигтай байсан хэдий ч, тэр түүнд хайртай байсан учир Брайны хэлснээр болжээ.

4. Рандийг арванхоёртой байхад гэр бүл нь Сүмд элсчээ. Тэрээр дикон болсондоо сэтгэл хөдөлж, бас аав нь түүнийг томилжээ. Гэр бүл нь гэр бүлийн үдшийг хийхийн тулд чадах бүхнээ хийдэг байсан бөгөөд гэр бүлийн залбирал тасрах нь огт байсангүй. Тэд сүмд хамт явж, сайн мэдээний заадаг зүйлүүдийг олонтаа ярилцдаг байлаа.

Лук 9

Арванхоёр Төлөөлөгч Номлохоор Гадагш Илгээгдэв

Өөрийнхөө ажилд туслуулж, мөн Түүнийг тэнгэрт дээшилсний дараа уг ажлыг цааш авч явахын тулд Есүс Арванхоёр Төлөөлөгчийг томилсон билээ. Энэ агуу ажлыг гүйцэлдүүлэхийн тулд Арванхоёрт хүч, эрх мэдэл, туршилага хийгээд мэдлэг хэрэгтэй байв, гэвч Тэргүүн Зөвлөлийн гишүүн, Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Бурхан хэнийг дуудна, Бурхан түүнийг чанаржуулдаг” гэдгийг бидэнд сануулсан билээ (in Conference Report, 1987оны 4-р сар, 54; Ensign, 1987 оны 5-р сар, 44). Лук 9-ийг уншихдаа, Арванхоёрыг шаардлагатай сургалт хийгээд туршилагаар, тэнцэхээр болоход нь Есүсийн тусалсан арга замуудыг ажигла. Дуудлага хүлээн авсан хэнд ч Их Эзэн туслах болно гэдэгт бид итгэлтэй байж болно. Тэр биднийг амжилт гаргахыг хүсдэг.

Лук 9-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастурууд

Лук 9:1–6—Матай 10; Марк 6:7–13
Лук 9:7–9—Матай 14:1–2; Марк 6:14–16
Лук 9:10–17—Матай 14:13–21; Марк 9:10–17; Иохан 6:1–14
Лук 9:18–50—Матай 16:13–18:8; Марк 8:27–9:50
Лук 9:57–62—Матай 8:19–22

Судруудыг Ойлгох нь



Лук 9

Богц (ш.3)—Аяны цүнх	Үхэл (ш.31)—Үхэл
Захирагч (ш.7)—Бүс нутгийн тэргүүн буюу захирагч	Амнаасаа хөөс сахруулж тарчилдаг (ш.39)—Энэ нь түүнийг татвалзах өвчинд хүргэдэг
Унд хоол (ш.12)—Хоол хүнс	Тэвчих (ш.41)—Зөвшөөрөх, гэсэх
Нүүрнийх нь төрх өөрчлөгдөж (ш.29)—Түүний нүүр, төрх байдал өөрчлөгдөж	

Лук 9:5—“Хөлийнхөө Тоосыг Сэгсрэн Унага”

Их Эзэний үйлчлэгчдийн нэг нь хөлийнхөө тоосыг гүвж унагах явдал нь түүнд заахаар Их Эзэний илгээсэн хүнд нөхөрлөл хийгээд захиас үгийг нь татгалзсаны гэрчлэл болдог байна. Энэ нь түүнийг эсэргүүцсэн хүмүүс дээр ирэх шүүлтүүдийн төлөө тэрээр хариуцлага хүлээхгүй гэсэн утгатай юм. Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит, “Хэрэв Их Эзэний Сүнс ингэх ёстойг заагаагүй бол, хариуцлагын ийм үйлдэл хийгдэх ёсгүй” гэж хэлжээ (Church History and Modern Revelation, 4 боть. [1946–49], 1:115).

Судруудыг Судлах нь



Лук 9-ийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Есүсийг Дагах нь

Лук 9:23–27, 57–62-г уншсан зүйл дээрээ тулгуурлан Есүсийг үнэнээр дагах гэдэг нь юу гэсэн үг болох хийгээд хүн яагаад ингэхийг хүсдэг тухай нэг юм уу хоёр догол мөр бич.

Лук 10

Дал Номлохоор Илгээгдэв

Өсөн нэмэгдсэн ажлын хэрэгцээний дагуу, Арванхоёрын нэгэн адил гадагш илгээхээр Есүс Далыг дуудаж, томилсон юм. Тэдэнд заасан зарим зүйлүүдийн тухай, тэрчлэн тэдэнд учирсан зарим тохиолдлын тухай бид Лук 10-т уншидаг. Арванхоёрт туслуулахаар Далыг дуудсан, “бүх үндэстнүүдэд . . . сүмийг байгуулах . . .” (С ба Г 107:34) загвар манай өнөө үед үргэлжилж байна. Түүнчлэн Лук 10 нь Есүсийн ихэд нэрд гарсан сургаалт зүйрлэлүүдийн нэгийг агуулдаг.

Лук 10-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастурууд

Лук 10:1–24—Матай 10:20–27

Судруудыг Ойлгох нь



Лук 10

Бидний хөлд наалдсан (ш.11)—Бидний хөлөн дээр наалдсан	Нүцгэлэн зодоод (ш.30)—Хувцсыг нь дээрэмдэж
Үл хэрэгсдэг (ш.16)—Эсэргүүцдэг, татгалздаг	Үйлчлэх ажилдаа түүртсэн (ш.40)—Хийгдсэн байх бэлтгэлийн бүхий л ажилд самгардсан
Ухаантан (ш.21)—Ухаантай, эрдэмтэй	

Лук 10:30–33—Ахлах тахилч, Леви хүн ба Самари хүн

Ахлах тахилчид болон Левичүүд нь гачигдалтай хүмүүст туслах ёстой шашны удирдагчид байв. Энэ сургаалт зүйрлэлд тусламж үзүүлсэн хүн нь Самари байсныг үзүүлэхэд Есүс голлон анхаарчээ. Самаричуудыг үзэн яддаг байжээ (Иохан 4:9-ийг үз). Иудейчүүд самаричуудыг бие бялдар (Хаадын Дэд 17:24–34-ийг үз) болон сүнслэг байдал (Иохан 4:20–22-ыг үз) аль алианаараа өөрсдөөсөө доогуур гэж үздэг байв. Самаричууд болон иудейчүүд ихэвчлэн бие биендээ илт дайсагнадаг байсан хэдий ч, хайр үндэстэн ястан буюу арсны өнгөөр хязгаарлагдах ёсгүйг Аврагч энэ сургаалт зүйрлэлээр дамжуулан заажээ.

Лук 10:38–42—Мариа, Марта Хоёр Бүхнээ Зориулсан нь



Ахлагч Жеймс Е.Талмейж бичихдээ: “Сайтар хангах гэсэн Мартагийн хүслийг буруутгах учиргүй, бас Мариагийн үл тоомсорлох хандлагыг ч зөвшөөрөх учиргүй. Мариа Эзэнийг ирэхээс өмнө дуртайяа туслагч байжээ гэж бид бодох ёстой; харин эдүгээ Тэр ирж, тэр Түүнтэй хамт үлдэхээр сонгосон юм. Тэрээр үүргээ огоорсон гэм буруутай байсан бол, Есүс түүний замналыг сайшаахгүй байсан биз ээ. Тэрээр зөвхөн хоол унд, материаллаг ая тухыг биш, харин эгч

дүүстэй хамт байж, Түүний хэлсэн зүйлд бүхнээс илүүгээр тэдний соргог анхаарлыг хандуулах хүсэлтэй байлаа. Түүнд зориулж тэдний хангаж чадахаас илүү ихийг Тэрээр тэдэнд өгөх учиртай байв. Есүс энэ хоёр эгчид, мөн тэдний ах нарт хайртай байв. Энэ хоёр эмэгтэй хоёул Есүст бүхнээ зориулсан бөгөөд, тэд тус бүр өөрсдийнхөө арга замаар өөрсдийгөө илэрхийлжээ. Марта материаллаг үйлчлэлд илүү санаа тавьсан, илүү практикч бодол санаатай байв; тэр төрөлхийн зочломтгой, өөрийгөө үл хайрхагч нэгэн байв. Бясалгагч хийгээд илүү сүнслэг Мариа бишрэн дээдлэх үйлчлэлээр дамжуулан өөрийн бүхнээ зориулах байдлыг харуулсан билээ” (Jesus the Christ, 433).

Судруудыг Судлах нь

Марк 10-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Далын Сүрэг

1. Лук 10:1–24-ийг уншиж, Далын үүрэг нь Лук 9:1–6, 10-т цэдэглэгдсэн Арванхоёр Төлөөлөгчийн үүрэгтэй адил байгаа арга замуудыг жагсаан бич. (Түүнчлэн үүнийг Матай 10-г цэдэглэгдсэн Арванхоёрын үүрэгтэй харьцуулж болно.)

2. Сургаал ба Гэрээ 107:23, 25, 33–35, 38-ыг уншиж, өнөөгийн Далын гишүүн болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүний үүрэг хариуцлагуудын адил төстэй болон ялгаатай талуудын тухай бич.

Б Сурвалжлагч Бол

Лук 10:30–37 дахь сайн самари хүний тухай сургаалт зүйрлэлийг уншиж, уг түүхийн гурван гол баатрыг нэрлэ. Өөрсдийгөө сонины сурвалжлагч, тэгээд энэ үйл явдлыг сурвалжлах гэж байгаагаар төсөөлөн бод.

1. Гурван гол баатрын нэр тус бүрийн ард, сониныхоо өгүүлэлд зориулж өөрсдийнхөө тавих гурван асуултыг, тэрчлэн тэдний өгнө хэмээн бодож байгаа хариултаудыг бич.
2. Энэ сургаалт зүйрлэлийн гол санааг заах, түүнчлэн сургуулийнхаа сурагчдыг сайн самари хүнтэй адилхан байхад нь урамшуулан дэмжихийн тулд сонины өгүүлэлдээ зориулж дүгнэлтийн догол мөрийг бич.

В Утгыг Тааварла

Лук 10:38–42-ыг анхааралтай унш (түүнчлэн эдгээр шүлгийн “Судруудыг Ойлгох нь”-ыг үз). Энэ түүхэнд Аврагчийн заасан зүйлийг тайлбарласан догол мөрийг тэмдэглэлийн дэвтэртээ бич.

Лук 11

Гэрлээр Дүүрэн Бай

Чин сэтгэлийн гэдэг үг таны хувьд ямар утгатай вэ? Чин сэтгэлийг хоёр нүүр гаргахтай хэрхэн харьцуулж болох вэ? Хэрэв бид Аврагчийн заадаг зүйлүүдийг хэрэгжүүлэх юм бол тэдгээр нь бидний амьдралд хүчтэй байх болно. Жишээ нь, хэрэв бид итгэлтэйгээр, мөн үнэн хүсэлтэйгээр залбирах юм бол, Их Эзэн бидний залбирлуудад хариулах болно. Гэвч, бидний залбирлууд ердөө л бусдыг бишрүүлэхийн тулд хийгдэх юм бол, тэдгээр нь үр нөлөө багатай байх болно.

Та нар Лук 11-ийг уншихдаа Аврагчийн заадаг зүйлүүдийг амьдралдаа чин сэтгэлээс хэрэгжүүлдэг хүмүүсийг эдгээр нь хэрхэн адисалж болохыг анхаар. Хоёр нүүр гаргах тухай Есүс юу заасан бэ? Зөв шударга мэт дүр эсгэхгүй байх нь яагаад чухал гэж та нар боддог вэ?

Лук 11-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 11:1–4—Матай 6:9–13

Судруудыг Ойлгох нь



Лук 11

Ариунаар (ш.2)—Ариун, эсвэл нандинаар

Цөхрөлтгүй (ш.8)—Шаргуу, тэвчээртэй

Хэлгүй (ш.14)—Ярьж чаддаггүй

Беелзебул (ш.15)—Сатан

Өмч хөрөнгө (ш.21)—Эд зүйлс юмуу хөрөнгө

Олз (ш.22)—Булааж авсан эд зүйлс

Таныг тээсэн хэвлий, таныг торниулсан хөх нь ерөөлтэй еэ (ш.27)—Таныг төрүүлж, тэжээн өсгөсөн эх адислагдсан болой

Иона (ш.29)—Иона (Аварга загасанд залгиулсан Хуучин Гэрээний бошиглогч)

Хулгай дээрэм (ш.39)—Дээрэм

Гаа, сүлүү (ш.42)—Цэцэрлэгт тарьж ургуулдаг хоёр төрлийн өвс

Доромжлон гутааж байна (ш.45)—Доромжилж байна

Ачаа (ш.46)—Ачаа, дарамт

Булш (ш.47–48)—Онгон, бунхан буюу булш

Хорсол нь буцалж (ш.53)—Ихэд эгдүүцэн дургүйцэж

Лук 11:5—13—Шоно Дундын Найзын Тухай Сургаалт Слгэр

Хэрэв хүн өөрийн бүхий л амиа хичээсэн байдлаар хөршийнхөө гуйсан юмыг итгэлтэйгээр, мөн зав шударга санаа бодолтойгоор шаргуу гуйсны эцэст өгөхөөс дургүйцэж, түр хугацаагаар татгалзсан ч өгдөг, тэгээд ингэж хичээнгүйлэн гуйсан зүйлийг нь Бурхан түүнд заавал соёрхох болно гэдгийг Их Эзэн заажээ.

Лук 11:29—32—“Бошиглогч Ионагийн Тэмдэг Юу вэ?”



“Ионагийн оршуулга ‘аварга загасанд’ байж урагш гарч ирсэн нь (Иона 1:15–17; 2) Христийн үхэл, оршуулга хийгээд амилуулалтыг бэлэгддэг” гэж Ахлагч Брус Р.МакКонки бичжээ (*Mormon Doctrine*, 2 дахь хэвлэл. [1966], 711–12).

Лук 11:52—“Мэдлэгийн Түлхүүр” Гэдгээр Есүс Юуг Хэлсэн бэ?

Лук 11:53-ын Иосеф Смитийн Орчуулга мэдлэгийн түлхүүр нь судруудад холбогдоно гэж тайлбарласан байдаг. Ахлагч Брус Р.МакКонки тайлбарлахдаа:

“Судруудын эсрэг чөтгөр дайн зарладаг. Тэр тэдгээрийг үзэн ядаж, тэдгээрийн энгийн тодорхой утгыг мушгин гуйвуулж, чадаж байгаа үедээ тэдгээрийг устгадаг. Түүний устгах, голж хаях, сольж өөрчлөх, ялзруулах, өөр болгох, засвар оруулах зэрэг уруу таталтуудад анхаарсан хүмүүсийг тэр дор нь хөдөлгөж, тийнхүү хүмүүнийг ‘авралд ухаалаг’ болоход туслах түлхүүрийг холдуулан зайлуулдаг. (2 Тимот. 3:15–17.)

“Үүний улмаас, иудейчүүдийг удирдаж, гэгээрүүлэх учиртай судруудыг бохирдуулж, устгасан тэдний дээр Есүс халаглалыг овоолдог билээ” (*Doctrinal New Testament Commentary*, 1:624–25).

Судруудыг Судлах нь

Лук 11-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Сургаалт Зүйрлэлийг Тайлбарла

Хэрхэн залбирахыг шавь нартаа заасны дараа (Лук (Лук 11:1–4), залбирал хэрхэн үйлчилдгийг ойлгоход нь тэдэнд туслахын тулд Есүс хоёр богинохон сургаалт зүйрлэлийг тэдэнд өгчээ. Сургаалт зүйрлэлүүдийг уншиж (ш.4–13), бидний залбирлуудын талаар эдгээр нь бидэнд юу зааж байгааг өөрийн үгээр тайлбарла.

Б Халаг, Халаг, Халаг

“Халаг” гэдэг нь харуусал буюу уураа дуу алдан илэрхийлж, ёс бусчуудыг буруутган зэмлэх хэлбэр юм. Дараахтай адил схемийг тэмдэглэлийнхээ дэвтэрт хийж, жагсаасан таван өгүүлбэрийг Лук 11:37–53-аас эрж олоод, Есүс яагаад үйлдэл бүрийг буруутган зэмлэснийг, мөн Есүс хүмүүсийг хэрхэн өөрчлөхийг хүссэн хийгээд үүнтэй төстэй юуг өнөөдөр хүмүүс хийдэг гэж боддоггоо тайлбарла.

Лук 11-ээс Гарсан Хэлц Үг	Есүс яагаад тэр үйлдлийг буруутгасан бэ?	Хүмүүс ямар өөрчлөлт хийгээсэй гэж Есүс хүсч байсан гэж та нар боддог вэ?	Үүнтэй төстэй юуг хүмүүс өнөөдөр хийдэг вэ?
“Аяганыхаа гадна талыг цэвэрлэ” (ш. 39)			
“Та нар гаа, сүлүүнийхээ аравны нэгийг өргөдөг” (ш. 42)			
“Тэргүүн суудалд [хамгийн сайн] залрах дуртай” (ш. 43)			
“Үүрэхэд бэрх ачаагаар хүмүүсийг дардаг” (ш. 46)			
“Та нар бошиглогчдын булшийг барьж босгодог” (ш. 47)			

Лук 12

“Та Нар Бурханы Хаант Улсыг Хай”

Аврагчийг дагахын тулд бид дэлхийн ёс бус явдлыг ардаа орхих ёстой. Анхаарал сарниулах олон зүйл болоод уруу таталтуудын улмаас энэ нь хэцүү байж болно. Гэсэн хэдий ч Өөрийг нь дагадаг хүмүүст Есүс агуу адислалуудыг амладаг билээ. Лук 12-ыг уншихдаа Есүс Өөрийн шавь нараас юу шаарддагийг хийгээд Тэрээр ямар амлалтууд өгснийг эрж ол.

Судруудыг Ойлгох нь



Лук 12

Гишгэчин (ш.1)—Гишгэлэх

Хөрөнгө (ш.1)—Исгэх хөрөнгө

Хүлээн зөвшөөрөх (ш.8)—
Хүлээн зөвшөөрөх

Захирагчид (ш.11)—
Удирдагчид, толгойлогчид,
эсвэл эрх мэдэлтнүүд

Шунал (ш.15)—
Шунахайрал

Хадгалах байр сав
(ш.17–18)—Газар, агуулах
Уртасгах (ш.25)—Өндөрсгөх
Нэг хором (ш.25)—
Ойролцоогоор 18 инч буюу
5 метр
Ажиллах (ш.27)—Ажиллах
Утас ээрэх (ш.27)—Хувцас
хийх олс болон утас ээрэх
Хувцаслах (ш.27)—Хувцас
өмсөх

Судруудыг судлах нь



Лук 12-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Дуртай Шүлгээ Сонго

Лук 12-ыг уншихдаа өөрсөдөө хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн гурван шүлгийг сонгож олоод, дараах асуултуудад хариулах юмуу хий.

1. Эдгээр шүлэг бүрийг та нар яагаад сонгож авсан бэ?
2. Эдгээр шүлэг тус бүрээр юу заахыг хичээж байна гэж та нар боддог вэ?
3. Эдгээр шүлгүүдээс нэгийг нь цээжилж, үүнийг гэр бүлийнхээ гишүүн, багш, эсвэл найздаа зориулж иш тат.

Б Тоонд Юу Байдаг вэ?

Лук 12:15-ыг уншаад, Есүс юуны эсрэг сэрэмжлүүлснийг ол. Шүлэг 16–21-ийг уншиж, дараах асуултуудад хариул:

1. Баян хүн Их Эзэн өөрийг нь адисалсан зүйлүүдийн талаар юу гэж боддогоо дүрслэхдээ *би*, эсвэл *миний* гэсэн үгийг хичнээн удаа хэрэглэсэн байна вэ?
2. Энэ нь түүний хандлагын талаар юуг харуулж байна вэ?
3. Аврагчийн сургаалт зүйрлэл “шуналаас сэрэмжлэхийг” заахад хэрхэн тусалсан бэ?
4. Дэлхийн үнэт эрдэнэсийн талаар та нар энэ сургаалт зүйрлэлээс юуг мэдэж болох вэ?



В Өгүүлбэрүүдийг Төгсгө

Лук 12:35–48-ыг унш. Эндээс олсон мэдээллүүдээр дараах өгүүлбэрүүдийг гүйцээ.

1. Сэрэмжтэй байж . . . -д бэлтгэ.
2. Хэрэв бид хэзээ гэдгийг нь мэдэх юм бол, бид . . . болно.
3. Эзэнийг эргэж ирэхэд зарц нар нь . . . ёстой.
4. . . . байхад эзэн нь эргэж ирэх болно.
5. . . . зарц нарыг эзэн нь шийтгэх болно.
6. . . . их зүйл хүсэн хүлээгддэг.

Лук 13

Наманчил Эс Бөгөөс Мөхөгтүн

Өөрсдийн тань дуртай жимсээр дүүрэн мөчрүүдтэй гоё сайхан мод байна гэж төсөөлөн бод. Жимс нь томорч, боловсорч гүйцээд, амтлаг сайхан үнэртэнэ. Одоо, өтгөн сахлаг навчнуудтай, том том мөчиртэй жимсний модыг төсөөлөн бод. Хэдий тийм ч гэсэн, цаг нь болчихоод байхад, бүр тулаад хартал, тэр модон дээр ядахдаа ганцхан ч жимс харагдахгүй байна. Зөв шударга ёс хийгээд наманчлалын тухай заахын тулд Есүс энэ сургаалт зүйрлэлийг ашиглажээ.

Лук 13-ыг уншихдаа наманчлалын тухай заасан бусад зүйлүүд хийгээд эдгээр заасан зүйлүүд та нарын амьдралд хэрхэн хэрэгждэгийг ол.

Судруудыг Ойлгох нь



Лук 13

Цэцэрлэгчид (ш.7)—
Цэцэрлэг асрагч (тайран
арчилж, гэжээн тордож,
хураадаг нэгэн)

Юунд газрыг дэмий эзлэх гэж (ш.7)—Яагаад хөрсийг дэмий ашиглах гэж

Үүнийг бордох (ш.8)—
Модыг бордох

Бөгтөр болох (ш.11)—

Бөгтийсөн буюу цэх
шулуун биш

Гурван хэмжүүр гурил (ш.21)—Их хэмжээтэй гурил

Дэгдээхий (ш.34)—Тахианы дэгдээхий

Хоосон (ш.35)—Дотроо юмгүй

Лук 13:1–5—“Хэрэв Та Нар Наманчлахгүй Бол, Та Нар Бүгд Сүний Адил Мөхнө”

Ахлагч Брус Р.МакКонки эдгээр шүлгүүдийг тайлбарлаж бичихдээ:

“Осол, хэрцгий үхэл болон бусад гай зовлонгуудыг Бурхан хувь хүмүүсийн нүглүүдийн улмаас тэдэн дээр илгээдэг үү? Есүсийг сонсогчдын дунд ч ингэж боддог хүмүүс байсан бололтой. Ийнхүү, золгүй явдалд өртөгсөд амь нас нь хадгалагдаж үлдсэн нөхдөөсөө илүү ихээр нүгэл үйлдэгчид байгаагүй гэдгийг эзэн тод томруунаар хэлснийг бид олж мэддэг.

“Гай түйтгэр, гамшиг зовлон, өвчин тахал, зовлон шаналлыг Бурхан эсэргүүцэгчид дээр илгээж, бас өөрийг нь хайрлаж, өөрт нь үйлчилдэг хүмүүсийг хадгалж хамгаалдаг ерөнхий зарчим үнэн билээ. . . .

“Дайнд алагдсан, ослоор амь насаа алдсан, өвчин тахалд нэрвэгдсэн буюу байгалийн гамшигт өмч хөрөнгө нь үрэгдсэн хувь хүмүүс нөхдийнхөө дундаас авагдаж, бүр цээрлэл шийтгэл тэдний хувьд зүй ёсны мэтээр хэлэх нь огт баталгаагүй юм. Хувь хүнд тохиосон зовлон зүдгүүр буюу осол аюул нь түүний бурханлиг бус замналын төлөөх шийтгэл мөн хэмээн дүгнэлт хийх нь хүмүүний эрх дарх биш.

“ . . . Эндээс үзэхэд, Их Эзэн Өөрийн гэгээнтнүүдийн хамгийн зөв шударга хэсгийг сорьж туршихын тулд тэдэн дээр бэрхшээлүүдийг тохоон авчирдаг. . . .

“ ‘Хэрэв та нар наманчлахгүй бол та нар бүгд үүний адил мөхнө’ гэсэн Есүсийн дүгнэлтээс авах бодит сургамж бол алагдсан хийгээд амьд байгаа хүмүүсийн хооронд зөв шударгын ялгаа байгаагүй, мөн амьд байгаа нь эс наманчлах аваас, тэд үхэгсдийн хамт мөхөх болно гэсэн ойлголт юм” (*Doctrinal New Testament Commentary*, 1:475–76).

Судруудыг Судлах нь




Лук 13-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Сургаалт Зүйрлэлийг Тайлбарла

Лук 13:6–9 дэх сургаалт зүйрлэлийг уншиж, Есүсийн дүрсэлсэн зүйлийн зургийг зур. Уг зүйлийг тайлбарлахад тохиромжтой гэж өөрсдийн бодсон нэг үг буюу өгүүлбэрээр зүйл тус бүрийг нэрлэ. (Жишээ нь, тариалагч нь Бурханыг, инжирийн мод нь Есүсийн дунд нь амьдарч байсан иудейчүүдийг төлөөлж байгаа болно.)

Б Судруудтай Адилтга

Лук 13:10–17 Хүндэтгэлийн өдөр синагогт эдгээгдсэн нэг эмэгтэйн тухай өгүүлдэг. Энэхүү түүхийг өөрсдтэйгөө адилтгахад туслах хийгээд Аврагч Өөрийн гайхамшигт хүчээр та нарыг хэрхэн адислаж чадах тухай мэдэж авах асуултуудад хариул.



1. Юу хүнийг сүнс-лэг байдлын хувьд “бөгтийл-гөхөд” (ачаа үүрч яваа мэт бөхийх) хүргэж болох вэ?
2. Лук 13:12–13-ыг унш. Бид асуудлаасаа “чөлөөлөг-дөж”, “шулуун болохын” тулд Есүс биднийг хэзээ дуудаж болох вэ?
3. Шүлэг 16-гийн дагуу, биднийг юунаас чөлөө-лөгдсөн байхыг Есүс онцгойлон хүсдэг вэ?

В Сургаалт Зүйрлэл Бич

Сүмийн өсөлт хөгжилтийн тухай заадаг хоёр сургаалт зүйр-лэлийг Есүс Лук 13:18–21-д өгчээ. Энэ хоёр сургаалт зүйрлэ-лийг уншаад, Сүмийн өсөлтийг дүрслэн харуулахын тулд өөрсдөө нэг сургаалт зүйрлэл бич (өөрсдийн мэдэх жишээ-нүүд буюу амьдралаасаа авсан зүйлүүдээр). (Хөрөнгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Марк 8:15-ын “Судруудыг Ойлгох нь”-оос үз).

Лук 14

Шавилах Ёсны Үнэ Цэнэ

Тухайн үед Тэргүүн зөвлөлийн Хоёрдугаар Зөвлөх асан, Ерөнхийлөгч Марион Ж.Ромни, “Түүний шавь болох Христийн урилга ертөнц дахины юм. Тэрээр үүнийг хүн

болгонд хүргэдэг. ‘Эцэж туйлдсан, хүнд даралт үүрсэн хүмүүс ээ, бүгд над уруу ир, би та нарт амралтыг өгье’ (Матай 11:28) гэсэн нь Түүний дуудлага мөн амлалт юм. . . . Есүс урилган дээрээ мөнгөөр үнэлэх шошго тавиагүй. ‘Дэлхийн хязгаарууд та нар бүгд надад ирэг-түн, мөнгөгүйгээр, мөн төлбөргүйгээр сүү болон бал худалдаж авцаа’ хэмээн түүний хэлснийг Нифай иш татсан байдаг (2 Нифай 26:25). Гэсэн хэдий ч, энэ нь тэрбээр мөнгөний үнийг үүн дээр тавиагүй учир энэ нь үнэгүй гэсэн хэрэг биш юм. Христийн шавь болоход төлөх үнэ цэнэ, нэн бодит үнэ цэнэ буй. Гэвч энэ үнэ цэнэ бол мөнгөнхийг биш, гүйцэтгэлийн үнэ цэнэ билээ” (in Conference Report, 1978 оны 9–10-р сар, 53–54; or Ensign, 1978 оны 11-р сар, 38).

Лук 14-ийг уншихдаа Есүс Христийн шавь болохтой холбогдсон зарим үнэ цэнийг эрж хай.

Судруудыг Ойлгох нь



Лук 14

Усан хаван (ш.2)—Хаван, арьсан доор шингэн хуримтлагдаж, өвчнийг харуулсан хавдар мэт болох
Уригдсан (ш.7–8, 10)—Уригдсан, залагдсан

Ажигласан (ш.7)—Харсан
Номхруулагдаж (ш.11)—Даруусгагдаж, эсвэл томоо-жигдсон
Хариу барина (ш.12, 14)—Хариуд нь ямар нэг юм хийх

Лук 14:26–27—Бид Гэр Бүлээ Сээн Ядах Ёстой Юу?

“Үзэн ядах гэдгийг ихэд жигшин дургүйцэх гэсэн утгаар [Есүс хэлээгүй юм]; энэ нь сайн мэдээний бүхэл үзэл санаа хийгээд өнгө аяст харш юм. Хүмүүс өөрсдийнхөө мах цусны тасархайгаас гадна, бүр дайнаа ч хүртэл хайрлах ёстой (Матай. 5:43–48). Тийнхүү, Есүсийн энэ зааврын утга учир нь, үнэн шавь нар гэр бүлийн буюу хувь хүний үүргээсээ илүүгээр Их Эзэний өмнө үүрэг хүлээх ёстой гэсэн хэрэг мөн. [Матай 10:37; 19:27, 29; С ба Г 103:28-ыг бас үз]” (Doctrinal New Testament Commentary, 1:503).

Лук 14:28–33—“Та Нарын Хэн Чинь Цамхаг Барья Гэж Хүсвэл Эхлээд Сууж Зардлыг нь Тооцдог Вэ?”

Сүмд элсдэг хүмүүс сайн мэдээнд шаардагддаг золиослолуудыг хийхийн тулд бэлтгэгдсэн байх ёстой. Бүр баптисмынхаа өмнө хөрвөгчид эдгээр зардлуудыг анхаарч тооцон Есүсийн заадаг зүйлүүдийг бүрэн дагахын төлөө шийдвэр төгс байх ёстой. Ерөнхийлөгч Жон Тейлор шинэ дуудлагад бэрхшээлтэй тулгарсан тухайгаа: “Би анх Мормонизмд орж ирээд, хийж байсан юмаа бүрэн ойлгож, би өртөг зардлыг нь тооцож үзсэн байлаа. Энэ бол насан туршийн хөдөлмөр юм байна гэж би үзсэн, тэгээд би зөвхөн цагаа төдийгүй, бас үүрд мөнхийн төлөө гэдгийг ухаарсан байлаа, хэдийгээр надад мэдэх юм алга гэж бодож байсан ч, эдүгээ би ухрахыг хүсээгүй юм” хэмээн өгүүлсэн байдаг (in B. H. Roberts, The Life of John Taylor [1963], 48).

Судруудыг Судлах нь



Лук 14-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Зарчим нь Юу Вэ?

Та нар судруудыг уншихдаа үе үе зогсолт хийж “Эдгээр шүлгүүд дэх зааж байгаа зүйлүүдээр ямар асуулт, асуудалд хариулагдаж буюу шийдэгдэж байна вэ?” гэдгийг өөрсдөөсөө асууж байх хэрэгтэй. Лук 14:7–14-ийг уншихдаа, энд заагдаж байгаа зүйлээр хариулагдаж байгаа, наад зах нь нэг чухал асуултыг бич, тэгээд дараа нь уг асуултын хариуг өөрсдийн үгээр бич.

Б Шалтгаануудыг Жагсаа

Лук 14:15–24 дэх сургаалт зүйрлэл нь нэгэн агуу оройн зоогт уригдсан олон хүний тухай өгүүлдэг.

1. Дараах хүснэгтийг тэмдэглэлийнхээ дэвтэрт зур. Сургаалт зүйрлэл дэх уригдсан хүмүүсийн тоочсон шалтгаануудыг жагсаа, дараа нь сургаалт зүйрлэлд байгаагай адил төстэй өнөө үеийн шалтгаануудыг жагсаан бич.

	Сургаалт Зүйрлэл дэх Шалтгаан	Өнөө Үеийн Шалтгаан
Лук 14:18		
Лук 14:19		
Лук 14:20		

2. Сургаалт зүйрлэлийн гол зарчмыг нэгтгэн дүгнэ.

В Зардлыг Авч Сэ

Лук 14:25–34 нь Христ Өөрийн шавь нараас хүсэн хүлээж байсан зарим зүйлүүдийн тухай өгүүлдэг.

1. Эдгээр шүлгүүдийг уншаад, хүсэн хүлээж байсан аль болох олон зүйлийг чадахаараа олж жагсаа.
2. Өөрийг нь дагахын тулд яагаад ийм их золиослол хийхийг Аврагч биднээс хүсдэг гэж та нар боддог вэ?
3. Эдгээр заасан зүйлүүдийг дагахын тулд та нарын хийж болох зарим өвөрмөц зүйлүүд юу вэ?
4. Христийн шавь нар болох тэдгээр хүмүүст ямар адислалууд ирнэ гэж та нар итгэдэг вэ?

Лук 15

Сургаалт Зүйрлэлүүдийн Цаг



Сургаалт зүйрлэл бол мөнхийн үнэнийг заадаг богинохон өгүүлэг юм. Есүсийн сургаалт зүйрлэлүүд энгийн зүйлүүд байдаг ч эдгээр нь шашны чухал үнэнүүдийг заадаг. Сургаалт зүйрлэлүүд нь оюун билгийн хүчнээс илүү Сүнсний хүчээр үнэнийг ойлгоход хүмүүст тусалдаг. Лук 15–16 дахь олон сургаалт зүйрлэл нь бодгалийн

үнэ цэнэ болон бусдад тусалж, тэднийг адислах бидний үүргийн тухай заадаг.

Судруудыг Ойлгох нь



Лук 15

Дур зоргоороо (ш.13)—
Дураараа, хяналтгүй

Тэврээд (ш.20)—Тэвэрч
Аргадан гуйж (ш.28)—Гуйж

Лук 15:3–22—Хонь, Зоос, Тэрчлэн Срэлгэн Хүү Тус Бүртээ Оор Оор Шалтгаанаар Алдагдсан Байлаа

Энэ гурван сургаалт зүйрлэлд алдагдсан зүйлүүдийг Ерөнхийлөгч Давид О.МакКей өнөө үед Их Эзэний хүүхдүүд алдагддаг зарим арга замуудтай харьцуулжээ:

Алдагдсан Хонь: “Хонь хэрхэн алдагддаг билээ? Тэр эсэргүүцэн тэмцээгүй. Хэрэв та нар харьцуулж үзэх юм бол, хурга амьдралын төгс байдлыг, нэг бол гэнэн тэнэгдүүхнээр, эсвэл ухамсаргүйгээр эрж хайн, бэлчээрээр уруу татагдаж, илүү сайхан өвстэй газрыг эрж хайсаар, сүргээсээ тасарч, алдагдсан байж болно.”

Алдагдсан Зоос: “Энэ тохиолдолд алдагдсан зүйл алдагдсаныхаа төлөө өөрсдөө хариуцлага хүлээх боломжгүй. Энэ зоосыг итгэл хүлээлгэж өгсөн хүн анхааралгүй буюу тоомжиргүйгээс, буруу газарт тавсан буюу хаясан ажээ.”

Алдагдсан буюу Үрэлгэн Хүү: “Энд хүслийн, сонголтын, зориудын сонголтын тохиолдол бий. Энд, ямар нэг байдлаар эрх мэдлийн эсрэг тэмцэл бий” (in Conference Report, 1945 оны 4-р сар, 120–21, 123).

Судруудыг Судлах нь

Лук 15-ыг судлахдаа дараах үйл ажиллагаанууд (А буюу Б)-гээс нэгийг нь хий.

А Хүснэгтийг Бөглө

Дараах бүдүүвчийг тэмдэглэлийн дэвтэртээ хуулж ав. Лук 15-д өөрсдийн олсон мэдээллүүдээр үүнийг бөглө.

Сургаалт Зүйрлэл	Олдсон Шүлгүүд	Гол Санаа	Сургаалт Зүйрлэлийн Өнөө Үеийн Жишээ	Сургаалт Зүйрлэлд Тэдэнд Хэрхэн Тусалсан бэ?	Өнөөдөр Ийм Байдлаар Алдагдсан Хүнд Та Нар Хэрхэн Тусалж Чадсан Бэ?
Алдагдсан Хонь		Сүмээс хонди?рч алга болсон хүмүүс		Ерэн есөн хонио орхиж, алдагдсан хони?г аварсан хоньчин	
	Лук 15:8–10		Болгоомж-гү? буюу бүдүүлэг шүүмжлэл хэн нэгни? сэтгэлд сөв суулгаж, тэгээд тэр хүн сүмд ирэхээ больжээ.		
Үрэлгэн Хүү		Эсэргүүцэж, Сүми?г орхидог хүмүүс			

Б Захидал Бич

Лук 15-ыг уншсаны дараа дараах хэлбэрийн захидлуудаас нэгийг тэмдэглэлийн дэвтэртээ бич. (Даалгаврыг буцаж өгсний дараа, та нар үүнийг бичсэн хүндээ шуудангаар явуулж болно.) Захидлын нэг хэсэг болгон, захидлыг хүлээж авах хүнд туслах болно гэж өөрсдийн бодсон, наад тал нь судрын таван шүлгийг энд оруул.

1. Өөрсдийн таньдаг номлогчдод бичих захидал. Тэнгэрлэг Эцэгийн алдагдсан хүүхдүүдийг олохоор хичээж буй номлогчийн ажилд нь урам хайрлаж, талархал илэрхийл.
2. Номлолд бэлтгэж байгаа өөрсдийн тань таних хүнд бичих захидал. Лук 15-аас мэдсэн зүйлийнхээ тухай түүнчлэн энэ нь номлолын үйлчлэлд бэлтгэхэд нь түүнд хэрхэн туслах талаар ярь.
3. Өөрсөддөө зориулж бичээд, лацдаж, номлолын нас хүртлээ задлахгүй байх захидал. Лук 15-ыг судалснаас төрсөн сэтгэгдлээ тэрчлэн номлогчийн ажлын талаарх өөрсдийн зорилгуудыг тэмдэглэ.

Лук 16

Бурханыг Угтахаар Бэлтгэх нь

Лук 15 дахь сургаалт зүйрлэл Их Эзэн нүгэл үйлдэгчдийг хичнээн их хайрладаг хийгээд “алдагдсан” хэн нэгэн наманчлахаар шийдсэн үед нь хичнээн их баяртай байдагт онцгой анхаарчээ. Лук 16 дахь сургаалт зүйрлэлүүд хийгээд заадаг зүйлүүд нь шүүлтийн өмнө Их Эзэн рүү эргэх нь яагаад чухал болохыг бидэнд сануулахаар эдгээр санаанууд дээр нэмэгджээ.

Судруудыг Ойлгох нь



Лук 16

Нярав (ш.1–3)—Зарц, үйлчлэгч

Ажил үүрэг (ш.2–4)—Хариуцсан ажил, үүрэг

Эд баялаг (ш.9, 11, 13)—Дэлхийн баялаг, эд агуурс

Жигшмээр юмс (ш.15)—Ёс бус явдал

Найрлан цэнгэдэг (ш.19)—Тансаглан амьдардаг

Абрахамын өвөр (ш.22)—Сүнний ертөнц, бүр тодруулбал диваажин

Үхэгсдийн орон (ш.23)—Сүнний шорон

Лук 16:1–15—Яагаад Их Эзэн Энэ Сургаалт Зүйрлэлд Шударга Бус Няравыг Жишээ Болгон Ашигласан Бэ?

Бид тэр нярав шиг шударга биш байх ёстой гэж Есүс хэлээгүй юм. Үүний оронд амьдрал нь мөнгөний орчинд төвлөрдөг хүн ч гэсэн ирээдүйгээ төлөвлөх явдлыг хангалттай мэддэг байх ёстойг Тэрээр заажээ. Бурханы зүйлүүдийг ойлгодог хүмүүс ирээдүйн төлөө—дараагийн амьдралын төлөө илүү хичнээнгийг төлөвлөх ёстой вэ. Тэдгээр шуналтай Фарисайчууд Бурханы дагалдагчдын дүр үзүүлдэг байсан хэдий ч, дэлхийн санал болгодог зүйлүүдийг олж авахад илүү их анхаардаг байлаа.

Лук 16:14–23—“Фарисайчууд . . . Түүгээр Доог Тохуу Хийж Байлаа”

Бошиглогч Иосеф Смит, ИСО, Лук 16:16–23-т байдаг, сүнсээр нөлөөлөгдсөн хэд хэдэн өөрчлөлт энэхүү хам сэдэвт оруулсан билээ. Уг өөрчлөлтүүд нь бидний ойлголтыг (1), Фарисайчуудын ичгүүргүй ёс бус байдал, (2) Аврагч тэднийг шууд зэмлэсэн байдал, (3) Фарисайчуудын гэм буруутай байсан тодорхой нүглүүдийн талаар өргөжүүлдэг бөгөөд эдгээр нь тэднийг Лук 16:18–31 дэх заадаг зүйлүүд хийгээд сургаалт зүйрлэл рүү хөтөлдөг билээ.

Диваажин болон сүнний шоронгийн хоорондох ангалыг Есүс Христ холбов.



Судруудыг Судлах нь



Лук 16-г судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Сургаалт Зүйрлэлийг Өөрсдийн Сгээр Дахин Бич

Шударга биш няравын тухай сургаалт зүйрлэл (Лук 16:1–14), эсвэл баян хүн ба Лазарын тухай (Лук 16:19–31-ийг үз) сургаалт зүйрлэлийн аль нэгийг сонгож, дараах зүйлийг хий:

1. Сургаалт зүйрлэлийн эхний шүлгийг унш.
2. Уг шүлгийг өөрсдийн үгээр дахин бич.
2. Сургаалт зүйрлэлийн шүлэг бүрийг ийм байдлаар үргэлжлүүл

Лук 17

Бурханы Хаант Улс Хэзээ Ирэх Вэ?

Хоёр дахь Ирэлтийн талаар Есүс шавь нартаа заасан юм. Тэрээр Өөрийн ирэлтийн яг тодорхой хугацааг тэдэнд хэлээгүй. Үүний оронд Тэрээр, олон хүмүүсийг гайхахад хүргэх тэрхүү өдөрт бэлтгэх тухай тэдэнд ярьжээ. Итгэл, дуулавартай байдал, үйлчлэл, талархал хийгээд ёс бус явдлаас зайлсхийхийг багтаасан, Лук 17-д байдаг заасан зүйлүүд Христийн ирэлтэд бэлэн байхыг хичээдэг хүмүүсийн хувьд чухал юм. Та нар энэ бүлгийг уншихдаа, эдгээр заасан зүйл бүр нь эцсийн өдрүүдэд хэрхэн бэлтгэх хийгээд та нарыг хэрхэн хамгаалахыг анхаарч үз.

Судруудыг Ойлгох нь



Лук 17

Бүдрэх чулуууд (ш.1)—
Хүмүүсийг бүдрүүлэх буюу
нүгэл үйлдэхэд хүргэх үйлд-
лүүд

Тээрмийн чулуу (ш.2)—
Тариа тээрэмдэхэд ашигла-
даг байсан том дугуй чулуу
Идэх (ш.8)—Идэх

Бүсээ бүслэх (ш.8)—Бэлтгэх
(ажил хийхэд бэлэн байхын
тулд урт орхимжоо бүсэн-
дээ шууж уяахыг хэлж бай-
гаа)

Ноа (Ное) (ш.26, 27)—Ноа
Тэнд (ш.37)—Тэр газарт,
тэнд

Лук 17:11–19—Эдгэрсэн Уяман Өвчтэй Арван Хүнээс Зөвхөн Нэг нь л Есүст Талархлаа Харуулав

“Тусыг мартаж нь Их Эзэний уурыг дүрэлзүүлдэг гашуун нүгэл юм. (С ба Г 59:21-ийг үз.) . . . Аврагч уяман өвчтэй арван хүнийг эдгээхэд зөвхөн нэг нь л түүнд талархсанд тэрээр тусыг мартагч нөгөө ес рүү зааж, бүгдэд сургамж болгон, ‘Арван хүн цэвэршээгүй байх нь ээ?’ гэж хэлжээ (Лук 17:17.) Насанд хүрэгчид түүнчлэн залуучууд өөрсдөд нь бүхнийг өгсөн Тэнгэрлэг Эцэгтээ дуулгаваргүй, талархалгүй байснаар гэм буруутай байх нь олонтаа тохиолддог. Олон хүмүүс үйлчлэлээр дамжуулан, гэр бүлийн залбирлуудаар дамжуулан, аравны нэгээ төлснөөр, түүнчлэн Бурхан хүсэн хүлээх эрхтэй өөр үй олон арга замаар талархлаа илэрхийлэхэд алдаж энддэг” хэмээн Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл бичжээ (*The Miracle of Forgiveness*, 58–59).



Судруудыг Судлах нь



Лук 17-г судлахдаа үйл ажиллагаа Б, түүнчлэн нөгөө хоёр үйл ажиллагаанаас (А буюу В) нэгийг нь хий.

А Адил Төстэй Судрыг Харьцуул

Лук 17:5–10, Мозая 2:18–22-ыг унш.

1. Эдгээр шүлгүүдэд адил төстэй юуг та нар олж харав?
2. “Ашиггүй зарц нар” гэсэн холбоо үгийн зааж байгаа гол захиас юу вэ?

Б Бүр Ойртож Хар

Лук 17:11–19-д уяман өвчтэй арван хүнийг эдгээсэн тухай түүхийг дахин унш.

1. Уяман өвчтэй арван хүнд ямар адислал ирсэн бэ? (ш.14-ийг үз).
2. Талархал илэрхийлсэн уяман өвчтэй хүнд ямар нэмэлт адислал ирсэн бэ? (ш.19-ийг үз).
3. Эдгэрэх, эрүүл болох хоёрын хоорондын ялгаатай талыг мэдэх ач холбогдлыг та нар юу гэж боддог вэ?
4. Талархал илэрхийлсэн уяман өвчтэй хүн самари хүн байв. Самаричуудын тухай та нар мэддэг зүйлээсээ энэ нь яагаад уг түүхийн чухал хэсэг гэж боддог вэ?

В Хоёр Дахь Ирэлт

Лук 17:22–23-ыг уншаад, Хоёр дахь Ирэлтийн үед дэлхий ямар байдалтай байхыг түүнчлэн тэр үед хүмүүс юу хийж байх тухай бод. Эдгээр шүлгүүдэд ямар чухал зөвлөгөө өгөгдсөн, тэрчлэн энэ зөвлөгөө өнөөдөр яагаад хүмүүст хэрэгтэй гэж боддог тэмдэглэн бич.

Лук 18

Тэнгэр дэх Эрдэнэс

Та нар сэлэстиэл хаант улсад орохыг хүсдэг үү? Яагаад? Тэнд та нар ямар адислал хүлээж болно гэдэгт итгэдэг вэ? Тэнд орохын тулд та нар ямар хүн байх хэрэгтэй гэдэгт итгэдэг вэ?



“Бурханы хаант улсыг бяцхан хүүхэд адил хүлээн авахгүй хүн тийш ерөөсөө орохгүй” гэж Есүс сургажээ (Лук 18:17). Лук 18 дахь түүхүүд хийгээд сургаалт зүйрлэл

бүр нь Есүсийн заадаг зүйлүүдийг дагадаг итгэлтнүүд тэнгэрт орох болно гэдэг амлалтын эргэн тойронд төвлөрдөг. Та нар энэ бүлгийг уншихдаа, Есүсийн заадаг зүйл бүр нь хүүхэд лугаа адил болж, Түүний хамгийн агуу эрдэнэсийг хүлээн авахад тохирохоор та нарт хэрхэн тусалж чадахыг эрж хай.

Лук 18-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 18:15–30—Матай 19:13–29; Марк 10:13–30
Лук 18:31–34—Матай 20:17–19; Марк 10:31–34
Лук 18:35–43—Матай 20:29–34; Марк 10:46–52

Судруудыг Ойлгох нь



Лук 18

Өмгөөлөх (ш.3, 5, 7–8)— Шударга хандах
Удтал хойшлуулах (ш.7)— Тэвчих, тэсэх
Зальхай, шударга бус (ш.11)—Дээрэмчид, хилэн-цэгийг үйлдэгчид

Номхруулагдаж (ш.14)— Даруусгагдаж
Өчнөөн дахинаар (ш.30)— Олон дахин
Доромжлон (ш.32)— Доромжилж

Лук 18:1–8—Их Эзэн Яагаад Шударга Бус Шүүгчийн Тухай Сургаалт Зүйрлэлийг Өгсөн Бэ?

Ахлагч Е.Талмейж, “Ёс бус шүүгч эцэстээ Бурханы хийж болох даруухан залбиралд бууж өгснийг Есүс харуулаагүй юм; харин бүр Бурханаас эмээдэггүй, хүмүүнийг ч хүндэлдэггүй энэ шүүгч лугаа адил хүн эцсийн эцэст сайхь бэлэвсэн эмэгтэйн гуйлтыг сонсож, гүйцэлдүүлэх болно гэдэгт, Шударга, Нигүүлсэнгүй Бурхан [бидний залбирлуудыг] сонсож, бас хариулах болно гэдэгт хэн ч эргэлзэх хэрэггүйг заасан юм” гэж бичжээ (Jesus the Christ, 436; мөн D&C 101:81–92-ыг үз).

Судруудыг Судлах нь



Лук 18-ыг судлахдаа үйл ажиллагаанууд А, Б-г хий.

А Өөрсдийн Сгээ Ашигла

Лук 18:1–8 дахь шударга биш шүүгчийн тухай сургаалт зүйрлэлийг уншиж, гол захиасыг нь юу гэж бодож байгаагаа өөрсдийн үгээр бич (мөн Лук 18:1–8-ын “Судруудыг Ойлгох нь”-ыг үз).

Б Харьцуулалт Хий

Лук 18:1-д бид үргэлж залбирч байх ёстойг Есүс сургажээ. Түүнээс гадна, Лук 18:9–14 дэх сургаалт зүйрлэл нь бид залбирч байхдаа тодорхой хандлагатай байх ёстойг заадаг. Сургаалт зүйрлэл дэх фарисай хүн болон татвар хураагчийг зэрэгцүүлэн тавьж, дараах бүдүүвчийг тэмдэглэлийн дэвтэртээ бөглөж, бас хуул.

	Фарисай Хүн	Татвар Хураагч
Хүмүүс түүний тухай юу гэж боддог байсан бэ?		
Тэр өөрсдийнхөө тухай юу гэж боддог байсан бэ?		
Тэр юуны төлөө залбирдаг байсан бэ?		
Энэ хоёр хүн тус бүрийн талаар Есүс юу хэлсэн бэ?		
Алма 31:13–20, 33:3–11-ийг унш. Хүн тус бүрийн залбирлаас аль нь хамгийн тохиромжтой гэж та нар бодож байна?		

Лук 19

Есүс Иерусалимд Ирэв

Есүс танай хотод, сургууль дээр тань, эсвэл гэрт тань ирэх гэж байгааг мэдлээ гэж төсөөлөн бод. Та нарт ямар санагдах вэ? Түүнийг баяртайгаар хүлээн авахын тулд та нар юу хийх вэ? Түүнийг хүлээн авахад бэлэн байхын тулд та нар юу өөрчлөх вэ? Есүс тэнд ажигласан зүйлийнхээ талаар юу хэлэхийг төсөөлөн бод. Тэр чамаас ямар өөрчлөлт хийхийг хүсэх бол? Тэр юунд баярлах бол? Тэр юунд сэтгэл дундуур байх бол?

Есүс Иерихог дайрч, Иерусалимд орж байгаа тухай өгүүлдэг Лук 19-ийг уншихдаа, Түүний ирэлтэд хүмүүс хэрхэн өөр байдлаар хариулж байгааг анхаар. Түүнчлэн эдгээр хотуудын хүмүүсийн талаар Түүнд ямар бодол төрснийг Есүсийн үйлдэл хэрхэн харуулж байгааг анхааралтай авч үз.

Лук 19-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 19:29–48—Матай 21:1–16; Марк 11:1–18

Судруудыг Ойлгох нь



Лук 19

Биеэр бага (ш.3)—Намхан
Түргэл, шалавхан (ш.5–6)— Яаран

Залилан (ш.8)— Түүнийг мэхэлж, хуурч

Мина (ш.13)—Нэг талант нь зуун мина байв; мөнгөний хэмжүүр

Хав дарчихсан (ш.20)—Хадгалчихсан

Хүү (ш.23)—Хөрөнгө оруулалтаас авдаг ашиг (мөнгөний хүү)

Лук 19:12–27—Энэ Сургаалт Зүйрлэлийн Тайлбар
Ахлагч Брус Р.МакКонки тайлбарлахдаа:

“Христ бол сурвалжит хүн; алс холын орон нь бол тэнгэр; түүнд өгөгдөх тэндэх хаант улс бол ‘... тэнгэр дэх мөн газар дээрх бүх хүч’ юм (Матай 28:18); мөн амлагдсан түүний эргэн ирэлт бол хаант улс газар дээр яг байхаараа, нүдэнд харагдахаар байгуулагдах тэрхүү Хоёр дахь Ирэлт юм. Арван үйлчлэгч бол түүний үйлчлэлд ашиглагдах бие бялдрын, оюуны хийгээд сүнсний хүч чадлыг (мина) тэрээр тэдэнд өгсөн Сүмийн гишүүд юм. ‘Иргэд’ хэмээн тодорхойлогдсон тэр хүмүүс бол, тэрээр бүхэл газар дэлхийн Бурхан учраас түүнд харьяалагддаг дэлхий дээрх хүмүүс боловч, түүний сайн мэдээг хүлээн авч, түүний сүрэгт үйлчлэгчид болж ирээгүй хүмүүс юм. Үйлчлэгчид Их Эзэнийг эргэж ирэх хүртэл түүний зараалд жимсний цэцэрлэгт хөдөлмөрлөхөөр зарлиг буулгуулсан юм. . . .

“Сурвалжит хүн дэлхийг шүүхээр эргэж ирэхдээ өөрийн үйлчлэгчдийг ажлуудынх нь дагуу шагнах болно. Бүгд бэлтгэгдсэн орон байрандаа нэгэн адил байдлыг хүлээн авахгүй, тэнд алдар суугийн зэрэглэлүүд буй. Зарим нь арван хот, бусад нь таван хот захирах болно, мөн залхуучууд бүхэлдээ өвлөх юмгүй байх болно.

“Ашиглагдаагүй авьяас чадвар хаягддаг; зөвөөр ашиглагдсан чадварууд төгс төгөлдөржилтөд хүртэл өсөн нэмэгддэг. Хичээл зүтгэлтэй үйлчлэгч бүрт агуу шагнал өгөгдөх болно; мөн залхуу түүнээс тэр ч байтугай, түүнд байсан гэрэл, чадварууд хийгээд авьяас билиг нь авагдах болно” гэжээ (*Doctrinal New Testament Commentary*, 1:572–73).

Судруудыг Судлах нь

Лук 19-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-гийн аль нэгийг хий.

А Өдрийн Тэмдэглэлд Оруулах



Та нар Лук 19-ийг уншихдаа Есүс Иерусалим уруу аялж, тэнд ялгууснаар ороход нилээд хэдэн хүмүүс түүнтэй холбоо тогтоохоор ирснийг үзэх болно. (Түүний амьдралын сүүлчийн долоо хоногт Есүсийн ялгуусан оролт эхэлснийг сана). Дараах хүмүүс тус бүрийг өөрсдийгөө байсан гэж бод. Есүстэй харилцсан тэдний туршлага судруудад та нарын олж үзсэн түлхүүр ойлголтуудтай

адил байсан гэж бод, ингээд тэд Аврагчийг хэрхэн ойлгож, хүлээн авах тухай бод. Эдгээр хүн тус бүрийн хувьд, энэ үед Есүстэй холбогдсон тэдний туршлагын талаар өдрийн тэмдэглэлдээ бич (та нар тэднийг таньдаг байсан мэтээр).

1. Закхай
2. Есүсийг дудран унаж Иерусалимд орж ирэхийг харсан цугласан олны нэг гишүүн.
3. Есүс ариун сүмийг цэвэрлэж байхад тэнд байсан нэг хүн.

Б Өнөө Сеийн Хувилбарыг Бич

Лук 19:11–27 дахь сургаалт зүйрлэлд мина гэдэг үгийг мөнгөний нэгжийн хувьд хэрэглэсэн байдаг. Энэ мөнгө бидэнд өгөгдсөн хийгээд энэ амьдралын туршид бид хөгжүүлэх ёстой ур чадвар, авьяас билгийг бэлэгддэг. Энэ сургаалт зүйрлэлийг уншиж, мөнхүү нэгэн адил сургамжийг заах энэ сургаалт зүйрлэлийн орчин үеийн хувилбарыг бич. Жишээ нь, сурвалжит хүний оронд ажил олгогч буюу эцэг эхийг ашиглаж болно.

Лук 20

Тэд Түүнийг Хөнөөхөөр Оролдож Байв

Лук 20 дахь үйл явдлууд Аврагчийн мөнх бус амьдралын сүүлчийн долоо хоногт болсон юм. Та нар үүнийг уншихдаа, дараах асуултуудыг анхаар: Иудейчүүдийн удирдагчид яагаад Есүсийг хөнөөхөөр оролдож байсан бэ? Тэднийг уурлуулах ямар шүүмжлэлүүдийг Есүс хэлсэн бэ? Өөрийн тохинууллын үед Есүсийн үзүүлсэн хайр, өрвөч сэтгэл хийгээд баяр хөөрийг онцгой мэдэрч байсан атлаа хүмүүс яагаад Түүнийг хөнөөхийг бодож байсан бэ? Бурханы хаант улсыг эсэргүүцдэг хүмүүсийг зохицуулах талаарх Аврагчийн үлгэр жишээнээс би юу сурч болох вэ?

Лук 20-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 20:1–8—Матай 21:23–27; Марк 11:27–33
Лук 20:9–19—Матай 21:33–46; Марк 12:1–12
Лук 20:20–39—Матай 22:15–33; Марк 12:13–27
Лук 20:40–47—Матай 22:41–23:15; Марк 12:34–40

Судруудыг Ойлгох нь

Лук 20

Доромжлон гутаагаад (ш.11)—Доромжлоод

Зөвт мэт дүр эсгэх (ш.20)—Итгэлтэй, зөв шударга хүмүүсийн дүр үзүүлэх

Хэнийг ч ялгалгүй (ш.21)—

Хэнийг ч тусгайлан үзэхгүй

Дүрс, бичээс (ш.24)—Зоосон дээр сийлсэн үгс

Өгөх (ш.25)—Өгөх

Үр удмыг залгуулах (ш.28)—Хүүхэдтэй болох

Дайснуудыг чинь би чиний хөлийн гишгүүр болгох

хүртэл (ш.43)—Дайснуудыг чинь би бүгдийг байлдан

дагуулах хүртэл

Лук 20:9–18—Ёс Бус Тариаланчдын Тухай Сургаалт Зүйрлэл

Энэ сургаалт зүйрлэл дэх зарцууд, эсэргүүцэгдэж байсан эртний бошиглогчдыг төлөөлдөг. Өв залгамжлагч бол, хүмүүсээр хүндлэгдэх ёстой атлаа эсэргүүцэгдэж, улмаар алагдсан Есүс Христ юм.

Лук 20:27–38—“Эхнэр ч Авахгүй, Нөхөрт ч Гарахгүй . . . Хүмүүс нь”

Гэрлэлт болон гэр бүлийн харилцаа үхлийн дараа үргэлжилж болно гэдгийг судрууд хийгээд өнөөгийн бошиглогчдын үгс тодорхой харуулдаг билээ (С ба Г 132:19–22; Матай 19:6-г үз). Гэр бүлийн мөнхийн харилцааны адислаалууд нь ариун сүмүүдэд лацдан холбуулсан хийгээд тэнд хийсэн гэрээнүүдээ сахидаг хүмүүст ирдэг. Амилуулалтад итгэдэггүй байсан Садукайчуудад хандан Есүс ярьдаг байв. Үүнийг мэдэх нь Есүс яагаад Өөрийнхөө арга замаар тэдэнд хариулж байсныг илүү сайн ойлгоход та нарт туслах болно. (“Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийг үз, *Ensign*, 1995 оны 11-р сар, 102.)

Ахлагч Жеймс Е.Талмейж, “Эмэгтэй хүн мөнхийн дэлхийд нэг л хүний эхнэр байж болно, мөн ингэх ч болно, газар дээр Ариун Санваарын эрх мэдлээр түүнд өгсөн эр хүн энэ амьдралд хийгээд үүрд мөнхөд хань нь байх болно. Товчоор өгүүлбэл, тэр эмэгтэй Бурханлиг эрх мэдлийн лацан дор мөнхийн гэрээнд орсон хүний гэргий нь байх болно; тийнхүү зөвхөн энэ амьдрал дахь гэрээ нь амилуулалтад хүчин төгөлдөр болж эс чадна” гэж сургажээ (*The House of the Lord* [1968], 90).

Судруудыг Судлах нь

Лук 20-ийг судлахдаа үйл ажиллагаанууд А, Б-г хий.

А Сонины Сурвалжлагч Бол

Та нар өөрсдийгөө Лук 20 дахь үйл явдлуудын үед Есүсийг дагах үүрэг хүлээсэн сонины сурвалжлагч гэж бод. Та түүний дагалдагчдын нэг биш, Түүний дайсан ч биш. Өөрсдийнхөө гэрчилсэн үйл явдлуудын тухай маргаашийнх нь сонинд зориулж нэг өгүүлэл бич. Уншигчдынхаа анхаарлыг татна гэж бодсон өөрсдийн бодсон гарчиг олж тавь.

Б Сударт Судалгаа Хий

Лук 20:9–18 болон тэдгээр шүлгүүдийн “Судруудыг Ойлгох нь” хэсгийг унш.

1. Сургаалт зүйрлэл дэх гурван зарцын адилаар тэдэнд хандсан гурван бошиглогчийн нэрийг Хуучин Гэрээнээс олж бич.
2. Энэ сургаалт зүйрлэл дэх өв залгамжлагчид хандсаны адилаар Есүст хандсаныг харуулсан Шинэ Гэрээний нэг шүлэг ол.

Лук 21

“Тэр Цаг Ойртож Байна”

Өөрийн тохинууллын төгсгөл хэрд Аврагч Өөрийнх нь Хоёр дахь Ирэлтийн өмнө юу тохиохыг илчилжээ. Эдгээр үйл явдлуудыг бид цагийн тэмдгүүд гэж олонтаа нэрлэдэг. Лук 21-ийг уншихдаа, бошиглогдсон тэмдгүүдээс зарим нь тохиохоор ирж байгаа энэ үед та нар амьдарч байгаагаараа хэрхэн адислагдсан тухай бод. Түүнчлэн эдгээр тэмдгүүдийг мэдэж, ойлгоход тань тусалж чадах амьд бошиглогчоор удирдуулах ямар давуу талтай байгаагаа тунгаан бод.

Лук 21-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 21:1–4—Марк 12:41–44

Лук 21:5–38—Матай 24:1–42; Марк 13; Иосеф Смит—Матай

Судруудыг Ойлгох нь

Лук 21

Зэс зоос (ш.2)—Маш бага үнэтэй жижиг зооснууд
Илүүдэл (ш.4)—Эд баялаг
Ядуу (ш.4)—Ядуу зүдүү байдал

Гай гамшиг (ш.11)—Өвчин тахал

Та нарт үг өгнө (ш.15)—Юу хэлэхээ мэдэхэд тань сүнслэг урмыг өгнө

Бүслэгдэх (ш.20)—Бүслэгдэх

Хөхүүл хүүхэдтэй эхчүүд (ш.23)—Хүүхдээ асардаг эхчүүд

Айдас (ш.25)—Эргэлзээ
Ойрхон (ш.30–31)—Хол биш
Дарамтлагдах (ш.34)—Хэтэртлээ уух



Лук 21:5–38—Иосиф Смитийн Орчуулгын Чухал Туслахууд

Матай 24-ийн (х.39) “Судруудыг Ойлгох нь” хэсгээс туслах олон зүйлийг олж болно. Иосеф Смит, Матай 24-т сүнслэг урмаар хийгдсэн олон өөрчлөлт оруулсан бөгөөд (Иосеф Смит—Матайг үз) та нар тэндээс туслах олон зүйлийг олж болно.

Лук 21:24—“Харийнханы Цаг”

Тухайн үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит, “Харийнханы цаг бидний Гэтэлгэгч егүүтгэгдсэний дараа удалгүй эхэлсэн

юм. Иудейчүүд удалгүй сайн мэдээг эсэргүүцэж, улмаар энэ нь Харийнханд аваачигдсан байлаа. Харийнханы цаг тэр үеэс одоог хүртэл үргэлжилсээр байна” гэж тайлбарлажээ (Church History and Modern Revelation, 1:179).

Судруудыг Судлах нь

Лук 21-ийг судлахдаа үйл ажиллагаанууд А, Б-г хий.

А “Цагийн Тэмдгүүд”

Лук 21:5–36-д Иерусалим дахь ариун сүмийн устгал, түүнчлэн тэрхүү устгалын өмнө тохиох үйл явдлуудын тухай шавь нарынхаа асуултуудад Есүс хариулсан байдаг. Энэ хэсэг нь зөвхөн ариун сүм устгагдахын өмнө юу тохиохыг төдийгүй, бас Их Эзэн алдар суунд эргэж ирэхийн өмнө юу тохиохыг өгүүлдэг.

Энэ шастирыг уншихдаа, Лук 21:8, 11–12, 26–27-д өгөгдсөн тэмдгүүдийг дүрсэл.



Б Бэлтгэлийг Шалгах Хуудас Хий

Хоёр дахь Ирэлт ёс бусчуудын хувьд “аугаа хийгээд аймшигтай” (Малахи 4:5) байх хэдий ч, “хэрэв та нар бэлтгэгдсэн байх аваас та нар эмээх хэрэггүй” (С ба Г 38:30). Лук 21:32–38-ыг уншаад, Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд өөрийнхөө бэлтгэх наад тал нь долоон арга замыг жагсаа.

Лук 22

Ариун Ёслолын Бэлэгдэл

Тэнгэрлэг Эцэгийн хүслийн дагуу, түүнчлэн Цагаатгалыг бэлтгэхэд Есүс Христ Иерусалимд дээд өрөөнд ариун ёслолыг үндэслэн бий болгосон юм. Энэ нь

биднийг хайрлах Аврагчийн хайрын улмаас гүйцэлдсэн хязгааргүй хийгээд мөнхийн золиослолыг бэлэгддэг. Дээд өрөө болон Гетсеманид болсон явдлын тухай Лукийн гэрчлэлийг уншихдаа Цагаатгал та нарын амьдралд хичнээн чухал болохыг анхаар. Есүсийн золиослолын учир та нар хэрхэн адислагдсан бэ? Ариун ёслолоос хүртэх нь Есүс Христийн цагаатгалд итгэх итгэлийг төлөвшүүлэх болон Тэр бол та нарын Аврагч бөгөөд Гэтэлгэгч болох тухай гэрчлэлийг тань нэмэгдүүлэхэд хэрхэн тусалдаг вэ?

Лук 22-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 22:1–65—Матай 26; Марк 14

Лук 22:66–71—Матай 27:1; Марк 15:1

Судруудыг Ойлгох нь

Лук 22

Маргаан (ш.24)—Санал зөрөлдөөн

Ноёрхдог (ш.25)—Захирдаг

Буянтнууд (ш.25)—Ариун журамтнууд, шударга сайн үйлстнүүд

Гурвантаа (ш.34)—Гурван удаа

Хүүдий, богц (ш.35–36)—Түрийвч буюу юм хийх сав

Боль, үүнийгээ зогсоо (ш.51)—Боль, дахиад бүү ингэ

Доромжлон гутаах элдвийн юм (ш.65)—Доромжилсон зүйлүүд

Лук 22:31–34, 54–62—Петр Есүсийг Сгүйсгэв



Тухайн үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Спенсер В.Кимбалл, *Петр, Миний Ах* гэсэн яриандаа, Есүсийг баривчилдаг шөнө Петрийн хийсэн үйлдлийн төлөө түүний хатуу шүүхэд бид болгоомжтой хандах ёстой гэж хэлжээ. Петр Есүсийг дагахын тулд бүх юмаа орхисныг тэрээр бидэнд сануулсан юм (Матай 19:27–28-ыг үз). Түүнээс гадна, янз бүрийн үйл явдлуудыг тохиолдуулан, өөрсдийн мэддэг зүйлээ, “хүний Хүү үхэгсдээс дахин босч ирэх хүртэл” ярихгүй байхыг Есүс

Арванхоёрт зарлигласан байлаа (Матай 17:9; түүнчлэн Матай 16:20-ийг үз).

Тэгээд Ахлагч Кимбалл хэлсэн нь: “Петрийн оюун санааны хариу үйлдэл юу байсныг, тэрчлэн аймшигт тэр шөнө юу түүнийг тэгж хэлэхэд албадсаныг мэдэхийг би зорьсон нь үгүй. Гэвч түүний нотлогдсон эрэлхэг зориг, бүхнээ зориулсан агуу чанар хийгээд Эзэнийг хайрлах хязгааргүй хайрын нь улмаас, бид түүний зөөлхнөөр ч гэсэн шүүж чадахгүй гэж үү, тийнхүү наанадаж л Аврагч үүнийг бүрэн дүүрнээр хийсний нэгэн адил, түүнийг уучлах ёстой биш үү. Христ түүнийг өөрийнхөө сүмийн хамгийн өндөр албан тушаалд өргөмжилсөн бараг тэр даруйд, хаант улсын бүрэн түлхүүрүүдээр түүнд индаумент хүртээсэн билээ” (Brigham Young University Speeches of the Year, 1971 оны 7-р сарын 13, 5).

Лук 22:39–44—Гетсеманид Есүсийн Сүв Бүрээс Цус Шүүрээв

“Цагаатгалын хүнд бэрх сорилт Иерусалим хотын орчимд төвлөрсөн билээ. Түүхэнд бүгд тэмдэглэгдсэн хайрын тэрхүү хамгийн агуу, хосгүй үйл явдал тэнд болсон юм. Есүс болон Түүний найз нар дээд өрөөнөөс гарч хотын зүүнтэйх гүнзгий жалгыг гаталж, Чидуны Уулын намхан бэл дэх чидуны моддын цэцэрлэгт хүрч иржээ. Тэр цэцэрлэг Гетсемани—“тос шахах” гэсэн еврей нэртэй байсан нь — тос болон хүнс гаргаж авахын тулд чидуныг няцалж, шахдаг байжээ. Гетсеманид Их Эзэн, “бүх хүмүүн наманчилж, мөн түүнд ирж болохын тулд . . . бүх хүмүүний зовлонг биеэр амссан” юм. Түүний сүв бүрээс цус шүүрэх болгосон нүсэр ачааг үүрэн, бүх хүн төрөлхтний нүглүүдийн хүндийг Тэрээр Өөр дээрээ авсан юм” гэж Ахлагч Рассел М.Нелсон сургажээ.

Судруудыг Судлах нь

Лук 22-ыг судлахдаа үйл ажиллагаа Б, түүнчлэн бусад гурван үйл ажиллагаанаас (А, В, Г) нэгийг нь хий.

А Сүнийг Хүүхдэд Тайлбарла




Лук 22:7–20-ийг уншиж, эдгээр шүлгүүд яагаад анхны ариун ёслолын цуглааныг дүрсэлсэн байж болох шалтгаануудыг эрж хай. Шүлэг 19–20-д Есүсийн хэлсэн зүйлийг хүүхдийн хэсгийн хичээл дээр тайлбарлаж өгөхийг өөрсдөөс тань хүсчээ гэж бод. Хүүхдүүдэд ярих зүйлээ бич.

Б Энэ нь Таны Хувьд Юу Гэсэн Утгатай Вэ?

Лук 22:39–53-ыг уншсаны дараа Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смитийн дараах гэрчлэлийг анхаар: “Энд миний гэм буруугийн, таны гэм буруугийн, бас Есүс Христийн сайн мэдээг хүлээн авдаг бодгаль бүрийн гэм буруугийн ачааг үүрсэн Бурханы Хүү бидэнд бий. . . . Тэрбээр ачааг—бидний ачааг үүрсэн юм. Би үүн дээр ямар нэг зүйл нэмсэн; та нар ч бас тэгсэн. Бусад нь ч бас бүгдээрээ тэгсэн. Би үүнээс зугтааж болох байсан, та нар ч зугтааж болох байсан тэрхүү төлөөс—бид түүний сайн мэдээг хүлээн авч үүнд үнэнч итгэлтэй байх нөхцлийн шийтгэлийг Тэрбээр өөр дээрээ үүрсэн билээ” (Fall—Atonement—Resurrection—Sacrament [Солт Лейк дахь Шашны Институт дээр хэлсэн үг, 1961 оны 1-р сарын 14], 8).

Эдгээр үйл явдлуудыг хийгээд Есүс ганцаар шаналан зовж байсныг санаандаа дүрсэл. Есүсийн шаналал зовлон та нарын хувьд ямар утга учиртайг тайлбарла.



В Хоёр Хүнийг Харьцуул

Лук 22:1–6, 46–48 дахь Иудасын тухай, Лук 22:31–34, 54–62 дахь Петрийн тухай унш. Дараах асуултуудад хариул:

1. Өөрийн хийсэн зүйлийг Иудас яагаад хийсэн гэж та нар боддог вэ?
2. Өөрийн хийсэн зүйлийг Петр яагаад хийсэн гэж та нар боддог вэ?
3. Иудас өөрийгөө дүүжилсэн; Петр дараа нь Сүмийг удирдахаар дуудагдсан. Энэ хоёр хүний хоорондох ялгааг юу харуулж байна вэ?

Г Баримтуудыг Илтгэ

Өнөө үед сурвалжлагчид шүүх хурлуудын тэмдэглэлийн тухай тодорхой бичиж, баримтуудыг илтгэдэг. Хэрэв та Лук 2:66–71-д дүрслэгдсэн шүүх хуралд сурвалжлагчаар томилогдсон бол, юу бичих вэ? Сурвалжлага бичиж, сонинд ашиглаж болох толгой гарчиг тавь.

Лук 23

Цовдлолт

Есүс Христийн Цовдлолтыг авч үзэхдээ
“Би Гайхишрна” дууллын үгсийг анхаар:

Би Есүсийн хайранд өлгийдөгдөн гайхишрч байна
Бэлэглэсэн авралд нь тээнэгэлзэн гайхишрна
Гэм нүгэлт миний төлөө тэр цусаа урсган зовж
Тэр цовдлогдсоныг мэдэн би мэгдэн айж чичирнэ.

Гэм нүгэлт даруу бус нэг намайг тэр аврахаар
Тэнгэрлэг гэрээсээ ирсэнд би гайхишрна
Гэм нүгэлт намайг Тэр хайрлан ивээж энэрсэн
Тийн намайг цагаатган, аварсанд гайхишрна би

Тэр төлөөсийг төлөхөөр цусаа урсган зовсон
Тэрхүү энэрлийг үтэр мартана гэж үү би?
Хаан сэнтийний өмнө мэхийн ёсолж хүндэтгэн
Тэр энэрэнгүй суудлыг би магтан хүндэтгэнэ,
Өө, намайг хайрлаж тэр цусаа урсган зовоод
Амиа өргөөд тэр халисан! Өө, энэ их гайхалтай,
үнэхээр гайхалтай!
(Сүмийн Дуулал болон Хүүхдийн Дуу, х.22).

Лук 23-г Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 23—Матай 27:2–61; Марк 15; Иохан 18:28–19:42

Судруудыг Ойлгох нь



Лук 23

Үндэстнийг төөрөгдүүлэн
(ш.2)— Хүмүүсийг Цезариас
холдуулж удирдан

Хатуу ширүүн (ш.10)—
Хүчлэн, албаар

Доромжлон гутааж
(ш.11)—Тэд түүнийг үл
тоомсорлон, түүнийг юу ч
биш мэтээр үзэж, тоохгүй
байв

Тэд хоорондоо дайсагналц-
даг (ш.25)—Дайснууд

Бослого (ш.32)—Үймээн
самуун

Адилхан ялд унасан
(ш.40)—Нэгэн адил шийт-
гэгдэх болсон

Буруу юм (ш.41)—Буруу
зүйл

Даатгая (ш.46)—Даатгах,
хариуцуулж өгөх

Лук 23:7—Херод

Херод бол хувь хүний нэр биш, харин Их Херодын үр
удмынх байсан бүх хүмүүст хамаарах гэр бүлийн нэр байв.
Энэ захирагч бол Херод Антипа байв.



Лук 23:18—Бараб

Бараб бол бослого хийгээд аллагын учир Иерусалимд
хорионд байсан гэмт хэрэгтэн байв. Түүний нэр харгис
хэрцгийн егөөдлийг төлөөлдөг. Барабыг үгчлэн орчуулбал
“аавын хүү” гэсэн утгатай. Дээгүүр Өнгөрсний Баяр тэм-
дэглэхийн нэг хэсэг болгон нэг хоригдлыг суллахыг Пилат
санал болгоход, иудейн удирдагчид Эцэгийн Төрүүлсэн
Ганц Хүү Есүсийн оронд Барабыг суллахыг хүссэн билээ.

Лук 23:31—Хатсан болон Ногоон Мод

“Хатсан мод болон ногоон модонд энэхүү илэрхийллийн
талаар Лук хэлэхдээ: ‘Тэрээр Израилын тараагдалт, түүнч-
лэн буруу номтнуудын, эсвээс өөрөөр хэлбэл Харийнханы
үгүйрлийг, мөн тэрчлэн Иерусалимын устгалын үед тохиох
Израилын тараагдалт, мөн түүний Хоёр дахь Ирэлтийн
өмнө хожмын өдрүүдэд бүх хүмүүн дээр ирэх устгал хий-
гээд өшөө авалтыг бэлэгдэн, үүнийг хэлсэн юм’ ” гэж
Ахлагч Брус Р.МакКонки бичжээ (*The Mortal Messiah*, 4:208).



Лук 23:39–43—“Өнөөдөр Би Чамтай Хамт Диваажинд Байх Болно”

“Өнөөдөр би чамтай хамт диваажинд байх болно” гэсэн энэ өгүүлбэрийг Бошиглогч Иосеф Смит, “Энэ өдөр би та нартай хамт сүнсний дэлхийд байх болно; тэгэхэд би та нарт энэ тухай зааж, бас та нарын асуултуудад хариулах болно” гэж тайлбарлажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 309). Амьсгал хураах эцсийнхээ мөчид наманчлахыг Есүс дэмжээгүй юм.

Судруудыг Судлах нь

Лук 23-ыг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Өөр Бусдын Сээл Бодлоор

Лук 23-ыг анхааралтай уншиж, дараах таван хүн тус бүрийн оронд өөрсдийгөө тавьж, төсөөлөн бод: Пилат, Бараб, загалмай дээрх даруу хорлон сүйтгэгч (хулгайч; Матай 27:38-ыг үз), Курений Симон, Ариматын Иосеф. Судруудад байдаг түлхүүр ойлголтуудыг ашиглан, тэдгээр таван хүн тус бүр Аврагчийн тухай бодлын талаар юу гэж байгаагаа бич.

Лук 24

“Аврагч Минь Амьдардгийг Би Мэднэ”

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүн асан, Ахлагч Роберт Л.Бакман сорилт даалгаврыг өгчээ: “Амилуулалтын өдөр шавь нар хийгээд бусад итгэгчдийн дунд өөрсдийгөө байсан гэж төсөөлөн бод. Назарын номхон дөлгөөн түүнийг аймшигтайгаар цовдолсныг та гэрчилснээс хойш хэдхэн цаг өнгөрөөд байв. Та гүн эмгэнэлийн хормуудыг хуваалцжээ. Хаашаа эргэхээ, хэрхэн үйлдэхээ мэдэхгүй төөрөлдсөн оюун ухаан тань цөхрөлийн манангаар харанхуйлагджээ. Тэгтэл Елмау уруу зам дээр Их Эзэнтэй өөрсдийн ярьсан үгтэйгээр хоёр шавь тантай нэгдэв. ‘Их Эзэн үнэхээр босч ирсэн. Тэгээд Симон дээр хүрч ирсэн’ (Лук 24:34) хэмээн хэлсэн тэдэнд та итгэж зүрхлэх үү?” (in Conference Report, 1991оны 10-р сар, 9; Ensign, 1991оны 11-р сар, 9).

Лук 24-ийг уншихдаа, Их Эзэний Амилуулалтын талаарх өөрсдийн гэрчлэлийг, түүнчлэн гэрчлэлээ хүчтэй болгохын тулд та юу хийж болохыг бод.

Лук 24-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Лук 24:1–11—Матай 28:1–15; Марк 16:1–11; Иохан 20:1–18
Лук 24:36–48—Марк 16:14; Иохан 20:19–23
Лук 24:49–53—Марк 16:19–20

Судруудыг Ойлгох нь

Лук 24

Жаран стадиа (ш.13)—
Жаран стадиа, 8-11 орчим
километр буюу 5-7 миль
хол

Тайлбарлав (ш.27)—Хэлэв,
тайлбарлав, ойлгуулав
Ятган (ш.29)—итгүүлэн,
ятгаж итгүүлэн

Лук 24:1—“Долоо Хоногийн Эхний Өдөр”

Иудейн хуанлид долоо хоногийн эхний өдөр нь Ням гараг байв. Есүс энэ өдөр амилуулагдсан юм. Түүнийг Дээшлэн одсоны дараа Сүмийн гишүүд, Иудейчүүд болон Харийнхан аль аль нь энэ өдрийг ариунаар хадгалж, үүнийг Их Эзэний өдөр хэмээн нэрлэх болжээ (Үйлс 20:7; 1 Коринт 16:2-ыг үз).

Судруудыг Судлах нь

Лук 24-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Судруудыг Олж, Тайлбарла

Түүнд юу тохиолдсон, эсвэл Түүний үүрэг зорилго юу байсныг тодорхой ойлгоогүй хоёр хүн дээр Есүс хүрч ирсэн тухай бид Лук 24:13–35-д уншдаг. Түүний амьдрал хийгээд үүрэг зорилгыг хэрхэн бошиглосон тухай Тэрбээр ухуулсан, эсвэл нарийн тодорхой тайлбарласан тухай шүлэг 27 бидэнд өгүүлдэг. Түүний амьдрал хийгээд үүрэг зорилгын тухай бошиглосон гурван судрыг Хуучин Гэрээнээс олж, эдгээр судар тус бүр ямар утгатайг тайлбарла.




Б Их Эзэн Бидэнтэй Хэрхэн Харилцдаг Вэ?

Их Эзэн Өөрийн хүүхдүүдтэй олон арга замаар харилцдаг. Эдгээр арга замуудын зарим нь Лук 24:13–45-д байдаг. Дараах судрын ишлэлүүдийг уншиж, Их Эзэнтэй харилцах наад зах нь зургаан арга замыг жагсаан бич.

1. Лук 24:13–16, 33–52
2. Лук 24:23
3. Лук 24:32; түүнчлэн Сургаал ба Гэрээ 9:8-ыг үз.
4. Лук 24:27, 32, 44–45
5. Лук 24:36; түүнчлэн Сургаал ба Гэрээ 6:23-ыг үз.

В Төгс Эзэмших Судар—Лук 24:36–39

Лук 24:36–39-ийг уншаад, амилуулагдсан биеийн талаар хамгийн чухал ямар сургаал энд заагдсан гэж бодож байгаагаа бич. Мөн Лук 24:40–44; Алма 11:42–46; тэрчлэн 40:19–24-ийг унш. Амилуулалт хийгээд амилуулагдсан биеийн тухай өөрсдийн мэдэж авдаг, наад тал нь таван өөр чухал сургаалыг жагсаан бич.



Гэгээнтэн Иоханы Сайн Мэдээ

Иохан Гэж Хэн Байсан Бэ?

Иохан бол Есүсийн Арванхоёр Төлөөлөгчийн нэг байв. Түүний дүү Иаков бас Арванхоёр Төлөөлөгчийн нэг байсан. Есүс тэднийг Өөрийн шавь нараар, хожим нь Төлөөлөгчдөөр дуудах хүртэл Иохан, Иаков хоёр загасчид байлаа. Иохан бол Хувиралтын Уулан дээр Есүстэй хамт байсан гурван Төлөөлөгчийн нэг байсан бөгөөд Гетсеманий Цэцэрлэгт Есүс Өөртэйгөө хамт очихыг хүссэн гурван төлөөлөгчийн нэг байсан юм. Тэрээр өөрийгөө “Есүсийн хайрладаг байсан шавь нь” гэж үздэг байсан учраас түүнийг Хайрт Иохан гэж олонтаа нэрлэдэг (Иохан 13:23; 19:26; 20:2; 21:7, 20).

Иоханыг бас Илчлэгч Иохан гэдэг, учир нь тэрээр Илчлэлтийн номыг бичсэн билээ. Тэр бас Шинэ Гэрээнд байдаг гурван богино захидлыг бичжээ. Есүсийн үхэл хийгээд амилуулалтын дараа Петрийг Сүмийн тэргүүн болоход, Иохан түүний зөвлөхүүдийн нэг байв (John W. Taylor, in *Collected Discourses*, Brian H. Stuy, 5 боть зохиолын эмхтгэл. [1987–92], 4:256-г үз) Иохан нас эцэслээгүй, харин зөөгдөж, Их Эзэний Хоёр дахь Ирэлтийг хүртэл Их Эзэний үйлчлэгчдийн нэг болж газар дээр үлдэх нь зөвшөөрөгджээ (С ба Г 7-г үз). 1830 онд Иохан, Петр, Иаков нарын хамт Иосеф Смит, Оливер Каудери хоёр дээр ирж, Мелкизедек Санваарыг сэргээсэн юм.



Загасчин Иохан



Хувиралтын Уул



Иоханы бичээс



Иосеф болон Оливерийг Иохан томилж байгаа нь

Энэ Сайн Мэдээг Иохан Яагаад Бичсэн бэ?

Иохан Есүстэй хамт байсан бөгөөд Түүнийг мэддэг бас хайрладаг байв. Дэлхий даяарх хүмүүс Түүний мэдэхээр, бас Түүнийг хайрлахаар ирэхийн тулд тэрээр Аврагчийн тухай бичсэн юм. Тэрээр Есүсийн хэлж, хийж байсан зүйлийн гэрч байлаа. Түүний ном Есүсийн түүх биш, харин

Түүний тухай гэрчлэл юм хэмээн Иосеф Смитийн орчуулганд бичигдсэн байдаг. “Есүс бол Христ, Бурханы Хүү гэдэгт хүмүүс итгэж болохын тулд тэрээр өөрийн сайн мэдээг бичсэн хэмээн тэр өгүүлжээ” (John 20:31). Иохан өөрийн номонд Бурханы хайрын тухай олонтаа өгүүлсэн байдаг учраас Иоханы сайн мэдээг заримдаа “хайрын сайн мэдээ” хэмээн нэрлэдэг. Түүнчлэн тэрээр Есүс бол амлагдсан Месая байсан гэдгийг онцгойлон тэмдэглэсэн билээ.

Иохан, Хосгүй Сайн Мэдээ

Матай, Марк, Лукийн Сайн Мэдээнүүд олон адилхан түүхийг өгүүлж, нэг адил үндсэн дараалал хийгээд загварыг баримталсан байдаг. Тэдгээр нь Есүс Галилд юу хийж байсныг ихэвчлэн өгүүлдэг бол Иоханы Сайн Мэдээ өөр түүхүүдийг оруулж, Иудей болон Иерусалимд юу хийж байсан тухай илүү ихийг өгүүлдэг. Есүсийн зарим сургаалууд хийгээд зөвхөн Иоханд тохиосон туршлагауудыг дор харуулав:

- Мөнх бус байдлын өмнөх Есүс (Иохан 1-ийг үз)
- Тэр үнэхээр хэн байсан талаараа Есүс хувь хүмүүст гэрчилж байсан үеүд (Иохан 3–4, 8-ыг үз).
- Есүс бол Амьдралын Талх, мөн Амьдралын Ус мөн (Иохан 6–7-г үз)
- Лазарыг үхэгсдээс босгосон нь (Иохан 11-ийг үз)
- Төлөөлөгчдийн хөлийг угаасан нь (Иохан 13-ыг үз)
- Ариун Сүнсний тухай сургаалууд (Иохан 14–15-ыг үз)
- Төлөөлөгчдийнхөө төлөөх Есүсийн залбирал (Иохан 17-г үз)
- “Миний хонинуудыг тэжээх” талаар Петрт өгсөн Есүсийн үүрэг (Иохан 21-ийг үз)

Иохан 1

Есүс Бол Мөнх Бус Байдлын Өмнөх Христ бөгөөд Бүтээгч Мөн

Матай, Марк, Лук нар Есүсийн төрөлт буюу баптисмын тухай өгүүлснээр өөрсдийн шастирыг эхэлсэн байдаг. Иохан өөрийн сайн мэдээг өөрөөр эхэлжээ. Нэгдүгээр бүлэгт Иохан, Есүс бүр дэлхийд ирэхээсээ өмнө Тэрээр хэн байсан тухай өгүүлсэн Иохан Баптистынхтай өөрийн гэрчлэлийн нэгтгэжээ.

Их Эзэн Иохан 1 дэх олон өөрчлөлтийг Бошиглогч Иосеф Смитэд илчилсэн билээ.

Иохан 1-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Иохан 1:32–34—Матай 3:13–17

Судруудыг Ойлгох нь



Тайлбар: Судруудыг ойлгох эдгээр тусламжуудын ихэнх нь ИСО, Иохан 1:1–34-г зориулагдсан болно

ИСО, Иохан 1

Адил (ш.2)—Есүс Христ, Бурханы Хүү

Ухамсарлах (ш.5)—Харах, ойлгох

Иохан (ш.6)—Энд Төлөөлөгч Иоханыг биш, Иохан Баггистыг ярьж байгаа

Надаас эрхэм (ш.15, 30)—Надаас агуу

Үхэшгүй байдал хийгээд мөнхийн амьдрал (ш.16)—Үхэшгүй байдал нь үүрд амьд байна гэсэн үг; Мөнхийн амьдрал нь Бурхантай хамт амьдарч, түүнтэй адил болохоор

Иохан 1

Багш (ш.38)—Удирдагч, багш

Буудаллаж байгаа (ш.39)—Буудалсан, үлдсэн

• өргөмжлөгдөнө гэсэн үг

Нигүүлсэл (ш.16)—Итгэлтэй хүмүүсийг өөрсдийн чадахаас илүү сайн байхад тусалдаг Бурханаас ирсэн хүч

Өвөр дэх (ш.18)—Дэргэдэх

Исаиа (ш.24)—Исаиа

Харатгун (ш.30)—Танигтун

• **Аравдугаар цаг** (ш.39)—Оройн 4:00 цаг

• **Заль мэх** (ш.47)—Арга заль

ИСО, Иохан 1:1, 14—Иохан Ягаад Есүсийг “Сг” Гэж Нэрлэсэн бэ?

“Есүс бол Эцэгийн хүсэл, зарлиг буюу үг түүгээр дамжин хэрэгжсэн тэр хүн байлаа” гэж Ахлагч Жеймс И.Талмейж сургажээ (*Jesus the Christ*, 33). Тэрбээр үзэл санааг үг төлөөлөх замаар Тэнгэрлэг Эцэгийг төлөөлдөг. Үг нь аливаа юмны буюу үзэл санааны элчид тооцогддог бол, Христ бол Эцэгийн, мөн Түүний Сайн Мэдээний элч байсан бөгөөд энэ нь бүх хүн төрөлхтний авралын төлөвлөгөө юм.

Иохан 1:18—“Бурханыг Хэн ч Хэзээ ч Хараагүй”

Иосеф Смитийн Орчуулгын тусламжгүйгээр Жеймс Хааны Хувилбарт энэ шүлэг нь Бурханыг харсан хүн байхгүй хэмээн өгүүлдэг. Иосеф Смитийн Орчуулга энэ шүлгийн утгыг сэргээж, Эцэг хэдийд хүрч ирсэн, эсвэл Есүс бол Христ бөгөөд Түүний Цорын Ганц Төрүүлсэн Хүү мөн болохыг Тэрээр гэрчилдэг тохиолдол байдгийг ойлгоход бидэнд тусалдаг билээ (Матай 3:17; 17:5; 3 Нифай 11:6–7; С ба Г 76:23; Иосеф Смит—Түүх 1:17-г үз). Бурхан Эцэгийг харах нь зарим хүмүүст зөвшөөрөгдсөн хэдий ч ингэж үзэгдэх нь нэн ховор юм. Жишээ нь Үйлс 7:55–56; С ба Г 76:23; Иосеф Смит—Түүх 1:17-г үз. Төлөөлөгч Иохан өөрөө амилуулагдсан Их Эзэнийг харсан билээ (Илчлэлт 1:12–18-ыг үз).

Иохан 1:41—“Мессиа”

Месая гэдэг еврей үг “Сонгогдсон Нэгэн”, эсвэл “Тослогдсон Нэгэн” гэсэн утгатай. Месая буюу “Сонгогдсон Нэгэний”

Грек хэлний орчуулга нь Христ юм. “Есүс Христ” гэдэг нь “Сонгогдсон Есүс” гэсэн утгатай. Шинэ Гэрээнд, Еврей үг Месая нь Мессиа гэж бичигдсэн байдаг. Есүс бол Месая мөн. Есүс бол Христ мөн. Есүс бол Сонгогдсон Нэгэн мөн.

Судруудыг Судлах нь

Иохан 1-ийг судлахдаа дараах үйл ажиллагаа А, Б-г хий.

А Хүн Бурханыг Харж Чадах уу?

Сүмийн гишүүн биш нэг найз тань, Бурхан Эцэг болон Есүсийг харсан гэсэн Иосеф Смитийн түүхэнд итгэдэггүй байж, учир нь “Бурханыг хэн ч хэзээ ч хараагүй” гэж Библид хэлсэн байдаг (Иохан 1:18) хэмээн хэллээ гэж бод. Дээрх “Судруудыг Ойлгох нь” хэсэг дэх мэдээлэл дээр тулгуурлан найздаа юу хэлэхээ бич.

Б “Ирж, Сэ”

1. Доорхтой адил хүснэгтийг хийж Иохан 1:35–51 дэх мэдээллээр бөглө.

Нэр	Тэр Есүсийн тухай яаж мэдсэн бэ?	Тэр юу хийсэн буюу хэлсэн бэ?	Есүс түүнд юу гэж хэлсэн бэ?
Андрей			
Симон Петр			
Филипп			
Натанел			

2. Өнөөдөр хүмүүсийг Христийг болон Түүний сайн мэдээг олоход эдгээр хүмүүс хэрхэн үлгэр жишээ болж болох вэ?

Иохан 2

Есүс Өөрийн Ажлыг Эхлэв

Тэрээр хүмүүсийн дунд заах, адислах болон олон гайхамлигуудыг үйлдэхээр явж Өөрийн тохинууллыг эхлэхдээ Есүс гучин настай байв. Назараас умард зүгт арван зургаан километр орчим дахь Кана хотод болсон хуриман дээр Есүсийн анхны гайхамшиг цэдэглэгдсэнийг та

нар Иохан 2-т унших болно. Есүс дараа нь Дээгүүр Өнгөрсний Баярт оролцохоор Иерусалим уруу явлаа. Ариун сүмийг цэвэршүүлсэн тухай энэ бүлэгт Иохан бичсэн нь, Есүс үүнийг анх удаа хийсэн байлаа. Тэрээр цовдлогдохынхоо өмнөх сүүлчийн долоо хоногт ариун сүмийг дахин цэвэршүүлсэн билээ (Матай 21; Марк 11; Лук 19-ийг үз).



Судруудыг Ойлгох нь

Иохан 2

Метретас (ш.6)—Нэг метратас нь 34 литрийн багтаамжтай байв, иймээс сав бүр нь 68–102 литрийн багтаамжтай байв.

Аваачиж өг (ш.8)—Аваачиж өг

Илэрхийлсэнд (ш.11)—Үзүүлсэнд, харуулсанд
Шилбүүр (ш.15)—Ташуур
Зайлуул (ш.16)—Эндээс холдуул

Иохан 2:4—“Миний Цаг Хараахан Болоогүй Байна”

Иохан 2:4-өөс бид Есүс ээжийнхээ хүсэлтийг биелүүлэхийг хүсээгүй юм байна гэж бодож болох хэдий ч, Тэрээр Өөрийн чадах л арга замаар түүнд туслахыг хүсч байсан бөгөөд Тэрээр мөн тусалсан юм гэдгийг ИСО, Иохан 2:4 харуулдаг.

Иохан 2:14–16—Хүмүүс Яагаад Ариун Сүмд Эд Юмсыг Зарж, Худалдан Авч Байсан бэ?

Матай 21:12–13-ын “Судруудыг Ойлгох нь”-ийг үз.

Судруудыг Судлах нь

Иохан 2-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Дарсны Оронд Ус

Иохан 2:1–11-д өгүүлсэн “дарс нь ‘ороонгын модны жимсээр’ (Матай 26:29) хийсэн ундаа буюу тунгалаг, чихэрлэг дарс (ердийнхөөр эсгээгүй) байсан бөгөөд тэр үед талхтай хамт хэрэглэдэг үндсэн хүнсний нэг байжээ” хэмээн Ахлагч Брус Р.МакКонки бичжээ (Doctrinal New Testament Commentary, 1:136).

1. Энэ гайхамшигт Есүсийн шавь нарт ямар нөлөө үзүүлсэн бэ? (шүлэг 11-ийг үз).
2. Энэ түүхэнд Түүний хийсэн зүйлээс тэд (мөн та нар) Есүсийн тухай юу мэдсэн бэ?



Б Ариун Сүмийг Цэвэршүүлсэн нь

1. Иохан 2:13–17-гийн дагуу, өдий олон хүнийг сэтгэлээр унагах юуг Есүс хийсэн бэ? Юуны учир?
2. Энэ шастир Бурханы ариун зүйлүүдтэй хэрхэн харьцах тухайд Есүс биднээс хүсдэг зүйлийн талаар бидэнд юуг зааж байна вэ?
3. Бурханы өргөөнд илүү хүндэтгэл үзүүлэхийн тулд өөрсдийн хийж чадах гурван зүйлийг нэрлэ.

В Гурван Өдрийн Дотор Босгосон Ариун Сүм?

Иохан 2:19-д Есүс ямар “ариун сүмийг” хэлсэн бэ? (Нэмэлт тусламж болгож Матай 27:62–64-ийг үз).

Иохан 3

“Та Нар Дахин Төрөх Ёстой”

Шашны үндсэн гол асуудлуудаас заримыг нь дурдвал: Бурхан байдаг уу? Тэрээр намайг мэдэж, миний төлөө анхаарал халамж тавьдаг уу? Тэр надаар юу хийлгэх байсан бол? Тэнгэр гэж байдаг уу? Хэрэв байдаг бол, би хэрхэн тийшээ очиход тэнцэхээр болох вэ? Никодем гэгч нэгэн Фарисай хүн яг ийм хэдэн асуулт тавьсан байдаг. Бидний бодоход, бусад фарисайчууд түүнийг харахгүйн тулд тэрээр Есүс уруу шөнөөр очжээ. Иохан 3-ыг уншихдаа Есүс тэдэнд юу заасныг эрж ол.

Судруудыг Ойлгох нь



Иохан 3

Дуртай газраараа (ш.8)— Хүсэвч, сонговч

Багш (ш.10)—Багш, эзэн

Ил гарчих вий (ш.20)—Бүү ил гараасай гэж эмээх

Ил гарчих (ш.20)— Шийтгэгдэх, шүүмжлүүлэх

Хамт тэнд байж (ш.22)— Тэнд үлдэж

Ариусгал (ш.25)—Багтисм болоод бусад ёслолын цэвэршүүлэлт



Квимраны ариусгалын сан

Хэмжээлшгүйгээр (ш.34)— Багахан хэмжээгээр биш

Иохан 3:8—“Салхи Дуртай Газраараа Слээдэг”

Сүнсийг мэдрэхийн тулд ямар мэдрэмж төрдгийг тайлбарлах нь хэцүү юм. Дагалдах зураг үүнийг харуулж байгаачлан, Есүс үүнийг хүнд тайлбарлахыг хичээж, салхитай харьцуулжээ.

**Энэ нь нүдэнд харагдах нь үгүй,
гэвч бид ажиллагааг нь
ухамсартаа хүлээж авдаг
Бид үүнийг мэдэрдэг;
бид үүнийг ойлгодог.
Бид гаргадаг үр нөлөөгөөр нь
үүний оршдогийг мэддэг
Энэ нь намуухан, эсвэл нэн хүчтэй
байж болдог.**

Ариун Сүнс



Салхи



Мосегийн саванд өлгөсөн могой бол Аврагчийн бэлэгдэл байлаа. Ердөө могойг харах нь л Израилчуудыг бие бялдрын үхлээс аварсан бол, Христ өөд харах нь биднийг бие бялдрын хийгээд сүнсний үхэл аль алианаас нь аварч чадна.

Судруудыг Судлах нь

Иохан 3-ыг судлахдаа үйл ажиллагаа А болон өөр нэг үйл ажиллагааг (Б-Г) хий.

А Төгс Эзэмших Судар—Иохан 3:5


1. Иохан 3:2-ын дагуу, Есүсийг “Бурханаас” байсан гэдгийг Никодем яаж мэдсэн бэ?
2. Есүсийн юу гэж хэлсэн нь илүү итгэлтэй “харахын” (ш.3-ыг үз) арга зам байсан бэ?
3. Тэрээр Есүстэй ярьж эхлэхдээ сүнслэг байдлаар бодоогүй байсан гэдгийг харуулах юуг Никодем хэлсэн бэ?
4. Бид хүлээн авах ёстой хэмээн Есүсийн хэлсэн хоёр төрлийн баптисмыг тайлбарласан, наад зах нь хоёр судрыг ол (Эдгээрийг олохын тулд өөрсдийнхөө судруудыг ашигла).
5. Никодем Есүс уруу яагаад “шөнөөр” явсан гэж та нар бодож байна? (ш.2-ыг үз)
6. Иохан 19:38–40-ийг унш. Түүнд Есүсийн заасан зүйлд Никодем итгэсэн гэж та нар бодож байна уу? Хариултаа тайлбарла.

Б Бурхан Дэлхийд Снэхээр Хайртай Байсан

1. Иохан 3:16–17-гийн дагуу, Бурхан бидэнд хичнээн хайртайг бид мэдэж болох нэг арга зам юу вэ?
2. Тэнгэрлэг Эцэг болон Есүс бүх хүмүүсийн төлөө хийхийг хүсдэг ямар зүйлийн тухай эдгээр шүлгүүд бидэнд заадаг вэ?
3. Хэрэв Есүс дэлхийд ирээгүй бол хүмүүс хэрхэн мөхөх байсан гэж та боддог вэ?

В Гэрэл Харанхуйг Эсэргүүцдэг

1. Иохан 3:19–21-д Есүсийн заасан зарчмуудыг тайлбарласан, наад зах нь хоёр үнэний нотолгоог өөрсдийн үгээр бич.
2. Өөрсдийнхөө амьдралаас буюу харсан зүйлүүдээсээ эдгээр нотолгоо бүр нь хэрхэн үнэн байсан талаар нэг жишээ гарга (Жишээндээ та хүмүүсийн нэрсийг бүү хэрэглэ).




Г Агуу Бошиглогчоос Авсан Сургамжууд

Иохан 3:25–33-аас, Иохан Баптистын хэлж байсан болон хийсэн зүйлүүдээс удирдагчид, багш нар болон номлогч нарын авч болох сургамжуудыг жагсаа. Санаа тус бүрийг олсон шүлгүүдээ оруул.

Иохан 4 Худаг Дээрх Эмэгтэй



Есүс болон Түүний шавь нар Дээгүүр Өнгөрсний Баяраар Иерусалимд байлаа. Галил уруу буцах цаг болоход тэд Самари гэгддэг газрын нэг хэсгээр дамжин өнгөрчээ (дагалдах газрын зургийг хар). Самаричууд болон Иудейчүүд бие биенийхээ зүг эвсэг найртай байсангүй, Иудейчүүд Самаричуудыг “цэвэр бус” гэж тооцдог байв. Зарим үед Иудей хүн Самариаар дайрч өнгөрөхөөс зайлсхийн тойруу замаар нэг юм уу хоёр өдөр явдаг байв. Та нар Иохан 4-ийг уншихдаа, эдгээр уламжлалын талаар Есүс Өөрийн хэлсэн, хийсэн зүйл аль алинаар нь юу заасныг анхаар.



Судруудыг Ойлгох нь



Иохан 4

Зургадугаар цаг (ш.6)—
Үд дунд орчим

Ус татах (ш.7)—Худгаас
ус татаж гаргах

Харлаа (ш.19)—Ойлголоо,
мэдлээ

Мессиа (ш.25)—Месая
(Иохан 1:41-ийн “Судруудыг
Ойлгох нь”-ыг үз).

Тэр үед (ш.27)—Энэ үед

Хоол (ш.32)—Хүнс (судруу-
дад *мах* гэдэг үг бараг бүх
тохиолдолд “хоол” гэсэн

утгатай байдаг; бидний мах
гэж нэрлэдэг зүйл ихэвчлэн
махан бодь гэж нэрлэгддэг)

Юм (ш.33)—Ямар нэг зүйл

Тариа хураагч (ш.36)—
Хурааж авч байна

Гуйв (ш.40, 47)—Хүсэв

Өмнө (ш.49)—Урьд

Сайжрах (ш.52)—Засрах,
дээрдэх

Долдугаар цаг (ш.52)—
Үдийн 1:00 цагийн орчим

Иохан 4:12—“Бидний Эцэг Иаков”

Самаричууд болон Иудейчүүд аль аль нь, Израил болж нэр нь өөрчлөгдсөн Иаковын үр удам байлаа. Эцэг гэдэг нь “өвөг дээдэс” гэсэн утгатай.

Иохан 4:22—“Аврал Бол Иудейчүүдийнх”

Фарисайчууд болон Садукайчуудын шашин хүмүүст авралыг авчрах болно гэж Есүс хэлээгүй юм. Нэгэн цагт энэ шашин авралын ёслолууд, сургаалууд хийгээд зан үйлүүдийг агуулж байсан хэдий ч, хүмүүс тэдгээрийг өөрчилсөн юм. Есүс бол эхийнхээ талаас Иудей хүн байсан бөгөөд авралыг авчирсан хүн нь Тэр байлаа. Есүс гэдэг нь “аврал” гэсэн утгатай юм.

Иохан 4:24—“Бурхан Бол Сүнс”

Бурханы сүнс нь амилуулагдсан хийгээд алдар сууг олсон мах, ясан биед хувцаслагдсан байдаг гэдгийг бид судрын хэсгүүдээс, ялангуяа өнөө үеийн илчлэлтээс бид мэддэг билээ (Эхлэл 1:26–27; Лук 24:39; С ба Г 130:22-ыг үз).

Судруудыг Судлах нь



Иохан 4-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Алгуур Хөрвүүлэг

Та нар Иохан 4:5–42-ыг уншсанаар, Есүс бол Месая буюу Христ мөн гэдэг гэрчлэлтэй болохоор нэг эмэгтэй хэрхэн ирснийг бид мэдэж чадна.

1. Шүлэг 9, 11, 15, 19 болон 29-т Самари эмэгтэй Есүсийг хэн гэж нэрлэснийг жагсаа.
2. Тэр эмэгтэй Есүсийг улам олон дуудах тутам, Түүнтэй ярилцаж, Түүнийг мэдэхийн тулд улам олон удаа ирж байсныг та нар юу гэж боддог вэ?
3. Тэрээр үнэхээр хэн байсныг мэдсэний дараа эмэгтэй юу хийсэн бэ? Үр дүн нь юу байв (шүлэг 28–30, 39–42-ыг тусгайлан үз).

4. Өөрсдийн тань гэрчлэл өсч хөгжсөн арга замуудын талаар бич. Гэрчлэл тань яагаад өссөн гэж боддог зүйлийг оруул.

Б Номлогч Бол

Иохан 4:24-т “Бурхан бол Сүнс” гэж хэлсэн байтал, Бурхан бодит биетэй гэж заадгийг тайлбарлаж өгөхийг хүссэн сонирхогчид та нар юу гэж хэлэх вэ? Хариултандаа наад зах нь хоёр судар ашигла.

В Өдрийн Тэмдэглэл

Иохан 4-т өгүүлсэн үйл явдлуудын үеэр Есүстэй хамт байсан шавь нарынх нь нэг өөрсдийгөө байсан гэж бод. Тэр өдөр Есүстэй хамт байснаар юу мэдсэнээ өдрийн тэмдэглэлийнхээ нэг хэсэг болгон бич. Шүлэг 31–38-д Есүсийн шууд заасан зүйлийн тухай ямар нэг юмыг оруул. Түүнчлэн ил харагдах нь бага зарим сургамжийг оруул.

Иохан 5

“Би Эцэгийнхээ Нэрээр Ирсэн Юм”

Самарид нэг худгийн дэргэд Есүс нэг эмэгтэйтэй уулзсанаас хойш жил орчмын дараа (Иохан 4-ийг үз) Тэр Иерусалим уруу эргэж явжээ, учир нь Дээгүүр Өнгөрсний Баярын үе дахин ирсэн байв. Иерусалим уруу аялсан энэ хоёр аяллын хоорондох жилд Есүс юу хийсэн нь Матай 5–11 болон Лук 6–8-д үздэг гэдгээ. Иохан 5 нь Иерусалим дахь Дээгүүр Өнгөрсний хоёр дахь баярын үеэр Есүсийн хийсэн болон хэлсэн зүйлийн талаарх шастираар эхэлдэг.

Судруудыг Ойлгох нь



Иохан 5

Өвчтэй (ш.3)— Хүч хийгээд чадалгүй хүмүүс

Доголон (ш.3)—Хазгар

Хатингар (ш.3)—Хөл гар нь хатангиришсан

Өвчтэй (ш.5)—Өвчтэй буюу тахир дутуу

Эрүүл (ш.6, 9, 11, 14–15)—
Эрүүл, зүгээр байгаа

Зайлан явсан (ш.13)—Өөр тийшээ сэмхэн яваад өгсөн
Даатгасан (ш.22)—Эрх мэдлийг өгсөн

Иохан 5:4—“Эзэний Тэнгэр Элч Доош Бууж Ирэн . . . Ус Хөдөлгөв”

Бетзада цөөрөм хавраас эхлэн үе үе оргилдог байсан бололтой. Үл үзэгдэх тэнгэр элч усыг оргилуулж, тэгээд ус “хөдөлсний”, эсвэл бургилсны дараа цөөрөмд анх орсон хэн ч гэсэн эдгэрдэг гэсэн заншил байжээ. Энэ бол ердөө

л мухар сүсэг байсан хэдий ч, олон хүн оролдож үзэхийг ихэд хүсдэг байсан бололтой, учир нь тэд өөрсдийн асуудлуудыг амархан шийдвэрлэнэ гэж найддаг байсан байж магадгүй, эсвэл тэд ямар нэг өөр зүйл мэдэхийг хичээдэг байсан ч байж болно.

Иохан 5:25, 28—“Схэгсэд Бурханы Хүүгийн Дуу Хоолойг Сонсох Болно”

Сүнсний шорон дахь сүнснүүд Бурханы Хүүгээр айлчлагдах тухай Хуучин Гэрээнд олон бошиглол байдаг (Дуулаал 88:10; Исаиа 24:22; 61:1-ийг үз) Иохан 5:25, 28-д цэдэглэгдсэнчлэн, Тэрээр удахгүй эдгээр бошиглолуудыг гүйцэлдүүлэхээ мэдэгджээ. Тэрээр цовдлуулсныхаа дараа сүнсний дэлхийд анх очихдоо эдгээр бошиглолуудыг гүйцэлдүүлжээ (С ба Г 138:11–22, 29–35).

Иохан 5:29—“Сайны Сйлийг Сйлдсэн Хүмүүс нь Амийн Амилуулалт Уруу”

Бошиглогч Иосеф Смит сүнсээр нөлөөлөгдөн, Библийн хяналт дээр ажиллаж байхдаа Иохан 5:29-ийн утгын талаар Тэнгэрлэг Эцэгээс асуужээ. Хариуд нь тэрээр Сургаал ба Гэрээ 76-д цэдэглэгдсэн үзэгдлийг хүлээн авчээ.

Судруудыг Судлах нь

Иохан 5-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Б) нэгийг хий.

А Гайхамшгаас Авсан Сургамж

Шинэ Гэрээнд цэдэглэгдсэн гайхамшгуудын олонх нь үнэний нэгэн адил, Есүс болон гайхамшигт оролцсон хүмүүсийн хийж байсан буюу хэлж байсан зүйлүүдээс бид сүнсний үнэнүүдийг мэдэж болно. Дараах асуултууд нь Иохан 5:1–16 дахь түүхээс мэдэж болох үнэнүүдийн зарим дээр анхаарлаа төвлөрүүлэхэд та нарт туслах учиртай.



1. Есүс яагаад тэр хүнийг эдгээхээр сонгож авсны шалтгаан юу байж болох вэ? (ш.5–6-г үз).
2. Энэ нь Есүсийн тухай бидэнд юу зааж байна вэ?
3. Тэр хүн нүгэл үйлддэг бүх хүмүүстэй юугаараа адилхан бэ?
4. Нүгэл үйлддэг хийгээд наманчилдаг бүх хүмүүсийн төлөө Тэрээр хийж чадах ба хийх зүйл нь тэр хүний

төлөө Есүсийн юу хэлсэн болон хийсэн зүйлтэй хэрхэн адил байна вэ?

5. Түүхэн дэх тахир дутуу хүнд уг түүхэн дэх хүнээс илүү муу юм тохиолдохгүйн тулд түүнийг яах хэрэгтэй гэж Есүс хэлсэн бэ?
6. Тэр Иудейчүүдэд хандан ярьж байх үед түүний хэлсэн гэж өөрсдийнхөө бодсон зүйлүүдийг бич.

Б Эцэг нь Ямар Байна Хүү нь Тийм Байна

1. Иохан 5:17–47-д Есүс Өөрийнхөө тухай түүнчлэн Тэнгэрлэг Эцэгийн тухай заасан үнэнүүдийг жагсаан бич.
2. Есүсийн заасан зүйлүүдээс юу нь та нарт хамгийн их сэтгэгдэл төрүүлэв? Яагаад?
3. Учир шалтгааны хувьд Есүс болон Тэнгэр дэх Түүний Эцэг хоёр нэг адил Хүмүүн Биет байж болохгүйг эдгээр заасан зүйлүүд хэрхэн харуулж байна вэ?

Иохан 6

“Есүс Бол Амьдралын Талх”

Яагаад биеийн нэгэн адил сүнсэнд тэжээл хэрэгтэй байдаг вэ? Таван мянган хүнийг Есүс хэрхэн хэдхэн талхаар хооллосон тухай та нар өмнөх Сайн Мэдээнүүдэд уншсан. Иохан 6-д, тэр түүхийн тухай, ялангуяа Есүсээс хүмүүсийн хүлээж авсан биет хоол хүнсийг Тэрбээр тэдэнд өгөхийг хүсдэг байсан сүнсний тэжээлтэй харьцуулсан хүмүүсийн өвөрмөц хандлагыг харуулсан тухай илүү олон түүхийг бид мэдэх болно. Бидний сүнсний тэжээн тэтгэхийг, бидний биеийг хоол хүнсээр тэжээхийн нэгэн адил холбогдолтойг Есүс гэрчилдэг байв. Хүмүүс хэрхэн хариулж байсныг ажигла.

Иохан 6-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Иохан 6:1–14—Матай 14:13–21; Марк 6:30–44; Лук 9:10–17
Иохан 6:5–21—Матай 14:22–33; Марк 6:52

Судруудыг Ойлгох нь

Иохан 6

Денар (ш.7)—Ажилчны нэг өдрийн цалин

Орой (ш.16)—Үдэш

Хорин таван эсвэл гучин стадиа (ш.19)—5-аас 6.5 орчим километр

Завинуудад сууж (ш.24)—Завинд орж суугаад

Дургүйцэн шивнэх (ш.41, 43, 61)—Гомдоллох

Маргалдах (ш.52)—Зөрөлдөх, маргах

Амь өгөх (ш.63)—

Амьдруулах, амьтай болгох

Судруудыг Судлах нь

Иохан 6-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А—Г) хоёрыг нь хий.

А Хааныг Сонго

1. Үй олон дагалдагчид нь Аврагчийг хаанаа болгохыг хүсч байв (Иохан 6:15-ыг үз). Иохан 6:5–14, 24–26-д өгүүлснээр, хүмүүс яагаад Есүсийг хаанаа болгохыг хүсдэг байсан бэ?



2. Бид яагаад Түүнийг хаанаа болгохыг хүсэх ёстой вэ?

3. Есүсийг дагах бидний хүсэл эрмэлзэл бидний амьдарч байгаа арга замд ямар өөрчлөлт оруулдаг вэ?

Б Харьцуулалт Хий

Доорхтой төстэй хүснэгтийг хий. Иохан 6:22:27-д Есүсийн хэлсэн зүйлүүдээр үүнийг бөглө.

Мөхдөг “Хоол”	Тэсэн Гардаг “Хоол”

В Амьдралын Талх

Хэрэв та зүсэм гэрийн халуун талх идэж үзсэн бол энэ нь хичнээн их амттай байдгийг, мөн энэ нь танд юуг хангаж өгдгийг бод. Иохан 6:48–59-ийг уншиж, Есүс биднийг сүсний тэжээлээр хэрхэн хангадаг тухай бод. Дараах асуултуудад хариул:

1. Шүлэг 51–58-д өгүүлснээр, бид мөнх амьдралтай байхын тулд ямар хоёр зүйл хийх хэрэгтэй гэж Есүс хэлсэн бэ?
2. Ариун ёслолын ёслолыг таны хувьд илүү утга төгөлдөр болгоход эдгээр заасан зүйлүүд хэрхэн тусалж чадах вэ?

Г “Тохиромжгүй Месая”

Тухайн үед Бригам Янгийн Их Сургуулийн ерөнхийлөгч асан, Ахлагч Жеффри Р.Холанд, “Амьдрал [Есүсийн хувьд] нэн тохиромжгүй байлаа, тийнхүү, хэрэв миний таавар алдаатай биш бол, бид түүний нэрийг өөр дээрээ авах нь таны хувьд ч бас миний хувьд ч тохиромжгүй байх болно” гэж хэлжээ (“The Inconvenient Messiah,” *Brigham Young University 1981–82 Fireside and Devotional Speeches*, 77). Иохан 6:60–71-ийг уншиад, дараахыг тайлбарла.

1. Түүний шавь нараас олонд нь Есүсийн сургаал хэрхэн “тохиромжтой бус” байсан бэ?
2. Петр “тохиромжтой бусыг” үл хайхран, Есүсийг дагахад үргэлжлүүлэхийн тулд ямар хүч чадлыг өгсөн бэ?

3. Их Эзэн танаас хэцүү зүйлүүдийг хийхийг хүсэхэд та нар дуулгавартай байдлаа баталгаажуулахын тулд юу хийж чадах вэ?

Иохан 7

Есүс Иерусалимд Гэрчилсэн нь

Иохан 7 дахь үйл явдлууд Табернеклын Баярын үеэр Иерусалимд болжээ. Мосегийн үеэс сахицыг Израилын хүүхдүүдэд Их Эзэний зарлигласан энэ баяр нилээд хэдэн чухал бэлэгдлийг ёслолууд буюу ёс жаягийг өөртөө багтаадаг байв. Есүсийн үед эдгээрийн нэг нь Силоамын цөөрмөөс ахлах тахилчид ус татаж гарган, үүнийг сүмийн ариун газарт асгадаг байсан нь—Бурхан Өөрийн Ариун Сүнснийг хүмүүсийн дунд цутгахын бэлэгдэл байлаа (Bruce R. McConkie, *The Mortal Messiah*, 3:123-ыг үз). Иохан 7-г уншиж байхдаа энэ бэлэгдлийн үйл ажиллагааг Түүний хүмүүст хэлсэн өөр олон гэрчлэлүүдтэй холбоотой юуг Есүс заасныг мэдэгд.

Судруудыг Ойлгох нь

Иохан 7

Иудей (ш.1)—Иудей

Хуулийг зөрчихгүйн тулд (ш.23)—Хуулийг бүрэн дүүрэн дагах

Хаанаас (ш.27–28)—Хаанаас

Суурьшсан (ш.35)—Тараагдсан Израилчууд

Тэнд (ш.36)—Тэр газар

Иохан 7:1, 13, 15, 35, 45–48—Их Эзэнийг Хөнөөхөөр Оролдож Байсан Иудейчүүд Хэн Байв?

Иудейчүүдийн дунд Есүс олон дагалдагчидтай байлаа (Иохан 6:2-ыг үз). Түүнийг хөнөөхөөр оролдож байсан Иудейчүүд бол Иудейчүүдийн удирдагчид, гол төлөв хуулийн багш нар хийгээд Фарисайчууд байлаа. Есүс Хүндэтгэлийн өдөр гайхамшгуудыг үйлдэж байснаараа, бас Өөрийгөө Бурханы Хүү үнэхээр мөн хэмээн мэдэгдсэнээрээ тэдний уурыг хүргэжээ (Иохан 5:16–18-ыг үз).

Иохан 7:6–9, 30, 33; 8:20—“Миний Цаг Хараахан Болоогүй”

Есүс мөнх бус амьдралынхаа сүүлчийн саруудад амьдарч байснаа мэдэж байлаа. Тэрээр бас Өөрийнх нь үүрэг зорилго дуусаагүйг мэдэж байв. Түүгээр хийлгэхээр илгээсэн бүхнийг хийж дуустал Түүний амьдралыг Тэнгэр дэх Түүний Эцэг сунгах учиртай байлаа. Иохан 9:4-ийн Иосеф Смитийн Орчуулгын дагуу, Их Эзэн “Миний ажлаа дуусгах тэр цаг ирэх болно, тэгээд би Эцэг рүүгээ явна” хэмээн гэрчилжээ.

Судруудыг Судлах нь

Иохан 7-г судлахдаа дараах хоёр үйл ажиллагаанаас (А эсвэл Б) нэгийг нь хий.

А Өгүүлбэрүүдийн Доогуур Зур

Та хэзээ нэгэн цагт ганцаардаж байсан уу, эсвэл хүн бүхэн таны эсрэг байсан уу? Иохан 7:1–13-ыг уншиж, тиймэрхүү ганцаардлыг Есүс мэдэрч байсан байж болох үеүдийг эрж хай.

1. Иудейчүүдийн удирдагчид Есүсийг хөнөөхөөр илт оролдож байсныг харуулсан өгүүлбэрүүдийг агуулсан шүлгүүдийг жагсаан бич.
2. Иохан 7:5 дахь нөхцөл байдал Есүсийн санаа сэтгэлд хэрхэн нөлөөлж байсныг ярь. Энэ таны санаа сэтгэлд хэрхэн нөлөөлж болох вэ?

Б Төгс Эзэмших Судар—Иохан 7:17

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Ричард Ж. Скотт, “Та нарын сонгох эрх чөлөө, сонголт хийх эрх та нарыг юу хүссэнээ хийж байх боломжтой байхын тулд өгөгдсөн юм биш. Энэхүү бурханлиг бэлэг нь Тэнгэр дэх Эцэг тань та нарын хийхийг хүсдэг тэр зүйлүүдийг та нар хийж байхын тулд хангагдсан юм. Та нарыг ямар болоосой гэж Тэрээр төлөвлөсөн тэр замаар Тэрбээр та нарыг удирдаж чадна” (in Conference Report, 1996 оны 4-р сар, 33; *Ensign*, 1996 оны 5-р сар, 25).

Иохан 7:17-гийн утгыг ойлгоход Ахлагч Скоттын нотолгоо та нарт хэрхэн туслахыг тайлбарла.

Иохан 8 “Би Байдаг”

Иохан 8 дахь үйл явдлууд Иохан 7-д бидний унидаг мөнөөх Майхан (Табернекл) Баярын үеэр болжээ. Энэ баярын өөр нэг бэлэгдлийн үйл ажиллагаа нь ариун сүмд олон лаа асаадаг явдал байв. Энэ бол ертөнцөд гэрэл байхыг Израилчуудад сануулахаар байсан юм. Үүнийг Есүс Өөрийгөө хэн байсныг дахин гэрчлэх боломж болгон ашигласан. Та нар энэ бүлгийг уншихдаа Есүс болон Түүний заадаг зүйлүүд гэрэлтэй хэрхэн адилхан болохыг, түүнчлэн харанхуй нь нүгэл хийгээд итгэлгүй байдлын бэлэгдэл болох тухай эргэцүүлэн бод.

Судруудыг Ойлгох нь

Иохан 8

Би хаанаас ирснээ (ш.14)—
Хаанаас би ирснээ

Хаашаа (ш.14, 21–22)—
Хаашаа

Сан хөмрөг (ш.20)—Өргөл
хадгалдаг газар

Абрахамын удам (ш.33,
37)—Абрахамын үр удам

Садар самуунаас төрсөн
(ш.41)—Гэрлэлтээс гадуур
төрсөн хүүхдүүд

Иохан 8:11—Есүс Завхайрагч Эмэгтэйг Уучилсан уу?



Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл, “Тэр эмэгтэйд Түүний өгсөн зарлиг нь, ‘Яв, үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд’ гэж хэлжээ. Тэрээр нүгэлт эмэгтэйг хилэнцэт амьдралаа орхин, дахиад нүгэл үйлдэхгүй байж, амьдралаа өөрчлөн, замаараа явахад нь чиглүүлжээ” хэмээн заажээ (*The Teachings of Spencer W. Kimball*, хянан тохиолдуулсан Edward L. Kimball [1982], 89).

Иосеф Смитийн Орчуулганд, “Тэгээд эмэгтэй тэр цагаас Бурханыг алдаршуулж, мөн

түүний нэрэн дээр итгэсэн” хэмээн хэлснийг тэмдэглэх нь урамшуулмаар юм (ИСО, Иохан 8:11).

Иохан 8:58—“Абрахамыг Бий Болохоос Өмнө Би Байдаг Мөн.”

“Би Байдаг” гэдэг нь тэрээр бошиглогчоор дуудагдсаныг нь Мосед илчилсэн Бурханы нэр юм (Египетээс Гарсан нь 3:14-ийг үз). Энэхүү хэллэгт, Тэр (Иехова) бол Хуучин Гэрээний Бурхан түүнчлэн амлагдсан Месая байсныг Их Эзэн тунхаглажээ. Энэ тунхаглалыг Иудейчүүд Бурханыг доромжилсон хэрэг гэж үзэн, “тэд түүн уруу чулууудааар чулуу шүүрэн авчээ” (Иохан 8:59).

Судруудыг Судлах нь

Иохан 8-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) гурвыг нь хий.

А Амьдрал Шударга Байдаг уу?

Иохан 8:1–11-ийг уншиж, энэ түүхийн тухайд та нарт шударга бус гэж санагдсан зүйлүүдийг жагсаан бич. Та нарт шударга санагдсан зүйлүүдийн өөр нэг жагсаалтыг гарга. Та нарын амьдралд юмсыг “шударга” болгох хүч Есүс Христэд хэрхэн байдаг талаарх бодлуудаа бич.

Б Гэрлийг Дээш нь Барь



Харанхуй өрөөнд асч байгаа лаг дээш нь өргөхөд юу болох тухай бод. Лааны дөлийг гараараа таглахад юу болох вэ? Марк болон Иохан 8:12-ыг 3 Нифай 18:24-ын ишлэлүүдийг харьцуул. Гэрэл нь юу болохыг тэрчлэн та нар үүнийг хэрхэн “дээш нь өргөхийг” тайлбарла.

В Жишээ Гарга

Иохан 8:32–34-т Есүс эрх чөлөө хийгээд боолчлолын тухай хоёр чухал үгийг хэлжээ. Зарим үед бусад хүмүүс, Есүсийн үнэн гэж хэлсэн зүйлийн эсрэг итгэлтэй байхыг биднээс хүсдэг. Гэсэн хэдий ч, Түүний заасан зүйлийн үнэнийг харахын тулд бид зөвхөн эргэн тойрноо харах ёстой. Хэрэв бид Түүний заасан зүйлүүдийн дагуу амьдрах юм бол энэ нь үнэн гэдгийг бид бүр ч мэдэх болно (Иохан 7:17-г үз).

1. Иохан 8:32-т Мэргэн Ухааны Үг, ариун явдлын хууль, эсвэл бусад зарлигуудын аль нэгний талаар Есүсийн хэлсэн зүйл хэрхэн үнэн болох тухайд жишээ гарга.
2. Мөнхүү зарлигийн талаар Иохан 8:34-т Түүний хэлсэн зүйл хэрхэн үнэн болох тухайд жишээ гарга.

Г Түүх Бич

Та нар Иохан 8:48–49-ийг уншихдаа Иудейчүүдийн удирдагчид Есүсийг ямар хүн гэж яллаж байсныг болон Есүс Өөрийгөө хэн байсан гэж гэрчилж байсныг эрж ол. Тэргүүн Зөвлөлийн Нэгдүгээр Зөвлөх Ерөнхийлөгч Томас С.Монсон, “өөрсдийнхөө доторх хаанд үнэнч бай” гэж хэлжээ (in Conference Report, 1991 оны 4-р сар, 65; *Ensign*, 1991 оны 5-р сар, 48). Та нар өөрсдийгөө хэн болохыг бодож үзээд, Түүнийг үнэхээр хэн байсныг мэдсэнээр Есүс хүнд бэрх хавчлагатай тулгарахад хэрхэн урам өгсөн талаар товч догол мөр бич.

Иохан 9

Есүс ба Төрөлхийн Хараагүй Хүн

Та хэзээ нэгэн цагт шөнө дунд гэрэлгүй, төөрч байсан уу? Та бодлоо хэрхэн дүрслэх вэ? Их Эзэний үүрэг зорилго бол харанхуйлагдсан дэлхийд гэрэл авчрах явдал байлаа. Тэрээр чухамдаа Өөрийн үүрэг зорилгын хүчийг бэлэгдэн, төрөлхийн хараагүй хүнд хараа оруулсан билээ. Та нар Иохан 9-ийг уншихдаа, хүмүүс бүр “дэлхийн гэрэл” тэдэн дээр тусч байлаа ч гэсэн зөвхөн харанхуйг хардаг арга залуудыг эрж ол.



Судруудыг Ойлгох нь



Иохан 9

Хараан зүхэж (ш.28)—Харааж

Иохан 9:1–3, 34—“Хэн Нүгэл Сйлдсэн Бэ?”

Хүмүүс нүгэл үйлдсэн учраас л хүнд сорилттой тулгардаг гэж итгэх нь тэр үед нийтлэг байсан, өнөөдөр ч гэсэн ямар нэг хэмжээгээр байгаа зүйл (Лук 13:1–5). Мөнх бус байдлын өмнөх амьдралын хэлбэрт Иудейчүүд итгэдэг байсан бололтой, учир нь түүний хараагүй нь нүглийнх нь үйлийн үр үү гэж тэд асуусан байдаг. Тэр төрөлхийн хараагүй байсан учир, тэр төрөхөөсөө өмнө нүгэл үйлдсэн байх учиртай гэж бодсон байх ёстой. Гэвч түүний хараагүй нь нүглийнх нь үйлийн үр биш гэж Есүс хэлжээ.

Иохан 9:22, 34—“Синагогоос Хөө”

Синагогоос хөөгдсөн хүн олон эрх, онцгой боломжууд хийгээд хэлхээ холбоогоо алддаг байв. Тэдний хүүхдүүдийг сургуульд явахыг нь хориглож, нийгмийн хэлхээ холбоо болон шашны сургаал сонсохыг нь хаадаг байв.

Судруудыг Судлах нь



Иохан 9-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Хүнд Сорилтуудын Зорилго

1. Иохан 9:1–3-т Есүсийн хэлснээр, тэр хүн яагаад хараагүй төрсөн бэ?
2. Түүний хариулт тахир дутуу зарим хүмүүсийн талаар бидэнд юу заадаг вэ?

Б Хэн Жинхэнээсээ Сохор Байсан бэ?

1. Хуудас цаасан дээр “Фарисайчууд,” “Эцэг эхчүүд,” “Хараагүй хүн” гэсэн гурван нэрийг бич. Нэр бүрийн дор тэдний сүнсний харалган байдал буюу эсвэл сүнсний харааны талаарх үгс буюу хэлц үгсийг Иохан 9:13–38-аас тэмдэглэж ав.
2. Нүдний хараагүй нь энэ амьдрал дахь бие эрхтний хүнд согог гэж тооцогдох нь олонтаа байдаг. Үүний адилаар, сүнсний сохор нь хэрхэн согог байж болох вэ?

Иохан 10

Сайн Хоньчин



Есүсийн үед Палестинд олон хоньчид байжээ. Сайн хоньчид нь хониндоо анхаарал халамж тавьж, хамгаалдаг итгэлтэй байдлаараа нэрд гардаг байв. Жинхэнэ хоньчин хониныхоо ард явж, тэднийг араас нь туух биш харин өмнө нь явж, удирдах ёстой ба тэр ч байтугай олон хоньчид хонинуудаа тус тусад нь нэрээр нь дууддаг. Хонинд анхаарал халамж тавихын тулд хэн нэгнийг хөлслөхтэй адилгүй, хоньчин нь өөрийнхөө хонинуудыг эзэмшиж, тэдгээрийн аль нэгнийг нь амь нас хийгээд аюулгүй байдлын төлөө эрсдэл хүлээж болно. Хонь нь эдгээр сайн хоньчдод итгэдэг учраас тэд гаднын хүнийг дагадаггүй, сайн хоньчид тэднийг дуудахад хүрч ирдэг. Иохан 10-т хонь болон хоньчны тухай нийтээрээ сайн мэдэх эдгээр санаануудыг Тэрээр Өөрийн шавь нартайгаа харилцах тухайд Есүс хэрхэн ашигласан талаар та нар унших болно.

Түүнчлэн Иохан 10 нь Түүний заадаг зүйлүүдийг хүлээн авахаас татгалзсан, мөн Түүнийг зэмлэн буруутгахаар оролдож байсан хүмүүст болон тэдний талаар Есүс юу ярьсныг өгүүлдэг.

Судруудыг Ойлгох нь

Иохан 10

Хонины хашаа (ш.1)—Хонь хашдаг хашаа

Сахиул (ш.3)—Хонь харж, хаалга нээдэг зарц

Гаргаад (ш.4)—Хашаанаас гадагш гаргаад

Сургаалт зүйрлэл (ш.6)—Тодорхой утга агуулсан өгүүлэг (Матай 13-ын оршлыг үз, х.26)



Хонины хашаа

Тэжээл (ш.9)—Бэлчээр (энэ хам сэдэвт Аврагчийг дагадаг тэдгээрт сүнсний хоолны тэжээлийн тухай ярьж байна.)

Бялхсан (ш.10)—Илүү бүрэн дүүрэн
Хөлсний хүн (ш.12–13)—Хонь маллахаар хөлслөгдсөн хүн
Хагарал (ш.19)—Хэрүүл, зөрчил
Булаах (ш.28–29)—Хулгайлах, аваад явчих
Бурханыг доромжлох (ш.33)—Ариун нандин зүйлүүдийн талаар хөнгөн хуудамгайгаар, тоглоом тохуу болгох буюу үл хүндэтгэсэн байдлаар ярих

Иохан 10:22—Зориулалтын Баяр

МЭӨ 167 онд хэсэг Иудейчүүд дайнд өөрсдийн ариун сүмийг Грекчүүдээс эргүүлж авсан үеийг дурсан санахын тулд одоогийн Арванхоёрдугаар сард энэ баярыг найман өдөр тэмдэглэдэг байжээ. Ариун сүмийг Грекчүүд эзэлж, тэгээд бузарлагдсан байжээ (ариун бус болгогдсон). Иудейчүүд үүнийг ариусгаж, дахин онцгойлон адислажээ. Өнөөдөр энэ баярыг Гэрлийн Баяр буюу Ханукка гэдэг.

Судруудыг Судлах нь

Иохан 10-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Бэлэгдлүүдийн Талаарх Ойлголтоо Гүнзгийрүүл

Иохан 10:6–18, 25–29-д Есүс шүлэг 1–5 дахь сургаалт зүйрлэлийн зарим утга юу болохыг тайлбарлажээ. Есүс Өөрийн тайлбарт уг сургаалт зүйрлэл дэх хоёр өөр зүйл Түүнийг төлөөлж байгааг хэлжээ (ш.7, 11-ийг үз). Эдгээр хоёр зүйл хоёулаа Түүний үүрэг зорилгын зарим хэсгийг бэлэгдсэнийг учир билээ.

1. Есүс уг сургаалт зүйрлэлд хаалганы бэлэгдэл болсныг ойлгоход тань та нарт туслах ямар нэмэлт мэдээллийг та нар 2 Нифай 9:41–42-оос мэдэж авдаг вэ?
2. Иохан 10-т бичигдсэн зүйл дээр тулгуурлан, сайн хоньчин хониныхоо талаар хийдэг зүйл нь бидний талаар Есүсийн хийдэг зүйлтэй хэрхэн адил төстэй вэ?
3. Иохан 10-ыг ашиглан, Есүсийн хонины тухай заадаг шүлэг бүрийг тэмдэглэж, таних тэмдгийг жагсаа.
4. Мозая 5:10–13 хонины тухай ямар нэг зүйлийг тусгайлан хэлээгүй ч гэсэн, Есүсийн хонь болох хүмүүсийг, түүнийг биш хүмүүстэй хэрхэн харьцуулах талаар бид эдгээр шүлгүүдээс юу сурч болох вэ?

Б Төгс Эзэмших Судар—Иохан 10:16

Иохан 10:16-д дурдсан “бусад хонинууд” хэн бэ гэдгийг мэдэхийн тулд 3 Нифай 15:11–24 болон 16:1–3-ыг унш. Үүнийг тэмдэглэлийн дэвтэртээ тэмдэглэ. Түүнчлэн тэд

хэн болохыг та нар өөрсдийн Библийн зах дээр Иохан 10:16-гийн дэргэд бичиж болно.

В “Та Христ Мөн үү?”

Иудейчүүдийн зарим нь Тэрээр Христ мөн үү гэдгийг тэдэнд тусгайлан хэлж өгөхийг Есүсээс асуусныг бид Иохан 10:22–39-д уншдаг. Тэрээр тэдэнд шууд хариулаагүй ч гэсэн ч, тэд Түүний юу гэснийг ойлгож, үүнийх нь төлөө Түүнийг хөнөөхийг хүсч байлаа. Магадгүй энэ нь яагаад Тэрээр тодорхой хариулаагүйн учир байж болно.

1. Тэрээр хэн байсан тухай гэрчлэлээ илэрхийлж Есүс юу гэж хэлсэн бэ? (ш.25, 37–38-ыг үз).
2. Зарим хүмүүс Түүнийг чулуугаар шидэхийг өдөөн хатгаж байхад Есүс юу гэж хэлсэн бэ?
3. Сүмийг шүүмжилдэг буюу эсвэл өөрсдийн тань гэрчлэлийг дайрч довтолдог хүмүүстэй зохицохдоо та энэ түүхийг, мөн Есүсийн үлгэр жишээг хэрхэн ашиглаж болох вэ?

Иохан 11

Лазар Үхэгсдээс Босч Ирэв



Иохан 10-т, Тэрээр хэн байсныг Түүний ажлууд гэрчилсэн хэмээсэн Түүний үгст итгээгүй хүмүүст Есүс хандан хэлжээ (ш.25, 32, 37–38-ыг үз). Лазар үхэгсдээс босч ирсэн нь, Иохан 11-д цэдэглэгдсэнээр, Есүс бол яах аргагүй тэдний Месая байсан гэдэг гэрчлэлийг үл итгэгчид хүлээн авах хамгийн агуу боломж байсан байж магадгүй. Энэхүү гайхамшиг Түүний мөнх бус байдал дахь тохиолуулын төгсгөл ойртож байхад тохиосон Түүнийг таних хийгээд Түүний хүчний тухай агуу гэрчлэл байв. Иоханы түүх зөвхөн Есүсийн хүчийг гэрчилсэн төдийгүй, бас Түүний хайр хийгээд өрөөч сэтгэлийг харуулсан юм. Иохан 11-ийг уншихдаа, Иудейчүүдийн удирдагчдад үзүүлсэн энэ гайхамшигийн нөлөөг анхаар.

Судруудыг Ойлгох нь



Иохан 11

Таван стадиа . . . орчмын гэртээ (ш.18)—2 800 метр орчим хол

Дээр гэдгийг (ш.50)—
Хэрэгтэй, зохино
Тарсан (ш.52)—Израилын гадна талд

Иохан 11:55—“Өөрсдийгөө Ариусга”

Дээгүүр Өнгөрсний Баярын ариун зоог болон өргөлүүдэд оролцохын өмнө, эрэгтэй, эмэгтэйчүүд өөрсдийгөө ёс жаягийн хувьд ариусгах зарим тодорхой заншлуудыг баримталдаг байлаа. Энэ нь өвөрмөц тусгай байдлаар хийдэг угаалга, Мосегийн хуулийн дагуу ямар нэг үхсэн буюу бузар зүйлд хүрэхгүй байх, түүнчлэн олон жилийн туршид Иудейчүүдийн удирдагчдын нэмж оруулсан дараах дүрмүүдийг багтаадаг. Тэд Есүсийг цовдлохоор оролдож байхдаа зарим нь хоёр нүүр гаргаж байсныг харуулдаг. Тэд бүр Түүний гэмгүй цусны төлөө улайран байхдаа ч, “бузар” болохгүйг анхаарч байжээ (Иохан 18:28-ыг үз).

Судруудыг Судлах нь



Иохан 11-ийг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-гийн нэгийг хий.

А Өгүүлбэрүүдийг Дуусга

Лазарын тухай өгүүлдэг дараах өгүүлбэрүүдийг тэмдэглэлийнхээ дэвтэрт бичиж, Иохан 11-ээс өөрсдийн уншсан мэдээллийг чадах чинээгээрээ ашиглан тэдгээрийг бөглө.

1. Лазарыг өвчтэй гэж Есүс дуулаад . . .
2. Бетани уруу явахаасаа өмнө Есүс хоёр өдөр хүлээв, учир нь . . .
3. Есүсийг Бетанид хүр очиход, Лазар . . .
4. . . . гэдэгт Марта итгэж байв.
5. . . . учраас Есүс уйлав.
6. Есүс Эцэгт хандан чангаар залбирав, учир нь . . .
7. Есүс Лазарыг үхэгсдээс босгосны дараа олон Иудейчүүд . . . хэдий ч, зарим Иудейчүүд . . .

8. Энэ түүхээс надад хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн зүйл бол . . .

Б Сонины Шинэ Дугаар Бич

Есүс Лазарыг үхэгсдээс босгосонд Иудейчүүдийн удирдагчдын үзүүлсэн хариу үйлдэл Иохан 11:47–54-т байдаг. Тэр үед сонинууд байсан гэж төсөөлөн бодоод, дараах зүйлд хариулахад өөрт тань туслах шүлгүүдийг ашигла:

1. Хэрэв Ромын сонин, Есүс болон Түүний тохинууллын талаарх бодлыг нь Каиафаас асуусан бол тэр юу гэж хэлнэ гэж бодож байгаага бич.
2. Каифа ромчуудыг уншихгүй гэж бодон, Иудей хэлээр гардаг орон нутгийн сонинд юу гэж нотлох байсан гэж та бодож байна?
3. Каифагийн санааг хамгийн их зовоож байсан зүйл юу гэж та бодож байна?
4. Каифа Бурханы талаар хүчтэй гэрчлэлтэй байж Түүнтэй харилцахаас хөндий байсан яг тэр үндсэн шалтгаанаар өөрсдийн тань насны хэн нэгэн Бурхантай ойр дотно харилцаатай байхаас хол хөндий байгаа тухай өнөө үеийн жишээ гарга.

Иохан 12

Нийтийн Өмнөх Есүсийн Сүүлчийн Гэрчлэл

Хэрэв та нар Есүсийн үед амьдарч байсан бөгөөд Иохан 1–11-д уншсан зүйлүүдээ харсан бол өөрсдийн тань гэрчлэл хэр зэрэг хүчтэй байх байсан гэж бодож байна? Иохан дахь бараг бүлэг болгон Есүсийн тухай өсөн нэмэгдсэн гэрчлэлтэй байх хүчтэй шалтгаануудыг агуулсан төдийгүй, бас ихэвчлэн тэр гэрчлэлийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж байсан хүмүүсийн шастирыг багтаадаг билээ. Иохан 12 ч гэсэн мөн адил. Та нар уншихдаа, Есүст итгэдэг байсан хүмүүс юу хийж мөн юу хэлж байсныг мөн Түүнд итгэдэггүй хүмүүс юу хэлж, мөн юу хийж байсныг ажигла.

Иохан 12-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Иохан 12:1–7—Матай 26:6–13; Марк 14:3–9
Иохан 12:12–19—Матай 21:1–11; Марк 11:1–11; Лук 19:28–40

Судруудыг Ойлгох нь



Иохан 12

Цэвэр нардын үнэрт тос (ш.3)—Үнэртэн шингээсэн тос

Анхилам үнэр (ш.3)—Сайхан үнэр

Гурван зуун динар (ш.5)—Дундаж ажилчны нэг жил орчмын ажлын хөлс

Зөвлөлдөв (ш.10)—Хамтран зөвлөв

Хосанна (ш.13)—“Одоо авраач” гэсэн утгатай хашгирч хэлдэг магтаал

Хараач (ш.19)—Ойлгох
Үйлс (ш.19)—Гүйцэтгэл
Ганцаараа үлдэнэ (ш.24)—Хэвээрээ үлдэнэ
Исаиа (ш.38–39)—Исаиа
Иохан 12:14–19—Есүс
Дудран Унаж Иерусалимд Ирсэний Ач Холбогдол Юу вэ?
Матай 21:1–11-ийн (х.33).
“Судруудыг Ойлгох нь”-ыг үз.

Иохан 12:25–26—Бид Снэхээр Өөрсдийнхөө Амийг Сзэн Яддаг Гэж үү?

Эдгээр шүлгүүд дэх зөвлөгөө нь Түүний төлөө өөрсдийнхөө амийг “алдах” тухай бусад тохиолдлууд дахь Есүсийн зөвлөгөөтэй тун адилхан юм (жишээ нь, Матай 16:24–26-г үз). Мозая 3:19-д “эгэл хүн Бурханы дайсан” гэдгийг бид мэддэг. Иохан 12:25–26-д Есүсийн амласан мөнх амьдралыг олж авахын тулд, биднийг Бурханы дайсан болгодог тийм маягийн амьдралыг бид үзэн ядах ёстой гэдгийг ойлгох нь хэцүү биш юм.

Иохан 12:31—“Энэ Ертөнцийн Захирагч”

Энэ өгүүлбэр Сатан, чөтгөрийг хэлж байгаа юм. Тэрээр унасан энэ дэлхийд агуу хүч хийгээд нөлөөтэй бөгөөд өөрсдийгөө ноёрхох хүчийг түүнд олгосон олон хүмүүсийг захирдаг гэдэг утгаар тэр “энэ ертөнцийн захирагч” юм. Христийн Хоёрдахь Ирэлтээр анх удаа тохиох шүүлтийн үеэр тэр өөрийн хүчний байр сууриасаа зайлуулагдах болно гэдгийг Иохан 12:31 бидэнд өгүүлдэг.

Судруудыг Судлах нь



Иохан 12-ыг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Есүсийн Талаарх Өөр Өөр Хандлагууд

1. Дараах хүмүүс болон бүлэг хүмүүсийг тэмдэглэлийнхээ дэвтэрт жагсаа: Мариа (Иохан 12:1–8-ыг үз), Иудас (ш.1–8-ыг үз), далдуу модны мөчиртэй ирсэн хүмүүс (ш.12–18-ыг үз), Грекчүүд (ш.20–22-ыг үз), ахлах тахилчид хийгээд ахлах захирагчид (ш.10–11, 42–43). Эдгээрийн тус бүрийнх нь дараа, Иохан 12-т уншсан зүйл дээрээ тулгуурлан, Есүсийн тухай та нар өөрсдөө юу бодож байгаага ярь.

2. Есүс Христийг хайрлах хайраа харуулахын тулд та одоо амьдралдаа баримталж байгаа хоёр буюу гурван зөв зарчмыг дүрсэл.

Б Би Байдаг

Иохан 8-д тайлбарласнаар, “Би байдаг” нь Иудей хүмүүсийн хувьд тусгай нэр байжээ (Иохан 8:58-ын “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз, х.95). Есүс Өөрийгөө хэн болох хийгээд Өөрийн үүрэг зорилгыг “Би байдаг”-аар гэрчлэхийн тулд сонгож авсан олон үйл явдлыг Иохан цэдэглэжээ. Иохан 6:35, 41, 48, 51; 8:12 (мөн 12:46); 10:7, 9, 11, 14; 11:25; 14:6 болон 15:1, 5-ыг жагсааж, унш. Судрын ишлэл бүрийн дараа, уг ишлэл Есүс Христийн үүрэг зорилгын талаар бидэнд юу заадгийг товч тайлбарла.

Иохан 13

“Бие Биенээ Хайрла”



Иохан 13 дахь үйл явдлууд Есүсийг цовдлогдохын өмнөх үдэш болж өнгөрсөн юм. Тэр үдэш Есүс юу хийж, юу хэлж байсан тухай Иоханы гэрчлэл энэ бүлэгт цэдэглэгдэж, Иохан 17-г дуустал үргэлжилдэг. Тохих гэж байгаа зүйлийг Есүс мэдэж байсан учраас Өөрийгөө хөнөөгдөхөөс өмнө тэд мэдэх ёстой гэж Өөрийнхөө бодсон сургаалуудыг Тэрбээр шавь нартаа өгчээ. Эдгээр өдрүүдэд Түүний шавь нартаа юу гэж хэлж байсан нь өнөөдөр ч Түүний шавь нарт хамаатай.

Иохан 13-т Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Иохан 13:18–30—Матай 26:21–25; Марк 14:18–21; Лук 22:21–23
Иохан 13:36–38—Матай 26:33–35; Марк 14:29–31; Лук 22:31–34

Судруудыг Ойлгох нь



Иохан 13

Бүслэв (ш.4)—Бүс бүслэв

Угаах хэрэгтэй (ш.10)—

Угаах л хэрэгтэй

Гүйцэд цэвэрхэн байна

(ш.10)—Бүрэн цэвэрхэн байна

Миний эсрэг өсгийгөө

өргөв (ш.18)—Урвасан буюу

эсрэг эргэсэн гэдгийг хэлэх

бэлэгдлийн хэлбэр

Дохиж (ш.24)—Толгой

дохиж

Иохан 13:25—“Есүсийн Цээжийг Налсан Хэвээр”

Есүсийн үед хүмүүс хөлөө ширээнээс хол байлган, нэг төрлийн дэрэн дээр тохойлдон, хоолоо газар дээр тавьж иддэг байжээ (дагалдах зургийг үз). Хүн баруун гараараа идэхийн тулд зүүн талаараа тохойлдон налдаг заншилтай байв. Иймээс Есүсийн баруун талд байгаа хэн ч гэсэн Есүсийн цээжинд толгойгоороо налах учиртай байв.



Иохан 13:34–35—Шинэ Зарлиг

Хуучин Гэрээнд Есүс бусдыгаа хайрлахыг Өөрийн хүмүүст заадаг байлаа (Левит 19:18-ыг үз), гэвч энэ шинэ зарлиг нь “би та нарыг яаж хайрласан шиг” хайрлах тухай байлаа (Иохан 13:34). Өөрийн Цагаатгалаар Тэрээр нотолсончлон, бидний хайрладаг, мөн Түүнд байдаг хайр нь гүн гүнзгий, өөрийгөө золиосолсон хайр бөгөөд энэ нь өөр хэн нэгний хувьд хамгийн чухалчлах, мөнхийн халамж юм. Ерөнхийлөгч Ховард В.Хантер, “Бид бие биендээ илүү эелдэг ялдам, илүү уян зөөлөн хийгээд илүү уучламтгай байх хэрэгтэй. Бид уурлахдаа илүү удаан харин туслахдаа илүү шаламгай байх хэрэгтэй. Бид нөхөрлөлийн гараа сунгаж, харин хариу [өс] авахаас гараа татгалзуулах хэрэгтэй. Товчхондоо, бид бие биенээ Христийн цэвэр хайраар, жинхэнэ энэрлээр хийгээд өрөвч сэтгэлээр хайрлах хэрэгтэй бөгөөд, хэрэв шаардлагатай бол, Бурхан биднийг хайрладаг тэр байдлаар зовлонгоо хуваалцах хэрэгтэй” гэж сургажээ (“Come to the God of All Truth,” *Ensign*, 1994 оны 9-р сар, 72).

Судруудыг Судлах нь

Иохан 13-ыг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Энэ Ямар Ялгаатай Вэ? Би Сүнийг Хэрхэн Өөрчилж Чадах Вэ?

1. Иохан 13:1–17-д Есүс юу хийснийг авч үзэн, Есүс шавь нартаа удирдлагын тухай заасан арга замууд нь дэлхий ердийн байдлаар удирдлагыг дүрсэлдгээс өөр удирдлагын тухай шавь нартаа заасныг бич.
2. Танай Сүмийн удирдагчдын нэг буюу судрууд дахь хэн нэгэн, шавь нартаа Есүсийн заасан байдлаар ажилласан тохиолдлын тухай бич.

Б Снэн Сорилт

1. Иохан 13:34–35-д өгүүлснээр, биднийг Есүс Христийн шавь нар гэдгийг бусад хүмүүс яаж мэдэх вэ?
2. Христийн жинхэнэ шавь болохоор хичээж байгаа хүнд (Иохан 13:34–35-д Есүсийн өгүүлсний дагуу) дараах нөхцөлүүдэд хариулж болох зарим өвөрмөц арга замуудыг санал болго.
 - а. Танай сургуульд хэн ч үнэхээр дуртай байдаггүй нэг оюутан байдаг, учир нь тэрээр бусад оюутнуудын огт хүлээн зөвшөөрдөггүй тийм байдлаар, эвгүй, инээд хүргэж шоолмоор байдлаар хувцасладаг ажээ.
 - б. Сүмд шинэ хүн ирснийг та харжээ.

Иохан 14

“Хэрэв Та Нар Намайг Хайрладаг Бол, Зарлигуудыг Минь Сахь”

Хэрэв та нар ердөө хэдхэн өдрийн, эсвэл хэдхэн цагийн дараа үхэхээ мэдвэл бодол санаа тань ямар байх вэ? Үхэл хичнээн аймшигтай байх тухайд эсвэл ардаа үлдэж байгаа хүмүүсийн хувьд санаа тань зовох уу? Иохан 14–16 нь, Өөрийн зовлон болон үхлийн өмнө Өөрийн Төлөөлөгчдөд заасан Есүсийн сүүлчийн сургаалуудаас заримыг нь багтаадаг.

Хэрэв та нар тэр үед Есүсийн шавь нарын нэг байсан бол, хэрэв та нар Есүсийг үхэж, өөрсдийгөө орхин одох болно гэдгийг мэдсэн сэн бол, юуны төлөө санаа тань зовох байсан бэ? Та нар дараагийн хэдэн хуудсыг уншихдаа, Есүсийн сургасан зүйлүүд тайтгарлыг хэрхэн авчирч, Төлөөлөгчдийг айдсыг хэрхэн багасгах байсныг бод.

Судруудыг Ойлгох нь

Иохан 14

Хаашаа (ш.4–5)—Тийшээ
Хангалттай (ш.8)—Сэтгэл
ханамжтай
Орон байр (ш.23)—Гэр

Ертөнцийн захирагч
(ш.30)—Энэ дэлхийн хун-
тайж, Сатан (Иохан 12:31-
ийн “Судруудыг Ойлгох
нь”-ыг үз, х.99).

Иохан 14:2—“Миний Эцэгийн Гэрт Орон Байр Олон Бий”

Бошиглогч Иосеф Смит энэ хэсгийг “Миний Эцэгийн хаант улсад олон хаант улс бий” гэж унших ёстой гэж хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 366).

Иохан 14:4–6—“Би Бол Зам”

Бид булшнаас гэтэлгэгдсэн байхын тулд Есүс Христ бидний төлөө үхсэн билээ. Тэр бас “[биднийг] өөрсдийнхөө мөрөөр дагуулахын тулд бидэнд үлгэр дуурайлыг үлдээн” (1 Петр 2:21) бидний төлөө амьдарч байсан юм. Мөнхийн амьдралд хүрэх зам бол Их Эзэний төгс үлгэр жишээг дагах явдал мөн. Есүс Христийн дагалдагчид байсан хүмүүст Түүний “замыг” дагахыг хэлжээ (Үйлс 9:2; 16:17; 18:25–26).



“Селестиал хаант улсад хүрэх зам бол нэг зам мөн. Хэрэв бид судруудыг судлахгүй бол, бид их дардан зам дээрх буруу замаар явж байж болно” (L. Lionel Kendrick, in Conference Report, 1993оны 4-р сар, 13; Ensign, 1993 оны 5-р сар, 13).

Иохан 14:26–26—Хоёр Тайтгаруулагч Хэн Бэ?

Бошиглогч Иосеф Смит, “Хүн Есүс Христэд итгэх итгэлтэй болж, нүглүүдээ наманчлан, нүглүүдийнхээ ангижралын тулд баптисм хүртэж, эхний Тайтгаруулагч болох Ариун Сүнснийг хүлээж авсны дараа (толгой дээрээ гар тавиулах замаар), зөв шударга байдлын төлөө өлсч, цанган, Бурханы үг бүрээр амьдарч, Бурханы өмнө өөрийгөө даруусгахаа үргэлжлүүлэхэд өөрийгөө хүргэх юм бол . . . тэгвэл Гэгээнтнүүдэд Их Эзэний амласан өөр нэг Тайтгаруулагчийг хүлээн авах онцгой боломжтой байх болно. . . . Тэгвэл энэ өөр нэг Тайтгаруулагч нь юу вэ? Энэ бол Их Эзэн Есүс Христээс Өөрөөс нь өөр юм биш” хэмээн хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 150–51).

Судруудыг Судлах нь

Иохан 14-ийг судлахдаа үйл ажиллагаа Б болон бусад үйл ажиллагаануудаас (А–В) нэгийг нь хий.

А Аль Замаар Би Явах Вэ?

1. Иохан 14:1–6-д өгүүлснээр, Төлөөлөгчид хаашаа явах хэрэгтэй байсан бэ? Тэд тийшээ хэрхэн хүрсэн бэ? (3 Нифай 18:24).

- Их Эзэний замаар аялахын тулд юу хийснээ тунгаан бод. Энэ замаар замнахаа үргэлжлүүлэхийн тулд энэ дагуу өөрсдийн амьдрах хоёр буюу гурван зарчмыг бич

Б Төгс Эзэмших Судар—Иохан 14:15


- Аврагчийг хайрлах хайраа харуулахын тулд өөрсдийнхөө сахихаар хичээж буй хоёр зарлигийг нэрлэ.
- Зарлигуудыг сахих замаар хайраа харуулсан хүмүүст Есүс ямар амлалт өгсөн бэ? (Иохан 14:16–21-ийг үз).

В Зүрх Сэтгэлийн Зовлонд Жор Байдаг уу?

- Иохан 14:1, 27-д өгүүлснээр, Өөрийнх нь Төлөөлөгчдийн эсрэг байх ямар нөхцлийг Есүс зөвлөсөн бэ?
- Тэр нөхцлөөс зайлсхийхэд нь тэдэнд тусалж болох талаар Иохан 14-т Есүсийн заасан зүйлүүдээс наад зах нь гурвынх нь тухай бич.

Иохан 15

Есүс Бол Усан Үзмийн Жинхэнэ Мод



Хэрэв гэр ахуйн цахилгаан хэрэгсэл буюу багажийг эрчим хүчний эх үүсвэрт залгахгүй бол ашиггүй. Иймэрхүү үзэл санааг заасан сургаалт зүйрлэлийг Есүс Христ Өөрийн шавь нарт ярьсан байдаг. Иохан 15-ыг уншихдаа, та нар лагаад—бас хэрхэн Аврагчийн амьдрал, гэрэл хийгээд хүчинд “залгаагдах” ёстойг тунгаан бод.

Судруудыг Ойлгох нь



Иохан 15

Тариалагч (ш.1)—
Цэцэрлэгч

Байх (ш.4–7, 10)—
Үргэлжлүүлэх
Хаягдаж (ш.6)—Таслагдаж

Иохан 15:3—“Sr” Та Нарыг Хэрхэн Цэвэр Болгох вэ?

Их Эзэний “Yr” бол Түүний зарлигуудыг багтаасан Түүний сайн мэдээ юм. Ахлагч, Төлөөлөгч Жозеф Б.Вертлин, “Есүс Христийн Цагаатгалын гайхамшигт хүчээр дамжсан хүч нь Түүний зарлигуудад бид дуулгавартай байснаар идэвхждэг болохоор бид нүглүүдээсээ угаагдаж болно” гэж хэлжээ (in Conference Report, 1996 оны 10-р сар, 98; Ensign, 1996 оны 11-р сар, 72).

Иохан 15:22–24—“Тэд Өөрсдийн Нүгэлд Шалтаг Байхгүй Боллоо”

Хууль зөрчсөнийх нь төлөө хүнийг, ийм хууль байдгийг мэдэхгүй тэр хүнийг ч гэсэн буруутгах нь зөв үү? Мормоны Номны бошиглогч Иаков заахдаа, “Хууль өгөгдөөгүй тэнд шийтгэл үгүй байдаг” гэжээ (2 Нифай 9:25). Гэвч өөрсдийнхөө нүглүүдэд “шалтаг” эрэхгүй байхыг Их Эзэн тэдэнд сургасан хүмүүс хүлээн авсан зүйлүүдээрээ амьдрахад хариуцлага хүлээх болно (С ба Г 82:3–4-ийг үз).

Судруудыг Ойлгох нь



Иохан 15-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг нь хий.

А Зураг Зур

- Мөчиргүй мод зур. Модноос тасдуулсан нэг мөчир зур.
- Модноос тасдуулсан мөчирт тодорхой хугацааны дараа юу тохиолдох вэ?
- Тэр мөчир дээрх жимсэнд юу тохиолдох вэ?
- Модны эрүүл тал дээрх мөчрүүд дээр бид амьдралтай байж, Их Эзэний үр жимстэй мөчрүүд байх Есүсийн заасан арга замуудыг бич (Иохан 15:2–8, 16-г үз).

Б Хэрэв . . .

Иохан 15:6–20, Их Эзэнээр хэлэгдсэн найман “хэрэв”-ээр цэдэглэгдсэн байдаг. “Хэрэв” гэсэн холбоостой өгүүлбэр шалтгаан болон үр дагаврыг заасан байдаг. Жишээ нь, хэрэв та нар зарлигуудыг сахих юм бол, та нар адислагдах болно. “Хэрэв”-тэй найман өгүүлбэрийг үр дагаврын хамт жагсаан бич.

В Чи Их Эзэний Найз уу, Эсвэл Дэлхийн Найз уу?

Иохан 15:9–14-ийг Иохан 15:18–19, 23–25-тай харьцуулж, дараах асуултуудад хариул:

- Тэрхүү агуу хайр юу вэ, мөн энэ нь жинхэнэ нөхөрлөлд яаж тусгалаа олдог вэ?
- Дэлхий, эсвэл “дэлхийнх” болох хүмүүс яагаад Бурханы зүйлүүдийг үзэн яддаг гэж та нар боддог вэ?
- Их Эзэний найз байхын тулд та нар юу хийж болох вэ?

Г Номлогчийн Өдрийн Тэмдэглэл

Өөрсдийгөө номлогч гэж бод тэгээд та нар хамтрагчийнхаа хамт нэг гэр бүлд баптисмын тухай заажээ гэж санаа. Тэдний нэг нь тэд өөрсдийнхөө тохинуулагчдаар аль хэдийн усанд умбуулан баптисм хүртсэн гэж тайлбарлав. Зарим тохинуулагчид тэд ердөө Библийг зааж байгаа учраас л эрх мэдэлтэй байдаг гэж мэдэгддэг. Баптисм хүртээх зохих эрх мэдлийн тухай үнэнийг тэр гэр бүлд заахын тулд Иохан 15:16-ыг хэрхэн ашиглах тухай өдрийн тэмдэглэл бич.

Иохан 16

Ариун Сүнсний Үүрэг

Та нар хэзээ нэгэн цагт эцэг эхээсээ салж, олны дунд төөрч байсан уу? Тэгэхэд ямар байсан бэ? Өөрийн удирдлага хийгээд хүч чадлыг Тэрээр тэдэнд өгөн, Түүнгүйгээр ажлыг үргэлжлүүлэхээр Өөрийн шавь нарыг орхин Тэрээр удахгүй явах болно гэдгийг Есүс мэдэж байлаа. Тэрээр тэднийг ганцааранг нь орхихгүй гэдгийг тэдэнд хэлж, тэдэнтэй хамт байлгахын тулд Ариун Сүнсний илгээхээр амлажээ. Та нар Иохан 16-г уншихдаа, хэрэгтэй цагт Ариун Сүнс хэрхэн хүч чадал өгч чадах талаар Есүсийн заасан зүйлийг эрж ол.

Судруудыг Ойлгох нь

Иохан 16

Ертөнцийн захирагч

(ш.11)—Сатан, энэ дэлхийн хун тайж (Иохан 12:31-ийн “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз, х.99).

• Үнэний Сүнс (ш.13)—

Ариун Сүнс

• Төрөхдөө зовдог (ш.21)—

Хүүхэд төрүүлэхэд өвдөх

• Одоо болтол (ш.24)—Одоог

хүртэл

Иохан 16:1–3—“Та Нарыг Алах Хүн Бүр Өөрийгөө Бурханд Сйлчилж Байна Гэж Бодох Болно”

Ахлагч Брус Р.МакКонки, “Чин сэтгэл бол авралыг олоход бараг юу ч хийх хэрэггүй юм. Гэгээнтнүүдийг хөнөөдөг хүмүүс алагдаж зовж тарчлагдсан гэгээнтнүүдийн адил шударга, чин сэтгэлтэй байж болно. Худал хуурмагт тэгтлээ өөрсдийгөө зориулдаг хүмүүс үүнийхээ төлөө амь насаа ч зориулах болно. Бошиглогчдыг хөнөөсөн хүмүүс эрт дээр үеийнх ч байна уу, өнөөгийнх ч байна уу, ялгаагүй тэд Бурханд үйлчилж байна гэж бодож байсныг юу гэх вэ? Үнэнд тооцогддог тэр зүйл бол Бурханаас өгсөн цэвэр үнэн мөн” гэж бичжээ (*Doctrinal New Testament Commentary*, 1:752).

Иохан 16:33—“Би Ертөнцийг Ялсан”

“Христ дэлхийг—манай дэлхийг ялсан юм—тэгээд бидэнд өгсөн Түүний бэлэг бол одоо үед амар амгалан, ирэх дэлхий дэх өргөмжлөл мөн. Бидэнд тавигддаг үндсэн шаардлага бол Түүнд итгэх итгэл хийгээд Түүнийг цаг ямагт дагах явдал мөн. Түүний арга замаар, Түүний гэрлээр ярихыг Тэрбээр бидэнд санал болгох, Тэрбээр биднээс өмнө энэ замаар алхаж байсан учраас, Тэрээр

үүнийг ийшээ ирэх бидний аяллын хувьд аюулгүй болгосон билээ” гэж Ахлагч, Төлөөлөгч Жеффри Р.Холланд сургажээ (in *Conference Report*, 1997 оны 10-р сар, 89; *Ensign*, 1997 оны 11-р сар, 66).

Хэрэв бид Есүс Христийн заадаг зүйлүүдэд итгэлтэй байж, эцсээ хүртэл тэвчих аваас, бид ч бас дэлхийг ялах болно (С ба Г 63:47-г үз).

Судруудыг Судлах нь

Иохан 16-г судлахдаа А буюу Б үйл ажиллагааны аль нэгийг хий.

А Ерөндөг Тавь!

Ерөндөг бол ямар нэг муу юмны үр дагаврыг сулруулах буюу үүний эсрэг нөлөө үзүүлдэг зүйл юм. Жишээ нь, зарим нэг хорны үйлчилгээний эсрэг нөлөө үзүүлдэг ерөндөг тавьж болно. Ерөнхийлөгч Жорж Алберт Смит нэг удаа сургаж хэлэхдээ: “Их Эзэний сүнтэй хамтрагч байх нь сул дорой байдлын эсрэг, өлсөхийн эсрэг, айдсын эсрэг, түүнчлэн амьдралд биднийг сөгтгөдөг бүх зүйлийн эсрэг ерөндөг юм” (in *Conference Report*, 1945 оны 10-р сар, 115–16).

1. Иохан 16:1–4-т Их Эзэн юуны талаар шавь нараа сэрэмжлүүлсэн бэ?
2. Ариун Сүнс сүнсний бэрхшээлүүдийн хувьд хэрхэн сүнсний ерөндөг байж чадах вэ?
3. Ариун Сүнс амьдралд биднийг сөгтгөдөг муу зүйлүүдийн заримд нь хэрхэн ерөндөг байж чадах вэ?

Б Ээжтэй Ярилцлага Хий



1. Дараах асуултуудад хариулахад ээжийгээ (эсвэл ямар ч хамаагүй нэг ээжийг) урь.
 - а. Та дэлхийд хүүхэд төрүүлэхдээ ямар золиослол, тэмцэл хийгээд өвдөлт зовлонг амссан бэ?
 - б. Хүүхэд төрсний дараа танд ямар мэдрэмж төрж байсан бэ?
 - в. Дээрх золиослол, тэмцэл хийгээд өвдөлт зовлонд хандах таны хандлагад бодол санаа тань хэрхэн нөлөөлсөн бэ?
2. Төрөлт дэх тэмцлийг Есүс Иохан 16:19–22-т юутай харьцуулсныг, түүнчлэн амлагдсан баяр хөөр хэрхэн ирдгийг дүрсэл.
3. Аврагчийг дахин харахад ямар мэдрэмж төрнө гэж найддагаа дүрсэл.

Иохан 17

“Энэ Бол Мөнхийн Амь”

Тэрээр сүүлчийн удаа Гетсемани уруу явахынхаа яг өмнөхөн Есүс агуу Өмгөөллийн Залбирал гэж нэрлэгддэг зүйлийг өгсөн билээ. Үүнийг ингэж нэрлэсний учир бол үүнд Аврагч Өөрийн шавь нар түүнчлэн тэдний үгст итгэдэг бүх хүмүүсийн нэрийн өмнөөс төлөөлөн Өөрийн Эцэгт хандан залбирсан ажээ. Ерөнхийлөгч Давид О.МакКей, “Үүнээс илүү чухал бүлэг Библид байдгийг би мэдэхгүй” гэж гэрчилжээ (in Conference Report, 1967 оны 10-р сар, 5). Иохан 17-г уншиж, энэ нь Ерөнхийлөгч МакКейд яагаад ийм их ач холбогдолтойг тунгаан бод.

Судруудыг Ойлгох нь



Иохан 17

Ертөнцийг бүтээхээс өмнө, Илэрхийлсэн (ш.6)—
ертөнцийн сууриас өмнө Мэдүүлсэн
(ш.5, 24)—Дэлхий бүтээгдэ- Тэднийг ариусгах (ш.17,
хээс өмнө 19)—Тэднийг ариун болгох

Иохан 17:11–17—Та Нар Хэрхэн “Ертөнцийнх Биш”, Харин “Ертөнц Дээр” Байж Болох вэ?

Ахлагч, Төлөөлөгч Жозеф Б.Вортлин, “Магадгүй бид бүгдээрээ амьдралын шуургуанаас, бас Сатаны галт сумнуудаас өөрсдийгөө тусгаарлан холдуулахыг заримдаа хүсдэг. Гэсэн хэдий ч, бид дэлхийнх биш, харин дэлхий дээр байх ёстой, дэлхийнх гэдэг нь дэлхий дээр байдаг нүгэл, хилэнц хийгээд ялзал дундуур, гэхдээ эдгээрийг эсэргүүцэж, няцааж явна гэсэн үг” гэж хэлжээ (in Conference Report, Apr. 1993, 84; or *Ensign*, May 1993, 68).

Иохан 17:22—“Мөхлийн Хүү Хэн Бэ”?

Их Эзэн Өөрөөс нь урвасан Иудас Искариотыг ийнхүү хэлжээ. Мөхөл гэдэг нь Сатаны өөр нэг нэр юм (С ба Г 76:25–27-г үз). Хилэнцийг үйлдэхээр сонгодог хүн “чөтгөрийн хүүхэд болдог” (Алма 5:38–41).

Судруудыг Судлах нь



Иохан 17-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Төгс Эзэмших Судар—Иохан 17:3

Бурханы амьдардаг амьдралын хэлбэр болох мөнх амьдралыг олж авах нь Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн олонхийх нь бодол төлөвлөгөө юм.

1. Цорын ганц үнэн Бурханыг “мэдэх”, мөн ердөө л Түүнийг “тухай мэдэхийн” хоорондох ялгааг тайлбарла.
2. Та нар Иохан 17:3 болон 1 Иохан 2:3–6-г ишлэлээр нь харьцуулж болно. 1 Иохан 2:3–6 болон бусад судруудаас олж болох, бид Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүүтэй адилхан болж болох зарим арга замуудыг жагсаан бич.
3. Тэдэнтэй адилхан болох нь Тэднийг илүү сайн мэдэхэд бидэнд хэрхэн тусалж болохыг тайлбарла.

Б “Тэд Бүгдээрээ Нэг Байхын Тулд”

Иохан 17:9–11-ийг уншиж, Иохан 17:20–23-тай харьцуулан, дараах зүйлийг хий:

1. Ишлэл бүрээр, Есүс хэний төлөө залбирч, тэдний төлөө Тэрээр юу хүсч байсныг тодорхойл.
2. Сургаал ба Гэрээ 38:27-г уншиж, энэ нь Их Эзэний залбирлын ач холбогдол дээр юу нэмснийг хуваалц.
3. Сургаал ба Гэрээ 88:67–68-ыг уншиж, “бүхнээ зориулах” нь Их Эзэний залбиралд хэрхэн холбогдохыг тайлбарлаж, үүний улмаас амьдралд тань ирж болох адислалуудыг дүрсэл.

В Найзын Төлөөх Залбирал

Өөрсдийгөө шинэ хотод шилжиж ирлээ гэж бод. Хэдэн сарын дараа хамгийн дотнынхоо найз нарын нэгнээс нь та нар захидал хүлээн авчээ. Энэ хүн шинэ найз нартай болж, тохиромжгүй үйл ажиллагаануудад оролцох болжээ. Иохан 17:11–17 дахь Аврагчийн залбирлаас найзынхаа төлөө залбирах өөрсдийнхөө залбиралд оруулж болох, наад зах нь хоёр санааг жагсаан бич. Эдгээр санаанууд найзад тань хэрхэн тусалж болохыг тайлбарла.

Иохан 18

Есүсээс Урваж, Тэрээр Баривчлагдав

Иоханы цэдэг Гетсемани дахь Есүсийн зовлонгийн тухайд чимээгүй юм хэлээгүй л байдаг. Гэвч энэ нь Есүсийг баривчилсан, Түүнийг Пилатын өмнө шүүсэн болон Петрийн үгүйсгэлийн талаар чухал ойлголтууд өгдөг. Энэ бол бас Аннасын өмнө Есүсийг шүүснийг цэдэглэсэн цорын ганц сайн мэдээ юм (Иохан 18:19–24-ийг үз). Энэ нь хэдийгээр эрх чөлөө хийгээд амь нас нь Есүсээс авагдсан ч гэсэн, “өөр дээр нь ирэх бүх зүйлүүдийг” (Иохан 18:4) Тэрээр мэдэж байсан юм. Та нар Иоханы гэрчлэлийн сүүлчийн бүлгүүдийг уншихдаа, үйл явдлуудыг санаандаа зураглахыг хичээ. Өөрсдийгөө тэнд байсан гэж төсөөлөн бодоод, тэдгээрийг харснаар ямар бодол төрөх байсан тухайгаа бод.



Иохан 18-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Иохан 18:1–16—Матай 26:47–58; Марк 14:43–54; Лук 22:47–55

Иохан 18:17–18, 25–27—Матай 26:69–75; Марк 14:66–72;

Лук 22:56–62

Иохан 18:28–38—Матай 27:2, 11–14; Марк 15:1–5; Лук 23:1–7

Иохан 18:39–40—Матай 27:15–23; Марк 15:6–14; Лук 23:13–22

Судруудыг Ойлгох нь



Иохан 18

Цугладаг байв (ш.2, 20)—
Уулздаг байв

Дээр (ш.14)—Хэрэгтэй,
чухал

Хамаатан (ш.26)—Төрөл
садан

Тахиа (ш.27)—Азарган тахиа

Бузрыг үйлдэх (ш.30)—

Гэмт хэрэгтэн

Иохан 18:2–13—Есүсийг Баривчлуулахын Тулд Иудас Цэргийн Зэвсэгт Багийг Дагуулж Ирэв

Сайн мэдээнүүдийн бусад зохиогчид Есүсийг баривчлахаар “олон хүн” Гетсемани руу Иудасыг дагалдан ирснийг харуулдаг бол, ганцхан Иохан л энэ бол “цэргийн баг” байсныг цэдэглэжээ. Ахлагч Брус Р.МакКонки, “Баг нь цэргийн даргаар толгойлуулсан Ромын зургаан зуу орчим цэргээс бүрдсэн байлаа. Ромын захирагчид Дээгүүр Өнгөрсний Баярын долоо хоногийн үеэр үймээн самуун гарахаас болгоомжилж байв” гэж өгүүлжээ (*Doctrinal New Testament Commentary*, 1:781).

Иохан 18:39–40—Бараб

Лук 23:18-ын (х.85) “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз.

Судруудыг Судлах нь



Иохан 18-ыг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Сонины Сурвалжлага Бич


Та нар өөрсдийгөө орон нутгийн сонины сурвалжлагч гэж бодон Иохан 18:1–13-ыг унш. Дараах асуултуудыг удирдамж болгон ашиглаж, сонины өгүүлэл бич.

1. Уншигчдын анхаарлыг татахын тулд ямар гарчиг ашиглах вэ?
2. Ямар арга замаар Аврагч нөхцөл байдлыг хянаж байсан бэ?
3. Энэ үйл явдлын талаар уншигчдыгаа юу мэдээсэй гэж та нар хүсэх вэ?

Иохан 19

Есүс Христ Амиа Өгөв

Ромын цэргүүд үүргэнээр өргөст титэм сүлжиж Аврагчийн тэргүүн дээр өмсгөжээ. Тэд доог тохуу хийж, “Иудейчүүдийн Хааныг мэндчилье” гэж хашгирч байв. Ташуурдуулсан Их Эзэнийг Пилат Иудейчүүдийн удирдагчдад тэдний хаан мөн үү гэхэд тэд “Түүнийг тонилогло... Түүнийг Цовдол” хэмээн хашгиралдаж байв. Тийм ээ, “Хаадын Хаан, Эздийн Их Эзэн Есүс Христ” (Илчлэлт 19:16) дахин ирж, үхэл гашуудал, өвчин зовлонг үгүй болгох болно (Илчлэлт 21:4). Иохан 19-д цэдэглэгдсэн эмгэнэлт хийгээд зүрх шимширүүлэм үйл явдлуудыг та нар уншихдаа: Бурханы Хүү яагаад ийм доромжлол, шударга бус явдлыг хүлцэн тэвчих болов? Энэ нь Түүний хайрын тухай бидэнд заадаг уу? гэдгийг өөрсдөөсөө асуу.



Иохан 19-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Иохан 19:1–24—Матай 27:27–36; Марк 15:16–24; Лук 23:23–34

Иохан 19:28–30—Матай 27:46–49; Марк 15:34–37; Лук 23:46

Иохан 19:38–42—Матай 27:57–61; Марк 15:42–47; Лук 23:50–56

Судруудыг Ойлгох нь



Иохан 19

Сүлжээд (ш.2)—Томох, сүлжих

Зургадугаар цаг (ш.14)—
Үд дундын орчим

Гадуур хувцас (ш.23)—
Хүзүүнээс өвдөг хүртэл
урттай хувцас

Урах (ш.24)—Урах, тасдах
Шодох (ш.24)—Ялагчийг
тодруулдаг тоглоом маягаар
тодруулах

Хиссоп (ш.29)—Хиссоп гэдэг
нэртэй бутны урт гол буюу
мочир

Мирр, алое (ш.39)—Цогцсыг
оршуулахад бэлтгэхэд
Иудейчүүдийн ашигладаг
байсан халуун ногоонууд

Булш (ш.41–42)—
Хиргисүүр, эсвэл булш

Иохан 19:1—Пилат Есүсийг Ташуурдахыг Тушаав

Ахлагч Жеймс Е.Талмейж, “Ташуурдах нь загалмай дээрх үхлийн өмнөх айлгалт байв. Зодуурын хэрэгсэл нь үзүүрт нь төмөр, хурц үзүүртэй яс хийж хүндрүүлсэн, олон салаатай сур байжээ” гэж бичжээ (*Jesus the Christ*, 638).

Иохан 19:6–30—“Цовдол Түүнийг, Цовдол Түүнийг”

Ахлагч Жеймс Е.Талмейж, “Цовдлуулж үхэх нь цаазаар авах бүх хэлбэрүүдээс тарчилган зовоох нь хамгийн удаан үргэлжилдэг нь юм. Улам өсөн нэмэгддэг тарчилган зовоолтод хохирогчид ерөнхийдөө олон цагаар, заримдаа олон өдөр амьд байдаг байв. Гар, хөлийг нь цоо хатгасан том хадааснууд яс янгинам өвтгөж, мэдрэлийн тогтолцоог алдагдуулж, шөрмөсийг тасддаг хэдий ч үхэлд хүргэдэг шарх биш юм. Үхлийн тайтгарал нь биеийн хэвийн биш байрлалд биеийн эрхтнүүдийн үйл ажиллагааг хөвчрүүлэн, өвдөлтийг бүх биеэр тархааж, улмаар өвдөлтийг тэсэхийн аргагүйд хүргэснээр туйлдалт бий болж үхэл ирсэн байна” гэж тайлбарлажээ (*Jesus the Christ*, 655).

Иохан 19:31–37—“Тэдний Хөлийг Хугалахын Тулд”

Нар жаргах үед эхэлдэг байсан Иудейчүүдийн Хүндэтгэлийн өдөр ойртож байв. Цогцсыг Хүндэтгэлийн өдөр загалмайгаас буулгахыг, бас үүнийг Хүндэтгэлийн өдөр загалмай дээр байлгахыг ч Иудейн хууль зөвшөөрдөггүй байв. Иудейн удирдагчдын хүсэлтээр Ромын цэргүүд тэдний үхлийг түргэсэхийн тулд хулгайч нарын хөлийг хугалжээ. Есүс аль хэдийнэ үхчихсэн байв, тийнхүү “түүний нэг ч яс хугалагдахгүй” гэсэн судар гүйцэлджээ (Иохан 19:36; тэрчлэн бас Египетээс гарсан нь 12:46; Дуулал 34:20-ийг үз).

Судруудыг Судлах нь



Иохан 19-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Тэр Юу Хэлэх Вэ? Чи Юу Хэлэх Байсан Бэ?

Иохан 18:28–19:22 дахь үйл явдлуудаас хойш хэдэн жилийн дараа Пилаттай уулзах боломж чамд олджээ гэж бод.

1. Судруудад өөрсдийнхөө уншсан зүйлүүд дээр тулгуурлан, Есүсийн тухай, Түүний цовдлолтын тухай хэдэн жил

өнгөрсний дараа үүнийг эргэн хараад тэрээр юу гэж хэлэх байх гэж та нар бодож байна?

2. Иохан 18:38-д тэрээр Есүсээс асуусан тэр асуултаа чамаас асуувал, та нар юу гэж хариулах вэ?

Б Бусдыг Цаг Сргэлж Хайрлаж Сурах нь

1. Иохан 19:25–27-г уншиж, Аврагч загалмай дээр дүүжлэгдэж байхдаа Түүний санаа тавьж байсан зүйлүүдийн нэгийг дүрсэл.
2. Энэхүү үйлдэл Түүний амьдарч байсан амьдралыг хэрхэн тодорхойлдог вэ?



В Есүс Христийн Шавь Байх нь

Ариматын Иосеф, Никодем хоёул Иудейн удирдагчид мөн Санхедрин гэдэг байсан удирдах байгууллагын гишүүд байв. Хоёулаа нууцаар Есүсийн шавь байжээ.

1. Лук 23:50–51, Иохан 7:45–53-ыг уншиж, энэ хоёр хүн тус бүр өөрсдийнхөө шавь болохыг хэрхэн харуулсныг дүрсэл.
2. Шинэ булш хэнийх байсан бэ? (Матай 27:59–60-ыг унш).
3. Шавилах ёсны талаар та нар Иосеф, Никодем хоёроос юу сурч болох вэ?

Иохан 20

Есүс Христийн Амилуулалтанд Итгэхүй

Аврагчийн мөнх бус байдал дахь тохинуулал загалмай дээр дууссан юм, гэвч хоосон булш нь Түүний бурханлиг чанарыг гэрчилж амилуулалтын найдварыг бид бүгдэд өгсөн билээ. Есүс Христ амлуулагдсаны нотолгоо юу вэ? Түүнийг үхэгсдээс босч ирсэн гэдэгт итгэхийн тулд яагаад Түүнийг харах хэрэггүй гэж та нар боддог вэ? Энэ

бүлгийг судлахынхаа өмнө *Иоан 20:31* дэх *Иоханы гэрчлэлийг унш*.



Иоан 20-д Та Нарын Уншдаг Зүйлээрх Бусад Шастирууд

Иоан 20:1–2—Матай 28:1–8; Марк 16:1–8; Лук 24:1–9

Иоан 20:3–10—Лук 24:12

Иоан 20:19–23—Марк 16:14; Лук 24:36–48

Судруудыг Ойлгох нь



Иоан 20

Даавуу (ш.7)—Нас барсан хүний нүүрийг бүтээдэг даавуу

Долоо хоногийн эхний өдөр (ш.1, 19)—Ням Гараг
Уучлах (ш.1, 19)—Өршөөх, уучлах

Иоан 20:17—Түүний Цогцос Булшинд Байхад Их Эзэний Сүнс Хаана Байсан Бэ?

Амилуулагдсан Аврагч Магдалын Мариа дээр хүрч ирээд, “Би дээшээ Эцэгтээ хараахан очоогүй байна” гэж Тэрээр хэлжээ. Түүний цогцос булшинд байхад Их Эзэний Сүнс хаана байсан бэ? “Тэр явж, шорон дахь сүнснүүдэд номлосон юм” гэж Петр заасан байдаг (1 Петр 3:18–20). Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит 1918 оны Аравдугаар сарын 3-нд Петрийн шастирласан зүйлийг тунгаан боджээ. Тэрбээр Аврагчийн гурван өдрийн номлолын тухай илүү өргөн үзэл бодлыг үзэгдэлд хүлээн авсан байна (С ба Г 138-ыг үз).

Судруудыг Судлах нь




Иоан 20-ийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Их Эзэн Христ Босч Ирэв

Есүс Христ амилуулагдсан гэдгийг бид хэрхэн мэдэж болох вэ? Амилуулалтын талаарх мэдлэгийн гурван түвшнийг Иоан 20-д цэдэглэсэн байдаг. Доорх ишлэлүүдийг уншиж, мөн дагалдах асуултуудад хариулах замаар эдгээр төвшнүүдийг ол.

1. Иоан 20:1–10-ыг унш. Эдгээр шүлгүүд Амилуулалтын талаар ямар нотолгоо өгч байна вэ? Хоосон булш хэрхэн нотолгоо болох вэ? Хоосон булш Магдалын Мариа, Петр хийгээд “өөр нэг шавийг” (Иоан) итгэхэд хэрхэн нөлөөлсөн бэ?
2. Магдалын Мариад ямар шинэ нотолгоо өгөгдсөн бэ? (ш.11–18-ыг үз). Энэ туршлага Аврагчийн Амилуулалтын талаарх Мариагийн итгэлд хэрхэн нөлөөлсөн бэ?
3. Иоан 20:19–20-д өгүүлснээр, Их Эзэн арван Төлөөлөгчид үзэгдсэний дараа, Их Эзэнийг харсан хэмээх тэдний түүхэнд тэрээр итгэхийнхээ өмнө Томас юу шаардсан бэ? Амилуулалтын талаар ямар шинэ нотолгоог Томас хүлээж авсан бэ? Амилуулалтад итгэх талаар ямар чухал зарчмыг Их Эзэн Томаст заасан бэ?

Есүс амилуулагдсан гэдгийг та нар хэрхэн мэдэж болох вэ? Есүс Христийн Амилуулалтын тухай гэрчлэлээ бич.



Иоан 21

Их Эзэний Ажлыг Үргэлжлүүл

Иоан өөрийн Сайн мэдээг төгсгөхдөө, түүний бичсэн зүйл үнэн гэдгийг гэрчлээд, хэрэв Есүсийн хийсэн бүхнийг бичих юм бол, “бичигдсэн номнууд нь энэ ертөнцөд багтахгүй байх байсан” гэдгийг харуулжээ (Иоан 21:25). Иоан 21-ийг уншихдаа, та нар яагаад Иоан Есүс Христийн тухай өөрийн гэрчлэлээ төгсгөхөд эдгээр түүхүүдийг сонгосныг бодож үзнэ үү.

Судруудыг Ойлгох нь



Иохан 21

Харуулжээ (ш.1, 14)—
Үзүүлжээ

Тибер тэнгис (ш.1)—
Галилын тэнгис

Та нарт ямар ч загас алга
уу? (ш.5)—Та нарт идэх юм
бий юу?

Өмсөж (ш.7)—Өмсөөд

Тайлсан (ш.7)—Зөвхөн
дотуур хувцас өмссөн

Хоёр зуун тохой (ш.8)—
Ойролцоогоор нэг зуун ярд
(91 метр)

Бүсээ бүсэлж (ш.18)—
Хувцаслаж

Байлгах (ш.22–23)—Үлдээх,
үлдэх

Иохан 21:18–19—Петрийн Схлийн Хэлбэрийг Их Эзэн Бошиглов

Есүс Христ Өөрийгөө амьдралд дагахад Петрийг урьсан юм (Матай 4:18–20-ийг үз). Ам дамжсан яриагаар бол, Петр Аврагчийн тухай гуйвшгүй гэрчлэлийнхээ улмаас хожим нь Ром хотод цовдлуулжээ.

Иохан 21:20–23—Хайрт Иоханд Юу Тохиолдсон Бэ?

Тэрээр Хоёр дахь Ирэлтийг хүртэл бодгалиудыг авчрахын тулд дэлхий дээр үлдэж болох уу хэмээн Хайрт Иохан Их Эзэнээс асуусныг бид илчлэлтээр мэдэх билээ (С ба Г 7-г үз). Тэрээр Өөрийнхөө хүслийг дэлхий дээр гүйцэлдүүлэхийн тулд зөөгдсөн юм. 3 Нифай 28:7–22-ыг уншсанаар та нар зөөгдсөн хүмүүн биетүүдийн мөн чанарын тухай илүү ихийг мэдэж болно.

Судруудыг Судлах нь



Иохан 21-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Загасчлахаар Явцгаая



Петр болон бусад Төлөөлөгчдийн зарим нь ажил мэргэжлийн хувьд загасчид байлаа. Тэднийг Галилын тэнгис дээр загасчилж байхад амилуулагдсан Их Эзэн тэдэнд дээр хүрч иржээ. Иохан 21:3–11-ийг Лук 5:4–11-тэй харьцуулж, дараах асуултуудад хариул:

1. Тэд өөрсдөө шөножингөө хэдий хэр их загас барьсан бэ?

2. Тэд Есүсийн чиглүүллийг дагаснаар хэдий хэмжээний загас барьсан бэ?

3. Их Эзэн та нараас хүсдэг зүйлийг хийснээр амьдралд тань ямар адислалууд ирж болох вэ?

4. Петр эрэг рүү сэлэхээр сонгосон тухайд та нар юу мэдэж авдаг вэ?

Б Загасчинаас Хоньчин

1. Иохан 21:15 дахь *тэднээс* гэдэг үгээр Их Эзэн хэнийг хэлсэн бэ?

2. Петрийн тэжээх ёстой хурганууд болон хонинууд хэн байсан бэ? (ш.15–17-г үз).

3. Есүс нэг л асуултыг яагаад Петрээс гурван удаа асуусан байж болох вэ? (Матай 26:69–75-ыг үз).

4. Энэ чухал сургамжийг Петр Аврагчаас хэр сайн сурсан бэ? (1 Петр 5:1–4-ийг үз).

5. Өөрийн тохинууллын эхэнд Эзэн жинхэнэ хоньчдын тухай Петр болон Арванхоёр Төлөөлөгчид заасан байдаг. “Би бол сайн хоньчин, мөн би хонинуудаа мэднэ. . . Би хонинуудынхаа төлөө амиа өгнө” гэж Тэрбээр хэлжээ (Иохан 10:14–15). Иохан 21:18–19-ийг уншиж, Жинхэнэ Хоньчны үлгэр жишээг Петр хэрхэн дагасан тухай ярь. Их Эзэний хурганууд болон хонинуудад хоньчин байхын тулд та нар өөрсдийн амийг бэлэгдлийн байдлаар хэрхэн өгч болох вэ?



Үйлсийн Номыг Хэн Бичсэн Бэ?

Үйлсийн номыг Паултай хамт түүний номлолын аяллуудад явсан шавь, Лук бичжээ.

Энэ Ном Сайн Мэдээнүүдээс Юугаараа Ялгаатай Вэ?

Үйлсийн ном бол Лукийн Сайн Мэдээнд түүний эхэлсэн цэдгийн үргэлжлэл юм. Лукийн Сайн Мэдээ бол Есүс Христийн амьдралын тухай түүний шастир юм; Үйлсийн ном бол “Иерусалимаас эхлээд бүх үндэстний дунд түүний нэрээр” (Лук 24:47) сайн мэдээг номлуулахаар Өөрийн Төлөөлөгчдөд Есүсийн өгсөн зарлигийг хэрэгжүүлсэн тухай өгүүлэмж юм. Энэ хоёр ном аль аль нь Лукийн найз Теофилд зориулагджээ (Лук 1:1–3; Үйлс 1:1–3).

Үйлсийн ном бол Аврагчийг Дээшлэн Одсоны дараа Сүмд тохиолдсон бүх зүйлийн тухай бүрэн цэдэг биш. Лук ихэвчлэн Төлөөлөгч Паулын тохинууллын тухай бичиж, Петр хийгээд бусад Төлөөлөгчдийн тухай цөөн хэдхэн цэдгийг оруулжээ. Үйлс бол болсон явдлыг өгүүлдэг, Шинэ Гэрээний сүүлчийн ном юм; номнуудын үлдсэн хэсэг нь захидлууд болон тэр үеийн үзэгдлүүд билээ.

Паулын Тохинуулал Хэзээ Болсон Бэ?

Үйлсийн ном нь Есүс Христийн Амилуулалтын дараахнаас эхэлж, МЭ 60 онд Паулыг Ромд хоригдож байхад дууссан Паулын тохинууллын тухай ихэвчлэн өгүүлдэг.

Паул Хаашаа Аялсан Бэ?

Дагалдах газрын зураг Паулын үеийн тухай зарим сонирхолтой баримтуудыг өгүүлдэг. Үүнийг орчин үеийн газрын зурагтай харьцуулж эдгээр орнуудын одоогийн нэрийг мэд.



Үйлс 1

Есүс Христ Тэнгэрт Дээшлэн Одов

Сэтгэл догдлуулам мэдээг хэн нэгэнд ярихаар та нар хэзээ нэгэн цагт хүнд бичиж байсан уу? Есүс Христ үхэгсдээс босч ирэн тэнгэрт дээшлэн одсон (буцсан) тухай—дэлхий хэзээ ч сонсож дуулаагүй хамгийн агуу мэдээг өөрийн найз Теофилд дуулаахыг хүсчээ. Аврагч Өөрийн Хоёр дахь Ирэлтийн өмнө сайн мэдээг бүх дэлхийд хүргэх дуудлагыг Төлөөлөгчдөд хэрхэн өгснийг Лук дүрсэлсэн байдаг. Түүнийг тэнгэрт дээшлэн одсоны дараа, ирээдүйн нэгэн өдөр Тэрээр алдар сууд эргэн ирэх болно гэдгийг тэнгэр элчүүд Төлөөлөгчдөд амлажээ. Сайн Мэдээг дэлгэрүүлэх Их Эзэний дуудлагыг Төлөөлөгчид хүлээн авч, Искаротын Иудасын оронд Маттиаг шинэ Төлөөлөгчөөр томилсон билээ. Лукаас ийм мэдээ хүлээж аваад Теофилд ямар санагдсан байж болохыг төсөөлөн бод.



Судруудыг Ойлгох нь



Үйлс 1

Номонд (ш.1)—Бичиглэсэн,	Нэг санаагаар (ш.14)—Эв
бичгээр үйлдсэн	нэгдэлд
Маргашгүй (ш.3)—Буруу	Залбиралд (ш.14)—Асууж
байх аргагүй	

Сйлс 1:18—Сйлсийн Номны Тойм

“Иерусалимд, мөн бүх Иудейд, бас Самарид байтугай энэ дэлхийн хязгаар хүртэл” Түүнийг гэрчлэх гэрчүүд байх зарлигийг Есүс Өөрийн Төлөөлөгчдөд өгсөн нь Үйлсийн номны тоймын загвар юм. Үйлс 1–7 нь Иерусалим дахь

номлолыг цэдэглэдэг, Үйлс 8–9 нь сайн мэдээг Иудей, Самарид дэлгэрүүлснийг, Үйлс 10–28 нь “энэ дэлхийн хязгаар хүртэл” сайн мэдээ хэрхэн аваачигдаж эхэлсэн тухай өгүүлдэг. Үйлсийг уншихдаа энэ загварыг санаж бай.



Сйлс 1:18—Иудас Хэрхэн Схсэн Бэ?

Матай 27: 5 болон Үйлс 1:18 нь Иудас хэрхэн үхсэн тухайд Матай, Лук хоёр санал нийлдэггүй гэсэн сэтгэгдэл төрүүлдэг.

Сйлс 1:26—Шавга Гэж Юу Вэ?

Шавга хаях гэдэг нь өнөөдрийн сугалаа сугалахтай адил төстэй үйл юм. Гэсэн хэдий ч, Төлөөлөгчид шинэ Төлөөлөгчийг сонгоход таамгаар хандаагүй юм. Энэ бол өнгөрсөн үед Тэрбээр Өөрийн хүслийг тэдэнд илчлэх арга болгон ашиглахыг тэдэнд зарлигласан арга байлаа (Левит 16:7–8-ыг үз).

Судруудыг Судлах нь

Үйлс 1-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Төлөөлөгчдөд Өгсөн Сүрэг Даалгавар

Үйлс 1:1–8-ыг нэгтгэн дүгнэж, дараах асуултуудад тэмдэглэлийн дэвтэртээ хариул:

1. Есүс Амилуулалтынхаа дараа Өөрийн Төлөөлөгчидтэй хэр зэрэг удаан уулзсан бэ?
2. Тэр тэдэнд юу заасан бэ?
3. Тэд яагаад Иерусалимд үлдэх ёстой байсан бэ?
4. Хоёр дахь Ирэлтээр Израилыг сэргээх тухай тэд юу мэдэж авсан бэ?
5. Ариун Сүнснийг хүлээн авсны дараа юу хийхийг Есүс тэдэнд зарлигласан бэ?

Дээрх “Судруудыг Ойлгох нь” хэсэг дэх “Үйлсийн Номны Тойм” дахь мэдээллийг ашиглан, шүлэг 8-аас хойших Үйлсийн номны тоймыг судруудынхаа зах дээр бич.

Б Шинэ Төлөөлөгч Сонгогдов

Үйлс 1:13–26 дахь, Төлөөлөгчид Иудасын оронд шинэ Төлөөлөгч дуудсан тухай шастирыг нэгтгэн дүгнэж, тэд хэрхэн “томилсон”, “залбирсан”, хийгээд “шавга орхисныг” ажигла. Болсон явдлыг нэгтгэн дүгнэхийн тулд эдгээр түлхүүр санаанууд тус бүрийн тухай нэг буюу хоёр өгүүлбэр бич.

Үйлс 2

Гэрчлэлийн Өдөр

Таны хувьд онцгой дурсамжийг эргэн санагдуулдаг тийм баяр байдаг уу? Төлөөлөгчдийн хувьд, Иудейн Пентекостын баяр ийм дурсамжийн баяр болсон байлаа. Есүс Христийн Амилуулалтын дараах Пентекостын баярын үеэр Төлөөлөгчид Ариун Сүнсний илэрхийллийн гайхамшигт турлилагатай болсон ажээ. Үзэж байсан хүмүүс өөрсдийнхөө харсан зүйлийг “бүгдээр гайхан алмайрч, гайхан биширч байлаа” (Үйлс 2:7). Төлөөлөгчид Ариун Сүнсээр дамжуулан Иерусалимд олон өөр газраас ирсэн Иудейчүүдэд, тэр ч байтугай тэд олон өөр хэлээр ярьдаг ч гэсэн, сайн мэдээг номлох боломжтой байжээ. Энэ бол Сүнс бүх хүмүүст адислал болон ирэх тухай Иоел 2:28–32-т байдаг бошиглоглын гүйцэлдэлт байлаа хэмээн Петр тайлбарлажээ. Тэр өдөр тэрбээр Есүс бол Христ мөн гэдгийг хүмүүст гэрчилж, сонсож байсан хүмүүсийг баптисм хүртэхэд урьсан ажээ. Гурван мянган орчим хүмүүс урилгыг хүлээн авч, Сүмд баптисм хүртсэн байлаа.



Судруудыг Ойлгох нь

Үйлс 2

Пентекост (ш.1)—Ургацын зуны баяр

Хаялах (ш.3)—Хуваагдах

Ярих (ш.4)—Ярих чадвар

Гайхжээ (ш.6)—Учрыг олохгүй байв

Шинэ сүсэгтнүүд (ш.10)—Хөрвөгчид, шинэ гишүүд

Урьдаас тогтоосон төлөвлөгөө (ш.23)—Тогтоосон зорилго

Ялзрал (ш.27)—Доройтол, ялзрал

Хөндсөнд (ш.37)—Хүрэх, гэмшил төрөх

Сйлс 2:1–4—Пентекостын Өдөр Юу Тохилдсон Бэ?

Дээгүүр Өнгөрсний Баярын дараа тавь хоноод, зуны эрт ургацын баяр Пентекостын Баярыг тэмдэглэдэг байв. Энэ

баярын найр болон тэмдэглэх үйл ажиллагаанд оролцохоор үй олон хүн Иерусалимд ирдэг байжээ. Итгэгчид энэ өдөр хамтдаа цуглахад Их Эзэн тэнгэрт дээшлэн одохынхоо өмнө амласныхаа дагуу Ариун Сүнсийг илгээдэг байв (Үйлс 1:4-8-ыг үз).

Энэ хүчийг хүлээн авсны дараа Есүс Христийн тухай цугласан олонд ярихад Төлөөлөгчид эргэлзсэнгүй. Пентекостын гайхамшиг нь Ариун Сүнс Төлөөлөгчдөд хэлний бэлэг өгдөгт байлаа (С ба Г 46:11, 24-ийг үз). Сүнс тэдэнд төрөлх хэлээрээ ойлгоход нь тусалж байсан учир сонссон бүх хүмүүс номлогдсон зүйлийг ойлгох боломжтой байв. Энэхүү агуу үйл явдал гурван мянга орчим шинэ гишүүдийг Сүмд авчирчээ.

Сйлс 2:44—“Байгаа Бүхнээ Нийтээрээ”

Байгаа бүхнээ нийтээрээ эзэмших нь бүх Гэгээнтнүүд өөрсөддөө байгаа юмыг тэдний дундах ядуустай хуваалцахаар тийм хайр хийгээд эв нэгдэл Сүмд байх ёстой гэсэн үг юм. Энэ бол “өргөл” хэмээн нэрлэгддэг сайн мэдээний нэг зарчим юм (С ба Г 42:30-39). Ахлагч Брус Р.МакКонки, “Өргөлийн хууль бол манай үед бид өөрсдийн авьяас чадвар, мөн өөрсдийн мөнгө хийгээд өмч хөрөнгийг Сүмийн зорилгын тулд өргөл болгон барьж байгаа [онцгойлон өргөх буюу өргөн барих] явдал мөн; эдгээр нь дэлхий дээр Их Эзэний сонирхлуудад түлхэц үзүүлэхэд шаардлагатай байгаа тохиолдолд бэлэн байх ёстой” гэж өргөлийг дүрсэлжээ (in Conference Report, 1975 оны Дөрөвдүгээр сар, 74; эсвэл *Ensign*, 1975 оны Тавдугаар сар, 50).

Өргөл бол сэлэстиэл хаант улсын хувьд зохистой байхаар амьдрахын тулд Гэгээнтнүүдийн сурах ёстой зарчмуудын нэг юм (С ба Г 105:3-5-ыг үз).

Өнөөдөр бид аравны нэгээ төлөх тэрчлэн гачигдалтай хүмүүст тусалдаг бусад өргөлүүдийг төлөх хүсэлтэй байгаагаараа өргөлийн хуулийн дагуу амьдрахад бэлтгэж байгаа юм.

Судруудыг Судлах нь

Үйлс 2-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А-Г) хоёрыг нь хий.

А Сонины Сурвалжлагч Бол

Пентекостын өдрийн үйл явдлууд гайхамшигтай байлаа. Үйлс 2:1-16-д дүрслэгдсэн үйл явдлуудыг та нар сонины сурвалжлагчийн хувиар үзэж байна гэж бод. Оройн сонинд зориулж, уг үйл явдалд ямар хүмүүс оролцсон хийгээд юу болсныг дүрсэлсэн өгүүлэл бич.

Б Бошиглолын Гүйцэлдэлт

Үйлс 2:6-21-ийг нэгтгэн дүгнэж, дараах асуултуудад хариул:

1. Төлөөлөгчдийг сонсож байсан зарим хүмүүс яагаад тэднийг халамцуу байна гэж бодсоныг та нар юу гэж боддог вэ?
2. Тэдний төрх байдлын талаар Петр ямар тайлбар өгсөн бэ?
3. Иоел 2:28-32 дахь бошиглол гүйцэлдэхийн тулд Төлөөлөгчид юу хийсэн бэ?

4. Иоелын бошиглол дахиад хэзээ гүйцэлдэх вэ? (Иосеф Смит—Түүх 1:41-ийг үз).

Өөрсдийн тань амьдралд Ариун Сүнс бялхан ирснийг мэдэрсэн үеийнхээ тухай бич.

В Петрт Гарсан Өөрчлөлт

1. Үйлс 2:22-36 дахь Петрийн үйл ажиллагаануудыг Иохан 18:25-27 дахь үйл ажиллагаануудтай харьцуул. Тэрээр хэрхэн өөрчлөгдсөн хийгээд өөрчлөлтөд юу шалтгаалсан гэж боддогоо ярь.



2. Пентекостын тэрхүү үйл явдлууд Үйлс 1:4-5, 8 дахь Их Эзэний амлалтыг хэрхэн гүйцэлдүүлж эхэлсэн бэ?
3. Есүс Христийн тухай Петрийн зоримог гэрчлэлийг унш. Өөрсдийн тань хувьд хамгийн чухал ач холбогдолтой хоёр санааг түүний гэрчлэлээс сонгож аван, яагаад гэдгийг тайлбарла.

Г “Бид Одоо Яах вэ?”

Петрийг сонсож, Христийн тухай түүний гэрчлэлд итгэсэн олон хүмүүс, тэд юу хийх ёстойг асуужээ. Наманчилж, баптисм хүрт хэмээн Петр тэдэнд хэлэв. Тэр өдөр гурван мянга орчим хүн Сүмд нэгджээ.

Сүмд сонирхлоо илэрхийлсэн нэг найз чамд бий гэж бод. Бид Есүс Христийг хэрхэн, мөн яагаад дагах ёстойг, түүнчлэн бид хэрхэн Түүний Сүмийн гишүүн болсныг ойлгоход нь найздаа туслахын тулд захиа бич. Үйлс 2:37-40-д Петрийн хэлсэн зүйлийг захидалдаа ашиглаж, өөрсдийн үгээр оруул.

Үйлс 3

Петр Наманчлалыг Зоригтойгоор Номлов

Үйлс 3 нь Петр, Иохан хоёр өөрсдөд нь Есүсийн өгсөн хүчийг батлан харуулсан нэг гайхамшигийг үйлдсэн тухай өгүүлдэг. Петр ариун сүмийн хаалганы дэргэд гуйлга гуйж байсан тахир дутуу хүнд туслахаар, санваарыг ашиглан түүнийг эдгээхийн тулд зогсчээ. Эдгэрсэн тэр хүнийг

харахаар цугласан хүмүүст Петрийн зоримгоор тунхагласан зүйлийг ажигла.

Судруудыг Ойлгох нь



Үйлс 3

Есдүгээр цаг (ш.1)—15 цаг орчим

Төрөлхийн хазгар (ш.2)—Төрснөөсөө хойш явж чадахгүй байгаа

Гуйлга (ш.2)—Ядууст туслах өглөг

Мэдэхгүйн харгайгаар (ш.17)—Үнэнийг мэдэхгүйн улмаас

Сэргээх цаг (ш.19)—Христийн Хоёр дахь Ирэлт

Салахын тулд (ш.19)—Ангижрах, уучлах

Бүхнийг сэргээх (ш.21)—Хожмын үед сайн мэдээг сэргээх

Сйлс 3:19–21—Сэргээлтийн Тухай Петр Гэрчлэв

Ерөнхийлөгч Иосеф Фийлдинг Смит, “Бүх зүйлийн сэргээлт тэдний өдөр буюу тэдний үед болохгүй, мөн ‘Эцэг Өөрийн эрх мэдлээрээ тогтоосон тэр цаг, үеийг мэдэх нь’ [Үйлс 1:7] та нарын хэрэг биш гэдгийг Их Эзэн тэнгэрт дээшлэн одохынхоо өмнө төлөөлөгчдөд үзүүлсэн билээ. Сайн мэдээний өөр эрин үе тэдний амьдарч байсан эрин үеийг залгаахаар ирэх ёстой гэдгийг, түүнчлэн Бурханы Хүүгийн Хоёр дахь Ирэлтийн өмнөхөн, бүх ариун бошиглогчдоор хэлэгдсэн бүх зүйлийн сэргээлтэд хүн төрөлхтөн хийгээд газар дэлхийг бэлтгэхийн тулд энэхүү төгсгөлийн эрин үе өгөгдөх ёстой гэдгийг Петр, Паул хоёр өөрсдийн заасан зүйлүүдэд нэн тодорхой харуулсан юм [Үйлс 3:21-ийг үз]” гэж хэлжээ (Doctrines of Salvation, 1:164).

Судруудыг Судлах нь



Үйлс 3-ыг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Петр Хазгар Гуйлгачинг Эдгээв

Үйлс 3:1–11-д Петр хазгар гуйлгачинг эдгээсэн тухай болсон явдлыг нэгтгэн дүгнэж, дараах асуултуудад хариул:

1. Хазгар хүн яаж ариун сүм рүү хүрч очсон бэ?
2. Петр, Иохан хоёроос тэр юу хүссэн бэ?



3. Оронд нь Петрийн түүнд өгсөн бэлгийн талаар тэр юу гэж бодсон бэ?
4. Хазгар хүн мөнгө гуйсан ч оронд нь хүч чадал өгөгджээ. Их Эзэн та нарын хүсэлтэд заримдаа хариулдаг арга замтай энэ нь хэр зэрэг адилхан бэ?


Б Илүү Дээд Хүчний Тухай Петр Гэрчлэв

Үйлс 3:12–26-г судалж, Иудейчүүдэд хэлсэн Петрийн гэрчлэл дэх хамгийн чухал нь гэж өөрсдийн боддог таван өгүүлбэрийг сонго.

Үйлс 4

Петр, Иохан Хоёр Баривчлагдав

Есүсийг гайхамигууд үйлдэхэд Иудейчүүдийн удирдагчид хичнээн их уурлаж байсныг та нар санаж байна уу? Төлөөлөгчид Есүсийн нэрээр гайхамигуудыг үйлдэж эхлэхэд тэдэнд ямар санагдаж байсныг төсөөлөн бод. Та нар Үйлс 4-ийг уншихдаа, Петр хичнээн зоригтой болсныг эрж хай. Түүнчлэн Иудейчүүдийн удирдагчид яагаад Есүс Христийн тухай гэрчлэлээ хэлэхээс нь Петр болон бусад Төлөөлөгчдийг болиулахаар тийм их шийдэмгий байсан тухай бод.



Судруудыг Ойлгох нь



Үйлс 4

Төвөгшөөж байлаа (ш.2)—Дуртай биш байлаа

Удмынхан (ш.6)—Төрөл төрөгсөд

Өвчтэй (ш.9)—Хазгар

Зөвлөлдөн (ш.15)—Ярилцан

Бялхам их нигүүлсэл (ш.33)—Тэнгэрээс ирдэг хүч

Сйлс 4:1–3—Тахилчид болон Садукайчууд Яагаад Ууртай Байсан Бэ?

Аннас, Каиаф мэтийн хүмүүс бол ариун сүмийг хянадаг бүлэг Садукайчууд байлаа. Тэд Амилуулалтад хийгээд Христийн Амилуулалтын тухай Петрийн зааж байсан зүйлүүдэд итгэдэггүй байжээ. Тэд Иудейчүүдийн удирдагчид болон ромчуудтай хамтран Түүний сургаалуудын учир Христийг цовдолсон бөгөөд энэ нь Христэд итгэн



Фарисайчууд



Садукайчууд

бишрэх явдлыг төгсгөл болгоно гэж бодож байжээ. Төлөөлөгчид Есүс Христийн сайн мэдээг заах явдлыг үргэлжлүүхэд тахилчид, Садукайчууд болон бусад олон бүлэг хүмүүс ихэд уурладаг байв.

2. Өөрсдийн бүхнээ зориулсан байдал хийгээд итгэлийн учир тэдгээр хүмүүс ямар адислалуудыг хүртэж байсан бэ?
3. Гэгээнтнүүдийн хандивласан мөнгө болон эд хөрөнгийг тарааж өгөх үүрэг хэнд байсан бэ?
4. Өргөлийн хуулийн дагуу амьдрахад бэлтгэхэд бидэнд тусалж чадах ямар зүйлийг бид өнөөдөр Сүмд хийдэг вэ?
5. Хэрэв танай бүс дэх Сүмийн гишүүдийг энэ арга замаар амьдрахад уриалан дуудвал та нарт ямар санагдах вэ?

Үйлс 5

Шоронгоос Суллагдав

Судруудыг Судлах нь

Үйлс 4-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудын (А–В) нэгийг нь хий.

А Эдгээсний Болон Заасны Учир Төлөөлөгчид Баривчлагдав

Петр, Иохан хоёр хазгар хүнийг эдгээж байхад (Үйлс 3:1–11-ийг үз), мөн тэднийг баривчлагдаж байхад (Үйлс 4:1–30-ийг үз) өөрсдийгөө тэдэнтэй хамт байсан гэж төсөөлөн бод. Болсон явдлын талаар сонсоогүй нэг найз тань өөр хотод байдаг байжээ гэж бод. Тэр найздаа захидал бичиж, үүнийг тайлбарлахыг хичээ. Дараах тодорхой зүйлүүдийг оруулахад анхаар:

- Эдгэрсэн хазгар хүний нас
- Тахилчид болон Садукайчууд яагаад тэгтлээ их ууртай байсан бэ?
- Петрээс асуусан ахлах тахилчийн асуулт
- Энэ шүүх хурлыг Петр яаж давсан бэ
- Петр, Иохан хоёрт юу хийхийг тэд хэлсэн болон Төлөөлөгчид хэрхэн хариулсан бэ
- Болсон явдлын талаар та нарт ямар сэтгэгдэл төрсөн бэ

Б Өөрсдийн Сгээр

Энэ түүнийг үхэлд хүргэж болно гэдгийг Петр мэдэж байсан ч гэсэн, тэрээр Есүс Христийн тухай хүчирхэг гэрчлэл хэлж байжээ. Үйлс 4:8–12-ыг дахин уншихдаа Петрийн жинхэнэ утгыг хэвээр хадгалахад анхаар.

В Тэдний Дунд “Бүх Юм нь Нийтийнх” Байв

Үйлс 4:31–37-гоос Сүмийн эхэн үеийн амьдралыг харж болно. Гишүүд “нэг зүрх сэтгэлтэй: . . . тэдний бүх юм нийтийнх байв” (Үйлс 4:32; мөн Үйлс 2:42–47; Үйлс 2:44-ийн “Судруудыг Ойлгох нь, х.110 болон х.112-ыг үз.)” Үйлс 4:31–37-г уншиж, тэмдэглэлийн дэвтэртээ дараах асуултуудад хариул:

1. Өөрсөдөө байсан бүхнийг бие биентэйгээ хуваалцах явдлыг тэдэнд боломжтой болгосон ямар чанарууд анхны Гэгээнтнүүдэд байсан бэ?

Амьдрал хүнд сорилтуудаар дүүрэн байдгийг та нар ажигласан уу? Ёс бусчуудад гай зовлон тохиоход бид гайхдаггүй, гэвч зөв шударга хүмүүс ч бас хүнд сорилтууд болон уруу таталтыг тэсэн гарах ёстой гэдгийг тэдэнд сануулсан байдаг билээ (Үйлс 14:22; Иаков 1:12-ыг үз). Эдгээр хүнд сорилтуудыг даван туулах нь зөв шударга хүмүүсийн өргөмжлөлд нөлөөлдөг (Алма 36:3-ийг үз).

Үйлс 5 нь энэ зарчмын сайн зураглалыг агуулдаг. Хэрэв тэд үнэнийг өргөсөөр байх юм бол тэд агуу их бэрхшээлтэй тулгаргах юм байна гэдгийг Төлөөлөгчид мэдэж байлаа. Гэвч тэдэнд тохиолдсон зүйлийг, зөвийг хийхийг сонгоогүй Ананиа, Сапфир нарт тохиолдсон зүйлтэй харьцуул.

Судруудыг Ойлгох нь

Үйлс 5

Бүрэн мэдэж байв (ш.2)— Мэдэж байснаас

Сэтгэлд төрөх (ш.4)— Бодогдох

Ороогоод (ш.6)—Түүний үхсэн биеийг даавуугаар боогоод

Атаархал (ш.17)— Дургүйцэл, атаа жөтөө

Харуулууд хаалганы дэргэд зогсож байв (ш.23)— Харуулууд гадаа зогсож байв

Үүнээс үүдэн юу болж болох талаар будилж орхив (ш.24)—Яагаад ийм юм болдог билээ гэж гайхаж хоцров

Болгоомжтой хандацгаая (ш.35)—Анхааралтай бодоцгоо

Алга болцгоосон, нурж унах болно (ш.36, 38)—юунд ч хүрэхгүй

Судруудыг Судлах нь

Үйлс 5-ыг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Төлөөлөгчид Дахиад Шоронд!


Үйлс 5:12–32 дахь Төлөөлөгчид дахиад шоронд орж байгаа тухай болсон явдалд зориулсан сонины байж болох толгой гарчгуудыг та нар дор олох болно. Толгой гарчиг бүрийг болсон явдалтай харьцуулж, толгой гарчиг бүрийн утгыг тайлбарласан нэг буюу хоёр өгүүлбэр бич.

1. Эдгэрэхийн Төлөө Түмэн Олон Цугларав (ш.16-г үз)
2. Гэмгүй Хүмүүс Шоронд (ш.18-ыг үз)
3. Шоронгоос Гайхамшигтайгаар Оргосон нь (ш.22-ыг үз)
4. Христэд Итгэгчид Дээд Тахилчийг Эсэргүүцэв (ш.29-ийг үз)

Б Тэр Юун Тухай Бодож Байв?

Үйлс 5:34–42-ыг нэгтгэн дүгнэ. Өөрсдийгөө Петртэй хамт байсан гэж бодоод тэмдэглэлийнхээ дэвтэрт нэг тэмдэглэл бич. Зөвлөлийн, ялангуяа Гамалиелийн үйл ажиллагааны тухай мэдээлж, Гамалиелийг ямар утгатай гэж бодож байгаагаа тайлбарла.

Үйлс 6–7 Стефений Үхэл



Үйлс 5-д та нар “түүний [Есүсийн] нэрийн төлөө доромжлогдон зовох нь зохистой гэж үзэгдэх болсондоо тэд баярлалдаж” байсан шавь нарын тухай унидаг (Үйлс 5:41). Үйлс 6–7-д, итгэлийнхээ төлөө үхэхээс

айгаагүй анхны шавь нарын нэгний тухай та нар унших болно. Стефен үнэний тухай туйлын зоригтойгоор гэрчилсэн учир ёс бус хүмүүс түүнийг үхтэл нь чулуугаар цохьжээ. Та нар эдгээр шүлгүүдийг уншихдаа Стефен гэж хэн байсныг, мөн өөрсдийг нь алахаар хүмүүсийг уурлуулах юу хэлснийг нь эрж хай.

Стефенд тохиолдсон шиг, гэрчлэлийнхээ төлөө та нар үхэхээр дуудагдахгүй байж болно. Гэсэн хэдий ч, та нар зөв гэдгийг нь мэдэж байгаа юмыг хийхийн төлөө тэмцэхдээ өөр бэрхшээлүүдтэй тулгарахаар уриалан дуудагдаж болно. Үүнд та нар бэлэн үү?

Судруудыг Ойлгох нь

Үйлс 6

Өдөр тутмын үйлчлэл (ш.1)—Ядуус болон гачигдалтай хүмүүст өдөр бүр анхаарал халамж тавих

Нууцаар ятгах (ш.11)—Худал хэлүүлэхээр хахуулдах

Бурханы эсрэг хараалын үг (ш.11)—Бурханыг үл хүндлэх

Сйлс 6:1–6—Долоон Шинэ Удирдагч Сонгогдов

Сүмийг цөөн тооны хүмүүсээс мянга мянган гишүүнтэй болж өсөхөд ажилд нь туслах илүү олон удирдагчид Төлөөлөгчдөд хэрэгтэй болов. Тэд Сүнсээр амьдарч байсан долоон хүнийг дуудаж, онцгойлон адислав. Өнөөдөр түүнчлэн долоон эрэгтэй хүмүүс Төлөөлөгчдөд тусалдаг. Тэд бол Далын Долоон Ерөнхийлөгч юм. Эдгээр хүмүүс Далын ажлыг чиглүүлж, дэлхий даяарх Бурханы хаант улсын ажлыг хянан зохицуулж байлаа. Далыг зохион байгуулж, ажил үүргийг тогтоосон нь Сүмийн зохион байгуулалт өсч хөгжихийн хэрээр олон тооны өөрчлөлт гарчээ.

Үйлс 7

Болон (ш.6)—Амьдрах Тэнгэрийн эрхэс (ш.42)—Нар, сар, одод

Зайлуулсан (ш.45)—Хөөсөн Зүрхэндээ хөвч хөндүүлээгүй (ш.51)—Ёс бус

Сйлс 7:19–25—Өөрийгөө Хэн Байсныг Мосе Мэдсэн үү?



Египетээс Гарсан нь номны эхний бүлгүүд Мосе бол египет бус, харин еврей хүн байсныг тэрээр өөрөө мэдэж байсан тухай бидэнд өгүүлдэг. Гэвч тэрээр өөрийн дуудлага хийгээд хувь тавиланг мэдэж байсныг Египетээс Гарсан нь бидэнд өгүүлдэггүй. Гэвч Хуучин Гэрээнд өнөөгийн бидний мэддэгээс илүү мэдээлэл Стефенд байсан байх ёстой, учир нь “Бурхан өөрөөр нь дамжуулж тэднийг

Египетийн боолчлолоос хэрхэн чөлөөлөхийг ах дүү нар нь ойлгоно” гэдгийг Мосе мэдэж байсан хэмээн тэрээр

гэрчилжээ (Үйлс 7:25). Үүнчлэн, Мосе “Бурханы хүмүүстэй хамт зовлон эдлэх нь дээр гэдгийг сонгон, Фараоны охины хүү гэж нэрлэгдэхээсээ татгалзсан юм” (Еврей 11:24–25) хэмээн Төлөөлөгч Паул хэлжээ.

Хэрэв Мосе өөрийн дуудлагыг мэдэж байсан бол тэрээр хэрхэн энэ тухай мэдсэн байх билээ? Магадгүй тэрээр энэ тухай бошиглолоос мэдсэн байж болно. Иосеф Смитийн Орчуулга Иосефоос (Египетэд худалдагдсан), тэрээр нас барахаасаа өмнө өөрийн хүмүүст хандаж хэлсэн үгийг агуулсан байдаг. Энэ үгэнд Египетээс Израилыг гаргаж авахын тулд Их Эзэн чөлөөлөгчийг илгээх бөгөөд түүний нэр Мосе байх болно хэмээн тэрээр бошигложээ (ИСО, Эхлэл 50:24–38-ыг үз). Бас бошиглогч Лихай 2 Нифай 3:6–10-т энэ үгийн хэсгээс иш татсан байдаг.

Судруудыг Судлах нь

Үйлс 7-г судлахдаа үйл ажиллагаа А буюу үйл ажиллагаа Б, В-г хий.

А Стефен, Итгэлтэй Сйлчлэгчдийн Сүргийн Загвар

Үйлс 6:3–8-д, Төлөөлөгчдөд тулахаар сонгогдсон долоон хүний нэг Стефен, чин шударга хийгээд Ариун Сүнс, мэргэн ухаан, итгэл бишрэл, залбирлын хүчээр дүүрэн байсан хэмээн дүрслэгддэг. Үйлс 6–7 дахь Стефений тухай түүхийг нэгтгэн дүгнэж, Стефен дээрх чанар тус бүрийг хэрхэн нотолж байсныг жишээгээр гарга.

Б Мосе, Бошиглолын болон Хувь Тавилант Хүн

Үйлс 7:19–29-д Стефенээс Мосегийн талаар хийсэн дүрслэлт түүнчлэн Еврей 11:24–25 дахь Паулын дүрслэлийг нэгтгэн дүгнэ. Мосегийн тухай өмнө мэддэггүй байсан юуг мэдсэн тухайгаа тэмдэглэлийнхээ дэвтэрт бич.

В Төгс Эзэмших Судар—Сйлс 7:55–56

Аврагчийн тухай гэрчлэлийнхээ учир Стефен чулуугаар шидүүлж үхэхээсээ өмнө, тэрээр Түүнийг гайхамшигт үзэгдэл харсан хэмээн гэрчилжээ. Үйлс 7:55–60-ыг уншиж түүний үгсийг судрууддаа тэмдэглэ. Түүний сүүлчийн үгсийн товч хураангуйг болон эдгээр үгсийн талаар өөрсөддөө төрсөн сэтгэгдлийн тухай бич.

Үйлс 8–9

Саулын Хөрвүүлэг

Та нар зөв юм хийж байгаа гэж бодсон учраас ямар нэг зүйлийг зоригтой, урамтайгаар хийсэн хэдий ч, хожим энэ нь буруу байсныг мэдсэн явдал чамд тохиолдож



байсан уу? Үйлс 8–9 Тарсын Саул хэмээх Фарисай хүнийг бидэнд танилцуулдаг. Саул бол яг Аврагчийн угтан хэлсэн шиг, Назарын Есүсийн дагалдагчдыг мөрдөн хавчих явдал нь Бурханд үйлчилж байна гэж бодож байсан хүмүүсийн нэг байлаа (Иохан 16:2-ыг үз). Гэвч Саулын хамгийн агуу хүсэл бол зөвийг хийх явдал байв. Фарисай хүн Саул хэрхэн Төлөөлөгч Паул

болж, мөрдөн хавчигчаас бошиглогч болсон тухай та нар эдгээр бүлгүүдэд унших болно.

Судруудыг Ойлгох нь

Үйлс 8

Сайшаах (ш.1)—Зөвшөөрч	Хор шар (ш.23)—Туйлын ёс бус явдал
Хоосруулж (ш.3)—Эмх зам-бараагүй явдал, эвдрэл сүйтгэл учруулж	Худал хуурмагийн хүлээс (ш.23)—Нүглийн боолчлол
Гайхашруулж (ш.9)—Гайхлыг төрүүлж	Тайган (ш.27)—Итгэгдсэн зарц

Сйлс 8:14–17—Ариун Сүнсний Бэлэг Өгөх Хүч

Аароны Санваар болон Мелкизедек Санваарын хооронд эрх мэдлийн ялгаа байдгийг орчин үеийн илчлэлтээс бид мэдэх билээ. Аароны Санваар баптисм хүртээх эрх мэдлийг атгадаг (С ба Г 20:46-г үз) ч гэсэн, Ариун Сүнсний бэлгийг олгоход нэмэлт эрх мэдэл хэрэгтэй байдаг. Мелкизедек Санваар бол энэхүү илүү өндөр эрх мэдэл юм. Үүгээр хүн Сүмийн бүхий л сүнслэг адислалууд, түүний дотор Ариун Сүнсний бэлгийг олгож болно (С ба Г 20:38–41-ийг үз). Самари дахь Филиппийн номлогчийн ажил эрх мэдэл дэх энэхүү ялгааг харуулсан байдаг. Тэрээр Аароны Санваартай байсан учраас заах болон хүмүүст баптисм хүртээх эрх мэдэлтэй байсан боловч, шинэ гишүүдэд Ариун Сүнсний бэлгийг өгөхөд Төлөөлөгчид хүрч ирэх ёстой байлаа.

Үйлс 9

Тэр замд хамаарагдах хэнийг ч болов (ш.2)—Есүс Христэд итгэдэг хэнийг ч болов	Сонгогдсон сав (ш.15)—Тусгай үйлчлэлийн тулд урьдчилан томилогдсон хүн
Хавчиж мөрдөөд байгаа (ш.5)—Сүнсний өдөөлтийн эсрэг тэмцэх	Хичээсэн (ш.26)—Оролдсон

Сйлс 9:7—Хүмүүс Юу Харсан Буюу Сонссон Бэ?

Иосеф Смитийн Орчуулга нь Үйлс 9:7 болон 22:9 дэх Паулын туршлагын үед хүмүүс юу харж, сонссон тухай шастирын ялгааг тодруулдаг (ИСО, Үйлс 9:7-г үз).

Судруудыг Судлах нь

Үйлс 8–9-ийг судлахдаа үйл ажиллагаа А–В-г хий.

А Илбэч Симон

Саул шиг хавчин мөрдөгчдөөс болж Сүмийн гишүүд их хавчлага мөрдлөгтэй тулгарч Иерусалимаас дүрвэхээс аргагүйд хүрчээ. Филип Самари уруу зугтаж, тэнд илбэч Симонтой танилцав. Үйлс 8:1–24-ийг нэгтгэн дүгнэж, дараах асуултуудад хариул:

1. Филиппийг ирэхээс өмнө хүмүүс Симоны тухай юу гэж боддог байсан бэ?
2. Симоны хүч хаанаас ирдэг гэж тэд боддог байсан бэ?
3. Филиппийн захиасын талаар Симон юу гэж боддог байсан бэ?
4. Петр, Иохан хоёр яагаад Самари уруу явсан бэ? (Үйлс 8:14–17-гийн “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз).
5. Симон Петрээс юу хүссэн бэ?
6. Санваарын тухай Петр Симонд юу заасан бэ?

Б Филип ба Этиоп Хүн

Филипп аялж явахдаа санваараа ашиглах олон боломжтой таарчээ. Тэрээр судруудыг ойлгохоор тэмцэн буй нэгэн Этиоп хүнийг хараад түүн рүү гүйж очин, наманчлалын сайн мэдээг түүнд номлосон ажээ. Сургаал ба Гэрээ 13-т санваар нь, (1) тэнгэр элчүүдийн тохинууллыг хүлээн авах, (2) наманчлалын сайн мэдээг заах, (3) нүглүүдийн ангижралын тулд усанд умбуулалтаар баптисм хүртээх түлхүүрүүд буюу хүчийг атгадаг билээ. Үйлс 8:26–40-ийг уншиж, эдгээр хүс тус бүрийг Филип хэрхэн ашиглаж байсныг тэмдэглэлийнхээ дэвтэрт дүрсэл.

В “Саул, Юунд Чи Намайг Хавчина Вэ?”



Дамаск орох замд Саул гайхамшигтайгаар хөрвүүлэгдсэн болон түүний номлогчийн ажил алба эхэлсэн тухай шастирьг Үйлс 9:1–31 агуулдаг. Энэхүү туршлагын дараа Саул (Паул хэмээгдэх болсон) яагаад өөрийгөө сайн мэдээнд ийнхүү ихээр зориулах болсныг ойлгоход нилээд хэдэн үйл явдал бидэнд тусалдаг.

1. Үйлс 9-ийг уншсанаасаа, зурагласан үйл явдал тус бүрт тайлбар бич.
2. Саулын тухай болон Их Эзэн Өөрийн хүүхдүүдэд, ялангуяа зөв зүйл хийхийг хүсдэг хүмүүст хэрхэн тэвчээртэй ханддаг тухай энэ бүлгийн заадаг зүйлийг хураангуйлан дүгнэсэн нэг догол мөр бич.

ҮЙЛС 10

Сайн Мэдээ Хүн Бүгдэд Зориулагдсан Юм

Мосегийн үеэс эхлэн Бурханы гэрээт хүмүүс болон бусад хүмүүсийн хооронд зааг ялгаа тогтооход их анхаарч иржээ. Харийн хүн (Израил биш) Бурханы хувьд хүлээн авч болохуйц болох цорын ганц арга зам бол уг хүн Мосегийн хуулийн бүх ёслолууд хийгээд шаардлагуудад захирагдах замаар эхлээд Иудей хүн болох явдал гэдэгт Иудейчүүд итгэдэг байжээ.

Сүмийн практик хийгээд Иудейчүүдийн мянган жилийн ёс заншлыг өөрчилсөн хоёр эмгэнэлт туршилага Петрт байлаа. Бурхан “хүмүүсийг ялгаварлагч биш” гэдгийг тэрээр үзэгдлээр дамжуулан мэджээ (Үйлс 10:34). Өөрсдийгөө зориулсан зарим харийнхантай Петр гайхамшигтайгаар танилцжээ Энэ үеийг хүртэл Сүмд нэгдсэн бүх хүмүүс, Иудейчүүд эсвэл Иудейн шашинд хөрвүүлэгдсэн Харийнхан байлаа. Мосегийн хууль бүрэн гүйцэлдсэн болохоор харийнхан эхлээд Иудейчүүд бололгүйгээр Сүмд шууд ирж болохыг Петр хүмүүст заах боломжтой болов.

Судруудыг Ойлгох нь

Үйлс 10

Зуутын дарга (ш.1)—Ромын цэргийн захирагч
Есдүгээр цаг (ш.3)—
Өдрийн 3:00 цаг орчим



Есүсийн үед цагийг хэлдэг байсан нь

Өглөгүүд (ш.4)—Ядууст өгөх өглөг хандив

Зургадугаар цаг (ш.9)—
Үдийн орчим
Хэт хөөрөлд автах (ш.10)—
Ариун Сүнс түүн дээр ирэв
Ариун бус, бузар юм
(ш.14)—Мосегийн хуулиар
хориглогдсон зүйл
Хамт явахад (ш.23)—Цуг
явахад
Түдгэлзэх (ш.29)—Татгалзах
Ойлгох (ш.34)—Мэдэх,
ойлгох
Ховч хөндүүлсэн итгэгчид
(ш.45)—Христэд хөрвүүлэгдсэн
Иудейчүүд

Сйлс 10—Орчин Сейин Адил Төстэй Зүйл

Бурхан бол “хүмүүсийг ялгагч биш” (Үйлс 10:34) гэдгийг түүнд заасан Петрийн үзэгдэл Сүмд үндсэн өөрчлөлт авчирсан юм. Анх удаа харийнхан Мосегийн хуулийн шаардлагудыг үл харгалзан, Сүмд баптисм хүртэв. Энэ нь Сүм зөвхөн Иудейчүүдийн дунд биш, харин бүх хүмүүсийн дунд түргэн өсөхөд туслав.

Үүнтэй төстэй нөхцөл байдал Сүмд манай өнөө үед оршиж байв. Хуучин Гэрээний үеэс Тэнгэрлэг Эцэг санваарыг атгах эрхийг хязгаарлаж байв. Абрахамын үед санваарын эрх патриархийнх байсан нь, энэ нь эцгээс хүүд дамжуулан өгөгддөг гэсэн утгатай байв (С ба Г 107:40; Абрахам 1:2–4, 26–27-г үз). Мосегийн үед Мелкизедек Санваар Израилаас авагдаж, Аароны Санваарыг зөвхөн Левийн овог атгаж байжээ (Тооллого 18:6–8-ыг үз). Хожмын өдрүүдэд Мелкизедек Санваар мөн сэргээгдэж, уг санваарыг авч явах эрх Израилын угсаанаас гаднах олон хүмүүст өгөгджээ.

1978 оны Зургадугаар сард “Сүмийн бүх зохистой эрэгтэй гишүүд яс үндэс буюу арьсны өнгөөс үл хамааран санваарт томилогдож болох” цаг ирснийг Их Эзэн, Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллд илчилсэн юм (Албан Тунхаг 2). Дэлхий даяарх Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүдэд сайн мэдээг хүргэхэд Их Эзэн Сүмд туслахын тулд дахин ажиллав.

Судруудыг Судлах нь

Үйлс 10-ыг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Мянган Жилийн Хууль хийгээд Ёс Заншил Илчлэлтээр Төгсгөл Болов

Үйлс 10-ыг уншсаны дараа өөрсдийгөө Петр байсан гэж бодоод Петрийн туршлагын тухай өдрийн тэмдэглэл бич. Олон үеийнхний туршид баримталсаар ирсэн Мосегийн хуулийн зан үйлийг төгсгөл болгосон илчлэлт хүлээн авах нь ямар байж болохыг төсөөлөн бод. Дараах үйл явдлуудыг хэлэх хийгээд эдгээрийн талаар Петрт ямар бодол төрж байсан болохыг анхаар:

- Дээвэр дээр хүлээн авсан Петрийн үзэгдэл (ш.9–16-г үз).
- Корнелийн үзэгдэл (ш.1–8-ыг үз).
- Петр харийнхантай уулзсан нь (ш.17–48-ыг үз).

Энэ яагаад гайхалтай үйл явдал байсныг тайлбарла (Үйлс 10-ын оршлыг үз).

Б Том Бүтээлэгний Тухай Петрийн Сээгдэл

Петрийн том бүтээлэгний зургийг зурах буюу Петрийн үзсэн байж болох бузар амьтдыг жагсаа. Бузар амьтдын жагсаалтыг Левит 11-ээс үз.

Үйлс 11–12

Христэд Итгэгч Байх нь

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд бид Христэд итгэгчид мөн. Есүс Христ бол Сүмийн тэргүүн гэдгийг бид мэднэ. Тэр бол бидний Аврагч хийгээд Гэтэлгэгч болохыг бид мэднэ. Христэд итгэгчдийн хувьд бид бүх зүйлүүдэд Түүний үлгэр жишээг дагахыг хичээдэг.

Үйлс 11–12 нь Есүс Христ Өөрийн эхэн үеийн Сүмийг илчлэлтээр хэрхэн удирдаж, хүнд үед нь Гэгээнтнүүдийг хэрхэн адисалж байсныг харуулдаг.

Судруудыг Ойлгох нь

Үйлс 11

Мэтгэлцэж (ш.2)—
Маргалдаж

Дэс дараатай . . . тайлбар-
лав (ш.4)—Болсон арга
замыг тайлбарлав

Байхыг (ш.23)—Үлдэхийг
Сүнсээр зааварчлагдан
(ш.28)—Сүнсээр үнэн үзүү-
лэгдэн

Үйлс 12

Хорлох зорилгоор (ш.1)—
Зовоох, мөшгин хавчих

Ёврон (ш.7)—Цохиж

Бүсээ бүсэлж (ш.8)—Бүсээ
бүсэлж хувцсаа чангалах

Нэг, хоёр дахь харуулууд
(ш.10)—Нэг дэх мөн хоёр
дахь харуулууд

Батлан хэлэх (ш.15)—
Шаардах
Гараараа дохиод (ш.17)—
Гараараа зангах
Багагүй сандрал (ш.18)—
Их үймээн сандрал

Сйлс 12:1–3, 21–23—Аль нь Ёс Бус Хаан Херод Вэ?

Шинэ Гэрээнд хэд хэдэн Херод дурдагдсан байдаг. Есүсийг төрөхөд Херод Хаан бол бусдынхаа эцэг болон өвөг эцэг нь байжээ. Улс төрийн хувьд тэрээр ромчуудтай нөхөрлөдөг байсан учраас тэрээр хаан байжээ. Тэрээр Иудей биш, мөн Иудейчүүд түүнийг харгис хэрцгийнх нь улмаас үзэн яддаг байв. Иаковыг хөнөөсөн Херод бол эхний Херодын ач хүү Херод Антипа I байв. Иудейчүүдийн удирдагчдыг тэрээр баярлуулахыг эгээрэн хүсч байсан учраас Христэд итгэгчдийг мөшгин хавчиж байлаа. Түүний хүү, Херод Антипа II Паулын сайн мэдээ заахыг сонсон, түүнээс бурууг олоогүй ажээ (Үйлс 25:13–26:32-ыг үз).

Судруудыг Судлах нь

Үйлс 12-ыг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Бошиглогч Бодлогын Сндсэн Өөрчлөлтийг Зарлав

1. Үйлс 11:1–18-ыг нэгтгэн дүгнэж, дараах асуултуудад хариул:
 - а. Петр харийнхантай уулзаж, тэдэнтэй хамт хооллосныг сонсоод Иерусалим дахь Гэгээнтнүүд хэрхэн хариу үйлдэл үзүүлсэн бэ?
 - б. Өөрийгөө хамгаалахын тулд Петр юу хэлсэн бэ? (Үйлс 11:4–17-г үз)
 - в. Петрийн тайлбарыг сонсоод Гэгээнтнүүд яасан бэ?
2. Сургаал ба Гэрээ 21:4–6-г уншаад, Өөрийн бошиглогчоор дамжуулан өгсөн Их Эзэний илчлэлтүүдийг дагах нь яагаад нэн чухал шаардлагатайг тайлбарла.

Б Тэнгэр Элч Петрийг Оргоход Туслав



Үйлс 12:1–19 дэх түүх бол гайхамшигтай түүхүүдийн нэг юм. Эдгээр шүлгүүд дэх гурав буюу дөрвөн чухал ач холбогдолтой үйл явдал юу болохыг жагсааж, яагаад тэдгээр нь чамд онцгой сэтгэгдэл төрүүлснийг тайлбарла.

Үйлс 13–14

Паулын Анхны Номлол

Танай гэр бүлээс, эсвэл танай бүсээс номлогч нар ямар орнуудад үйлчилсэн бэ? Өнөөдөр номлогч нар бараг л дэлхий даяар хаа сайгүй илгээгдэж байна. Энэхүү дэлхий даяарх номлогчийн хүчин чармайлтыг эхлэхэд Паул чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Үйлс 13 Паул өөрийн анхны номлолын аялалд дуудагдсан тухай өгүүлдэг. Тэрээр Барнабтай хамт Антиохаас гарч одоогийн Турк болох Кипр уруу аялжээ. Түүний захиасыг олон хүмүүс хүлээн авч байсан хэдий ч, бусад нь түүнийг дайсан гэж үзэн түүний хийж байсан ажлыг зогсоохоор оролдож байв. Тэрээр эсэргүүцлийг үл хайхран, явсан газар болгондоо Сүмийн олон шинэ салбаруудыг байгуулж байлаа. Та нарын мэддэг номлогч нарын адил, дэлхийн хүмүүст сайн мэдээг хүргэхийн тулд Паул бүхий л зурх сэтгэлээрээ үйлчилж байлаа.



Судруудыг Ойлгох нь

Үйлс 13

Томилогтун (ш.2)—
Номлолын тулд онцгойлон адислах
Заль (ш.10)—Худал хэлэх, мэхлэх
Ялзрал (ш.35–37)—Бие ялзрах

Зөвтгөгдөж (ш.39)—
Уучлагдаж, гэм буруугүй гэж тооцогдох
Шинэ итгэгчид (ш.43)—
Хөрвөгчид
Хөөн гаргав (ш.50)—Орхин явахаар албадуулагдав

Үйлс 14

Бодол санааг үймүүлж (ш.2)—Бодол санааг нь эсрэг эргүүлэх
Зевс . . . Хермес (ш.12)—
Ром домгийн хоёр хуурамч бурхад

Арай чамай хориглож байлаа (ш.18)—Арай ядан зогсоож барьж байв

Судруудыг Судлах нь

Үйлс 13–14-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг нь хий.

А Паулын Номлол Эхлэв



Үйлс 13:1–5-ыг уншиж, дараах асуултуудад хариул:

1. Паул (Саул) номлолд хэрхэн дуудагдсан бэ?
2. Паултай хамт үйлчлэхээр хэн дуудагдсан бэ?
3. Энэ нөхцөл байдалд итгэлийн тав дахь тунхаг хэрхэн нийцэх вэ?

Б Синагогт Заасан нь

Паул Антиоход сайн мэдээг заахдаа өөрийн анхны номлолын үед ихэнх газарт хэрэглэж байсан тэр арга барилуудыг ашиглажээ. Та нар Үйлс 13:14–52-ыг уншихдаа, тэмдэглэлийнхээ дэвтэрт дараах асуултуудад хариул:

1. Паул Антиоход сайн мэдээг заахыг хүсэхдээ тэр анх хаашаа явсан бэ?
2. Паул яагаад Израилын түүхийг хүмүүст сануулсан бэ? (Үйлс 13:16–22-ыг үз).




3. Антиох дахь хүмүүсийн хариу үйлдлийг өнөөдөр хүмүүс номлогч нарт үзүүлдэг хариу үйлдэлтэй хэрхэн харьцуулж болох вэ?

В Зовлон Зүдгүүр ба Бурханы Хаант Улс

Бид гагцхүү их зовлон зүдгүүрээр дамжин Бурханы хаант улсад орно гэж Паул хэлжээ (Үйлс 14:22-ыг үз). Үйлс 14:6–18-д Паулд тохиолдсон явдлыг шүлэг 19–21-д тохиолдсон явдалтай харьцуул. Туршлага бүр нь шүлэг 22-т Паулын хэлсэн зүйлийн жишээ хэрхэн болж чадах вэ?

Г Паултай Хамт Аялалд Гар

Доор харуулсантай адил газрын зургийг тэмдэглэлийн дэвтэртээ зур. Паулын анхныхаа номлолоор явсан газруудыг тогтоож, түүний аяллыг харуулахын тулд сум ашигла.



Үйлс 15

Иерусалимын Чуулган

Сүмийн зөв сургаал юу вэ гэдэг талаар Сүмийн гишүүд хэзээ нэгэн цагт будилж байдаг уу? Эхэн үеийн Сүм дэх иймэрхүү нөхцөл байдлын тухай бид Үйлс 15-д уншидаг. Сүмд нэгдсэн олон Иудейчүүд Мосегийн хууль хийгээд хөвч хөндөх ёслол зайлшгүй чухал хэвээрээ байгаа гэж бодсоор байлаа. Тэр ч байтугай тэд Христэд итгэгчид болохыг хүсдэг харийнханыг Иудейчүүдийн ёс заншлыг дагахыг хүсэн хүлээдэг байв. Та нар энэ бүлгийг уншихдаа, сургаалын талаарх маргаан Сүмд хэрхэн шийдвэрлэгдэж байсныг ажигла. Сургаалын талаарх маргааныг шийдвэрлэх энэ үйл явцын өнөөгийн жишээнүүдийг та нар мэдэх үү?

Судруудыг Ойлгох нь

Үйлс 15

Маргаан (ш.2)—Мэтгэлцээн
Бусад хүмүүс (ш.17)—
Үлдсэн нь, үлдсэн хүмүүс
Хиймэл шүтээнээр бузарлагдсан зүйлсээс цээрлэх (ш.20)—Хиймэл шүтээнд оролцохоос татгалзах

Байсан (ш.33)—Үлдсэн
Санал зөрөлдөөн (ш.39)—
Маргах, үгээр марган тэмцэлдэх

Сйлс 15:1–5—Иудейн Христэд Итгэгчид ба Христэд Итгэгч Харийнхан

Фарисайчууд бол Мосегийн хууль болон ахмадын ёс заншлуудыг чанд сахьдаг Иудейчүүд байсан гэдгийг та нар Сайн Мэдээнүүдээс мэдсэн билээ. (Энэ сурах удирдамж дахь Матайн 12-ын оршлыг үз, х.25). Эдгээр фарисайчуудын зарим нь Есүс Христийн сайн мэдээнд хөрвүүлэгдэхэд, тэд өөрсдийн ёс заншлуудыг хэвээр хадгалахыг хүсч, мөн Сүмд нэгдсэн хүн бүр, түүний дотор харийнхан ч гэсэн мөн ингэх ёстой гэдэгт итгэдэг байв.

Мосегийн хууль, түүний дотор хөвч хөндүүлэх шаардлага Есүс Христэд гүйцэлдсэн болохоор энэ нь зөв биш гэдгийг Паул ойлгож байлаа (Лук 24:44; 3 Нифай 15:4–5). Иудейчүүд ч, харийнхан ч илүү бага хуулиар цаашид амьдрах шаардлагагүй болсон байв. Паул болон Христэд итгэгч Иудейчүүдийн хоорондох санал зөрөлдөөн нь зөвхөн Сүмийн чуулган дээр Төлөөлөгчдөөр шийдвэрлэж болох, Сүм дэх хагарал зөрчилдөөнд хүргэжээ.

Харийнханы итгэгчид Мосегийн хуулийн зохицуулалтгүйгээр Бурханд хүлээн авагдаж болохыг Их Эзэн өөрт нь илчиллээ гэдгийг Петр чуулган дээр тайлбарласан байна (Үйлс 10-ыг үз). Хуучин хуулийн зөвхөн ганцхан хэсэгт л, тухайлбал хиймэл шүтээн шүтэхээс хүмүүсийг хол байлгахад дуулгавартай байдал шаардлагатай гэж зөвлөл шийджээ. Асуудал шийдвэрлэгдсэн үйл явцыг ажигла.

- Сүмийн удирдагчид асуудлыг авч хэлэлцэхээр зөвлөлд цуглав (Үйлс 15:1–6-г үз).
- Бошиглогч бөгөөд Сүмийн Ерөнхийлөгч уг сэдвээр Их Эзэний илчилсэн зүйлийг тайлбарлав (ш.7–11-ийг үз)
- Сүмийн бусад удирдагчид Ерөнхийлөгчийн зөвлөлийг дэмжиж, хариулт нь Бурханаас ирсэн гэдгийг батлахын тулд үг хэлэв (ш.12–20-ийг үз).
- Зөвлөлийн шийдвэрийг үлдсэн гишүүдэд илгээв (ш.22–31-ийг үз).

Хоёр Албан Тунхаг (С ба Г 138-ын дараах) бол Сүм дэх энэ үйл явцын өнөө үеийн жишээ мөн.

Судруудыг Судлах нь

Үйлс 15-ыг судлахдаа А буюу Б үйл ажиллагааг хий.

А Сургаалын Маргааныг Шийдвэрлэх нь

Үйлс 15-д Их Эзэний Сүмд сургаалын талаарх маргааныг хэрхэн шийдвэрлэдгийн нэг жишээ байна (Үйлс 15:1–5-ын “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз). Маргаан шийдвэрлэх тухай дараах асуултуудыг нэгтгэн дүгнэж хариултуудыг тэмдэглэлийн дэвтэртээ бич:

1. Үйлс 15 дахь маргаан юуны тухай байсан бэ? Хариултыг авахаар хүмүүс хэн рүү очсон бэ?
2. Асуултанд хариулахаар хэн эхэлж боссон бэ? Сүм дэх түүний дуудлага юу байсан бэ? (Матай 16:16–19-ийг үз). Итгэдэг мөн наманчилдаг хийгээд Мосегийн хуулийн дагуу амьдрахыг өөрсдөөсөө шаарддаггүй байсан харийнханыг Бурхан хүлээн зөвшөөрсөн гэдгийг тэрээр яаж мэдсэн бэ? (Үйлс 10-ыг үз).
3. Сүмийн өөр ямар удирдагчид үг хэлсэн бэ? Тэд санал нийлж байсан уу? Эсвэл үгүй юу? (Үйлс 15:12–22-ыг үз).

4. Маргааны хариуг Сүмийн үлдсэн хэсэг нь яаж мэдсэн бэ? (Үйлс 15:22–31-ийг үз).
5. Өнөөдөр Сүм дэх энэ үйл явцын ямар жишээнүүд бидэнд байдаг вэ?

А Дэлхий Дахины Сүм Дэх Соёлын Ялгаанууд

Үйлс 15 дахь хөвч хөндөх болон Мосегийн хуулиарх маргаан нь зөвхөн сургаалын маргаан байсангүй, бас соёл, ёс заншлын зөрчил сөргөлдөөн байв. Паулын хөрвүүлсэн харийнхан олон өөр орных байсан бөгөөд тэдний ёс заншлууд Иудейн хүмүүсийнхээс тэс ондоо байлаа. Арванхоёр Төлөөлөгчийн гишүүн, Ахлагч Ричард Г.Скотт хэлэхдээ:

“Ёс зүй, соёлын буюу үндэсний өв уламжлалаа дээдлэх нь нэн эрхэм нандин, ашиг тустай ч гэсэн, энэ нь бүхнээ зориулдаг Хожмын Үеийн Гэгээнтнээр хажуу тийш тавигдах ёстой, насан туршид үргэлжлэх ёстой амьдралын загварууд байж бас болно . . . гэжээ

“[Ерөнхийлөгч Ховард В.Хантер хэлэхдээ]: ‘Есүс Христийн Сүмийн гишүүнчлэлийг эн тэргүүнд тавихыг би танд санал болгож байна. Гэр бүл, хайртай хүмүүсээс тань, таны соёлын өв, эсвэл өөрсдийн тань өвлөж авсан ёс заншлуудаас тань ч байсан таныг хийхийг хүссэн тэрхүү зүйлийг цэгнэж үз—Аврагчийн заадаг зүйлийн эсрэг бүх зүйлийг цэгнэж үз. Эдгээр заадаг зүйлүүдээс зөрөөтэй зүйлийг олох аваас, тэр зүйлээ өөрсдөөсөө холдуулж, бүү мөрд. Энэ танд аз жаргал авчрахгүй’ (*Prepare Yourself* [pamphlet, 1996], 1–2)” (in Conference Report, 1998 оны 4-р сар, 112; *Ensign*, 1998 оны 5-р сар, 85).

Нэг орны Сүмийн гишүүдэд чухал байж болох хэдий ч, өөр нэг орны хувьд ийм биш ёс заншлын тухай бод. Ерөнхийлөгч Хантер, Ахлагч Скотт нарын хэлсний дагуу, ёс заншлын талаар өөрсдийн жишээ гаргаж, хүн юу хийх ёстой талаар юу гэж бодогоо тайлбарла.



Үйлс 16

Паул Хоёр Дахь Номлолоо Эхэлсэн нь

Хүмүүс өөр оронд очоод ямар бэрхшээлүүдтэй тулгарч болох вэ? Тавин жилийн өмнөхөөс өнөөдөр илүү амархнаар аялах орчин үеийн аятайхан олон боломжууд

бидэнд байна. МЭ 50 онд аялагчид ямар хэцүү байсныг эргэн төсөөл. Үйлс 15:40–18:22-т бид Паул хоёр дахь номлолдоо аялсан тухай уншидаг. Тэрээр сайн мэдээг дэлгэрүүлж явахдаа аяллын, мөшигин хавчилтын аюул осол, мөн бусад олон саад бэрхшээлийг тэвчиж, даван туулсан билээ. Та нар Үйлс 16-г уншихдаа Паулын туршилагуудыг манай өнөө үеийн номлогч нарынхтай хэрхэн харьцуулж болох талаар бод.



4. Паул, Силас хоёр яагаад шоронд орсон бэ? Энэ тухайд тэд юу хийсэн бэ?
5. Тэдний шоронгийн харгалзагч яагаад баптисм хүртсэн бэ?

Үйлс 17–18

“Бид Бурханы Үр Удам”

Судруудыг Ойлгох нь



Үйлс 16

Завдан байтал (ш.7)—
Хичээх, оролдох үед

Ятгаснаар (ш.15)—
Шавдуулснаар

Мэрэг төлөгчийн сүнс
(ш.16)—Мууг ёрлон хэлэх

Мэрэг төлөг (ш.16)—Хувь заяаг зөгнөн хэлэх, хилэнцэт аргаар ирээдүйг урьдчилан хэлэх

Тэргүүн захирагчид
(ш.20)—Шүүгчид

Судруудыг Судлах нь



Үйлс 16-г судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Филиппой дахь Паулын Номлол


Үйлс 16:6–15-ыг нэгтгэн дүгнэж, энэ хэсэгт болсон үйл явдлуудыг дэс дараагаар нь байрлуул.

- Паул Филиппой уруу аялав.
- Паул Тимоттой уулзав.
- Сүнс Паулд Тодорхой бүсүүдэд номлохыг зөвшөөрсөнгүй.
- Македоны хүний тухай үзэгдлийг Паул харав.
- Паул Лудиатай уулзав.

Б Паул болон Мэрэг Төлөгчийн Тухай Түүхийг Ярь

Үйлс 16 Филиппой уруу хийсэн Паулын номлолын тухай түүхийг өгүүлдэг. Дараах асуултуудад хариулах замаар уг түүхийг өөрсдийн үгээр ярь:

1. Македон дахь Филиппой хот уруу Паул яах гэж явсан бэ?
2. Лудиа гэж хэн байсан бэ?
3. Силас тэр хоёр “бүхнээс дээд Бурханы үйлчлэгчид” байсан гэдгийг мэрэг төлөгч гэрчлэхийг Паул яагаад хүсээгүй вэ?



Та нар хэзээ нэгэн цагт Тэнгэрлэг Эцэгийн тухай гэрчлэлээ Түүнд огт итгэдэггүй хэн нэгэнтэй хуваалцахаар оролдож байсан уу? Уг хүнд ойлгогдох нэр томъёогоор өөрийн мэддэг зүйлийг илэрхийлэх нь хэцүү байсан уу? Бид Бурханы үр удам мөн гэдгийг хүмүүст заах гэж оролдохдоо Петр эртний Грект үүнтэй адил туршилагатай учирч байжээ. Тэндхийн хүмүүс олон бурханд итгэдэг байсан бөгөөд харин Тэнгэр дэх Эцэгийн тухай мэдэхгүй байжээ. Тэдний ойлгодог зүйлээр тэдний ойлгоогүй зүйлийг заахад Паул хэрхэн ашигласныг ашигла.



Үйлс 17

Тайлбарлан нотлоод (ш.3)—Тайлбарлан, үзүүлж, заагаад

Нийлэв (ш.4)—Нэгдэв

Балмад . . . хэрцгий (ш.5)— Ёс бус, бусармаг санаа бодолтой

Баталгаа гаргуулан авч (ш.9)—Аюулгүйн баталгаа болгож мөнгө төлөөд

Хэлэлцэн (ш.17)—Шүүн ярилцаж

Номлогч (ш.18)—Заадаг хүн

Түүнтэй нэгдсэн (ш.34)— Тэд түүнтэй нэгдэв

Сйлс 17:18—“Епикурийн, мөн Стоикийн Гүн Ухаантнууд”

Епикурынхан болон Стоикийнхон бол эртний Грек дэх хоёр бүлэг философчид байлаа. Епикурынхан дэлхий тохиолдлоор бий болсон бөгөөд хэрэв бурхад байлаа гэхэд тэд хүний төлөө санаа тавьдаггүй, эсвэл хүнтэй зууралдаад байдаггүй гэдэгт итгэдэг байж. Тэдний хувьд амьдралын дээд зорилго бол баяр баясгаланг эрж хайн, уй гашуу, өвчин зовлонгоос зайлсхийх явдал байлаа.

Стоикийнхон ертөнцийг бүтээж, тушаал өгөн, дараа нь амьдралыг удирдах хуулиудыг бий болгосон бурханлиг хүчинд итгэдэг байжээ. Хүний хувийн эрэлт хэрэгцээнүүд ач холбогдолгүй, харин амьдралынхаа хувь тавиланг хүлээн авах нь л түүний үүрэг гэж тэд заалаг байв. Стоикийнхон бас бодит мэдрэмжээр ухамсарлагддаг зүйлүүд л зөвхөн бодитой байж болно гэдэгт итгэдэг байв.

Сйлс 17: 22-31—Тэнгэрийн Бурханы тухай Паул Гэрчлэв

Хиймэл шүтээнүүдээс Бурхан нилээд хэдэн байдлаар ялгаатайг Паул гэрчлэв:

- Бурхан тэнгэр болон газар дээрх бүх зүйлийг бүтээсэн.
- Тэрээр хүний хийсэн баримал буюу барилгаар хязгаарлагдаж эс чадна.
- Тэрбээр бүх хүмүүсийг бүтээгч бөгөөд бүх хүмүүс ах дүүс юм.
- Хүн хэзээ, хаана амьдрахыг Тэрбээр шийддэг.
- Тэр бол чулуун буюу төмөр дүрс биш; Тэр бол бидний Эцэг бөгөөд бид чухамдаа Түүний хүүхдүүд юм.
- Түүнийг эрэлхийлж, наманчлан, мөн Түүний зарлигуудыг сахихыг Тэрээр бидэнд зарлигласан юм.
- Тэрээр бүх хүн төрөлхтнийг шүүх өдөр ирэх болно.

Үйлс 18

Ажиллах болов (ш.3)— Ажиллав

Эсэргүүцэж (ш.6)— Өөрсдийгөө Паулын эсрэг тавьж

Босож (ш.12)—Дайрч
Гал цогтой (ш.25)—Эрч хүчтэй
Хүссэн (ш.27)—Хүссэн



Үйлс 17–18-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Сл Таних Бурханы Тухай Паул Заав

Паул Афинд очоод Грекчүүдтэй—ялангуяа шинэ санаануудын тухайд нээлттэй—Епикурчүүд болон Стоикийнхонтой учирчээ. Тэдний үл мэдэгдэх бурхдын тухай тэрээр номлол номлож, тэнгэрийн үнэн Бурханы тухай тэдэнд заажээ (Үйлс 17:16–31-ийг үз).

1. Үйлс 17-гийн “Судруудыг Ойлгох нь” хэсгийг уншсаны дараа энэ номлолд Паулын заасан үнэнүүд энд дүрслэгдсэн хуурамч санаануудыг хэрхэн залруулсныг дүрсэл.
2. Бурхан үнэхээр юутай адилхан болохыг зохих ёсоор ойлгоход залруулагдаж болох, зарим хүмүүст өнөөдөр байдаг хуурмаг санаанууд юу вэ?

Үйлс 19–20
Санваарын Эрх Мэдэл болон Паулын Номлолын Гурав Дахь Аялал

Санваарын зохих эрх мэдэлгүйгээр Түүний нэрээр баптисм хүртээх болон бусад ёслолуудыг гүйцэтгэдэг хүмүүсийн талаар Бурхан ямар бодолтой байдгийг та нар хэзээ нэгэн цагт бодож үзсэн үү? Бурханы дууддаг болон өөрсдийгөө дууддаг хүмүүсийн хооронд ялгаа бий юу? Үйлс 18:23–21:17, Паулын гурав дахь номлолын үеэр түүнийг Ефес, Грек, Мальт уруу явахад хичнээн их ялгаатай байдалтай байсныг харуулдаг.



Судруудыг Ойлгох нь



Үйлс 19

Зарим нь (ш.9)—Зарим хүмүүс, хэсэг хүмүүс

Шившлэг хийдэг тэнүүлчин Иудейчүүд (ш.13)—Тэнүүлчилж, муу ёрын сүнсийг зайлуулах хүч тэдэнд бий гэж мэдэгддэг Иудейчүүд

Хөөж байна (ш.13)—Тушааж байна

Ид шид (ш.19)—Илбэ шид **Зам** (ш.23)—Христийн шашин

Хэн нэгний эсрэг гомдолтой байгаа бол (ш.38)—Албан ёсоор гомдол гаргах

Үйлс 20

Ятган сургасаар (ш.2)—Хүчтэйгээр урамшуулан дэмжсээр

Хуйвалдаж (ш.3, 19)—Нууцаар хуйвалдаж

Санаатай байлаа (ш.13)—Шийдэв

Зайлхийсэн нь (ш.27)—Татгалзсан нь

Догшин (ш.29)—Харгис, ёс бус

Гажууд (ш.30)—Худал хуурмаг, хилэнцэг

Сйлс 19:23–41—Мөнгөний Дархчуудын Сймээн

Ефес дэх Паулын номлолын үр нөлөөг ажигла. Паулын захиасыг зарим харийнхан сонсож, хүлээн аваад тэд хиймэл шүтээнийг орхисон байдаг. Тэд Дианагийн ариун сүмд шүтэн бишрэхээ больсны улмаас хүмүүс Деметр болон бусад мөнгөний дархчуудын хийж амьдралаа залгуулдаг байсан охин бурхдын жижиг баримал дүрүүдийг худалдаж авахаа мөн больжээ. Мөнгөний дархчууд, өөрсдийн хуурмаг бурхдын нэр төрийн төлөө тэмцэнэ хэмээн мэдэгдэж Христэд итгэгчдийн эсрэг үймээн дэгдээсэн хэдий ч, үнэн хэрэг дээрээ бол баялгийнхаа эх үүсвэрийг эргүүлж авахаар найдаж байлаа.

Сйлс 20:28–30—Паул Урвалтын Тухай Бошиглов

Хүмүүсийн шударга бусын улмаас урвалт тохиох болно гэдгийг Паул харсан байлаа. Ахлагч Жеймс Е.Талмэйж, “Амин хувийн эрх ашгийн зорилгоор гадныхан өөрсдийгөө гэгээнтнүүдийн хувьд нэрд гаргах төдийгүй—сүрэгт догшин чононууд орж ирэн—хагарал бутрал удахгүй тохиох байлаа; мөн эдгээр зөрчилдөөн дараа нь удирдлагад улайран тэмүүлсэн хүмүүс, өөрсдийн сургаалыг бий болгосон хүмүүс, тийнхүү шавь нарыг Сүмээс холдуулж, өөрсөд рүүгээ татжээ” гэж бичжээ (*The Great Apostasy* [1953], 28). Урвалтын тухай бусад тодорхой зүйлүүдийг Матай 24:23–24; Галат 1:6–8; 2 Тесалоник 2:1–3; мөн 2 Петр 2:1–3-ыг үз.

Судруудыг Судлах нь



Үйлс 19–20-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) нэгийг хий.

А Мөрдөгч бол

Тэд аль хэдийнэ баптисм хүртсэн гэж хэлсэн хэсэг шавь нартай Паул уулзжээ (Үйлс 19:1–7-г үз). Гэвч тэрээр тэднээс асуусны дараа тэд дахин баптисм хүртэх хэрэгтэйг тэр мэд-

жээ. Эдгээр шүлгүүдийг судалж, доорх сонголтуудаас аль нь, яагаад Паул тэдэнд дахин баптисм хүртээх болсны хамгийн сайн тайлбар болохыг тогтоо.

1. Иохан Баптист баптисм хүртээх эрх мэдэлтэй байсанд Паул итгээгүй.
2. Тэдгээр шавь нар Иохан Баптистын баптисм хүртээдэг арга маягаар баптисм хүртсэн хэдий ч, зохих эрх мэдэлгүй хүнээр энэ нь хийгдсэн байв.
3. Иохан тэдэнд баптисм хүртээхдээ Есүс Христ болон Ариун Сүнсний тухай тэдэнд хэлэхээ мартсан учраас Паул тэдэнд дахин баптисм хүртээжээ (С ба Г 22-ыг бас үз).

Б Санваарын Эрх Мэдэл Хэр Зэрэг Чухал Вэ?



Үйлс 19:1–17-д Лукийн цэдэглэсэн үйл явдлуудыг нэгтгэн дүгнэ. Санваарын бүх ёслолуудыг гүйцэтгэхэд санваарын эрх мэдэл зайлшгүй шаардлагатайг Паулын үйл ажиллагаа хэрхэн харуулсныг тайлбарла.

В Сүмд Унтсан нь

Паулыг ярьж байхад нэг залуу хүн таг унтчихсан тохиолдлын тухай бид

Үйлс 20:1–12-т уншдаг. Хэрэв та нар орон нутгийн сонин сурвалжлагч байсан бол тэр үйл явдлын тухай сонинд юу бичих байсан бэ? Тэрхүү үйл явдал цугласан хүмүүсийг хэрхэн цочоох байсныг анхаар. Энэ хэсэг дэх баримтуудад өгүүлэл тань тулгуурлах ёстойг анхаар.

Г Паулын Салах Ёс Гүйцэтгэж Хэлсэн Сг

Номлолд үйлчилж байсан бүсүүдээ номлогч нар орхин явахдаа, хамтран ажиллаж байсан, сайн мэдээг зааж байсан, хайрлах нь өсөн нэмэгдэж байсан хүмүүстэйгээ тэд салах ёс гүйцэтгэдэг. Орхин явах болсон хүмүүстээ хандаж Паулын хэлсэн салах ёслолын үг байнгын салах ёс гүйцэтгэх үгнээс ямар нэг байдлаар өөр байлаа.

1. Үйлс 20:17–38-ыг уншиж, Паулын салах ёслолын үгс бусад номлогч нарынхаас хэрхэн өөр байгааг дүрсэл.
2. Эдгээр шүлгүүдэд Паулын заасан зарчмуудаас өөрсөдөө их сэтгэгдэл төрүүлсэн, наад зах нь хоёрыг сонгож, яагаад гэдгийг тайлбарла.
3. Ийм маягийн салах ёс гүйцэтгэхэд холбогдох Сүмийн дууллыг сонгож, яагаад үүнийг сонгосноо хэл.

Үйлс 21–23

Паул Иерусалимд Баривчлагдав

Мөнх бус байдал дахь сурахад хамгийн хэцүү сургамжуудын нэг бол Бурханы хаант улс дахь үйлчлэл хэзээд хөнгөн хялбар байдаггүй явдал мөн. Тэр ч байтугай Бурханы хамгийн итгэлтэй үйлчлэгчид ч гэсэн хатуу бэрхшээл зовлон хүнд сорилтуудыг тэсэх ёстой болдог. Паул Есү Христийн зорилгын төлөөнөө асар их бэрхшээл зовлон туулсан билээ. Номлолын гурав дахь аяллынхаа дараа түүнийг Иерусалимд эргэж ирсний дараа Ромын эрх баригчид түүнийг баривчилж, хэдэн жил шоронд хорьсон юм. Энэ бүхний туршид Их Эзэн түүнийг дэмжин, хамгаалж, сайн мэдээг хаад болон захирагчдын өмнө номлох боломжийг түүнд олгосон ажээ.

Судруудыг Ойлгох нь



Үйлс 21

Бүс (ш.11)—Бүсэлхийгээр бүсэлдэг даавуун бүс
Зүтгэдэг (ш.20)—Хүсэл эрмэлзэлтэй, зориулсан

Ам очиг (ш.23)—Бурханд өөрийгөө зориулахыг илтгэсэн тусгай амлалт
Шуугианаас (ш.34)—Үймээнээс болж

Үйлс 22

Энэхүү зам (ш.4)—Христийн дагалдагчид, Христэд итгэгчид
Хэт хөөрөлд автаж (ш.17)—Сүнсэнд аваачигдаж

Гэрч (ш.20)—Итгэл бишрэлийнхээ төлөө алагдсан хүн
Хувцсаа хүү татаж (ш.23)—Уураа харуулахын тулд хувцсаа урах

Үйлс 23

Цагаанаар будсан хана (ш.3)—Цэвэр харагдуулахын тулд будсан хана; сайн мэт дүр үзүүлдэг хэдий ч, дотроо хилэнцэт хүмүүсийн бэлэгдэл

Маргаан (ш.7, 10)—Санал зөрөлдөөн, зөрчил
Хуйвалдаан (ш.13)—Хилэнцэтийг үйлдэхээр төлөвлөж хуйвалдах

Сйлс 23:24–35—Фелик Хэн Байсан Бэ?

Антони Фелик бол Иудей мужийн захирагчаар томилогдсон Ром хүн байв. Түүний төв байр Цезарьт байлаа. Түүний гэргий Друзил (Үйлс 24:24-ийг үз) Херод Антипа I-ийн охин байв. Фелик Порк Фестээр солигдсон ажээ (Үйлс 24:27-г үз).



Каисарийн балгас

Судруудыг Судлах нь

Үйлс 21–23-ыг судлахдаа Б, Г болон өөр нэг үйл ажиллагааг (А, В буюу Д) хий.

А Паулын Иерусалим руу Эргэж Ирсэн Аялал



Паулын аялсан газар нутгийг Ром байлдан эзэлсэн нь зарим талаар адислал болжээ. Ромын Эзэнт Гүрэн энх тайвныг албадлагаар авчирсан нь аяллыг аюулгүй болгож, түүнчлэн сайн замууд байгуулсан нь аяллыг хөнгөвчилж өгчээ. Гэсэн хэдий ч, Паулын үед аялах нь өнөөдрийнхөөс хавьгүй илүү

хэцүү байсан ажээ. Паул явган буюу далай тэнгисээр аяллаа ч энэ аялал нь хэдэн долоо хоног тэр ч байтугай хэдэн сарыг авдаг байсан бөгөөд Иерусалим уруу эргэж ирсэн аялал нь ч мөн л ийм байв.

Паул Иерусалим руу ирэх замдаа Сүмийн салбаруудаар орж үзэхээр саатжээ. Үйлс 21-д дурьдсан газруудыг дор харуулав. Түүний аялж байсан аргыг дотроо санан, Паул хот бүрээс дараагийн хот хүртэл хичнээн миль (километр) хол аялж байсныг тэмдэглэлийнхээ дэвтэрт жагсаа.

1. Кос
2. Род
3. Патар
4. Кипр
5. Тир
6. Птолем
7. Каисари
8. Иерусалим

Б Агаб Паулын Тухай Бошиглов

Агаб нэртэй Сүмийн гишүүн бошиглолын сүнтэй байсан бөгөөд Иерусалимд Паулд юу тохиолдохыг угтан хэлжээ.

1. Үйлс 21:10–13-ыг нэгтгэн дүгнэж, Агабын бошиглосон зүйлийг бич.

2. Паул хэрхэн хариу үйлдэл үзүүлсэнийг нэгтгэн дүгнэж, Паул яагаад ингэж бодсоныг хэл.
3. Хэрэв Аврагч Өөрийн үйлчлэлд амь насаа зориулахыг чамаас асуулаа гэж бодвол, судрын ямар хэсгүүд чамд зориг, тайтгарлыг авчрах байсан бэ?

В Паул Иерусалимд Баривчлагдав

Өөрийнхөө зорилгуудыг гүйцэлдүүлэх сонирхолтой арга зам Их Эзэнд олон байдаг. Ромд тэр гэрчлэх болно гэдгийг Паул илчлэлтээр мэдсэн байлаа (Үйлс 19:21; 23:11-ийг үз), гэвч Ром уруу хийх түүний аялал хэрэг дээрээ Иерусалимд түүнийг баривчилснаар эхэлжээ. Та нар Үйлс 21:27–40-ийг нэгтгэн дүгнэхдээ, доорх нотолгоонуудыг авч үзэн, аль нь зөв болохыг тогтоо:

1. Паул нэг харийн хүнийг өөрсдтэйгөө хамт ариун сүмд авч оржээ (Үйлс 21:29-ийг үз).
2. Мосегийн хуулийг сайн мэдээ халсан гэдгийг Паул хүмүүст заасан (ш.28-ыг үз).
3. Ромын цэрэг Паулын амийг аврав (ш.32-г үз).
4. Паул, Египет хүн хоёр хотод бослого гаргуулсан (ш.38-ыг үз).



Г Хаад хийгээд Захирагчдын Өмнө Паул Гэрчлэв

Түүнийг дайрсан Иудейчүүдэд хандан үг хэлэхийг Ромын ахмад Паулд зөвшөөрөв. Паул энэ боломжийг өөрийн хөрвүүлгийн түүх болон гэрчлэлээ хуваалцахад ашиглажээ. Түүний хэлсэн зүйлийн ихэнх нь Үйлс 9:1–18-д бидний уншдаг зүйлтэй адил төстэй юм. Үйлс 9 дэх түүхийн хэсэг биш, ямар шинэ мэдээллийг бид Үйлс 22:17–21-ээс мэдэх вэ?

Д Ромын Иргэн Байсны Ашиг Тус

Ромын иргэд өөрсдийнх нь байлдан дагуулсан орнуудын иргэдэд байдаггүй тийм тусгай ашиг тусыг хүлээн авдаг байжээ. Жишээ нь, Ромын иргэдийг шүүх хуралгүйгээр шийтгэх ёсгүй байлаа (Үйлс 16:37-г үз). Түүнчлэн тэд Цезарийн өмнө сонсохоор Ромд даван заалдах боломжтой байв (Үйлс 25:11-ийг үз). Хүн төрөлтөрөө (хэрэв эцэг эхчүүд нь ромчууд бол), эсвэл иргэний харьяаллыг худалдаж авснаар иргэн болдог байв, гэвч энэ нь маш их үнэтэй байлаа. Паул төрөлтөрөө Ромын иргэн байв, гэвч яагаад гэдгийн нарийн ширийнийг бид мэддэггүй.


1. Үйлс 22:24–23:35-ыг унш. Паул Ромын иргэн байсан учраас түүнд өөр байдлаар хандаж байсан арга замуудыг тэмдэглэ.
2. Бурханы хаант улсын иргэн буюу гишүүн байх нь ямар үнэтэй байдаг вэ? Ийм гишүүнчлэл ямар ашиг тус авчирдаг вэ?

Үйлс 24–26

Паул Сайн Мэдээг Дэлгэрүүлэв

Иудейчүүдийн удирдагчид Ромчуудаар Есүс Христийг цовдлуулж чадах л юм бол Христийн шашин төгсгөл болно гэж бодож байжээ. Тэдний эндүүрэл болж, сайн мэдээний “баярт мэдээ” үлдэж хоцорсон төдийгүй, урьдынхаасаа улам ч түргэн тархсаар байлаа. Христэд итгэгчид үзэн ядагдсан харийнханд хүрч, Мосегийн хуульгүйгээр Иудейчүүдтэй адил тэгш үндсэн дээр Есүс Христээр дамжин ирэх авралыг тэдэнд амлаж байлаа. Та нар Үйлс 24–26-г уншихдаа тэд сайн мэдээг дэлгэрүүлэхийг зогсоохын тулд Иудейчүүдийн удирдагчид Паулыг яахаар оролдож байсныг эрж хай. Тэд амжилт олсон уу?

Хожмын өдрүүдэд Есүс Христ Өөрийн сайн мэдээг сэргээхэд үүнтэй төстэй нөхцөл байдал үүссэн билээ. Танхайрагч бүлгийнхэн Бошиглогч Иосеф Смитийг алчих юм бол сэргээгдсэн Сүм төгсгөл болно гэж бодож байсан хэдий ч, түүний бошиглосончлон, “ямар ч бохир гар уг ажлыг өсөн хөгжихийг зогсоож чадахгүй; . . . Бурханы үнэн тив бүхэнд нэвтэрч, нутаг бүрт айлчилж, орон бүрийг шүүрдэн, чих бүхэнд сонсогдох хүртлээ, Бурханы зорилгууд гүйцэлдэж, Агуу Иехова ажил хийгдэж дууслаа гэж хэлэх хүртэл зоригтойгоор, эрхэм ариунаар, мөн бие даан урагш гарч ирэх болно” (History of the Church, 4:540).



Судруудыг Ойлгох нь



Үйлс 24

Чилээх (ш.4)—Тавгүйтүүлэх
Хичээнгүйлэн (ш.4)—
Ялдамхнаар
Үймээн (ш.5)—Бослого,
үймээн самуун

Бузарлах (ш.6)—Бохирлох,
бузар болгох
Бүлэглэл (ш.14)—Хуурамч
сургаал
Хойшлуулж (ш.22)—
Тэднийг хүлээлгэж

Сйлс 24:27—Фест Гэж Хэн Байсан Бэ?

Порк Фест бол Иудейн захирагч болж Феликийн халааг авсан Ром хүн байв.

Үйлс 25

Хөдлөв (ш.1)—Явав
Ноцтой (ш.7)—Хэцүү
Давж заалдах (ш.11, 21,
25)—Цезарь Августын өмнө
шүүгдэх хүсэлт гаргах нь
Ромын иргэний эрх байв

Боломж (ш.16)—Эрх, зөв-
шөөрөл
Ихэд сүржин (ш.23)—
Өөрсдийгөө их чухал гэд-
гийг харуулан

Сйлс 25:13—Агрийп Хаан ба Бернике Гэж Хэн Бэ?

Энд дурьдагдаж байгаа Агрийп Хаан бол Херод Агрийп I-ийн хүү, Херод Агрийп II юм. Бернике бол түүний эгч.

Үйлс 26

Хүсье (ш.3)—Гуйя
Хамгийн чанд дэгтэй
бүлэглэл (ш.5)—Шашны
чанд хатуу бүлэглэл;
Фарисайчууд

Шилбүүрийг өшиглөх
(ш.14)—Сүнсний өдөөлтийн
эсрэг тэмцэх
Галзуу (ш.24)—Солиотой,
галзуу

Судруудыг Судлах нь




Үйлс 24–26-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А-Б) нэгийг нь хий.

А Шүүхийн Өрөөний Ажиглагч Бол

Үйлс 24 Феликийн өмнө Паул хоёр удаа шүүгдэхээр хүрч ирсэн тухай өгүүлдэг. Энэ хоёр шүүх хурал дээр дараах хүмүүсийн хэлсэн болон хийсэн зүйлийг нэгтгэн дүгнэж, та нар тэнд байгаад харж байгаа юм шиг асуултуудад хариулан тэмдэглэлийнхээ дэвтэрт бич:

1. Фелк, Паул нарын тухай Тертул юу гэж хэлсэн бэ? Энэ нь хэр зэрэг үнэн байв?
2. Паулын хэлсэн юу түүнийг баривчилсны жинхэнэ шалтгаан байсан бэ?
3. Паулын хэлсэн юу Феликийг дагжин чичрэхэд хүргэсэн бэ?
4. Яагаад Фелик Паулыг явуулаагүй вэ?
5. Бүр хүнд нөхцөлд ч гэсэн өөрсдийнхөө итгэдэг зүйлийн төлөө босох эрэлхэг зоригтой хэнийг та нар таньдаг вэ? Ийм эрэлхэг зоригийг хөгжүүлэхийн тулд та нар юу хийж болох вэ?



Б “Чи Чинь Намайг Богинохон Хугацаанд Христийнх Болгох нь ээ?”


1. Үйлс 26-г нэгтгэн дүгнэж, Фест, Ром хүн, Агрийп, Иудей хүнээс Паулын гэрчлэлд үзүүлсэн хариу үйлдлүүдийн ялгааг харьцуулж үз. Тэднээс хэн нь, “Чи чинь намайг богинохон хугацаанд Христийнх болгох нь ээ?” гэж хэлсэн бэ? Яагаад хүн тус бүр өөрсдийнхөө байдлаар хариу үйлдэл үзүүлсэн гэж та нар боддог вэ?
2. Өнөөдөр хүмүүс үнэнийг сонсоод бүрэн дүүрэн хүлээн авахаас юу тэднийг түдгэлзүүлж болох вэ?

Үйлс 27–28

Паул Ром уруу Явсан Бүх Замынхаа Туршид Гэрчлэв

Иудей дахь Ромын эрх баригчид Паулыг ямар ч буруу юм хийгээгүйг мэдэж, улмаар түүнийг суллан тавьж явуулан тус хүргэжээ. Гэвч Паул Цезарийн өмнө шүүх хурлаар орох хүсэлт тавьж, тийнхүү тэрээр Ром уруу илгээгдсэн ажээ (Үйлс 26:31–32-ыг үз). Энэ нь бидний хувьд тоогүй мэт санагдаж болох хэдий ч, Паулын хувьд хэрэг дээрээ адислал байлаа. Хэрэв тэрээр Иудейд суллагдсан бол, Иудейчүүд түүнийг хөнөөхөөр оролдохоо үргэлжлүүлэх байсан биз ээ. Түүнчлэн Их Эзэн бас түүнд, “Ромд ч бас гэрчлэлээ ярь” хэмээн хэлсэн байлаа (Үйлс 23:11). Паулыг эзэнт гүрний хоригдол болгож Ром уруу явуулсан нь, хэдийгээр уг аялал хэцүү бэрх

байсан ч гэсэн түүний хувьд тийшээ хүрэх хамгийн аюулгүй зам байлаа. Паулыг Их Эзэний зараалд байхад, түүнд олон бэрхшээл тохиолдож байсан ч гэсэн, Ром уруу явах бүх замынхаа турийд тэрээр бас гэрчлэх боломжтой байв. Хэрэв аялал илүү амар хялбар байсан бол Паулд олдсон боломжууд түүнд байх учиргүй байсныг ажигла.



Ром уруу хийсэн Паулын аялал

Сйлс 28:30—Паулын Амьдралын Сүүлчийн Жилүүд Паул шүүгдэж, тэгээд хоёр жилийн дараа Ромд суллагдсаныг бид өөр эх сурвалжуудаас мэддэг билээ. Тэрээр номлолынхоо хүчин чармайлтаар нилээд хэдэн өөр газарт очиж, магадгүй бүр Испани хүртэл аялсан бололтой. Дөрөв орчим жилийн дараа тэрээр дахин баривчлагдаж, Ромд аваачигджээ. Тэрбээр тэнд МЭ 65 оны хавар алагдсан бололтой.



Судруудыг Ойлгох нь



Үйлс 27

Эсрэг (ш.4)—Салхи сөрж

Мацаг барих (ш.9)—Цагаатгалын өдөр (Иом Киппур)

Сэрэмжлүүлж (ш.9)—Болгоомжлуулж

Тохиромжтой (ш.12)—Аятайхан, тавлаг, тухлаг

Усан онгоцыг бүслэн татах (ш.17)—Усан онгоцон доогуур татлагаар уях

Удаан хугацаагаар хоол ундгүй байх (ш.21)—Хоолгүй байсан удаан хугацаа

Тэнгисийн гүнийг хэмжих (ш.28)—Усны гүнийг хэмжихийн тулд ус уруу татлага хийх

Хорин алд (ш.28)—36.5 метр, нэг алд нь зургаан фут (1.8 метр)

Дүр үзүүлэн (ш.30)—Дүр үзүүлэх, ямар нэг юм хийж байгаа мэт байдал харуулах

Далан зургаан (ш.37)—Далан зургаа

Үйлс 28

Мальт (ш.1)—Мальт арал

Нутгийн хүмүүс (ш.2, 4)—Тэд соёл иргэншилгүйгээс биш, харин Грек буюу Латин хэлээр ярьдаггүй байснаас бүдүүлэг хүмүүс гэж нэрлэгддэг байжээ.

Хорт могой (ш.3)—Наж могой, хорт могой

Шударга ёс (ш.4)—Бурханы шударга ёс

Хангаж байв (ш.10)—Өгч байв

Зөвшөөрчээ (ш.16)—Зөвшөөрчээ, боломж олгожээ

Аргагүйн эрхэнд шаардсанд (ш.19)—Нөхцөл байдалд албадуулан

Тэр бүлэглэл (ш.22)—Христийн шашин, Есүс Христийн Сүм

Судруудыг Судлах нь



Үйлс 27–28-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Паул, Эцэж Цуцашгүй Номлогч

Ром уруу хийсэн Паулын аялал бэрхшээлүүдээр дүүрэн байсан хэдий ч, тэрбээр тэдгээрийг боломжууд болгон хувиргасан юм.

1. Үйлс 27–28 Паул бусдад заах хийгээд тэднийг адислахад олон боломжуудыг хэрхэн ашигласан тухай өгүүлдэг. Боломж бүрийг тэмдэглэлийнхээ дэвтэрт дүрсэлж, түүний итгэл хийгээд эрэлхэг зоригийн учир Паулд болон бусдад ирсэн адислалуудыг жагсаан бич.
2. Төлөөлөгч Паулын тухай мэдсэн бүх зүйлээ эргэн бодож, өөрсдөд тань их сэтгэгдэл төрүүлсэн, түүнд байсан нэг зан төлөв буюу чанарыг дүрсэл. Энэ чанарыг харуулдаг хамгийн наад тал нь нэг жишээг Паулын амьдралаас иш тат.
3. Тэр чанарыг амьдралдаа улам сайнаар хөгжүүлэхийн тулд та нар юу хийж болох вэ?

Ромчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Захидал



Ромын ном нь Паулын захидал хэмээн нэрлэгддэг Шинэ Гэрээний хэсгээр эхэлдэг. Эл захидал бол “зүгээр нэг захианаас илүү зүйл; энэ бол заах албан ёсны зэмсэг юм.” Паул өөрийн захидлуудаа хол газруудад суугаа Гэгээнтнүүдэд Сүм өсч хөгжихийн тухайд тэднийг тайтгаруулж, зөвлөгөө өгөхөөр бичжээ. Паулын Захидлуудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг энэ гарын авлага дахь “Шинэ Гэрээг Урьдчилан Тоймлох нь — Агуулгын товъёог” (х.iii-v)-гээс үз.

Ромчуудад Хэзээ Бичсэн Бэ?

Төлөөлөгч Паул Ромчуудад зориулсан захидлаа өөрийн номлолын гурав дахь аяллыг дуусахаас өмнө (МЭ 57–59 оны орчимд; Есүс Христийн Амилуулалтаас хойш ойролцоогоор хорин тав орчим жилийн орчим) бичжээ. Тэр үед тэрээр Коринтод байсан бөгөөд Иерусалим уруу хийсэн сүүлчийн аялалдаа яваагүй байлаа. Ромчуудын тухай дэлгэрэнгүй мэдээлэл болон ерөнхий тоймыг Ромчуудад бичсэн захидал хэсгээс үз.

Паулын Бичсэн Ромчууд Хэн Байсан Бэ?

Ром бол Ромын Эзэнт гүрний хамгийн том хот бөгөөд нийслэл нь байлаа. Паул бүх Ромчуудад биш, харин багтисм хүртэж, Ариун Сүнсний бэлэг хүлээж аван, сайн мэдээний зарчмуудын талаар үндсэн ойлголттой болсон Сүмийн гишүүдэд хандан бичсэн юм. Паулын бичсэн сэдвүүд Сүмээс гадуурх хүмүүст ойлгоход хэцүү буюу будилж самуурахад хүргэж болох байв. Ромын ном нь өнөөдөр ч гэсэн Христийн сүмүүдийн дунд сургаалыг буруугаар ойлгох явдлын эх сурвалж болсон хэвээр байна. Гэвч, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд Ромыг сайн мэдээний заадаг зүйлүүдийн эрдэнэсийн сан хөмрөг, мэргэн зөвлөгөө гэж хүлээн зөвшөөрдөг билээ, учир нь Ариун Сүнсний бэлэг, эртний хийгээд өнөө үеийн боциглогчдын сүнсээр нөлөөлөгдсөн удирдамж тэнд байдаг.



Ромын Зарим Чухал Сургаалууд

Ром нь Паулын сургаалын заадаг зүйлүүдээс хамгийн яруу сайхан заримыг нь агуулдаг. Үүний ихэнх хэсэг нь

Мосегийн хуулийн дагуу амьдрах нь зайлшгүй гэдэгт итгэдэг байсан Христэд итгэгч Иудейчүүдийн эсрэг итгэлтэй нотолгоо юм. Сайн мэдээний хууль Мосегийн хуулийг халсныг тэрээр заадаг байсан бөгөөд Бурханы адислалуудыг хүлээн авахын тулд хүн болгон бүрэн хуулийг сахихыг шаардах аваас, энэ нь бүтэхгүй юм гэдгийг тайлбарлажээ. Есүс Христээс өөр хэн ч нүгэлгүй амьдралаар амьдарч байгаагүй буюу амьдрах нь үгүй билээ.

Хуулийн хувьд зөв болох (*зөвтөгдөх* гэдэг үгийг тэр ашигласан) цорын ганц арга бол Их Эзэнд итгэх итгэлтэй байж, нүглүүдээ наманчлан, мөн зарлигуудыг сахихаар хичээн зүтгэх явдал мөн гэдгийг Паул онцлон заасан байдаг. Есүс Христийн хүч хийгээд ач ивээлээр дамжуулан, бидний хүн нэг бүр ариун, зохистой болж, Бурханд байгаа бүхнийг хүлээж аван, Аврагчийн хамтын өв залгамжлагчид болдог гэдэг өөрийн гэрчлэлийг Паул оруулжээ.

Ром 1

“Христийн Сайн Мэдээнээс Би Ичдэггүй”

Есүс Христийн сайн мэдээ нь биднийг энэ амьдралд амар амгалан хийгээд аз жаргалд, түүнчлэн Тэнгэрлэг Эцэгтэйгээ хамт мөнх амьдрал өөд хөтөлдөг замаар хангадаг. Нөгөө талаар, гай зовлон хийгээд устгал уруу хөтөлдөг замыг дагуулахаар Сатан биднийг уруу татдаг. Ром 1-д Паул хоорондоо ялгаатай эдгээр замуудыг амьд тодорхойгоор дүрсэлсэн байна. Тэгээд тэрбээр аль замыг дагахаар сонгосноо зоригтойгоо мэдэгдэхдээ: “Учир нь би Христийн сайн мэдээнээс ичихгүй; учир нь энэ бол итгэдэг хүн бүрийг авралд хүргэх Бурханы хүч юм” гэжээ (Ром 1:16).

Судруудыг Ойлгох нь



Ром 1

Үр удмаас төрсөн (ш.3)—
Үр удам

Үр дүн (ш.13)—Сайн
мэдээнд хөрвөгчид

Бусад үндэстнүүд (ш.14)—
Гадаадынхан

Уур хилэн (ш.18)—
Шийтгэл, хилэгнэл

Хорон муу санаа (ш.29)—
Бусдад хор хүргэх санаа

Үзэн ядах (ш.29)—Ихэд
дургүй байх

Хов жив яригчид (ш.29)—
Хов хөөцөлдөгчид,
гүтгэгчид

Үл хайрлагч (ш.31)—
Гэр бүл найз нөхдөө
хайрладаггүй

Ром 1:24–32—“Бурхан бас Тэднийг Орхисон”

Хүмүүс Бурханыг эсэргүүцэхэд Тэрбээр “тэднийг орхидог,” эсвэл тэднийг нүглүүдийнх нь төлөөх шийтгэлд зовохоор тэднийг орхидог. Ийнхүү орхих нь Бурхан хүүхдүүддээ хайргүй гэсэн үг биш, харин ёс бус хүмүүс Түүнийг орхисон болохоор Тэр тэдэнд тусалж чадахгүй байгаа юм. Паулын хэлсэнчлэн тэд Бүтээгчийн оронд нүглийн бүтээлий шүтэн бишрэхээр, мөн түүнд үйлчлэхээр сонгодог (Ром 1:25-ыг үз). Шүлэг 24-27-д Паулын хэлсэн “цэвэр бус байдал,” “гутамшигт хүсэл тачаал” гэдэг үгс нь ижил хүйстэнтэйгээ хурьцах болон бэлгийн харьцааны бусад нүглүүд юм.

Судруудыг Судлах нь

Ром 1-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Төгс Эзэмших Судар—Ром 1:16

Үйл хөдлөл үгнээс илүү үр нөлөөтэй байдаг. Есүс Христийн сайн мэдээнээс ичдэггүй гэж Паул хэлсэн бөгөөд түүний үйл хөдлөл үүнийг нотолсон юм. “Төлөөлөгч Паул аймшиггүй, Есүсийн тухай гэрчлэлдээ хэзээ ч гуйвшгүй байсан юм. Түүний итгэл хийгээд шийдвэр төгс байдал түүнийг майхан хийгчээс Христийн сүмийн салбаруудын багш, номлогч, удирдагч, зохион байгуулагч болгосон билээ. Тэрбээр аймхай хулгар ч, сул дорой ч байгаагүй нь хамгаас тодорхой юм. Агуу итгэлтэй хүмүүс юу зөв бэ гэдгийг мэддэг мөн үүнийгээ хийдэг. Гандан бууршгүй шийдвэр төгс байдал хийгээд үүргээ ухамсарласан чанар тэдэнд байдаг, түүнчлэн дарамт болоод бэрхшээл саадыг даван туулах чадвартай байдаг билээ. Юу зөв бэ гэдгийг Паул мэддэг байсан, мөн та нар ч юу зөвийг мэддэг. Та нар Паулын нэгэн адил зориг гаргаж, зөв гэдгийг нь мэддэг зүйлээ хийх юм бол, зөвхөн өөрсдөөс тань өөр юу ч өсөлт хөгжилтийг тань зогсоож чадахгүй” гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Давид Б.Хейт хэлжээ (in Conference Report, 1991 оны 10-р сар, 50; *Ensign*, 1991 оны 11-р сар, 36–37).



Сонгож авсан судруудаа уншсаны дараа Паул сайн мэдээнээс ичдэггүй байсан гэдгийг нотлон харуулах та нарын итгэдэг, түүний хийж байсан өвөрмөц зүйлүүдээс наад зах нь тавыг жагсаан бич.


Б Өөрсдийн Сгээр

Ром 1:24–32-ын “Судруудыг Ойлгох нь” хэсгийг унш.

1. Ром 1:24–32-ыг унш.
2. “Бурхан тэднийг орхисон” гэх мэт өгүүлбэрийг агуулсан шүлэг бүрийг жагсаа.
3. Энэ өгүүлбэр ямар утгатайг өөрсдийн үгээр тайлбарла (Тусламж болгож Мозая 2:36–37-г үз).

Ром 2

Бурхан Бидний Ажлуудын Дагуу Биднийг Нэг Бүрчлэн Шагнах Болно



Есүс Христ, Зөв Шударга Шүүгч

Та нарт хэн нэгнийг буруу зүйл хийлээ гэж шүүмжилсэн хэрнээ дараа нь өөрсдөө яг ийм юм хийснээ мэдсэн явдал тохиолдож байсан уу? Энэ бол Паулын үе дэх Сүмийн гишүүдийн дунд байсан нийтлэг дутагдал юм. Бидний олонтаа шүүдэг арга зам, Бурхан шүүдэг арга замын хоорондох ялгааны тухай Паулын заадаг зүйлүүдийг ажигла.

Судруудыг Ойлгох нь

Ром 2

Гэмшдэггүй (ш.5)—
Наманчилдаггүй

Уур хилэн ба хилэгнэл
(ш.8)—Хилэгнэл болон уур

Ром 2:14–29—“Учир нь Тэр Бол Гаднах Байдлаараа Иудей Хүн Биш”

Хэрэв Христэд итгэгч Иудейчүүдэд итгэлийн сүнс болон дуулгавартай байдал байхгүй байх аваас, зөв шударга байдлын гадна талын тэмдгүүд (хөвч хөндөх мэтийн) ямар ч утга учиргүй юм гэдгийг Паул заадаг байлаа. Мөн энэ нь өнөөдөр ч гэсэн үнэн юм. Зөв шударга байдлын гадна талын тэмдгүүд (Сүмд ирдэг гэх мэт) хангалтгүй. Итгэлийн сүнс, хайр хийгээд дуулгавартай байдал бидний зүрх сэтгэлд оршдог байх ёстой.

Судруудыг Судлах нь

Ром 2-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий


А Өөрсдийн Сгээр

Бусдыг шүүх тухай түүнчлэн Их Эзэн бидний хүн бүрийг шүүх тухай Паулын заадаг зүйлүүдийг анхааралтай авч үзэн, Ром 2:1–2, 5–11-ийг уншиж, гол санаануудыг бич.

Ром 3

Христ Хүн Бүгдэд Хэрэгтэй

Бурханы шүүлт хүн бүрийг хүлээдэг гэдэгт Паул Ромын Гэгээнтнүүдийг сэрэмжлүүлдэг байлаа. Ёс бус байдал хийгээд дуулгаваргүйн улмаас хүн бүр төгс байдалд хүрч чадахгүй болж, улмаар Түүнд Аврагч, Гэтэлгэгч хэрэгтэй болдог. Есүс Христ бол бидний Аврагч. Түүнд итгэх итгэл болон үнэн наманчлалаар дамжуулан шударга хийгээд хайрлагч Бурханы буруутгалаас бид зайлсхийж болохын тулд Тэрээр бүх хүн төрөлхтнийг гэтэлгэсэн юм.



Хуулийг хэн ч төгс сахьдаггүйн улмаас бид бүгдэд Аврагч хэрэгтэй

Судруудыг Ойлгох нь



Ром 3

Бурханы үгс (ш.2)—

Бурханы үгс

Бялхдаг (ш.7)—Нэмэгддэг, ихэсдэг

Гүтгэн хэлдэг (ш.8)—Худал хэлдэг

Эвлэрүүлэл (ш.25)—

Золиослол буюу нүглийн төлөөс

Тэвчин өнгөрүүлсэн

(ш.25)—Бидний нүглүүдийн төлөөх золиослол буюу төлөөс

Ром 3:12–20—“Тэдний Хоолой нь Онгорхой Булш Юм”

Бидний яриа бид дотоод сэтгэлээрээ хэн гэдгийг хэрхэн илчилдгийг тайлбарлахын тулд Паул энгийн зүйлүүдийг ашигладаг байв. Бунхан бол булш гэсэн үг бөгөөд “тэдний хоолой онгорхой булш юм” гэсэн өгүүлбэр нь тэдний үгс зүрх сэтгэлийнх нь ялзралыг харуулдаг гэсэн утгатай юм. Урт хорхой гэдэг нь могой бөгөөд “Тэдний уруул дор могойн хор бий” гэдэг нь тэдний хэл хортой, өөрсөддөө болон бусдад хор хохирол учруулдаг гэсэн утгатай юм.

Ром 3:23—Бид Бүгд “Бурханы Алдар Сууд Хүрдэггүй”


Бид бүгд Бурханы хуулиудыг зөрчсөн, тиймээс бид цэвэр, гэм зэмгүй (зөвтгөгдсөн) хэмээн хуулиар тунхаглагдсан байж чадахгүй (1 Иохан 1:8-ыг үз). Хууль нь зөвхөн бид хаана буруу явсныг л бидэнд харуулж чадна. “Бурханы алдар сууд хүрч чадахгүй” (Ром 3:23) учраас, бидний нүглүүдийн улмаас цагаатгал хийсэн Есүс Христийн ач ивээл хийгээд нигүүлслээр дамжихаас бусдаар авралын найдвар бидэнд үгүй билээ (Ром 3:24–25; 2 Нифай 2:8).

Судруудыг Судлах нь



Ром 3-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Судрыг Өнөө Сейн Зөвлөгөөнд Холбогдуулах нь



Ром 3-ыг уншиж, шүлэг 10–12, 20–25 нь: “Цагаатгалын утга учрыг бүрэн дүүрэн ойлгохын төлөө бид чармайх ёстой. Гэвч бид үүнийг бүрэн дүүрэн ойлгохын өмнө, бид Адамын уналтыг ойлгох ёстой” гэсэн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн Ахлагч Рассел М.Нелсоны нотолгоог дэмждэг билээ (in Conference Report, 1993 оны 10-р сар, 45; Ensign, 1993 оны 11-р сар, 33).

Дээрх “Судруудыг Ойлгох нь” хэсгийг унших нь тустай байж болно.

Ром 4–5

Есүс Христэд Итгэх Итгэл Бол Нүглийг Даван Туулах Түлхүүр Мөн

Өөрсдийнхөө сул талуудыг хормын төдийд анхааралтай бод. Өөрсөддөө учрах уруу таталтуудыг хэрхэн илүү сайнаар даван туулж чадахаа хэзээ нэгэн цагт бодож байсан уу? Их Эзэнтэй харилцах харилцаагаа сайжруулж, зөв шударгаар амьдрахын тулд илүү хүчтэй байхаар та нар юу хийж болох вэ?

Абрахамд Мосегийн хууль байгаагүй ч гэсэн тэрээр итгэлийн үлгэр жишээ байж, зөв шударга амьдралаар амьдарч байсныг Паул Христэд итгэгч Иудейчүүдэд сануулдаг байжээ. Мосегийн хууль хожим нь дуулгаваргүй байдлын улмаас нэмэгдсэн юм. Израилын хүүхдүүдэд илүү өндөр хуулийн итгэл хүлээлгэхийн өмнө уг хуулийг дуулгавартай дагаж сурах нь тэдэнд хэрэгтэй байлаа.

Эрин үе бүхэнд Мосегийн хууль биш, харин Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл нь нүглийг даван туулж, зөв шударга амьдрахын түлхүүр байсныг Паул хүмүүст заадаг байв.

ашигладаг байв. Бүр Мосегийн хууль өгөгдөхөөс өмнө Абрахам зөв шударга гэж нэрлэгддэг байсан юм. Дараах өгүүлбэрүүдийг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, Ром 4:9–25-ыг уншиж, тэдгээрийг гүйцээ.

Судруудыг Ойлгох нь



Ром 4

Үйлсээрээ зөвтгөгдсөн (ш.2)—Нүглийг даван туулах хийгээд авралыг олохын тулд хүний сайн үйлс дангаараа хангалттай гэж үздэг хуурамч санаа.

Тооцогдох, тооцогдсон, тооцогддог (ш.6, 8, 11, 22, 23–24)—Тооцогдох, үзэгдэх

Ром 4:2–5—Иосеф Смитийн Орчуулгаас Ирдэг Нэмэлт Ойлголт

Хэрэв бид өөрсдийгөө аврах хуулинд дуулгавартай байхаас хамааралтай юм бол, бид илүүг биш, зөвхөн өөрсдийнхөө олсныг л авч байх ёстой гэдгийг ойлгоход Иосеф Смитийн Орчуулга бидэнд тусалдаг. Гэвч бид Бурханд итгэлтэй байж, дуулгавартай байхыг хичээх юм бол, бидний итгэл зөв шударга байдалд тооцогдож, бидний нүглүүд өршөөгдөх болно.

Ром 4:9–12—Хөвч Хөндөлтийн Талаарх Энэ Яриагаараа Паул Юу Хэлсэн бэ?

Хөвч хөндөлт гэдэг үг энд Мосегийн хуулийн бэлэгдэл болж хэрэглэгдсэн байна. Олон Иудейчүүд зөвхөн тэд л өөрсдийг л зөв шударга хэмээн нэрлэгдэж чадна, учир нь зөвхөн тэд л Мосегийн хуулийг сахьдаг гэж боддог байлаа. Уг хууль Мосед өгөгдөхөөс урт удаан хугацааны өмнө Бурхан Абрахамыг итгэлийнх нь учир зөв шударга хэмээн нэрлэснийг Паул тэдэнд сануулдаг байв.

Ром 5

Харуулсан (ш.8)—Үзүүлсэн, харуулсан

Бурхантай эвлэрүүлэгдсэн (ш.10)—Бурханд сайнаар хандах болсон


Нүгэл хэмээн тооцогдохгүй (ш.13)—Нүглээр нь шийтгэхгүй

Адил байдлаар (ш.14)—Адил төстэй байдлаар

Бялхагдсан (ш.15, 20)—Хэт ихээр ирсэн

Ром 5:12–21—“Нэг Алдаа Зөрчлөөс Болж . . . Нэг Зөвт Сйлээс Болж”

Нэгний (Адам) гэмээс болж, үхэл болоод нүгэл дэлхийд нэвтэрсэн. Өөр нэгний (Есүс Христ) үүргээр дамжуулан бид Бурханы бэлгийг хүлээн авч, үхэл нүглээс аврагдаж чадна (1 Коринт 15:21–22-ыг мөн үз).



1. Абрахам итгэлийнхээ _____ байжээ (ш.11-ийг үз).
2. Абрахамд өгөгдсөн амлалтууд нь _____, харин _____ иржээ (ш.13-ыг үз).
3. Бурханы амлалт _____ учир _____ ирдэг. Ингэснээр тэрхүү амлалт _____ боломжтой болдог (ш.16-ийг үз).
4. Есүс Христ бидний _____ болж алагдсан бөгөөд, мөн Түүний Амилуулалтаар дамжин бид _____ (ш.25-ийг үз).

А Гэрчлэлээ Бич

Ром 5:12–21-ийг уншсаны дараа, Есүс Христийн тухай болон өөрсдийн тань Аврагч болох Түүний үүргийн тухай гэрчлэлээ бич.



Судруудыг Судлах нь



Ром 4–5-ыг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Абрахам, Итгэлийн Слгэр Жишээ

Бурханд итгэх итгэл бол зөв шударга байдлын эхлэл мөн гэдгийг харуулахын тулд Паул Абрахамын үлгэр жишээг

Ром 6

“Мөнх Бус Биенд Чинь . . . Нүгэл Бүү Ноёрхог”

Цагаан хувцас өмсөж, баптисмын сангийн дэргэд зогсож байгаа шинэ хөрвөгчийг санаандаа дүрслэн бод. Ийм нөхцөлд байгаа хүнийг дүрслэхийн тулд та нар ямар үгсийг ашиглаж болох вэ?

Нүглүүдээ арилгаж, бие сэтгэлээ Бурханд өргөн барьж, Христэд ирэхэд нь Төлөөлөгч Паул Гэгээнтнүүдийг урамшуулан дэмждэг байв. Итгэл, наманчлал болон Их Эзэнтэй ариун гэрээнүүд хийж, сахиснаар бид Паулын зөвлөгөөг дагаж чадна.

Судруудыг Ойлгох нь



Ром 6

Ихсэх (ш.1)—Нэмэгдэх

Махан бие сул дорой
(ш.19)—Махан биеийн сул
дорой байдал

Ром 6:4—“Баптисмаар Түүнтэй Хамт Оршуулагдсан”

Бид “түүнтэй хамт баптисмаар оршуулагдсан” гэдэг нь ямар утгатай вэ (Ром 6:4)? Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн Ахлагч Рассел М.Нелсон, “Аврагчаас ирдэг үхэшгүй байдлын бэлэг нэгэн цагт амьдарч байсан бүх хүмүүст ирдэг. Гэвч Түүнээс ирдэг мөнх амьдралын бэлэг нь наманчлал хийгээд өвөрмөц тусгай ёслолууд болон гэрээнүүдэд дуулгавартай байх явдлыг шаарддаг. Сайн мэдээний чухал ёслолууд нь Цагаатгалыг бэлэгддэг. Усанд умбуулалтаар баптисм хүртээх нь үхэл, оршуулга, түүнчлэн Гэтэлгэгчийн Амилуулалтыг бэлэгддэг” гэж сургасан байдаг (in Conference Report, 1996 оны 10-р сар, 47; *Ensign*, 1996 оны 11-р сар, 35).

Судруудыг Судлах нь



Ром 6-г судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Таван Минутын Яриа Бич

Эрэгтэй буюу эмэгтэй дүүгийнхээ баптисмын үйлчлэл дээр үг хэлэхийг өөрөөс тань хүсчээ гэж бод. Баптисмын бэлэгдлийн тухай ярих даалгавар авчээ. Ром 6-д өөрсдийн олсон мэдээллийг ашиглан, уг үйлчлэл дээр хэлэх таван минутын яриа бич. (Ярианыхаа хэсэг болгож, наад зах нь судрын гурван шүлэг оруул.)

Ром 7

Есүс Христ Мосегийн Хуулийг Гүйцэлдүүлэв

Ром 7 нь Есүс Христ Мосегийн хуулийг гүйцэлдүүлж, сайн мэдээг авчирсны дараа Мосегийн хууль шаардлагагүй болсон тухай Паулын заадаг зүйлүүдийг агуулдаг. Иосеф Смит энэ бүлэг дэх хорин таван шүлгийн хорин нэгд нь өөрчлөлт оруулсан билээ. Жэймс Хааны Хувилбарт эдгээр шүлгүүд зохих ёсоор орчуулагдаагүй учраас тодорхой биш байгаа шүлэг 13–24-ийг ажигла.

Судруудыг Ойлгох нь



Ром 7

Шунахайрал (ш.8)—
Хориглосон зүйлийг хүсэх

Хөөрхийлөлтэй (ш.24)—
Зовсон

Махан бие (ш.14)—
Хүмүүний мөн чанарт захи-
рагдах, эгэл хүн

Судруудыг Судлах нь



Ром 7-г судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Та Нар Юу Гэж Бодож Байна

Ром 7-г судлахдаа дараах асуултуудад хариул:

1. Ром 7-гийн гол захиасыг юу гэж бодож байна?
2. Энэ бүлэгт хэрхэн Ариун Сүнс уруу таталтыг даван туулахад тусалдаг талаар бидэнд юу заадаг вэ?

Ром 8

“Христийн Хамтран Залгамжлагчид”

Ром 8-д байдаг амлалтууд сэтгэл хөдөлгөм хийгээд урам оруулагч юм. Паулын эдгээр үгсийг уншихаасаа өмнө: “[Та нар] Бурханы өв залгамжлагчид мөн Есүс Христтэй нэгдсэн өв залгамжлагчид байх болно. Энэ тань юу гэсэн үг вэ? Бид Бурханы суудалд очин, өмнө нь очсон тэдний



нэгэн адил, мөнхийн хүчний хаан сэнтийд хурч, мөнхүү хүч, алдар суу хийгээд өргөмжлөлийг өвлөх болно” гэсэн Бошиглогч Иосеф Смитийн нотолгоог анхааралтай авч үз (Teachings of the Prophet Joseph Smith, 347).

Ром 9–10

Христийн Хуулийн Дагуу Амьдрах нь

Зөвхөн зохистой амьдардаг Сүмийн гишүүд, энэ амьдралын төгсгөл болоход сайн мэдээний бүрэн адислалуудыг хүлээн авах болно. Христэд итгэх итгэлээр амьдардаггүй бөгөөд зарлигуудыг сахьдаггүй гэрээт охид, хөвгүүд сайн мэдээний адислалуудаа алддаг гэдгийг харуулахын тулд Иаков, Есав хоёрын тухай түүхийг Паул ашигласан байдаг. Зүгээр л Сүмийн гишүүн байх нь хангалттай юу? Есүс Христэд итгэх итгэл илүү зөв шударга амьдрахад тань та нарт хэрхэн тусалж чадах вэ?

Судруудыг Ойлгох нь



Ром 8

Махан биеийн бодол санаа (ш.6, 7)—Чивэлт буюу хилэнцэт хүсэл бодолтой
Дайсагнал (ш.7)—Үзэн ядалт, хүчтэй дургүйцэл
Үрчлэлийн Сүнснийг хүлээн авсан (ш.15)—Бурханы сүнсэн хүүхдүүд болох

Өв залгамжлагчид (ш.17)—Ямар нэг юмыг хүлээж авах буюу өвлөх эрхтэй хүмүүс
Төрөх зовлонг эдэлдэг (ш.22)—Хүүхэд төрөх үеийн өвдөлтийг тэвчдэг
Зуучлан гуйдаг (ш.26, 34)—Өмнөөс нь хүсэх, зуучлах

Ром 8:15—А66а

Ахлагч Брус Р.МакКонки, “Abba (Аав) гэдэг нь Эцэг гэсэн Араб үг юм; Мөнхийн Эцэгийн гэр бүл дэх өргөмөл хөвгүүд нь Ертөнцийн Захирагч болох түүнийг ийнхүү дотноор нэрлэх онцгой боломжтой юм” гэж сургажээ (Doctrinal New Testament Commentary, 2:261).

Судруудыг Судлах нь



Ром 8-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Эцэгт Байдаг Бүхнийг Өв Залгамжлах нь

Ром 8:13–18; Сургаал ба Гэрээ 84:33–42; тэрчлэн 132:19–21-ийг уншиж, сэлэстиэл хаант улс болон Тэнгэрлэг Эцэгт байдаг бүхнийг өв залгамжлах хүмүүст амлагдсан адислалуудын цар хүрээг тунгаан бод.

1. Христийн Цагаатгалаар хангагддаг адислалуудыг хүлээн авахад юу шаардагдах вэ?
2. Та нар ямар адислалыг хамгийн чухал гэж боддог вэ?
3. Та нар яагаад амлагдсан адислалыг хүлээн авахад дуртай байдаг вэ?

Судруудыг Ойлгох нь



Ром 9

Махан биеийн хүүхдүүд (ш.8)—Дэлхийн буюу эгэл хүмүүс
Сонголт (ш.11)—Мөнх бус байдлын өмнөх үед хийсэн сонголт

Уур хилэнгийн савнууд (ш.22)—Дуулгаваргүй хүмүүс
Зориулагдсан (ш.22)—Бэлтгэгдсэн

Ром 9:3—Паул Яагаад “Христээс Салгагдаж, Өөрөө Хараал Болохыг” Хүссэн Бэ?

Паул “Христээс салгагдахыг” хүссэн үү (Ром 9:3)? Тэрээр Есүс Христийн Сүмийг мөшгин хавчиж байсан үеэ хэлсэн бололтой.

Ром 9:4–5—“Срчлэлт Хэнд Хамаатай Вэ?”

Сайн мэдээнд хөрвүүлэгдэхийг Паул үрчлэлтээр төлөөлүүлэн ашиглажээ. “Үрчлэлт тэднийх юм” (Ром 9:4) гэсэн нь сайн мэдээг хүлээн авч, үүний заадаг зүйлүүдийн дагуу амьдарч байсан Израилын угсааных биш хүмүүсийг хэлжээ. Тэд Абрахамын гэр бүлд үрчлэгдэж тийнхүү жинхэнэ Израилчууд болсон ажээ. Бошиглогч Иосеф Смит, “Харьд үзүүлсэн Ариун Сүнсний нөлөө нь хуучин цуснаас гадуур шавдуулж, түүнийг үнэнхүү Абрахамын үр удам болгосон юм” хэмээн сургажээ (Teachings of the Prophet Joseph Smith, 150).

Ром 9:30–33—Бүдрүүлэх Чулуу Юу Байсан Бэ?

Есүс Христ бол Иудейчүүдийн дээр нь бүдэрсэн хад буюу чулуу юм (Ром 9:32-ыг үз). Тэрбээр Мосегийн хуулийг гүйцэлдүүлж, сайн мэдээг бүрнээр нь сэргээсэн хэдий ч, Иудейчүүд Түүнийг эсэргүүцэж, тэд Түүний тусламжгүйгээр “хуулийн ажлуудаар” аврагдаж чадна гэдэгт итгэдгээр үргэлжлүүлсээр байжээ (Ром 9:32).

Ром 10

Хичээл зүтгэлтэй (ш.2)—
Урам зоригтой

Хуулийн төгсгөл (ш.4)—
Хуулийн зорилго

Атаархуулж (ш.19)—Хутган
үймүүлж

Гараа сунгасан (ш.21)—
Туслахаар гараа сунгасан

Судруудыг Судлах нь

Ром 9–10-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Хэн Сүмийн Жинхэнэ Гишүүн Бэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон, “Сүм өөрийнх болох Түүний хувьд гишүүнчлэл нь зөвхөн бүртгэлээр гишүүн байхаас хавьгүй илүү зүйл юм” гэж хэлжээ (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 165).

1. Ром 9:6–8, Сургаал ба Гэрээ 10:67-г унш. Есүс Христийн Сүмийн “бүртгэлийн гишүүн” байхаас илүү байхын тулд хүн юу хийх ёстой вэ?
2. Сүм дэх гишүүнчлэлээ бэхжүүлэхийн тулд та нар юу хийж болох вэ?

Б Бурханы Сонгосон Хүмүүс Хэн Бэ?

Ром 9:18–24-ийг уншиж, Паул хүмүүсийг хэрхэн “савнууд” (сав суулга) хэмээн дүрсэлснийг ажигла. Сайн мэдээг эсэргүүцдэг хүмүүс бол “уур хилэнгийн савнууд” бөгөөд Есүс Христийг дагадаг хүмүүс нь “нигүүлслийн савнууд” юм. Сайн мэдээг хүлээн авч, зөв шударга байдлаар дамжуулан “нигүүлслийн савнууд” болдог харийнхан Израилын угсааны нэгэн адил мөнхүү адислалуудыг хүлээн авах болно.

1. Ром 9:25–26-г уншиж, харийнхан Бурханы сонгосон удмынх биш байсан хэдий ч, харин үүний нэг хэсэг болсныг харуулсан үгс болон өгүүлбэрүүдийг жагсаан бич.
2. Ром 9:30–33-ыг уншиж, яагаад олон Иудейчүүд Бурханы сонгосон удам дахь байр сууриа алдаж, уг байр суурь харийнханд өгөгдсөнийг тайлбарла.



Дэлхий дахинаас Израил цуглуулагдах нь

В Судруудын Жагсаалтыг Ол

1. “Израилын төлөө Бурханд хандсан залбиралдаа” Паул юу хүссэн бэ (Ром 10:1)?

2. Ром 10:9–13-ыг уншиж, Паулын залбирлыг гүйцэлдүүлэхийн тулд бидний хийх ёстой гурван зүйлийг жагсаан бич.
3. Ром 10:14–15-д, хүн аврагдахын тулд хэрхэн итгэл олж авахыг бидэнд өгүүлдэг “хэрхэн” гэсэн дөрвөн асуултыг Паул жагсаасан байдаг. Асуулт бүрийг өөрсдийн үгээр дахин бичиж, хүмүүст Паулын ярьж байсан зүйлийг тайлбарла.

Ром 11

Сайн Мэдээ Бурханы Бүх Хүүхдүүдэд Зориулагдсан Юм

Мөнх бус байдлын өмнөх амьдралд олон хүмүүс зөв шударга байдлынхаа учир Израилын угсаанд төрөх адислал хүлээж авдаг. Гэвч хэрэв тэд сайн мэдээний дагуу амьдрахыг эс сонгох аваас адислалуудаа алддаг. Анхнаасаа Израилын угсааных биш харийнхан Их Эзэнтэй гэрээнүүд хийж, сахиснаар сайн мэдээний бүрэн адислалуудыг хүлээн авч чадна (2 Нифай 30:2-ыг үз). Сайн мэдээний авчирдаг адислалуудыг Өөрийнх нь бүх хүүхдүүд эдлээсэй гэж Тэнгэрлэг Эцэг хүсдэг.

Судруудыг Ойлгох нь

Ром 11

Үлдэгсэд (ш.5)—
Итгэгчдийн үлдсэн зарим нь
Атаархлыг хөдөлгөх (ш.11,
14)—Өдөөн хатгах
Атаархал (ш.14)—Өөр нэг-
ний жишээг дагах
Эвлэрэл (ш.15)—Эв зохиц-
лыг сэргээх

Мөчрүүдийн эсрэг бүү
сайрх (ш.18)—Өөрийн
өвийн үнэ цэнийг өндрөөр
үнэлэх
Ихэмсэг (ш.20)—Бардам
Хатуу байдал (ш.22)—Хүнд
байдал

Ром 11:25—“Харийнханы Бүрэн Байдал”

“Харийнханы бүрэн байдлын” тухай Ахлагч Брус Р.МакКонки дараах зүйлийг заасан байдаг: “Абрахам болон Христийн хоорондох бараг хоёр мянган жилийн туршид Бурханы хууль дүрмүүд болон шүүлтүүд нь бараг л Абрахам хийгээд Израилын угсаагаар дангаар нь хадгалагдаж ирсэн юм. Бидний Их Эзэний мөнх бус байдал дахь тохинууллын үед захиас нь зөвхөн Изриалаар, Иудейчүүдээр хязгаарлагдаж байсан бөгөөд тэгэхэд энэ нь харийнханд санал болгогдоогүй байв. Есүсийн амилуулалтын дараа Харийнханд сайн мэдээг номлох үүд хаалгыг Петр нээж, мөн Паул тэдний ерөнхий төлөөлөгч өмгөөлөгч бөгөөд багш болжээ. Тийнхүү Иудейчүүдийн хувьд үгийг сонсох цаг буюу хугацаа томилогдсон бөгөөд дараа нь Харийнханы хувьд чухалд тооцогдох цаг иржээ. Харийнханы цаг хугацаа нь сайн мэдээ тэдэнд

онцгой халамж анхаарлын үндсэн дээр хүрч ирэх үе бөгөөд, ийнхүү энэ нь тэд үнэнийг хүлээн авах бүрэн боломжтой болох хүртэл буюу өөрөөр хэлбэл, Харийнханы бүрэн байдал хүртэл үргэлжлэх болно. Дараа нь захиас Иудейчүүдэд, Иудейчүүд нь үндэстний хувьд мөн хүмүүсийн хувьд гэдэг утгаар дахин очих болно”.

Ром 11:1–5—Ач Ивээлийн Сонголт

Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө нь Түүний бүх хүүхдүүд сайн мэдээг хүлээн авах буюу эсвэл эсэргүүцэх боломжтой байхыг шаарддаг. Үүнийг бодитой болгохын тулд сүнснүүдийг Абрахамын удмаар дамжуулан ах эгч нартаа сайн мэдээг заах үүрэг хариуцлагатайгаар дэлхий дээр очуулахын тулд сонгосон байлаа (Абрахам 2:9–11-ийг үз). Тэнгэрлэг Эцэг тэднийг мөнх бус байдлын өмнөх амьдралд тэдний тухай

“урьдаас мэддэг байсныхаа” дагуу эдгээр сүнснүүдийг “сонгож”, мөн тэднийг мөнх бус байдал дахь Өөрийн тохиулагчид байхаар сургасан ажээ (С ба Г 138:55–56-г үз). Энэхүү “ач ивээлийн сонголт нь” энэ хариуцлагыг манай өнөө үед хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг Сүмийн гишүүдэд өгдөг билээ (see Bruce R. McConkie, *Doctrinal New Testament Commentary*, 2:273–75).

Ром 11:16–25—“Тэдний Дунд Залгагдаж”



Жимсний моднууд дээрх мөчрүүд үхэж эхлэхэд, цэцэрлэгч тэдгээрийг тайрч, эрүүл модноос шинэ мөчрүүд авч залгадаг. Хэрэв үүнийг зөв хийсэн бол, шинэ мөчрүүд ургаж хуучин модны нэг хэсэг болдог. Харийнхан Израилын бүх адислалуудыг хэрхэн хүлээн авч болохыг тайлбарлахын тулд Паул мөчир залгах жишээг ашиглажээ. Израилын угсааны, Их Эзэний гэрээт хүмүүс цаг ямагт итгэлтэй биш учраас, жимсний модон дээрх үхсэн мөчрүүдтэй адилхан, Их Эзэн тэднийг тайрч, өөр модноос шинэ мөчрүүд авч, тэднийг орлуулж болно. Хөрвүүлэгдсэн харийнхан бол Израилын модны “дунд залгагдсан” шинэ мөчрүүд мөн хэмээн Паул сургажээ (Ром 11:17).

Судруудыг Судлах нь

Ром 11-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Сайн Мэдээг Заахаар Сонгогдогсод

Ром 11:1–5-ын “Судруудыг Ойлгох нь” хэсэг дэх ач ивээлийн сонголтын тухай унш. Тэгээд энэ сургаал хувь хүний тань тухайд чамд ямар учир холбогдолтойг нэг богино догол мөрөөр бич.

Б Чидун Модны Тухай Сургаалт Зүйрлэл

Чидун модны унаган мөчрүүд нь Иудейчүүдийг, харин зэрлэг мөчрүүд нь Харийнханыг төлөөлдөг болохыг Паул заажээ. Хоёр багана гаргаж, *Унаган Мөчрүүдийг* нэгнийх нь дээд талд, *Зэрлэг Мөчрүүдийг* нөгөө дээр нь бич. Ром 11:17–24-ийг уншихдаа эдгээр тус бүрийн тухай мэдсэн зүйлээ холбогдох багануудад жагсаан бич. Дараах асуултууд тустай байж болно:

1. Унаган мөчрүүдийг яагаад огтолж хаясан бэ?
2. Чидуны модонд зэрлэг мөчрүүдийг залгах нь яагаад зайлшгүй чухал байсан бэ?
3. Зэрлэг мөчрүүдэд Паул ямар сэрэмжлүүлэг өгсөн бэ?
4. Их Эзэн Өөрийн бүх хүүхдүүдэд хэрхэн ханддаг тухай та нар юу мэдэв?



Ром 12–13

Гэгээнтнүүдэд Өгсөн Зөвлөгөө

Гэгээнтнүүд үгийг хэрэгжүүлэгчид байх ёстой. Ариун Сүнс тэдэнд нөлөөлж, мөн бусдад үйлчлэхэд нь тэдэнд тусалж байхаар Гэгээнтнүүд амьдрахыг Паул хүсдэг байв. Тэнгэрлэг Эцэгээс бидэнд өгсөн үндсэн зарлигуудын

нэг нь бид хөршүүдийгээ хайрлах явдал бөгөөд энэ зарчмын дагуу амьдрах бидний хүсэл эрмэлзэл нь бидний авралд нөлөөлөх болно. Та хөршийгөө хайрладаг гэдгээ ямар арга замаар харуулж чадах вэ? Бусад хүмүүс чамийг хайрладаг гэдгээ хэрхэн харуулсан бэ?

Судруудыг Ойлгох нь



Ром 12

Гуйя (ш.1)—Хүсье

Нэг бие дэх олон эрхтэн (ш.4)—Нэг Сүм дэх олон гишүүн

Ятгалга (ш.8)—Урамшуулан дэмжих

Жигш (ш.9)—Үзэн яд, дургүй бай

Зуурч ав (ш.9)—Нэгд, нийл, барьж ав

Хариул (ш.17)—Хариу төл, сэргээ

Галтай нүүрс (ш.20)—Гэм буруугийн мэдрэмж

Ром 12:1–2—“Өөрсдийн Биеийг Амьд Тахил Болгон Өргөх” Гэдэг нь Ямар Утгатай Вэ?

“Өөрийн биеийг амьд тахил болгон өргөх” гэсэн өгүүлбэрийг (Ром 12:1) сайн мэдээний дагуу бүх зүрх сэтгэлээрээ амьдрахын ач холбогдлыг онцгойлон заахад Паул ашиглажээ. Хуучин Гэрээний үед хүмүүс итгэлээ харуулахын тулд амьтнаар Бурханд тахил өргөдөг байжээ. Хуучин Гэрээний хуулийг гүйцэлдүүлэхийн тулд Есүс Христ Өөрийн амиар тахил өргөж, бидэнд шинэ арга замыг харуулсан билээ. Өөрсдийнх нь амьдрал байдаг, Есүс Христэд итгэх итгэлтэй нь нийцдэггүй зүйлүүдийг золиослохыг Паул Гэгээнтнүүдээс урьжээ.

Ром 13

Илд дэмий зүүгээгүй (ш.4)—Шүүлтийг заавал гүйцэтгэх болно

Юугаар ч бүү ханга (ш.14)—Бүү анхаар, эсвэл бүү ханга

Судруудыг Судлах нь



Ром 12–13-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Жинхэнэ Утгыг Олох нь

Сайн мэдээний бүх адислалуудыг хүлээн авахын тулд, зөвхөн Сүмийн гишүүн байх нь хангалтгүй юм. Ром 12:1–3-ын дараах өгүүлбэр тус бүрт, уг өгүүлбэрт хамгийн сайн тохирно гэж өөрсдийн бодсон тодорхойлолтыг сонго. Дараа нь Паулын захиасыг дүгнэх өгүүлбэр бич.

1. “Өөрийн биеийг өргөх” (ш. 1)
 - а. Өөрчлөх
 - б. Та нарын бүгдэд нь таалагдах золиослол
2. “Энэ үеийн явдалд бүү нийцэгтүн” (ш. 2)
 - а. Ёс бус
 - б. Дэлхийн арга замуудыг хуулбарлах

3. “Өөрчлөгтүн” (ш. 2)
 - а. Үйлчлэлийн амьдралаар амьдрах
 - б. Дээшилсэн
4. “Эрүүл сэтгэх” (ш. 3)
 - а. Бүү бардамна
 - б. Шог хошигнолоос зайлхий

Б Өөрсдийн Сгээр

Хоёр нүүр гэдэг нь чин үнэнээсээ биш байх, дүр эсгэх гэсэн утгатай. Сайн мэдээний дагуу амьдрахад чин үнэнч сэтгэл зайлшгүй чухал юм. Ром 12:9–21-ийг уншиж, шүлэг 12, 13, 16, 17 мөн 20-ийн гол санааг өөрсдийн үгээр бич. Гишүүдийг үнэнч байж, дүр эсгэхээс зайлхийхийг Паул хүсдэг байсныг сана.

В Хайр Хуулийг Хэрэгжүүлдэг

Гэгээнтнүүд сэрж, сайн мэдээний дагуу амьдрахыг Паул тэднээс хүссэн байдаг. Шашны хувьд хайш яйш байх нь хялбар юм. Хэрхэн илүү шийдэмгий байхад суралцахын тулд доорх нөхцөл бүрт хамгийн тохиромжтой гэж өөрсдийн бодсон шүлгийг ром 13:8–14-өөс бич:

1. Том унтчихаад, гэр бүлийн судрын уншлагыг тасалжээ. Тэр хэт ядарсан байлаа гэж ээждээ хэлэв.
2. Тэдний харьцаа хэтэрхий ноцтой болж байгаа учраас уулзахаа болих ёстой гэж Сара гишүүн биш найз залуудаа хэлжээ.
3. Деннис Сүмийн заадаг зүйлүүдийн талаар буурь суурьтайгаар боддоггүй. Юм болгон түүний хувьд шог наргиан байдаг. Тэр шог наргиан хийж, хүн болгоныг инээлгэж, тоглон, Ням гарагийн хичээлийг үймүүлдэг.
4. Ами баптисмынхаа ярилцлагад орох гэж номлогч нартай уулзжээ. Тэрээр сайн мэдээний дагуу амьдрах шийдвэр төгс байгаа бөгөөд өмнөх алдаануудаа ардаа орхихыг хүсч байна гэж тэдэнд ярьжээ.

Ром 14–16

Жинхэнэ Гэгээнтнүүд Бие Биентэйгээ Нөхөрлөдөг

Сайн мэдээг хүлээн авч, үүний дагуу амьдрах хүслээ илэрхийлсэн бүх хүмүүсийг Сүмд баяртайгаар хүлээн авах ёстой. Үгийг хэрэгжүүлэгчид ард сууж, бусдыг шүүж байж таарахгүй; тэд найз нөхдийн хувиар гараа сунгаж, Сүмд хийгээд Бурханы хаант улсад шинэ орон байр олоход нь хүмүүст туслах хэрэгтэй. Та нар өөрсдийн хэсэг буюу салбарт амьдардаг аль нэг шинэ гишүүдийг таних уу? Өөрсдийгөө Сүмийн нэг хэсэг гэж бодуулахад та нар тэдэнд хэрхэн тусалж чадах вэ?

Судруудыг Ойлгох нь



Ром 14

Зарга (ш.1)—Хүний хувийн санал бодлыг зөвшөөрөхгүй байх
Босгох (ш.4)—Босоогоор байлгах

Ах дүүгээ басамжлах (ш.10)—Ах дүүгээ үл тоомсорлох
Үздэг (ш.14)—Үнэлэн, ойлгох, цэгнэх

Ром 14—Иудейчүүдийн болон Харийнханы Ёс Заншлын Зөрчилдөөн

Гэгээнтнүүд Иудейчүүдийн ёс заншил хийгээд уламжлалуудын дагуу амьдрах ёстой гэж байнга шахаж шаардах явдалтай Паул тулгарч байжээ. Хүндэтгэлийн өдрийн тодорхой зарим уламжлалуудыг сахин, тодорхой хоол хүнснээс татгалзаж, мөн бусад ёс заншлуудыг баримтлах нь Иудейчүүдийн хувьд идэвхтэй үйл ажиллагаа байсан хэдий ч, харийнханы хувьд тийм байсангүй. Нэг бүлэг өөрийн шашны итгэл хийгээд соёлын уламжлалуудын дагуу нөгөөгөө хатуу ширүүнээр шүүх нь олонтаа гарч байв. Ёс заншил нь Есүс Христэд итгэх итгэлтэй байх хийгээд Түүний үлгэр жишээг дагахтай харьцуулбал ач холбогдолгүй юм гэдгийг бүх хүмүүс ойлгоосой гэж Паул хүсч байв. Бүр өнөөдөр ч гэсэн дэлхий даяарх сүмд үүнтэй төстэй бэрхшээлүүд бидэнд тохиолддог. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли сургахдаа:



“Энэ Сүмийн гишүүн болно гэдэг амаргүй хэрэг. Ихэнх тохиолдолд энэ нь хуучин заншлуудаа хойш тавьж, хуучин найз болоод хэлхээ холбоогоо орхин, өөр бөгөөд ямар нэг байдлаар шаардлага тавигддаг шинэ хамт олон дотор алхан орох явдал байдаг.

“Хөрвөгчдийн тоо цаг ямагт өсөн нэмэгдэж байгаатай холбоотойгоор тэднийг замаа оло-

ход нь туслах зайлшгүй шаардлагатай хүчин чармайлтыг бид гаргах ёстой. Тэдний хүн болгонд гурван зүйл: найз нөхөр, ажил үүрэг, түүнчлэн ‘Бурханы сайн үгээр’ гэжээгдэж байх нь хэрэгтэй (Моронай 6:4). Эдгээр зүйлүүдээр хангах нь бидний үүрэг мөн” гэжээ (in Conference Report, Дөрөвдүгээр сар. 1997, 66; or *Ensign*, Тавдугаар сар 1997, 47).

Ром 15

Сул дорой байдал (ш.1)—Үнэнийг мэдэхгүйгээс үүдэлтэй сул дорой байдал
Босгон байгуулахын тулд (ш.2)—Сайжруулах, өргөх

Магтах (ш.11)—Магтаал өргөх
Та нартай (ш.24)—Та бүгдтэй

Ром 16

Туслах (ш.2)—Тус дэм үзүүлэх

Сан хөмрөгийн нярав (ш.23)—Итгэмжит зарц

Ром 16:17–19—“Хэрүүл Маргаан Гаргагчдаас Сэрэмжил”

Үнэн шашнаас урвах нь өсөн нэмэгдэж байсан үед Паул амьдарч байв. Сайн гишүүд мэт харагдавч, хуурамч сургаал заадаг зарим хувь хүмүүс байлаа (Үйлс 20:28–32-ыг үз). “Хэрүүл маргаан гаргагчдаас” болон ийнхүү өөртөө үйлчлэгч хүмүүсээс Ромчуудыг сэрэмжлүүлэхийг Паул хүсдэг байлаа (Ром 16:17-г үз).

Ром 16:20—“Та Нарын Хөл Дор Сатаныг Няцална” Гэдэг нь Ямар Утгатай Вэ?

Ахлагч Брус Р.МакКонки, “Та нарын хөл дор Сатаныг няцална” (Ром 16:20) гэдэг нь: “Дэлхийг ялдаг хүмүүс түүний уруу таталтуудыг эсэргүүцэх замаар Сатаныг хөл дорoo дэвсэлдэг” гэж тайлбарласан байдаг (*Doctrinal New Testament Commentary*, 2:308).

Судруудыг Судлах нь

Ром 14–16-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) нэгийг нь хий.

А Шинэ Гишүүнтэй Ярилц

Өөр өөр соёлын хүмүүс Сүмд нэгдэж байна. Ром 14 дахь “Судруудыг Ойлгох нь” хэсэг дэх Ерөнхийлөгч Хинклигийн хэлсэн үгийг унш. Тэгээд сүүлийн сард Сүмд нэгдсэн хэн нэгэнтэй ярилцаж, дараах асуултуудад түүний хариулсан байдлыг товч дүгнэн бич:

1. Сүмийн шинэ гишүүний хувьд та ямар өөрчлөлтүүд хийх хэрэгтэй байсан бэ?
2. Таныг амжилт олоход туслахын тулд Сүмийн гишүүд юу хийсэн бэ?
3. Шинэ гишүүдийг Сүмд шилжилт хийхэд илүү сайн туслахын тулд гишүүд өөр юу хиймээр байна?

Б Шүүлтийн Талаарх Таны Шүүлт Юу Вэ?

Гэгээнтнүүд бие биеэ шүүх ёсгүйг Паул заасан байдаг. Ром 14:4–13-ыг уншаад, дараах асуулт тус бүрт хариултыг бич:

1. Хэрэв бид бүгд Бурханы үйлчлэгчид юм бол, бид яагаад бие биенээ шүүх ёсгүй юм бэ? (Ром 14:4-ийг үз).
2. Хүмүүс өөр өөр санал бодол, дадал зуршилтай байж болно, гэвч санаж явбал зохих хамгийн чухал зүйл юу вэ? (ш.5–6-г үз).
3. Бурханд хамаатай байдал нь гэгээнтнүүдийн хоорондох ялгаануудыг хэрхэн багасгадаг вэ? (ш.7–9-ийг үз)
4. Эцэст нь, бид бүгдийн ямар зүйл нийтлэг байдаг вэ? (ш.10–11-ийг үз).
5. Хэрэв бид бие биенээ шүүх юм бол, энэ нь бидэнд болон биднийг шүүсэн хүмүүст ямар хохирол учруулах вэ? (ш.13-ыг үз).

В Сүм бол Хамт Олон мөн

Бүх хүмүүсийг Өөртөө ирэхийг Есүс Христ урьдаг. Янз бүрийн авьяас билиг хийгээд хүч чадалтай Гэгээнтнүүдийн хамт олон дотор, бид бүгдээрээ Христтэй илүү адилхан болж чадахын тулд бие биендээ туслах хэрэгтэй. Ром 15:1–7-г унш. Тэгээд шүлэг 1–2, 5, 7-д юу хийхийг Паул бидэнд зөвлөснийг бичиж, бидний дундах ялгааг даван туулахыг хичээ.



Коринтчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Анхны Захидал

Коринтчууд Гэж Хэн Байсан Бэ?

Паул номлолынхоо хоёр дахь аяллын үеэр сайн мэдээг Коринтод зааж, мөн тэнд Сүмийн нэг салбарыг зохион байгуулсан байна (Үйлс 18:1–17-г үз). Коринт бол хиймэл шүтээн хийгээд ёс суртахуунгүй байдлаараа нэрд гарсан хот байсан ажээ, иймээс тэндхийн Сүмийн гишүүд сайн мэдээнд үнэнч хэвээр үлдэх боломжийн талаар санаа тавьдаг байжээ.

Коринтчуудтай Харилцсан нь

Паул Коринтчуудад хамгийн наад зах нь гурван захидал бичжээ (1 Коринт 1:1–2; 5:9; 2 Коринт 1:1-ийг үз). Коринтын Гэгээнтнүүд Сүмийн сургаал болон дадал заншлын талаарх асуудлуудад туслалцаа хүсч түүнд хандан бичжээ. 1 Коринтын ном бол тэдгээр захидлуудын нэгэнд өгсөн Паулын хариу юм. Үүнийг тэрээр Ефест амьдарч байхдаа МЭ 54 оны орчимд бичжээ.



Өөрчилж Болохгүй Зарим Зүйлүүд

Өнөөдөр Гэгээнтэн байснаар Коринтод Гэгээнтнүүдэд тулгарч байсан тэр бэрхшээлүүдээс олонтой тулгардаг. Дараах зөвлөгөө өнөөдөр хичнээн ач холбогдолтойг ажигла:

- Бурханыг мэдэх цорын ганц зам нь Сүнсээр дамждаг (1 Коринт 2:9–16-г үз).
- Бидний бие бол Бурханы ариун сүм бөгөөд цэвэр ариун байх ёстой (1 Коринт 3:16–17; 6:19–20-ийг үз).
- Бидний тэсч чадахаас илүү хэмжээгээр соригдохыг Бурхан бидэнд зөвшөөрдөггүй (1 Коринт 10:13-ыг үз).
- Гэрлэлт нь Бурханы аз жаргалын төлөвлөгөөнд чухал юм (1 Коринт 11:11-ийг үз).
- Хэрэв бид ариун ёслолыг зохисгүйгээр хүртэх юм бол, бидний төлөө Есүс Христийн хийснийг бид дооглон тохуурхна гэсэн үг (1 Коринт 11:27-г үз).
- Бид Сүмийн гишүүдийн хувьд нэгэн адил оюун бодол хийгээд шүүлтэд хамтдаа байх ёстой (1 Коринт 12:20–26-г үз).

1 Коринт 1–4

Сүнсээр Дамжсан Эв Нэгдэл

Зарим үед Сүмийн гишүүд өөрсдийн мэргэн ухааныг Бурханы мэргэн ухаанаас дээгүүр тавьдаг. Амьдралын бэрхшээлүүдийн шийдлийг олоход Сүнс хэрхэн тусалж чаддагийг ойлгоход тэд алддаг. Коринтод зарим Гэгээнтнүүд өөрсдийнхөө хувийн санаа бодлыг Христийн сайн мэдээний хэсэг хэмээн маргаж, улмаар энэ нь гишүүдийн дунд хагарал бий болгожээ. 1 Коринт 1–4-т энэ асуудлын шийдлийг Сүнс хэрхэн хангасан хийгээд иймэрхүү хүндрэл бэрхшээл тохиолдоход энэ нь танд нэрт хэрхэн тусалж чадах вэ?

Судруудыг Ойлгох нь

1 Коринт 1

Аливаа үг (ш.5)—Хэлэгдсэн үгс

Түүний Хүүтэй нөхөрлөх (ш.9)—Түүний Сүмийн гишүүний хувьд Христтэй ойр дотно байж, нөхөрлөх

Хүсэмжлэн гуйя (ш.10)—Гуйя, хүсье

Кеф (ш.12)—Петр

Мэргэд (ш.19)—Эрдэмтэй, боловсорсон

Маргалдагч (ш.20)—Философич, гүн ухаантан

Мунхаг, мөхөс, шалихгүй юмс (ш.27–28)—Есүс Христийн даруухан дагалдагчид

1 Коринт 1:26–28—“Мэргэдийг Ичээхийн Тулд . . . Бурхан Мунхагчуудыг Сонгосон Юм”

“Мэргэдийг ичээх” “дэлхийн мунхаг юмс” хэн бэ? (1 Коринт 1:27) Паул дэлхийд явж, амьдралын бүхий л түвшингийн хүмүүст заадаг байсан номлогч нарыг хэлжээ. Номлогч нарыг тэнэг гэж тэр хэлсэн үү? Дэлхий манай номлогч нарыг олонтаа юу гэж үздэгийг Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли тэмдэглэжээ:

“ВВС-гийн Дэлхийн Радиогийн Үйлчлэлийн нэгэн төлөөлөгч надаас ярилцлага авч байлаа. Тэрээр номлогч нарыг харсан байж, тэгээд тэдний бага залуухан гадаад төрхийг ажигласан гэнэ. Ийм гэнэн залуусыг хүмүүс яаж сонсоно гэж та боддог юм бэ?

“Хэрэв та нарын зарим нь бага залуу гэдэг үгийн утгыг мэдэхгүй бол, энэ нь эрийн цээнд хүрээгүй, туршлагажаагүй, ухаан сууж боловсроогүй гэсэн утгатай.

“Гэнэн залуус гэв үү? гэж би сурвалжлагчид инээмсэглэн хариулав. Энэ бол өнөөдрийн номлогч нарын хувьд Паулын үе дэх Тимоттай адил юм. [1 Тимот 4:12-ыг үз]. . . .

“Гайхамшигтай зүйл гэвэл хүмүүс тэднийг хүлээн авч, тэднийг сонсдог юм. Тэд эрүүл саруул. Тэд гэрэл гэгээтэй, тэд сэргэлэн цовоо, тэд өөдрөг. Тэд цэвэр цэмцгэр харагддаг бөгөөд хүмүүс тэдэнд түргэн итгэж эхэлдэг юм. . . .

“Гэнэн залуу гэнэ ээ? Тийм ээ, тэдэнд хэрсүү ухаан суугаагүй л дээ. Энэ нь ямар агуу адислал билээ. Тэдэнд залилан мэхлэхийн үнэр ч байхгүй. Тэд өчүүхэн ч хоёрдмол утгаар ярьдаггүй. Тэд хувь хүний итгэл үнэмшлээр чин сэтгэлээсээ ярьдаг. Тэдний хүн бүр амьд Бурханы үйлчлэгч, Их Эзэн Есүс Христийн элчин сайд юм. Тэдний хүч дэлхийн зүйлүүдэд тэдний сурч боловсорсноос ирдэггүй. Тэдний хүч итгэл, залбирал хийгээд даруу байдлаас ирдэг” (in Conference Report, Sept.–Oct. 1995, 69; or *Ensign*, Nov. 1995, 51).



1 Коринт 2

Ингэхдээ (ш.6)—Хэдийгээр
Удирдагчид (ш.6, 8)—

Сүнсний зүйлийг (ш.14)—
Ариун Сүнсээр дамжуулан
Захирагчид

1 Коринт 2:14—“Эгэл Хүн Гэж Юу Вэ”?

Адамын уналтын дараа хүн төрөлхтөн “төрөлхөөсөө эгэл, тачаангуй, чөтгөр мэт” болсон юм (Алма 42:10). Энэ төрөлх чанар Бурханы тэнгэрлэг чанартай харш юм (Мозая 3:19-ийг үз). “Эгэл” байдлаар амьдардаг эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүд сүнсний мэдлэгийг ойлгодоггүй; энэ бол тэдний

хувьд тэнэглэл байдаг. Эгэл хүн “Ариун Сүнсний таталтанд автагдан, эгэл хүмүүнээ орхисон” үед тэрээр сүнсний мэдлэг олж авдаг (Мозая 3:19).

1 Коринт 3

Сүрэл (ш.12)—Тариа хураас-
ны дараа талбайд үлддэг рү
тарианы богинохон хуурай
ишнүүд

Үлдвэл (ш.14)—Тэсч үлдвэл
Тэсч үлдвэл
Тэсч үлдвэл
Тэсч үлдвэл
Тэсч үлдвэл

1 Коринт 3:1–3—“Би Та Нарт Сүү Өгсөн”

Коринтчууд бол Есүс Христийн сайн мэдээний шинэ хөрвөгдөгчид байлаа. Тэднээс олон нь эгэл тачаангуй (дэлхийн) сул дорой талуудад нухлагдсаар байлаа. Тэд бор хоолонд бэлэн биш байсны улмаас тэрээр тэдэнд сүү өгсөн юм гэдгийг тэдэнд тайлбарлан Паул тэднийг “Христ доторх балчир хүүхдүүдтэй” харьцуулжээ (1 Коринт 3:1–2). Сүү гэдэг нь бор хоол буюу нилээд нарийн сургаалуудын өмнө ойлгогдсон байх ёстой, заагдаж болох сайн мэдээний заадаг энгийн зүйлүүд юм. Аль хэдийнэ хүлээн авсан гэрлийнхээ дагуу амьдарснаар олж авдаг сүнсний хувьд эрийн цээнд хүрч боловсорсон хүмүүс л гагцхүү ийм сургаалуудыг ойлгож чаддаг (С ба Г 50:24; Алма 12:9–11-ийг үз).

1 Коринт 4

Зүрхний зорилго (ш.5)—
Зүрх сэтгэлийн нууцууд
буюу эрмэлзэл

Хэрэгжүүлсэн нь (ш.6)—
Надад байсан нь, зүйрлэсэн

Гүтгэхэд нь тайтгаруулахыг бид хичээдэг (ш.13)—
Бид худлаа хэлээд, ялгааг нь шийдвэрлэхийг хичээдэг.
Хог, шаар шавхруу (ш.13)—
Хог, хаягдал

Судруудыг Судлах нь



Коринт 1–4-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг нь хий.

А Гэр Бүлийнхээ Тухай Ярь

Хүмүүс Сүмд нэгдэхдээ Христийн гэр бүлийн гишүүд болдог (Мозая 15:11-ийг үз). 1 Коринт 1:9–13-ыг унш.

1. Коринт дахь “Христийн гэр бүлд” байсан буруу зүйлүүдийг жагсаан бич.
2. Танай гэр бүл хамтдаа байсан нь чамд агуу баяр хөөрийг авчирсан үйл явдал буюу хугацааг дүрсэл.
3. Христийн гэр бүлийн хувьд бас чухал болох ямар туршлага танай гэр бүлд байдгийг жагсаа.

Б Эгэл Бус Хүн

Хэрэв та нар үл мэдэгдэм өвчний улмаас, өвдөлт мэдэрсэн бол, тусламж авахаар—цагдаа, таксины жолооч, эсвэл өөрсдийн эмчийн хэн рүү нь явах бэ? Яагаад? 1 Коринт 2:10–14-ийг унш.

1. Сүнсний хариултыг олж авахын тулд хаашаа явах ёстойгоо бич.
2. Сүнсний мэдлэгтэй болоход “эгэл хүнд” яагаад хэцүү байдгийг тайлбарла.

3. Мозая 3:19-ийг уншиж, эгэл хүнээ даван туулахад бидэнд юу тусалдгийг жагсаа.

В Ариун Сүм, Намайг Ариусга

1 Коринт 3:16–17-г уншиж, та нарын бие ямар замаар ариун сүмтэй адил болох тухай бод. Дараах нөхцлүүд ийм сүмд хэрхэн нөлөөлөх хийгээд Сүнсийг хүлээн авах чадварыг хязгаарлагдгийг тайлбарла.

1. Том, Сюзан хоёр болзож, тэгээд биеэрээ харилцаанд оржээ.
2. Жөү найз нарынхаа хамт тамхи захилах дуртай.
3. Катрина найз нар нь тэнд байхгүйн улмаас Сүмээс зайлсхийдэг.

Г Сүмийн Удирдагчид Зурвас Бич

Сүмийн удирдагчид итгэлтэй байх шаардлагатайг Паул тэдэнд хэлж, түүнчлэн итгэлтэй байдлынхаа улмаас тэд мөрдөн хавчигдах болно гэдгийг тэдэнд сануулжээ (1 Коринт 4-ийг үз). 1 Коринт 4:9–16-г уншсаны дараа, Сүмийнхээ удирдагчдын нэгэнд талархлын зурвас бич. Тэр хүний юуг нь та нар үнэлдэг хийгээд тэр чамд хэрхэн тусалсныг жагсаа. (Та нар уг зурвасыг явуулахаасаа өмнө багштайгаа хуваалц.)

1 Коринт 5–7 Сүмд Өгсөн Зааврууд

1 Коринт 5–7-д Коринт дахь Гэгээнтнүүдэд өгөх зөвлөгөөгөө Паул үргэлжлүүлдэг. Тэрээр: Гэгээнтнүүд нүгэл үйлдэгчидтэй ямар холбоотой байх вэ? Гэгээнтнүүд бие биетэйгээ заргалдах нь хэдийд зүгээр вэ? Номлолд явсны дараа гэрлэх нь яагаад илүү сайн бэ? гэхчилэн чухал асуудлуудад тэрбээр хариулсан байдаг. Эдгээр асуудлаарх Паулын зөвлөгөөг эрж, эдгээр нь өөрсдөд тань хэрхэн холбогдох тухай бод.

Судруудыг Ойлгох нь



1 Коринт 5

Садар самуун явдал (ш.1)—
Гэрлээгүй хүмүүсийн хоорондох бэлгийн харилцаа
Жаахан хөрөнгө нь зуурсан гурилыг бүхэлд нь исгэдэг (ш.6)—Жаахан хөрөнгө талхыг өсгөхөд хүргэдэг; бяцхан

нүгэл хүнд буюу цугласан олонд бүхэлд нь нөлөөлдөг
Цэвэрлэ (ш.7)—Зайлууул, наманчил
Хорсол (ш.8)—Бусдыг хорлох хүсэл

1 Коринт 5:5—“Тийм Нэгэнийг Сатанд Тушаая”

Илүү мэдлэгтэй, Сүмд туршлагатай гишүүдэд илүү хүнд шийтгэл ирэх болдог. “Тийм хүнийг махан биеийг нь сүйрүүлэхийн тулд Сатанд тушаахын” (1 Коринт 5:5) тулд тэднийг сайн мэдээний адислалуудаас тусгаарлах явдал мөн. Үүний дотор тэднийг Бурханы эдгээх хийгээд хамгаалах хүчгүй орхиж, Ариун Сүнснийг алдах явдал багтдаг. Ийм байдал дахь хувь хүмүүс дайсны устгагч хүчний бүрэн эрхшээл дор өөрсдийгөө орхидог билээ.


1 Коринт 6

Шүүлгэх, шүүх, заргалдах (ш.1, 6-7)—Заргалдах, хэрэг үүсгэх	Мэхлэгдэх (ш.7)— Залилуулах
Сүйрэл (ш.7)—Бүрэн бүтэл-гүйтэл	Янхан эр, ижил хүйстэн-тэйгээ нөхцөгчид (ш.9)— Ижил хүйстний янз бүрийн нүгэлд оролцогчид

1 Коринт 6:9-12—Эдгээр Схлийн Нүглүүд Паулын Оюунд Хууль Ёсных Байсан уу?

Иосеф Смитийн Орчуулганд, 1 Коринт 6:12-т чухал өөрчлөлтөөр хангасан. Эдгээр бүх зүйл нь түүний хувьд хууль ёсны биш бөгөөд тийм их яаралтай биш юм гэж Паул тайлбарласан (ИСО, 1 Коринт 6:12-ыг үз).

1 Коринт 6:19-20—“Та Нар Өөрсдийнх Чинь Биш”



Төлөөлөгч асан Ахлагч Ли Гранд Ричардс, “Бие нь өөрсдийнх нь гэж боддог, мөн түүгээрээ яаж ч байсан тэдний дур гэж боддог хүмүүс олон байдаг ч гэсэн, бие нь өөрсдийнх нь биш гэдгийг Паул тов тодорхой болгосон юм, учир нь тэдгээр нь үнээр авчрагдсан юм” гэж хэлжээ (*A Marvelous Work and a Wonder*, дахин хянасан хэвлэл. [1973], 380).

1 Коринт 7

Үүргээ биелүүлэг (ш.3)— Эелдгээр гүйцэтгэг	Хөвч хөндөх (ш.18-19)— Хөвч хөндөх ёслол
Биеэ барьж тэвчихгүй байдлаар (ш.5)— Биеэ барих чадвараар сул	Та нарыг боогдуулах (ш.35)—Та нарыг хязгаарлах
Боолчлол дор (ш.15, 27)— Гэрээн дор	Зохистой (ш.35)—Зохих ёсны, хүндэтгэвэл зохих

1 Коринт 7:29-33—“Эхнэртэй Эрчүүд Эхнэргүй Мэт Байг”

“Эхнэртэй хүмүүс нь эхнэргүй мэт байг” (1 Коринт 7:29) хэмээн Паулын зөвлөснийг Иосеф Смитийн Орчуулга Тэр үйлчлэлд дуудагдсан, Их Эзэний ажлыг хийхээр дуудагдаж, сонгогдсон, хүмүүст хандан хэлсэн хэмээн тодорхой болгосон (ИСО, 1 Коринт 7:29-ийг үз). Өөрөөр хэлбэл, гэрлэсэн хүмүүс номлолынхоо үед эхнэргүй мэт байг.

Судруудыг Судлах нь

1 Коринт 5-7-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А-Г) хоёрыг нь хий

А Бишоптойгоо Ярилц

Бишопын сахилгын зөвлөл Сүмд болон наманчлах шаардлагатай хийгээд бүрэн нөхөрлөлд эргэж ирэх шаардлагатай хүнд хэрхэн тусалдгийг тайлбарлаж өгөхийг бишпоосоо хүс. 1 Коринт 5-ыг уншиж, эдгээр шүлгүүд болон бишопынхоо тайлбарласан зүйлүүдийн хоорондох адил төстэй зүйлүүдийн талаар бич.

Б Нүглийн Sp Дагавруудыг Жагсаа

Коринт дахь Гэгээнтнүүдийг нүглүүдээ хаацайлах гэснийг нь төлөө Паул шүүмжилжээ. Хэрэв тэд зөв шударга биш байх юм бол, Сүнс тэдэнд оршиж чадахгүйг тэрээр тэдэнд сануулдаг байв. 1 Коринт 6:9-20-ийг уншихдаа, Паулын дурьдсан хамгийн наад зах нь таван нүглийг жагсааж, эдгээр нүглүүд нүгэл үйлдэгч, нүгэл үйлдэгчийн гэр бүл хийгээд Сүмд яаж нөлөөлөхийг тайлбарла.

В Паулын Заасныг Нэгтгэн Дүгнэ

Та нар 1 Коринтыг уншихдаа, *салалт* гэдэг үгийг “орхих” (мөн салах гэсэн утгатай “хаях” гэдэг үгээр орлуул, тэгээд шүлэг 12-13-т “итгэдэггүй тэд” гэдэг өгүүлбэрийг *гишүүн бус* гэдэг үгээр орлуул. Эдгээр орлуулсан үгстэй өгүүлбэрүүдийг уншсаны дараа Паул юу зааж байсан гэж өөрсдийн боддог зүйлийг дүрсэлсэн нэг догол мөр бич.

Г Нэг Хичээл Бич

1 Коринт 7:8-9, 29-35-аас номлогч нарт хандан Паулын хэлснийг уншиж, дараах асуултуудад хариул:

1. Эдгээр заасан зүйлүүд бүрэн цагийн номлогч нарын хувьд хэр зэрэг ашиг тустай вэ?
2. Найз охин буюу найз хөвгүүн номлогчийг дуудлагаас нь хэрхэн анхаарлыг нь сарниулж болох вэ?

1 Коринт 8-11

Шинэ Гишүүдэд Өгсөн Зөвлөгөө

Коринтын Гэгээнтнүүд Паулд бичиж, түүнээс олон асуулт асуужээ. Тэдгээр асуултуудыг тэдэнд өгсөн түүний хариултаар бид мэддэг. Хувь хүний үйл хөдлөлөөр дамжуулан бусдыг гомдоохын эсрэг тэднийг сануулж,

уруу таталтаар шударга бусаар хэт их дарагдахыг Бурхан бидэнд зөвшөөрөхгүй гэдгийг, түүнчлэн ариун ёслолоос хүртэхийн тулд зохистой байхын ач холбогдол, чухлыг санахыг Паул зөвлөжээ.

Судруудыг Ойлгох нь



1 Коринт 8

Ихэрхэг болгодог (ш.1)—
Их зантай болгодог

Зоригжих (ш.10)—Зориг
орох

Аваачихгүй (ш.8)—Биднийг
аваачдаггүй

1 Коринт 8:4, 8-13—Хиймэл Шүтээнүүдийн Хоолыг Идэх нь

Хуурамч бурхдад тахил өргөсөн идээг идэхийг Мосегийн хууль Иудейчүүдэд зөвшөөрдөггүй байжээ. Идээ нь өөрөө хүнийг бузар болгодоггүй гэж Паул тэдэнд заадаг ч шүтлэгийн идээг харийнхан идэж байгааг харсан үедээ Иудейн хөрвөгчид гомддог байжээ. Өөрсдийн нөхөр Гэгээнтнийг гомдоосноос идээг идэхгүй байсан нь дээр хэмээн Паул зөвлөдөг байв.

1 Коринт 9

Хөлсөөр (ш.7)—Зардлаар
Саад тотгор (ш.12)—Явцыг
удаашруулах

Биеэ барих (ш.25)—Даруу
байх, өөрийгөө хянах

Муудах (ш.25)—Дэлхийн,
цаг зуурын

Няравын үүрэг нь надад
даалгагдсан юм (ш.17)—
Даамлынхаа төлөө би
хариуцлага хүлээх болно.

Агаар цохих (ш.26)—
Зодолдох гэж байгаа дүр
үзүүлэн агаарт нударгаараа
цохих

1 Коринт 10

Шүтээн шүтэгчид (ш.7)—
Хиймэл шүтээн шүтэгчид
Эзэний ширээ (ш.21)—
Ариун ёслол мэт Их Эзэний
арга замууд

Чөтгөрүүдийн ширээ
(ш.21)—Хиймэл шүтээний
найр мэтийн чөтгөрийн
арга замууд
Хардалт (ш.22)—Уур

1 Коринт 11

Үсээ хяргах (ш.6)—Үсээ
бүрэн хусах (Паулын үед
үүнийг гутаамшиг гэж
үздэг байв)

Түүний сургаалын талаарх
худал зүйлс

Шийтгэгдэхдээ (ш.32)—
Шийтгэлээр залруулагдах

Бүлэглэлүүд (ш.19)—Худал
зүйлүүд, Христ болон

1 Коринт 11:2-12—Эрэгтэйчүүд Эмэгтэйчүүдийг Захирдаг уу?

Христ “эр хүн бүрийн тэргүүн”, “эр хүн бол эмэгтэй хүний тэргүүн” (1 Коринт 11:3) байхаар Бурхан байрлуулсан гэдгийг Паул заадаг байв. Энэ загвар нь захирах буюу давамгайлах хэрэг биш, харин зөв шударга санваарын удирдлагаар

дамжуулан дэг журам хийгээд амар амгаланг бий болгоно гэсэн үг юм. Эрчүүд болон эмэгтэйчүүд нь бие биенээсээ хамааралтай бөгөөд ухаалаг эрчүүд итгэлтэй эмэгтэйчүүдийн санал бодлыг анхааралтай сонсдог.

Судруудыг Судлах нь



1 Коринт 8-11-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А-Г) хоёрыг нь хий.

А Орчин Сеийн Жишээ Гарга

1 Коринт 8:9-13-ыг уншиж, хилэнцийн бүр гадаад байдлаас ч зайлсхийхийн тулд бид хэрхэн анхааралтай байх тухай орчин үеийн жишээ гарга. 1 Коринт 8:4, 8-13-ын “Судруудыг Ойлгох нь” хэсгийг нэгтгэн дүгнэх нь ашигтай байж болно.

Б Сургалтын Хөтөлбөр Зохио

1 Коринт 9:24-27-г уншиж, Паул өөрийн номлолыг юутай харьцуулсныг ол. Тэмдэглэлийнхээ дэвтэрт дараах хүснэгтийг зур. Өөрсдийгөө дасгалжуулагч гэж бодоод тамирчныг салбартаа онцгой амжилт гаргахад нь туслах өөрсдийн биеийн тамирын сургалтын хөтөлбөр дэх алхмуудыг жагсаа. Дараа нь номлол буюу ариун сүмийн гэрлэлтэд бэлтгэхэд нь шаардлагатай сүнсний сургалттай харьцуулалт хий.

Биеийн Тамирын Сургалтын Хөтөлбөр	Сүнсний Сургалтын Хөтөлбөр
1.	1.
2.	2.
3.	3.

В Төгс Эзэмших Судар—1 Коринт 10:13

Хэрэв бид Бурханы зарлигуудад дуулгавартай байхад шийдвэр төгс байх юм бол уруу таталт биднийг дийлж чадахгүй гэдгийг 1 Коринт 10:13-14-т Паул тодорхой хэлжээ. Алма 13:28-ыг уншиж, уруу таталтыг даван туулахын тулд бид Бурханы тусламжийг хүлээн авахад бидэнд хэрэгтэй гэж Алмагийн хэлсэн гурван зарчмыг жагсаа. “Та нар хэрээс хэтэрсэн хүчээр соригдохгүйн” (1 Коринт 10:13) тулд эдгээр зарчмууд та нарт хэрхэн туслах тухай нэг догол мөр бич.

Г Ариун Ёслолоос Хэрхэн Хүртэх нь

Сүмд ирэхийн хамгийн чухал хэсэг нь ариун ёслолоос хүртэх явдал мөн. 1 Коринт 11:20-34-ийг уншсаны дараа Их Эзэний зорьсон байдлаар ариун ёслолоос хүртэхэд бусдад туслах бүрэн удирдамж бич. Заавруудаа хүмүүст өгөхийн тулд картан дээр багтааар товч бич.



1 Коринт 12–14

Сүнсний Бэлгүүд

Манай шашин бусдаас юугаараа өвөрмөц ялгаатайг Нэгдсэн Улсын ерөнхийлөгч асуухад энэ бол ариун сүнсний бэлэг мөн гэж Бошиглогч Иосеф Смит тайлбарласан байдаг. Бид үнэнийг мэдэж, бие биенээ адисалж болохын тулд Ариун Сүнсээр дамжуулан, Өөрийн хүүхдүүд дээр Ариун Сүнсний бэлгүүд хэмээн нэрлэгддэг тусгай адислалуудыг Бурхан хүртээдэг билээ. 1 Коринт 12–14-ыг уншихдаа өөрсдийн адислагдсан Сүнсний бэлгүүдийг эрж хай.

Судруудыг Ойлгох нь



1 Коринт 12

Ялгаатай (ш.4, 6, 10)—
Олон өөр

Үйлдлүүд нь ялгаатай
(ш.6)—Эдгээр бэлгүүдийн ажилладаг арга замууд нь өөр

Бие бол ганц эрхтэн бус
(ш.14)—Сүм бол олон өөр гишүүд бүхий нэг байгууллага мөн.
Хагарал (ш.25)—Бутрал

1 Коринт 12:21–28—Яагаад Сүмийн Гишүүн Болгон Чухал Вэ?



Хувь хүн бүр чухал бөгөөд тусгай бэлгүүд хийгээд авьяасуудыг Сүмд авчирдаг. Сүмд гишүүн болгон хэрэгтэй. Төлөөлөгч, Ахлагч Жозеф Б.Вертлин, “Бид хэн байх нь хамаагүй—бидний авьяас, чадвар, санхүүгийн нөөц, боловсрол эсвэл туршлага ямар байх нь хамаагүй—бид бүгдээрээ хаант улсад үйлчилж чадна. Хэрэв бид даруу байдал, залбирал, хичээл зүтгэл хийгээд итгэлтэйгээр үйлчлэх юм бол, биднийг дууддаг хүн биднийг уг ажилд тэнцэхээр болгох болно. Бидэнд тохирмооргүй санагдаж магадгүй, Их Эзэнд бидний хувиараа өргөх зүйл хэтэрхий бага, тэр ч байтугай, бүр ажиглагдамгүй байна гэж бодон, бид өөрсдөдөө эргэлзэж болно, Их Эзэн бидний мөнх бус байдлыг сайн ойлгодог. Тэрбээр бидний сул талуудыг ойлгодог. Тэрбээр бидний өдөр тутмын амьдралын бэрхшээлүүдийг ойлгодог” гэж хэлжээ (in Conference Report, 1996 оны 4-р сар, 46; *Ensign*, 1996 оны 5-р сар, 34).

1 Коринт 13

Хайр (ш.1)—“Христийн цэвэр хайр” (Моронай 7:47)
Бардам зан гаргадаггүй (ш.4)—Ихэрхэх буюу сагсуурдаггүй
Уурладаггүй (ш.5)—Сэтгэл зовоодоггүй, уурлуулдаггүй

Хэсэгхэн гэдэг нь (ш.10)—
Төгс бус зүйлүүд
Бүдэг бадаг хардаг (ш.12)—
Толинд саатай тусгалыг харах

1 Коринт 14

Урамшуулах (ш.3)—
Сүнсний өсөлт
Тайтгаруулах (ш.3)—
Урамшуулах

Утга (ш.10)—Утга учир
Ээлжлэн (ш.27)—Эмх цэгцтэй байдлаар

1 Коринт 14:2, 4, 13–14, 19, 27—“Хэл”

1 Коринт 14-т хэрэглэгдсэн “хэл” гэсэн үгийг өгүүлбэр бүрд “өөр хэл” гэсэн үгээр Иосеф Смитийн Орчуулгад сольжээ.

1 Коринт 14:4–11, 19—Хэлнүүдийн Бэлгийг Бид Хэзээ Эрэх Ёстой Вэ?

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит, “Хүмүүнд өгөгдсөн Ариун Сүнсний бэлгүүдэд би итгэдэг, гэсэн хэдий ч, хэрэв энэ нь хэрэгтэй болохыг эс тооцвол, би хэлний бэлгийг хүсдэггүй. Нэгэн үед надад хэлний бэлэг хэрэгтэй байсан, тэгээд Их Эзэн үүнийг надад өгсөн. Би хүний нутагт байлаа, хэлийг нь би үл ойлгох хүмүүст сайн мэдээг заахаар илгээгдсэн байлаа. . . Үүнд зорилго байсан юм. Итгэлийг минь хүчтэй болгох, надад урам өгөх, бас тохинуулалд минь туслах ямар нэг юм үүнд байсан юм. Хэрэв танд хэлний энэ бэлэг хэрэгтэй болбол, үүний төлөө эрэлхийл, тэгвэл Бурхан танд туслах болно” гэж хэлжээ (*Gospel Doctrine*, 5 дахь хэвлэл. [1939], 201).

1 Коринт 14:34–35—Эмэгтэйчүүд Сүмд Сг Хэлж Болох уу?

Иосеф Смитийн Орчуулга үг хэлэх гэдгийг удирдах гэдэг үгээр сольжээ. Эмэгтэйчүүд сүмд үг хэлж болдог нь мэдээжийн юм.

Судруудыг Судлах нь



1 Коринт 12–14-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг нь хий.

А Нэвтэрхий Толийн Тайлбар Бич

Сүнсний олон төрлийн бэлэг байдгийг Паул зааж, мөн хэдэн жишээ өгчээ. 1 Коринт 12:4–11-ийг уншиж, Ариун Сүнсний бэлгээр Сүмийн хэтийн төлвийг тайлбарласан нэвтэрхий толийн тайлбар бич. Нэвтэрхий толийн зай хязгаартай учир тавь буюу түүнээс доош үгтэй нэг догол мөрөөр хязгаарла.

Б Энэрэл

Хоёр багана зурж нэгийг нь *Энэрэл Бол*, нөгөөг нь *Энэрэл Бол Биш* гэж гарчигла. 1 Коринт 13:1–7, 13-ыг уншаад, холбогдох гарчгийн дор өгүүлбэр бүрийг жагсаа. Хэн нэгэн хүн чамд энэрлийг үзүүлсэн үеийг дүрсэлснээр төгсгө.

В Би Яагаад Осөх Ёстой Юм Бэ?

1 Коринт 13:9–12-ыг уншиж, сүнсний хувьд өсч хөгжих талаар энэ нь юу заадаг гэж боддоогоо тайлбарла. Тэд өдий болтол зарим зүйлээр хүүхэд шиг байдгийг харуулсан өөрсдийнхөө насны хүмүүсийн зарим чанаруудыг нэрлэ. Дараа нь сайн мэдээнд тэд өсөн хөгжих нь өсөн нэмэгдэж байгаа, өөрсдийн тань насны хүмүүсийн зарим чанаруудыг тогтоо.

Г Сүм Дэх Дэг Журам

Сүм дэх дэг журмын ач холбогдлын талаар Гэгээнтнүүдэд заахыг Паул хүсдэг байжээ (1 Коринт 14:26–40-ийг үз). Доорх хэлсэн үг тус бүрт энэ нь Сүм дэх журамд хэрхэн холбогдоно гэж бодож байгаагаа бич:

1. “Бүх зүйл босгон байгуулахын төлөө хийгдэх болтугай” (1 Коринт 14:26).
2. “Бүгд сурч болохын тулд нэг нэгээрээ бошигло” (ш.31).
3. “Бурхан бол самуурлын Бурхан бус, харин амар амгалангийн Бурхан мөн” (ш. 33).
4. “Тэдэнд [эмэгтэйчүүдэд] захирахыг зөвшөөрдөггүй” (ИСО ш. 34).
5. “Бүх юм зохистой, эмх журмынхаа дагуу байг” (ш. 40).

1 Коринт 15–16

Амилуулалтын Сургаал

Та нарын хайрладаг байсан хэн нэгэн нас барсан уу? Ийм тохиолдолд чамд ямар байсан бэ? Өөрийн цагаатгагч золиослолоор дамжуулан Есүс Христ үхлийг даван туулсан юм. Түүний бэлгийн улмаас үхэл түр зуурынх юм. Бүх хүн төрөлхтөн амилуулагдаж, үхэшгүй байдлыг эдлэх болно.

Паулын үед Христийн Амилуулалтын бодит үнэний талаар зарим хүмүүс эргэлздэг байв. 1 Коринт 15–16-г уншихдаа, Амилуулалтын бодит үнэний тухай Паулын хүчирхэг гэрчлэл, мөн түүнчлэн алдар суугийн гурван зэрэглэл болоод нас барсан хүмүүсийн өмнөөс ариун сүмүүдэд гүйцэтгэсэн ёслолын ажлын талаарх сургаалын үнэнийг эрж ол.

Судруудыг Ойлгох нь



1 Коринт 15

Дэмий хоосон (ш.2, 14, 17)—
Шалтгаангүй, хоосон

Нойрсжээ (ш.6)—Нас
нөхчжээ

Анхны үр жимс (ш.20, 23)—
Эхэнд амилуулагдагчид

Эрхшээлд (ш.28)—
Эрхшээлд оруулсан

Амилах (ш.36)—Амь
өгөгдөх

Амь өгөгч сүнс (ш.45)—
Алдар сууг олсон үхэшгүй
хүн, төгс бие

1 Коринт 15:19—Нас Барагсдын Төлөөх Баптисм




Хэрэв амилуулалт байгаагүй сэн бол нас барагсдын төлөө баптисм хийлгэх шалтгаан Гэгээнтнүүдэд байхгүй байх байсан гэж Паул тайлбарлажээ. Амилуулалт бол бодит байдал бөгөөд нас барагсдын нэрийн өмнөөс гүйцэтгэгддэг энэхүү ёслол тэдний хувьд ч, мөн ёслолуудыг гүйцэтгэдэг хүмүүсийн хувьд ч бас агуу адислалууд болдог гэдгийг тэрээр дараа нь гэрчилжээ.

Бошиглогч Иосеф Смит, “Нас барсан бөгөөд . . . Тэдэнд заахаар итгэмжлэгдэгсдийн зэмсгээр дамжуулан сайн мэдээг сүнсэнд хүлээн авсан төрөл төрөгсдийнхөө төлөө баптисм хүртэх онцгой боломж Гэгээнтнүүдэд байдаг” гэж сургажээ (*History of the Church*, 4:231). Түүнчлэн тэрээр “нас барсан төрөл төрөгсдийнхөө нэрийн өмнөөс үүнийг үйлдэхийг эс тоомсорлодог гэгээнтнүүд, өөрсдийнхөө авралыг эрсдүлдэг” гэж сургажээ (*History of the Church*, 4:426; мөн С ба Г 128:15–18-ыг үз).

1 Коринт 15:40–42—Сэлэстиэл, Тэррэстриэл мөн Тэлэстиэл Биетүүд

Хүн бүхэн амилуулагдах болно, гэвч бид нэг цагт, эсвэл нэгэн адил алдар суугаар бүгдээрээ нас барагсдаас босч ирэх нь үгүй. Хамгийн зөв шударга хүмүүс эхний удаад амилуулагдаж, Түүний мянган жилийн хаанчлалын үед Есүс Христтэй хамт үйлчлэх болно. Зөв шударга багатай нэгэн нь хамгийн сүүлд амилуулагдана. Дараах бүдүүвч Амилуулалтын дэг жаягийг илүү сайн ойлгоход та нарт туслах болно (С ба Г 88:98–102-ыг үз):



1 Коринт 15:42–54—“Муудах Байдал . . . Сл Муудах Байдал”

Муудах байдал гэдэг үгийг Паул үхэлд, түүнчлэн *үл муудах байдал* гэдэг үгийг үхэшгүй байдалд холбогдуулан нилээд хэдэн удаа ашигласан байдаг (1 Коринт 15:42–54-ийг үз). Хэдийгээр бүр бид Амилуулалтад нэгэн адил биеийг хүлээн авах боловч, тэдгээр нь өвчин, ялзрал хийгээд төгс бус байдлын алинд ч хамаагүй, харин тэдгээр нь алдар суут олсон, төгөлдөржсөн хийгээд үхэшгүй байх болно.

Судруудыг Судлах нь

1 Коринтыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Төгс Эзэмших Судар — 1 Коринт 15:20–22

1 Коринт 15:20–22-оос эхэлдэг судрын гинжин хэлхээг жагсаа. Эдгээр харьцуулах ишлэлүүдийг та нар судрынхаа зах дээр бичиж болно.

Б Төгс Эзэмших Судар—1 Коринт 15:29

Ариун сүмд очиж, нас барагсдын өмнөөс баптисм хүртсэн хүнтэй ярилцлага хий. (Хэрэв ийм боломж та нарт өөрсдөд тань байсан бол, энэ тухай хувийнхаа туршлагыг бич.) Дараах асуултуудад хариултыг бич:

1. Нас барагсдын төлөө баптисм хийлгэхэд юу хамгаас илүү чамд таалагдсан бэ?
2. Та нарын үйлчлэл нас барагсдад ямар ашиг тус өгөх вэ?
3. Нас барагсдын төлөөх баптисм яагаад ийм чухал сургаал байдаг гэж та нар боддог вэ?

В Төгс Эзэмших Судар— 1 Коринт 15:40–42

Амилуулалтын тухай буюу эсвэл алдар суугийн гурван зэрэглэлийн тухай гишүүн бус хүн номлогчоос асууж болно гэж өөрсдийн бодсон гурван асуулт бич. Тэгээд 1 Коринт 15-ын шүлгүүдийг ашиглан асуултуудын хариуг бич.



Коринтчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Хоёр Дахь Захидал

Паул Яагаад Коринтод Өөр Захидал Бичих Болсон бэ?

Коринт дахь Сүмийн салбарын асуудлууд үргэлжилсээр байв. Паулын өмнөх захидал дэвшил гаргахад нь Гэгээнтнүүдэд тусалсан хэдий ч, цаашдын заавар хэрэгтэй байв. Энэхүү хоёр дахь захидал Паулын хайрын талаар Гэгээнтнүүдэд итгэл төрүүлж, бүхий л үүргүүддээ итгэлтэй байхаа үргэлжлүүлэхэд нь тэднийг урамшуулан дэмжжээ.



2 Коринт 1–3 Сүнс Амь Өгдөг

Сүмд нэгдсэн олон хүмүүс сайн мэдээний үндсэн зарчмууд, хийгээд Сүмийн гишүүдийн хувьд онцгой өвөрмөц байдаг дадал хэвшилүүд болоод жишгүүдийн талаар сурагцаар байхдаа шилжилтийн үеийг туулж өнгөрүүлдэг. Баптисм нь нэгэнтээ дагаж байсан хуурмаг сургаалууд хийгээд дадал заншлуудаа мартсан шинэ хөрвөгчдийг аяндаа бий болгодоггүй.

Коринтын Гэгээнтнүүд үүнээс ангид байсангүй. 2 Коринт 1–3-т та нар сүнсний сайн сайхан байдалд зайлшгүй хэрэгцээтэй сайн мэдээний зарчмуудын тухай тэдэнд сануулах шаардлагатай байсан тухай унших болно. Паулын заалтын хайрын арга зам тэдгээр Гэгээнтнүүдийг итгэлд нь хэрхэн хүчирхэгжүүлсэн бэ?

Судруудыг Ойлгох нь



2 Коринт 1

Арвин (ш.5)—Элбэг
Тайвшрал (ш.5–7)—
Тайтгарал
Хэтэрсэн хүнд дарамт
(ш.8)—Хэрээс хэтэрсэн ачаатай
Соёрхогдсон (ш.11)—
Илэрхийлэх, өгөх

Махан биеийн (ш.12)—
Дэлхийн
Бодохдоо (ш.17)—
Төлөвлөгөө хийгээд
За за, үгүй үгүй (ш.17–19)—
Тийм, үгүй
Барьцаа (ш.22)—Амлалт

2 Коринт 2

Вий гэсэндээ (ш.3, 7)—
Эмээхдээ
Хэт автуулах (ш.7)—
Хэтэрхий их

Анхилуун үнэр (ш.14–16)—
Сайхан үнэр, анхилуун үнэр

2 Коринт 3

Магтах, итгэмжлэлийн
(ш.1)—Зөвлөмжийн
Үхлийн үйлчлэл, ял
зэмлэлийн үйлчлэл
(ш.7–9)—Мосегийн хууль
Сүнсний үйлчлэл, зөвт
байдлын үйлчлэл
(ш.8–9)—Есүс Христийн
бүрэн сайн мэдээ

Байхгүй болох (ш.13)—
Авагдах, хэрэггүй болох
Бүтээлэг (ш.14–16)—Харах
болоод ойлголтыг хязгаар-
ладаг буюу хаадаг зүйл
Тусган (ш.18)—Толинд

2 Коринт 3:2–4—“Та Нар Бол Бидний Зүрхэнд Бичигдсэн Захидал Минь Юм”

Ахлагч Брус Р.МакКонки, “Төгс утгаараа бол сайн мэдээ нь чулуун хавтан буюу судрын номнуудад биш, харин итгэлтэй хийгээд дуулгавартай хүмүүсийн биенд бичигдсэн юм; тийнхүү гэгээнтнүүд бол үнэний амьд захидлууд, амьдрал нь бүхний хувьд уншихад нээлттэй номнууд юм” гэж хэлжээ (*Doctrinal New Testament Commentary*, 2:414).

2 Коринт 3:6—“Сцэг Хөнөөдөг, Харин Сүнс Амь Өгдөг”

Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар Зөвлөх Ерөнхийлөгч Жеймс И.Фауст, “‘Үсэг хөнөөдөг, харин сүнс амь өгдөг’ гэж Паул хэлжээ: Бид хилэнцээс зөвхөн зайлсхийдэг төдийгүй, зөвхөн сайныг үйлддэг төдийгүй, харин хамгийн чухал, хамгийн агуу үнэ цэнэтэй зүйлүүдийг хийх ёстой. Бид зөн билгээрээ мэдэж, үнэлдэг хэдий ч, жирийн, өнгөц, эсвэл бардамнал мэтээр үзэж, тоодоггүй зүйл болох зүрх сэтгэлийнхээ дотоод зүйлүүдэд анхаарал төвлөрүүлэх учиртай” гэж сургажээ (in Conference Report, 1997 оны 10-р сар, 75; *Ensign*, 1997 оны 11-р сар, 53).



Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон, “Энэ ажилд тооцоо хийдэг нь Сүнс юм” гэж зөвлөжээ (in Conference Report, 1986 оны Дөрөвдүгээр сар, 98; эсвэл *Ensign*, 1986 оны Тавдугаар сар, 77).

Судруудыг Судлах нь

2 Коринт 1–3-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Товчлол Бич

Мөнх бус байдал нь хүндрэл бэрхшээлүүдийг авчирдаг. Бүр Есүс Христ хүртэл Өөрийн мөнх бус байдлын нэг хэсэг болгон зовж шаналахаас аргагүй байсан юм. 2 Коринт 1:3–7-д бид зовлон зүдгүүрүүдийн маань үр дагавар болон ирж болдог зарим адислалуудын тухай мэдсэн билээ. Та нар энэ хэсгийг уншихдаа өгүүлбэр бүрийг өөрсдийн үгээр илэрхийлсэн өгүүлбэрээр товчлол бич.

Б Та Юу Заах Вэ?

2 Коринт 2:1–11 болон Сургаал ба Гэрээ 64:10-ыг судал. Эдгээр судрууд дахь мэдээллийг ашиглан, хэрэв танд дараах нөхцөлүүдтэй тулгарсан найз байгаа бол түүнд юу заахаа ярь:

1. Найз Роберта тань Сүмээс хөөгдсөн эцэгтээ эвгүй хандах болжээ. Тэр яагаад эцгээ уучлах ёстойг танаас асуужээ.
2. Ричард найзаасаа асуулгүйгээр машиныг нь түр авчээ. Тэр машиныг осолд оруулж, засвар хийлгэх мөнгө түүнд байсангүй. Тэр ердөө л уучлаарай гэж хэлжээ.



В Өгүүлбэрүүдийг Гүйцээ

2 Коринт 3:2–18 болон “Судруудыг Ойлгох нь” хэсгийг уншихдаа дараах өгүүлбэрүүдийг гүйцээх санаануудыг эрж хай:

1. Бидний захидлууд “махан биеийн зүрхний самбарт” бичигдсэн гэдэг нь . . . гэсэн утгатай юм.
2. Сүнс сайн мэдээнд амьдралыг өгдөг, учир нь . . .
3. Тэд Бурханыг харах хүсэлгүй бол нүүрээ халхлахыг Мосе хүмүүсээс хүсдэг байсан бол, харин Есүс Христ . . .
4. Бид Есүс Христийг дагахад, бидний нүүр . . .

2 Коринт 4–6

Итгэлээр Алхагтун

Яагаад амьдрал үргэлж та нарын хүссэнээр болдоггүйг та нар гайхаж байна уу, тэр ч байтугай зөв зүйл хийж байхад хүртэл? Сайн хүмүүст муу зүйлүүд тохиолдож болно, түүнчлэн амьдрал зарим үед шударга бус байдаг гэдгийг Паул хүлээн зөвшөөрдөг байв. Есүс Христ бидний гай зовлонд тайвшруулах хүчтэй байж, бүх зүйлийг үүрд мөнхөд зөв болгох хүчтэй байдгийг тэрээр гэрчилдэг байв. Аврагчийн хүчинд итгэх итгэлээр алхах нь хичнээн чухал болохыг 2 Коринт 4–6-гаас бид мэддэг.

Судруудыг Ойлгох нь

2 Коринт 4

Үл хэрэгсэж (ш.2)—
Татгалзаж

Энэ үеийн бурхан (ш.4)—
Сатан; энэ дэлхийн бурхан

Шавар савнууд (ш.7)—
Бидний мөнх бус бие

Бялхсанаар (ш.15)—Элбэг
дэлбэгээр

2 Коринт 4:17—Зовлонг Тэвчсэн Хүмүүст Мөнхийн Агуу Адислалууд Ирдэг



Далын гишүүн Ахлагч Анжел Абреа, “Хэрэв бид итгэлд тэвчээртэй байх юм бол, гай түйтгэр, зовлон бэрхшээлийн цагт ч, тайтгарлын адислалууд хийгээд найдвар бидний амьдралд ирэх болно, мөн Аммон болон түүний ах дүүсийн хүлээн авсан ‘үлэмжийн баяслыг’ эдлэх боломж бидэнд байх болно (Алма 27:17–18; 28:8-ыг үз). Тиймээс, Иосеф Смитийн хэлснээр, ‘Бурханы

Гэгээнтнүүд та нар гуйвшгүйгээр зогсож, арай илүү гэвч, тэгвэл амьдралын шуурга өнгөрөх болно, тэгээд та нар түүний үйлчлэгчид хэмээгдэн Бурханаар шагнагдах бөгөөд Тэрээр Христийн хийгээд Сайн Мэдээний төлөөх та нарын бүхий л хүчир хөдөлмөр хийгээд зовлон зүдгүүрүүдийг зохих ёсоор үнэлэх болно” (*Teachings of the Prophet Joseph Smith*, х. 185)” гэж гэрчилжээ (in Conference Report, 1992 оны 4-р сар, 37; *Ensign*, 1992 оны 5-р сар, 27).

2 Коринт 5

Бидний газар дахь гэр майхан (ш.1)—Бидний мөнх бус биес

Бурханы барилга (ш.1)—Алдар сууг олсон, амилуулагдсан бие

Өмсөх (ш.2–4)—Амилуулагдах

Барьцаа (ш.5)—Баталгаа

Эрүүл ухаантай (ш.13)—Эрүүл саруул ухаантай

Албаддаг (ш.14)—Албадах, эрмэлзэл төрүүлэх

2 Коринт 5:18–20—Эвлэрэл

“Иймийн тул, хайрт ах дүү нар минь, Бурханы таалалд өөрсдийгөө эвлэрүүл, харин чөтгөрийн болон биеийн таалалд бус; мөн та нар Бурханд эвлэрүүлэгдсэнийхээ дараа, та нар аврагдах нь зөвхөн Бурханы ач ивээлд мөн үүний дагуу байна гэдгийг санагтун” гэж Мормоны Номын бошиглогч Иаков сургасан байдаг (2 Нифай 10:24).

2 Коринт 6

Тусалсан (ш.2)—Тайтгаруулсан, тусалсан
Зодуур (ш.5)—Ташуурдан зодох

Жинхэнэ хайр (ш.6)—Цэвэр хайр

Баригдаагүй (ш.12)—

Хязгаарлагдаагүй, зовлонд унаагүй

Дотроо (ш.12)—Зовлон зүдрэлүүд

Белиал (ш.15)—Ёс бус явдал

Итгэгч бус (ш.15)—Үл итгэгч

2 Коринт 6:14–17—Найз Нараа Сонгоход Ухаалаг Бай

“Хүн бүгдэд сайн найз нар хэрэгтэй. Таны найз нарын хүрээ таны сэтгэлгээ хийгээд зан төлөвт, мөн та тэдний-хэд нөлөөлдгийн нэгэн адил ихэд нөлөөлөх болно. Та нийтлэг үнэт зүйлсийг найз нартайгаа хуваалцахад та нар бие биенээ хүчирхэг болгож, урамшуулан дэмждэг. Хэрэв та нарын зарим найз нар тань ичимхий буюу оролцохоосоо зовдог байвал, тэдний бодол санаанд илүү мэд-рэмтгий бай, мөн сайн найз нарын хүчтэй хүрээллийн нөлөөнд татан оруулах замаасаа бүү ухар. Та нар хамтдаа сайн мэдээний амьдралын өндөр жишгийг ханган сахьж чадна” (Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө [эмхэтгэл, 1990], 9).

Судруудыг Судлах нь


2 Коринт 4–6-г судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Хэтийн Гай Зовлонгууд

Амьдрал баяр хөөргүй, хүнд хэцүү байж болно. Юмс бидний найдсанаар болохгүй байгаад сэтгэлээр унаж, хяслан тохиох

нь бидэнд олонтаа байдаг. Ийм цаг үед энэ амьдралын хүндрэл бэрхшээлүүдийг мөнх амьдралтай холбоотой амлалтуудтай харьцуулах юм бол юу ч биш гэдгийг Сүнс гэрчилдэг билээ. Та нар 2 Коринт 4:8–18-ыг уншихдаа мөнх бус байдлын зовлон зүдгүүрүүд нь мөнхийн алдар суугай харьцуулах юм бол юу ч биш гэдгийг гэрчлэхийн тулд Паулын ашигласан өгүүлбэрүүдийг жагсаа.

Б “Сл Итгэгчдийн Хамт Нэг Буулганд Бүү Орогтун”



Та нар нэг буулганд бүү ор

2 Коринт 6:11–18-ыг уншиж, дараах хэлсэн үг тус бүр нь ямар утгатай гэж бодож байгааг, түүний дотор, үүнийг дагахын тулд өөрсдийн тань хийж болох зүйлээс нэг жишээ оруулан тайлбарла:

1. “Үл итгэгчдийн хамт нэг буулганд бүү ор” (Буулга гэдэг бол шар үхрүүдийг ажилд зүтгэж байхад тэднийг хооронд нь холбодог модон хүзүүвч юм.)
2. “Тэдний дундаас гарч тусгаар бай.”
3. “Бузар юманд бүү хүр.”

2 Коринт 7 Бурханлиг Харамсал

Хэрэв жинхэнэ ёсоор наманчлах юм бол, “Бурханы хүслийн дагуух гашуудал” шаардлагатайг Паул сургажээ (2 Коринт 7:10). Та нар 2 Коринт 7-г судлахдаа: “Өөрсдийнхөө үйлддэг буруу зүйлүүдийн төлөө гэмшиж харуусдаг эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийг олно гэдэг ховорхон зүйл. Энэ нь заримдаа тэдний үйл хөдлөл тэдэнд өөрсдөд нь буюу хайртай хүмүүст нь гашуудал, зовлон зүдгүүр учруулсны улмаас байдаг. Заримдаа тэд өөрсдийн үйл хөдлөлөөс болж баригдан, шийтгүүлсний улмаас тэдний гашуудал үүдэлтэй байдаг. Дэлхийн иймэрхүү мэдрэмжүүд ‘Бурханы хүслийн дагуух гашуудал’ болдоггүй (2 Коринт 7:10). Бурханы хүслийн дагуух гашуудал бол Сүнсний бэлэг юм. Энэ бол бидний үйл хөдлөл, бидний Тэнгэрлэг

Эцэгийг хийгээд бидний Бурханыг гомдоосныг гүнээ хүлээн зөвшөөрөх явдал мөн. Энэ бол бидний зан төрх, нүгэл гэдгийг мэддэггүй, бүр бүхнээс хамгийн агуу Аврагч Түүнийг эмзэглэн шаналахад хүргэдэг гэдгийг хурц тодоор ухамсарлах явдал мөн. Бидний нүглүүд Түүний сүв бүрээс цус шүүрэхэд хүргэсэн билээ. Энэхүү туйлын бодитой үнэн оюуны хийгээд сүнсний өвдөлт бол судруудад 'гэмисэн зүрх, харууссан сэтгэл' хэмээн нэрлэгддэг тэр зүйл юм (С ба Г 20:37). Ийм сэтгэл бол жинхэнэ үнэн наманчлалын угтвар нөхцөл мөн" гэж Паул сургажээ (The Teachings of Ezra Taft Benson, 72).



Судруудыг Ойлгох нь



2 Коринт 7

Халуун хүсэл (ш.11)—Чин хүсэл

Судруудыг Судлах нь



2 Коринт 7-г судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Зөвлөгөө Өг

2 Коринт 7:8–11-ийг судалж, өмнөх оршил дахь Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны хэлсэн үгнээс иш тат. Өөрсдийгөө *New Era* сэтгүүлд ажиллаж байгаа, түүнчлэн өсвөр насныхны асуултуудад хариулахыг өөрсдөөс тань хүсчээ гэж бод. Хэрэв дараах гурван нөхцөл байдлууд өөрсдөд тань тохиолдсон бол, наманчлалын талаар өөрсдийн өгөх зөвлөгөөг бич:

1. Тиймээ, би дэлгүүрээс нэг юм авч гарах гээд баригдчихсан, гэвч хүн бүгд л ингэдэг шүү дээ. Энэ бол нэг их сүйдтэй юм биш, наманчлах ч юу байхав, тийм биз дээ?
2. Би бишоптой ярилцсан. Хийсэн зүйлээ би түүнд ярьчихсан, тэгэхлээр одоо бүх юм зүгээр шүү дээ.
3. Бишопт ярих хэрэг надад байхгүй. Хэрэв би үүний талаар зүгээр л залбирчих юм бол, энэ л наманчлахад хангалттай байх болно.

2 Коринт 8–10

Бэлгүүд ба Өглөг

Коринт дахь Гэгээнтнүүдэд өгөх зөвлөгөөгөө Паул үргэлжлүүлж, Есүс Христээс бидний хүн бүрт өгсөн тусгай бэлгийн талаар тэр бичжээ (2 Коринт 8:9-ийг үз). Түүнчлэн тэрээр Аврагчийн үлгэр жишээг дагах хийгээд өөрсдийгөө зориулахаар бид хичээхдээ, үүнийг баяртайгаар хийх ёстойг бас тайлбарлажээ (2 Коринт 9-7-г үз). Паулын заадаг зүйлүүд нь бид өөрсдийнхөө хүлээж авсан бэлгүүдийн төлөөнөө Их Эзэнд алдар сууг өргөж, бүх зүйл Түүнээс ирдгийг хүлээн зөвшөөрөх ёстойг ойлгоход бидэнд тусалдаг (2 Коринт 10:16–18-ыг үз).



Есүс Христ Гетсеманид

2 Коринт 11

Сайн Мэдээний Төлөөх Паулын Золиослол

Бусад номлогч нарын адил Паул сайн мэдээг номлолын тулд төлөөс төлсөн юм. Номлолд үйлчилж байхад нь түүнд тулгарч байсан зовлон бэрхшиэлүүдийн талаар эргэж ирсэн номлогч ярьж байхыг нь та нар хэзээ нэгэн цагт сонссон уу? Паул номлогчийн хувиар биеэрээ туулсан зарим зүйлийн тухай та нар 2 Коринт 11-д унших

болно. Түүнд учирсан гай зовлонгуудаас тэрээр хэрхэн сурагцаж болох байсан хийгээд тэрээр хэрхэн тэдгээрийг тэвчин гарах боломжтой байсныг анхаарч үз.

Судруудыг Ойлгох нь



2 Коринт 11

Гучин ес ташуурдсан (ш.24)—Гучин есөн удаа (ихэвчлэн ташуур буюу шилбүүрээр) ташуурдаж, занчих, зодох

Аюул (ш.26)—Аюул, осол
Цагдаж (ш.32)—Хамгаалж



Судруудыг Судлах нь



2 Коринт 11-ийг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Номлогчтой Ярилцлага Хий



2 Коринт 11:24–33-ыг өөрсдийн таньдаг эргэж ирсэн номлогчтой хамт унш. Дараах зүйлийн тухай өөрсөддөө ярьж өгөхийг түүнээс хүс:

1. Номлолд үйлчилж байхад нь түүнд учирсан зовлон бэрхшээл
2. Уг зовлон бэрхшээлийг Паулд учирч байсантай харьцуулбал ямар байсан

3. Тэрхүү зовлон бэрхшээлийг даван туулахын тулд тэр юу хийсэн бэ?

Зовлон бэрхшээл бидний гэрчлэлүүдийг хэрхэн хүчтэй болгодог тухай богинохон догол мөр бич.

2 Коринт 12–13


Паул Гурав Дахь Тэнгэрт Дээш Аваачигдав

Тэрээр “гурав дахь тэнгэр” —сэлэстиэл хаант улсад “аваачигдсанаа” Паул бичсэн байдаг (2 Коринт 12:2). 1836 онд бас Бошиглогч Иосеф Смит сэлэстиэл хаант улсын тухай үзэгдэл харжээ. Тэрээр бичихдээ:

“Тэр хаант улсын өвлөгчдийн ордог хаалганы хуйларсан галын дөл лугаа үлэмж гоё сайхныг би харав;

“Тэрчлэн дээр нь Эцэг мөн Хүү залардаг Бурханы гялалзсан сэнтийг болой.

“Гаднах төрх нь алтаар бүрсэн мэт харагдах тэрхүү хаант улсын үзэсгэлэнт гудамжуудыг би харав”(С ба Г 137:2–4).



Судруудыг Ойлгох нь



2 Коринт 12

Үгээр хэлшгүй (ш.4)—
Дүрслэхийн аргагүй, ярихад хэтэрхий ариун байж болох
Нударгалах (ш.7)—Дарж байх

Гашуудах (ш.21)—Уй гашуу болох

Тачаангуй байдал (ш.21)—
Хазаардагдашгүй тачаадал

2 Коринт 12:2—Паул Сэлэстиэл Хаант Улсыг Харав

Ахлагч Брус Р.МакКонки, “Паул өөрийнхөө тухай өгүүлэхдээ, сэлэстиэл хаант улс болох ‘гурав дахь тэнгэрт аваа

чигдсанаа' тэрээр хэлжээ" гэж хэлсэн байдаг (*The Mortal Messiah*, 4:394).

2 Коринт 12:7—“Махан Бие Дахь Өргөс”

Паулыг зовоон шаналгаж байсан “махан бие дэх өргөсний” тухай судрууд ч, орчин үеийн илчлэлт ч бидэнд өгүүлдэггүй. Паул номлолын ажилд нь саад болж, өөрийг нь шаналгаж байсан бие бялдрын согогтой байсан гэдэгт олон хүн итгэдэг.

2 Коринт 13

Шалгалтандаа унах (ш.5)— : нарыг буруутгахын тулд
Зохисгүй буюу сорилтонд : бус, та нарыг хүчирхэгжүүл-
унадаг хүмүүс : лэхийн тулд

Нураахын тулд бус, байгуу- :
лахын тулд (ш.10)— Та :

2 Коринт 13:1—“Хоёр буюу Гурван Гэрч”

Бурхан Өөрийн үгсийг дэмжүүлэхийн тулд ямагт нэгээс дээш гэрчээр хангадаг. Үүнийг гэрчүүдийн хууль гэж нэрлэдэг (2 Нифай 11:3–4; С ба Г 6:28-ыг үз). Бүр өнөөдөр ч гэсэн санваарын ёслолуудыг нэгээс дээш гэрчийг байлцуулан гүйцэтгэх ёстой.

2 Коринт 13:12—“Ариун Үнсэлтээр Харилцан Мэндчилээрэй”

Иосеф Смитийн Орчуулга *үнсэлт* гэдэг үгийг халуун мэндчилгээ гэсэн утгатай *мэндчилгээ* гэдэг үгээр сольжээ.

Судруудыг Судлах нь

2 Коринт 12–13-ыг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Судруудыг Ойлгож Сур

Дараах хос судруудыг уншаад, эхний судар нь хоёр дахь судар дахь Паулын заасан зүйлүүдийг илүү сайн ойлгоход та нарт хэрхэн тусалж байгааг тайлбарла:

1. Сургаал ба Гэрээ 137:1–5 болон 2 Коринт 12:1–4
2. Ифэр 12:27 болон 2 Коринт 12:5–10

Б Дуртай Шүлгээ Сонго

Та нар 2 Коринт 13-ыг уншихдаа өөрсдийн тань хувьд нэн ач холбогдолтой санагдсан шүлгийг сонго. Уг шүлгийг тэмдэглэлийнхээ дэвтэрт бичиж, яагаад та нар үүнийг сонгосноо ярь.

Галатчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Захидал

Галатчууд Гэж Хэн Байсан Бэ?

Паулын захидал “Галатын сүмүүд” (Галат 1:2) буюу уг бүс нутаг дахь Сүмийн нилээд хэдэн өөр салбаруудад амьдарч байсан гишүүдэд хандсан байлаа. Галат одоогийн Туркийн төв хэсэгт байдаг байжээ.



Паул Яагаад Энэ Захидлыг Бичсэн бэ?

Эдгээр эхэн үеийн жилүүдэд Галатын Гэгээнтнүүд адил нийтлэг асуудалтай тэмцэж байжээ. Христийн шашинд хөрвөсөн олон Иудей хөрвөгчид Мосегийн хуулийн зарим тодорхой хэсгүүдийг мөрдсөн хэвээр байсан бөгөөд харийн хөрвөгчид Сүмийн гишүүн байхын тулд мөн адил тэдгээрийн дагуу амьдрах ёстой гэж шахааж шаарддаг байлаа. Үнэн хэрэгтээ, Мосегийн хууль нь үргэлж сайн мэдээний

нэг хэсэг байгаагүй юм. Сайн мэдээг Бурхан эхлэлд Адамд өгсөн билээ. Дараа нь Бурхан үүнийг, түүний итгэл хийгээд зөвийг хийх хүслийнх нь улмаас Абрахамд өгчээ. Хожим нь хүмүүс дуулгаваргүй байсны улмаас Мосегийн хууль түр хугацааны үндсэн дээр сайн мэдээн дээр нэмэгджээ. Бага хууль нь Абрахамд байсан бүрэн сайн мэдээг хүлээн авахад хүмүүсийг сургаж, тэднийг бэлтгэх зорилготой байлаа. Галатчуудыг Мосегийн хууль болон Иудейчүүдийн ёс заншилд баригдахгүй, сайн мэдээний дагуу бүрэн амьдрахад нь урамшуулан дэмжихийн тулд Паул Галатчуудад хандан бичжээ.

Юуг Эрэх Вэ

Энэ захидалд Паул Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хувьд ч сурах нь ач холбогдолтой хэд хэдэн зарчмыг эхэн үеийн Гэгээнтнүүдэд бичжээ:

- Хуулинд дуулгавартай байх нь биднийг аварч чадахгүй, учир нь хэн ч хуулиар төгс амьдарч чаддаггүй (Галат 2:16-г үз). Бүх зарлигуудыг сахиснаар тэнгэрт хүрэх замаа олж авч чадна гэж бодон, адил төстэй алдаа гаргадаг хүмүүс өнөөдөр Сүмд байдаг уу?
- Зөв шударга байдал нь зөвхөн Есүс Христэд итгэх итгэлээр дамжин ирдэг. Нүглийг байлдан дагуулахад Тэрээр бидэнд тусалдаг; Бид зөвхөн өөрсдийнхөө хүчинд тулгуурлан зөв шударга байж чадахгүй (Галат 2:16–21-ийг үз).
- Бид Бурханы хөвгүүд охид болдог учраас, бид бас Есүс Христээр дамжуулан Бурханы өв залгамжлагчид болдог (Галат 3-ыг үз).

- Сүнсэнд ойр амьдрах нь махан биеийн нүглүүдийг илүү сайн эсэргүүцэхэд бидэнд тусалж чадна (Галат 5-ыг үз).

Галат 1–2

Хуурамч Багш Нар Үнэн Сайн Мэдээг Гуйвуулав

Паул Есүс Христийн сайн мэдээг Галатын хүмүүст хүргэснээс хойш их удалгүй тэдний дундах Иудейн Христэд итгэгчид, бүр харийнхан ч гэсэн Мосегийн хуулийн дагуу, ялангуяа хөвч хөндөлтийн дүрмийн дагуу амьдрах ёстой хэмээн зааж эхэлжээ (Дээрх “Паул Яагаад Энэ Захидлыг Бичсэн бэ?” хэсгийг үз). Сайн мэдээ хаанаас ирснийг гэрчлэх замаар тэрээр зааж, Паул үүнийг хэрхэн хамгаалж байсныг ажигла.

Судруудыг Ойлгох нь



Галат 1

Гуйвуулах (ш.7)—Өөрчлөх, мушгин гуйвуулж өөрчлөх
Хараагдаг (ш.8)—Зүхэгдэг, хараал идэг

Тусгаарлаж (ш.15)—Салгаж, тусад нь байлгаж
Би махан биетэйгээ, цустайгаа зөвлөсөнгүй (ш.16)—Газар дээрх хэн нэгэнтэй би зөвлөлдсөнгүй

Галат 1:14—“Өвөг Дээдсийнхээ Ёс Заншил”

“Өвөг дээдсийнхээ ёс заншил” гэж Паул гэр бүлийнхээ шашны уламжлалуудын тухай бичжээ. Тэрээр идэр залуу насандаа Фарисай болж сургагдсан ажээ (Үйлс 26:5-ыг үз). Иудейн багш нараас судруудын талаар бичсэн дүрмүүд хийгээд хувийн санаа бодол нь жинхэнэ судруудтай эн дүйцхүйц ач холбогдолтой гэдэгт Фарисайчууд итгэдэг байжээ. Фарисайчууд ийнхүү сүнсээр нөлөөлөгдөөгүй эдгээр дүрмүүдэд дуулгавартай байдлаараа нэн хатуу (чанд) байлаа (Марк 7:10–13-ыг үз).

Галат 2

Бид тэдний эрхэнд хормын зуур ч ороогүй (ш.5)—Бид тэдний эрхэнд бүр ганцхан цаг ч ороогүй
Эсрэгээр (ш.7)—Нөгөө талаар, эсрэгээр

Идэвхтэй ажилласан (ш.8)—Үр ашигтай ажилласан
Кеф (ш.9)—Төлөөлөгч Петр

Галат 2:7–9—“Хөвч Хөндүүлээгүй Хүмүүсийн Төлөөх Сайн Мэдээ . . . Хөвч Хөндүүлсэн Хүмүүсийн Төлөөх Сайн Мэдээ”

Төлөөлөгч Паул сайн мэдээг Харийнханд (“хөвч хөндүүлээгүй хүмүүс”) хүргэжээр дуудагдсан байлаа, харин Петр

Иудейчүүдийн дунд тохинуулахаар чиглүүлэгдсэн ажээ (“хөвч хөндүүлсэн хүмүүс”).

Галат 2:11–16—“Петрийг Ирэхэд . . . Би Түүнийг Нүүрэн Дээр нь Эсэргүүцэв”

Паул Петртэй санал нийлэхгүй байгаа талаараа юу ч илчилсэнгүй. Петр Иудей хөрвөгчдийг гомдоохоос эмээж, Иудейн ёс заншил шаарддагийн дагуу харийн хөрвөгчидтэй хамт хооллохоо зогсоосон бололтой. Есүс Христийн сайн мэдээний дагуу бүрэн амьдрахын оронд ёс заншил бууж өгсөн Петртэй Паул олны өмнө сөргөлджээ. Ахлагч Брус Р.МакКонки, “Хэрэв бидэнд бүрэн шастир байсан бол, өөрсдийгөө бүрмөсөн өөрчилж, Мосегийн хууль Христэд гүйцэлдэж, Иудей хийгээд Харийнхан хоёуланд нь үүнээс хойш хэрэглэгдэхгүй болсныг Иудейн гэгээнтнүүдэд итгүүлэхийн тулд Петр өөрийнхөө хүч хүрэх бүхнийг хийх байсныг бид олж мэдэх байсан нь эргэлзээгүй” гэж бичжээ (*Doctrinal New Testament Commentary*, 2:464).

Судруудыг Судлах нь



Галат 1–2-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Паулын Захиасыг Нэгтгэн Дүгнэ

Галат 1–2-т Паул Галатын Гэгээнтнүүдийн талаар санаа зовж байсан зүйлээ илэрхийлжээ. Бас тэрээр өөрийн Төлөөлөгчийн дуудлага хийгээд зааж байсан сайн мэдээний захиасыг хамгаалж байв.

1. Дараах асуултуудад хариулах замаар Галат 1–2-ын гол санаануудыг нэгтгэн дүгнэ. (Тусалцаа авахын тулд энэ гарын авлага дахь Галатын оршил болон Галат 1–2-ын “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз.)
 - a. Галат дахь Гэгээнтнүүдийн төлөө Паулын санаа зовж байсан гол зүйл юу байсан бэ?
 - b. Сүмийн зарим Иудей гишүүд хүмүүст заахыг оролдож байсан “бусад сайн мэдээ” (Галат 1:8–9-ийг үз) нь юу байсан бэ? Энэ нь яагаад үргэлжлэх учиргүй байсан бэ?
 - v. Петр, Паул хоёрын хооронд болсон зүйлийн талаар бид юу мэддэг вэ?
2. Өнөөдөр хүмүүс уруу татагдаж болох зарим “бусад сайн мэдээнүүдийг” (Есүс Христийн сайн мэдээний оронд хүмүүсийн санал болгодог хуурамч сургаалууд) тэмдэглэлийнхээ дэвтэрт дүрсэл.

Галат 3–6

Итгэлийн Сайн Мэдээ Мосегийн Хуулиас Өмнө Ирсэн Юм

Есүс Христэд итгэх итгэлтэй байснаараа Абрахам зөв шударга болсон бөгөөд Түүний сайн мэдээ нь дуулгавартай байдлаар дамжин Мосегийн хуулиас урт




удаан хугацааны өмнө өгөгдсөн юм гэдгийг Паул Галатын Гэгээнтнүүдэд сануулдаг байжээ. Израилын хүүхдүүд (Галатын Гэгээнтнүүдийн өвөг дээдэс) Египетээс гаргаж авчрагдсан тэр үед тэд бүрэн сайн мэдээний дагуу амьдрахад

бэлэн биш байсан учир Абрахамын амьдарч байсан илүү дээд хуульд тэднийг бэлтгэхийн тулд Мосегийн хууль өгөгдсөн юм гэдгийг тэрээр заадаг байлаа.

Энэхүү илүү өндөр хуулийг хийж, сахиснаар, бид Бурханы хүүхдүүд болж, сүнсээр дахин төрж чадна. Бид “Сүнсэнд алхахыг” эрэлхийлсэн үед (Галат 5:16) дахин төрөхөд Бурхан бидэнд хэрхэн тусалдгийг ажигла.

Судруудыг Ойлгох нь



Галат 3

Та нарын нүдний өмнө . . . та нарын дунд цовдлогдсон (ш.1)—Есүс Христийн Цагаатгал та нарын дунд тодорхой заагдаж байсан учраас

Харь үндэстнүүд (ш.8)—Абрахамын удам буюу гэр бүлийн бус хүмүүс

Хүний гэрээ байлаа ч гэсэн батлагдсан л бол хүчингүй болгохгүй (ш.15)—Бүр хүмүүсийн хоорондох гэрээ нүүдийг ч гэсэн хууль бусаар цуцлах буюу өөрчилж болохгүй
Зууч (ш.19, 20)—Хоёр хүний хооронд зуучилж, асуудлыг шийдэхэд тусалдаг хүн

Галат 3:2–5—Итгэл ба Сүнс

“Итгэлийг сонссоноор” (Галат 3:2, 5) тэд Сүнсийг хүлээн авсныг Паул Галатын Гэгээнтнүүдэд сануулдаг байв. Тэд Мосегийн хуулийг дуулгавартай дагаж байсны улмаас бус, харин сайн мэдээг сонсож хүлээн авсан учир тэд Есүс Христийн тухай гэрчлэлтэй болжээ. Бошиглогч Иосеф Смит, “Бурханы үгийг сонссоноор, Бурханы үйлчлэгчдийн гэрчлэлээр дамжин тэрхүү гэрчлэл бошиглолын хийгээд илчлэлтийн Сүнсээр ямагт ирдэг” гэж хэлжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 148).

Галат 3:8–11, 24—Бид Хэрхэн Зөвтөгөгддөг Вэ?

“Шударга байх” буюу “зөвтөгдөх” гэдэг нь нүглийн гэм буруугүй, цэвэр хийгээд Бурханд хүлээн авагдахуйц байхаар мэдэгдэнэ гэсэн үг. Мосегийн хуулиар амьдрах нь тэднийг зөвтгөхгүй гэдгийг Паул Галатын Гэгээнтнүүдэд заадаг байв. Мосегийн бага хууль, сайн мэдээний илүү өндөр хуулийн аль алианаар хэн ч гэсэн төгс амьдарч чадахгүй учраас Тэнгэрлэг Эцэг Гэтэлгэгчийг илгээхээр амласан ажээ. Есүс Христийн Цагаатгалд итгэх итгэлээр дамжуулан, тэрчлэн сайн мэдээний хуульд дуулгавартай байснаар, тэр ч байтугай Мосегийн хуулийг огт мэддэггүй байсан Харийнхан хүртэл аврагдаж чадна.

Галат 3:16–19—Абрахамын Гэрээ ба Мосегийн Хууль

Сайн Мэдээ болон Аврагч түүний гэр бүлийн үр удмаар дамжин ирэх тухай Их Эзэн Абрахамтай гэрээнд орсныг Паул тайлбарладаг байжээ. Израилчууд дуулгаваргүй байсан учраас тэднийг Есүс Христийн ирэлтэд бэлтгэхийн тулд Мосегийн хуулийг Их Эзэн түр хугацаагаар нэмж өгсөн юм. Хэдий тийм ч Мосегийн хуулийг нэмж өгсөн нь Аврагч ирэх хийгээд сайн мэдээг дахин авчрах амлалтыг цуцлаагүй юм.

Галат 4

Асрамжлагсад болоод итгэмжлэгдсэн хүмүүс (ш.2)—Багш нар болон хамгаалагчид

Та нар өдрүүдийг сахидаг (ш.10)—Мосегийн хуулийн хэсэг байсан ариун өдрүүд болон баяруудыг Паул хэлсэн бөгөөд эдгээрийг цаашид сахих шаардлагагүй байв

Хичээнгүй байх, хичээнгүй байлгах (ш.17)—Та нарыг өөрчлөхөөр ихэд чармайдаг
Зовлон эдлэх (ш.19)—Зовлон үзэх
Үлгэрлэсэн (ш.24)—Зүйрлэсэн, адилтгасан
Төрүүлэх (ш.24)—Хүүхэд төрүүлэх

Галат 4:5—“Ингэснээр Бид Хөвгүүд нь Адил Срчлэлийг Хүлээн Авч Болно”

Ахлагч Брус Р.МакКонки, “Сайн мэдээг хүлээн авч, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд нэгддэг хүмүүст Бурханы хүүхдүүд болох хүч өгөгддөг (С ба Г 11:30; 35:2; 39:1–6; 45:8; Иохан 1:12). Ганцхан сүмийн гишүүнчлэлээр Бурханы хүүхдүүд болдоггүй, харин хэрэв үүнийг итгэл, өөрсдийгөө бүрэн зориулах явдал дагалдах юм бол, Сүмд элсэх нь ийм өндөр байр суурийн үүд хаалгыг нээж өгдөг. (Ром 8:14–18; Галат 3:26–29; 4:1–7.) Бурханы хүүхдүүд бол түүний гэр бүлийн гишүүд бөгөөд эндээс Христтэй хамт нэгдсэн—өв залгамжлагчид болж, түүнтэй хамт Эцэгийн бүх юмыг өвлөх болно” гэж заажээ (С ба Г 93:17–23). (*Mormon Doctrine*, 745).

Галат 4:22–31—Хоёр Гэрээний Тухай Ёгтлол

Тэд яагаад өөрсдийгөө Мосегийн хууль болон үүний ёс жагуудтай холбох ёсгүйг Галатын Гэгээнтнүүдэд ойлгоход нь туслахын тулд Паул Мосегийн хууль болон Есүс Христийн сайн мэдээг Абрахамын хоёр эхнэр болон тэдний хөвгүүдтэй зүйрлүүлсэн хоёр гэрээний тухай ёгтлолыг ашигладаг байжээ.



Абрахамын Эхнэрүүд: Хуучин, Шинэ Хоёр Гэрээний Бэлэгдлүүд

Хагар (Агар), шивэгчин эмэгтэй, махан биеийн дагуу хүү (Ишмаел) төрүүлжээ.

Сара, эрх чөлөөт эмэгтэй, гайхамшгаар, амлалтын хүү (Исаак) төрүүлжээ.

Хагар, Ишмаел хоёрыг Паул, Синайн Уулан дээр хүлээн авагдсан Мосегийн хуулийн, түүнчлэн бас Ромчуудын боолчлолд байсан, дэлхийн хот Иерусалимын боолчлолын бэлэгдэл болгон ашигласан байдаг.

Сара, Исаак хоёрыг Паул, Өөрийн сайн мэдээтэй хамт Есүс Христийн авчирсан эрх чөлөө болон боолчлолоос чөлөөтэй тэнгэрлэг Иерусалимын бэлэгдэл болгон ашиглажээ.

Мосегийн хуулиас зуурч авсан Иудейчүүд бол боолчлолын хүүхдүүд юм. Хагар, Ишмаел хоёр Сара, Исаак хоёрыг мөшгин хавчиж байсантай яг адил, тэд Христэд итгэгчдийг мөшгин хавчихаа үргэлжлүүлсээр байдаг.

Есүс Христийн сайн мэдээг хүлээн авдаг Христэд итгэгчид Мосегийн ёс жаягуудаас чөлөөтэй бөгөөд Абрахамтай хийсэн амлалтуудыг өвлөгчид юм.



Мосегийн хууль болон ахмадуудын ёс заншлыг Паул “боолчлолын буулгатай” зүйрлүүлжээ (Галат 5:1).

Галат 5

Үзэл бодол (ш.8)—Итгэл
Хөрөнгө (ш.9)—Талхыг том болгож исгэдэг хөрөнгө; жижигхэн хуурамч сургаал хүнд буюу эсвэл бүлэг хүмүүст бүхэлд нь нөлөөлж болно гэдгийг Паул хэлжээ.

Махан биеийн төлөөх таатай боломж (ш.13)—Ёс бусаар үйлдэх аян шалтаг болгож

Тачаангуй байдал (ш.19)—
Ёс бус хүсэл ба үйлдлүүд
Маргаан хардалт (ш.20)—
Зөрчил, тэмцэл
Атаархал (ш.20)—Атаа жетөө

Галат 5:2–6—Хуульд Итгэхүй

Эдгээр шүлгүүдэд хөвч хөндүүлсэн гэдэг үгийг Паул Мосегийн хуулийн бэлэгдэл болгон ашигласан байдаг. Иудейн ёс заншлууд болон Мосегийн хууль тэднийг аварч чадна гэдэгт итгэдэг хүмүүс бүхэл хуулиар шүүгдэх бөгөөд хэрэв тэд төгс дуулгавартай байхгүй аваас, буруутгагдах болно гэж тэр ярьдаг байв. Сайн мэдээний илүү өндөр хуулийг хүлээн авсан хүмүүс, хэрэв наманчилж, Есүс Христэд итгэх итгэлтэй байх аваас, нүглүүдээсээ өршөөгдөх болно.

Галат 6

Буруу юманд эзэмдүүлэх (ш.1)—Нүгэл үйлдсэн бол
Хуваалцдаг (ш.6)—
Хуваалцдаг

Ялзрал (ш.8)—Устгал, сүнсний үхэл

Галат 6:17—“Би Биедээ Их Эзэн Есүсийн Ормуудтай Билээ”

Энэ шүлэгт Паул Есүс Христийн үйлчлэлд өөрийн туулж өнгөрүүлсэн зовлонгуудыг хэлжээ (мөн 2 Коринт 11:23–25; Филиппий 3:10–12 үз).

Судруудыг Судлах нь

Галат 3–6-г судлахдаа үйл ажиллагаа А-г, дараа нь үйл ажиллагаа Б, В-ны аль нэгийг хий.

А Мосегийн Хуулийн Зорилго

Галат 3-ыг нэгтгэн дүгнэ. Хэрэв Абрахам бүр тэрч байтугай Мосегийн хуулийн тухай огт мэдэхгүйгээр зөв шударга амьдрах боломжтой байсан юм бол, уг хуулийн зорилго юу вэ? (Хэрэв тусламж хэрэгтэй бол Галат 3-ын “Судруудыг Ойлгох нь” хэсгийн хуудас 153-ыг үз).

Б Өөрсдийнхөө Мэдлэг Сорих Асуултуудыг Бич

Үйл ажиллагаа А дахь асуултыг загвар болгон ашиглаж, Галат 4–6-г нэгтгэн дүгнэж бүлэг бүрийн хувьд сайн тохирно гэж өөрсдийн бодсон, дахиад зургаан асуулт бич (бүлэг бүрт хоёр). Асуулт бүрийн дараа зөв хариуг оруулахад анхаар.

В Сүнсний Тулалдаан Та Нарт Хэрхэн Явагддаг Вэ?

Сүнс болон махан бие нь бие биенийхээ эсрэг үргэлж тэмцэлддэг тухай Паул зааж байжээ. Та нарын амьдралд аль нь ялж байна?

1. Тэмдэглэлийнхээ дэвтэрт хоёр багана гаргаж нэгийг нь *Махан Биеийн Ажлууд*, нөгөөг нь *Сүнсний Үр Жимсүүд* гэж нэрлэ. Галат 5:16–26-г уншиж, эдгээрийг тус бүрийг нь дүрсэлдэг түлхүүр үгс болон өгүүлбэрүүдийг жагсаан бич. Жагсаалтыг тунгаан бодоод, өөрсдийн тань хувьд сүнсний дайн хэрхэн явагдаж байгааг тодорхойл.
2. Галат 6:1–9-ийг уншиж, сүнсний тулалдаанд өөрсдөд тань тусалж чадах Сүнсний илүү үр жимстэй байхын тулд өөрсдийнхөө хийж болох гурван зүйлийг нэрлэ.

Ефесчүүдэд Бичсэн Толоологч Паулын Захидал

Ефесчүүд Хаана Амьдарч Байсан Бэ?

Ефесчүүд одоогийн баруун Турк дэх Эгейн Тэнгис дээрх худалдаа, соёлын чухал төв Ефест амьдарч байв. Энэ бол Артемис буюу Дианагийн охин тэнгэрийг тахин шүтдэг төв байжээ. Дианагийн ариун сүм бол эртний дэлхийн гайхамшгуудын нэг, Ефесийн наймаачдын эд баялгийн эх сурвалж байв (Үйлс 19:24–27-г үз).



Паул Яагаад Энэ Захидлыг Бичсэн бэ?

Паулын захидлуудаас олон нь урвалтыг зогсоох буюу сургаалын зарим алдааг залруулахын тулд бичигдсэн байлаа. Ефесчүүдэд бичсэн Паулын захидал өөр юм. Энэ бол сайн мэдээний илүү их гэрлийг Гэгээнтнүүдэд өгөх зорилготой, сургаалын заадаг зүйлүүдийг дээш өргөх эрдэнэсийн сангийн хайрцаг юм. Паул энэ захидлыг МЭ 60 оны орчим Ромд шоронгоос бичжээ.



Юуг Эрэх Вэ

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн заадаг олон сургаалыг Ефест заадаг. Урьдчилсан томилолтын сургаалын ишлэлүүд, цаг хугацааны бүрэн байдлын эрин үе, Сүм дэх бошиглогчид хийгээд төлөөлөгчдийн ач холбогдол, цорын ганц үнэн хийгээд нэгдмэл сүм байх тухай санаа, түүнчлэн Сүмийн байгуулалт зайлшгүй чухал болох тухай баримтыг

бид үүн дотроос олж үздэг. Энэ захидалд бид гэр бүлийн үүрэг болон гэр бүлийн зохистой амьдралын ач холбогдлын талаарх хамгийн сүнслэг, хамгийн дээд оргил болсон зарим сургаалыг олж үздэг.

Ефес 1–3

Есүс Христийн Сүмийн Нэн Чухал Сургаалууд

Хэрэв бусад хүмүүс Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн нэгэн адилаар Ефесийн эхний гурван бүлгийг үнэнээр нь ойлгосон бол, Христэд итгэгчдийн дунд өнөөдрийнх ишиг ийм их будлиан төөрөгдөл байхгүй байх байсан. Мөн Христийн ийм олон өөр сүмүүд ч байхгүй байх байсан биз. Та нар Ефес 1–3-ыг уншихдаа, Бурхан Тэргүүтэн, урьдчилсан томилолт, ач ивээл, Цагаатгал, түүнчлэн Есүс Христийн Сүмийн тодорхойлолтын талаар Паул юу заасныг ажигла.

Судруудыг Ойлгох нь



Ефес 1

Урьдаас тогтоожээ (ш.5, 11)—Тусгай адислалууд хийгээд үүргүүдийн тулд мөнх бус байдлын өмнөх оршигчид урьдчилсан томилогдож, сонгогдсон

Хөвгүүд болгон үрчилж авах (ш.5)—Бурханы хөвгүүд охид болж сүнний хувьд дахин төрөх (Мозая 27:25–26-г үз)

Гүнзгий мэдлэг (ш.8)—Ойлголт

Хүслийнхээ нууцыг (ш.9)—Илчлэлтээр биш бол ойлгогдох боломжгүй, мөн дараа нь ариунаар хадгалагддаг, Өөрийнхөө хүүхдүүдэд зориулсан Бурханы төлөвлөгөөний тухай үнэнүүд

Бидний өвийн батлан даагч (ш.14)—Сэлэстиэл хаант улсыг олж авах баталгаа

Бүх засаг захиргаа (ш.21)—Аль нэг хаан буюу захирагч

Ефес 1:4–5—“Тэрээр Биднийг Өөрийнхөө Дотор Дэлхийн Сууринаас Өмнө Сонгосон Юм”

Үнэнийг мэдэх хийгээд зөв шударгаар амьдрах яг нэгэн адил хүсэл бүх хүмүүст байдаггүй. “Тэрээр биднийг Өөрийнхөө дотор дэлхийн сууринаас өмнө сонгосон юм” гэж Паул бичжээ (Ефес 1:4). Тэнгэрлэг Эцэгийн зарим хүүхдүүд, үнэн өөд чиглэсэн хүмүүсийн хандлага дахь ялгааг тайлбарлахад тусалдаг тодорхой дуудлагуудад “сонгогдон”, “урьдчилан тогтоогдсон” (урьдчилан томилогдсон) байдаг.

“Урьдчилсан томилолт нь мөнх бус байдал дахь зөв шударга байдлын төлөөх адислал буюу шагнал болон ирдэг бөгөөд Есүс Христийн төлөөх шийдвэр төгс байдал юм. Израилын угсаанд төрж, Абрахам, Исаак, Иаковын бүх адислалуудыг залгамжлах нь бүхнээ зориулдаг бодгалиудын өв залгамжлах эрх хэмээн тооцогдох нь олонтаа байдаг (Ефес 1:4-5; Ром 9:4-ийг үз). Эдгээр эрхүүд хийгээд адислалуудыг энэ амьдралд болон дараагийн амьдралд хүлээн авахаар сонгогдсон нэгэн, эсвэл бүгдээрээ олж авч болдог (in Daniel H. Ludlow, ed., *Encyclopedia of Mormonism*, 5 боть зохиол. [1992], 2:522).

Ефес 1:10—“Цаг Хугацааны Бүрэн Байдлын Эрин Се”

Тэнгэрлэг Эцэг дэлхийн түүхийн янз бүрийн үеүдэд сайн мэдээг хүмүүнд илчилж иржээ. Адам, Ноа, Мосе нарт өгөгдсөн Бурханы илчлэлтүүд жишээ нь байна. Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан илчлэгдсэн сүүлчийн (манай эрин) энэ эрин үе Паулаар бошиглогдож, “цагийн дүүрний (цаг хугацааны бүрэн байдлын) эрин үе” гэж нэрлэгджээ (Ефес 1:10). Бүх зүйлүүд бол өмнөх аль ч эрин үеүдийн нэг хэсэг байсан нь эдүгээ Есүс Христэд хамтдаа цуглуулагдах учраас энэ нэрийг манай эрин үед өгсөн ажээ (С ба Г 128:18-ыг мөн үз).

Ефес 1:13—“Амлалтын Ариун Сүнсээр Тамгалагдагсад”

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит тайлбарласан нь:

“Амлалтын Ариун Сүнс бол ёслол бүр дээр: баптисм, гишүүний баталгаа, томилолт, гэрлэлт дээр баталгаажуулсан тамга дардаг Ариун Сүнс юм. Итгэлтэй байдлаар дамжин адислалууд хүлээн авагдах болно гэдэг нь амлалт мөн.

“Энэ нь баптисм ч байна уу, томилолт ч байна уу, гэрлэлт буюу өөр юу ч байлаа гэсэн, хэрэв хүн гэрээг зөрчих юм бол, Сүнс баталгаажуулсан тамгыг буцаан авч, ингэснээр адислалууд хүлээн авагдахгүй болдог” (*Doctrines of Salvation*, 1:45; С ба Г 132:7-г мөн үз).

Ефес 2


Амьд болгосон (ш.1, 5)— Амьдруулсан	Хөвч хөндүүлээгүй (ш.11)— Харийнхан
Заншил (ш.2)—Арга зам	Хөвч хөндүүлсэн (ш.11)— Иудейчүүд
Агаарын хүчний ноёрхогч (ш.2)—Сатан	Ойр (ш.13, 17)—Хол биш, ойрхон

Ефес 2:4-10—“Учир нь Та нар Ажлуудаар Бус . . . Ач Ивээлээр Аврагддаг”

Бид итгэлээр дамжуулан ач ивээлээр аврагддаг хэмээн Паул хэлсэн учир бид аврагдах уу, үгүй юү гэдэгт бидний хийдэг аливаа зүйл ямар ч нөлөө үзүүлэхгүй—энэ бол Бурханаас ирэх төгс бэлэг гэдэгт зарим хүмүүс итгэдэг. Энэ үзэл бодол “ажлуудгүйгээр итгэл үхмэл юм” гэсэн Иаковын сургаалтай харшилж байна (Иаков 2:10-26).

Мормоны Номны бошиглогчдод өгсөн Их Эзэний илчлэлтүүд энэхүү чухал сургаалыг тодруулахад тусалдаг. Хүн дуулгавартай байдлаараа аврагдахуйцаар хуулийн дагуу хангалттай сайнаар амьдарч чадахгүй нь үнэн юм бол (Ром 3:20-23; 2 Нифай 2:5-ыг үз), дуулгавартай байдал чухал биш гэдгийг энэ нь харуулж байгаа хэрэг биш юм. Хэрэв бид зарлигуудыг сахихад хичээл зүтгэл гаргахгүй юм бол, зөв-

хөн итгэлтэй байх нь хангалтгүй юм (Матай 7:21; Иаков 2:17-19-ийг үз).



Дагалдах зургуудыг харуулснаар, бид бүгд сэлж чаддаггүй, тэгээд голд живж байгаа хүнтэй адилхан юм. Аврагч голын эрэг дээр зогсож, биднийг аврахын тулд гараа сунган мөчир өгч байна. Тэр мөчир бол Цагаатгалаар дамжуулан бидэнд санал болгосон Бурханы ач ивээл бөгөөд Цагаатгалгүйгээр бид аврагдаж чадахгүй. Хэрэв бид тэр мөчрөөс барьж авахын тулд урагш ухасхийх хүч чармайлт гаргахгүй юм бол, бид живэх болно. Гэвч бид үүнийг ганцаархнаа хийхгүй л дээ. Хэрэв бид хичээх юм бол, Бурханы ач ивээл бидний хүч чадлыг нэмэгдүүлж, тэсч гаран, улмаар аврагдах хүчийг бидэнд өгөх болно. Бошиглогч Нифайн хэлсэнчлэн, “Бид ач ивээлээр л аврагддаг гэдгийг бид мэднэ, бидний хийж чадах бүхний дараа буюу” (2 Нифай 25:23; налуу бичиглэлийг нэмэв).

Ефес 2:14-17—“Бидний Хоорондох Хуваагдлын Хана . . . Нурав”

Есүс Христийн Цагаатгал Мосегийн хуулийг төгсгөл болгосон юм. Тэгээд Христ сайн мэдээ бүх дэлхийд номлогдохыг зарлиглажээ (Марк 16:15-16-г үз). Иудейчүүд болон Харийнханыг хуваагдал буюу хана мэтээр зааглан тусгаарлаж байсан дайсагнал (өшөөрхөл) Цагаатгалаар дамжин үгүй болжээ (халагджээ).

Ефес 2:19—“Ариун Хүмүүсийн Адил Нутгийн Иргэд”

Хэрэв тэд Христэд итгэх итгэлтэй байж, наманчлан, өөрсдийгөө бэлтгэх юм бол, баптисмын ёслолоор дамжуулан хүн болгон Гэгээнтнүүдтэй нутгийн иргэд (нөхөд) байж чадна. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд хэзээ ч ганцаараа гэж бодох хэрэггүй; анхаарал халамж тавихад нь туслах ах эгч нар тэдэнд байдаг.

Ефес 2:20—Төлөөлогчид Болон Бошиглогчдоор Дамжсан Илчлэлт Энэн Сүмд Зайлшгүй Чухал уу?



Арванхоёр Төлөөлогчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Марк Е.Петерсен, “[Үнэн Сүмийн] өөр нэг чухал тэмдэг бол уг Сүм амьд бошиглогчдоор дамжуулан хүлээн авдаг байнгын илчлэлтээр уирдагддаг байх явдал мөн. Эрх мэдэл олгогдсон Өөрийн бошиглогчдоор дамжуулахгүйгээр Их Эзэн юу ч хийх боломжгүй гэж Амос хэлсэн байдаг (Амос 3:7-г үз). Бурханлиг

Сүм сэргээгдсэн болохоор, тэнгэрээс байнгын чиглүүлэл хүлээж авдаг амьд үзмэрчид хийгээд илчлэгчдээр удирдагдах болно” гэж гэрчилжээ (in Conference Report, 1979 оны 4-р сар, 31; *Ensign*, 1979 оны 5-р сар, 22–23).

Ефес 3

Та нарын төлөөх . . .

Бурханы нигүүлсэл (ш.2)—
Харийнханд тохинуулахын тулд Паулд өгөгдсөн Бурханы хүч хийгээд ач ивээл (нигүүлсэл)

Нууц (ш.3, 9)—Зөвхөн илчлэлтээр мэдэгдэж, тэгээд ариунаар сахигддаг бурханлиг үнэн

Захирагчид (ш.10)—

Захирагчдын засагладаг бүс нутаг

Түүнд бид зоримог байдал . . . бат итгэлтэйгээр (ш.12)—Есүс Христэд итгэх итгэлтэй бол бид Бурханд бат итгэлтэйгээр хандаж болно.

Ефес 4–6

Шавийн Зан Төлөв

Хэрэв хүн Ефес 1–3-т Паулын дүрсэлсэн сургаалуудад итгэж, тэдгээрийн дагуу амьдарч байсан бол тэр амьдралдаа ямар өөрчлөлт гаргах байсан бэ? Тэр хүн бусад хүмүүсээс өөр байдалтай харагдах буюу үйлдэх байсан уу? Ефес 4–6, Христийн жинхэнэ шавийг Паул хэрхэн дүрсэлснийг эрж ол.

Судруудыг Судлах нь

Ефес 1–3-ыг судлахдаа үйл ажиллагаа В-г мөн наад тал нь өөр нэг үйл ажиллагааг (А, Б буюу Г)-гээс хий.

А Сургаалыг Ол

Ефес 1-ийг нэгтгэн дүгнэж, Бурхан Тэргүүтний мөн чанарыг дүрсэлсэн наад зах нь гурван шүлгийг ол. Эдгээр шүлгүүд Бурхан Эцэг болон Есүс Христ нь хэрхэн тусдаа хүмүүн биесүүд болохыг харуулдгийг тайлбарла.

Б Сүнсний Адислалуудыг Ол

Ефес 1:3–14-т Есүс Христийн улмаас итгэлтэй хүмүүст ирдэг сүнсний зарим адислалуудыг Паул жагсаажээ. Уг адислалуудыг жагсааж, эдгээр нь яагаад та нарт ач холбогдолтойг ярь.

В Сургаалыг Тайлбарла

1. Ефес 2:4–10-ыг нэгтгэн дүгнэж, дараа нь Иаков 2:17–20-ийг унш. Энэ хоёр судар хоорондоо зөрөөтэй боловч үнэндээ хоёул хэрхэн зөв болохыг тайлбарла (Ефес 2:4–10-ын “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз).
2. Дээрх “Судруудыг Ойлгох нь” хэсэг дэх зурагтай адил зураг зурж үүнийг бидний дэлхийн нөхцөл болон Цагаатгалыг Аврагчид үзүүлэхийн тулд нэрлэ.

Г Сүнийг Зур

Ефес 2:18–22-т Есүс Христийн Сүм бол “хамтдаа нийцсэн” барилгатай адил болохыг Паул заасан байдаг. Сүм ийм байдлаар зохион байгуулагдах ёстой гэж Паулын хэлснийг харуулсан барилгын зураг зур.

Судруудыг Ойлгох нь

Ефес 4

Өндөрт дээш гарах (ш.8–10)—Өгсөх, дээшлэх

Доод хэсэгт буусан (ш.9–10)—Доош буух

Байгуулах (ш.12, 29)—Барих

Христийн дүүрэн байдлын чанар (ш.13)—Есүс Христийн таалдаг алдар суугийн түвшин

Ов мэх (ш.14)—Худал хэлэх, мэхлэх, залилах

Хоосрол (ш.17)—Хоосон зүйл, үнэнээс гадуур сул дорой байдал

Хөндийрчээ (ш.18)—Таслагджээ, гадныхн болжээ

Тачаангуй байдал (ш.19)—Хазаарлагдашгүй тачаадал

Урьдын хэв маяг (ш.22)—Урьдын зан төрх

Бузар муу (ш.31)—Хилэнцэт санаа бодол ба үйл хөдлөл

Ефес 4:8—“Тэр Олон Хоригдол Олзлов, мөн Хүмүүст Бэлгүүд Өгөв”

Үхэл бүх хүмүүсийг олзолтод барьж байдаг. Есүс Христ “хоригдлуудыг олзолж, мөн хүмүүст бэлгүүд өгсөн” (Ефес 4:8) гэдэг нь Тэрээр үхлийг байлдан дагуулж, үхэшгүй байдлын бэлгийг бүх хүмүүнд өгсөн гэсэн утгатай юм.

Ефес 4:15–16—“Түүн Уруу Бүх Талаар Өс”

Ефес 4:15–16, түүнчлэн 1 Коринт 12:12–18-д Сүм бол Есүс Христ тэргүүн нь байх бие махбодтой адилхан юм гэж заасан байдаг. Гишүүн бүр өөрсдийн үүрэгтэй байхад, бүхэл Сүм хамтдаа хайранд өсч болно.

Ефес 5

Анхилуун үнэрт (ш.2)—Бурханы таалалд нийцдэг өргөл гэсэн утгатай анхилуун үнэр

Шунал (ш.3)—Шунахай сэтгэл

Бузар булай (ш.4)—Гутамшигтай, муухай

Садар самуун (ш.5)—Эр эмийн харилцааны нүгэлтэй эр хүн

Илчлэх (ш.11, 13)—Зэмлэх, шүүмжлэх

Харагддаг (ш.13)—

Харагдахаар болгосон, харагдсан

Мэргэн (ш.15)—Ухаалаг, нарийн нягт ханддаг

Цагийг авар (ш.16)—Цагаа сайн ашигла

Захирагд (ш.21–22)—Хамтран ажиллаж захирагд

Эмээх (ш.33)—Хүндлэх, хүндэтгэх

Ефес 5:22–33—Нөхөр, Эхнэрүүдэд Өгсөн Паулын Зөвлөгөө

Нөхөр нь гэрийн тэргүүн байх ёстой гэдэг Паулын зөвлөгөөг өнөөдөр зарим хүмүүс эсэргүүцдэг. Ийм эсэргүүцэл нь бурханлигаар тогтоогдсон нөхөр болон эхнэрийн үүргийг буруугаар ойлгохоос үүдэлтэй юм. Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөл:

“Бурхан бүх хүн төрөлхтөн—эрэгтэй эмэгтэй хүмүүсийг Өөрийн дүр төрхөөр бүтээсэн. Хүн бүр тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнслэг хүү, охин нь бөгөөд ийм учраас бурханлиг чинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнх амьдралын зайлшгүй тодорхойлолт бөгөөд зорилгын шинж чанар юм. . . .

“Гэр бүл Бурханаас томилогддог. Эрэгтэй, эмэгтэй хүний хоорондох гэрлэлт нь Түүний мөнхийн төлөвлөгөөнд зайлшгүй чухал юм. . . . Бурханлиг төлөвлөгөөгөөр эцэг нь гэр бүлээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлж, амьдралын хэрэгцээт зүйлсээр нь хангаж гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайрлан өсгөж хүмүүжүүлэх явдал мөн. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш түншүүдийн хувиар туслах ёстой” (“Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг” 1995 он, 1).

Ефес 6

Уур (ш.4)—Уур хилэн, хилэгнэл

Хүмүүжүүл (ш.4)—Сургаж хүмүүжүүлэх

Харцаар үйлчлэх (ш.6)—Хүн харж байвал л дуулгавартай байх

Ялгаварладаггүй (ш.9)—Хүмүүсийг ялгаварладаггүй

Залбирал ба гуйлтаар (ш.18)—Гуйлтын залбирал

Ефес 6:14—“Та Нар Бэлхүүсээрээ Снэнийг Бүсэл”


“Бэлхүүс” гэдэг нь бүсэлхий болон дунд чөмөгний орчим юм. “Бүслэх” гэдэг нь хувцасласан буюу бүсээ бүсэлсэн байх гэсэн утгатай. “Та нар бэлхүүсээрээ үнэнийг бүсэл” гэсэн нь (Ефес 6:14) үнэнээр, ариун явдлаар мөн ариун журмаар хувцаслагдсан, бүсээ бүсэлсэн, бүрхэгдсэн хийгээд хамгаалагдсан бай гэсэн утгатай юм.

Судруудыг Судлах нь

Ефес 4–6-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг нь хий.

А Төгс Эзэмших Судар—Ефес 4:11–14

1. Сүм хэрхэн зохион байгуулагдах нь хамаатай асуудал мөн үү? Дараах схемийг тэмдэглэлийнхээ дэвтэрт хуулж, Ефес 4:11–14-ийг судалж, байхгүй байгаа хэсгүүдийг бөглө.



2. Сүм яагаад Их Эзэний чиглүүлснээр зохион байгуулагдах ёстойг өөрсдийн үгээр тайлбарла.

Б Христийн Шавь Гэж Юу Вэ?

Ефес 4:21–5:4-ийг судал. Есүс Христийн дагалдагчийг дүрсэлсэн шүлгүүдээс өөрсдийн олж чадах бүх тодорхойлолтуудыг жагсаа. (Жишээ нь: нүглийн тухайд “хуучин хүнээ. . . хойш тавьж” [ш. 22], “сүнс дотор шинэчлэгдэж” [ш. 23]). Эдгээр тодорхойлолтуудын алинаар нь өөрсдөө цаашид ажиллах хэрэгтэй байгаа талаар тунгаан бод.

В Нөхрүүд, Эхнэрүүд Болон Хүүхдүүдэд Зориулсан Их Эзэний Төлөвлөгөө Юу Вэ?

Ефес 5:22–6:4-ийг нэгтгэн дүгнэ.

1. Хэрэв та залуу эрэгтэй бол, нөхөр болон эцгийн хувьд таны үүрэг юу байхыг дүрсэлсэн нэг догол мөр бич. Хэрэв та залуу эмэгтэй бол, эхнэр болон эхийн хувьд таны үүрэг юу байхыг дүрсэлсэн нэг догол мөр бич. (“Судруудыг Ойлгох нь” хэсэг дэх мэдээллийг өөрсөдөө тусламж болгон ашигла.)
2. Эцэг эхийнхээ өмнө хүүхдийн хувьд өөрсдийн хүлээх үүргийг дүрсэлсэн өөр нэг догол мөрийг бич. “Эзэн дотор эцэг эхээ дага” гэсэн нь ямар утга учиртай гэж бодлогоо тайлбарла.


Г “Бурханы Бүрэн Зэвсэг”



1. Тэмдэглэлийнхээ дэвтэрт цэргийн дагалдах зургийг зур. Тэгээд, Ефес 6:11–17-г судлахдаа, эдгээр шүлгүүдэд дүрсэлгдсэн хэдий ч, зурагт байхгүй байгаа хуяг дуулгууд болон зэвсгүүдийн зургийг өөрсдийнхөө зурагт нэм. Зэвсгүүдийг нэрлэхийг анхаар.
2. Зэвсэг бүрийг жагсааж, энэ нь юуг төлөөлж байгааг, тэрчлэн энэ нь яагаад ач холбогдолтойг тайлбарла. (“Бэлхүүсээрээ үнэнийг бүсэл” гэсэн нь ямар утгатайн жишээ болгож Ефес 6:14-ийн “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз.)

Филиппойчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Захидал

Филиппойчууд Гэж Хэн Байсан, Түүнчлэн Паул Яагаад Тэдэнд Бичсэн Бэ?



Филиппой хот бол Ромын эзэмшил бөгөөд Филиппчүүдэд бичсэн захидал дахь сайн мэдээний талаарх мэдээллийг хүлээж авсан Европын анхны хот байв. Паул өөрийнхөө хоёр дахь номлолын үеэр Филиппчүүдэд анх удаа сайн мэдээг номложээ (Үйлс 16:9–40). Арван жилийн дараа Ромд Паулыг шоронд хорих шүүх хурал дээр Филиппийн Гэгээнтнүүд түүнийг зовлон

зүдгүүрт нь дэмжиж бэлэг илгээсэн ажээ. Тэрээр энэ захидлыг тэдэнд шоронгоос илгээсэн байна. Энэ бол түүний нөхөрлөл, хайр, сайн зөвлөгөө болон өөрт нь туслах хүслээ илэрхийлсэн найз нөхөддөө илэрхийлсэн талархал байлаа.

Филиппой 1–4

Есүс Христэд Хүч Олох нь

Та нар хэзээ нэгэн цагт өөрсдөө даван туулж чадахгүй юм шиг санагдаж байсан тийм бэрхшээлтэй тулгарч байсан уу? Тэр үед санаа сэтгэл тань ямар байсан бэ? Тусламжийн төлөө хаана хандаж байсан бэ? Ромд шоронгийн хоригдол байсан Паул, бид хаашаа хандах ёстойг зааж: “Надад хүч өгөгч Түүгээр би бүгдийг хийж чадна” гэсэн байдаг (Филиппой 4:13).

Судруудыг Ойлгох нь



Филиппой 1

Хүлээстэй байхад (ш.7, 13–16)—Шоронд байхад Илэрхий болов (ш.13)—Харагдав

Өрсөлдөөн (ш.15)—Зөрчил
Хуурамч (ш.18)—Хуурмагаар
Авч явагтун (ш.27)—Хөтлөх

Филиппой 1:28—“Энэ нь Тэдний хувьд Сүйрлийн Тэмдэг Байна”

Иосеф Смитийн Орчуулга эдгээр хэлцүүдийг сайн мэдээг эсэргүүцдэг тэдгээр нь өөрсөддөө сүйрлийг авчирдаг хэмээн өөрчилжээ (ИСО, Филиппой 1:28-ыг үз).

Филиппой 2

Дэмжлэг (ш.1)—Тайвшрал, урам өгөх
Бардам зан (ш.3)—Сарсуурал

Филиппой 2:5–8—“Өөрийгөө Хоослов”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Нил А.Максвелл, “Христийн эрхэм дээд нэр бүх хүн төрөлхтний авралыг дэлхийд санал болгосон цорын ганц нэр байхаар Тэнгэрт тодорхойлогдсон хэдий ч (Үйлс 4:12; 2 Нифай 25:20; түүнчлэн Абрахам 3:27-г үз), Хаадын Хаан, Мөнх бус Мессиа даруухнаар хүлцэнгүй амьдарч байсан, тэр ч байтугай “өөрийгөө хоосолсон” хүн байлаа гэж Паул бичсэн юм гэж бичжээ (Филиппой 2:7)” (*Men and Women of Christ* [1991], 63–64).

Филиппой 2:25—Епафродит Гэж Хэн Байсан Бэ?

Епафродит бол Филиппийн Гэгээнтнүүдээс Паулд бэлэг хүргэсэн элч байлаа (Филиппой 4:18-ыг үз). “Үхтэлээ өвдсөний дараа” тэрээр Паулаас энэ захидлыг авч гэртээ буцаж иржээ (Филиппой 2:25–28-ыг үз).

Филиппой 3

Хуурамч (ш.2)—Хуурч мэхэлдэг, урвалт
Хог (ш.8)—Хог, хаягдал
Барьж авах (ш.12–13)—Олж авах, эзэмших
Иргэний харьяалал (ш.20)—Иргэний харьяалал
Захируулах (ш.21)—Захируулах
Филиппой 4
Гуйя (ш.3)—Хүсье

Судруудыг Судлах нь

Филиппой 1–4-ийг судлахдаа үйл ажиллагаа А мөн үйл ажиллагаа Б, В-гийн аль нэгийг хий.

А Өөрсдийнхөө Чадавхийн Талаарх Та Нарын Бодол

“Ерөнхийлөгч [Лорензо] Сноү доорх сайхан яруу найргийг нас барахаасаа арав орчим жилийн өмнө зохиожээ. Энэ бол . . . Тавин хоёр жил орчмын тэртээ түүнд илчлэгдсэн сургаалд насан туршдаа дуулгавартай байсны үр дүн мөн. Уг яруу найраг Төлөөлөгч Паулд зориулагдаж, Филиппойчуудад хандсан төлөөлөгчийн захидлын хариу болон бичигдсэн аж: . . .

Абраам, Исаак, Иаковын нэгэн адил
Анхны балчрууд, дараа нь эрчүүд—бурхад болон өссөн буюу.
Өдгөөгийн хүн лугаа адил Бурхан өнө эрт ийм байсан буюу;
Өнөөгийн Бурхан лугаа хүмүүн бас ийм болох буюу,—
Хүмүүний хувь тавилан ийм л буюу.

.....

Бурханы хүү Бурхан лугаа адил байх буюу,
Бурханыг тэгээд дээрэмдэх нь үгүй буюу;
Энэхүү найдварыг дотроо агуулагч тэрбээр,
Эгнэгт өөрийгөө нүглээс цэвэрлэх буюу.

(LeRoi C. Snow, "Devotion to a Divine Inspiration,"
Improvement Era, 1919 оны 6-р сар, 659–61.)

Энэ яруу найргийг Филиппой 2:1–8-тай харьцуул.

1. Өөрсдийнхөө чадавхийн талаар та нар юу мэдэв?
2. Өөрсдийнхөө чадавхийг гүйцэлдүүлэхийн тулд та нар юу хийж болох вэ?

Б Гишүүн Бус Эцэгт Бичих Захидал

Филиппой 3:7–16-г уншаад, Паул сайн мэдээний төлөө юу хийх хүсэлтэй байсныг бод. Тэрээр үүнийг золиослол гэж үздэг байсан уу? Дараах түүхийг уншиж, Паулын илэрхийлсэн үнэнийг төлөөлсөн төгсгөлийг бич:

Сюзан өмнө нь аавыгаа ууртай байхыг нь огт хараагүй ажээ. "Өөр сүмийн номлогч нараас хичээл авч та нар яаж чадаж байна аа? Та нар гэр бүлээ ч бас эсэргүүцэх үү?" гэж аавынхаа хэлэхийг тэр сонссоор л байв. Сюзан аавыгаа хүндэтгэдэг бөгөөд түүний хэлсэн зүйлийн талаар ихийг эрэгцүүлэн боддог байв. Тэр сууж, аавдаа захидал бичиж, тайлбарласан нь . . .

В Хамгийн Сайн Зүйлүүдийг Эрэлхийл

Итгэлийн Арвангуравдугаар тунхагт Бошиглогч Иосеф Смит Филиппой 4:8–9-өөс иш татсан байдаг. Уг судрыг уншиж, итгэлийн тунхагтай харьцуул. Дараах жагсаалтыг нэгтгэн дүгнэж, үг бүрт адил утгатай үг олж бич:

1. Үнэн
2. Үнэнч
3. Ариун журамтай
4. Цэвэр
5. Сайхан
6. Сайн гэгддэг
7. Ач буянтай
8. Сайшаалтай

*Шударга, үнэнч, ариун явдалтай,
нинжин сэтгэлтэй, ач буянтай байхад
мөн бүх хүмүүнд сайн сайхныг үйлдэхэд
бид итгэдэг; чухамдаа, бид бүх зүйлд
итгэдэг, бид бүх зүйлд найддаг, бид олон
зүйлийг хүлцэн тэвчлээ, мөн бүх зүйлийг
хүлцэн тэвчих болно гэдэгт найддаг гэсэн
Паулын зөвлөгөөг бид дагадаг хэмээн хэлж
болно. Хэрэв ариун журамтай, сайхан
эсвээс сайн гэгддэг буюу сайшаалтай
ямар нэгэн зүйл байдаг бол, бид эдгээр
зүйлүүдийг эрэлхийлдэг.*

Колоссайчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Захидал

Паул Колоссайчуудад Зөвлөсөн нь

Филиппойчуудад бичсэн захидлын нэгэн адил Паул Ромд шоронд хоригдож байхдаа колоссайчуудад энэ захидлыг бичжээ. Колоссайчууд бол Колосайн хот дахь Сүмийн гишүүд байв. Епафра нэртэй нэг колосай хүн Ромд Паул дээр ирж, Гэгээнтнүүдийн дунд буруу сургаалууд дэлгэрүүлж байгаа хуурамч багш нарын тухай ноцтой асуудалд хэрхэн хандаж шийдвэрлэх талаар зөвлөгөө хүсчээ. Энэ захидал бол Епафра болон бусад Колоссайчуудад өгсөн Паулын зөвлөгөө юм



Колоссай 1–4

Хуурамч Заалтуудын Эсрэг Сэрэмжлүүлэг

Аврагдахын тулд бид Бурханд итгэж, “түүний зан чанар, төгс байдал хийгээд түүнд хамаарах зүйлүүдийн талаар зөв санаа ойлголттой” (Lectures on Faith [1985], 38) байх ёстой гэж Бошиглогч Иосеф Смит заажээ. Тиймээс, үнэнийг мэдэж, буруу заалтууд хийгээд сургаалуудаас хамгаалах нь чухал юм. Та нар Колоссайг уншихдаа Паулын сэрэмжлүүлгүүдийг ажиглаж, эдгээр нь өөрсдийн тань амьдралтай хэрхэн холбогдохыг авч үз.

Судруудыг Ойлгох нь



Колоссай 1

Зохистой (ш.12)—
Чадвартай

Шилжүүлсэн (ш.13)—
Авчирсан

Тэргүүн байр (ш.18)—
Эхний байр

Эвлэрүүлэх (ш.20)—
Зөв болгох, ялах

Махан бие доторх өөрийн
үхлээр (ш.22)—Есүс
Христийн Цагаатгалаар
дамжуулан
Соёрхсон үүрэг (ш.25)—
Итгэмжлэл

Колоссай 1:25–29—“Өнгөрсөн Сөүдээс Нууцлагдаж Байсан Нууц” Гэж Юу Вэ?

“Өнгөрсөн үеүдээс нууцлагдаж байсан нууц” (Колоссай 1:26) гэдэг нь Бурхан Өөрийн Хүү, “бүх бүтээлийн ууганыг” (Колоссай 1:15) дэлхий уруу илгээж, Түүний Хүүгийн Цагаатгалаар дамжин бүх хүн төрөлхтөн цэвэр, гэм буруугүй болж, Түүний оршихуйд аврагдаж чадах болсныг хэлж байгаа юм (Колоссай 1:20–23-ыг үз). Паул энэхүү нууцыг сонсох бүх хүмүүнд мэдүүлсэн билээ.

Колоссай 2

Төөрөгдүүлэх (ш.4, 18)—
Мэхлэх

Үндсэн зарчмууд (ш.8, 20)—
Үндсэн зарчмууд

Зарлиг тогтоолууд (ш.14,
20)—Мосегийн хууль болон
үүний дүрмүүд

Түүнийг загалмайд хадаж
(ш.14)—Есүс Христийн
золиослолоор Мосегийн
хууль гүйцэлдсэн юм.
Хүсэл (ш.23)—Хувиа бодсон

Колоссай 2:16–19—Хуурамч Заалтуудаас Болгоомжил

Өөрсдөд нь заагдсан сайн мэдээнээс “хөдлөхгүй байхыг” Паул колоссайчуудад сэрэмжлүүлжээ. Мосегийн хуулийн дагуу амьдрахыг Харийн гишүүдээс хүсч байсан Христэд итгэгч Иудейчүүд хуурамч сургаалыг дэлгэрүүлж байв

(Колоссай 2:16–17-г үз). Иудейн эдгээр хөрвөгчид Христэд итгэгчдэд идэхийг зөвшөөрдөг хоол хүнсний нэр төрөл болон болон тэмдэглэхийг нь зөвшөөрдөг баяруудын талаар хатуу чанд дүрмүүдийг тогтоосон байв. Зарим Гэгээнтнүүд бас тэнгэр элчүүдийг, мөн залбирлуудад хариулах хүч тэнгэр элчүүдэд байдаг хэмээх заалтыг шүтэн биширч байлаа (Колоссай 2:18–19-ийг үз). Энэхүү хуурамч сургаал авралын төлөвлөгөөн дэх Есүс Христийн байр суурийг бууруулж байв. Тэд гагцхүү Христээр дамжуулан авралыг олж чадна, учир нь Тэр бол уг төлөвлөгөөнд гарамгай байр суурь эзэлдэг гэдгийг Паул Колоссайчуудад сануулжээ.

Колоссай 3

Газар дээрх эрхтнүүдийг
үхүүл (ш.5)—Өөрсдийн дэл-
хийн хандлагуудаас дээгүүр
бай

Тачаал (ш.5)—Хяналтгүй
хүслэн

Муу хүсэл (ш.5)—Нүгэлт
хүслэн, тачаадал

Хүлцэж (ш.13)—Дэмжиж
Уурлуул (ш.21)—Хутган
үймүүл

Колоссай 4

Гаднах хүмүүс (ш.5)—
Гишүүн бус хүмүүс

Цагийг үнэлж (ш.5)—
Сайныг үйлдэх боломж
бүрийг ашиглан
Давс (ш.6)—Мэргэн ухаан

Судруудыг Судлах нь



Колоссай 1–4-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг нь хий.

А Есүс Христийн Тухай Өөрийнхөө Гэрчлэлийг Бич

Есүс Христийн тухай та нар хэр зэрэг ихийг үнэхээр мэддэг вэ? Колоссай 1:13–22-ыг уншиж Аврагчийг дүрслэхийн тулд Паулын ашигласан нэр, цол гуншин болон өгүүлбэрдүүдийг жагсаа. Есүс Христийн эдгээр чанаруудын тухай өөрийнхөө гэрчлэлийг хураангуйлан дүгнэсэн нэг догол мөр бич.

Б Та Нар Юу Гэж Боддог Вэ?

Хуурамч санаануудыг төлөөлсөн хэд хэдэн нотолгоог дор жагсаав. Эдгээр санаа тус бүрт юу нь буруу гэж бодож байгаага бич.

1. Ямар кино үзэхээр явах нь миний хувьд падгүй хэрэг; эцсийн эцэст тэдгээр нь ердөө л кино шүү дээ.
2. Хэзээ болзоо тавих тухай шийдвэр нь хувь хүний л асуудал шүү дээ.
3. Сүм уйтгартай иймээс үүнийг хэн нэгэн сэтгэл хөдөлгөм болгох хэрэгтэй.

Колоссай 2:1–12-ыг уншиж, хуурамч заалтуудаар мэхлэгдэхээс зайлсхийхэд тань та нарт юу тусалж болохыг бич.

В **Өмсөгтүн**

Зарим сөрөг зан төлвийг зайлуулж, мөн илүү сайнуудыг өмсөх замаар хэрхэн дахин төрөхийг Паул заадаг байжээ. Хоёр багана хийж нэгийг нь *Зайлуулах* нөгөөг нь *Өмсөх* гэж нэрлэ. Та нар Колоссай 3:1–14-ийг уншихдаа, юуг зайлуулах болон юуг өмсөх хэрэгтэйг холбогдох багануудад жагсаа.

Г **Гэр Бүлд Хамаатай Хэрэг Явдлууд**

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл, “Гэр бүл бол газар дээрх Бурханы хаант улсын үндсэн нэгж мөн. Сүм өөрийн гэр бүлүүдээс илүү эрүүл саруул байж чадахгүй” гэж бидэнд сануулжээ (*The Teachings of Spencer W. Kimball*, 331–32). Колоссай 3:15–21-ийг уншиж, гэр бүлүүд Бурханы хаант улсын илүү эрүүл саруул хэсэг байхад нь туслах таван санааг бич.



Тесалоникчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Анхны Захидал

Паул Яагаад Энэ Захидлыг Тесалоникчуудад Бичсэн бэ?

Паул өөрийн хоёр дахь номлолын эхэн үеэр Тесалоник хотод сайн мэдээг тунхаглаж байжээ. Олон хүмүүс түүний захиасыг маш их урам зоригтойгоор угтан мэндчилж байлаа. Гэсэн хэдий ч, зарим үл итгэгч Иудейчүүд Паулын номлолын эсрэг хүчтэй эсэргүүцэлд өдөөн хатгаж байсан учраас шинээр хөрвөгчдийг цаашид мөрдөн хавчихаас аврахын тулд тэрээр уг хотыг орхин явжээ (Үйлс 17:1–10-ыг үз).

Тесалоник дахь Сүмийн шинэ гишүүдийг тохиуулахын тулд Паул Тимотыг илгээжээ. Паулаас ирсэн захидал Тесалоникийн Гэгээнтнүүдийг зохистой амьдралаар амьдарч, хүн бүрийг шүүхээр Аврагч ирэх болно гэдгийг санаж явахад нь урамшуулан дэмжжээ. Тимот хожим нь Коринтод Паултай нэгдэж, Тесалоникчуудын нөхцөл байдлын талаар илтгэжээ.

захидлыг бичсэн байна. Сайн мэдээг мэдэх нь хангалттай бус; бүх цаг үед Ариун Сүнснийг хөтчөө байлгахын тулд бид хичээн чармайх ёстой гэдгийг тэрбээр тэдэнд сануулж байв. Та нар 1 Тесалоникийг судлахдаа сайн мэдээ болон Сүнсний хүч нь Христийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэдэг арга замуудыг эрж ол.



1 Тесалоник 1–5

**Сайн Мэдээ Биднийг
Есүс Христийн Хоёр Дахь
Ирэлтэд Бэлтгэдэг**

Хот дахь мөрдлөг хавчлагын улмаас Паул Тесалоникийг яаралтай орхин явжээ. Гэвч тэрээр ардаа орхин явж байгаа Гэгээнтнүүдэд хайраа илэрхийлэхийн тулд энэ

Судруудыг Ойлгох нь

1 Тесалоник 1:4—“Бурханаар Сонгогдсон” Гэж Юу Вэ?

“Бурханаар сонгогдох” нь сайн мэдээтэй аятай сайхан хэлхээ холбоонд байх тийм нэг цаг хугацаа, газар, мөн нөхцөл байдалд төрсөн байдаг гэсэн үг юм. Энэхүү сонголт мөнх бус байдлын өмнөх оршихуйд тохиосон юм.

1 Тесалоник 2

Ятгалга (ш.3)—Сайн мэдээний хүчирхэг заавар
Заль мэх (ш.3)—Хуурч мэхлэх
Зусарч үг (ш.5)—Шунаг сэтгэлээ халхавчлах

Тэд өөрсдийн нүглүүдийг дүүргэж байна (ш.16)—Хүмүүс бүрмөсөн ёс бус болж байна

1 Тесалоник 4

Ариусгал (ш.3)—Ариусах, ариун болох
Тэвчиж (ш.3)—Оролцохгүй байх, холбогдохгүй байх
Өөрийн савыг хэрхэн эзэмдэхийг (ш.4)—Бие, дур хүсэл, үйл хөдлөлөө хянах

Тачаангуй хүсэл (ш.5)—Нүгэлт хүсэл, тачаадал
Нойрссон (ш.13–15)—Нас нөхчсөн, үхсэн

1 Тесалоник 5

Хүчтэй өвдөлт (ш.3)—Өвдөлт, шаналгаа
Сэрүүн ч бай, унтсан ч бай (ш.10)—Өөрсдийгөө бэлтгэсэн бөгөөд Аврагчийн ирэхийг хүлээж байгаа хүмүүс, мөн ингэж хүлээгээгүй

хүмүүс; Их Эзэнийг ирэхэд амьд байх буюу нас барсан байх хүмүүс
Хариулах (ш.15)—Хариу барих, хариу үйлдэл үзүүлэх
Бүрэн (ш.23)—Бүрмөсөн

Судруудыг Судлах нь

1 Тесалоник 1–5-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг нь хий

А Паулын Сгсийг Тэмдэглэ

Номлогч хэрхэн ажилладаг нь түүний юу гэж хэлэхтэй адил чухал ач холбогдолтой юм. Энэ нь сүмийн бүх гишүүдийн

хувьд үнэн юм. Хэрэв Сүмийн нэг гишүүн дараах зүйлүүдийн аль нэгийг хийх юм бол гишүүн бус найз нь юу гэж бодож болохыг бич.

1. Зүйд үл нийцэх буюу ёс суртахуунгүй кинонд явсан бол
2. Сүмийн цуглаан дээр болсон ямар нэг зүйлийн талаар гомдоллосон бол
3. Өөр хүний талаар хов жив ярьсан бол
4. Зүйд эс нийцэх үдэшлэгт явсан бол

1 Тесалоник 2:1–12-ыг уншиж, дээр жагсаасан нөхцөл байдлуудаас зайлсхийхэд тань та нарт тусалж чадах, наад зах нь найман үг буюу өгүүлбэр жагсаан бич.

Б Ариусгагдах нь

Ерөнхийлөгч Бригам Янг, “Хүний хүсэл, дур шохоорхол сэтгэл санааны байдал Бурханд болон Түүний Шаардлагуудад төгс байдлаар захирагдаж байвал тэр хүн ариусдаг” гэж сургажээ (*Journal of Discourses*, 2:123). 1 Тесалоник 4:1–8-ыг уншиж, бид өөрсөддөө хянаж байх ёстой гэж Паулын хэлсэн дур хүсэл болон сэтгэл санааны байдлыг жагсаа.

В Сүнийг Зурагла

1 Тесалоник 4:13–18-ыг уншиж, дүрслэгдсэн үйл явдлын зургийг зур.

Г Яаж Гэрлийн Хүүхдүүд Болох вэ?

“Гэрлийн хүүхдүүд” Их Эзэний ирэлтээр гайхшрахгүй байх болно хэмээн 1 Тесалоник 5:1–6-д Паул заасан байдаг. Та нар Хоёр дахь Ирэлтэд бэлтгэгдэхийг хүсдэг үү? 1 Тесалоник 5:12–23-ыг уншаад, та нарыг гэрлийн хүүхэд байхад тань тусалж чадах, Паулын өгсөн арван дөрвөн зөвлөмжийг жагсаан бич. Эдгээр зөвлөмжүүдээс гурав буюу дөрвийг сонгож, илүү агуу гэрэл өөд явах замд та нарыг оруулах нэг зорилго бич.

Тесалоникчуудад Бичсэн Төлөөлөгч Паулын Хоёр Дахь Захидал

Паул Яагаад Хоёр дахь Захидлыг Бичсэн бэ?

Тесалоникчуудад бичсэн Паулын анхны захидлын дараа Есүс Христийн Хоёрдахь Ирэлтийн талаар зарим нэг төөрөгдөл гарчээ. Туршлагагүй Гэгээнтнүүд хуурамч багш нараар мэхлэгдсэн, эсвэл Паулыг зүгээр л буруу ойлгосон байв. Өөрийн заасан зүйлүүдийг тодруулж, урамшуулан дэмжих үгс нэмэхийн тулд Паул хоёр дахь захидлаа бичжээ.



2 Тесалоник 1–3

Сайныг Үйлдэхээс Бүү Зүрхшээ

Тесалоникийн Гэгээнтнүүд Хоёр дахь Ирэлтийг их удахгүй тохиох юм шигээр хүсэн хүлээж байжээ, иймээс олон хүн ирээдүйн төлөө бэлтгэх тухайд санаа зовохоо больсон байв. Тэрхүү хуурмаг санааг залруулахын тулд, тэрчлэн тэднийг авралынх нь төлөө дахин ажиллуулахын тулд Паул бичсэн ажээ. Их Эзэнийг дахин ирэхийн өмнө юу тохиох ёстой гэж Паул заасныг ажигла. Тэрчлэн Гэгээнтнүүдийг сайн үйлсээ үргэлжлүүлэхэд нь тэрээр хэрхэн сүнслэгээр нөлөөлж байсныг эрж ол.

Судруудыг Ойлгох нь



2 Тесалоник 1

Хариулж (ш.6)—Хариу барьж

2 Тесалоник 2

Төөрөгдлийн ажиллагаа : Тайтгарал (ш.16)—Амар
(ш.11)—Алдаатай сэтгэлгээ : амгалан, тайвшрал

2 Тесалоник 2:1–3—Урвалт

Христэд итгэгчдийн Сүмийн эхэн үед олон хуурамч багш нар Сүмийн сургаалуудыг тухайн үеийн филасофтой нийцүүлэхийн тулд өөрчлөхөөр оролдож байв. Тэдгээр багш нар олон хүнийг үнэний замаас гажуудуулж дөнгөсөн юм. Бусад Гэгээнтнүүд Ромын хүчтэй мөрдлөг хавчлагыг тэсэн гарч чадаагүйн улмаас цөхөрч найдвараа алдсан байв. Тэгээд дараа нь Төлөөлөгчид алагдахад, аль хэдийн суларсан Сүм удирдлагагүй хоцорчээ.

Он жилүүдийн туршид Сүм нь Есүс Христийн Сүм байснаа хүмүүний үзэл санаа хийгээд хүмүүний философ дээр тулгуурласан сүм болж хувирав. Гишүүд нь үнэнээс урвасан түүхэн дэх энэ үеийг эдүгээ Урвалт гэдэг. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр Бошиглогч Иосеф Смит дээр хүрч ирэх хүртэл дэлхий дээр бүрэн сайн мэдээ сэргээгдээгүй билээ.

2 Тесалоник 2:3–10—“Хууль Бус Байдлын Нууц” Гэж Хэн Бэ?

Есүс Христ бол “бурханлиг байдлын нууц” (1 Тимот 3:16), харин Сатан бол “хууль бус байдлын нууц” юм. Сатан болон түүнтэй хамт бослого гаргагчид зайлуулагдаж, “мөхлийн хөвгүүд” хэмээн нэрлэгдсэн юм. Гагцхүү Бурхан түүнд зөвшөөрсөн учраас л Сатан хүн төрөлхтөнд

нөлөөлдөг (2 Тесалоник 2:7-г үз). Тэр нь Есүс Христ Сатанд өнөөгийн төлөө ажиллахыг зөвшөөрдөг гэсэн үг (ИСО, 2 Тесалоник 2:7-г үз). Гэвч Сатаныг хийгээд бүх ёс бусыг Есүс Христ “Өөрийн ирэлтийн хурц гэрлээр” зайлшгүй устгах болно (2 Тесалоник 2:8; тэрчлэн С ба Г 5:19-ийг үз).

2 Тесалоник 3

Эцэж туйлдталаа ажиллаж байна (ш.8)—Хүнд хэцүү ажил хийж байна

Бусдын хэрэгт оролцдог (ш.11)—Бусад хүмүүсийн ажил хэрэгт буруу байдлаар санаа тавьж оролцдог

Судруудыг Судлах нь



2 Тесалоник 1–3-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Хоёр дахь Ирэлт

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит, “Энэхүү агуу хийгээд аймшигт өдөр нь, дэлхий дээр Өөрийн хаант улсыг байгуулахаар, мөн дэлхийг бүх алдсаас цэвэршүүлэхийн тулд Есүс Христийн ирэхээс өөр цаг үе байж таарахгүй. Энэ нь зөв шударга хүмүүсийн хувьд аймшигтай буюу айдас хүйдсийн өдөр биш, харин энэ нь бурханлиг бус хүмүүсийн хувьд аймшигийн хийгээд аюумшигт өдөр байх болно. Үүнийг бид Аврагчийн Өөрийнх нь үгнээс мэддэг билээ” гэж тайлбарлажээ (*Doctrines of Salvation*, 1:173).

2 Тесалоник 1-ийг уншиж, Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн үед ёс бус хүмүүст юу тохиох болно гэж хэлэгдсэнийг мөн зөв шударга хүмүүст юу тохиолдохыг бич.



Б Төгс Эзэмших Судар— 2 Тесалоник 2:1–3

2 Тесалоник 2:1–3-ын “Судруудыг Ойлгох нь” хэсэг дэх мэдээллийг нэгтгэн дүгнэ. Тэгээд 2 Тесалоник 2:1–12-ыг унш. Шүлэг 3, 4, 8, 10 ямар утгатай гэж бодож байгаагаа тайлбарла.

В Найздаа Зурвас Бич

Сүмийн үйлчлэлийн төслүүдэд тусалсаар байгаад ядарчихлаа гэж хэлсэн найздаа та нар юу гэж хэлэх вэ? “Сайныг үйлдэхдээ бүү зүрхшээ” хэмээн Тесалоникийн

Гэгээнтнүүдийг урамшуулан дэмжиж Паулын хэлснийг сана (2 Тесалоник 3:13).

1. 2 Тесалоник 3:1–13-ыг уншиж, хүн үйлчлэл үзүүлэхдээ бага ядарснаа мэдрэхэд нь туслах, наад зах нь хоёр зарчмыг тогтоо.
2. Энэ хоёр зарчмыг ашиглан, найзыгаа урамшуулан дэмжсэн зурвас бич.



Тимотод Бичсэн Төлөөлөгч Паулын Анхны Захидал

Тимотын Тухай Та Нар Юу Мэдэх Хэрэгтэй Вэ?

Тимот бол Паулын хамгийн их итгэл найдвартай, чадварлаг туслагч байсан бололтой. *Тимот* гэдэг нэр “Бурханаар хүндлэгдсэн” гэсэн утгатай бөгөөд энэ нь итгэлтэй, өөрийгөө зориулдаг сайн үйлчлэгч гэдгийг нь харуулдаг.

Тимот Паулын анхны номлолын үед хөрвүүлэгдсэн байх магадлал их өндөр байна. Тэрээр сайн мэдээнд өсч хөгжихийн хэрээр итгэлтэй шавь гэж өндөр үнэлэгдэн, Паул түүнийг номлолын хамтрагчаа болгон сонгож авчээ (Үйлс 16:1–5-ыг үз). Тэд Ефест номлож байхдаа, Сүмийн гишүүдийн дунд асуудлууд, түүний дотор хуурамч заалтууд хийгээд таамаглал өсөн нэмэгдэж байгааг Паул илрүүлжээ. Эдгээр асуудлуудын улмаас хоёр ахлагчийг Паул Сатаны эрхшээлд тушаажээ (1 Тимот 1:19–20-ийг үз). Тэгээд Паул Сүмийг харж хандаж байхын тулд мөн Ефесийн Гэгээнтнүүдийн итгэлийг сэргээхийн тулд Тимотыг дуудаж, түүнийг дуудлагад нь урамшуулан дэмжиж, хүч чадал өгөхийн тулд тэрээр энэ захидлыг Македоноос Тимотод бичжээ.

Пасторын Анхны Захидал

Пасторын Захидлууд бол “Тимот, Тит хоёрт бичсэн захидлуудад өгсөн нэр байв, учир нь тэд хоньчдын буюу Сүмийн тохинуулагчдын пасторын албан тушаал болон үүргүүдийг эрхэлж байв.” Пастор бол бишоп бөгөөд Тимот Ефес дэх Сүмийн анхны бишопоор томилогджээ. Тиймээс, *пасторын* гэдэг нь бишопын албан тушаал болон үүргүүдэд хамаарна.

1 ТИМОТ 1–2

Сайн Мэдээний Дагуу Амьдрах нь

Есүс Христийг дагадаг хүмүүсийн хувьд өвөрмөц онцлог нь юу вэ? Тэдний амьдралыг ийнхүү өөр болгодог ямар энгийн зарчмуудыг тэд баримталдаг вэ? Сайн мэдээн дээр төвлөрсөн амьдралаар хэрхэн амьдрах тухай Паул Тимотод зөвлөжээ. 1 Тимот 1–2-ыг уншихдаа, Паулын зөвлөгөөг дагах нь Аврагчийг дагахаар хичээн чармайхад тань та нарт хэрхэн тусалж чадах тухай бод.

Судруудыг Ойлгох нь



1 Тимот 1

Заах (ш.3)—Зарлиглах, заах

Чин үнэнч (ш.5)—Чин сэтгэлийн

Садар самуун (ш.10)—
Садар самууныг үйлдэгч,
завхайрагч хүмүүс

Тангарагаасаа няцагч (ш.10)—Худалч, амлалтаа зөрчдөг хүмүүс

Доромжлогч (ш.13)—
Бурханы тухай мөн бусдын
тухай хилэнцэтийг ярьдаг
хүн

1 Тимот 2

Залбирал (ш.1)—Өөр хүний нэрийн өмнөөс хийх залбирал

Зууч (ш.5)—Хоёр хувь хүний хооронд асуудлыг шийдвэрлэхэд зуучилдаг хүн

Золиос болгож (ш.6)—
Төлөөс төлж
Хувцаслан (ш.9)—Хувцас
өмсөн
Түвшин байдал (ш.9)—
Өөрийгөө хянах

1 Тимот 2:9–12—“Эмэгтэй Хүн Заахыг Зөвшөөрөхгүй Юу?”

Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит сургахдаа:

“Энэ эрин үед Сүмийн эгч нар цулаанууд хийж, хаант улсын сайн мэдээг бие биендээ зааж, ядуус, гачигдалтай хүмүүс, түүнчлэн зовлонд нэрвэгдэгсдийг адислахын тулд зохион байгуулагдах ёстой гэсэн зарлигийг Их Эзэн өгсөн юм. Тэд өвчтөнүүдийг асарч, гачигдалтай хүмүүсийг тайтгаруулдаг байлаа.



“Манай Нийгмийн Халамжийн Бүлэг бурханлиг илчлэлтээр ирсэн юм. Энэ нь Харилцан Сайжралт болон Хүүхдийн Хэсгийн байгууллагуудын хувьд ч адил юм. Иудейчүүд хийгээд эрт үеийн бусад хүмүүсийн хэрэгжүүлж байсан тэнэг үзэл санаа өнөөдөр Бурханы хаант улсад байхгүй. Итгэл,

даруу байдал хийгээд үнэн наманчлалын нөхцөлд эрэгтэй, эмэгтэй ялгаагүй бүх хүмүүст Ариун Сүнсний бэлгийг Их Эзэн амласан билээ. Тэд сайн мэдээний үнэнүүдийг судалж, мэдэн сэлэстиэл алдар сууд эрх олгож болох гэрэл хийгээд үнэнийг эрэлхийлэхийн тулд, суралцахаар, итгэлээр түүнчлэн бүх зарлигуудад дуулгавартай байх явдлаар тэд өөрсдийгөө бэлтгэх шаардлагатай” гэжээ (*Answers to Gospel Questions*, 3:68–69).

Судруудыг Судлах нь

1 Тимот 1–2-ыг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А “Хийх Зүйл” Жагсаалт Гарга

Тэмдэглэлийнхээ дэвтэрт хоёр багана гарга. Нэг баганыг *Хийх Зүйл* нөгөөг *Хийхгүй Зүйл* гэж гарчигла. 1 Тимот 1–2-ыг уншаад, бидний хийх болон хийх ёсгүй зүйлүүдээс наад зах нь арван зүйлийг холбогдох багануудад жагсаа. 1 Тимотын 1–2-ын “Судруудыг Ойлгох нь” хэсгийг бас ашиглаж болно.

Б Хувцасны Загварын Талаар

- 1 Тимот 2:9–10-ыг уншиж, Паул эмэгтэйчүүдэд хэрхэн хувцаслах тухай зөвлөснийг эрж ол. Хэрэв Паул өнөөдөр танай сургууль дээр ирлээ гэхэд тэрээр хувцасны ямар загвар, хэв маягийн хандлагыг буруутгах байсан бол? (Наад зах нь тавыг нэрлэ.)
- Хэрхэн хувцаславал зохихыг Их Эзэн биднээс хүсэн хүлээдэг тухай судрууд бидэнд сургадаг. 1 Нифай 13:7–8; Иаков 2:13; Алма 1:6; 4:6; 5:53; 31:27–28; 4 Нифай 1:24; Мормон 8:36–37; тэрчлэн Сургаал ба Гэрээ 42:40-ийг унш. Эдгээр шүлгүүд бидэнд юу зааж байгааг нэгтгэн дүгнэ. Өөрсдийн тань нэгтгэн дүгнэлт *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимол дахь удирдамжуудтай хэр тохирч байна вэ?

1 ТИМОТ 3

Бишопууд болон Диконуудад Өгсөн Зөвлөгөө



Сүмийн дуудлагууд бусдад үйлчлэх хийгээд сайн мэдээнд өсч хөгжих боломжийг бидэнд олгодог. Бид Сүмд үйлчлэхээр дуудагдахдаа тодорхой чанарууд болон хандлагуудыг хөгжүүлэхээр хичээн чармайх ёстой. Бишопууд болон диконуудаас Их Эзэн юу хүсэн хүлээдгийг бид 1 Тимот 3-аас уншидаг. Та нар энэ бүлгийг судлахдаа дуудлагууддаа илүү сайн үйлчлэхэд тань тусалж чадах арга замуудыг Паулын зөвлөгөөнөөс ол.

Судруудыг Ойлгох нь

1 Тимот 3

Харгалзагч (ш.2)—
Сэрэмжтэй, соргог

Мөнгө (ш.3, 8)—Мөнгө

Хүндэтгэлтэйгээр (ш.4)—
Хүндэтгэл, нэр төртэйгөөр
Буруутгал (ш.7)—Гутаах,
ширүүн шүүмжлэх

1 Тимот 3:11–12—Гэрлэсэн Диконууд?

Паулын үед, мөн түүнчлэн Сүм сэргээгдсэн эхний үед диконууд гэрлэсэн байж болдог, Аароны санваар атгадаг насанд хүрсэн эрэгтэйчүүд байжээ. Их Эзэн Өөрийн бошиглогчдоор дамжуулан, Аароны санваарыг атгах онцгой боломжийг арван хоёр болон түүнээс дээш настай залуу эрэгтэйчүүдэд олгосон билээ.

Судруудыг Судлах нь

1 Тимот 3-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Өөрийнхөө Бишопын Тухай Бич

- 1 Тимот 3-г уншиж, Их Эзэн Өөрийн бишопуудаас юу хүсэн хүлээдгийг ол. Бишоп яагаад эдгээр шаардлагуудыг хангадаг байх ёстой гэж та нар боддог вэ?
2. *New Era* сэтгүүлд зориулж өөрсдийнхөө бишопын тухай өгүүлэл бич. Хэрэв та нар түүнтэй ярилцлага хийх бол бишопоосоо өөрсдийн асууыг сонирхсон хэд хэдэн асуултыг жагсаа.

1 ТИМОТ 4–6

“Сайнтай Тэмцэх нь Итгэлийн Эсрэг Тэмцсэн Хэрэг”

Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд болон Сүмийг Сатан устгахыг эрэлхийлдэг. Итгэлтэй Гэгээнтнүүд Сатаны хүчнээс хамгаалагдан хадгалагдаж үлдэхийн тулд “тушаа, зааж сурга” (1 Тимот 4:11) хэмээх чухал зөвлөгөөг Паул Тимотод өгчээ. Хэрэв бид Паулын зөвлөгөөг дагах юм бол дайсантай хийх тулалдаанд ялах хүч бидэнд бас байх болно, тэгээд “мөнх амьдралыг барьж ав” (1 Тимот 6:12).

Судруудыг Ойлгох нь

1 Тимот 4

Зүтгэдэг (ш.10)—
Зэмлүүлдэг

Дорд үзэх (ш.12)—Үл тоомсорлох, тоохгүй байх
Ятгалга (ш.13)—Номлох

1 Тимот 4:2—“Өөрсдийн Мөс Чанартаа Халуун Төмрөөр Тамгалагдан”



Төөнүүр төмөр

Арьсны эд эсийг түлж, заримдаа цус гоожихыг нь зогсоохын тулд халуун төмрөөр хайрч шархыг аниулах аргыг ашигладаг байжээ. Эцсийн өдрүүдэд

ухамсар нь хатуурсан буюу зөв шударга бишийн улмаас лацдагдсан зарим хүмүүс байх болно гэдгийг тайлбарлахад энэ зүйрлэлийг Паул ашигласан байдаг. Мормоны Номны бошиглогчид тэдний “мэдрэхээс өнгөрсөн” (1 Нифай 17:45; Моронай 9:20) байдлыг дүрсэлжээ.

1 Тимот 4:3—“Гэрлэхийг Хориглодог, Хоол Хүнснээс Цээрлэхийг Албаддаг нь”

Гэрлэхийг хориглох болон хоол хүнснээс татгалзах хуурамч дадал хэвшлүүдийг баримталдаг зарим хүмүүс хожмын үеүдэд байх болно гэдгийг Паул бошигложээ. Сургаал ба Гэрээ 49:15–21-ийг уншиж, энэ хоёр асуудлаар Бошиглогч Иосеф Смитэд Их Эзэний илчилсэн зүйлийг мэдэж ав.

1 Тимот 5

Хүндлэхэд (ш.4)—Үнэнч итгэлтэй байхад

Ачийг хариулахад (ш.4)—
Хариу барихад

Итгэлийг үгүйсгэсэн (ш.8)—Үл итгэгч

Христийг үл ойшоож эхэлдэг (ш.11)—Хүн Христэд шийдвэр төгс байхаас илүүгээр эр эмийн харилцааг хүсэх
Хов жив ярьдаг (ш.13)—Хов жив хөөцөлдөгчид

1 Тимот 6

Гэм зэмгүйгээр (ш.14)—
Шийтгэл хүлээхээргүйгээр

Хэмжээлшгүй Эрхэт (ш.15)—Хэмжээлшгүй эрх бүхий захирагч

Судруудыг Судлах нь

1 Тимот 4–6-г судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Паулын Заасан Зүйлүүдийг Өнөө Сед Хэрэглэ

- 1 Тимот 6:11–12-т Паулын заасан зүйлүүдийг уншиж, энэ тухай бод. Эдгээр шүлгүүд өөрсдийн тань хувьд ямар утга учиртайг нэгтгэн дүгнэсэн нэг догол мөрийг тэмдэглэлийн дэвтэртээ бич.
2. Танай сургуульд хамгийн их хэрэгтэй гэж өөрсдийн бодсон тус бүр хоёр заалтыг 1 Тимот 4, 5, 6-гаас сонгож ав. Эдгээр заасан зүйлүүдийг олсон шүлгүүд, заалтуудыг жагсааж, эдгээр нь өнөө үед яагаад ач холбогдолтой гэж та нар боддог вэ.

Тимотод Бичсэн Төлөөлөгч Паулын Хоёр Дахь Захидал

Тимотод Бичсэн Хоёр дахь Захидал

Паул хоёр дахь захидлаа Ромын шоронгоос Тимотод бичжээ. Олон найз нар нь Паулыг орхиж явсан бөгөөд өөрөө удалгүй үхэх юм шиг түүнд санагдаж байсан болохоор үнэнч найз Тимотдоо өөр нэг захидал бичиж, өөртөө туслахаар ирэхийг түүнээс хүсчээ. Ромын эзэн хаан Неро Христэд итгэгчдийг цаазалж, Паулын амь насанд аюул их хэмжээгээр заналхийлэх болов. Энэ захидалд Паул өрөвч уян сэтгэл хийгээд агуу сэнхрүүллийг илэрхийлжээ. Тэрээр Ефес дэх Гэгээнтнүүдэд санаа тавьж, сайн мэдээг чанга тэвэрч, үүн дотор хадгалагдан, үүнийг номлож, хэрэв шаардлагатай бол үүний төлөө зовж зүдрэхийг (Паул өөрөө ингэж байсан шиг) Тимотод зөвлөжээ. Тэгээд тэрээр Есүс Христийн тухай гэрчлэлийнхээ хүчирхэг тунхаглалаар захидлаа төгсгөжээ.

2 ТИМОТ 1–2

Зовлон Зүдгүүрийг Тэвч

Цэргийн алба хаасан, спорт, фермийн буюу мал аж ахуйн ажилд оролцсон хэн нэгнийг та нар таньдаг уу? Тимот 1–2-ыг уншихдаа, сайн мэдээгээр амьдрах явдлыг Паул дайнтай, спортын тэмцээн буюу ургац хураалттай хэрхэн зүйрлүүлснийг ажигла. Паул яагаад эдгээр харьцууллыг ашигласан гэж та нар боддог вэ?

Судруудыг Ойлгох нь



2 Тимот 1

Чин сэтгэлийн (ш.5)—Чин үнэнч

2 Тимот 2

Тариачин (ш.6)—Фермийн ажилчин, газар дээр ажиллагч

Тушаа (ш.14)—Зарлигла

Сүйрэл (ш.14)—Устгал, мөхөл

Төөрөн одож (ш.18)—Алдаа гаргаж

Бий болгох (ш.23)—Авчрах буюу хүргэх

Судруудыг Судлах нь



2 Тимот 1–2-ыг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Сүнслэг Цэргүүд, Тамирчид мөн Тариаланчид

Тэмдэглэлийнхээ дэвтэрт гурван багана гаргаж, тэдгээрийг Цэргүүд, Тамирчид, Тариаланчид гэсэн үгнүүдээр гарчигла.

1. 2 Тимот 2:1–6-г уншиж, баганууд дахь хүн тус бүр юу хийх ёстойг (жишээ нь, цэрэг “зовлон зүдгүүрийг тэвчих”) жагсаан бич.

2. Сүнслэг байдлыг хөгжүүлэх тухай ярианд ашиглахад цэргүүд, тамирчид болон тариаланчид яагаад сайн зүйрлэл болсон гэж бодож байгаагаа дүрсэлсэн нэг догол мөр бич.

Б Өөрсдийн Сгээр

2 Тимот 2:22–26-г уншаад, өнөөдөр өөрсдийн тань хувьд эдгээр шүлгүүд яагаад чухал ач холбогдолтой гэж боддог уу тайлбарласан нэг богинохон догол мөр бич.

2 ТИМОТ 3–4

Урвалт

Та нар “эцсийн өдрүүдэд” амьдарч байна. Энэ цаг үед Сүмийн гишүүн байсны төлөөх адислалууд буюу давуу талууд юу вэ? Манай өнөө үед тохиох ёс бус байдал хийгээд урвалтыг Паул дүрсэлсэн юм. 2 Тимот 3–4-ийг уншиж, түүний дүрслэл үнэн гэж боддог уу гэдгээ анхаар. Эдгээр хүнд цаг үед юу биднийг удирдах вэ?

Судруудыг Ойлгох нь



2 Тимот 3

Хэцүү (ш.1)—Хүнд хэцүү, бэрх

Зүсэн бүрийн (ш.6)—Янз бүрийн

Гологдсон (ш.8)—Тохирохгүй

2 Тимот 3:8—Ианн, Иамбре Нар Хэн Байсан Бэ?

Ианн, Иамбре хоёр бол Мосегийн гайхамшгуудыг эсэргүүцсэн египетийн ид шидтэнгүүд байлаа.

2 Тимот 4

Амьд (ш.1)—Амьд байгаа

Бөөгнөрүүлэх (ш.3)—Цуглуулах

Чих үнэнээс эргэж (ш.3)—Үнэнийг сонсохын оронд баярлуулдаг сургаал сонсохыг хүсэх

2 Тимот 4:2—“Цагаа Олсон ч, Олоогүй ч Бэлэн Байгтун”

Итгэлийн талаар тэмцэн байсан буюу итгэлээсээ урвасан хүмүүсийг засч залруулах талаар шаргуу байхыг Паул Тимотод зөвлөжээ.

Судруудыг Судлах нь

Тимот 3–4-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Төгс Эзэмших Судар—2 Тимот 3:1–5

Эцсийн өдрүүдэд нийтлэг байх хорин нэгэн нүгэл хийгээд сул талуудыг Паул бичсэнийг 2 Тимот 3:1–7-д жагсаажээ. Тэдгээрээс тав буюу түүнээс илүүг сонгож, танай хамт олон буюу улс оронд байгаа эдгээр асуудлуудыг харуулсан сонин, сэтгүүлийн буюу бусад өгүүлүүдийг ол.

Б Төгс Эзэмших Судар—2 Тимот 3:16–17

Эдүгээг хүртэл та нар семинарт судруудыг судалсаар хэдэн сарыг өнгөрөөлөө.

1. 2 Тимот 3:16–17-г уншиж, сүнслэг нөлөө бүхий судраас бид хожих болно гэж Паулын хэлсэн долоон арга замыг жагсаа.

2. Өөрсдийнхөө гэрчлэлийг бичиж, судруудаар өөрсдөө хэрхэн адислагдсанаа энд оруул.

В Та Нар Сайн Тэмцлээр Тэмцдэг үү?


Сүүлийн хэдэн долоо хоногийн турш дахь судалгаагаар Паулын талаар мэдсэн зүйлийнхээ талаар та нар юу гэж боддог вэ? 2 Тимот 4:7–8-ыг уншсаныхаа дараа, дараах асуултуудад хариул:

1. Паулын энэ тунхаглал та нарын хувьд яагаад их сэтгэгдэл төрүүлдэг вэ?
2. Түүний хэлсэн зүйл ямар утга учиртайг та нарт хэлж өгдөг ямар гурван зүйлийг тэрээр амьдралдаа хийсэн бэ?
3. Ирэх жилд та нар сайн тэмцлээр тэмцэхийн тулд ямар таван зүйлийг та нар хийж болох вэ?

Титэд Бичсэн Паулын Захидал

Тит гэж Хэн Байсан Бэ?

Шинэ Гэрээнд Тит олон удаа дурьдагддаг. Тэр бол Паулын грек хөрвөгчдийн нэг байв. Тэр бол итгэл найдвар хүлээсэн, итгэлтэй нэгэн байсан бөгөөд номлолын нилээд хэдэн аялалд Паултай хамт үйлчлэхээр дуудагдсан байлаа. Паул Крет арал дээр (Ромд анх удаа шоронд хоригдсоныхоо дараа бололтой) Сүмийг үндэслэн байгуулж, тэнд Сүмийн ажил үүргийг Титэд хариуцуулж, өөрөө тэндээс явжээ. Тит, бишопын хувьд тэнд дутагдаж байсан зүйлийг эмх цэгцэд оруулах үүрэг хүлээжээ.



Энэ Ном Юуны Тухай Вэ?

Паул Крет арал дээрх Сүмийн гишүүдийг Титэд хариуцуулжээ. Тэрээр грекийн яруу найрагч Ефименидээс иш татан тэднийг: “Кретчүүд ямагт худал яригчид, хилэнцэт араатнууд, хөшүүн залхуу ховдгууд” (Тит 1:12) хэмээн дүр-

сэлжээ. Гэвч, Есүс Христ “Өөрийгөө бидний төлөө өгсөн нь аливаа ёс бусаас гэтэлгэсэн юм” (Тит 2:14). Хүн бүр, тэр ч байтугай, Кретчүүд шиг муу нэртэй хүмүүс ч гэсэн Есүс Христийн сайн мэдээгээр адислагдахыг Христ боломжтой болгосныг Паул мэдэж байлаа.

Сүмийг зохион байгуулахад учирч байсан бэрхшээлүүдэд Титэд туслахын тулд, түүнчлэн зөв шударгаар амьдрахад нь Кретийн Гэгээнтнүүдэд туслахын тулд Паул бичжээ. Тэрээр зөв шударга удирдлагын чанаруудын талаар Титэд сануулж, Сүмийн удирдагчийн зохих үлгэр жишээг үзүүлэхэд нь түүнийг урамшуулан дэмжжээ.

Тит 1–3

“Итгэл Дотроо Эрүүл Бай”

Крет дэх гишүүдээс олон нь нүгэл үйлдэж, буруу зарчмуудыг зааж байжээ. Тэднийг итгэлдээ эрүүл болоход нь туслахын тулд “Тэднийг хатуу зэмлэж” (Тит 1:13), тэдэнд эрүүл сургаал заа хэмээн Паул тэдний бишопт зөвлөжээ (Тит 2:1-ийг үз). Титэд бичсэн энэ захидлыг уншихдаа Гэгээнтнүүдэд заа гэж түүнд Паулын хэлсэн сургаалуудыг эрж ол. Эдгээр үнэнүүдийг мэдсэн нь та нарын амьдралд ямар өөрчлөлт гаргасан бэ?

Судруудыг Ойлгох нь



Тит 1

Дутуу зүйл (ш.5)—
Дутагдаж байгаа зүйл

Зодоонч биш (ш.7)—
Зөрчилдөгч биш

Хөвч хөндөх ёслол үйлдэгчид (ш.10)—Мосегийн хуулийн тодорхой хэсгүүдийн дагуу амьдарсан

хэвээр байсан Христэд итгэгч Иудейчүүд

Үгүйсгэх (ш.12)—Устгах, ялзуулах

Зэмлэ (ш.13)—Залруул, зөвлө

Зохисгүй (ш.16)—Ихэд ёс бус

Тит 2

Биеэ барьдаг (ш.2, 4, 6, 12)—
Даруу, өөрийгөө хянадаг

Хүндэтгэлтэй (ш.2)—
Буурь суурьтай, хүндэтгэл хүлээдэг

Ухаалаг (ш.2)—Хянуур, хэрсүү

Зүтгэлтэй (ш.14)—Урам зоригтой

Тит 3

Удирдагчид (ш.1)—
Захирагчид, удирдагчид

Шинэтгэлийн угаал (ш.5)—Усанд умбуулалтаар хийх баптисм

Зөрчилдсөн (ш.10)—

Урвагч, хуурамч номлол баримтлагч

Судруудыг Судлах нь



Тит 1–3-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Снэн Сургаалын Sp Нөлөө

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Бойд К.Пакер сургахдаа:



“Үнэн сургаал хандлагууд хийгээд зан төлвийг ойлгодог байсан, мөн өөрчилдөг.

“Сайн мэдээний сургаалуудыг судлах нь зан төлвийг судалснаар зан төлвийг сайжруулахаас илүү хурднаар зан төлвийг сайжруулах болно” (in Conference Report, 1986 оны 10-р сар, 20; *Ensign*, 1986 оны 11-р сар, 17).

1. Тит 1:9, 13; 2:1, 15; мөн 3:8-ыг унш. Ахлагч Пакерын нотолгоо Титэд өгсөн Паулын зөвлөгөөтэй хэрхэн нийцэж байна вэ?
2. Тит 2-ыг эмээ буюу өвөөгийнхөө аль нэгэнд уншиж өг, тэгээд энэ нь та нарын насны хэн нэгэнд яагаад сайн зөвлөгөө болохыг асуу. Хариултыг тэмдэглэлийнхээ дэвтэрт бич.

Филемонд Бичсэн Паулын Захидал

Паул Яагаад Филемонд Бичсэн бэ?

Паул өөрийн найз Пилемонд, Онесим гэгч оргосон боолд өршөөнгүй хандахыг түүнээс хүсч бичжээ. Онесим Сүмд нэгдсэн бөгөөд түүнд тусламж хэрэгтэй байсан аж. Ромын хуулиар бол эзнээсээ оргож зайлсан боолд цаазаар авахуулах шийтгэл оноодог байв. Онесимийн хувьд гэртээ аюулгүй эргэж очих нь чухал байсныг Паул мэдэж байсан бөгөөд тухайн үеийн соёлын жишгүүдээс дээгүүр байх, түүнчлэн энэ боолд өршөөл, хүлээн зөвшөөрөлт хийгээд хайраар хандахыг тэрээр Филемоноос хүсчээ.

Филемон 1

Сайн Мэдээн Дэх Ахыгаа
Хүлээж Авагтун

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли сургахдаа:



“Энэ Сүмийн гишүүн байна гэдэг амар хялбар зүйл биш. Олонх тохиолдолд энэ нь хуучин дадал зурилуудаа хойш тавьж, хуучин найз нөхдөө хийгээд хуучин хэлхээ холбоогоо орхиж, өөр бөгөөд ямар нэг зүйл шаарддаг шинэ хамт олон уруу хөл тавих явдал байдаг.

“Хөрвөгчдийн тоо ямагт өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан, тэдэнд замаа олоход нь туслахын тулд бид улам өсөн нэмэгдэх сааригүй хүч чармайлт тавих ёстой. Тэдний хүн бүрт гурван зүйл: найз нөхөр, ажил үүрэг, түүнчлэн ‘Бурханы сайн үгээр’ тэжээгдэж байх нь хэрэгтэй. Эдгээр зүйлүүдээр хангах нь бидний үүрэг хийгээд

боломж юм” гэжээ (in Conference Report, 1997оны 4-р сар, 66; Ensign, 1997оны 5-р сар, 47).

Филемонд бичсэн Паулын захидлыг уншихдаа, сайн мэдээнд ахыгаа хүлээж авах тухай түүнд Паулын өгсөн зөвлөгөө Ерөнхийлөгч Хинкли биднээс хийхийг хүссэн зүйлтэй хэрхэн нийцэж байгаа тухай бод.

Судруудыг Ойлгох нь



Филемон 1

Чамд тушаах (ш.8)—Чамд зарлиглах

Ашиггүй (ш.11)—Хэрэггүй, тус нэмэргүй

Ашигтай (ш.11)—Хэрэгтэй, тус нэмэр бүхий

Еврейчүүдэд Бичсэн Төлөөлөгч Паулын Захидал

Еврейчүүд Гэж Хэн Байсан Бэ?

Абрахам бол судруудад Еврей хэмээн нэрлэгдсэн анхны хүн байв (Эхлэл 14:13-ыг үз). Түүний үр удам— ялангуяа Иудей хүмүүс хамтдаа нэг бүлэг болон хамгийн урт удаан хугацаанд оршин тогтнож, Еврей хэмээн нэрлэгдэж, Еврей хэлээр ярьж байжээ. Есүс Христ, Түүний анхны Арванхоёр Төлөөлөгч тэрчлэн Түүний Сүмд анх хөрвөгчид бүгдээрээ Еврейчүүд байлаа.

Яагаад Христийн шашинд хөрвөгч зарим Еврейчүүд Мосегийн хууль дээр тулгуурласан өөрсдийн зан үйл хийгээд ёс заншлуудыг орхих хүнд бэрх цаг үеийг туулж өнгө­рүүлсэн нь тэдний Еврей хөрс сууриар тайлбарлагддаг. Есүс Христ уг хуулийг гүйцэлдүүлэхээр ирсэн бөгөөд Тэрээр тэднийг илүү өндөр хуулийн дагуу амьдрахыг шаардсаныг тэд бүрэн ойлгоогүй юм. Өмнө нь фарисай хүн байсан Паул, “шинэ гэрээ” буюу Есүс Христийн бүрэн сайн мэдээний дагуу тэд амьдрахаар хичээхэд тулгарсан бэрхшээлүүдийг ойлгосон ажээ. Цаашид үргэлжлүүлэн мөрдөх нь ямар ч утга учиргүй болсон Еврейн буюу Иудейн ёс заншлууд хийгээд дадал зуршлуудыг бус, харин Есүс Христэд итгэх тэдний итгэлийг хөгжүүлэхийг тэрбээр тэдэнд урамшуулан дэмжиж байв.

Энэ захидалд Паул Хуучин Гэрээ болон Мосегийн хуулийн тухай гаргууд ойлголтоо, түүнчлэн Их Эзэн Есүс Христийн Төлөөлөгчийн хувьд өөрийн гэрчлэлийг Еврейчүүдтэй хуваалцжээ. Хуучин Гэрээ Христийн эсрэг байгаагүй, харин ч Түүний тухай, Түүний сайн мэдээний тухай бодитойгоор гэрчилж байв.

Судруудыг Судлах нь

Филемон 1-ийг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.


А Сйл Хөдлөлийн Төлөвлөгөө Бич

Хэрэв одоо биш гэхэд нэгэн цагт Сүмд шинээр хөрвөгчтэй уулзаж, танилцах боломж та нарт олдох болно. Филемоныг уншсаны дараа Онесимд яаж хандахыг Паул хүсч байсан шиг, шинэ хөрвөгчид зөвөөр хандаж болох наад зах нь таван өвөрмөц зүйл бич. Тэдгээр таван зүйл тус бүрээр өөрсдийн тань үйл хөдлөлийн төлөвлөгөөнд дэмжлэг болох нэг шүлгийг Филемоноос олж бич.

Еврейг Судлахад Бэлэн Болох нь

Еврейн номноос эрж олох зарим чухал санаануудыг дор өгөв:

1. Хуучин Гэрээний заадаг зүйлүүд хийгээд дадал хэвшилүүд Есүс Христийн амьдрал хийгээд үүрэг зорилгод гүйцэлдсэн билээ. Еврей бол Хуучин Гэрээний талаар бидэнд байдаг хамгийн агуу их тайлбаруудын нэг юм. Та нар Еврей, Хуучин Гэрээг анхааралтай уншиж, ойлгохыг хичээх үед, илүү их ойлголтыг өөрсөддөө олж авах болно.



2. *Есүс Христ болон Түүний сайн мэдээ нь Мосегийн хуулийн дагуу Еврейчүүдийн хөгжүүлж байсан шашны бүх элементүүдээс илүү дээгүүр юм. Мосегийн хуулийн дагуух Еврейн шашин хэдийгээр нэгэн цаг үед зөв байсан хэдий ч, Есүс уг хуулийг гүйцэлдүүлж, илүү өндөр, сэлэстиэл хуулийг өгсөн юм. Мосегийн хууль хүмүүст авралыг авчирч чадаагүй, харин Есүс Христ чадсан бөгөөд үүнийг хийсэн билээ. Христ бол тэнгэр элчүүд, бошиглогчид хийгээд санваартнуудаас илүү агуу гэдгийг харуулахын тулд Паул Хуучин Гэрээний судруудыг ашигладаг байв. Түүнчлэн Христийн Санваар—Мелкизедек Санваар нь Мосегийн хуулиар хөгжүүлж байсан Аароны санваараас илүү агуу гэдгийг тэр бас харуулжээ.*
3. *Хуучин Гэрээний хүмүүс Христэд итгэх итгэлийнхээ учир агуу зүйлүүдийг хэрэгжүүлж байсанд бид гайхан биширдэг. Амьдралаа Есүс Христэд төвлөрүүлж байсан Хуучин Гэрээний олон баатруудын тухай (Иахова; Еврей 11-ийг үз) Паул бичиж, тэднийг үлгэр жишээ болгон харуулахад тэрээр Гэгээнтнүүдийг урамшуулан дэмждэг байв.*

Еврей 1–2

Дорд Байснаар Илүү Агуу Болох нь

Христэд итгэгч еврейчүүд өөрсдийн хуучин итгэл бишрэлүүд хийгээд ёс занлиудыг ардаа орхиж, Есүс Христ болон Түүний сайн мэдээнд бүрэн төвлөрөхийн тулд тэмцэж байлаа. Үүний улмаас Паул тэдэнд хандсан захидлаа, Есүс Христ бол Өөрийн Эцэгээс бусад бүх зүйлүүдээс илүү агуу хийгээд тэд бүгдийн өмнө байсан гэсэн хүчирхэг гэрчлэлээр эхэлжээ. Та нар Еврей 1–2-ыг уншихдаа, Есүс Өөрийн хүчийг хэрхэн олж авсан хийгээд яагаад Тэрээр тэнгэр элчүүдээс дээгүүр болох талаар Паул юу зааж байсныг ажигла.

Судруудыг Ойлгох нь



Еврей 1

Томилсон (ш.2)—Сонгосон, томилсон
Өвлөгч (ш.2)—Өв залгамжлагч
Түүний мөн чанарын бодит илэрхийлэл (ш.3)—Өөрийнхөө төрхтэй

Ариусгалыг гүйцээгээд (ш.3)—Цэвэршүүлж (бидний нүглүүдийн төлөө Есүс Христ төлөөс төлснийг хэлж байна)
Очирт таяг (ш.8)—Хүчийг бэлэгдэгч таяг буюу саваа
Хувцас (ш.12)—Өмсгөл

Еврей 1:4–8, 13–14; 2:2, 5–9, 16—Тэнгэр Элчүүд

Тэнгэр элч гэдэг нэр томъёо нь “элч” гэсэн утгатай. Тэнгэр элч бол Өөрийн ажлыг хийлгэхээр Бурханы илгээсэн аливаа элч юм. Еврей 1–2-т дурьдагддаг тэнгэр элчүүд бол үйлчлэх болон Түүний ажлыг гүйцэтгэх тусгай дуудлагууд бүхий Тэнгэрлэг Эцэгийн гэр бүлийн гишүүд байлаа. Зарим тэнгэр элчүүд бол дэлхийд хараахан ирээгүй, Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүд юм. Бусад нь газар дээр амьдарч байсан хүмүүс бөгөөд, (а) сүнсний дэлхий дэх Сүнснүүд, (б) зөөгдсөн хүмүүн биетүүд (Хайрт Иохан шиг), (в) амилулагдсан хүмүүн биетүүд (Иосеф Смит дээр хүрч ирсэн Моронай буюу эсвэл Иохан Багтист шиг) юм.



Еврей 2

Анхаарал хандуулах (ш.1)—Ариусгах (ш.11)—Ариун болгох
Баттай (ш.2)—Байнгын, өөрчлөгдөшгүй
Хариугаа хүртсэн бол (ш.2)—Шударга, зөв шийтгэл
Баталсан (ш.3)—Гэрчилж, заасан
Захируулах (ш.5)—Хяналтан дор тавих
Ариусгах (ш.11)—Ариун болгох
Боолчлогдож (ш.15)—Боол лугаа адил
Ёстой байв (ш.17)—Чухал байв
Эвлэрүүлэл (ш.17)—Бүрэн төлөөс (Бурханд өргүй болох)
Тусалж (ш.18)—Тайтгаруулж, туслах

Еврей 2:7–9—“Тэнгэр Элчүүдээс Арай Дорд”

Еврей 1-д Есүс Христ бол тэнгэр элчүүдээс илүү агууг Паул заажээ. Дараа нь Еврей 2-т Христ тэнгэр элчүүдээс арай дорд болгогдсон гэж тэр хэлжээ. Яагаад ийм байдаг билээ? Үнэндээ бол энэ хоёр нотолгоо хоёул зөв юм. Есүс Өөрийн Эцэгээс бусад бүх зүйлээс илүү агуу боловч, Тэрбээр Өөрийгөө “дорд” тавьж, бүх хүмүүний адилаар төрж, мөнх бус байдлын өвчлөлүүдэд (үүнд тэнгэр элчүүд өртдөггүй) өртдөг болгосон билээ. Бүх хүн төрөлхтний өвдөлтийг тэвчихийн тулд Есүс мөнх бус байдлын өвдөлтийг тэсвэрлэхээс илүү хол давж гарсан юм (2 Нифай 9:21-ийг үз). Тэрбээр ийнхүү Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүдээс аль нь ч, мөнх бус байдалд хэзээ ч байгаагүйгээр “доош бууж ирсэн” юм. Мөнх бус байдлын нөхцлүүдэд захирагдсанаар Түүний зовлонгууд хийгээд Цагаатгалаар нигүүлсэлд суралцаж, бүх зүйлсийн дээрх хүчийг олж авснаар Паул үүнийг тайлбарлажээ.

Судруудыг Судлах нь

Еврей 1–2-ыг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Есүс Христийн Тухай Илүү Ихийг Мэд

1. Еврей 1:1–4 болон 2:9–18-аас Есүсийн талаар өөрсдийн мэдэж авсан зүйлүүдээс наад зах нь тавыг жагсаа.
2. Иудейн хөрвөгчид Есүс Христэд итгэх итгэлээ нэмэгдүүлэхэд нь туслахын тулд Паул Еврейчүүдэд бичжээ. Өөрсдийн тань жагсаалтан дахь аль зүйл тэдний хувьд хамгийн их утга учиртай байна гэж та нар бодож байна? Яагаад?
3. Өнөөдөр Түүний талаарх хүмүүсийн буруу ойлголтыг залруулахын тулд Еврей 1–2-оос Есүсийн талаар мэдэж авсан зүйлээсээ юуг нь ашиглаж болохыг тайлбарла.

Б Есүс Христийн Сүргийг Тунгаан Бод

1. Еврей 2:9–11-ийн дагуу, яагаад Есүс Өөрийгөө “тэнгэр элчүүдээс арай дорд” болгогдохыг зөвшөөрсөн бэ? (Тусламж болгож дээрх “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз).
2. Еврей 2:10-г Паул Есүсийг юу гэж нэрлэснийг ол. Хэрэв хүн Түүний тухай ийм байдлаар бодох юм бол, энэ нь ямар өөрчлөлт гаргаж болох вэ?
3. Есүс юу хийхээс ичээгүйг Еврей 2:11-ээс ол. Үүнийг мэдсэнээр та нарт ямар бодол төрөх вэ?
4. Есүс мөнх бус байдлыг биеэрээ туулсны ач холбогдлын талаар Еврей 2:14–18 бидэнд юу өгүүлдэг вэ? (Та нар энэ асуудлыг авч үзэхдээ Алма 7:11–13, Еврей 4:15–16-г уншиж болно.)

Бурханы Оршихуй

Тэнгэрлэг Эцэгийнхээ орон гэрт хүрэх замыг хэрхэн олохыг бидэнд үзүүлэхийн тулд Есүс Христ Өөрийн Эцэгийн оршихуйг орхиж, мөнх бус байдалтай болсон билээ.

Мөнх бус байдал

Еврей 3–4

Египетээс Гарсан нь-аас
Авах Сургамжууд

Хуучин Гэрээн дэх хамгийн чухал хийгээд нэрд гарсан түүхүүдийн нэг нь Израилчууд Египетээс Гарсан болон

амлагдсан нутаг тийш явсан тэдний аяллын тухай түүх юм. Эртний Израилчуудын нэгэн адил Паулын үе дэх Христэд итгэгч Иудейчүүдийн зарим нь, тэднээс Бурханы хүссэн зүйл хэтэрхий хүнд байсан гэж боддог байжээ. Иудейн хөрвөгчдийг итгэлээ хадгалж, өвөг дээдсийнхээ алдааг давтахгүй байхад нь урамшуулан дэмжихийн тулд Египетээс Гарсан тухай түүхийг Паул Еврей 3–4-т ашигладаг байв. Мосегийн үе дэх Еврейчүүд Египетээс гарч аялсан бүхий л аяллын туршид Бурханд итгэж, Түүний дуулгавартай дагах нь хангалтгүй байсны улмаас амлагдсан нутагт орох нь тэдэнд зөвшөөрөгдөөгүй ажээ. Итгэл дутсаны улмаас Еврейчүүд түүний үед Их Эзэний амралтад орохоос татгалзагдсан байхыг Паул хүсээгүй юм. Яг Мосе тэдний өвөг дээдсийг удирдсан шиг, Есүс Христ тэднийг Тэнгэрлэг Эцэгийн оршихуй уруу эргүүлэн удирдах болно гэдгийг Паул гэрчилжээ.

Еврей 5

Есүс Христ, Агуу Дээд Санваартан

Левийн овгийн олон хүн Израилын ариун сүмүүдийн санваартнуудаар ажиллахаар дуудагддаг байсан хэдий ч—Аароны удмын ганцхан хүн—дээд санваартнаар (Аароны Санваарын жаягаар) дуудагджээ. Левит 16-д тайлбарласанчлан ариун сүм дэх Ариунаас Ариунд орсон энэ дээд санваартан нь бүх хүмүүсийн нүглүүдийн төлөө жилд нэг удаа тусгай тахил өргөдөг байжээ. Цагаатгалын өдөр хэмээгддэг байсан энэ өдөр хүмүүс мацаг барих нь олон-таа байлаа. Еврей 5-д, Израил дахь дээд санваартан нь, бүх хүмүүсийн нүглүүдийн төлөө төгс Цагаатгалыг хийж, дараа нь Өөрийн Эцэгийн оршихуйд орсон, тэдний үнэнхүү бодит дээд санваартан, Есүс Христийн зөвхөн бэлэгдэл байсныг Паул тайлбарласан байдаг. Энэ мэдлэг нь, хамт олон дахь хүчирхэг хүн, Иудейн дээд санваартныг дагах дарамтыг мэдэрсэн хэвээр байсан Иудейн итгэлээс хөрвөгчдийн хувьд ашиг тустай байлаа.

Судруудыг Ойлгох нь

Еврей 5

Мөхөс байдлаар хүрээлэгдсэн (ш.2)—Сул дорой байдалаар дүүрсэн

Хүмүүсийн ба түүнчлэн өөрийнхөө төлөө (ш.3)—

Санваартан тахилыг зөвхөн

хүмүүсийн төлөө төдийгүй, бас түүнчлэн өөрийнхөө төлөө өргөдөг байжээ.

Хүндлэл (ш.4)—Дуудлага
Залбирал болоод гуйлтууд
(ш.7)—Бурханд хандсан зал-
бирлууд болон гуйлтууд

Бурханы үгс (ш.12)—
Бурханы үгс болон айлдва-
рууд
Ялгах (ш.14)—Ялгагч нь
хэлэх, шүүх

Еврей 5:6–10—Мелкизедек

Еврей 5:6, 9–10 нь Мелкизедек Санваарт хамаардаг. Аврагчийн санваар нь хоёр шалтгааны улмаас Христийн нэрийг хэтэрхий олон удаа давтан хэрэглэхээс зайлсхийхийн тулд, түүнчлэн Мелкизедек нь агуу их хаан хийгээд дээд санваартан байсны улмаас Мелкизедек Санваар хэмээн нэрлэгдсэнийг Сургаал ба Гэрээ 107:1–4 бидэнд өгүүлдэг. Есүс бол Мелкизедекийн жаягаарх дээд санваартан байсан юм гэдэгт Паул Еврей номны туршид онцгой анхаарал хандуулсан байдаг. Мелкизедек Санваар бол Мосегийн хуулийн дагуу хэрэгжүүлж байсан Аароны Санваараас илүү агуу байсныг тэрээр заадаг байв. Энэхүү илүү өндөр санваар зохистой бөгөөд Сүмд боловсорч эрийн цээнд хүрсэн бүх эрэгтэйчүүдэд, тэд Христийн аврагч ажлыг хийж болохын тулд өгөгддөг энэ үед бид аж төрж байгаа нь аз завшаантай хэрэг юм.

Судруудыг Судлах нь

Еврей 5-ыг судлахдаа үйл ажиллагаа А–В-г хий.

А Төгс Эзэмших Судар—Еврей 5:4

1. Еврей 5:4-ийн дагуу, санваарыг буюу үүн доторх аливаа дуудлагыг хэн хүлээж авах эрхтэй вэ?
2. Египетээс Гарсан нь 28:1-ийг уншиж, Аарон хэрхэн дуудагдсаныг дүрсэл. Энэ шүлгийг итгэлийн тавдугаар тунхагтай харьцуул.



Б Дуулгавартай Байдалд Суралцах нь

1. Еврей 5:7–8-ын дагуу, Мелкизедек хэрхэн тийм агуу болсон бэ?
2. Хүн яагаад тийм замаар дуулгавартай байдалд суралцаж болно гэж боддогоо тайлбарла.

В Сүү Юү, Эсвэл Хоол уу?

Бяцхан хүүхдүүд мэтийн зарим гишүүд сайн мэдээгээр амьдрахад илүү боловсорч, сүнсний “хоолтой” харьцах

хүртлээ “сүүгээр” тэжээгдэх учиртайг Паул Еврей 5:12–14-т тайлбарлажээ. Өөрсдийнхөө сүнсний боловсорсон байдлыг яг одоогийн байдлаар авч үзэн, та нар өөрсдөө сүнсний ямар хоолонд бэлэн байгаа тухайгаа бич. Яагаад гэдгийг тайлбарла.

Еврей 6–10

Мосегийн Хууль Христийн Тухай Гэрчилдэг

Хуучин Гэрээний заадаг зүйлүүд хийгээд дадал хэвшилүүд Есүс Христ болон Түүний сайн мэдээгээр хэрхэн гүйцэлдсэнийг Паул Иудейн хөрвөгчдөд заадаг байлаа (Еврей 6–10-ыг үз). Есүс Христийн “шинэ гэрээ”, “хуучин гэрээнээс” илүү агуу юм, учир нь шинэ гэрээ мөнх амьдралыг баталгаажуулагч хүчтэй юм.

Судруудыг Ойлгох нь

Еврей 6—Урагш Ахих нь

Иудейчүүд сайн мэдээний үндсэн зарчмуудыг аль хэдийнэ сайн мэддэг байсан бөгөөд тэд сүнсний дэвшилдээ урагш ахих хэрэгтэйг Паул тэдэнд сануулдаг байв. Абрахамд Бурханы өгсөн мөнх амьдралын тухай амлалт нь, хэрэв тэд үнэнч бөгөөд эцсээ хүртэл итгэлтэй хэвээр байх юм бол Абрахамын үр удам —тэдэнд уламжлан өгөгдөх болно гэдгийг тэр тайлбарладаг байв.

Еврей 7—Дээд Санваар

Мелкизедекийн тухай, түүнчлэн Христийн авчирсан Мелкизедек Санваар хийгээд Мосегийн хуулийн дагуу Иудейчүүдийн хөгжүүлж байсан Аароны Санваарын хоорондох ялгааны талаар Паул хүмүүст улам ихийг заадаг байв. Аароны Санваар хязгаарлагдмал учраас, мөнх амьдралын адислалуудыг олж авч, адислахын тулд илүү өндөр санваар хэрэгтэй юм.

Еврей 8—Шинэ Гэрээ

Есүс Христ бол Иеремиа 31:31–34 дэх бошиглолын гүйцэлдэлт болсон, “шинэ гэрээний” дээд санваартан байсан юм гэдгийг Паул гэрчилжээ.

Еврей 9–10—Золиослол

Ариун сүм хийгээд Мосегийн хуулийн дагуух үүний ёслолуудын ач холбогдлыг Паул Еврейчүүдэд заадаг байжээ. Өргөдөг байсан бүх тахил нь түүний золиослол бусад бүх золиослолуудыг утга учиртай болгосон Есүс Христийн бэлэгдэл байсныг тэрээр гэрчилдэг байжээ. Есүс Христийн золиослолоор дамжуулан бид өөрсдийн нүглүүдийн ангижралыг олж авч чадах бөгөөд зөвхөн дээд санваартан төдийгүй, бүх хүмүүс Бурханы оршихуйд зайлшгүй орж болно.



Судруудыг Судлах нь

Еврей 6–10-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Хоёр Агуу Бошиглогч

Еврей 7:1–4-ийг уншаад, Абрахам, Мелкизедек нарын тухай юу мэдсэнэ бич. Шүлэг 3-ын эхний хэсэг нь Мелкиздекийн тухай биш, харин санваарт хамаардаг бөгөөд энэхүү өндөр санваарыг хүлээж авахын тулд хүн, Израилын аль нэг овгоос гаралтай байх нь албагүй гэсэн үг юм. Уг шүлгийн сүүлчийн хэсэг нь Мелкизедек санваарыг хүлээн авдаг хүн болгонд хамаатай юм. (Bruce R. McConkie, *The Promised Messiah: The First Coming of Christ* [1978], х. 451-ийг үз.)

Еврей 11

Есүс Христэд Итгэх Итгэлийн Хүч

Мөнх бус энэ амьдрал итгэлээр амьдрахыг биднээс шаарддаг. Үүнийг хэрхэн хэрэгжүүлэхийг бидэнд харуулсан хүмүүсийн олон жишээг Библи агуулдаг бөгөөд Паул тэднээс нилээдийг нь Еврей 11-д нэрлэжээ. Судрууд дахь эдгээр агуу эрчүүд болон эмэгтэйчүүдийн нэгэн адил бид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг итгэлээр ойлгож, итгэлээр дагахыг эрэлхийлдэг билээ. Бид итгэлээ Есүс Христэд төвлөрүүлэхэд, бид зовлон зүдгүүрүүд хийгээд уруу таталтуудыг тэсэн гарах хүч чадалтай болж, тэнгэрлэг гэр орон өөдөө сүнснэг ахиц дэвшил хийх чадвартай байх болно.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли, “Хамгийн гол чухал зүйл бол, Сүмийн цорын ганц үнэн бодит баялаг нь хүмүүсийнх нь итгэлд байдаг” гэж хэлжээ (in *Conference Report*, 1991 оны 4-р сар, 74; *Ensign*, 1991 оны 5-р сар, 54). Еврей 11-ийг уншихдаа Паулын бичсэн тэдгээр эрчүүд болон эмэгтэйчүүдийн харуулсан итгэлийн агуу үлгэр жишээг та нар хэрхэн хэрэглэхийг, Бурханы хаант улсын үнэн бодит баялагт өөрсдийн итгэлийг хэрхэн нэмэхийг авч үз.

Судруудыг Ойлгох нь

Еврей 11

Баталгаа (ш.1)—Гэрчлэл, нотолгоо

Бүтээгдсэн (ш.3)—
Бүтээгдсэн

Өвлөгч (ш.7)—Ямар нэг зүйлийг хүлээж авах буюу өв залгамжлах эрхтэй хүн

Хамт нутаглаж (ш.9)—
Байнга биш, түр хугацаагаар нэг газарт амьдрах

Майхан (ш.9)—Асар, майхан, түр сууц

Үртэй болох (ш.11)—
Хүүхэдтэй болох

Нэгэн эрээс заяажээ (ш.12)—Нэг хүнээс хүүхдүүд иржээ

Итгэл дотор (ш.13)—
Итгэсээр, сүнсээр нөлөөлөгдөн

Буцаан (ш.19)—Бэлэгдэл

Эрийн цээнд хүрээд (ш.24)—Насанд хүрсэн гэж тооцогдохоор болсон

Үзжээ (ш.26)—Үнэлжээ

Христийн төлөөх буруутгал (ш.26)—Христийг дагаснаас түүний хүлээсэн шүүмжлэл

Тэр шагнал уруу харж байлаа (ш.26)—Тэр зайлшгүй шүүгдэж мөн шагнагдана гэдгээ мэдэж байв

Завдах (ш.29)—Оролдох, хичээх

Тойрох (ш.30)—Бүслэх

Харийн дайчид (ш.34)—
Гадаадынхан, дайснууд

Ташуурдуулах (ш.36)—
Ташуурдуулах, зодуулах

Хоосон тарчиг (ш.37)—
Амьдралын хэрэгцээт зүйлсгүйгээр

Еврей 11:1—Итгэлийн Тухай Паулын Тодорхойлолт

Тухайн үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Ховард В.Хантер Еврей 11:1-ийг тайлбарлахад тусалж хэлэхдээ, “Итгэл нь бидний найддаг тэр зүйлд мөн бидний хардаггүй тэр зүйлийн үнэмшилд биднийг итгэлтэй болгодог. . . . Бурханыг чин сэтгэлээсээ эрэлхийлдэг хүмүүс түүнийг хардаггүй, гэвч тэд итгэлээр түүнийг бодитойг мэддэг. Энэ бол найдвараас илүү юм. Итгэл нь үүнийг үнэмшил—харагддаггүй юмсын нотолгоо болгодог” гэжээ (in *Conference Report*, 1974 оны 10-р сар, 138; *Ensign*, 1974 оны 11-р сар, 97). Та нар бас Алма 32:21 болон Ифэр 12:6-д бусад бошиглогчдын өгсөн итгэлийн тухай тодорхойлолтуудыг уншиж болно.

Еврей 11:5—Енох Зоогдов

Енох зөөгдсөн бөгөөд, энэ нь тухайн хүний амилуулалт хүртэл өвдөхгүй буюу үхэхгүй болж, биед нь Бурхан өөрчлөлт оруулсан гэсэн үг юм. (Өөр нэг жишээ болгож, 3 Нифай 28:4–9-ийг үз.)

Еврей 11:10–16—Ямар “Хот” буюу “Орныг” Эртний Бошиглогчид Эрж Байсан бэ?

Энгийнээр өгүүлбэл, эртний бошиглогчдын эрж байсан хот буюу орон нь Бурханы амьдардаг газар болох тэнгэр, сэлэстиэл хаант улс байлаа. Дэлхий Уналтын үр дагаврын нөлөөнд байхдаа дэлхий дээр тэнгэр байх нь үгүй болов. Гэсэн хэдий ч, Бурханы хүмүүс Түүнтэй ариун гэрээнүүдийг хийж, бүрнээр сахсан үед тэд Сион хэмээн нэрлэгддэг зөв шударга ёст хотуудыг үндэслэн байгуулдаг (Мосе 7:18-ыг үз). Сион дахь хүмүүс дэлхий дээр Бурханы оршихуйг эдлэх онцгой боломжтой байдаг. Сионыг байгуулснаар “барилгач бөгөөд бүтээгч нь Бурхан байдаг”, Паулын дурьдсан, бошиглогчдын эрэлхийлж байсан тэрхүү хотыг итгэлтэй Гэгээнтнүүд олж авч болно (Еврей 11:10). Эцсийн өдрүүдэд дэлхий дээр Сион, тухайлбал Шинэ Иерусалим хэмээн нэрлэгдэх Сионы төв хот дахин байгуулагдах болно гэдгийг судрууд бошиглодог (С ба Г 45:65–67; 84:2–5-ыг үз).

Ирээдүйн Иерусалимууд

<p style="text-align: center;">Мянганы Өмнө</p> <div style="text-align: center;">  <p>Миссурийн Индепенденс</p> </div> <p style="text-align: center;">Эцсийн өдрүүдэд Гэгээнтнүүдээр баригдах хот</p>	<p style="text-align: center;">Мянганы Дараа</p> <div style="text-align: center;">  <p>Сэлэстиэл Дэлхий</p> </div> <p style="text-align: center;">Сэлэстиэл дэлхийтэй нэгдэхээр бууж ирэх ариун хот</p>
--	--

Судруудыг Судлах нь

Еврей 11-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Итгэлийн Жишээнүүд

- Тэмдэглэлийнхээ дэвтэрт итгэлтэй хүмүүсийг жагсаасан хүснэгт хий. Еврей 11-ээс түүнчлэн дараах хүснэгт дэх жишээнээс мэдсэн зүйлээ ашигла.

Нэр	Еврей 11	Итгэлээ Хэрхэн Харуулсан	Хүлээж Авсан Адислалууд
Абел	шүлэг 4	Бурханд “илүү онцгой тахил” өргөсөн	Түүний мэлмийд тэрээр зөв шударга байсан хэмээн Бурханаас ирсэн гэрчлэл

- Итгэлийн үлгэр жишээ байсан хүмүүсээс нэгийг нь сонго. Тэр хүний үлгэр жишээ танд хэрхэн холбогдох хийгээд өнөөдөр танд тулгарч байгаа бэрхшээлийг шийдвэрлэхэд өөрсдөд тань хэрэгтэй байгаа итгэлийн тухай товчхон бич. Тэр хүний бэрхшээлүүд таны бэрхшээлүүдтэй хэр зэрэг адилхан байна вэ?

Б “Итгэлээр”

Өнгөрсөн үеийн тэдгээр агуу эрчүүд хийгээд эмэгтэйчүүд Бурханы адислалуудыг “итгэлээр” олж авч байсныг Еврей 11 бидэнд олон удаа өгүүлдэг.

- Хэрэв энэ нь та нарын үед мөн та нарын амьдардаг газарт бичигдсэн гэж үзвэл, үүнд оруулж болно гэж өөрсдийн бодсон, наад зах нь гурван хүний үлгэр жишээг дурьд.
- Еврей 11-ээс Паулын загварыг ашиглан, өөрсдийн сонгосон гурван хүний тухай бич. Жишээ бүрийг “Итгэлээр” эхэлж, дараа нь хүний нэрийг өгч, агуу итгэл үзүүлэхийн тулд тэрээр юу хийж байсныг хэлж, яагаад ийн агуу итгэл үзүүлж байсныг тайлбарлаж, энэ амьдралд болон дараагийн амьдралд ийм хүнд Бурханы амласан адислалуудаас заримыг нь жагсаан бич.

Еврей 12

Шийдвэр Төгс Байдал ба Залруулга

Есүс Христэд итгэх итгэлээ харуулж байсан хүмүүсийн тухай олон түүхийг Еврей 11 агуулдаг. Еврей 12-т, ийм итгэлтэй байх нь Их Эзэнд итгэхэд бидэнд хэрхэн сүнс­лэгээр нөлөөлөх ёстойг Паул тайлбарласан байдаг. Биднийг засч залруулах боломжийг Их Эзэнд олгож, амьдралынхаа эцсийг хүртэл шийдвэр төгс байх нь бид Түүнд итгэх итгэлээ харуулж болох хоёр чухал арга зам мөн. Еврей 11 дэх түүхүүд хийгээд үлгэр жишээнүүдээр сүнс­лэгээр нөлөөлөгдөн, та нар мэдэж авсан зүйлээ хэр­хэн хэрэглэхийг Еврей 12-оос эрж хай.

Судруудыг Ойлгох нь

Еврей 12

Хүрээлэн буй (ш.1)—
Тойрон буй
Үүл (ш.1)—Тоо, бүлэг
Саад тогтор (ш.1)—
Бэрхшээл, зовлон
Эс тоомсорлох (ш.2)—
Анхаарал үл тавих

Зэмлэл, зэмлэдэг, зэмлэ­сэн (ш.5–8, 10–11)—Загнах,
шүүмжлэх, залруулах
Ташуурддаг (ш.6)—
Шийтгэдэг

Бутач хүүхдүүд (ш.8)—
Гэрлээгүй эмэгтэйдээс төрсөн хүүхэд (өнөөдөр энэ нэр томъёог бүдүүлэг гэж үздэг); Тэд Бурханыг дагадаггүй учраас Түүний хууль ёсны хүүхдүүд биш гэдгийг харуулахын тулд Паул энэ нэр томъёог ашиглажээ.

Хүндэлдэг (ш.9, 28)—
Хүндэтгэл, дуулгавартай байдал

Захирагдан (ш.9)—
Дуулгавартай дагах хүсэлтэй, хяналтад байх

Уй гашуутай (ш.11)—
Уйтгартай, гунигтай

Сулдсан (ш.12)—
Сул дорой (тэрчлэн айдсыг бэлэгдсэн байж болно)

Зайлсхийж байсан (ш.19)—
Мэдрэмжтэйгээр хүсч байсан, гуйсан

Зууч (ш.24)—
Хоёр хүний хооронд энх тайван болон нөхөрлөлийг тогтоох (эсвэл сэргээх) буюу гэрээ батлахад зуучилдаг хүн.

Еврей 12:18–21—Уул

Эдгээр шүлгүүд Синайн Уулан дээрх Мосегийн болон Израилын хүүхдүүдийн туршлагад хамаарна. Мосетой хамт уулан дээр гарч, Их Эзэний оршихуйд орох боломжийг тэдэнд татгалзахаар Израилчууд тийм зохисгүй хийгээд аймтгай байжээ.



Еврей 12:22—Тэнгэрлэг Иерусалим

Еврей 12:22-т Паулын дурьдсан тэнгэрлэг Иерусалимын тухай уншихын тулд Еврей 11-ийн “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз.

Еврей 12:24—Христийн Цус “Абелынхаас Илүү Сайн Сайхан Зүйлсийг Ярьдаг”

Абелын үхэл мөнх бус амьдралын төгсгөлийг төлөөлдөг. Христийн үхэл болон амилуулалт мөнх амьдралд хүрэх замыг нээсэн нь—Абелын үхлийг төлөөлдөг зүйлээс хязгааргүй илүү юм.

Судруудыг Судлах нь

Еврей 12-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Хүч Чадлаар Тэсэх нь

1. Еврей 11-д Паул итгэлтэй хувь хүмүүсийн олон жишээг дурьджээ. Еврей 12:1–2-ыг уншаад, өөрсдийн итгэлийг харуулахын тулд Еврейн Гэгээнтнүүдийг юу хийхэд Паул урамшуулан дэмжиж байсныг жагсаан бич.
2. Есүс “уруу харах нь” “өмнөө тавигдсан уралдааныг” дуусгахад бидэнд хэрхэн тусалж болохыг тайлбарла (амьдралын бэрхшээлийг үхэл хүртэл итгэлтэйгээр даван туулахыг). Амьдралдаа Есүс уруу илүү бүрэн дүүрнээр харж болох хоёр арга замыг нэрлэ.

Б Хайрлагч Эцэгийг Залруулах нь

1. Еврей 12:5–8-ын дагуу, Тэнгэрлэг Эцэгээс, эсвэл Түүний үйлчлэгчдээс залруулга буюу шүүмжлэл хүлээж авахдаа бид яагаад баярлах ёстой вэ?
2. Тэнгэрлэг Эцэг биднийг засч залруулдаг наад зах нь хоёр арга замыг нэрлэ.
3. Тэнгэрлэг Эцэгийн залруулгууд өөрсдийг тань хайрладаг Түүний хайрыг хэрхэн харуулдгийг тайлбарла, эсвэл Еврей 12:11-д илэрхийлэгдсэн санаануудын үнэнийг өөрсдөө мэдэрч байсан цаг үеийн тухай жишээ гарга.

В Бусдад Сзүүлэх Бидний Нөлөө

Еврей 12:12–14-т Паул бие биендээ тусалж, бие биендээ үйлчилж байхыг Гэгээнтнүүдэд зөвлөжээ. Дараа нь шүлэг 15-д, хэрэв Бурхан тэднийг хэрхэн адисласныг умартаж, сөрөг санаа бодлуудаа өөгшүүлэх юм бол, тэдний муу үлгэр дуурайл тэдэнд өөрсдөд нь болон бусдад гай зовлон учруулах болно гэдгийг тэрээр сэрэмжлүүлсэн байдаг. Хэн нэгний хайрын, үйлчлэлийн, эсвэл нинжин сэтгэлийн эерэг үлгэр жишээ өөрсдийг тань илүү зөв шударга байхыг хүсэхэд тусалсан үеийн тухай бич.

Еврей 13

Зааврын Сүүлчийн Зүйлүүд

Еврейчүүдэд бичсэн захидлаа тэрээр төгсгөхдөө, гаднын хүмүүст элдэг (Еврей 13:1–3-ыг үз), гэрлэлтэд үнэнч итгэлтэй (ш.4-ийг үз), амин хувиа хичээдэггүй (ш.5–6-г үз), удирдагчдаа дэмждэг (ш.7, 17–19, 24-ийг үз) байх, түүнчлэн—бүхнээс илүүгээр—Есүс Христийг дурсан санаж (ш.8–16, 20–21-ийг үз), шашинаараа амьдрахыг Паул Гэгээнтнүүдэд зөвлөжээ.

Судруудыг Судлах нь

Еврей 13-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Энэ нь Их Сайн Сг Болно

Сүмийн удирдагчдын хэлж болох үгийн хувьд сайн сэдэв болно гэж өөрсдийн бодсон нэг өгүүлбэрийг Еврей 13-аас сонго. Яагаад уг сэдвийг сонгож авснаа тайлбарлаж, уг сэдвээр хэлэх үгэнд ярилцаж болно гэж өөрсдийн бодсон, наад зах нь хоёр санааг жагсаан бич.

Иаковын Нийтлэг Захидал

Нийтлэг Захидал Гэж Юу Вэ?

Иаковын ном бол нийтлэг захидал хэмээн нэрлэгддэг долоон захидлын эхнийх нь юм. Ингэж нэрлэгдсэний учир бол эдгээр нь, хувь хүмүүс буюу хэсэг бүлгүүдэд хандсан Паулын захидуудаас илүүгээр нийтлэг ерөнхий уншигчдад хандан бичигдсэн байлаа.

Иаков Гэж Хэн Байсан Бэ?

Иаков бол Еврей хэлний *Жакоб* гэсэн грек нэр бөгөөд Шинэ Гэрээн дэх нийтлэг нэр юм. Иаков нэртэй өөр зарим хүмүүс байсан нь, Петр, Иохан хоёрын хамт Тэргүүн Зөвлөлийн гишүүн асан, Хайрт Иоханы ах Иаков, Есүсийн Арванхоёр Төлөөлөгчийн нэг байсан, Алфайн хүү Иаков нар байлаа. Энэ захидлын зохиогч нь Шударга Иаков байв. Тэр бол Есүсийн дүү бөгөөд Иерусалим дахь Сүмийн бишпоор үйлчилж байжээ.

Амилуулагдсан Их Эзэнийг харах онцгой боломж Иаковт тохиожээ (1 Коринт 15:7-г үз). Тэр амьдралынхаа туршид сайн мэдээнд итгэлтэй байсан юм. Ам дамжсан яриагаар бол тэр өөрийнхөө итгэлийг буруутган шүүмжлэхийг түүнээс шаардсан хүмүүсээр МЭ 63 оны орчимд цаазлуулсан ажээ. Энэ захидал МЭ 50 оны орчимд бичигдсэн гэдэгт итгэдэг ажээ.

Иаков Юу Заасан Бэ?

Жинхэнэ Христийн шашин зөв шударга хүмүүс амьдрал ажил үйлс хийгээд үйлчлэлд байхыг шаарддагийг Иаков зааж байжээ. Есүсийн дагалдагч байх сорилт нь өдөр тутмын зөв шударга байдал болон нинжин сэтгэлийн үйл ажиллагаанд байдаг. Ийм үйлдлүүд бол Есүс Христэд итгэх бидний итгэлийн нотолгоо болдгийг Иаков заажээ.

Иаков 1–2

“Үйлсгүй Итгэл Үхмэл Юм”

Есүс Христ болон сайн мэдээнд итгэдэг гэж хэлдэг атлаа хэлсэн шигээ ажилладаггүй хүмүүсийн талаар та нар юу гэж боддог вэ? “Үйлсгүй итгэл үхмэл юм” (Иаков 2:26) гэж Иаков заажээ. Гэгээнтнүүдийн хувьд бид, сайн мэдээгээр амьдардгаараа итгэлээ харуулах ёстой. Та нар Иаков 1–2-ыг уншихдаа, сайн мэдээгээр амьдрахад тань та нарыг урамшуулан дэмжиж, туслах заалтуудыг эрж ол.



Судруудыг Ойлгох нь



Иаков 1

Төгс (ш.4)—Төгс, төгөлдөр
Өгөөмрөөр (ш.5)—Илээр,
чөлөөтэйгөөр

Буруушаалгүй (ш.5)—
Зэмлэлгүй, загналгүй

Хоёр санаа өвөрлөгч
хүн (ш.8)—Эргэлздэг,
тээнэгэлздэг хүн

Тэсвэрлэдэг (ш.12)—Тэсдэг
Өөрчлөлт ч байхгүй, өөрч-
лөгдөх сүүдэр ч байхгүй
(ш.17)—Өөрчлөлтгүй, өөрч-
лөлт байхгүй

Толь (ш.23)—Толь
Хазаарлах (ш.26)—Хянах

Иаков 1:5—“Та Нарын Хэн Нэгэн нь Мэргэн Ухаанаар Дутвал, Бурханаас Гуйг”

Ахлагч Брус Р.МакКонки, “Судрын энэ ганцхан шүлэг агуу үр нөлөөтэй бөгөөд ямар ч цаг үед, ямар ч бошиглогчоор хэзээ нэгэн цагт цэдэглэгдсэн ямар ч ганц өгүүлбэрээс хавьгүй илүүгээр хүн төрөлхтөнд нөлөөлсөн юм” гэж бичжээ (*Doctrinal New Testament Commentary*, 3:246–47). Энэ судрыг уншсаны дараа Иосеф Смит аль сүмд нэгдэх тухай залбирахаар явах мэдрэмж хийгээд үнэн түүнд ирсэн билээ. Энэхүү даруухан залбирлаар сайн мэдээний Сэргээлтийн эхлэл ирсэн юм.

Иаков 1:25—“Эрх Чөлөөний Төгс Хууль” Гэж Юу Вэ?

“Эрх чөлөөний төгс хууль” бол бүрэн сайн мэдээ юм. Хэрэв бид сайн мэдээний зарчмуудын дагуу амьдрахаар сонгосон л бол, бид нүглийн боолчлолоос хол байх ёстой (2 Нифай 2:27; С ба Г 88:86-г үз).

Иаков 2

Гутаан доромжлох (ш.7)—
Хүндэтгэлтэй бишээр
ашиглах

Бусдыг алагчлах (ш.1, 9)—
Зарим хүмүүсийг бусдаас
ялгаварлах

Яллагдах (ш.9)—Яллагдах
буюу шийтгэгдэх

Дутагдах (ш.15)—Гачигдах
Ажиллаж байсан (ш.22)—
Хамтдаа хөдөлмөрлөж
байсан

Тооцогдсон (ш.23)—
Тооцогдсон

Иаков 2:1—“Бидний Эзэнд Итгэх Итгэлгүй Юу”?

Иосеф Смитийн Орчуулга нь энэ хэлц үгийг бусдыг алагчилснаар та нар Есүс Христэд итгэлтэй байж чадахгүй гэжээ (ИСО, Иаков 2:1-ийг үз).

Судруудыг Судлах нь



Иаков 1–2-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Төгс Эзэмших Судар—Иаков 1:5–6

Иосеф Смитийг Иаковын номноос уншихад тэрээр дөнгөж арван дөрвөн настай байсан бөгөөд шашны талаар төөрөлдөж учраа олохыг болиод байжээ.

1. Иаков 1:5–8-ыг уншиж, Бурханаас чиглүүлэл эрэхэд тань та нарыг урамшуулан дэмжих үгс буюу өгүүлбэрүүдийг бич.

2. Иосеф Смит—Түүх 1:10–13 дахь Иосеф Смитийн туршлагын тухай унш. Туршлагаа хөгжүүлснээр, түүнчлэн Бурханаас мэргэн ухааныг гуйснаар та нар тусламж хүлээн авч болох нөхцөл байдлыг дүрсэл.



Б Ариун Ёслолд Зориулсан Яриа Бич

Ариун ёслолын цуглаан дээр үг хэлэхийг өөрсдөөс тань хүсчээ гэж бод. Иаков 1:12–16, 22–27-гоос мэдсэн зүйлээ ашиглан, залуу хүмүүс сайн мэдээгээр хэрхэн илүүтэй амьдрах тухай таван минутын яриа төлөвлө.



Иаков 1:23

В Төгс Эзэмших Судар—Иаков 2:17–18

Итгэл бол аврагдахад шаардлагатай бүх зүйл бөгөөд сайн үйлс шаардлагатай бус гэж зарим шашин заадаг. Иаков үүнээс өөрөөр заадаг байв. Доорх захидлыг уншаад, Иаков 2:14–16 дахь мэдээллийг ашиглан хариу бич.

Хүндэт Найз аа,

Чи Есүсийг Аврагчаа хэмээн хүлээн аваагүй учраас чи бол Христэд итгэгч биш гэдгээс би айдаг. Зөв шударга үйлс бүтээхийн хамт Бурханаар хүлээн авагдахын тулд итгэлтэй байх хэрэгтэй гэдэгт чи итгэдэг. Чи хууртагдаж байна! Хэрэв чи итгэлтэй байж итгэдэг бол үйлс шаардлагагүй. Христийн ач ивээл үйлсийг сайхан болгодог, гэвч энэ нь шаардлагатай бус. Алдаанаасаа эргэж,

Христийг хүлээн ав, харин өөрийг аврахын тулд үйлстээ бүү итгэл найдвар тавь. Зөвхөн тэгэхэд л чамд амар амгалан байж чадна.

Өөр сүмийн найз чинь.

Иаков 3

Хэлийг Номхруулах нь

Хэн нэгэн хүн өөрсдөд тань, эсвэл өөрсдийн тань тухай ямар нэг зүйл хэлснээс болж та нар хэзээ нэгэн цагт ихэд гомдож байсан уу? Хэн нь илүү гомдсон гэж та нар боддог вэ—та нар үү, эсвэл үүнийг хэлсэн хүн үү? Иаковын захидлын заадаг үндсэн зүйл бол хэл яриагаа хянах хэрэгцээ юм (Иаков 1:19, 26; 3:10). Иаков 3-ыг уншихдаа, биднийг төгөлдөржилтөөс хол байлгадаг юуг, яагаад бид хэлдгийг олж тогтоохыг хичээ.

Судруудыг Ойлгох нь



Иаков 3

Залуур (ш.4)—Жолоо

Хүссэн (ш.4)—Хүсэх, явахыг хүсэх

Түймэрддэг (ш.5)—Шатаадаг

Бүх биеийг бузарладаг (ш.6)—Устгаж, бузар болгодог

Адил байдлаар (ш.9)—

Дүр төрхөөр



Ухаалаг (ш.13)—Мэдлэг туршлагатай

Биеэ авч явах (ш.13)—

Биеэ авч явах

Төрөлхийнх (ш.15)—

Тачаангуй



Морины аманд зохих ёсоор байрласан жижигхэн амгай хүчирхэг морийг залж чаддаг. Үүнтэй адилхан, жижигхэн залуур асар том хөлөг онгоцыг чиглүүлэх буюу залж чаддаг.

Судруудыг Судлах нь



Иаков 3-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий

А Хэлээ Номхруул

Бидний хэлж байгаа юм чухал байдаг. Энэ бол бидний зүрх сэтгэлийн цонх юм. Цэвэр ариун санаа бодол хийгээд сайн мэдрэмжүүдээс найрсаг, өргөн дээдэлсэн үгс гардаг; хилэнцэт санаа бодлууд хийгээд муу муухай мэдрэмжүүдээс хилэнцэт хийгээд хортой үгс гардаг. Иаков 3:1–13-ыг уншиж, бид хэлж байгаа зүйлээ хянах тухайд өөр өөр санааг тусгасан, наад зах нь гурван өгүүлбэрийг жагсаа.

Иаков 4–5

Өөрийнхөө Амьдрал Дахь Хилэнцийг Даван Туулах нь

Бурханы хүсэлд захирагдахын ач холбогдол болон сүнсний хөгжилтийг эд баялаг хэрхэн хязгаарлаж болохыг ойлгох зэрэг өдөр тутмын амьдралын практик зөвлөгөө Иаков өгдөг байв. Түүний зөвлөгөө үүнийг тэрээр анх бичиж байсан үеийнх шигээ өнөөдөр ч гэсэн чухал юм. Иаков 4–5 дахь олон санаануудаас, Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөгөөр амьдрахыг хичээн чармайхад өөрсдөд тань хамгийн ихээр туслах санаануудыг ажигла.

Судруудыг Ойлгох нь



Иаков 4

Дайсагнал (ш.4)—Эсэргүүцсэн, эсрэг хандсан, үзэн ядалт

Атаархан хүсдэг (ш.5)—Атаархаг хүсэлтэй байдаг

Ойртоно (ш.8)—Ойрхон байна

Уйтгар гуниг (ш.9)—Гуниглал, уйтгар

Уур манан (ш.14)—Манан

Иаков 5

Түмэн Цэргийн (ш.4)—Олны, түмний

Баян тансаг (ш.5)—Тансаг амьдралд үрэн таран хийдэг

Тариачин (ш.7)—Цэцэрлэгч, фермчин

Гомдолло (ш.9)—Гомдол гарга

Үр нөлөөтэй (ш.16)—Нөлөөтэй, үр дүнтэй

Судруудыг Судлах нь

Иаков 4–5-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудыг хий.

А Жор Бич

Өөрсдийгөө эмч гэж бод. Иаков 4:1–4-ийг уншиж, “дэлхийтэй нөхөрлөх” гэж нэрлэгддэг өвчнөөс болж хохирдог хүмүүст илэрдэг дөрвөн шинж тэмдгийг тогтоо. Одоо та нар сүнсний өвчнийг оношилсон болохоор, Иаков 4:7–12-ыг уншиж, “дэлхийтэй нөхөрлөхийг” даван туулж, Бурханы найз болон эдгэрэхэд нь хүмүүст туслах жорыг бич.

Б Санваарын Адислалыг Дүрсэл

Ахлагч Нил А.Максвелл дараах түүхийг ярьсан юм:

“Эмэгтэй дүүгээ өвчтэй байхад би амьдралдаа анх удаа Сүнсний гэрчлэлийг мэдэрч билээ. Тэр зургаан долоо хоногтой байхдаа татдаг ханиад хүрч, үхлүүт хэвтэж байлаа. Би арван дөрөв орчим настай байв. Би Автобусны Грейхаунд Депот Компанид механикч байлаа. Би өглөөний

гурван цагт гэртээ ирээд, гэрлүүд асаатай байгааг харав. Би дүүгээ өвчтэй байсныг мэдэж байсан болохоор, ‘нэг л базаахгүй юм болж дээ’ гэж өөртөө хэлж билээ. Тэгээд намайг дотогшоо ороход, тэр хоолны өрөөний дугуй ширээн дээр, амьсгалахгүй хэвтэж байлаа.

“Антибиотик эм байсангүй. Шинэ Гэрээний жаягаар, санваарын хүчээр түүнийг адисалж байгаа аавыгаа би харлаа, бас тэгээд дүү маань дахин амьсгалж эхлэхийг харсан юм. Тэгэхэд би санваарын хүч бодитойг мэдсэн билээ” (“PBS Interview Studies Effect of God in Life,” *Church News*, 1996 оны 8-р сарын 31, 4).



1. Иаков 5:14–16-г уншсаны дараа, санваарын адислал гэж юу болохыг дүрсэл.
2. Өөрсдийнхөө амьдралд санваарын адислал хүлээж авсан буюу үүнийг гэрчилсэн үеийн тухай товч бич.

Петрийн Анхны Нийтлэг Захидал

Есүс Христийн Төлөөлөгч Петр

Есүс Христийг хөнөөсний болон амилуулагдсаны дараа Петр Сүмийн ерөнхийлөгч байлаа. Тэрбээр ерөнхий Төлөөлөгчийн хувиар яг өнөөдрийн манай бошиглогч лугаа удирдлагаар хангаж байжээ. Түүний амьдралын төгсгөлийг ойртож байхад Ромын эзэнт гүрний мөрдлөг хавчлага ширүүсч, Христэд итгэгчийн амь насанд улам илүү аюул заналхийлэх болов. Сүмийн итгэлтэй гишүүдээс олон нь итгэлийнхээ улмаас цаазаар авахуулжээ. Петр Гэгээнтнүүдийг гай зовлонд нь урамшуулан дэмжиж, тэдний итгэлийн учир мөнхийн шагнал хүлээж буйг тэдэнд сануулахын тулд энэ захидлыг бичжээ (1 Петр 4:12–13-ыг үз).

1 Петрийн Зарим Өвөрмөц Сэдвүүд

Бошиглогч Иосеф Смит, “Петр бүх бошиглогчдын алинаас нь ч илүү гаргуун хэлээр үзэглэжээ” хэмээн хэлжээ (*History of the Church*, 5:392). Есүс Христийн урьдчилсан томилогчдын тухай Петрийн гэрчлэл энэ захидалд орсон нь, Гэгээнтнүүд бол Бурханы “онцгой хүмүүс” гэдэгт тэрээр итгэлтэй байсны нотолгоо бөгөөд Библи дэх хамгийн илчлэгч зарим нотолгоонууд нас барагсдын авралын тухай байдаг.

1 Петр 1–2

Есүс Христ, Урьдчилан Томилогдсон Гэтэлгэгч

Аврагч Цовдлолтынхоо өмнө, “Чи нэгэн цагт дахин эргэж, ах дүүсээ батжуул” гэж Петрт хэлжээ (Лук 22:32). 1 Петр 1–2-ыг уншихдаа Есүс Христийн тухай Петрийн гэрчлэлийг эрж олон, тэрээр Их Эзэний зарлигийг хэрэгжүүлж, Гэгээнтнүүдийг хэрхэн урамшуулан дэмжиж, бэхжүүлж байсныг ажигла. Түүнчлэн “Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхэд эдгээр заасан зүйлүүд намайг хэрхэн бэхжүүлж чадах вэ?” гэдгийг өөрсдөөсөө асуу.

Судруудыг Ойлгох нь



1 Петр 1

Сонгогдох (ш.2)—Итгэл хийгээд дуулгавартай байдлынхаа улмаас Бурханаар сонгогдох

Ариусгал (ш.2)—Цагаатгалаар дамжуулан цэвэр ариун болох үйл явц

Нигүүлсэл (ш.2, 10, 13)—Бурханы ач ивээл хийгээд хайраар дамжин өгөгддөг бурханлиг тусламж буюу хүч чадал

Бузартаагүй, алга болчихгүй ов (ш.4)—Мөнхийн аврал

Элдвийн (ш.6)—Янз бүрийн

Бэлтгэж (ш.13)—Бэлэн байх, бэлтгэлтэй байх

Урьдаас мэдэгдсэн (ш.20)—Мөнх бус байдал дахь дуудлагын тулд мөнх бус байдлын өмнөх амьдралд бэлтгэгдсэн

Чин сэтгэлээс (ш.22)—Чин үнэнээсээ

1 Петр 2

Өс хонзон (ш.1)—Хорлох хүсэл

Заль мэх (ш.1)—Хуурах, залилах

Муу муухайг далдлах халхавч (ш.16)—Хилэнцэт бодол санаагаа нуух

Шируун нударгад өртөх (ш.20)—Нүдүүлсэн, сийчүүлсэн

Зүхэх (ш.23)—Загнах, буруушаах, гомдоох

1 Петр 2:2—“Сгийн Цэвэр Сүүг Хүс”

Нялх хүүхдүүд сүүг амархан шингээж чаддаг, тэгээд энэ нь зохих ёсоор өсөхөд тэдэнд тусалдаг. Үүн лугаа, сайн мэдээний зарчмууд нь итгэлээрээ нялх хүмүүст сайн мэдээнд өсөхөд нь тусалж чадна. Петрийн адилтгал 1 Коринт 3:2 дахь Паулынхтай төстэй юм.

1 Петр 2:4–8—Бүх “Чулуунууд” Юунд Хамаатай вэ?

Есүс Христийн Сүмийг Петр “сүнсний өргөөтэй” зүйрлүүлсэн байдаг (1 Петр 2:5). “Амьд чулуу” болох Есүс Христ (ш.4), сүнсний энэ өргөөний “булангийн гол чулуу” болгогдсон юм (ш.6). Тэр бол бас “барилгачдын голсон чулуу” юм (ш.7), энэ нь Есүс Христ Иудейчүүдээр эсэргүүцэгдсэнийг хэлж байна. Энэхүү эсэргүүцлийг эс хайхран, Есүс Христ “тэрхүү булангийн тэргүүн” болсныг Петр гэрчилжээ (ш.7). Тэр бол бид дээр нь барих ёстой “хад” юм (1 Хиламан 5:12-ыг үз).

Судруудыг Судлах нь



1 Петр 1–2-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий

А Ажлын Тодорхойлолт Бич

1 Петр 1:1–16-д Петр Сүмийн гишүүдийг тэд өөрсдөө хэн бэ гэдгийг танин мэдэхэд нь, түүнчлэн мөнх бус байдлын өмнөх амьдралд өөрсдийн хүлээн авсан үүрэг хариуцлагуудаа хэрэгжүүлэхэд нь тэднийг урамшуулан дэмжжээ.

Шүлэг 2–5, 6–9 болон 13–16-г уншиж, дараа нь энэ амьдралд Гэгээнтнүүдээс Бурхан хүсэн хүлээдэг нэг ажлын тодорхойлолт бич. Ажлын тодорхойлолт нь даалгасан ажил үүргийг хэрэгжүүлэхийн тулд хүн юу хийх ёстойг энгийн үгсээр тайлбарласан байна.

Б Судрын Сгсийн Толь Бичиг Хий

1. 1 Петр 2:9–10-ыг уншиж, дараах холбоо үг тус бүрт Библийн Толь Бичгийн тайлбар бич: сонгогдсон үеийнхэн, хаан санваар, ариун үндэстэн, онцгой хүмүүс.

Жинхэнэ толь бичиг дэх үгстэй адилхан өөрсдийн тодорхойлолтууд хийхийг хичээ.

2. Ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смит, “Тэгээнтнүүд бол онцгой хүмүүс юм. Энэ нь тэдний дадал заншил болоод шашных нь итгэл аль алиных нь хувьд үнэн юм. Хэрэв тэд итгэлдээ үнэнч юм бол, бусад хүмүүсээс өөр байхаас аргагүй. Шашин нь үүнийг тэднээс шаарддаг” гэж сургажээ (*Doctrines of Salvation*, 1:234). Энэ нотолгоо хэрхэн үнэн болохыг харуулсан нөхцөл байдлын тухай бич.



“Та нар бол . . . хаант тахилч нар”

В Жагсаалт Хий

Петр өөрийн үед Гэгээнтнүүдийг Есүс Христэд итгэж, “түүний мөрөөр дагахыг” (1 Петр 2:21) хүсдэг байв. 1 Петр 2:11–13, 21–25-ыг уншиж, Аврагчийг дагахад шаардлагатай алхмуудыг нэрлэ. Амьдралд тань аль нь хамгийн их хэрэгтэй талаар бод.

1 Петр 3–5

Нас Барагсдыг Гэтэлгэх нь

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Давид Б.Хейт, “Хожмын Үеийн Гэгээнтнүүд бол сонгогдсон хүмүүс юм, тийнхүү, амьд байгаа хүмүүс хийгээд нас барагсдын авралын төлөө Их Эзэнтэй хамтрагчид байхын тулд мөнх бус байдлын өмнөх дэлхийд томилогдсон юм. Сүмийн, түүнчлэн үүнээс үүдэн үүний гишүүдийн үндсэн үүрэг хариуцлагуудын нэг бол нас барагсдыг гэтэлгэх явдал мөн хэмээн Тэргүүн Зөвлөл мэдэгдсэн билээ” гэж хэлжээ (in Conference Report, 1990 оны 10-р сар, 74; Ensign, 1990 оны 11-р сар, 59). 1 Петр 3–5-ыг уншихдаа сайн мэдээний энэхүү чухал үүрэг хариуцлагын талаарх Петрийн заасан зүйлүүдийг эрж ол.

Судруудыг Ойлгох нь



1 Петр 3

Захирагд (ш.1)—Дага, дуул- гавартай бай, захирагд

Үс сүлжилт (ш.3)—Үс сүлжих

Биеэ авч явах байдал (ш.1–2, 16)—Биеэ авч явах

Доромжлол (ш.9)—Хараал, зүхэл, шүүмжлэл

Зөвт нь зөвт бус хүмүүсийн оронд (ш.18)—Нүгэл үйлч- дэгчдийн төлөөх Аврагч

1 Петр 3:18–20; 4:6—Сүнсний Дэлхий дэх Есү Христийн Номлол

1918 оны Аравдугаар сарын 3-нд Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит 1 Петрийн эдгээр шүлгүүдийг бясалган сууж байжээ. Түүний ойлголтын мэлмий нээгдэж, тэгээд тэрээр нас барсан олныг харж, нас барсан хүмүүст сайн мэдээ хэрхэн номлогддог нь түүнд үзүүлэгдсэн ажээ. Тэрхүү үзэгдлийн тухай түүний шастир Сургаал ба Гэрээний хэсэг 138-д байдаг. Их Эзэний цогцос булшинд байсан тэр хооронд Тэрээр сүнсний дэлхийд айлчилсныг энэ хэсэг бидэнд өгүүлдэг. Тэрээр зөв шударга сүнснүүдийг Өөрийнхөө эргэн тойронд цуглуулж, тэднийг номлолын хүч болгон зохион байгуулсан байлаа. Тэд шорон дахь сүнснүүдэд сайн мэдээг заах үүрэг хүлээн авсан байлаа.

Ариун сүмүүдэд бидний хийдэг ажил сүнсний дэлхийд сайн мэдээг хүлээн авдаг хүмүүст зориулсан шаардлагатай ёслолуудаар хангадаг. Ийм замаар Тэнгэрлэг Эцэгийн бүх хүүхдүүд сайн мэдээг хүлээн авч, зайлшгүй шаардлагатай аврагч ёслолуудыг хүлээж авах боломжтой байдаг.



1 Петр 4

Тачаал (ш.3)—Захирагдашгүй дур хүсэл, тачаангуй хүсэл

Архидалт (ш.3)—Уун сог- туурах, наргих, тачаангуй байх

Ёс бусын шүтээнд мөргөх (ш.3)—Хиймэл шүтээнүү- дийг зүй бусаар шүтэх

Бурханы үг (ш.11)—Бурханы өмнөөс ярьдаг хүн (бошиг- логчид)

Зүхэгдэх (ш.14)—Буруутгах, зэмлэх, шүүмжлэх

1 Петр 5

Албадлагаар (ш.2)—Хүчээр, шахалтаар, айлган сүрдүү- лэлтээр

Хомхой ашгийн төлөө (ш.2)—Ашиг буюу мөнгө олохын төлөө

Даалгасан хүмүүс (ш.3)—Хувь зохиолоор ирсэн зүйл, өв

Түүнийг эсэргүүц (ш.9)—Байснаараа түүнийг эсэргүүц

Вавилон (ш.13)—Ромыг зүйрлэжээ

Марк (ш.13)—Сайн мэдээ- ний нэг зохиогч, Марк

Судруудыг Судлах нь



1 Петр 3–5-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Харьцуулалт Хий

Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга, “Тэнгэрийн загвараар эцэг нь өрх гэрээ хайр болон зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр нь хангаж гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайрлан өсгөн хүмүүжүүлэх явдал мөн. Энэхүү нандин үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгш туслах ёстойг” тунхагласан билээ (“Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг,” Ensign, 1995 оны 11-р сар, 102).

1 Петр 3:1–12-ыг уншиж, дээрх нотолгоонд хамаарах гурван зарчмыг тогтоо. Тэдгээрийг тэмдэглэлийнхээ дэвтэрт бич. Энэ үйл ажиллагаанаас юу сурснаа, түүнчлэн энэ нь танай гэр бүлд хэрхэн холбогдож болохыг эцэг эхтэйгээ ярилцаж болно.



Б Сүнсний Дэлхийн Тухай Найздаа Заа

Саяхан Сүмд нэгдсэн найз тань сайн мэдээг сонсох, мөн баптисм хүртэх боломж олдоогүй, нас барсан төрөл төрөгсдийнхөө талаар санаа нь зовдог гэж төсөөлөн бод. 1 Петр 3:18–20 болон 4:6; Сургаал ба Гэрээ 138:18–20, 27, 30–32, 57–59-ийг уншиж, ишлэлүүдийг харьцуул. Найздаа юу зааж болох талаар ерөнхий загвар гаргаж тэмдэглэлийнхээ дэвтэрт бич.

В Хүнсний Жагсаалт Хий

“Миний хонинуудыг тэжээ” гэсэн нь ямар утгатай вэ?

1. Иохан 21:15–19-ийг уншиж, амилуулагдсан Их Эзэн юу хийхийг Петрээс хүссэнийг бич. Дараа нь 1 Петр 5:1–4-ийг уншиж, Петр өөрийнхөө үед санваарын удирдагчдаас юу хийхийг хүссэнийг бич. Энэ нь Петрийн дуулгавартай байдлын талаар юу заадаг вэ?
2. 1 Петр 5:5–9-ийг уншиж, Бурханы сүргийг тэжээхэд хэрэгтэй сүнсний хүнс тэжээлийн жагсаалт хий.

Петрийн Хоёр Дахь Нийтлэг Захидал

2 Петрийн Захиас Юу вэ?

Өөрийгөө удахгүй үхэх болсныг мэдэж байсны улмаас (2 Петр 1:14-ийг үз), мөн зарим хүмүүс худал хуурмаг зүйлүүдийг зааж, үнэнийг сөрөн эсэргүүцэж байгааг мэдэж байсан учраас (2 Петр 3:16-г үз), Петр энэ захидлыг энгийн бөгөөд шууд шулуун байдлаар бичжээ. Сайн мэдээний мөнхийн ач холбогдлыг Петр мэдэж, тийнхүү итгэлтэйгээр тэсэхийг Гэгээнтнүүдээс хүсч байлаа. Бид өөрсдийн Их Эзэн Есүс Христийн тухай мэдлэгийг хэрхэн олж авах тухай энэ захидал нэн тодорхой тайлбарладаг.

2 Петр дэх Петрийн үгс “сүнсний агуу байдал хийгээд алдар суугийн зэрэглэлүүдийн тухай Үзэгдэл дэх ойлголт болон Их Эзэний Өөрийнх нь номлолд байр суурь эзэлдэг” гэж Ахлагч Брус Р.МакКонки бичжээ (*Doctrinal New Testament Commentary*, 3:325).

2 Петрийн Гол Санаа Амархан


Сайн мэдээний нэг зорилго бол Есүс Христийн бурханлиг мөн чанараас бид хуваалцаж чадахын тулд нүглийг даван туулахад бидэнд туслах явдал мөн. Энэ зарчим 2 Петрт тодорхой заагддаг. Бүлэг 1 нь бид Их Эзэний тухай мэдлэгт хэрхэн ирж болох хийгээд Түүний бурханлиг мөн чанараас хэрхэн хуваалцахыг заадаг. Бүлэг 2 нь Христийн тухай үнэн мэдлэгийг урвагчдын дэлгэрүүлж байгаа хуурамч сургаалуудад сөргүүлэн тавьсан байдаг. Бүлэг 3 нь Их Эзэний тухай үнэн мэдлэгийн авчирдаг найдвар—дэлхийд эргэж ирэх Түүний алдар суут ирэлтийн тухай амлалтад анхаарал хандуулдаг.

2 Петр 1–3

Бурханлиг Мөн Чанараас Хүртэхүй

Бурханлиг чанар өөд дэвшил хийхийг шатаар өөд өгсөхтэй зүйрлүүлж болно (жишээ нь, Эхлэл 28:12–17-г үз). Их Эзэний тусламжтайгаар бид “бурханлиг мөн чанараас хуваалцагчид” (2 Петр 1:4) байхын тулд өөрчлөлт хийж, өсч хөгжих ёстой. Гэсэн хэдий ч, зарим хүмүүс сэлэстиэл хаант улс уруу хөтлөхгүй, өөр замыг дагахаар амьдралдаа сонгож авдаг. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн Ахлагч Брус Р.МакКонки ийм хүмүүсийг “мэдлэгийнхээ шатаар авирахдаа, зөвхөн буруу хананд налсныг нь олдог” хэмээн дүрсэлжээ (in Conference Report, 1984 оны 10-р сар, 37; Ensign, 1984 оны 11-р сар, 30). 2 Петрийг уншихдаа, дагахыг нь биднээс Их Эзэн хүссэн алхмуудыг, мөн биднийг буруу замаар удирдаж болох хуурамч багш нараас өөрсдийгөө хэрхэн хамгаалахыг эрж ол.

Бурханлиг Мөн Чанар



Зүтгэлтэй хийгээд Итгэлтэй Гишүүд

Судруудыг Ойлгох нь



2 Петр 1

Бурханлиг (ш.3–4)—
Бурханлиг

Хамаатай (ш.3)—Хамаарах

Үр жимс үгүй (ш.8)—
Хоосон

Цэвэршсэн (ш.9)—Цэвэр
болсон

Асар дотор (ш.13)—Амьд
сэрүүн, энэ биендээ

Ухаалгаар зохиогдсон
үлгэр домгууд (ш.16)—
Хүмүүсийг хуурахын тулд
ухаалгаар зохиогдсон хуу-
рамч түүхүүд

2 Петр 1:10—“Дуудлагаа Гүйцэтгэж, Сонгогдсоноо Бататга”

Ахлагч Брус Р.МакКонки, “Хүн дуудлагатай байж, сонгогдсоноо бататгана гэдэг нь мөнх амьдралд лацдагдана гэсэн үг; энэ бол сэлэстийл дэлхийн хамгийн дээд тэнгэрт өргөмжлөгдөх аливаа болзолгүй баталгаатай байна гэсэн үг; энэ бол бурханлиг мөн чанарын баталгааг хүлээн авна гэсэн үг мөн” гэж сургажээ (*Doctrinal New Testament Commentary*, 3:330). Үүнийг бас “илүү баттай болгогдсон эш үзүүлэгчийн үгтэй” зүйрлүүлж болно (2 Петр 1:19).

2 Петр 2

Нууцаар (ш.1)—Сэмхэн,
нууж

Хөнөөлт тэрс үзэл (ш.1)—
Авралыг биш, гагцхүү устга-
лыг авчирдаг хуурамч сур-
гаалууд

Тачаангуй (ш.2)—
Хортойгоор, устгалын
байдлаар

Худал хуурамга (ш.3)—
Хуурамч, буруу

Нүгэл үйлдсэн тэнгэр
элч нар (ш.4)—Мөнх бус

байдлын өмнөх амьдралд
Сатаныг дагалдагчид
(С ба Г 29:36–38-ыг үз)

Эрэмгий (ш.10)—Гүжирмэг
хийгээд бардам

Тогтворгүй сэтгэлтнүүд
(ш.14)—Сул дорой хүмүү-
сийг мэхлэх

Тачаал (ш.18)—Тачаадал

Шаварт буцаж хөлбөрдөг
(ш.22)—Шавар дотор хөрвөх

2 Петр 2:21—“Зөвт Байдлын Замыг Мэдэхгүй Байх нь” Сүнээс Нүүр Буруулан Эргэснээс Дээр

Үнэнийг мэдсэний дараа нүгэл үйлддэг хүмүүс, мэдэхгүйгээр нүгэл үйлддэг хүмүүсээс илүү их хариуцлага хүлээдэг (Сургаал ба Гэрээ 82:3-ыг мөн үз).

2 Петр 3

Элэглэн дооглогчид
(ш.3)—Ямар нэг юмыг шоо-
логчид

Түргэлүүл (ш.12)—Ямар нэг
зүйлийг ихэд хүсэх

Мушгин гуйвуулах
(ш.16)—Утгыг гуйвуулж,
өөрчлөх

2 Петр 3:3–9—Хоёр дахь Ирэлтэд Итгэдэггүй Хүмүүсийн тухай Петр Ярьсан нь

Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд итгэх нь Бүтээлтэд итгэ-
хийн адил хялбархан юм гэж Петр хэлжээ. Энэ бол дэлхий
үерээр устгагдсаны адил галаар устгагдахтай адил юм.
Бурханы зорилгууд гүйцэлдтэл урт удаан хугацаа байгаа
юм шиг бидэнд санагддаг хэдий ч энэ нь Түүний хувьд бол
тун богинохон хугацаа юм.



Судруудыг Судлах нь



2 Петр 1–3-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Христийн Адил Байх Чанаруудын Жагсаалт Хий

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон, “Петрийн тодорхойлсон ариун журмууд [2 Петр 1:5–7-д] бол бурханлиг чанар буюу Аврагчийн зан төлөв юм. Хэрэв бид Түүнтэй илүү адилхан байхыг хүсэх аваас, эдгээр ариун журмуудыг бид баримтлах [дагах] ёстой” гэж хэлжээ (in Conference Report, 1986 оны 10-р сар, 59; *Ensign*, 1986 оны 11-р сар, 45).

- 2 Петр 1:5–7-г уншиж, Петрийн дурьдсан чанаруудыг жагсаа.
- Эдгээр чанаруудыг эзэмших нь шатаар өгсөхтэй илүү адилхан гэж та нар боддог уу (нэг удаа нэг л алхам ахих), эсвэл үгийн сүлжээ бодохын адил (чанар бүрийг таамгаар)? Яагаад?
- 2 Петр 1:8–12-ыг уншиж, эдгээр шинж чанаруудыг хүлээж авсан хүмүүст ирдэг адислалуудаас хэдийг жагсаа.

Б Хамгаалагдсан уу, Эсвэл Хэлтрүүлэгдсэн үү?

2 Петр 2:1–9-д хоёр чухал сургаал байдаг. Нэг нь хуурамч багш нар хамгаалагдахгүй, гэдэг нь тэд хамгаалалтгүй байх болно гэсэн утгатай. Нөгөөх нь зөв шударга Гэгээнтнүүд хэлтрүүлэгдэх болно гэсэн сургаал. Эдгээр шүлгүүдийг уншиж, хамгаалагдаагүй хүмүүс буюу бүлгүүд наад зах нь гурвыг, мөн хамгаалагдсан буюу ёс бус байдлаас хэлтрүүлэгдсэн хүмүүс гурвыг судруудаас жагсаан бич.

В Найздаа Зөвлөгөө Өг

Есүс Христийн тухай, ялангуяа Түүний Хоёр дахь Ирэлтийн үнэн бодитой талаар өөрсдийнхөө гэрчлэлд эргэлзэж эхэлсэн нэг найз чамд байна гэж бод. Хоёр дахь Ирэлтэд итгэх нь биднийг үнэнээс холдоход хөтлөгдөхөөс хол хөндий байхад бидэнд хэрхэн тусалж чадах тухай бид 2 Петр 3:1–17-д уншдаг. Эдгээр шүлгүүдээс юу мэдсэнээ ашиглан, Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн талаар өөрсдийнхөө мэдэж авсан хамгийн чухал зүйлийн тухай найздаа захиа бич.

Иоханы Гурван Захидал

Иоханы Сайн Мэдээг бичсэн Төлөөлөгч Иохан эдгээр захидлуудыг МЭ 70-100 оны хооронд бичсэн бололтой. Тэр үед Сүм хоёр ноцтой бэрхшээлтэй тулгараад байлаа. Сүмийн гаднах дайснууд гишүүдийг мөрдөн хавчиж, бас Сүмийн доторх хуурамч багш нар удирдагчдыг эсэргүүцэж, олон гишүүдийг урвалтад өөгшүүлж байв. Иохан анхныхаа захидлыг Аврагчийн тухай болон сайн мэдээний үнэний тухай өөрсдийн гэрчлэл болгон бичжээ.

1 Иохан 1–2

“Тэрэлд Алх”

Хүн болгон нүгэл үйлдэж, Бурханы алдар сууд хүрч чадахгүй болдог (1 Иохан 1:8-ыг үз). Цагаатгалаар дамжуулан бид нүглүүдээсээ цэвэршиж, тэнгэрийн адислалуудыг хүлээн авч чадна. Та нар бүтэлгүйтэж болох зарим арга замуудын талаар бодож, нүглүүдээ даван туулж, өдөр бүр “гэрэл дотор явахад” юу тохиолдож болохыг авч үз (1 Иохан 1:7).

Судруудыг Ойлгох нь



1 Иохан 1

Эхнээсээ байсан (ш.1)—Есүс Христ : Тэрхүү амь нь илэрхийлэгдсэн (ш.2)—Есүс Христ махан биед амьдарч байв

1 Иохан 2

Эвлэрүүлэл (ш.2)—Төлөөс хийсэн золиослол : Тосолгоо (ш.27)—Ариун Сүнсний бэлэг

1 Иохан 2:1—“Хэрэв Хэн Нэгэн Хүн Нүгэл Сйлдвэл, Бидэнд Өмгөөлөгч Буй”

Иосеф Смитийн Орчуулга энэ шүлгийг, хэрэв аливаа хүн нүгэл үйлдээд, наманчилсан бол бидэнд Эцэгтэй хамт өмгөөлөгч буй гэж хэлэгдэхээр өөрчилсөн (ИСО, 1 Иохан 2:1-ийг үз).

1 Иохан 2:18–19, 22—Христийг Эсэргүүцэгчид

Иоханы дурьдсан Христийг эсэргүүцэгчид бол Сүмийг орхиж, Есүс Христэд итгэхээ больсон хүмүүс юм.

Судруудыг Судлах нь



1 Иохан 1–2-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Тэр Юу Гэсэн Бэ?



Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон, “Хүн өлсөөгүй байхдаа хоол идэхийг үнэхээр хүсдэггүй шиг, яг үүнчлэн тэрээр өөрсдөд нь Христ юунд хэрэгтэйг мэдэх хүртлээ Христийн авралыг хүсдэггүй. Уналтын сургаал болон бүх хүн төрөлхтөнд үзүүлсэн үүний нөлөөг ойлгож, хүлээн авах хүртлээ нэг ч хүн Христ яагаад өөрсдөд нь хэрэгтэйг зохих ёсоор нь мэддэггүй” гэж

тайлбарлажээ (in Conference Report, 1987 оны 4-р сар, 106; Ensign, 1987 оны 5-р сар, 85).

- 1 Иохан 1-д Иоханы бичсэн зүйл Ерөнхийлөгч Бенсоны нотолгоог хэрхэн дэмжиж байгааг дүрсэлсэн нэг догол мөр бич.
- 1 Иохан 2:1–3 нь яагаад 1 Иохан 1:8, 10-д илэрхийлэгдсэн лугаа, бид бүгдээрээ нүгэл үйлдэгчид гэдгийг ойлгосон хэн нэгнийг хэлсэн байж болох вэ?

1 Иохан 3–5

“Бурханы Хайр”

Бурханы хөвгүүд, охид болох нь Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхэд байхаас өөр юм. Христ болон Түүний сайн мэдээг хүлээж авснаар та нар Бурханы хүү буюу охин болдог (С ба Г 25:1; 45:8-ыг үз). Түүний итгэлтэй хөвгүүд, охид бас зайлиггүй өргөмжлөгдөх болно. Биднийг хайрладаг Тэнгэрлэг Эцэгийн хайрын улмаас эдгээр адислалууд байдаг гэдгийг Иохан тэмдэглэжээ.

Судруудыг Ойлгох нь



1 Иохан 3

Түүний өмнө зүрхээ бататгах болно (ш.19)—Бурханы өмнө итгэлтэйгээр зогсох

1 Иохан 3:15—“Ах Дүүгээ Сээн Яддаг Нэг нь Алуурчин Мөн”

Садар самуун хийгээд завхайрал нь тачаадлын үр жимс байдаг шиг, аллага бол үзэн ядалтын үр дагаврын нэг юм. Хайр хийгээд үзэн ядалтын хоорондох эсрэг тэсрэг чанарыг 1 Иохан 3:16-д харуулжээ. Үзэн ядалтаар дүүрсэн хүмүүс бусдыг хорлохыг эрэлхийлдэг бол, хайраар дүүрсэн хүмүүс, бүр бусад хүмүүс амьд явахын төлөө амиа золиослоход бэлэн байдаг.

1 Иохан 3:18—“Бид Сг Хэлээр Бус, . . . Харин Ажил Сйлс, Снэнээр Хайрлацгаая”

Христийн шавь нар Христийн адилаар бусдыг хайрладаг. Энэ хайрыг зүгээр л хэлэх биш (“үг хэлээр”) харин үйл хөдлөлдөө харуулах ёстой (“ажил үйлс, үнэнд”).

1 Иохан 4

Хүлээн зөвшөөрөх
(ш.2–3)—Гэрчлэх

Илэрхийлэгдсэн (ш.9)—
Харуулагдсан, үзүүлэгдсэн

Эвлэрүүлэл (ш.10)—Төлөх
золиослол

Хөөн зайлуулна (ш.18)—
Зайлуулна

Айдаст ял байдаг (ш.18)—
Айдаст өвдөлт байдаг

1 Иохан 4:7–12—“Бурхан Бол Хайр Мөн”

Ахлагч Брус Р.МакКонки, “Бурхан бол бас итгэл, найдвар, энэрэл, зөв шударга байдал, үнэн, сайн сайхан зүйл, биеэ барих чадвар, тэвчээр даруу байдал гэхчилэн юм. Энэ нь, Бурхан бол бүх ач ивээл хийгээд бурханлиг хамаарал бөгөөд энэ бүхэн түүний биед төгс хийгээд бүрэн дүүрэн байдлаар оршдог” гэж тайлбарлажээ (*Doctrinal New Testament Commentary*, 3:398).

1 Иохан 4:12—“Хэн ч, Хэзээ ч Бурханыг Хараагүй”

Иосеф Смитийн Орчуулга түүнд итгэдэг тэдгээрээс бусад хэн ч, хэзээ ч Бурханыг хараагүй гэж заасан байдаг (ИСО,

1 Иохан 4:12-ыг үз). Энэ бол Иоханы Сайн Мэдээнд цэдэг-лэгдсэн Иоханы гэрчлэлтэй нийцдэг (Иохан 6:46; С ба Г 67:10–12-той харьцуул).



Моше, Стефен хоёр Бурханыг харсан



1 Иохан 5

Түүгээр төрөгсөд (ш.1)—
Тэнгэрлэг Эцэг

Бид юуг ч гуйсан (ш.15)—
Бид гуйсан юмаа хүлээж
авсан

Судруудыг Судлах нь

1 Иохан 3–5-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Та Нар Юу Гэж Боддог Вэ?

1 Иохан 3:16–23; 4:7–21; түүнчлэн 2 Иохан 1:5–6-г унш. Бурхан биднийг хайрладаг хайраа хэрхэн харуулдаг хийгээд Бурханыг хайрладаг хайраа бид хэрхэн харуулж болохыг өгүүлсэн нэг догол мөр бич.

Иоханы Хоёр Дахь Захидал

Иоханы Хоёр Дахь Захидал

Иоханы хоёр дахь захидал Иоханы анхны захидлаас илүү хувь хүний шинжтэй бөгөөд “сонгогдсон хатагтай болон түүний хүүхдүүдэд” хаяглагдсан ажээ. Тэд бодит хүмүүс үү, эсвэл Сүмийн нэг салбар болон үүний гишүүд үү гэдэг нь тодорхой бус юм. Түүний анхны захидлын нэгэн адил, энэ нь сайн мэдээний үнэний тухай Иоханы гэрчлэл юм (1 Иоханы оршлыг үз).

2 Иохан 1

Хуурамч Багш Нараас Болгоомжил

Хуурамч мэхэлж, тэднийг үнэнээс гажуудуулахыг хүсдэг хүмүүсээс болгоомжлохыг Иохан Сүмийн гишүүдийг сэрэмжлүүлжээ. Та нар өнөөдөр ямарваа хуурамч багш нараас болгоомжилдог уу? Ямар нэг хүн буюу элч нь

(мөн түүний захиас) Бурханаас ирсэн гэдгийг та нар хэрхэн мэдэх боломжтой байдаг вэ? 2 Иоханы бичээсүүдээс тусламж эрж хай.

Судруудыг Ойлгох нь



2 Иохан 1

Сонгогдсон (ш.1)—

Сонгогдсон

Гуйж байна (ш.5)—Хүсч байна

Өөрсдийгөө хяна (ш.8)—Хянуур бай

Дотор байдаг (ш.9)—

Үргэлжилдэг

Мэндлэх (ш.10)—Түүнд туслах буюу түүнийг баярлуулах

Иоханы Гурав Дахь Захидал

Иоханы Гурав Дахь Захидал

Төлөөлөгч Иохан энэхүү гурав дахь захидлыг эхний хоёр захидлыг бичсэн мөн тэр үед бичжээ. Энэ захидлын үйл явдал хийгээд зорилго нь 1 Иоханыхтай адил байв (1 Иоханы оршлыг үз). Энэ захидал бол тэр бүс нутагт Иоханы илгээсэн ах нарыг (номлогч нарыг) дэмжсэнийх нь төлөө “нэн хайрт Гайост” талархал илэрхийлэхээр бичсэн ажээ. Түүнчлэн мөнхүү тэр удирдагчдыг хүлээн аваагүйнх нь төлөө Диотрефийг шүүмжлэх боломжийг Иохан ашигласан байв.

3 Иохан 1 Бусдад Тусалж, Тэднийг Хайрла



Танай хэсэг буюу салбарт хамгийн сүүлд шилжиж ирсэн, эсвэл танай бүсэд баптисм хүртсэн гэр бүлийн тухай бод. Гишүүд тэднийг хэрхэн аятай сайхнаар хүлээж авсан бэ? Тэд баяртай байж, хайрыг мэдэрсэн

Судруудыг Судлах нь



2 Иоханыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Дүгнэлт Нотолгоо Бич

Дүгнэлт нотолгоо бол өгүүллэг буюу номны гол санааг дүрсэлсэн нэг буюу хоёр өгүүллэр юм. 2 Иоханыг уншиж, энэ захидалд Иоханы заасан зүйлийн дүгнэлт нотолгоог бич.

байхын тулд та нар юу хийсэн бэ? Бусдад хандах хандлага нь өөр өөр байсан Гайос, Диотреф гэгч хоёр хүний тухай Иохан бичжээ. Эдгээр хүмүүсийн үлгэр жишээнээс та нар юу сурч болох вэ? Бусдад туслахын ач холбогдлын талаар 3 Иохан юу заадаг вэ?

Судруудыг Ойлгох нь



3 Иохан 1

Ахлагч (ш.1)—Төлөөлөгч Иохан

Миний хүүхдүүд (ш.4)—Иоханы зааж, тэргүүлж байсан гишүүд

Чиний хайрын тухай гэрчилсэн (ш.6)—Чиний хайр, нинжин сэтгэлийн тухай ярьсан

Бурханд зохистой байдлаар тэднийг аян замд нь үдэх (ш.6)—Бурхан сайшаадаг байдлаар аялалд нь тэдэнд туслах

Тэргүүн болохыг дурлагч (ш.9)—Өөрийгөө тэргүүнд тавих дуртай

Биднийг балмалд үгсээр зүй бусаар буруутгасан (ш.10)—Худал буруутгасан

Мэнд хүргэж байна (ш.14)—Мэндчилгээ хүргэж байна

Судруудыг Судлах нь



3 Иоханыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Тодорхойлолт Бич

Хүмүүсийн зургийг хэрхэн харагддагаар нь биш, харин хэрхэн ажилладаг дээр нь тулгуурлан зурдаг зураач найз чамд байдаг гэж бод. 3 Иоханыг уншаад, Гайос, Диотреф болон Деметр тус бүр ямархуу хүмүүс байхыг дүрсэлсэн нэг товч догол мөрийг уг зураачид зориулан бичиж, тодорхойлолтуудынхаа шалтгааныг тайлбарла.

Иуда гэж Хэн Байсан бэ?

Иуда бол Иаковын дүү бөгөөд “Их Эзэний дүү нарын” нэг байжээ. Тэрээр Хуучин Гэрээг сайн мэддэг байсан бөгөөд үнэ цэнэтэй сургамжуудыг заахын тулд тэрээр түүхүүд болон жишээнүүдийг үүнээс авч ашигладаг байжээ.

Иуда өөрийн хандаж бичсэн хүмүүсийн дунд түргэн өсч байсан урвалтын аюулд санаа нь зовж байжээ. Зарим хүмүүс тэдний дунд заагдаж байсан хуурамч сургаалуудын тахал мэт аюулыг ухамсарлахгүй байв.

Иуда 1

Өөрсдийнхөө Асуудлуудын Шийдлийг Судруудаас Ол

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон:

“Судруудад байдагчлан, амьд бошиглогчдын үгс, түүнчлэн хувь хүний илчлэл дэх Бурханы үг нь, хилэнцийг эсэргүүцэж, сайныг чанга тэвэрч, энэ амьдралд баяр хөөрийг олохын тулд Гэгээнтнүүдийг хамгаалж, тэднийг Сүнсээр зэвсэглэдэг. . . .

“... Хувь гишүүд болон гэр бүлүүд өөрсдийгөө судруудад тогтмол хийгээд байнга умбуулсан үед үйл ажиллагааны эдгээр бусад салбарууд аяндаа ирдэг. Гэрчлэлүүд өсөн нэмэгдэх болно. Шийдвэр төгс байдал эрч хүчээ авах болно. Гэр бүлүүд хамгаалагдах болно. Хувь хүний илчлэлт урсах болно. . . .

“Зөв шударга байдал дахь амжилт, заль мэхээс зайлсхийх хийгээд уруу таталтыг эсэргүүцэх хүч, бидний өдөр тутмын амьдрал дахь удирдамж, бодгалийг эдгээх нь —эдгээр бүгд нь Түүний үгэнд ирэх хүмүүст Их Эзэний өгсөн амлалтуудаас цөөн хэдхэн нь юм” гэж сургажээ (“The Power of the Word,” Ensign, 1986 оны 5-р сар, 79–82).

Иуда өөрийн хандаж бичсэн хүмүүст туслахын тулд судруудыг хэрхэн ашигласныг эрж ол.

Бурханы нигүүлслийг садар самуун болгон гажуудуулж (ш.4)—Бурхан нигүүлсэнгүйгээр өршөөх учраас бид зарлигуудыг дуулгавартайгаар дагах хэрэггүй; бид чөлөөтэйгөөр нүгэл үйлдэж, өөрсдийгөө тачаадалд өгч болно гэж хэлэх

Орон байраа орхин одсон тэнгэр элчүүд (ш.6)—

Люсиферийг дагахаар сонгосон мөнх бус байдлын өмнөх сүнснүүд

Махан биеийг бузарлах (ш.8)—Махан биеийн дур хүсэлд автагдах

Эрх мэдлийг эсэргүүцэн, тэнгэрлэг сүр жавхланг доромжилдог (ш.8)—Бурханы удирдлагаас татгалзаж, Түүний тухай, Түүний удирдагчдын тухай хилэнцэтийг ярих

Тэрслэлт (ш.11)—Бослого, үгүйсгэл

Хатуу үгс (ш.15)—Хилэнцэт, догшин үгс

Бардам ам (ш.16)—Сагсуурсан, ихэрхэг үгс

Бусдыг галаас суга татан гаргаж ав (ш.23)—Сатан болон түүнийг дагалдагчдын хүчнээс гарахад нь тэдэнд тусал

Махан биеэр бузарлагдсан хувцсыг нь хүртэл жигшин (ш.23)—Нүгэл үйлдэх хүсэлгүй байж

Судруудыг Судлах нь

Иудаг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А буюу Б) нэгийг нь хий.

А Зураг Зур

1. Иуда 1:12–13-т дүрслэгдсэн зүйлүүдийн зургийг зур.
2. Ус байхгүй үүлэнд, жимсгүй модонд, далайн давалгаан дээрх хөөсөнд, тэрчлэн тэнгэрт хэсүүчлэгч одонд юу тохиохыг, Хоёр дахь Ирэлтээр ёс бус хүмүүст тохиох зүйлтэй харьцуул (Иуда 1:5–7, 11, 14–15-ыг тусламж болгон ашигла).

Б Түүхийн Сургамжууд

Хуурамч заалтууд хүмүүсийг нүгэл болон аз жаргалгүй байдал уруу хөтөлдгийг мэдэж байсан бөгөөд үүний хэдэн жишээг өгчээ. Дараах тохиолдол бүрийг шалгаж, эдгээр жишээнүүд нь Иуда 1:12-т дурьдсан бороогүй үүл, үр жимсгүй жимсний модтой хэрхэн адилхан болохыг тайлбарла.

1. Содом, Гоморрын хүмүүс (ш.7–8-ыг үз)
2. Михаилтай маргаж байгаа Сатаны тухай сургаалт зүйрлэл (Адам; ш.9-ийг үз)
3. Каин Бурханаар тохуурхаж, Баалам Бурханаас хүлээн авсан бэлгүүдийн хамт мөнгө авахыг хичээж байв (ш.11-ийг үз)

Судруудыг Ойлгох нь

Иуда 1

Дуудагдсан (ш.1)—Ариусгасан, нүглээс нь цэвэрлэсэн

Төлөө тэмцэх (ш.3)—Хамгаалахын төлөө шаргуу ажиллах, хадгалж байх

Сэм (ш.4)—Нууцаар Урьдаас ял шийтгэлийнх нь тухай бичигдсэн хүмүүс (ш.4)—Ёс бус байдал нь мэдэгдэж байсан хүмүүс

Энэ Илчлэлт Юуны Тухай Байдаг Вэ?

Олон хүмүүс Илчлэлтийн номны талаар бодохдоо эцсийн өдрүүд, араатан амьтад хийгээд бэлэгдлийн хэлээр цэдэглэгдсэн бусад нууцуудын тухай бошиглолуудын талаар шууд боддог. Илчлэлт эдгээр зүйлүүдийг агуулдаг хэдий ч, эхний шүлгүүдэд Төлөөлөгч Иохан цэдэглэсэнчлэн, энэ бол өөрийнхөө үзсэн зүйлийг болон Есүс Христийн тухай гэрчлэх Өөрийн үйлчлэгчид Есүс Христийн өгсөн илчлэлт юм (Илчлэлт 1:1–2-ыг үз). Өөрөөр хэлбэл, Илчлэлтийн номны гол захиас бол судруудын бусад ихэнх номнуудын нэгэн адил—энэ нь Есүс Христийн тухай илчилдэг буюу заадаг бөгөөд биднийг Түүнд ирэхийг урьдаг.

Та нар Илчлэлтийн номыг уншихдаа, Есүс Христийн тухай үүний сургаалуудыг ол. Энэ номон дахь бэлэгдлийн хэл хийгээд дүрслэлүүд нь эхний үед хэцүү юм шиг санагдаж болох хэдий ч, тэдгээр нь Христийн үүрэг зорилго хийгээд Түүний хүчний талаарх ойлголтыг тань гүнзгийрүүлэхийг та нар олж мэдэх болно.

Түүхэн Үндэс



Иохан Эгейн тэнгис дэх Патм арал дээр хоригдол байхдаа энэ илчлэлтийг хүлээн авч бичжээ. Тэр үед Ромын засгийн газар Христэд итгэгчдийг мөрдөн хавчиж, Төлөөлөгчдийн олонх нь итгэлийнхээ улмаас хөнөөгдсөн байлаа. Ромд болон Ромын эзэнт гүрний өөр хаа нэгэнтээ бусад олон гишүүдэд харгис хэрцгийгээр хандаж байв.

Тэр үед Аврагчийн төлөө амь насаа өгөх нь Гэгээнтнүүдийн хувьд нэн бодит боломж байв. Энэ хэцүү бэрх цаг дундуур, яагаад тэд ийм гай зовлон туулах болсныг, түүнчлэн дэлхий дээрх ийм хилэнцэд, ялангуяа Их Эзэний хүмүүсийн эсрэг тусгайлан чиглэсэн ийм хилэнцэд Их Эзэн хэрхэн хариулах тухайд Сүмийн гишүүд гайхширч байсныг төсөөлөхөд хэцүү биш юм. Иоханд өгсөн Их Эзэний энэхүү илчлэлт Бурханы төлөвлөгөөний илүү том, илүү агуу зураглалыг илчилж, энэ амьдралд тохиолддог хилэнцэт нь сайныг мөрдөн хавчиж, гадаад байдлаараа ялж байгааг илүү сайн ойлгоход нь тэр үеийн Гэгээнтнүүдэд тусалжээ. Сайн ба муугийн хоорондох тэмцлийн талаар, түүнчлэн дэлхий дээр чөтгөрийн хүч мөн л урамшуулан дэмжигддэг мэт байдалд манай өнөө үеийн Гэгээнтнүүд гайхширч, Илчлэлтийн номны захиаст найдвар тавьдаг билээ.

Манай Үед

Илчлэлтийн эхний гурван бүлэг Иоханы үе дэх Сүмийн долоон салбарт өгсөн зөвлөгөөг агуулдаг хэдий ч, түүний зөвлөгөө манай өнөө үед ч холбогдож болно. Үзэгдэлд Иоханы харсан зүйлийн олонх нь Есүс Христийн Хоёрдахь Ирэлтийн өмнө Мянганы үед тохиох үйл явдлуудыг төлөөлдөг (1 Нифай 14:14–28-ыг үз). Ийм учраас, өнөө үеийн Гэгээнтнүүд үүний захиасыг бүр ч илүү сонирхох ёстой.

Иоханы Уриалга

Үзэгдэлд юу харснаа тайлбарлахаас өмнө, түүнчлэн өөрсдийн үеийн сүмүүдэд аливаа зөвлөгөө өгөхөөс өмнө Иохан, хэрэв бид “энэхүү бошиглолын үгсийг уншиж, мөн энд бичигдсэн зүйлүүдийг сахих юм бол [дуулгавартай дагах юм бол]” бид адислагдах болно: учир нь цаг ойрхон байна” гэж тэрээр хэлжээ (Илчлэлт 1:3). Илчлэлтийн номыг уншихдаа, сонсож, дуулгавартай дагах талаарх түүний уриалгыг анхааралтай авч үз. Энэ номонд бичигдсэн үйл явдлууд “ойрхон” байгаа үед—тэдгээр нь өнөө үед тохиосон буюу мөд тохиох үед та нар амьдарч байна.

Илчлэлт 1

Есүс Христийн Илчлэлт

Иохан яагаад Патм арал дээр байсныг бид мэдэхгүй, гэвч уг арал ихэвчлэн Ромын шоронгийн хуаран байсныг бид мэддэг. Эхний зууны сүүлчийн хагаст Христэд итгэгчид туйлын ихээр мөрдөгдөн хавчигдаж байжээ. Бурханы үгийн төлөө, мөн Есүс Христийн тухай гэрчлэлийн төлөө Иоханыг өөрийг нь Патм арал уруу очихыг хориглосон байв (Илчлэлт 1:9-ийг үз). Гэсэн хэдий ч, бүр ийм нөхцөлд ч гэсэн Иохан “Их Эзэний өдөрт” (Илчлэлт 1:10) Сүнснийг эрэлхийлж, Илчлэлт 1-д бидний унидаг Есүс Христийн тухай гайхамшигт үзэгдлийг хүлээн авчээ.

Судруудыг Ойлгох нь

Илчлэлт 1

Үзүүлэхийн тулд (ш.1)—
Илчлэх буюу хүргэх

Үхэгсдээс анх төрсөн
(ш.5)—Анх түрүүн амилуу-
лагдах

Ноёрхол (ш.6)—Эрх мэдэл,
захиргаа, захирах

Альфа ба Омега (ш.8, 11)—
Грек цагаан толгойн эхний
болон сүүлчийн үсэг,
Аврагчийн нэг нэр
Гай зовлон (ш.9)—Гай
зовлон, зүдгүүр

Эзэний өдөр (ш.10)—
Христэд итгэгчдийн
Хүндэтгэлийн Өдөр (Ням
гараг), Их Эзэн амилуулагд-
сан долоо хоногийн өдөр

Цээжээрээ бүс бүсэлсэн
(ш.13)—Цээжээрээ бүсэл-
сэн, ороосон
Нүүр нь (ш.16)—Гадаад
төрх, ялангуяа нүүрний
илэрхийлэл

Судруудыг Судлах нь

Илчлэлт 1-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Есүс Христийн Тухай Илчлэлт

Илчлэлт 1-ээс Есүс Христийн тухай юу мэдсэнээ тэмдэглэ-
лийнхээ дэвтэрт жагсаа.

1. Дараах хоёр асуултын нэгэнд хариул: Есүс Христийн
тухай өмнө нь мэдэхгүй байсан ямар зүйлийг та нар
Илчлэлт 1-ээс мэдэж авав уу? Түүний тухай Иоханы бич-
сэн зүйлээс Есүс Христийн тухай та нарт хамгийн их сэт-
гэгдэл төрүүлсэн нь юу вэ?
2. Та нар Илчлэлт 1-ийг уншиж эхлэхдээ эдгээр зүйлүү-
дийг мэдэх нь яагаад чухал гэж боддог вэ?

Б Чухал Бэлэгдлүүдийг Тайлбарлах нь

Илчлэлт 1-д дараах бэлэгдлүүдийг олж, бэлэгдэл бүр юуг
төлөөлдөг хийгээд энэ нь бидэнд юуг заадаг гэж бодлогоо
бич. Илчлэлт 1:20-д Иоханы харсан бэлэгдлүүдийн заримынх
нь утгыг Их Эзэн тайлбарласан байдаг. (Бэлэгдлүүдийг
тайлбарлахад тусламж болгож та нар “Бэлэгдлүүдийн
Хэлбэрүүд болон Утгуудыг Эрж Ол” хэсгийг, х.6-г дахин
уншиж болно.)


- Долоон алтан дэнлүүний суурь (Илчлэлт 1:12–13; 20 мөн
3 Нифай 18:24-ийг үз)
- Аврагчийн цав цагаан гадаад төрх (Илчлэлт 14:14; мөн
Алма 13:24-ийг үз)
- Аврагчийн баруун гар дахь долоон од (Илчлэлт 1:16, 20,
Иосеф Смитийн Орчуулга Илчлэлт 1:20 дахь “тэнгэр
элчүүд” гэсэн үгийг “долоон сүмийн үйлчлэгчид” гэж
сольсныг үз)
- Аврагчийн хэл хоёр талдаа иртэй илдтэй зүйрлэгджээ
(Илчлэлт 1:16; мөн Хиламан 3:29-ийг үз)
- Нэр мэт гэрэлтэх Аврагчийн нүүр (Илчлэлт 1:16; мөн
С ба Г 88:7-г үз)

Илчлэлт 2–3

Сүмийн Долоон Салбарт Зориулсан Зөвлөгөө

Илчлэлт 2–3 нь Иохан өөрийн үед Сүмийн долоон сал-
барт өгсөн зөвлөгөөг агуулдаг. Гэсэн ч, Иохан зүгээр л элч
байсан болохоос, үгс нь Их Эзэний зөвлөгөө юм гэдгийг та
нар ажиглах болно. Манай удирдагчдаар дамжуулан

бидэнд өнөөдөр өгдөг зөвлөгөө шиг, Илчлэлт 2–3 дахь зөв-
лөгөөний зорилго нь Христийн заадаг зүйлүүдийн дагуу
амьдарч, сайн мэдээний адислалуудыг хүлээн авахад нь
гишүүдийг урамшуулан дэмжих явдал байлаа. Эдгээр
бүлгүүдэд өгөгдсөн зөвлөгөө өнөө үед Сүмийн гишүүдэд
хэрхэн холбогдохыг ойлгох нь төдийлөн хэцүү биш юм.
Итгэлтнүүдэд Их Эзэний өгсөн амлалтуудад та нар
анхаарлаа хандуулахыг хүсч болно. Эдгээр амлалтууд
өнөөдөр ч гэсэн үнэн билээ.



Судруудыг Ойлгох нь

Илчлэлт 2

Тэвчих (ш.2)—Эвлэрэх,
хүлцэх, тэвчих

Шалгах (ш.2, 10)—Сорих
(тэдгээр нь үнэн үү гэдгийг
мэдэх гэж)

Тэвчиж (ш.3)—Тэвчиж, тэсч

Николайчууд (ш.6, 15)—
Тодорхой хуурамч заалтуу-
дад итгэдэг хийгээд үхэш-
гүй байдлын зарим үйл хөд-
лөлүүдийг зөвшөөрдөг,
тэрч байтугай үүнд урам-
шуулан дэмжигддэг, гэвч
гадаад байдлаараа нууцаар
ажилладаг бүлэг хүмүүс

Зовлон шаналал (ш.9–10,
22)—Зовлон зүдгүүр

Доромжлогддог (ш.9)—
Ариун зүйлүүдийн талаар
худал буюу хүндэтгэлгүй-
гээр ярих

Хоёр дахь үхэл (ш.11)—Их
Эзэний оршихуйгаас бүрмө-
сөн таслагдах

Чи бат сахьдаг (ш.13, 25)—
Чи итгэлтэй хэвээр байдаг

Алагдсан (ш.13)—
Итгэлийнхээ улмаас алагд-
сан хүн

Төөрөгдүүлэх (ш.20)—
Төөрөгдүүлэх, уруу татах

Шавар сав суулганууд
(ш.27)—Шавар савнууд

Хага цохих (ш.27)—
Хэлтэрхийнүүд болгон
Үүрийн цолмон (ш.28)—
Есүс Христийг хэлж байна
(Илчлэлт 22:16-г үз)

Илчлэлт 2—Иосеф Смитийн Орчуулгаас Гарсан Чухал Өөрчлөлтүүд

Илчлэлт 2:1, 8, 12 болон 18-ын Иосеф Смитийн Орчуулга
тэнгэр элч гэдэг үгийг үйлчлэгчээр сольсон. (Илчлэлт 3-т
мөн адил солигдсон). Илчлэлт 2:22 дахь ор гэдэг үгийг там
гэж Иосеф Смитийн Орчуулга өөрчилсөн. Илчлэлт 2:26–27
дахь Есүсийн удирддаг “төмөр таяг” гэсэн үгийг Бурханы

Үг (1 Нифай 15:23–24-ийг үз) тодруулж өгсөн бөгөөд Тэр шүлэг 27-д гардаг шиг хага цохих мэт биш харин үнэн, зөв шударга болон адил тэнцүү байдлаар удирддаг.

Илчлэлт 2:2, 13, 19 (мөн Илчлэлт 3:1, 8, 15-ыг үз)—“Би Чиний Ажил Сйлсүүдийг Мэднэ”

Тэдний бүхий л ажил хэргүүдийг Тэрээр харж, мөн мэдэж байдгийг Их Эзэн салбар болгонд тодорхой мэдүүлсэн юм. Тэрээр мөн үүнийг ч бидэнд хэлж чадна. Тэрээр бидний бодол санаа, үг хэл, үйл хэргийг мэддэг.

Илчлэлт 2:7, 11, 17, 26 (мөн Илчлэлт 3:5, 12, 21-ийг үз)—“Ялагч Нэгэнд” буюу “Ялдаг Тэр”

Сүмийн салбаруудад өгсөн Их Эзэний амлалтууд өөр өөр үгээр бичигдсэн хэдий ч, тэдгээр нь бүгдээрээ сэлэстиэл хаант улс дахь мөнх амьдрал хийгээд өргөмжлөлд холбогддог. Илчлэлт 2–3-т дүрслэгдсэн өргөмжлөлийн өөр өөр арга замуудыг унших нь ашиг тустай, бас сонирхолтой юм.

- “Амьдралын мод” (Илчлэлт 2:7) нь мөнх амьдралд холбогдоно (Илчлэлт 22:2).
- “Амьдралын титэм” (Илчлэлт 2:10) болон захирах амлалт нь сэлэстиэл хаант улсад захирагч хаад хийгээд санваартнууд болж үүрд захирах адислалд холбогдоно (С ба Г 76:56-г үз).
- Дээрээ шинэ нэртэй цагаан чулуу (Илчлэлт 2:17-г үз) нь гагцхүү сэлэстиэл хаант улсыг олж авдаг хүмүүст өгөгддөг (С ба Г 130:10–11-ийг үз).
- Цагаан хувцсаар хувцаслаж, нэр нь амьдралын номонд бичигдсэн хүмүүс бол цэвэршсэн бөгөөд сэлэстиэл хаант улсыг өвлөсөн хүмүүс юм (С ба Г 88:2-ыг үз).
- Бурханы нэрийг өөрсөд дээрээ бичүүлсэн хүмүүс (Илчлэлт 3:12-ыг үз) бол тэд өөрсдөө бурхад бөгөөд энэ нь өргөмжлөгдсөн хүмүүст амлагдсан адислал юм (С ба Г 76: 58).
- Христтэй хамт Түүний сэнтий дээр залрах (Илчлэлт 3:21-ийг үз) гэдэг нь Түүн шиг байна гэсэн үг. Энэхүү адислал нь гагцхүү сэлэстиэл хаант улсын хамгийн дээд зэрэглэлд өв залгамжилсан хүмүүст өгөгддөг (С ба Г 132: 20-ийг үз).

Өргөмжлөлийн эдгээр амлалтууд, хүмүүс нүгэл үйлддэг замуудыг Их Эзэн тайлбарласны дараа өгөгдсөн нь чухал ач холбогдолтой юм. Их Эзэн нигүүлсэнгүй бөгөөд хэрэв тэд наманчлах юм бол, нүгэл үйлдсэн хүмүүс мөнх амьдралыг олж болно.

Илчлэлт 3

Бат сахь (ш.3, 11)—Итгэлтэй хэвээр үлд

Хиртүүлэх (ш.4)—Цэвэр биш болгох (нүглээр дамжин сүнсний хувьд цэвэр биш болох)

Давидын түлхүүр (ш.11)—Захирах хүч

Амен (ш.14)—“Үнэн нэгэн” гэсэн утгатай, Христэд холбогдох нэр товёог

Хөөрхийлөлтэй (ш.17)—Зовлонтой, зовсон

Нүдний тос (ш.18)—Нүдний эм

Зэмлэдэг, сахилгажуулдаг (ш.19)—Засч залруулах, сахилгажуулах

Зүтгэлтэй (ш.19)—Чин үнэнч, хичээнгүй

Илчлэлт 3:1—“Чи Амьд Нэртэй Боловч Схдэл”

Тухайн үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Спенсер В.Кимбалл: “Өөрсдийгөө амьдарч байгаа гэж боддог хэдий ч, сүнсний зүйлүүдийн хувьд үхдэл болсон олон хүмүүс өнөөдөр энэ Сүмд байна. . . . Тэдний үйлчлэл үгсээр их, харин сүнсээр бага юм” гэж сургажээ (in Conference Report, 1951 оны 4-р сар, 105).

Илчлэлт 3:20—“Би Сүдэн Дээр Зогсоод Тогшиж Байна”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Спенсер В.Кимбалл Илчлэлт 3:20-ийн талаар дараах түүхийг ярьжээ:

“Зураач Холман Хант энэхүү сэтгэл гижигдсэн судрыг ёрог даавуун дээр зурж буулгахаар сүнсээр нөлөөлөгджээ. Нэг өдөр тэрээр ‘Хаалга Тогшиж Байгаа Христ’ нэртэй өөрийн зургийг нэг найддаа үзүүлж байтал найз нь: ‘Чиний зурганд нэг юм буруу байна’ гэж гэнэт дуу алдаж гэнэ.

“ ‘Юу байдаг билээ?’ гэж зураач асууж.

“ ‘Есүсийн тогшиж байгаа хаалга бариулгүй байна шүү дээ’ гэж найз нь хариулж гэнэ.

“ ‘Аа,’ гэж Ноён Хант хариулаад, ‘Энэ чинь алдаа биш. Энэ бол хүмүүний зүрх сэтгэлийн хаалга. Энэ хаалга зөвхөн дотроосоо онгойж болно.’

“Тиймээс ийм байгаа юм. Есүс зогсоод тогшиж болно, харин бид бүхэн нээх эсэхээ шийддэг. Хүнийг хөдөлгөхөөр албадах хүч Сүнсэнд байдаггүй. Санаачлагыг хүн өөрөө л гаргах ёстой” (*The Miracle of Forgiveness* [1969], 212).

Судруудыг Судлах нь

Илчлэлт 2–3-ыг судлахдаа дараах хоёр үйл ажиллагааг (А, Б) хий.

А Унших Зүйлээ Зохион Байгуул

Ази дахь Сүмийн долоон салбар тус бүрт Их Эзэний өгсөн зөвлөгөө загвартай юм. Тэрээр Илчлэлт 1-ээс Өөрийнхөө тухай тодорхойлолтуудын нэгийг давтаад, Өөрсдийнх нь таалалд нийцэх юуг тухайн салбарын гишүүд хийж байсныг тэдэнд ярьж, тэд ямар арга замаар наманчлах хэрэгтэйг Тэрээр тэдэнд өгүүлж, хэрэв тэд итгэлтэй байх юм бол тэдэнд ирж болох адислалуудын талаар тэдэнд ярьдаг байлаа. Доорхтой адил хүснэгтийг тэмдэглэлийнхээ дэвтэрт хийж, Илчлэлт 2–3-т өөрсдсийн олсон мэдээллээр үүнийг бөглө.

Хот	Христийн тухай тодорхойлолт	Тэд Их Эзэний таалалд нийцэх юу хийж байсан бэ	Юуны талаар тэд наманчлах хэрэгтэй байсан бэ	Амлагдсан адислалууд
Ефес (Илчлэлт 2:1–7-г үз)				
Смирна (Илчлэлт 2:8–11-ийг үз)				
Пергам (Илчлэлт 2:12–17-г үз)				
Туатейр (Илчлэлт 2:18–29-ийг үз)				
Сардей (Илчлэлт 3:1–6-г үз)				
Филаделфи (Илчлэлт 3:7–13-ыг үз)				
Лаодик (Илчлэлт 3:14–22-ыг үз)				

А Судруудыг Өөрсдийн Амьдралд Хэрэглэх нь

1. Ази дахь Сүмийн долоон салбарт өгсөн ямар зөвлөгөө өнөөдөр Сүмд хамгийн их холбогдоно гэж та нар боддог вэ? Яагаад?
2. Долоон Сүмд (Илчлэлт 2-ын “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз) Их Эзэний өгсөн амлалтуудаас аль нь мөнх амьдралыг эрэлхийлэхэд та нарт хамгийн ихээр сүнслэг нөлөө үзүүлсэн бэ? Яагаад?

Илчлэлт 4

“Үүний Дараа Тохиолдох Зүйлүүд”

Илчлэлт 4 нь ирээдүйн үйл явдлуудын тухай “үүний дараа тохиолдох зүйлүүдийн” (ш.1) тухай Иоханы үзэгдлээр эхэлдэг. Энэ үзэгдлийн тухай түүний шастир Илчлэлтийн номны үлдсэн хэсгийг бүрдүүлдэг. Хэдийгээр энэ нь зарим талаар Иоханы амьдарч байсан үеэс өмнө тохиосон үйл явдлуудад холбогддог ч гэсэн, үйл явдлууд нь ирээдүйд тохиох зүйлүүдийг илүү сайн заахын тулд үзүүлэгдсэн байлаа.

Илчлэлт 4-т Бурханы хаан сэнтийг тэрээр харсан тухай үзэгдлийг Иохан дүрсэлсэн байдаг. Энэ бүлэг дэх бэлэгдлүүдийн заримынх нь тайлбарыг Бошиглогч Иосеф Смит хүлээн авчээ (С ба Г 77:1–5-ыг үз).

Илчлэлт 5–7

Долоон Тамгатай Ном



Иохан өөрийн үзэгдэлд Бурханы хаан сэнтийг харжээ. Тэр бас долоон тамга дарж лацадсан ном барьж байгаа Бурханыг харжээ (Илчлэлт 5:1-ийг үз). Есүс Христ бол нэг үед Өөрийн лацадсан энэ номыг нээх цорын ганц зохистой нэгэн байлаа. Тэрээр лац бүрийг нээхэд, номын тухайн хэсэгт агуулагддаг зүйлүүдийн үзэгдлийг Иохан харжээ. Илчлэлт 6:1–11 нь эхний таван лацны нээлт тухай өгүүлдэг. Зургаа дахь лацны нээлт нь Илчлэлт 6:12-т эхэлж бүлэг 7-г дуустал үргэлжилдэг. Сургаал ба Гэрээ 77:6–7 нь долоон лац тус бүр нь түүхийн нэг мянган жилийг бэлэгддэгийг бидэнд заадаг. Тийнхүү, лац бүрийг нээгдэхэд Иоханы харсан зүйл нь түүхэн дэх тухай мянган жилийн туршид тохиосон үйл явдлуудыг—эхний лац нь Уналтын дараах анхны мянган жилийг төлөөлдөг байхад, хоёр дахь лац нь хоёр дахь мянган жилийг гэхчлэн цааш төлөөлдөг ажээ.

Судруудыг Ойлгох нь



Илчлэлт 5

Иудагийн овгийн Арслан : Сав (ш.8)—Сав суулга, аяга
 буюу Давидын Үндэс : Утлага (ш.8)—Шатаж бай-
 (ш.5)—Есүс Христ (Эхлэл : гаа хүжний сайхан үнэр
 49:9; Исаиа 11:10)

Илчлэлт 5:1, 5 (мөн Илчлэлт 1:4; 2:1; 8:2)—Долоогийн Тооны Утга Учир Юу Вэ?

Долоогийн тоо Илчлэлтийн номны туршид тохиолддог. Жишээ нь, Иохан Сүмийн долоон салбарт бичжээ (Илчлэлт 5-ыг үз), долоон бүрээчин дэлхий дээрх шүүлтийг зарладаг (Илчлэлт 8–9, 11-ийг үз); түүнчлэн хилэгнэлийн долоон сав дэлхий дээр юүлэгддэг (Илчлэлт 16-г үз). Долоогийн тоо гэсэн утгатай шева гэсэн Еврей үг бүрэн байдал буюу төгөлдөржилтийн санааг төлөөлсөн үг бөгөөд түүний үзэгдлийн тухай Иоханы шастир дахь бэлэгдлийн


хэсэг байж болох юм. Тэрээр долоон сүмд хандан бичсэн нь нийт Сүмд хандан ярьсны бэлэгдэл байж болно.

Илчлэлт 5:1–2, 5 (мөн Илчлэлт 6:1, 3, 5, 7, 9, 12-ыг үз)—Лац

Эрт үед албан баримт бичгүүд, хуйлмал бичгүүд болон цэдгүүдийг, ихэвчлэн үүнийг лацадсан хүн нь хэн болохыг илэрхийлсэн лаван дардсаар битүүмжлэн лацаддаг байжээ. Ийнхүү лацадсан баримт бичгүүдийг зөвхөн эрх мэдэл бүхий хүн гэрчүүдийн дэргэд задалдаг байв. Энэ утгаар, “Бурханы илчлэгдсэн хүсэл, нууцууд хийгээд үйлсүүдийг” (С ба Г 77:6) Иоханы харсан номонд цэдэглэсэн байжээ. Зөвхөн Есүс Христ л энэ номыг нээх эрх мэдэлтэй, мөн зохистой байлаа. Мөн энэ нь мөнх амьдралын хувьд үнэн юм. “Тэр л зөвхөн тэнгэрийн хаалгыг нээж, тэгээд биднийг дотогш оруулна” (“There Is a Green Hill Far Away,” *Hymns*, no. 194; налуу бичлэгийг нэмэв).

Илчлэлт 6

Дэнс (ш.5)—Жинлүүр



Бидний цусны өшөө (ш.10)—Аллагын төлөөх тохирсон шүүх

Хялгасаар хийсэн таар (ш.12)—Эртний Израилд хүмүүс наманчлахыг хүсэх буюу наманчилж байгаагаа харуулахын тулд хар ямааны хялгасаар буюу арьсаар хийсэн хувцас өмсдөг байжээ.

Боол (ш.15)—Боол Уур хилэн (ш.16–17)—Хилэгнэл, уур

Илчлэлт 6:1, 3, 5, 7 (мөн Илчлэлт 4:6–9-ийг үз)—Дөрвөн Амьтан

Дөрвөн амьтан нь өөрсдийн төрөл дотроос хамгийн дээд буюу хамгийн хүчтэй нь—ээрлэг амьтдаас арслан, гэрийн тэжээмэл амьтдын (хүн ашигладаг амьтад) дотроос шар (эсвэл тугал), шувуудын дундаас бүргэд түүнчлэн бүх амьд зүйлүүдийн дундаас хүн байна. Сургаал ба Гэрээ 77:2–4 нь эдгээр дөрвөн амьтны талаар сүнсээр нөлөөлөгдсөн тайлбар өгдөг билээ.

Илчлэлт 6–7—Зургаан Лацан Дахь Бэлэгдлүүд

Лац бүр нь түүхийн нэг мянган жилийн хугацааг төлөөлдгийг өнөө үеийн илчлэлт бидэнд заадаг (дээрх Илчлэлт 5–7-гийн оршлыг үз).

Нэгдэх лац нээгдэхэд, цагаан морь унаж, байлдан дагуулж байгаа, титэмтэй хүнийг Иохан харжээ. Энэ бол дайснаудаа—түүний дотор Сатаныг дарж—цагаан мориор бэлэгдсэн цэвэр ариун байдал хийгээд зөв шударгын хотыг үндэслэн байгуулахад нь өөрийн хүмүүст тусалсан Енохыг төлөөлдөг гэж Ахлагч Брус Р.МакКонки хэлжээ (*Doctrinal New Testament Commentary*, 3:476–78-ыг үз). Хоёр дахь лацыг нээхэд Ноа болон Үерийн үед тохиосон харгис хэрцгийлэл, үхэл хийгээд устгалыг илчилжээ.

Гурав дахь лацны нээлт Бурханы хүмүүс өлсгөлөнгөөр зовон шаналсан үеийг төлөөлсөн байв. Өлсгөлөнгийн улмаас Абрахам нүүсэн бөгөөд Иаковын (Израилын) гэр бүлийн түүх өлсгөлөнгөөр нэн их зовон шаналсан юм. Дөрөв дэх лацны нээлт, МЭӨ 1000 он болон Христийн

төрөлтийн хоорондох үе бол гэрээт хүмүүсийн дундах дайн дажны үе байсныг бидэнд сануулдаг. Энэ бол тэд гаднынхнаар байлдан дагуулагдаж, боолчлолд аваачигдан дэлхий даяар тараагдсан үе байлаа. Тав дахь лац, Иоханы үеийн итгэлтэй Гэгээнтнүүд гэрчлэлийнхээ төлөө амь насаа өргөхтэй тулгарсныг илчилжээ.

Зургаа дахь лацны нээлтэд дүрслэгдсэн үйл явдлууд илүү нарийн тодорхойлогджээ. Тэдгээр нь Аврагчийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх эрин үед хамаардаг.

Илчлэлт 6:6—Улаан Буудайн болон Арвайн Снэ Ямар Утга Учиртай Вэ?

Нэг хэмжүүр улаан буудай нэг хүнийг нэг өдөр хоолоход хангалттай байв. Нэг динар зоос тэр үед ажлын нэг өдрийн хөлс байв. Энэ нь өлсгөлөнгийн улмаас хоол хүнс өндөр үнэтэй байсныг харуулдаг. Арвай хямд боловч, чанар муу учраас хүн зөвхөн өлсгөлөнгийн үед л хэрэглэдэг байв. Илчлэлт 6:5-д дэнс авч яваа хүнийг дүрсэлсэн нь—яг тодорхой тоо хэмжээний хүнсийг тарааж өгдөг байсан нь—дахиад л өлсгөлөнгийн үеийг сануулдаг.

Илчлэлт 7

Цагаан дээлтэй (ш.13)—Гоё : Зовлон (ш.14)—Гай зовлон, хувцасласан : мөрдлөг хавчлага

Илчлэлт 7:3–8—Бурханы Сйлчлэгчдийн Духан Дээр Тамга Дарах нь

Иоханы үед хуурамч бурхдыг тахин шүтдэг хүмүүс духан дээрээ (эсвэл заримдаа гаран дээрээ) өөрсдийн бурхны нэр буюу бэлэгдлийг тэмдэглэдэг заншил нийтлэг байжээ. Аврагчийн заадаг зүйлүүдэд итгэдэг байсан хүмүүс өөрсдийгөө тэмдэглэдэггүй байлаа. Зөв шударга хүмүүст Бурханы нэр өгөгддөгийг бид Илчлэлт 3:12 болон 22:1–5-аас мэддэг. Тэд өөрсдөө бурхангай адил төстэй бөгөөд “түүний дүрслэлийг [өөрсдийн] царай төрхөндөө” (Алма 5:14) хүлээж авдгийг энэ нь харуулж байна. Тэдний бодол санаа ямагт өөрсдийн Бурхан дээр— тэд “үргэлж түүнийг санаж байхын” тулд байдгийг энэхүү бэлэгдэл бидэнд өгүүлдэг (С ба Г 20:77, 79-ийг үз).

Сургаал ба Гэрээ 77:9–11-д 144,000-ын тамгалалтын тухай бошиглолын зарим тайлбар байдаг.

Судруудыг Судлах нь

Илчлэлт 5–7-г судлахдаа дараах таван үйл ажиллагаанаас (А–Д) наад тал нь гурвыг хий.

А Чухал Сургаалыг Тайлбарла

Илчлэлт 5:2-т тэнгэр элчийн асуусан асуултын хариу юу вэ?

Б Тэр Хэрхэн Аль Аль нь Байж Чадах Вэ?

- Илчлэлт 5:5–6-д, бэлэгдлийн хувьд биенийхээ эсрэг байгаа Есүсийг нэрлэсэн нэрүүд юу вэ?
- Эдгээр нэр тус бүр Есүсийг хэрхэн төлөөлж байгааг болон Тэрээр хэрхэн энэ хоёр зүйлийн аль аль нь байж болохыг тайлбарла.

В Аврагчийг Хүндэтгэх нь

1. Тэнгэр дэх хувь хүмүүс Есүсийг магтаж, хүндэтгэсэн талаар Илчлэлт 5 бидэнд юу өгүүлдгийг дүрсэл. Тэд яагаад тэнгэрт Түүнийг хүндэтгэхээ үргэлжлүүлдэг гэж та нар боддог вэ?
2. Та нар дэлхий дээр Есүсийг хүндэтгэж болох, наад зах нь хоёр арга замыг нэрлэ. Илчлэлт 5-д *дүрслэгдээгүй* нэг арга замыг үүндээ оруулж, өөрсдийн тань үйл хөдлөл хэрхэн Түүнийг хүндэтгэж болохыг тайлбарла.

Г Эмчилгээний Жор Бич

1. Дөрөв дэх лацны тухай Иоханы үзэгдэл дэх морь унасан хүний нэр хэн бэ? Яг ард нь хэн дагасан бэ?
2. 2 Нифай 9:6–14-ийн тусламжтайгаар энэ хоёрыг хэрхэн даван туулахыг дүрсэл.

Д Хожмын Өдрүүд Дэх Сүнсний Хамгаалалт

1. Зургаа дахь лацны нээлтээр Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнө тохиох үйл явдлуудыг Иохан харсан нь өнөө үеийн Гэгээнтнүүдийн хувьд онцгой ач холбогдолтой юм. Үүнийг тэрээр уур хилэнгийн үе гэж дүрсэлсэн бөгөөд хэн үүнийг тэсэн гарах чадвартай байх талаар эргэцүүлэн боджээ (Илчлэлт 6:17-г үз). Илчлэлт 7-гоос, зөв шударга хүмүүс шүүлтийн өдөр хэрхэн хамгаалагдан үлдэх талаар Иохан юу харсан бэ?
2. 144,000-аас гадна хэн энэ адислалыг хүлээж авсан бэ, өөр хичнээн хүмүүсийг энд оруулсан бэ? (Илчлэлт 7:9-ийг үз).
3. Илчлэлт 7:13–17 дахь дүрслэл дээр тулгуурлавал, яагаад тэдгээр хүмүүс хамгаалагдан үлдсэн бэ? Та нар яагаад тэдний дунд байхыг хүсэх вэ? (Илчлэлт 7:3–8 дахь “Судруудыг Ойлгох нь” хэсэг дэх “гамгалах” гэсэн үгний тайлбарыг бас анхаар.)
4. Хожмын өдрүүд дэх сүнсний хамгаалалтын талаарх ярианд та нарын ашиглаж болох, Илчлэлт 7 дахь хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн хоёр бэлэгдэл буюу дүрслэлийг та нар юу гэж боддог вэ? Тэдгээрийг та нар хэрхэн ашиглаж болохыг тайлбарла.


Долоон Лацны Гол Санаа

Нэг дэх Лац	Эхний 1000 жил	Енох	Цагаан морь
Хоёр дахь Лац	Хоёр дахь 1000 Жил	Дайнууд ба Үер	Улаан морь
Гурав дахь Лац	Гурав дахь 1000 жил	Өлсгөлөнгүүд	Хар морь
Дөрөд дэх Лац	Дөрөв дэх 1000 жил	Эзэнт гүрнүүд	Цайвар морь
Тав дахь Лац	Тав дахь 1000 жил	Аллагууд	
Зургаа дахь Лац	Зургаа дахь 1000 жил	Сэргээлт ба байгалийн гамшгууд	
Долоо дахь Лац	Долоо дахь 1000 жил	Мянган Жил	

Хожмын Үе
Иохан
Өнгөрсөн Үеүд

Илчлэлт 8–9

Долоо Дахь Лацан Дахь Долоон Тэнгэр Элч



Илчлэлт 8 долоо дахь лацны нээлтээр эхэлдэг. Долоо дахь лац нээгдсэний дараа Иоханы үзсэн зүйл Илчлэлт 8–22-т цэдэглэгджээ. Долоо дахь лац бол Илчлэлтийн номны голт зүрх мөн гэдгийг ойлгоход дараах хүснэгт бидэнд тусалдаг.

Илчлэлтийн Номон дахь Онцлох Зүйл

Уналтын өмнөх үйл явдлууд	5 шүлэг (Илчлэлт 12:7–12) Тэнгэр дэх дайн
Эхний Лац Анхны 1000 жил	11 шүлэг (Илчлэлт 6:1–11) Тав дахь лацыг дуустал анхных
Хоёр дахь Лац Хоёр дахь 1000 жил	Есүсийн Төрөлт
Гурав дахь Лац Гурав дахь 1000 жил	
Дөрөв дэх Лац Дөрөв дэх 1000 жил	
Тав дахь Лац Тав дахь 1000 жил	
Зургаа дахь Лац Зургаа дахь 1000 жил	14 шүлэг (Илчлэлт 6:12–7–8) Зургаа дахь лац
Долоо дахь Лац Долоо дахь 1000 жил	211 шүлэг (Илчлэлт 8–19) Долоо дахь лацны нээлтээс Есүс Христийн Хоёр дахь Ирэлт хүртэл
Дэлхий сэлэстиэл хаант улс болно	33 шүлэг (Илчлэлт 21:1–22:6) Дэлхий сэлэстиэл болно

Gerald N. Lund, "The Book of Revelation—Three Keys for Making It a Book of Revelation," in *A Symposium on the New Testament*—эс халбаршуулан авав (1980), 120.

Тэнгэрт дээшлэн одож байгаа хүжийн утаагаар бэлэгдсэн Гэгээнтнүүдийн залбирлуудын талаар бид Илчлэлт 8-д уншидаг. Их гай зовлонгуудад зөв шударга байсан Гэгээнтнүүдийн залбирлын улмаас, зургаан тэнгэр элч—тус бүр ээлжээр—дэлхий дээрх ёс бус хүмүүсийн дээрх шүүлтэд иржээ. Илчлэлт 8 нь эхний дөрвөн тэнгэр элчийн тухай өгүүлдэг бол, шүүлтүүд нь эхний дөрвийнхөөс илүү эмгэнэлтэй хийгээд илүү хүчтэй байсан тав дахь болон зургаа дахь тэнгэр элчүүдийн тухай өгүүлдэг. Илчлэлт 10 доош бууж ирж байгаа долоо дахь тэнгэр элчийн тухай өгүүлдэг. Түүний хүрч ирэлтээр тохиох зүйл эхний зургаан тэнгэр элчийнхээс өөр юм.

Илчлэлт 9 дэх хоёр зүйл онцгой ач холбогдолтой юм. Нэгдүгээрт, тав дахь тэнгэр элчийн шүүлтүүд зөвхөн "духан дээрээ Бурханы тамгагүй" (ш. 4) ирэх нь, сайн мэдээний ёслолуудад дуулавартай байснаар хангагддаг сүнсний—мөн олонтаа биеийн хамгаалалтыг дахин онцлон тэмдэглэжээ. Хоёр дахь чухал зүйл бол хэдийгээр Их Эзэн эдгээр устгалуудыг хүмүүсийг наманчлахад нь урамшуулан дэмжихийн тулд илгээсэн ч гэсэн (С ба Г 43:20–25-ыг үз) зургаан тэнгэр элч шүүлтүүдийнхээ "дохиог дуугаргасны" дараа ёс бус хүмүүс наманчлахад мөн л итгүүлэгдээгүй байлаа (Илчлэлт 9:20–21-ийг үз). Ноагийн өдрүүдийнх шиг, мөн Мормоны Номон дахь Нифайчуудын сүүлчийн жилүүдийнх шиг, хүмүүс илт ихэд ёс бус болж, наманчлал бараг л боломжгүй болсон байв.

Илчлэлт 8–9-д олон бэлэгдлийн дүрслэлүүд байдаг. Та нарын уншиж өнгөрсөн эхний бүлгүүдэд байдаг шиг, Иоханы ашигласан дүрслэлүүд нь яг түүний үзүүлсэн

шиг байгаагүй, харин түүний харсныг бэлэгдлээр үзүүлсэн байж болно.

Илчлэлт 10 Иоханы Үүрэг Зорилго

Илчлэлт 9 тав дахь, зургаа дахь тэнгэр элчүүдийн тухай өгүүлдэг болохоор, бүлэг 10 долоо дахь тэнгэр элчийн тухай өгүүлэх байх гэж бодож болох юм. Гэтэл үүний оронд долоо дахь тэнгэр элч бүрээгээ үлээхээс өмнө юу тохиох ёстойг, түүнчлэн түүний харсан үзэгдэл дэх хожмын өдрүүдийн үйл явдлуудад Иоханы гүйцэтгэх үүргийн талаар Иоханд заахаар "өөр нэг хүчит тэнгэр элч" (ш. 1) доош бууж ирсэн тухай бид бүлэг 10-т уншидаг.

Судруудыг Ойлгох нь



Илчлэлт 10

Мэт (ш.1)—Шиг

Нууц (ш.7)—Бүхлээрээ дэлхийд мэдэгдэхгүй байгаа зүйлүүд

Илчлэлт 10:8–11—Иоханы Идсэн "Бяцхан Ном" Юу Байсан Бэ?

Сургаал ба Гэрээ 77:14 тэр бяцхан ном юуг төлөөлдгийг илчилдэг. Сургаал ба Гэрээ 7-д нотолсноор Иохан зөөгдсөн юм. Түүний биед өөрчлөлт орсон нь хөгшрөлгүйгээр амьдрах буюу бие нь өвдөхгүй болсон аж. Энэ нь Илчлэлт 10-т түүнд өгсөн тусгай үүрэг зорилгыг хэрэгжүүлэх боломжийг түүнд олгожээ. 1831 оны Зургадугаар сард Бошиглогч Иосеф Смит, "Ассирын хаан Шалманесераар аваачигдсан Израилын Арван Овгийн дунд Илчлэгч Иохан, тэднийг удаан хугацааны тараалтын дараа эргэж ирэхэд нь бэлтгэхийн тулд байсныг бошигложээ" (*History of the Church*, 1:176).

Судруудыг Судлах нь



Илчлэлт 10-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Номлогчийн Дуудлага

1. Иохан бяцхан номыг идсэн нь (Илчлэлт 10:8–11) Их Эзэний төлөө тусгай дуудлагад түүний дуудагдсаныг төлөөлдөг. 2. Нифай 32:3-ыг уншиж, Иохан ном идсэн нь юуг бэлэгддэг гэж боддоогоо, түүнчлэн яагаад тэрээр үүнийг номлолд үйлчлэхээсээ өмнө хийхийг тэрээр хүсэнийг тайлбарла (мөн С ба Г 11:21–22-ыг үз).

2. Тэр ном Иоханд ямар амттай байсныг дүрслэхэд ашигласан хоёр үгийг ол. Энэ хоёр зүйл ямар утгатай гэж боддог тухайгаа бич (мөн Алма 17:4–5; 26:28–33-ыг үз).

Илчлэлт 11

Хоёр Онцгой Гэрч

Илчлэлт 11 бүрээгээ үлээж байгаа долоо дахь тэнгэр элчийн тухай өгүүлдэг. Гэвч үүнийг тохиохоос өмнө Иохан гурван жил гаруй үргэлжилсэн өөр нэг чухал үйл явдлыг харжээ. Унишихдаа та нар үүнийг эрж ол. Түүнчлэн долоо дахь тэнгэр элч бүрээгээ үлээж байхад юу тохиосныг хийгээд энэ нь бусад зургаан бүрээ дуугарч байхад тохиосон зүйлээс юугаараа өөр байгааг ол.

Судруудыг Ойлгох нь



Илчлэлт 11

Хулс (ш.1)—Урт шулуун иш, хулс

Таяг (ш.1)—Хааны очирт таяг, явган явахад тулдаг таяг

Гадна (ш.2)—Гадна талд

Таар (ш.3)—Хар ямааны хялгасаар хийсэн эгэл хувцас, ихэвчлэн өөрийгөө даруусгадаг хүн өмсдөг байв

Гэрчлэл (ш.7)—Тохинуулал; тэд юм болгоныг хэлснийхээ дараа зааж, гэрчлэх хэрэгтэй байв

Баярлан хөөрч (ш.10)—Баяртай байх, баяр тэмдэглэх

Тарчилгасан юм (ш.10)—Нүглүүдийнх нь төлөөх гэм бурууг тэдэнд сануулсан

Үлдсэн нь (ш.13)—Устгагдаагүй үлдсэн хүмүүс

Гай тотгор (ш.14)—Уй ганцуугай, уйтгартай зүйл

Илчлэлт 11:2–3—“Дөчин Хоёр Сар” ба 1,260 Өдөр

Харийнхан Иерусалимыг дөчин хоёр сарын турш буюу гурван жил хагас “улан дороо дэвслэх” болно гэж Илчлэлт 11:2 өгүүлдэг. Энэ бол Их Эзэний ажил бэлэгдлээр улан дор дэвслэгдэж байсан урвалтын үед хамаарна. “Хоёр гэрч” ариун хотын төлөө 1 260 өдөр буюу бас гурван жил хагас тусгай номлолд үйлчлэх болно гэдгийг шүлэг 3 харуулдаг. Бэлэгдлээр бол, Их Эзэний үйлчлэгчдийн тохинуулал урвалтын үетэй тэнцвэр алдагдсаныг Иохан харж, тийнхүү Их Эзэн болон Түүнийг эсэргүүцэгчдийн алиныг нь сонгох тухайд адил тэгш боломжийг хүмүүст олгожээ. Харамсалтай нь, энэ бүлэгт цэдэглэгдсэнчлэн, олон хүмүүс тэдгээр бошиглогчдыг сонсохгүй байх болно.

Илчлэлт 11:3–12—“Хоёр Гэрч”

Сургаал ба Гэрээ 77:15 тэрхүү хоёр гэрчийн талаар илүү ихийг илчилдэг. Тэр хоёр гэрч Елиа (Хаадын Дээд 17:1-ийг үз) болон Нифайн (Хиламан 10:6–11-ийг үз) адил хүчтэй байдаг. Тэдний дайснууд зөвхөн номлол нь хийгдсэний дараа л тэд-

ний дээгүүр хүчтэй болно (Илчлэлт 11:7-г үз). Илчлэлт 11:4-т тэд “чидуны модод”, “лааны тавиурууд” гэж нэрлэгддэг. Ахлагч Брус Р.МакКонки, “Хүргэн Хүүг утгахаар гарах хүмүүсийн дэнлүүг тосоор хангах . . . [Матай 25:1–13; С ба Г 45:56–57-г үз] тэдний номлолыг эдгээр нь бэлэгддэг бөгөөд дэнлүү гэрэлтдэгийн адил Дэлхийн гэрэл болох Түүнээс ирдэг гэрлийг тэд хүмүүс уруу тусгах болно” гэж хэлжээ (*Doctrinal New Testament Commentary*, 3:510).

Илчлэлт 11:8—“Сүнслэг Байдлаараа Содом ба Египет Хэмээн Нэрлэгдсэн Агуу Хот”

Есүсийн цовдлогдсон болон бусад үед оршин суугчид нь Есүс хийгээд Түүний үйлчлэгчдийг эсэргүүцдэг байсан үеийн тус хот дахь ёс бус явдлыг бэлэгдлээр төлөөлүүлэн “Содом” гэж Иохан Иерусалимыг Илчлэлт 11:8-д нэрлэсэн байдаг. Энэхүү ёс бус байдлын үр дагавар болсон сүнслийн боолчлолыг бэлэгдэн Мосегийн өдрүүдэд Израилын хүүхдүүдийн туулсан боолчлолтой адилтган Иохан Иерусалимыг “Египет” гэж нэрлэжээ.

Судруудыг Судлах нь



Илчлэлт 11-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг хий.

А Их Эзэний Гэрчүүд

Бошиглогчид зөвхөн өөрсдийн хэлснээр төдийгүй, бас хийдэг зүйлээрээ Христийг гэрчилдэг. Илчлэлт 11:3–12-ыг уншиж, хоёр гэрчид тохиолдож байсан зүйл, түүнчлэн Христэд юу тохиолдож байсан хийгээд Түүний хийсэн буюу хийх зүйлийн хоорондох адил төстэй зүйлүүдийг жагсаа.

Б Та Нар Юу Хэлэх Вэ?

- Илчлэлт 11:10-д өгүүлснээр, үзэгдэлд Иоханы харсан хүмүүс номлолынхоо үед хоёр бошиглогчийн хийсэн зүйлийн талаар юу гэж бодсон бэ?
- Хүмүүс өнөө үеийн бошиглогчдыг мөн ийм байдлаар хэрхэн үзэж болохыг дүрсэл.
- Хэрэв та нар үзэгдэлд Иоханы харсан хүмүүсийн нэгэнтэй, эсвэл өнөөдөр бошиглогчдыг мөн тийм байдлаар үздэг хэн нэгэнтэй яривал, биднийг “зовоохоос” илүүгээр бошиглогчдыг ойлгоход нь тэр хүнд туслахын тулд та нар юу хэлэх вэ?

В Долоо Дахь Тэнгэр Элч Бүрээгээ Слээхэд

Тус бүр нь бүрээ үлээсэн долоон тэнгэр элчийг Иохан харсныг, тэрчлэн эхний зургаан тэнгэр элч бүрээгээ үлээхэд юу тохиосныг Илчлэлт 8-9 өгүүлдэг. Илчлэлт 11:15–19 долоо дахь тэнгэр элч бүрээгээ үлээхэд юу тохиосныг өгүүлдэг.

- Долоо дахь бүрээ юуг зарласан бэ?
- Долоо дахь бүрээ дуугарсны дараа тохиосон зүйл эхний зургаан бүрээ дуугарсны дараа тохиосон зүйлээс юугаараа ялгаатай байсан бэ?
- Гэгээнтнүүд яагаад Бурханы төлөө ийн талархал хийгээд магтаалын төлөө ялан дийлэх учиртай гэж та нар боддог вэ?

Илчлэлт 12

Сайн, Муугийн Хоорондох Агуу Тулалдаан

Долоо дахь тэнгэр элч бүрээгээ үлээсний дараа “Энэ дэлхийн хаант улсууд бидний Их Эзэний, мөн түүний Христийн хаант улсууд болно; тэгээд тэрээр үүрд мөн мөнхөд хаанчлах болно” (ш. 15). Ёс бус хүмүүс устгагдсаны дараа тохиох амар амгалангийн нэг мянган жил, Мянганы Жил үүгээр эхлэх болно. Энэ үед Христ дэлхий дээр хаанчилж, “дэлхий шинэчлэгдэн, диваажингийнхаа алдар сууг хүлээж авах” болно (Итгэлийн Тунхаг 1:10). Хэдий тийм ч Илчлэлт 12 нь, Мянганы үе дэх нөхцөл байдлуудын талаар өгүүлэх болно гэж бодож болох хэдий ч, ингэдэггүй. Үүний оронд, Илчлэлт 12-18 нь сайн ба муугийн хоорондох тулалдаан, Бурханы хаант улсыг эсэргүүцэхэд Сатаны хаант улсууд өсөх хийгээд Мянганы төлөө бэлтгэхэд Сатаны хаант улсуудын зайлбаршгүй устгалын тухай илүү ихийг өгүүлдэг. Чухамдаа, Илчлэлт 12 нь Сатаныг дагалдагчид хийгээд Бурханыг дагалдагчдын хооронд мөнх бус байдлын өмнөх амьдралд эхэлж, дэлхий түүхийн туршид үргэлжилж байгаа энэхүү агуу тулалдааныг Иохан хэрхэн үзсэн тухай өгүүлдэг. Гэтэл, дараагийн хэдэн бүлгийн ихэнх нь хожмын өдрүүдэд тохиох зүйлүүдэд холбогддог (1 Нифай 14:18–22, 27-г үз).

Судруудыг Ойлгох нь



Илчлэлт 12

Шаналсандаа (ш.2)—

Төрөхөөр өвдсөндөө

Залгих (ш.4)—Идэх (энэ тохиолдолд устгах)

Хүчийг олсон (ш.8)—Ялсан

Тэнд нутаглагчид (ш.12)—

Дэлхийн оршин суугчид

Уур хилэн (ш.12, 17)—Уур, хилэгнэл

Тэжээгдсэн (ш.14)—

Амьдрахад шаардлагатай зүйл нь өгөгдсөн

Нэг үе, хоёр үе, хагас үе

(ш.14)—Энэ нь гурван жил хагасын хугацаа юм

Бусад (ш.17)—Үлдсэн, үлдсэн хүмүүс

Илчлэлт 12:1–6, 13–17—Эмэгтэй Хүн ба Эр Хүн—Хүүхэд

Илчлэлт 12-ын Иосеф Смитийн Орчуулга бидэнд Иоханы харсан эмэгтэй Бурханы Сүмийг төлөөлдөг бөгөөд эрэгтэй хүн, хүүхэд Бурханы маань хаант улс болон бүх үндэстнүүдийг төмөр таяг буюу Бурханы үгтэйгээр удирддаг (ИСО, Илчлэлт 12:3-ыг үз) Христ юм (ИСО, Илчлэлт 12:7-г үз) гэдгийг ойлгоход тусалдаг. Христ дэлхий дээр амьдарч байхдаа Тэрээр энэ хаант улсыг Өөрөө байгуулсан юм. Урвалт

үүнийг олон зуун жилийн туршид “цөлд” хөөн аваачсан юм, энэ бол тэр үеийн туршид дэлхий дээрх Бурханы хүүхдүүдэд удирдагч нөлөө байхгүй байсан гэсэн үг. Гэсэн хэдий ч, эцсийн өдрүүдэд Бурханы хаант улсын түлхүүрүүд дэлхий дээр дахин сэргээгдсэн бөгөөд Христ дахин ирж, Мянганы туршид дэлхий дээр хаанчлах үед бүрэн ашиглагдах болно (С ба Г 65-ыг үз).

Илчлэлт 12:3–4, 7–17—Долоон Толгой, Арван Эвэр, мөн Долоон Титэмтэй Улаан Луу

Илчлэлт 12:9-д гардаг луу бол Сатан, чөтгөр юм. Толгойнууд нь түүний мэдлэгийг, эврүүд нь түүний хүчийг, түүнчлэн титмүүд нь өөрсдийгөө түүнд захируулахаар зөвшөөрсөн хүмүүсийн дээрх түүний захиргаа буюу хяналтыг төлөөлдөг. Шүлэг 4-ийн дагуу тэр “тэнгэр дэх ондуудын гуравны нэгийг дагуулсан юм.” Энэ бол мөнх бус байдлын өмнөх амьдралд түүнийг дагаж, биеийг олж, мөнхийн дэвшилээ үргэлжлүүлэх боломжгүй болсон хүмүүсийг төлөөлдгийг ойлгоход өнөө үеийн илчлэлт бидэнд тусалдаг билээ (С ба Г 29:36–38; Абрахам 3:23–28-ыг үз).

Илчлэлт 12:7–11—“Тэнгэр Дэх Дайн”

Бошиглогч Иосеф Смит, “Тэнгэр дэх зөрчилдөөн нь, аврагдахгүй нэг хэсэг тодорхой бодгалиуд байх болно гэж Есүс хэлсэн бол, тэрээр бүгдийг аварна гэж чөтгөр хэлсэн бөгөөд түүний төлөвлөгөөг их зөвлөлийн өмнө тавихад, тэд Есүс Христийн төлөө саналаа өгчээ. Тиймээс чөтгөр Бурханы эсрэг бослого гаргаж, улмаар толгойгоо түүнд мэдүүлсэн бүхний хамт доош хаягдсан ажээ” хэмээн хэлжээ (History of the Church, 6:314; тэрчлэн Мосе 4:1–4; Абрахам 3:23–28-ыг мөн үз).

Сайн ба муугийн хоорондох дайн мөнх бус байдлын өмнөх амьдралд Сатаны ялагдлаар дуусаагүй юм. Тэрээр Бурханы Гэгээнтнүүдийн эсрэг дайтахаа үргэлжлүүлсээр байгааг Илчлэлт 12:17 бидэнд өгүүлдэг (С ба Г 76:28–29-ийг мөн үз). Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон, “Илчлэгч Иоханы урьдчилан харсан тэр үед бид амьдарч байна. . . . Гэрчлэлүүдтэй бөгөөд зарлигуудыг сахихаар хичээж байгаа Сүмийн гишүүдийн эсрэг дайн өдөөсөөр байна” гэж хэлжээ (“The Power of the Word,” Ensign, 1986 оны 5-р сар, 79).

Судруудыг Судлах нь



Илчлэлт 12-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–В) хоёрыг нь хий.

А Нэрний Учир?

Илчлэлт 12:1–10-т Люсиферт холбогдох таван өөр нэр гуншинг жагсааж, бид түүнээс сэрэмжилж, түүний нөлөөнөөс зайлсхийхийн тулд эдгээр нэр тус бүр нь бидэнд түүний тухай юу зааж байгааг тайлбарла.

Б Судруудаас Өөрсдийнхөө Тухай Унших нь

1. Мөнх бус байдлын өмнөх амьдралд тэнгэрт болсон дайны тухай Илчлэлт 12:7–11 өгүүлдэг. Шүлэг 11-д дурьдагддаг хүмүүсийн нэгийг чамайг гэж үзэх нь хэр үндэслэлтэй байж болох вэ? (Алма 3:23–28-ыг үз).

- Илчлэлт 12:11-ээс өөрсдийнхөө талаар юу мэдсэнээ, түүнчлэн эдүгээ чамд тусалж болох юуг хэрхэн хийснээ тайлбарласан нэг догол мөр бич.
- Эдгээр заасан зүйлүүд хийгээд зарчмуудыг та нар өнөөдөр амьдралдаа хэрхэн хэрэглэж болох вэ?

В Жишээнүүд Ол

Бошиглогч Иосеф Смит, “Биетэй хүмүүн биегүй хүмүүсийн дээр хүчтэй байдаг. Гагцхүү бид л түүнд боломж олгохгүй бол чөтгөр бидний дээр хүчгүй байдаг” гэж сургажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 181). Тэрээр мөн, “Ёс бус сүнснүүд өөрсдийн хүлээс, хязгаарлалтууд хийгээд өөрсдөө захирагддаг хуулиудтай байдаг” гэж хэлжээ (*History of the Church*, 4:576). Тэргүүн Зөвлөлийн Хоёрдугаар Зөвлөх, Ерөнхийлөгч Жеймс И.Пауст, “Люсифер болон түүний олны хүчний эсрэг хангалттай бамбай” байдгийг гэрчилсэн байдаг (“*Serving the Lord and Resisting the Devil*,” *Ensign*, 1995 оны 9-р сар, 7).

Бошиглогч Иосеф Смит болон Ерөнхийлөгч Фаустын хэлсэн зүйлийн үнэнийг харуулсан жишээнүүдийг Илчлэлт 12-оос ол.

Илчлэлт 13

Мууг Төлөөлдөг Араатнууд

Сайн ба муугийн хоорондох тулалдааны тухай үзэгдлээ Иохан Илчлэлт 13-т бэлэгдлээр дүрсэлдэг. Бурханы хаант улсыг төлөөлж байгаа бүхний эсрэг явдаг хүчит араатан мэтээр Сатан дэлхий дээр өгшүүлэн дэмждэг тэр муу зүйлийг энэ бүлэг дүрслэн харуулдаг бөгөөд энэ нь өөрийн арга замуудыг сүрдүүлэг хийгээд хүчирхийлэлээр албадан тулгахыг эрэлхийлдэг. Араатан нь бас Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнөх Сатаны хүч чармайлтуудыг төлөөлж, араатныг шархтуулах нь түүнийг зогсоодоггүйг өгүүлдэг (Илчлэлт 13:3-ыг үз). Өөрөөр хэлбэл, тэр ч байтугай Сатаны нэг хүч чармайлт зогсоогдож болох хэдий ч, тэрээр өөр хүч чармайлтуудыг үргэлжлүүлэх буюу шинийг эхэлдэг байлаа.

“Амьтнуудын тоо” (666; ш.18) ямар учиртайг тайлбарлах гэж олон хүмүүс оролдсон юм. Өнөө үеийн бошиглогчид судрын энэ хэсгийг тайлбарлаж чадаагүй байгаа бөгөөд Сүмийн сургаалтай нийцдэггүй бөгөөд бошиглогчдоор заагддаггүй, хүмүүний онолуудыг заахгүй байх буюу хөхүүлэн дэмжихгүй байхад гишүүд анхаарах ёстой.

Илчлэлт 14

Дэлхий Дээрх Ургац Хураах Цаг



Илчлэлт 13 Сатаны хаант улсуудын хүч хийгээд өсөлтийн тухай өгүүлдэг бол, Илчлэлт 14-т бид Бурханы хаант улс хожмын өдрүүдэд дэлхий дээр Сэргээгдэж, өсөх тухай унидаг. Энэ үе нь, бүх сайн ургацыг хурааж, агуулахад хадгалан, харин ашиггүй бүх зүйлүүдийг— хадаж, анжсаар даран, шатаадаг ургац хураалтын үетэй харьцуулдаг байсан (мөн харьцуулдаг) билээ. Дэлхий дээр Бурханы хаант улсыг байгуулах нэг зорилго бол Христийн Хоёр дахь Ирэлтээр тохиох ургац хураалтын энэ үе буюу шүүлтийн өдрийг дэлхийн хүмүүст сануулах явдал мөн. Хэрэв бид сэрэмжлүүлэгдэх аваас, бид сайн үр жимс ургуулах буюу Бурханд эсэн мэнд цуглуулагдах боломжийг бидэнд олгох бурханлиг ажлуудаар бид бэлтгэлтэй байж чадна.

Судруудыг Ойлгох нь



Илчлэлт 14


Худалдагдаж авагдсан (ш.3-4)—Аврагдсан (үгчилсэн утга нь боолчлолоос худалдаж авсан)

Бузарласан (ш.4)—Ариун бус

Ариун (ш.4)—Онгон, бэлгийн харилцааны хувьд цэвэр ариун

Ямар ч худал (ш.5)—Аливаа шударга бус явдал, заль мэх
Уур хилэн (ш.8, 10, 19)—Шүүлт
Садар самуун (ш.8)—Хиймэл шүтээнүүд шүтэн бишрэх
Уур хилэн (ш.10)—Аймшигт шүүлтүүд

Хадуур (ш.14–19)—Тариа тарихад зориулсан махир, хурц иртэй багаж



Хадуур

Хадах (ш.15)—Ургац хураах үеэр тариаг хадах

Шахуурга (ш.19–20)—Жимсийг няцалж шахах замаар шүүс гаргаж авдаг газар



Шахуурга

Илчлэлт 14:1—Духан Дээрээ Эцэгийн Нэрийг Бичүүлсэн Байх нь

Илчлэлт 7:3–8-ын “Судруудыг Ойлгох нь” хэсгийг үз (х.194).

Илчлэлт 14:1–5—“Анхны Ср Жимсүүдийг Бурханд”

Эртний Израилд хүмүүс анхныхаа хамгийн сайн ургацыг Бурханд өргөх өргөл болгон ариун сүмд авчирдаг байжээ. Эдгээр анхны “үр жимсүүдийг” өргөснөөрөө Израилчууд Их Эзэн тэдний амьдралд хамгийн чухал ач холбогдолтой гэдгийг харуулдаг байв. Илчлэлт 14:1–5-д дүрслэгдсэн 144,000 хүн эртний израилчууд ургацынхаа дээжээр хийдэг байсан тэр зүйлийг хийсэн буюу тэд өөрсдийн дуулгавартай байдлын анхны хийгээд хамгийн сайн үр жимсийг Их Эзэнд өргөсөн байлаа (ш.4–5-д дүрслэгдсэнчлэн). Тийнхүү тэд дэлхий дээрх Их Эзэний хүмүүсийн “анхны үр жимсүүд” байв.

Илчлэлт 14:6–7—“Өөр Нэг Тэнгэр Элчийг Би Харав . . . , Дэлхийн Оршин Суугчдад Номлох Сүрдийн Сайн Мэдээ Түүнд Байв”



Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Илчлэлт 14:6-гийн хэсгийг иш татан хэлэхдээ, “Тэр тэнгэр элч ирсэн юм. Түүний нэр Моронай. Тоосноос ярьж, Их Эзэн Есүс Христ амьдардаг нь бодитойн өөр нэгэн гэрчийг авчирсан нь түүний дуу хоолой

мөн” гэжээ (in Conference Report, 1995 оны 10-р сар, 93; *Ensign*, 1995 оны 11-р сар, 70). Түүний зорилго бол Их Эзэний ирэлтэд хүмүүсийг бэлтгэх явдал мөн (С ба Г 133:17–19-ийг үз).

Иоханы үзэгдлийн энэхүү сэдвээр, Моронай Иосефийн амьдарч байсан газарт ургац хураалтын улирлын эхэн үеэр Бошиглогч Иосеф Смит дээр ирж, Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсонгийн хэлсэнчлэн, Их Эзэний ирэлтийн бэлтгэл болгож “Бурхан [Өөрийн] сонгогдсон хүмүүсийг цуглуулахын тулд дэлхийг үерээр мэт арчихаар төлөвлөсөн” тэр зэмсэг байж болох нэг номны тухай түүнд ярьжээ (Моце 7:62)” (in Conference Report, 1988 оны 10-р сар, 3; *Ensign*, 1988 оны 11-р сар, 4)

Судруудыг Судлах нь

Илчлэлт 14-ийг судлахдаа үйл ажиллагаа А, түүнчлэн бусад үйл ажиллагаануудаас (Б–Г) хоёрыг хий.

А Төгс Эзэмших Судар—Илчлэлт 14:6–7

1. Дээрх Илчлэлт 14:6–7-гийн “Судруудыг Ойлгох нь” хэсгийг унш. Та нар өөрсдийн уншсан зүйл дээрээ тулгуурлан энэ хоёр шүлгээр буюу өөр ямар нэг зүйлийг тэмдэглэх буюу бичиж болно.
2. Илчлэлт 14:6–7-г ашиглан, манай ариун сүмүүдийн орой дээрх баримал хэнийх болох бас юуг төлөөлдгийг асуусан хүнд юу ярихаа бич.

Б Бэлэгдлүүдийг Тайлбарла

Христийн шашныг сонирхож байгаа хэн нэгэн Илчлэлт 14:1–5-ын утгыг тайлбарлаж өгөхийг өөрсдөөс тань хүсчээ гэж бод. Ялангуяа Тэнгэрлэг Эцэгийн нэрийг духан дээрээ бичүүлсэн Сүмийн ямар нэгэн гишүүд байдаг уу гэдгийг тэд мэдэхийг бүр ч их хүсдэг ажээ. Бурханы нэрийг өөрсөд дээрээ авах гэдэг нь чухам ямар утга учиртай хийгээд дух нь юуг бэлэгддэг тухай тэдэнд юу ярихаа бич. Тэр 144,000 хүн Бурханы нэрийг өөрсөд дээрээ үнэхээр авснаа хэрхэн харуулсан тухай ямар нэг зүйл оруул (ш.4–5-ыг үз).

В Чухал Ажил Сүргүүд

1. Илчлэлт 14-т зургаан өөр тэнгэр элчийн тухай өгүүлсэн байдаг. Тус бүр нь өвөрмөц ажил үүрэгтэй байсан бололтой. Тэнгэр элч тус бүрийн ажил үүргийг дүрсэлсэн шүлгүүдийг тэмдэглэлийнхээ дэвтэрт бич. Тэгээд тэнгэр элчийн хийх ёстой зүйлийг дүрсэл. (Тэдгээр тэнгэр элч тус бүр нь тэнгэр элчүүдийн бүхэл бүтэн бүлэг, эсвэл тэнгэрлэг тохинуулагчдыг төлөөлсөн байж болно.)
2. Тэнгэр элчийн ажил үүргүүдээс хоёрыг нь сонгон, хэрэв тэдгээр ажил үүргүүд өөрсөд тань өгөгдсөн бол ямар санагдахаа дүрсэл. Яагаад ингэж бодогдох байсныг тайлбарла.
3. Сургаал ба Гэрээ 11:1–4, 27-г уншиж, аль тэнгэр элчийн ажил үүргүүд Их Эзэнээс өөрсөд тань өгсөн ажил үүргүүдийн алинтай нь хамгийн их адилхан байгааг тэмдэглэлийнхээ дэвтэрт бич.

Илчлэлт 14 Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнөх ургац хураалтын тухай өгүүлдэг. Дараах судрын ишлэл тус бүрийг уншиж, ургац хураалтаар юу тохиох хийгээд, ургац хураалтын зорилго нь юу болох талаар судрын эдгээр ишлэлүүд та нарт юу зааж байгааг бич: Илчлэлт 14:14–19; Алма 26:5–7; Сургаал ба Гэрээ 12:1–4; 29:7–12; 33:2–7; 45:1–5; 86:1–7; 88:84–85, 94.

Илчлэлт 15

Сэлэстиэл Дэлхийн Тухай Үзэгдэл

Хэдийгээр Илчлэлт 4–22 нь нэг үзэгдлийг авч үздэг ч гэсэн, үзэгдэл нь үйл явлуудыг үе үе өөрчилдөг байна. Илчлэлт 15 үзэгдэл дэх нэг шинэ үйл явдлыг тэмдэглэдэг. Үүнд Иохан “галтай холилдсон шилэн тэнгис” (ш. 2), “араатнуудыг” ялсан хүмүүс (Илчлэлт 13-т байдаг) амьдардгийг харжээ. “Бурханы оршихуйд”, “шил болон галан тэнгэстэй адилхан” бөмбөрцгүүд байдаг тухай Сургаал ба Гэрээ 130:6–7 бидэнд өгүүлдэг. “Энэ дэлхий сэлэстиэл эрхэс—шилэн тэнгис лугаа адил болох болно” гэж Ерөнхийлөгч Бригам Янг хэлжээ (Discourses of Brigham Young, sel. John A. Widtsoe [1941], 101). Бурханд зориулан магтуу дуулж байгаа тэнд оршин суудагчдыг Иохан харсан ажээ. Бас Бурханы алдар суугаар дүүрсэн ариун сүмийг тэрээр харжээ. Цагаан хувцастай долоон тэнгэр элч ариун сүмээс гарч иржээ. Тэдний ажил үүргүүд Илчлэлт 16-д дүрслэгддэг.

Судруудыг Судлах нь

Илчлэлт 15-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Сайн Асуулт

1. Сэлэстиэл дэлхийд дуулахыг нь сонссон дууны үгийг Иохан Илчлэлт 15-д цэдэглэжээ. Асуултын дараа юу хэлэгдсэнийг авч үзэн, шүлэг 4-т асуусан асуултад та нар хэрхэн хариулах вэ?
2. Хариулт тодорхой байгааг дуу харуулж байвал, яагаад олон хүмүүс Их Эзэнийг амьдралдаа хүндэтгэн, алдаршуулахад тэмцэл хийдэг юм бэ?
3. Хэзээ та нар эдгээр дуучдын боддогтой хамгийн их адилаар боддог вэ? Энэхүү бодол санааг амьдралдаа илүү олонтаа баримталж хэвшил болгохын тулд та нар юу хийж болох вэ?

Илчлэлт 16

“Бурханы Шүүлтүүдийг Цутгах” Долоон Тэнгэр Элч

Бурханы оршихуй дахь ариун сүмээс долоон тэнгэр элч гарч ирснийг Иохан үзсэн тухай Илчлэлт 15 өгүүлдэг билээ. Тэнгэр элч тус бүрт “Бурханы уур хилэнгээр дүүрэн” сав өгсөн байлаа (Илчлэлт 15:7). Тэнгэр элч бүр савнаасаа дэлхий дээр юүлэн, ёс бусчууд дээр Бурханы шүүлтүүд буюу шийтгэлүүдийг авчрахыг Илчлэлт 16 дүрсэлдэг.

Илчлэлт 16-д байдаг зарим зүйлс нь Илчлэлт 8–9-д бидний уншидаг зүйлтэй төстэй юм. Илчлэлт 12 дахь Иоханы үзэгдэл цаг хугацааны хувьд ухарч, Илчлэлт 8–11-д түүний үзсэн зүйл уруу хөтөлж түүнд үзүүлжээ. Үүний улмаас Илчлэлт 16 нь өмнө нь түүний харсан заримыг нь давтдаг хэдий ч, энэ удаад тэдгээр нь ирээдүйн зорилгуудын тулд үзүүлэгддэг. Жишээ нь, Илчлэлт 16-д эдгээр хожмын өдрийн шүүлтүүдэд оролцдог араатан амьтан, Сатаны үүргийг Иохан харжээ.

Зургаа дахь тэнгэр элч бүрээгээ үлээсний дараах дайн дажны талаар нилээд хэдэн шүлэг Илчлэлт 9-д байдаг. Зургаа дахь тэнгэр элч саваа юүлсний дараа, Есүс Христийн Хоёрдахь Ирэлтийн өмнөх сүүлчийн агуу тулалдааны газар болох Армагеддонд (ш.14–16)сайхь араатан хүмүүсийг цуглуулахыг Иохан Илчлэлт 16-д харжээ. Илчлэлт 16-д тохиодог дараагийн зүйл нь, Илчлэл 11 дэх долоо дахь тэнгэр элчийн нэгэн адил, долоо дахь тэнгэр элч Хоёр дахь Ирэлтийн цаг ирснийг буюу “энэ дууслаа” хэмээн зарладаг (Илчлэлт 16:17). Энэ цаг үе нь өмнөх шүүлтүүдээр дамжуулан наманчлахаас татгалзсан хүмүүсийн хувьд хамгийн аймшигтай боловч, зөв шударга хүмүүсийн хувьд алдар суут цаг үе байлаа.

Аврагчийг ирэхэд Иоханы харсан сүүлчийн үйл явдал бол чөтгөрийн хаант улсыг төлөөлдөг Вавилоны устгал байлаа. Чөтгөрийн хаант улсуудын устгал нь Илчлэлт 12-оос хойших сэдэв болох муугийн эсрэг сайны тулалдаан дахь агуу ялалт байв. Энэхүү устгал Илчлэлт 17–18-д дүрслэгддэг.

Илчлэлт 17–18

Янхан Вавилоны Устгал



Вавилон устгагдахыг нэг тэнгэр элч тунхаглахыг Иохан сонссон тухай Илчлэлт 14 өгүүлдэг (ш.8-ыг үз). Уг устгалын тухай шастир Илчлэлт 16:19-д эхэлж, Илчлэлт 17–18-д уг шастир ихэд нарийвчлалтайгаар үргэлжилдэг. Илчлэлтийн бусад хэсгүүдэд байдгийн нэгэн адил Вавилоны устгал нь бэлэгдлийн хэлийг ашиглан дүрслэгддэг.

Вавилон нь эртний Вавилон улсын нийслэл байсан хэдий ч, уг нэр судруудад бүхэл үндэстнийг нэрлэсэн нь олонтаа байдаг. Вавилончууд Иудагийн хаант улсыг байлдан дагуулж, олон Израилчуудыг Вавилонд боолчлолд аваачсаныг бид Хуучин Гэрээнд уншидаг. Вавилон хот нэн том байсан бөгөөд хотын хүмүүс нь гоёмсог барилгууд, тансаг хувцас хунар, чөлөөт цагийн үйл ажиллагааны баялгуудаа харуулан, маш их баян чинээлэг байжээ. Бас тэд хиймэл шүтээнүүдийг шүтдэг байв. Вавилоны дэлхийн чанарын улмаас, энэ бол Израилын хүүхдүүд боолчлолд аваачигдсан газар байсан бөгөөд нүгэл, дэлхийн чанар, газар дээрх чөтгөрийн нөлөө, түүнчлэн эдгээр зүйлүүдээс ирдэг сүнсний боолчлолыг төлөөлүүлэхэд Их Эзэн Вавилон гэдэг нэрийг судруудад олонтаа ашигласан байдаг (С ба Г 1:16; 133:5, 7, 14). Үнэ цэнийхээ хувьд Вавилон нь Сионы эсрэг юм (Мосе 7:18-ыг үз).

Судруудыг Ойлгох нь



Илчлэлт 17

Янхан (ш.1, 15–16)—Ёс суртахуунгүй үйлүүдийг үйлдэхийн тулд мөнгө авдаг хүн; энэ тохиолдолд энэ нь Вавилоныг буюу дэлхийг бэлэгджээ

Завхайрал (ш.2, 4)—Ёс суртахуунгүй үйлдлүүд; тэрчлэн хиймэл шүтээнүүдийг шүтэх явдал

Доромжлол (ш.3)—Бурхан болоод Түүнийг төлөөлдөг бүхнийг үл хүндэтгэн, доромжилсон үг хэллэг хийгээд үйл хөдлөл.

Хувцастай (ш.4)—Хувцасласан

Жигшүүрт юмс (ш.4–5)—Бохир буюу заваан, жигшүүртэй, гутамшигтай зүйл

Янхан (ш.5)—Ёс суртахуунгүй үйлүүдийг үйлдэхийн тулд мөнгө авдаг хүн

Сүйрэл (ш.8, 11)—Устгал буюу мөхөл (С ба Г 76:31–38-ыг үз)

Хоосруулж (ш.16)—Устгаж

Илчлэлт 17:8—“Байсан, Одоо Байхгүй Боловч Ирэх” Тэр Араатан

Энэ будилмаар өгүүлбэр чөтгөрийг, эсвэл чөтгөрийн үйлчлэлд өөрийгөө бүрэн эргүүлсэн хүнийг хэлж байгаа бололтой, тэрчлэн энэ нь Илчлэлт 1:4, 8-д Есүс Христийн тухай Иоханы мэдсэн зүйлийн эсрэг байдалтай юм. Хэдийгээр чөтгөр мөнхөд амьдарч болох хэдий ч, тогтворгүй, хувирамтгай, огт зохисгүй юм (Алма 30:60-ыг үз). Гэтэл Есүс Христ бол “өчигдөр, өнөөдөр, мөн үүрдийнх” (Мормон 9:9) бөгөөд зөвхөн хүчирхэг төдийгүй, тогтвортой хийгээд үргэлж итгэлтэй байж чадна. Чухам иймээс бид итгэлээ Түүнд төвлөрүүлж болно.

Илчлэлт 18

Нутагладаг газар (ш.2)—Хүмүүс амьдардаг байр, байшин

Хээнцэр тансгийнх нь хүчээр (ш.3)—Түүний (Вавилоны) тансаг эд агуурсын буюу дэлхийн зүйлүүдийн үлэмж их тоо

Гамшиг (ш.4, 8)—Гай зовлон, тохиох муу зүйлүүд

Хээнцэр тансаг байсных нь төлөө (ш.7)—Ёс бус, дэлхийн тансаглалыг эрэлхийлэн

Түүнийг хараад, уйлж гашуудна (ш.9)—Түүний

төлөөнөө ихэд гунигтай байж, уй гашуу болов

Сүйтгэгдэв (ш.17)—Юу ч үгүй болов

Тэд толгой дээрээ шороо цацаж (ш.19)—Библийн үе дэх уйтгар гуниг, уй гашуугийн тэмдэг

Шийтгэв (ш.20)—Өс авах, бусдын эсрэг өөрсдийн ёс бусын төлөө зохих шангаа тэд хүртэв

Ид шид (ш.23)—Ид шид

Судруудыг Судлах нь



Илчлэлт 17–18-ыг судлахдаа дараах үйл ажиллагааг хий.

А Судруудын Утгыг Олох нь

Зарим үед бэлэгдлийг тайлбарлах буюу судрын будилмаар хэсгийг тайлбарлах нь үүний өмнөх буюу дараах шүлгүүдэд түлхүүрүүдийг эрж хайх явдлаар ойлгогдож болдог.

- Илчлэлт 17:1–2, 6, 18-ыг Илчлэлт 18:2–3, 24-тэй харьцуулж, Илчлэлт 17 дахь “янхан” буюу эмэгтэй хэнийг бэлэгддэгийг тэмдэглэлийнхээ дэвтэрт бич.
- Илчлэлт 17:15 нь Илчлэлт 17:1-ийн тухай ойлгоход та нарт юугаар тусалдаг вэ?
- Илчлэлт 17:3 долоон толгойтой, арван эвэртэй араатны тухай өгүүлдэг. Илчлэлт 17:12-т өгүүлснээр, эврүүд нь юу вэ?

Бусад тохиолдлуудаар, ойлгохын тулд буюу нэмэлт мэдээллийн тулд та нар судрын бусад номнуудад хандаж болно. Тайллыг олж мэдсэний дараа (1–5 алхмыг гүйцэтгэх ёстой), эдгээр шүлгүүдийг та нар дараагийн удаа тайлбарлах явдал уруу хөтлөх тийм байдлаар судрууддаа тэмдэглэл хийж болно. Жишээ нь, та нар уг шүлгийн дэргэд харьцуулах ишлэлийг судрын зах дээр бичиж болно.

- Илчлэлт 17-г ойлгоход тусламж авахын тулд, 1 Нифай 14:9–17-г унш. Араатны утга учрын тухай, түүнчлэн Илчлэлт 17-д өгүүлсэн цаг үеийн өмнө сайхь эмэгтэй юу хийсэн талаар мэдсэн зүйлээ бич.
- Илчлэлт 18:4 дэх Их Эзэний зарлигийг дагах нь ямар утгатайг ойлгоход Сургаал ба Гэрээ 133:14 та нарт хэрхэн тусалдаг вэ?

Судруудад нэмэлт тусламж олох нь хэцүү байх үе ч байдаг. Та нарыг тунгаан бодох цаг гаргасан үед Сүнсээр дамжин утга хүрч ирэх учиртай. Бэлэгдлийн хэлний талаар тунгаан бодох ашиг тустай нэг арга бол бэлэгдлүүдийг оюун санаандаа зураглах цаг гаргаж тэгээд дараа нь тэдгээрийн тодорхойлолтыг тэмдэглэн бичих явдал мөн. Тухайн бэлэгдлийн хамгийн их учир холбогдол бүхий онцлогууд юу вэ? Эдгээр онцлогуудын бий болгодог мэдрэмж буюу захиас юу вэ? Сүнсний захиас нь юу вэ? гэх зэрэг асуултуудыг өөрсөдөө тавь. Эдгээр энгийн санаанууд нь ойлголт, ухаарлын сүнснийг урьдаг тунгаан бодолтыг олонтаа урамшуулан дэмждэг билээ. Тэдгээрийг ашиглан 6–7 алхмаар бясалган бодохыг хичээ.

- Илчлэлт 17:4 дэх тодорхойлолт Вавилоныг төлөөлдөг зүйлийн талаар та нарт юу заадаг вэ?
- Өөрсдийн мэдсэн зүйлийг авч үзвэл, яагаад янхан Вавилонд тохирох бэлэгдэл байдаг вэ? (Дээрх “Судруудыг Ойлгох нь” хэсэгт болон үүний оршилд өгөгдсөн мэдээллийг авч үзэж болно.)

Илчлэлт 19

Христийн Хоёр Дахь Ирэлт

Вавилон хийгээд үүнийг төлөөлдөг бүхний устгалд тохиодог эцсийн үйл явдал нь сайхь араатныг авч, түүнийг зайлуулах, Есүс Христ, “Хаадын Хаан, Эздийн Их Эзэний” (Илчлэлт 19:16) ирэлт юм. Энэ үйл явдлын шастир Илчлэлт 19-д байдаг. Иохан Илчлэлт 11:15–19-д энэ үйл явдлын цэдгийг эхэлсэн хэдий ч, дараа нь үүн уруу хөтөлсөн үйл явдлуудыг хийгээд шүүлтүүдийн ач холбогдол болоод Есүс Христийн ирэлтээр ёс бусчууд устгагдах тухай ихэд нарийвчлалтайгаар харуулсан байна. Илчлэлт 19-өөс номны төгсгөлийг дуустал, Есүс Христийн Хоёр дахь Ирэлтээр болон түүнээс хойш тохиох үйл явдлуудыг Иохан цэдэглэжээ.

Судруудыг Ойлгох нь



Илчлэлт 19

- | | |
|--|--|
| Халлелуяа (ш.1, 3–4, 6)—
Бурханд магтаал өргөө! | Дээл (ш.13, 16)—Орхимж,
нөмрөг |
| Төгс Хүчит (ш.6)—Бүхнийг
чадагч | Дарсан шахуургыг шахна
(ш.15)—Илчлэлт 14-ийн
“Судруудыг Ойлгох нь”
хэсэг дэх тусламж хийгээд
зургийг үз (х.199). |
| Хувцаслах (ш.8)—Хувцас
өмсөх | Бусад нь (ш.21)—Үлдсэн нь,
нэхээст давуу |
| Маалинга (ш.8, 14)—
Маалингаар хийсэн нарийн | |

Илчлэлт 19:7–9—Хурганы Гэрлэлт болон Гэрлэлтийн Зоог

Сүм эмэгтэй хүнээр бэлэгдэгдсэнийг бид Илчлэлт 12-т уншдаг. Есүс нэгээс дээш тохиолдолд Өөрийгөө уг эмэгтэйтэй гэрлэх хүргэн хүү хэмээн хэлсэн байдаг (Исаиа 54:5; Матай 22:2–14; Лук 5:34). Энэхүү бэлэгдлийн гэрлэлт нь бид Их Эзэнтэй гэрээт харилцаатай бөгөөд бид итгэл, найдвар тавьж болох, төгс төгөлдөр эр нөхрийн хувьд Тэрээр Сүмд анхаарал халамж тавьдаг гэдгийг бидэнд сануулдаг билээ (Ефес 2:25-ыг үз).

Гэрлэлтийн зоог бол гэрлэлтийг тэмдэглэх найр юм. Найрын дүрслэл нь Есүс Христийн сайн мэдээ Адам, Ева хоёрын бүхэл үр удмын сүнсний, сэтгэл хөдлөлийн хийгээд биеийн өлсгөлөн буюу хэрэгцээг хангадаг гэдгийг бидэнд сануулдаг. Энэхүү агуу зоогт бусдыг урих болон бэлтгэх нь хожмын өдрүүдийн чухал захиас мөн (С ба Г 27:5–14; 58:8–12; 65:2–3-ыг үз).

Илчлэлт 19:9, 17–21—Хоёр Зоог

Илчлэлт 19-д хоёр зоогны тухай өгүүлсэн байдаг. Тэдгээр нь яг адил биш ч, гэсэн дэлхийн түүхэн дэх нэгэн үед тохиодог. Нэгдүгээрт, Хурганы гэрлэлтийн зоог өмнөх хэсэгт өгүүлэгддэг. Нөгөө зоог, “агуу Бурханы зоог” нь (ш. 17) ёс бусчуудын устгалын тухай бидэнд сануулдаг бэлэгдэл юм. Түүнээс гадна, хэрэв бид итгэлээ энэ дэлхийн зүйлүүд дээр тавьж, үхлийн дараах амьдралд эс итгэх аваас, бидний хувьд урагш харах ганцхан ирээдүй нь дэлхий дээрх бусад бүх амьд зүйлүүдийн нэгэн адил—бид ялзарч эхлэн, үхэх болно, тэгээд махчин шувууд бидний махыг идэх болно гэдгийг энэ нь бидэнд сануулдаг. Үүний эсрэгээр, сайн мэдээ нь булшнаас ялалтыг хийгээд мөнхийн аз жаргалын боломжийг тунхагладаг билээ.

Илчлэлт 19:15, 21—“Түүний Амнаас Хурц Илд Цухуйх Агаад . . . Тэрээр Тэднийг Төмөр Таягаар Захирах Болно”

Илд хийгээд төмөр таяг хоёул Бурханы үгэнд холбогдоно (Еврей 4:12; 1 Нифай 15:23–24-ийг үз). Хэдийгээр энэ нь хатуу сонсогдож болох хэдий ч, өөрсдийн гэм бурууг хүмүүн байнга өөрчлөх буюу төгс байдлаар мэдэж байхад нь түүнд туслахад нь хүмүүний төв дэх бат, хүчирхэг чиглүүр юм (1 Нифай 16:2; Алма 31:5; 3 Нифай 11:3-ыг үз).

Судруудыг Судлах нь

Илчлэлт 19-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А-В) хоёрыг хий.

А Урилга Төлөвлө

1. Илчлэлт 19:7–9-д дүрслэгдсэн үйл явлуудад хэн нэгнийг урьсан урилга бич. Чухал ач холбогдолтой нарийн ширийн зүйл бүрийг, тухайлбал, юу болох, хүмүүс ямар хувцас өмсвөл зохихыг, түүнчлэн тэнд очихын тулд юу хийсэн байвал зохихыг оруул. Урилгын нарийн ширийн зүйлийг тогтоохдоо Матай 22:2–14; 2 Нифай 9:50–51; Сургаал ба Гэрээ 27:5–14 болон 58:8–9-ийг уншиж, ашигла.
2. Сургаал ба Гэрээ 65:1–5-д өгүүлснээр Илчлэлт 19:7–9-д өгүүлэгддэг тэрхүү агуу үйл явдлуудад урилгыг хэн хүргэдэг вэ?

Б Асуултуудад Хариулахын Тулд Судар Ашигла

1. Сүмийн гишүүн биш, Христэд итгэгч найз нарын тань нэг нь өнөөдрийн бошиглогчдод итгэдэггүй, Сүмд бошиглогчид байдаг гэж бид хэрхэн хэлж чадаж байгаад гайхдаг ажээ. Бошиглогчдод итгэдэг бидний итгэлийн тухай тайлбарлахдаа Илчлэлт 19:10-ыг ашигла (түүнчлэн Тооллого 11:29-ийг үз).
2. Үнэн гэрчлэлийн эх сурвалжийг тайлбарлахдаа Илчлэлт 19:10-ыг тайлбарла (1 Коринт 2:11; Алма 5:45–46-г үз).

В Яагаад Улаан Гэж?

1. Есүс Хоёр дахь Ирэлтээрээ улаан хувцас өмссөн байхыг Иохан дүрсэлжээ (Илчлэлт 19:13-ыг үз). Сургаал ба Гэрээ 19:16–19 болон 133:46–51-ийг уншиж, дараа нь Түүний улаан хувцас юуг бэлэгдэж байгааг тайлбарла.
2. Түүний ирэлтээр Есүстэй хамт ирэх хүмүүсийн хувцасны өнгө ямар байх вэ? Энэ өнгө юуг бэлэгдэж байна вэ? (Илчлэлт 19:8, 14-ийг үз).

Илчлэлт 20 Мянган Жил

Есүс Христ алдар суундаа ирж, Вавилон устгагдахад, Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөнд энэ дэлхийн хувьд “нэг мянган жилийн хугацаа” хэмээн нэрлэгдсэн Мянган Жил эхлэх болно. Хэдийгээр Илчлэлт 20-д мянган гэдэг үг байдаггүй ч гэсэн, энэ нь юуг дүрсэлдгийг Иохан тодорхой бичжээ.



Судруудыг Ойлгох нь

Илчлэлт 20

Ёроолгүй гүн (ш.20)—
Гадна харанхуй, Сатан
болон мөхлийн хөвгүүдийн
ирээдүйд орших газар (С ба
Г 76:31–38-ыг үз)

Төгсөх (ш.7)—Дуусах

Газрын энгээр (ш.9)—Энэ
нь дэлхийн ихээхэн хэсэг
гэсэн утгатай
Бүслэх (ш.9)—Эргэн той-
ронд байх

Илчлэлт 20:4—Шүүлтэнд Сэнттэй Хэн Суух Вэ?

Энэ нь Эцсийн одор Түүнтэй хамт шүүлтэнд суух болно хэмээн Түүний хэлсэн Их Эзэний үйлчлэгчид бололтой (1 Нифай 12:9–10; 3 Нифай 27:27-г үз).

Илчлэлт 20:4–6—Эхний Амилуулалт

Эхний Амилуулалтгад ямар хүмүүс хувьтай байх талаар дэлгэрэнгүй мэдээллийг Мозая 15:21–26, Сургаал ба Гэрээ 76:64, 70; 88:95–98-ыг үз.

Илчлэлт 20:7–10—Гог ба Магог

Гог ба Магог гэдэг нэрүүд Езекиел 38–39-д анх удаа хэрэглэгджээ. Эдгээр нэр Их Эзэний Хоёр дахь Ирэлтийн өмнө Түүний эсрэг тэмцэгч үндэстнүүдэд холбогдоно. Энэ нь Мянган Жилийн эцэст Сатаныг дагалдагчид хийгээд Их Эзэний эсрэг тэмцэгч хүмүүст холбогдон Илчлэлт 20-д хэрэглэгдсэн байдаг.

Судруудыг Судлах нь

Илчлэлт 20-ийг судлахдаа дараах хоёр үйл ажиллагааг (А-Б) хий.

А Энэ нь Юуг Өгүүлдэг Вэ?

1. Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнөх сүүлчийн өдрүүдийг дүрсэлдэг бараг арван таван бүлэг Илчлэлтэд байдаг хэдий ч, харин ганцхан бүлэг, бүлэг 20 л Мянган Жилийг дүрсэлдэг (“Илчлэлтийн Номон дахь Онцлох Зүйл”, х.196 дахь бүдүүвчийг үз). Мөн Мянган Жилийн тухай Иоханы тодорхойлолт хүмүүс хэрхэн амьдрах хийгээд тэд юу хийхийг бидэнд өгүүлдэггүй. Яагаад Мянган

Жилийн өмнө юу тохиох тухай төдий их өгүүлсэн хэрнээ Мянган Жилийн туршид тохиох үйл явдлууд хийгээд үйл ажиллагааны бараг юу ч дурьдаагүй гэж бодлогоо тайлбарла.

- Мянган Жилийн турш дахь хүмүүсийн үйл ажиллагааны талаар Илчлэлтийн номноос бид төдийлөн ихийг мэддэггүй ч гэсэн, бид дэлхийн түүхээс энэхүү чухал ач холбогдолтой эриний талаар нэн чухал сургаалуудыг мэддэг. Илчлэлт 20-иос өөрсдийн олддог Мянган Жилд хамаарах бүх үнэнүүдийг жагсаа. Эдгээрийг бүтэн өгүүлбэрээр бичиж, үнэн болгон нотлогдож байгаа шүлгүүдийг ажигла.

Б Төгс Эзэмших Судар— Илчлэлт 20:12–13

- Дэлхий дээрх хүн бүр тэрээр үхэхийнхээ өмнө мэдэхийг хүсэх ёстой гэж өөрсдийн боддог үнэнүүдийг Илчлэлт 20:12–13-аас жагсаа. Эдгээр зүйлүүдийг хүн яагаад мэдэх учиртай гэж бодлогоо тайлбарла.
- Илчлэлт 20:12–13-т дүрслэгдсэнчлэн, номнууд нээгдэхэд тохиох зүйлийн талаар 2 Нифай 9:10–16 бидэнд ямар нэмэлт ойлголт өгдөг вэ?
- Дараах нотолгоонуудын нэгийг сонгож, доорхийг хэлсэн хүнд юу гэж хэлэхээ бичиж, энэ үйл ажиллагаанаас мэдсэн зүйлээ ашигла:
 - “Хэрэв чи нүгэл үйлдсэн бол, үүнийг мартаж, харин гарах үр дагавраас нь зайлхийх нь амархан.”
 - “Бурхан хүн болгонд хайртай болохоор, шүүлтийн өдөр тийм ч муу байхгүй.”
 - “Хэн ч төгс биш, гэхдээ би өөрсдийн таньдаг олон хүнээс илүү гэдгээ мэддэг, тэгэхлээр шүүлтийн төлөө юунд санаа зовох билээ?” Энэ бол сонирхолтой зүйл хийхэд л саад болох зүйл.”
 - “Бусдыг удаан хугацаагаар гомдоогоогүй л бол чамд ямар пад байна.”

Илчлэлт 21–22

Газар Сэлэстиэл Дэлхий Болох нь

Илчлэлтийн номны сүүлчийн энэ хоёр бүлэгт, дээр нь амьдардаг хүмүүсийн хувьд газар дэлхий сэлэстиэл дэлхий болох Мянган Жилийн дараах дэлхийн ирээдүйн талаар Иохан юу харсныг бид уншидаг. Тэрээр бас өөрийн харсан зүйлүүд үнэн гэсэн өөрийн гэрчлэлийг бидэнд үлдээсэн юм. Сэлэстиэл хаант улсын тухай түүнчлэн тэнд амьдрах нь хичнээн сайхан болох тухай Иоханы бичсэн зүйлийг уншихдаа, тэнд амьдрахын тулд юу шаардлагатай талаар бод. Ийм алдар сууг олж авах нь эдгээр шаардлагуудад нийцэх үү?



Илчлэлт 21–22-т бичигдсэн зүйлийн талаар бодох арга замыг Ерөнхийлөгч Бригам Янг бидэнд өгч хэлэхдээ, “Энэ амьдрал дахь өөрсдийн гай зовлон хийгээд бэрхшээлүүдийн талаар бид ярьдаг: харин та нар энэ амьдрал дахь цөөхөн жилүүдийн туршид шашиндаа итгэлтэйгээ харуулсны дараа мянга мянга хийгээд сая сая жилүүдийн туршид өөрсдийгөө түүнчлэн Бурханы дэргэд мөнх амьдралыг хийгээд алдар суугийн титмийг олж авснаа, харж чадахаа бод; тэр үед эндэх амьдрал уруугаа эргээд харж, хохирлууд, бэрхшээлүүд, цөхрөлүүд хийгээд уй гашуунуудаа харвал. . . , та нар, ‘Энэ тань юу юм бэ? Ийм зүйлүүд агишин зуурын төдийд байсан хэдий ч эдүгээ бид энд байна шүү дээ. Бид мөнх бус байдлынхаа хэдхэн хормд л итгэлтэй байсан байна шүү дээ, харин эдүгээ бид мөнх амьдрал хийгээд алдар сууг эдлэн бүх зүйлд болоод хязгааргүй мэдлэгт өсөн дэвших хүчтэйгээр, дэвшлийн тоо томшиггүй үе шатуудаар дамжин бидний мөнхийн Эцэг хийгээд Бурхан, мөн Есүс Христийн инээмсэглэл болоод зөвшөөрлийг [ач тусыг] хүртэж байна шүү дээ’ гэж өөрийн эрхгүй дуу алдах биз ээ” гэжээ (in Journal of Discourses, 7:275).

Судруудыг Ойлгох нь



Илчлэлт 21

Гоёсон (ш.2)—Гоё сайхнаар хувцасласан
Бурханы асар (ш.3)—Амьдрах газар
Дөрвөлжин (ш.16)—Тэгш өнцөгт, шоо дөрвөлжин хэлбэртэй
Бузрыг үйлддэг (ш.27)—Бохир буюу бузар юм хийдэг

Илчлэлт 21:2—Шинэ Иерусалим

Илчлэлт 21-д өгүүлэгддэг Шинэ Иерусалим бол эцсийн өдрүүд болон Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн нэг хэсэг болон Америк тивд баригдах тэр хот биш (Итгэлийн Тунхаг 1:10-ыг үз). Энэ нь сэлэстиэл дэлхийд холбогдоно.

Илчлэлт 21:11–25—Бурханы Хотын Тодорхойлолт

Хэрэв та нар Иоханы өгсөн Бурханы хотын хэмжээг тооцоолж үзэх цаг гаргах юм бол, уг хотын хэмжээ нь хэзээ нэгэн цагт хүмүүний бүтээж байсан аль ч хотоос үлэмж том байсныг тэрээр дүрсэлснийг ойлгох болно. Түүнээс гадна үнэт төмөрлөгүүд хийгээд үнэт чулуунуудын байдал нь тодорхойлохын аргагүй гоё сайхан ажээ. Гэвч ариун сүм байх хэрэгцээ, эсвэл гэрлийг ч байхгүй болгохуйц Бурханы мөнхүү оршихуй бол хамгийн сүр жавхлантай хэсэг нь юм (ш.22-23-ыг үз).

Илчлэлт 22

Хараал (ш.3)—Адам, Ева хоёрын Уналтын үр дагавруудыг хэлж байна.

Гадна талд (ш.15)—Гадаа

Давидын үр удам ба Үндэс (ш.16)—Давидын удам бөгөөд Израилын хаан байх эрхтэй хүн; Есүс Христ
Гамшгууд (ш.18)—Зүхлүүд, гай гамшгууд

Илчлэлт 22:2, 14—Амьдралын Мод

Адам Ева хоёрын Уналтын дараа, тэд наманчилж, соригдох хугацаатай байхын тулд, тэрчлэн энэхүү агуу адислалаас хүртэхэд өөрсдөө бүх талаар бэлтгэгдэхийн тулд амьдралын мод уруу очих зам хаагдсан байлаа (Алма 12:22–26; 42:2–5; Мосе 4:31-ийг үз). Амьдралын модны жимс сэлэстиэл дэлхий дээрх хүн болгонд хүртээмжтэй байсныг Иохан харжээ. Амьдралын мод хүртээмжтэй байгаа нь, энэ газарт Уналтын бүх үр дагаврууд даван туулагдсаныг харуулдаг.

Илчлэлт 22:17—“Ирээрэй”

Энэ номны оршилд дурьдсанчлан (х.190-ыг үз), Илчлэлтийн номны гол зорилго нь биднийг Есүс Христэд ирэхийг урих явдал мөн. Номны хаалт—Илчлэлт 22:17 нь—энэхүү урилгад дахин онцгой анхаарал хандуулсан байдаг.

Илчлэлт 22:18–19—Эдгээр Зүйлүүд Дээр Нэмэх Буюу Түүнээс Авч Болохгүй

Библийн дараа ямар нэг илчлэлт буюу судар байж болохгүй, учир нь энэ нь Библи дээр нэмсэн болно гэсэн санааг хамгаалахын тулд зарим хүмүүс Илчлэлт 22:18–19-ийг ашигладаг. Ийм байдлаар тэд Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, түүнчлэн Агуу Үнэт Сувдыг гутаахыг оролддог.

Гэсэн хэдий ч, Мосе бас л өөрийн номны талаар яг ийм зүйл бичсэн байдаг (Дэд Хууль 4:2-ыг үз). Хэрэв Мосегийн үгсийг дээрх байдлаар тайлбарлах юм бол, эхний таван номноос хойш Библи байхгүй байх байсан. Мосегийн адилаар Иохан, Илчлэлтийн Номыг бичихэд Бурхан түүнийг чиглүүлсэн юм гэдгийг л зөвхөн хэлсэн хэрэг.

Орчин үеийн илчлэлт хийгээд хожмын үеийн судрууд үнэн үү гэдгийг Бурханаас Өөрөөс нь асуух замаар хэн ч гэсэн тэдгээрийн үнэнийг мэдэж болно (Матай 7:7–11; Иаков 1:4–5-ыг үз).

Судруудыг Судлах нь


Илчлэлт 21–22-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А–Г) хоёрыг нь хий.

А Сзүүлэн Төлөвлө

Их Эзэнд хийгээд Түүний заадаг зүйлүүдэд та нар үнэнч байгаагаа харуулж, мөн сануулахад сайн үзүүлэн болно гэж өөрсдийн бодсон нэг шүлгийг Илчлэлт 21–22-оос сонго. Яагаад энэ шүлэг та нарт сүнслэгээр нөлөөлөхийг тайлбарлаж, энэ үзүүлэнг ямар байдалтай харагдуулахыг хүсч байгаа талаараа бяцхан бүдүүвч гарга.

Б Эдгээр Хүмүүс Хэн бэ?

- Илчлэлт 7:9, 13–17-г Илчлэлт 21:1–4-тэй харьцуулж, Иоханы харсан ариун хотын нэг хэсэг ямар хүмүүс болохыг хэл. (Түүнчлэн та нар Илчлэлт 22:11–14-ийг бас уншиж болно.)
- Илчлэлт 21:8 болон 22:15-д өгүүлснээр тэр Ариун Хотод хэн байхгүй байх вэ? (Эдгээр шүлгүүд дэх бүх үгс ямар утгатайг ойлгох ёстойг анхаар.)



В Хамгийн Их Сэтгэгдэл Төрүүлэм

Ахлагч Брус Р.МакКонки Илчлэлтийн Номны талаар өгүүлж, хэлэхдээ, “Хүмүүнд одоо байгаа аль ч сударт ийм голыг нь олсон, итгүүлэн сэнхрүүлэгч тайлбарууд хаа ч байхгүй, тиймээс бид дэлхийг даван туулж, түүнээс урсан ирэх адислалуудыг хүртэх ёстой. . . . Энэхүү сүнсээр нөлөөлөгдсөн бүтээлийн заадаг зүйлүүд нь эдүгээ ариун бичээсүүдэд байдаг хувь хүний зөв шударга байдлын агуу шижим түлхэц [эрмэлзэл тэмүүлэл] жинхэнэ ёсоор болж байна” гэжээ (“Understanding the Book of Revelation,” *Ensign*, 1975 оны Есдүгээр сар, 89).

Ахлагч МакКонкийн хэлсэн дээр дэмжлэг болгож, өөрсдийг тань зөв шударгаар амьдрахад шижим түлхэц өгөхөд сүнслэгээр нөлөөлж, хамгийн их сэтгэгдэл төрүүлсэн, Илчлэлтийн номноос мэдсэн нэг буюу түүнээс илүү зүйлийн тухай бич.

Г “Ирээрэй, Их Эзэн Есүс ээ”

Илчлэлт 22:20-ийн унш. Шинэ Гэрээг судалсан үеийнхээ туршид юу сурсан тухайгаа бодож, Есүсийн тухай гэрчлэлээ бич. Есүсийг ирэхийг хүссэн Иоханы залбиралд та нар яагаад нэгдэх болсноо оруул.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

